ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ПРОКУРОРЫН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

VI

Энэхүү бүтээлийг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй "Залуу хуульчдыг чадавхжуулах замаар Монгол Улсад шүүх эрх мэдлийн тогтолцоог бэхжүүлэх нь" төслийн хүрээнд эрхлэн гаргасан ба уг бүтээлд дурдагдсан судалгааны үр дүн, дүгнэлт, санал нь судлаачдынх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департамент, Азийн сангийн үзэл бодол, байр суурийг илэрхийлээгүй болно.

Улаанбаатар хот
2024 он

ДАА 340
ННА 67
У-315

Зохиогчийн эрх @2024: Монгол Улсын Ерөнхий прокурорын газар
©Зохиогчийн эрхийн хуулийн дагуу хамгаалагдсан.

Энэхүү бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд прокурор, ажилтнууд эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр ашиглаж болно. Үүнээс өөр зорилгоор олшруулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно.

Хянасан:

Б.Бат-Орших — Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор

Боловсруулсан:

Бүлэг I	О.Мөнхсайхан	МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
Бүлэг II	Б.Өнөрмаа	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Бүлэг III, XVI	Я.Мөнхзаяа	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор
Бүлэг IV	Г.Оюунболд	Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүн, сургагч багш
Бүлэг V	Ж.Ариунаа	Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор
Бүлэг VI	Г.Гэрэлтуяа	Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих 2 дугаар хэлтсийн дарга, ахлах прокурор
Бүлэг VII	Б.Батсайхан	Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор

Бүлэг VIII, XIII	Ц.Насанбат	Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүн, сургагч багш
Бүлэг IX	Б.Мөнх-Од	Баянгол дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор
Бүлэг X	Д.Галбадар	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Бүлэг XI	Х.Батчимэг	Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийн төлөөлөх хэлтсийн дарга, ахлах прокурор
Бүлэг XII	Н.Одонтуул	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Бүлэг XIV	Ц.Хашбаатар	Хан-Уул дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор
	М.Болормаа	Улсын ерөнхий прокурорын газрын сэтгэл зүйч
Бүлэг XV	С.Энхтөр	Шүүхийн Сахилгын хорооны гишүүн, шүүгч
Бүлэг XVII	Ц.Хашбаатар	Хан-Уул дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор
Бүлэг XVIII	Э.Мөнх	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэл заслын багийн ахлагч
Бүлэг XIX	Д.Бөхчулуун	Улсын ерөнхий прокурорын газрын Бүртгэл мэдээллийн технологийн албаны дарга, ахлах прокурор

Чөлөөт Хэвлэл Сан-ийн хэвлэх үйлдвэрт эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN 978-9919-9076-0-0

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 11

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БА ХҮНИЙ ЭРХ 12

Сэдэв 1. Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах ажиллагаа 12

1.1 Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалтыг зөвхөн хуульд тодорхой заах 13

1.2 Хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлын аль нэгийг хамгаалах зорилготой байх 15

1.3 Хязгаарлалт нь хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод хүрэхэд тохирсон (зайлшгүй) байх 17

1.4 Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх 21

1.5 Ялгаварлан гадуурхахгүй байх 21

1.6 Хараат бус шүүхээр хянагддаг байх 22

Эх сурвалжийн жагсаалт 24

БҮЛЭГ 2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ 26

Сэдэв 1. Прокурорын тухай ойлголт 26

1.1 Прокурорын мэргэжлийн тухай ойлголт 26

1.2 Прокурорын хяналт, зорилго, ач холбогдол 26

1.3 Прокурорын үйл ажиллагааны зарчмууд, тэдгээрийн үзэл баримтлал 27

1.4 Прокурорын байгууллагын тогтолцоо, онцлог тал 30

Сэдэв 2. Прокурорын хяналтын ажлын онцлог 31

2.1 Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт 31

2.2 Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт 32

2.3 Шүүхэд төрийг төлөөлөх 33

2.4 Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт 34

2.5 Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь 35

Хавсралт 1. 37

Эх сурвалжийн жагсаалт 40

БҮЛЭГ 3. ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙ 41

Сэдэв 1. Хуульчийн мэргэжлийн нэр хүнд, ёс зүй ба хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах орчин цагийн сорилт 41

1.1. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт 41

1.2 Нийгмийн ёс зүйн тойрог ба мэргэжлийн ёс зүйн тойрог 44

Сэдэв 2. Хууль зүйн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ ба харилцаа хандлага 45

2.1 Хуульчийн ёс зүйн хариуцлага ба шударга ёс 45

2.2 Хуульч, прокурорт нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлага. 46

Сэдэв 3. Прокурорын ёс зүйн зөрчил 47
3.1 Ашиг сонирхлын зөрчилдөөн. 47
3.2. Нийгмийн болон ёс зүйн тойргоос үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилдөөн. 48
3.3. Гадаад орны туршлага 51

Эх сурвалжийн жагсаалт 53

БҮЛЭГ 4. ПРОКУРОРЫН ХАРААТ БУС БАЙДАЛ 54

Сэдэв 1. Хараат бус байдлын тухай ойлголт, эрх зүйн үндэс 54
1.1. Прокурорын хараат бус, бие даасан байдлын тухай ойлголт 54
1.2. Прокурорын хараат бус, бие даасан байдлын эрх зүйн үндэс 56
1.3. Прокурорын хараат бус байдлын бүрдэл хэсэг 58

Эх сурвалжийн жагсаалт 67

БҮЛЭГ 5. ХЭРГИЙН БҮРДЭЛ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧДЫН ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ 68

Сэдэв 1. Эрүүгийн хэрэгт нотлох баримт, мэдээллийг бэхжүүлсэн байдал 68
1.1 Эрүүгийн хэргийн нотлох баримт, баримтат мэдээлэл 68
1.2. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, үнэлэх 69

Сэдэв 2. Иргэн, хуулийн этгээд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогчоос гаргасан гомдол, хүсэлт, мэдээллийг хянаж шийдвэрлэхэд анхаарах асуудал 71
2.1 Гомдол хянаж шийдвэрлэх 72

Эх сурвалжийн жагсаалт 83

БҮЛЭГ 6. ХАВТАСТ ХЭРЭГ ХЯНАХ АРГА ЗҮЙ, ХЭРГИЙН ТҮҮВЭР ХИЙХ АРГАЧЛАЛ 84

Сэдэв 1. Хэрэгт хяналт тавих 84
1.1 Хэргийг ажиллагааны явцад хянах 84
1.2 Хэрэг бүртгэлт явуулсан хэргийг хянах: 86
1.3. Мөрдөн байцаалтын хэргийг хянах: 89

Сэдэв 2. Хэргийн түүвэр хийх аргачлал 93
2.1 Хэргийн түүвэр хийх арга зүй 93

Эх сурвалжийн жагсаалт 94

БҮЛЭГ 7. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН ТООЦООГ ГАРГАХ АРГА ЗҮЙ 95

Сэдэв 1. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг тодорхойлох 95
1.1. Гэмт хэргийн хохирлын талаарх ойлголт, хэрэглээ 95
1.2. Гэмт хэргийн хор уршгийн талаарх ойлголт, хэрэглээ 96
1.3. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг тодорхойлох нь 96

Сэдэв 2. Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцооллыг гаргах тухай ... 96
2.1. Хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 96
2.2. Мал хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 97
2.3. Залилах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 97
2.4. Албан тушаалын гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 98
2.5. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 101
2.6. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол ... 102
Эх сурвалжийн жагсаалт ... 102
БҮЛЭГ 8. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ХИЙХ ... 103
Сэдэв 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөтлөн явуулж буй субъектүүдийн эрх зүйн байдал, эрх, үүргийн хэрэгжилт буюу тэдний үйл ажиллагааны хууль ёсны байдал ... 103
1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид, тэдний эрх зүйн байдлын талаарх ойлголт, нийтлэг болон ялгаатай эрх хэмжээ, онцлог шинжийн тухай ... 104
1.2. Нотлох баримтын хууль ёсны байдал, хүрэлцээтэй хангалттай эсэх ... 106
1.3 Үйл баримтын талаарх ойлголт ... 109
2.1 Хууль хэрэглээ, нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар үнэлж, дүгнэх ... 110
2.2. Тохиолдол шинжлэх, түүнийг шийдвэрлэсэн сайн жишээ ... 112
2.3. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн алдаа буюу хууль хэрэглээний зарим алдаа, зөрчил ... 115
Эх сурвалжийн жагсаалт ... 118
БҮЛЭГ 9. НОТОЛБОЛ ЗОХИХ БАЙДАЛ, НОТЛОХ БАРИМТЫН ЭХ СУРВАЛЖИЙГ ШАЛГАХ, НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ ... 119
Сэдэв 1. Нотолгоо, нотлох баримтын тухай ойлголт, үндсэн ба нэмэлт шинж ... 119
1.1. Нотлох баримтын тухай ойлголт ... 119
1.2. Нотлох баримтын шинж, тэдгээрийн ангилал, төрөл ... 119
Сэдэв 2. Нотлох үйл ажиллагаа, түүний үе шат ... 122
2.1. Хууль зөрчиж цуглуулсан нотлох баримтыг хэрхэн шийдвэрлэх: ... 127
2.2. Нотлох баримтын хангалттай хүрэлцээтэй байдал ... 128
2.3. Нотлох баримтыг үнэлэх дотоод итгэл ... 128
Эх сурвалжийн жагсаалт ... 129
БҮЛЭГ 10. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ ... 131
СЭДЭВ 1. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД ... 131

1.1.Таслан сэргийлэх арга хэмжээний ойлголт 131
1.2.Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, ангилал 132

СЭДЭВ 2. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ АЖИЛЛАГАА 136
2.1. Шүүхийн зөвшөөрлөөр хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээний төрөл .. 136
2.2 Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний онцлог, анхаарах асуудал 140
2.3. Шүүхийн зөвшөөрлөөр таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагаа 144
2.4. Өсвөр насны хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх ажиллагааны онцлог 145
2.5. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах нь 145

Эх сурвалжийн жагсаалт 146

БҮЛЭГ 11. ШҮҮХ ХУРАЛДААНД БЭЛТГЭХ, ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭН 147

Сэдэв 1. Хэргийг хянах, шүүх хуралдаанд бэлтгэх үе шатанд анхаарах асуудлууд 147
1.1 Прокурор шүүх хуралдаан, мэтгэлцээнд бэлтгэхийн ач холбогдол 147
1.2 Хэргийн бүрдэл хангагдсан эсэхийг хянах: 148
1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн аливаа зөрчлийг мөрдөгч гаргасан эсэхийг хянах 149
1.4 Хэргийн онол боловсруулах буюу прокурорын яллах дүгнэлт үйлдэх нь 149
1.5 Хэргийн түүвэр хийх 153

Сэдэв 2. Шүүх хуралдаанд улсын яллагч яллах чиг үүргээ хэрэгжүүлэх ажиллагааны тухай 154
2.1. Шүүх хуралдаанд асуух асуултуудаа урьдчилан бэлтгэх 154
2.2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх 157
2.3. Мэдүүлгээс бусад нотлох баримтуудыг шинжлэн судлахад бэлтгэх нь 158
2.4. Улсын яллагчийн дүгнэлтийн үг бэлтгэх 159
2.5 Шүүх хуралдаанд оролцоход бэлтгэх бусад зүйлс 161

Эх сурвалжийн жагсаалт 162

БҮЛЭГ 12. ЯЛЫН ЗОРИЛГО, ЯЛЫГ НЭМЖ НЭГТГЭХ АРГАЧЛАЛ 163

Сэдэв 1. Эрүүгийн хариуцлагын ойлголт, оногдуулах хэм хэмжээ 163
1.1 Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт. 163
1.2 Эрүүгийн хариуцлагын зорилго 163

Сэдэв 2. Эрүүгийн хариуцлагыг нэмж нэгтгэх аргачлал 171
2.1 Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах 171
2.2. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах 173

Эх сурвалжийн жагсаалт 175

БҮЛЭГ 13. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ 176

Сэдэв 1. Олон улсын эрх зүй ба үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ... 176
1.1. Олон улсын эрх зүй ба Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт ... 176
1.2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ... 177

Сэдэв 2. Олон улсын эрүүгийн эрх зүй ба хамтын ажиллагаа ... 180
2.1 Мөрдөн шалгах ажиллагааны харьяалал, прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэл ... 180
2.2. Хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох хууль зүйн үндэслэл ... 183

Сэдэв 3. Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай ... 184
3.1 Өнөөгийн нөхцөл байдал ... 184
3.2 Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх албан бус арга хэрэгсэл ... 184
3.3. Гадаад орнуудын сайн туршлага. ... 199

Эх сурвалжийн жагсаалт ... 202

БҮЛЭГ 14. ПРОКУРОРЫН СЭТГЭЛ ЗҮЙ БА ХАРИЛЦАА, ХАНДЛАГА ... 203

Сэдэв 1: Бие хүний болон прокурорын сэтгэл зүй ... 203
1.1. Бие хүний авир араншин, зан төлөв ... 203
1.2 Прокурорын мэргэжлийн тогтсон хандлага, ажлын сэтгэл ханамж ... 205
1.3 Түгээмэл тохиолдох сэтгэл зүйн зарим өөрчлөлт ... 206

Сэдэв 2: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч болон бусад байгууллагын ажилтнуудтай үр нөлөөтэй харилцах нь ... 212
2.1 Прокурорын мэргэжлийн сэтгэл зүйн зарим онцлог байдал ... 212
2.2 ЭХХША-ны оролцогч нар болон бусад байгууллагын ажилтнуудтай харилцах харилцаа ... 216
2.3 Харилцааны ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах арга зам ... 229

Эх сурвалжийн жагсаалт ... 232

БҮЛЭГ 15. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙ /ЭРҮҮ, ИРГЭН, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ/ ... 236

Сэдэв 1. Хууль тайлбарлах ба хэрэглэх ойлголтын агуулга ... 236
1.1 Хуулийг хэн тайлбарлах, хэрэглэх шаардлага, эрх, хэмжээ ... 236
1.2. Хууль тайлбарлах болон ангиллын асуудал ... 237
1.3. Хуулийг хэрэглэх ажиллагааны тухай ... 240
1.4. Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлага ... 241

Сэдэв 2. Хууль тогтоогчийн хүсэл ба хуулийг тайлбарлан хэрэглэх ... 245
2.1. Хууль тогтоогч ... 245
2.2. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах зарчим, үнэт зүйлс, үзэл санаа: Эрх зүйт ёс (rule of law), эрх зүйн зайлшгүй процесс (due process),

нийгмийн зөвшилцөл 246
2.3. Хууль сахиулах ажиллагаа ба DUE PROCESS 248
2.4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба DUE PROCESS 248

Сэдэв 3. Хууль тайлбарлах онолын чиг хандлага 249
3.1. Онолуудын ойлголт, ангилал, төрлүүд 250
3.2. Эрүү, Иргэн, Захиргааны эрх зүйн зарчмууд 251
3.3. Цаашид анхаарвал зохих асуудал. 257

Эх сурвалжийн жагсаалт 258

БҮЛЭГ 16. ПРОКУРОРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 259

Сэдэв 1. Прокурор мэргэжлийн мөн чанар ба онцлог 259
1.1 Прокурорын ажил үүргийн онцлог ба мэргэжлийн хариуцлага 259
1.2 Мэргэжлийн онцлогийг хувь хүний хөгжилд хувирган мэдлэгээ дээшлүүлэх нь 261

Сэдэв 2. Хувийн төлөвлөлт хийх замаар ажлыг бүтээмжийг сайжруулах нь 267
2.1 Төлөвлөлт 267
2.2 Цагийн менежментийн тухай 268
2.3 Цаг төлөвлөх зарчим ба зохимжит арга барил 268
2.4 Прокурор туслах ажилтантай харилцах асуудал 269
2.5 Прокурор хууль сахиулах байгууллагын ажилтантай харилцах асуудал 270

Сэдэв 3. Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах хувийн зохион байгуулалт 270
3.1 Хувийн зохион байгуулалтад зайлшгүй нөлөөлөх зарим асуудлууд 270
3.2 Гадаад орнуудын сайн туршлага 272

Эх сурвалжийн жагсаалт 275

БҮЛЭГ 17. ПРОКУРОРЫН НИЙГМИЙН МЭДРЭМЖ 277

Сэдэв 1. Прокурор нийгмийн оролцогч болох нь 277
1.1 Прокурорын үйл ажиллагааны зарчим ба нийгмийн хандлага 277
1.2 Прокурорын хяналт ба хүний эрхийн мэдрэмж 280

Сэдэв 2. Нийгмийн холбоо хамаарал, нөлөөлөл 283
2.1. Нийгмийн мэдрэмжийн зарим ур чадварыг удирдах арга замууд 283
2.2 Нийгмийн хүрээллийн нөхцөл байдлыг шинжлэн судлах нь 284
2.3 Прокурорын ур чадвар ба шалгуур 286

Сэдэв 3. Нийгмийн хандлага, нөлөөллийн зарим шинжийг сайжруулах нь 288
3.1 Гадаад орны сайн туршлага 288
3.2 Өсөлтийн сэтгэлгээ ба шинэ чиг хандлагад суурилан бусдад нөлөөлөх нь 289
3.3. Цахим сүлжээ дахь цаг үеийн үзэл бодол ба олны анхаарал татсан, дуулиант хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нийгмийн хандлага 291

Сэдэв 4. Прокурорын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба олон нийтийн цахим сүлжээг ашиглах зохист байдал 292
4.1 Прокурорын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө 292
4.2 Прокурор олон нийтийн цахим сүлжээг зохистой ашиглах нь 293

Эх сурвалжийн жагсаалт 294

БҮЛЭГ 18. СТРЕСС МЕНЕЖМЕНТ 296

Сэдэв 1. Стресс, түүний үндсэн хэлбэр 296
1.1 Стрессийн тухай олон талт ойлголт 296
1.2 Стресс үүсгэгч хүчин зүйл 297
1.3 Ажил мэргэжилтэй холбогдох стресс 298
1.4 Стрессийн улмаас хүний бие махбод, сэтгэлзүйд үзүүлдэг нөлөө 299

Сэдэв 2. Стрессийг даван туулах арга зүй 300
2.1 Стресс үүсгэгчийг таньж мэдэх, ухамсарлах, хүлээн зөвшөөрөх тухай 301
2.2 Стресс тайлах энгийн аргуудыг хэрэгжүүлэх 302
2.3 Ажил эрхлэлтэй холбоотой стресст өртсөн үед хувь хүний түвшинд хэрэгжүүлэх алхам 304
2.4 Мэргэжлийн тусламжид хандах: 307

Эх сурвалжийн жагсаалт 308

БҮЛЭГ 19. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛ 309

Сэдэв 1. Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн нэгдсэн систем 309
1.1 Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хяналтын ажлын модуль 309
1.2. ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ 334
1.3. ШҮҮХЭД ТӨРИЙГ ТӨЛӨӨЛӨХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ 386
1.4 ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ 425

СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ (ERP)-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ 465
2.1 Үүрэг даалгавар, түүний биелэлт тооцох, ажлын төлөвлөгөө гаргах 466
2.2 Албан хэрэг хөтлөлт (Албан бичиг боловсруулалт, хүлээн авах, хариуг илгээх) 471
2.3 Цахим гарын үсэг ашиглах тухай ойлголт 475

ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагыг уншигч эрхэм танд ажлын амжилт, сайн сайхныг хүсэн мэндчилье!

Прокурорын байгууллагын хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага бүхий шударга, ёс зүйтэй прокурорыг төлөвшүүлэх явдал юм.

Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд энэ чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхой тусгаж, холбогдох зорилтыг дэвшүүлсэн.

Иймд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс прокурор, ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх, боловсролын зэргийг ахиулахад онцгой анхаарч, шинэ хандлага, шинэ арга барилаар ажиллахыг зорьж байна.

Энэ хүрээнд Прокурорын байгууллагаас сургалт, судалгааны талаар баримтлах бодлогын баримт бичгүүдийг шинээр боловсруулж, батлан хэрэгжүүлж байгаагаас гадна сургалтын хөтөлбөрүүдийг шинэчилж байна.

Тухайлбал шинээр томилогдсон прокурор нь ажлын байрандаа богино хугацаанд дадлагажиж, мэргэшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү сургалтын гарын авлагыг шинжлэх ухааны мэдлэгийн тодорхой салбараар мэргэшсэн эрдэмтэн, судлаач болон дадлага туршлагатай прокуроруудтай хамтран боловсруулж, та бүхэнд толилуулж байна.

Уг гарын авлага нь шинээр томилогдсон прокурор болгоны өдөр тутам хэрэглэх, ширээний номны нэг болж, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйлсэд тань бодитой дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.

Та бүхний мэргэжлийн үйл ажиллагаанд дахин амжилт хүсэхийн зэрэгцээ энэхүү гарын авлагыг эрхлэн гаргахад дэмжлэг үзүүлсэн Азийн сангийн “Залуу хуульчдыг чадавхижуулах замаар Монгол Улсад шүүх эрх мэдлийн тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Эрдэм номын цагаан буян түгэн дэлгэрэх болтугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР,
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР (Ph.D) Б.БАТ-ОРШИХ

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БА ХҮНИЙ ЭРХ

СЭДЭВ 1. ҮНДСЭН ХУУЛЬД ЗААСАН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ АЖИЛЛАГАА

1.1 Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалтыг зөвхөн хуульд тодорхой заах
1.2 Хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлын аль нэгийг хамгаалах зорилготой байх
1.3 Хязгаарлалт нь хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод хүрэхэд тохирсон (зайлшгүй) байх
1.4 Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх
1.5 Ялгаварлан гадуурхахгүй байх
1.6 Хараат бус шүүхээр хянагддаг байх

Зорилго. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй гэж заасан. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасан.

Прокурор нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад эдгээр үндсэн эрхийг хязгаарлах санал гаргах эсхүл хязгаарлах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохоор хуульчилжээ. Жишээлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7-т “хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд сэжигтнийг баривчлах саналыг шүүхэд хүргүүлэх, баривчлах ажиллагаа явуулахыг мөрдөгчид даалгах” бүрэн эрхийг прокурорт олгожээ. Мөн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, нэгжлэг хийх, эд зүйл, баримт бичиг хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, оршуулсан цогцсыг гарган шинжлэх, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна” гэж заажээ. Прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад энэ мэтээр үндсэн эрхийг хязгаарлах санал гаргах эсхүл хязгаарлах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо үндсэн эрхийг хязгаарлахад тавьдаг гол нөхцөлийг хангаж ажиллах нь үндсэн эрхийг хамгаалахад чухал.

Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс[1] бусад үндсэн эрхийг хязгаарлахад

[1] Эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх, итгэл үнэмшил, үзэл бодолтой байх зэрэг зарим үндсэн эрхийг ямар ч тохиолдолд хязгаарлахыг Монгол Улсын Үндсэн хууль болон олон

наад зах нь дараах зургаан гол нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг: (1) хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх; (3) хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон[2] байх (proportionality[3]); (4) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; (5) ялгаварлан гадуурхахгүй байх; (6) хараат бус шүүхээр хянагддаг байх.[4] Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь эдгээр зургаан нөхцөлийг аль нэгийг хангаагүй бол уул эрхийн зөрчил болно. Үндсэн эрхийг, ялангуяа иргэний болон улс төрийн эрхийг ийнхүү хязгаарлахад заавал хангах ёстой зургаан гол нөхцөлийг[5] Монгол Улсын Үндсэн хуульд хэрхэн заасныг товч байдлаар авч үзнэ.

1.1 Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалтыг зөвхөн хуульд тодорхой заах

Монгол Улсын Үндсэн хууль туйлын эрхээс бусад үндсэн эрхийг зөвхөн хуулиар хязгаарлахыг зөвшөөрнө. Учир нь, Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол хууль дээдлэх ёс учраас ийм нөхцөл тавигддаг. Хууль дээдлэх ёс нь хуульд заасан үндэслэл, журмаас гадуур үндсэн эрхийг хязгаарлахыг хориглодог юм.[6] Хууль дээдлэх ёс нь the Rule of Law, Эрх зүйт төрийг илэрхийлдэг. Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багш “Монгол дахь хууль дээдлэх ёсны үзэл санаа нь сая дээр дурдсан “Rule of law” буюу “эрх зүйт ёс”-ны, “Rechtsstaat” буюу “эрх зүйт төрийн” нэгэн хувилбар гэж болно. Эдгээр нь аялгуу ялгаатай ч агуулга, мөн чанараараа адил санаа”[7] гэж бичиж байжээ.

Онц болон дайны байдал зарласан үед хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлахыг шаарддаг Үндсэн хуулийн хэм хэмжээ нь ийм байдал үүсээгүй ердийн үед хүний эрх, эрх чөлөөг бас зөвхөн хуулиар хязгаарлах гэсэн санааг өөртөө багтаадаг. Үндсэн хуулийн 19-р зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал

улсын эрх зүй хориглодог учраас эдгээр эрхийг туйлын эрх гэдэг.

2 “Proportionality”-ийг хувь тэнцүүлэх зарчим, тэнцвэрийн зарчим зэргээр нэрлэх нь бий. Гэвч, “тохирсон байх” гэсэн нэр томьёо нь Эрүүгийн хууль, Захиргааны ерөнхий хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль зэрэг хууль тогтоомжид хэрэглэж хэвшсэн бөгөөд уул ойлголтыг ойлгомжтой илэрхийлж буй учраас энэ өгүүлэлд хэрэглэв. Энэ ойлголтын агуулга Монголын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөний дараа түүнийг “тохиромж” гэх илүү оновчтой, товч үгээр илэрхийлэх боломжтой.

3 Энэ зарчмын тухай дараахаас дэлгэрүүлэн уншина уу: Proportionality: New Frontiers, New Challenges, edited by Vicki C. Jackson and Mark Tushnet (Cambridge University Press, 2017); Warner Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis*, Constitutional Systems of the World (Hart Publishing, 2011), 42-43, 195-197; David P. Currie, *The Constitution of the Federal Republic of Germany*, 1st ed. (University of Chicago Press, 1995), 307-310. Энэ зарчмын утга, хэрэглээг харьцуулан судалж Монгол хэлээр бичсэн дараах өгүүллийг уншихыг зөвлөж байна: Д.Гангабаатар, “Тэнцвэрийн зарчим ба Үндсэн хуулийн эрх зүй,” Эрх зүй, 2016 №1, Цуврал 33, 3-14.

4 О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт,” Ардчиллын хөгжил – иргэний оролцоо Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл дотор (2017), 91-108.

5 Туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлаж болох дээрх гол нөхцөлөөс гадна бусад нөхцөлийг Үндсэн хууль агуулсан. Жишээлбэл, тухайн эрхийг шууд хязгаарлаж болох үндэслэлийг Үндсэн хуульд нэрлэн заасан тохиолдол олон бий. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 10 дахь хэсэгт “Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно” гэж заасны дагуу Шүүхийн тухай хуулийн 53.1.1-д шүүгчийн “улс төрийн намд харьяалагдах” эрхийг хязгаарласан уу гэдэг асуулт тавьж болно. Гэвч, ийм хязгаарлалт нь тусгай нөхцөлөөс гадна гол нөхцөлийг мөн хангасан байх ёстой учраас шүүгчийг улс төрийн намд харьяалагдахыг бүхэлд нь хориглож буй нь тохирсон, зайлшгүй байх зарчимд нийцсэн эсэхийг нягтлах шаардлагатай.

6 О.Мөнхсайхан, “Хууль дээдлэх ёс: ерөнхий хандлага ба Монгол,” Эрх зүй №4 (52) (МУИС-Хууль зүйн сургууль 2020), 1-63

7 Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Улаанбаатар, 2006), 67; Б.Чимид, “Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг,” 2009, 5.

зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" гэж заасан. Энэ заалт нь амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх эрхийг хүний салшгүй эрхэд тооцож, онц болон дайны байдал зарласан үед ч хязгаарлахыг хориглосноор ач холбогдолтой. Үүний зэрэгцээ эдгээрээс бусад хүний эрх, эрх чөлөөг онц болон дайны байдал зарласан тохиолдолд хязгаарлахаар бол энэ талаар заавал хуульчлахгүй бол болохгүй гэж заажээ. Хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлах гэсэн шаардлагыг ердийн бус үед тавьж байгаа бол ердийн үед эдгээр эрх, эрх чөлөөг хязгаарлахад үүнээс доогуур шаардлага тавих боломжгүй.

Хуулийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бус, харин парламент буюу Монгол Улсын Их Хурал (УИХ) баталдаг. Явцуу утгаараа төр гэдэг бол гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газар, түүний харьяа байгууллага юм. Харин, УИХ бол ардчилсан сонгуулиар бүрдсэн, төлөөллийн дээд байгууллага юм. Парламент иргэдийг төлөөлдөг төдийгүй тогтмол явагддаг сонгуулиар сонгогчдын өмнө шууд хариуцлага хүлээдэг учраас хууль батлахдаа хүний эрх, эрх чөлөөнд дур зоргын хязгаарлалт тавихгүй байхад хүргэдэг. Мөн, хуулийн төслийг боловсруулах, санаачлах[8] төдийгүй хэлэлцэн батлах[9] үйл явц нарийн журамлагдсан, ил тод, олон нийтийн оролцоог хангасан байдаг нь хүний эрх, эрх чөлөөнд дур зоргоор хязгаарлах агуулга хуульд тусахаас сэргийлдэг.

Үндсэн эрхийг зөвхөн хуулиар хязгаарлах зарчим нь зөвхөн хуульд заасан байхаас гадна тухайн эрхийг хязгаарлах тодорхой үндэслэл, нарийвчилсан журмыг хуульчлахыг шаарддаг. Ийнхүү тодорхой, нарийвчлан хуульчлах нь хууль дээдлэх ёс, эрх зүй төрийн[10] төдийгүй Хууль тогтоомжийн тухай хуулиар[11] тавигддаг шаардлага юм. Хуульд маш ерөнхий зохицуулалт оруулж хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нь гагцхүү хуулиар хязгаарлах нөхцөлийг хангахгүй гэсэн үг.

Монгол Улсын Үндсэн хуульд хувийн өмчийг хураах, дайчлан авах, албадан хөдөлмөрлүүлэх, нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг хязгаарлах, жагсаал, цуглаан хийх (16-р зүйлийн 3, 4, 13, 16) зэргийг хуулиар зохицуулахаар заасан нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны зүгээс дур зоргоор авирлахаас хувь хүнийг хамгаалдаг. Гэвч, хуулиар тухайн эрхийг зөрчих эсхүл хууль батлагдахгүй бол тухайн эрхийг эдэлж чадахгүй болох аюултай гэж шинжээчид болон БНМАУ-ын Ардын Их Хурал (АИХ)-ын зарим гишүүн Үндсэн хууль боловсруулах, батлах үед хэлж байв.[12] Жишээлбэл, хэвлэлд хуулиар дамжуулан цензур тавихаас болгоомжилж[13] Үндсэн хуулийн төслийн 17-р зүйлийн 16-аас "хэвлэн нийтлэх"

---

[8] Хууль тогтоомжийн тухай хууль (2015)-ийг харна уу.

[9] Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг; хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг; хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг; хуулийн төслийг эцэслэн батлах гэсэн дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн баталдаг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2020)-ийг уншина уу.

[10] О.Мөнхсайхан, "Хууль дээдлэх ёс: ерөнхий хандлага ба Монгол," Эрх зүй №4 (52) (МУИС-Хууль зүйн сургууль 2020), 1-63.

[11] Хууль тогтоомжийн тухай хуулийн 30-р зүйл.

[12] P.N. Bhagwati and Reed Brody, "Assistance to the Government of Mongolia Relating to the Draft Constitution" (UN Centre for Human Rights (Advisory services and technical cooperation), June 1991), 4–5; Герман Шварц, "Монголын Их цаазын төслийн тухай," 1991.07.18, 1; Э.Бат-Үүл, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 86.

[13] Д.Баярцэнгэл, С.Баярцогт, Л.Дашням, Ж.Уртнасан, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 17,

журмыг хуулиар тогтооно гэж байсныг АИХ хассан. Харин ийм хууль нь тухайн эрхийг баталгаажуулж буй хэлбэр бөгөөд уг эрхийн агуулгыг зөрчих ёсгүй гэж ойлгосны үндсэн дээр үндсэн эрхийг хуулиар зохицуулах тухай дээр дурдсан бусад заалт хэвээр батлагдсан юм.[14] Тухайлбал, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16-д "Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно" гэж заалт хэвээр үлдсэн.

1.2 Хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлын аль нэгийг хамгаалах зорилготой байх

Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэж оруулсан. Эндээс хүний эрх, эрх чөлөөг зөвхөн эдгээр хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор л хязгаарлаж болох бөгөөд өөр бусад зорилгоор үндсэн эрхийг хязгаарлаж болохгүй гэдэг нь харагдана.

Үндэсний аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүтэн бүтэн байдлыг ноцтой эрсдэлд оруулж буй тохиолдолд л үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл болох боломжтой юм. Жишээлбэл, иргэн бүр мэдээлэл олж авах эрхтэй ч үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад зайлшгүй төрийн нууцыг хуулиар хамгаалдаг. Гэвч, үндэсний аюулгүй байдлыг хэт өргөн хүрээнд ойлгож үндсэн эрхийг хязгаарлахыг манай Үндсэн хууль зөвшөөрөхгүй.

> Эдгээр эрхийг хязгаарлах арга хэмжээг зөвхөн тухайн үндэстний оршин тогтнохуй, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг хүч хэрэглэхээс эсхүл хүч хэрэглэх заналхийллээс хамгаалах зорилгоор авч байгаа тохиолдолд л үндэсний аюулгүй байдлыг үндэслэж болно. Үндэсний аюулгүй байдлыг хууль, хэв журамд зөвхөн орон нутгийн буюу харьцангуй тусгаарлагдсан аюул заналхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд хязгаарлалт тогтоох үндэслэл болгон ашиглах боломжгүй, түүнчлэн бүрхэг эсхүл дур зоргын хязгаарлалт тавих шалтаг болгон ашиглаж болохгүй. "Үндэсний" гэдэг үг нь зөвхөн засгийн газар, дэглэм эсвэл эрх мэдлийн бүлгийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлахыг үгүйсгэдэг гэж үздэг. Хэрэв хязгаарлалт нь үймээн самуун, бусад эмх замбараагүй байдлаас зайлсхийх, эсвэл бүхэл бүтэн үндэстний амьдралд заналхийлдэггүй хувьсгалт хөдөлгөөнийг няцаах цорын ганц зорилготой бол "үндэсний аюулгүй байдал"-д үндэслэдэггүй гэж зөвлөдөг. Хязгаарлалтын ийм үндэслэл нь заримдаа "нийгмийн хэв журам" эсвэл "нийтийн аюулгүй байдал"-ын хүрээнд хамаарах боловч "үндэсний аюулгүй байдал"-д хамаарахгүй.[15]

Үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах зүй ёсны зорилгын нэг нь бусад хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхол байж болохыг Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3 дахь хэсэгт хүлээн зөвшөөрсөн. Бусад хүний эрх, эрх чөлөө гэдэгт Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг ойлгоно. Жишээлбэл, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-аар

1991.11.28, 81, 107-117.

[14] Н.Лүндээжанцан, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 93; Л.Цог, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 17, 1991.11.28, 110.

[15] Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence*, 1st ed. (Cambridge University Press, 2003), 193-194.

хүний нэр төр, алдар хүнд халдашгүй байх эрхтэй[16] учраас уул эрхийг хамгаалах үүднээс гүтгэлгийг хуулиар зохицуулдаг. Хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй боловч бусад хүнийг гүтгэх[17] замаар алдар хүндийг нь гутааж болохгүй гэсэн үг. Гэхдээ, гүтгэлгийг хуулиар зохицуулахдаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай.[18]

Нийгмийн хэв журам гэдэг нь явцуу утгаараа энх тайвныг ойлгоно. Энх тайван нь нийтээрээ тайван, амгалан, аюулгүй байх буюу хүчирхийлэл, эмх замбараагүйтэл, үймээн самуунгүй байх гэсэн энгийн утгатай юм. Жишээлбэл, тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй ч жагсаал, цуглаан нь хүний амь нас, эрүүл мэндэд шууд аюул учруулах буюу хүчирхийллийн шинжтэй байж болохгүй. Гэхдээ, хууль, хэв журам зөрчсөн бүхэн энх тайвныг алдагдуулсанд тооцогдохгүй. Жишээлбэл, "хэн нэгнийг дур мэдэн зогсоож, зөвхөн иргэний үнэмлэх авч яваагүйн улмаас баривчлахыг зөвшөөрсөн хуулийг зөрчих нь улс орны нийтийн хэв журам сахиулахад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй."[19]

Эх газрын эрх зүйн тогтолцоотой улсад "нийгмийн хэв журам" гэдгийг илүү өргөн агуулгаар ойлгох тал бий. Тодруулбал, нийгмийн хэв журамд энх тайвнаас гадна хүн амын эрүүл мэнд, нийтийн ёс суртахууныг багтаадаг.[20] Энх тайвныг өмнө тайлбарласан агуулгаар ойлгоно. Хүн амын эрүүл мэнд гэдэг нь тухайн хамтлаг (community)-ийн ерөнхий эрүүл мэнд болон түүний гишүүний хувийн эрүүл мэндийг хамгаалахыг шаарддаг. Жишээлбэл, амь насанд шууд аюул учруулах, гоц халдварт өвчийг бусад хүмүүст халдаахаас сэргийлэхэд зайлшгүй тохиолдолд тухайн халдвартай хүнийг хөл хорионд оруулах замаар чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарлах хууль байж болно.

Нийгмийн хэв журамд нийтийн ёс суртахууныг хамааруулах эсэх нь маргаантай. Үүнийг хамааруулж үзнэ гэвэл маш явцуу, тодорхой бөгөөд тэгш, олон ургалч байдал зэрэг ардчилсан нийгмийн зарчмуудад нийцүүлэн ойлгох нь зүйтэй. Жишээлбэл, цөөнхийн үзэл бодлыг, тэр дундаа нийгмийн гишүүдийн олонхыг гомдоосон, цочирдуулсан, үймүүлсэн үзэл бодлыг хамгаалах нь ардчилсан улсын хувьд онцгой чухал бөгөөд үүнийг нийтийн ёс суртахуун зөрчсөн гэж шууд хязгаарлаж болохгүй.[21] Садар самууны талаарх зохицуулалт нь нийтийн ёс суртахууныг хамгаалахад зайлшгүйгээс үүдэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавьсан хязгаарлалтын жишээ гэж үзэх нь олон тохиолддог. Гэхдээ, садар самуун мэдээллийг нийтэд түгээхийг хязгаарлах үндэслэл нь нийтийн ёс суртахуун гэхээс илүүтэйгээр тэгш эрх, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй байх үүднээс яригдах боломжтой. Ийм мэдээлэл нь нэг талаас эмэгтэй хүнийг объект болгож харуулдаг,

---

[16] О.Мөнхсайхан, "Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь," Хүний эрх (ХЭҮК, 2016), 13-22.

[17] Гүтгэх гэдэгт хүний алдар хүндийг гутаасан, фактын хувьд илт худал мэдээллийг илт худлыг нь мэдсээр байж санаатайгаар нийтэд түгээхийг ойлгоно. О.Мөнхсайхан, "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь," *Эрх зүй* №2 (38) (МУИС-Хууль зүйн сургууль 2017), 1-38.

[18] Гүтгэх гэдэгт хүний алдар хүндийг гутаасан, фактын хувьд илт худал мэдээллийг илт худлыг нь мэдсээр байж санаатайгаар нийтэд түгээхийг ойлгоно. О.Мөнхсайхан, "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь," *Эрх зүй* №2 (38) (МУИС-Хууль зүйн сургууль 2017), 1-38.

[19] Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence*, 1st ed. (Cambridge University Press, 2003), 195.

[20] John Finnis, *Natural Law and Natural Rights* (Oxford University Press, 1980), 215-218.

[21] *Hertzberg* v. *Finland*, Communication No. 61/1979, HRC 1982 Report, Annex XIV, individual opinion of Torkel Opsahl.

хүн гэж хүлээн зөвшөөрч хүндэлдэггүй байгаа учраас “эмэгтэй, эрэгтэй тэгш эрх”-тэй байхад нийцээгүй, хүүхдийн ёс суртахууны хөгжилд сөргөөр нөлөөлж, “хүүхдийн ашиг сонирхол”-ыг хамгаалахтай зөрчилддөг.

Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хууль ёсны зорилго мөн боловч эдгээрийг хэт өргөнөөр ойлгож хуульчлах буюу хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөг дур зоргоор хязгаарлахад хүргэх эрсдэлтэй. Иймээс, эдгээр хийсвэр ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, ялангуяа төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хүний эрхийг дээдлэх үзэл санаанд нийцүүлэн тайлбарлах шаардлагатай. Мөн, үндэсний аюулгүй байдал эсхүл нийгмийн хэв журам гэж юуг ойлгох вэ гэдгийг ардчилсан улсуудын сайн туршлагыг харгалзан маш явцуу, тодорхой ойлгож хуульчлах, хэрэглэх шаардлагатай.22

1.3 Хязгаарлалт нь хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод хүрэхэд тохирсон (зайлшгүй) байх

Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан АИХ-ын гишүүд “…Тодорхой хүний эрх бусад хүмүүсийн мөн тийм эрхээр харьцангуй хэмжигдэн зохицуулагдах нь нийгмийн шударга ёсонд бүрэн нийцнэ”[23] хэмээн үзэж байсан. Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед тайван жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөтэй зорчих зэрэг эрхийг эдлэхэд тавих хязгаарлалт нь ИБУТЭТОУП-ын дагуу эдгээр ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй байх тохиолдолд хуулиар тогтоосон байх гэсэн нөхцөлийг хангах шаардлагатайг НҮБ-ын шинжээчид, АИХ-ын гишүүд хүлээн зөвшөөрч, зайлшгүй, тохирсон байх тухай үзэл санааг Үндсэн хуульд тусгасан юм.[24]

Туйлын эрхээс бусад эрхэд тавих аливаа хязгаарлалт нь Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3-т дурдсан үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн хэв журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй, тохирсон байна гэдэг нь Үндсэн хуулийн хоёр үндэслэлээр нотлогддог. Нэгд, Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим юм. Хууль дээдлэх ёс буюу эрх зүйт төрийн гол шаардлагын нэг нь үндсэн эрхийн аливаа хязгаарлалт дэвшүүлсэн зорилгодоо хүрэхэд тохирсон (холбогдолтой, зайлшгүй, тэнцвэртэй) байх явдал юм.[25]

Хоёрт, Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын нэг болох “шударга ёс” юм. Шударга ёс бол өргөн агуулгатай зарчим ч үүний хамгийн түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн, эртний утгын нэг нь тохирсон байх зарчим. Энэ зарчмын дагуу аливаа арга хэмжээ нь хууль ёсны зорилгодоо хүрэхэд тохирсон байх ёстой гэсэн үг. Уламжлалт жишээ гэвэл ял шийтгэл зорилгодоо хүрэхэд зайлшгүй шаардлагатайгаас илүү хүнд, хатуу байж болохгүй гэсэн үг. Ял шийтгэл нь гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байхыг шударга ёсны зарчим хэмээн Монгол Улсын Эрүүгийн хуулиудад

---

22 International IDEA, “Limitation Clauses,” November 2014, 5.

23 Монгол Улсын Үндсэн хуулийг баталсантай холбогдуулан АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан дээр Ерөнхийлөгч П.Очирбатын хэлсэн үг, 1992.01.13, 4.

24 P.N. Bhagwati and Reed Brody, “Assistance to the Government of Mongolia Relating to the Draft Constitution” (UN Centre for Human Rights (Advisory services and technical cooperation), June 1991), 5; Б.Чимид, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 89.

25 Тохирсон байх зарчим нь ХБНГУ-ын Үндсэн хуульд нэрлэгдээгүй, дурдагдаагүй ч түүний 20-р зүйлээр хамгаалсан Эрх зүйт төрийн зарчимд багтдаг гэх тайлбар түгээмэл байдаг ажээ. David P. Currie, *The Constitution of the Federal Republic of Germany*, 1st ed. (University of Chicago Press, 1995), 309.

тодорхойлж ирсэн байдаг.[26] Үүнтэй адилхан үндсэн эрхийг хязгаарлах арга хэмжээ нь Үндсэн хуулийн 19-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгод хүрэхэд үндэслэлтэйгээр холбогдож, илүү ч үгүй, дутуу ч үгүй тохирсон байх ёстой. Тохирсон байх зарчим нь үндсэн эрхийн хязгаарлалт тавигдсан зорилгодоо үйлчлэх буюу ухаалгаар холбогдох, уул зорилгодоо хүрэхэд зайлшгүй байх, тэнцвэржсэн байх тохиолдолд хангагдана. Тухайлбал, чухал ашиг сонирхлыг хамгаалах гэдгээр үндсэн эрхийг хэт өргөн хүрээнд хязгаарлаж болохгүй, үндсэн эрхийн хэрэгжилтийг аль нэг албан тушаалтны үзэмж, дур зоргоос хамааралтай болгож болохгүй, мөн эдгээр чухал ашиг сонирхлыг хамгаалах олон янзын арга хэмжээ авах боломжтой байвал үндсэн эрхэд хамгийн бага халдах арга хэмжээг сонгох зэрэг тодорхой шаардлагыг тохирсон байх зарчим илэрхийлдэг. Мөн, үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журам гэсэн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлага болон хөндөгдөж буй эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоёрын тэнцвэрийг олохыг энэ зарчим шаарддаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зүгээс тохирсон байх зарчмыг нэрлээгүй ч түүний агуулгыг баримталсан шийдвэр гаргаж байсан. Эдгээр шийдвэрээс хоёрыг нь танилцуулъя. Нэгд, “ажил нь тасалдсаны улмаас иргэдийн амь бие, эрүүл мэндэд аюул учирч болох бусад байгууллага, ... ажил нь зогсвол ихээхэн аюулд хүргэж болох тасралтгүй ажиллагаатай бусад үйлдвэрийн газар, байгууллагад ажил хаяхыг хориглоно” гэх мэтээр ажил хаяхыг хориглосон субъектүүдийг хэт өргөтгөсөн заалтууд” нь ажил хаях эрхийг зөрчсөн гэж Цэц дүгнэсэн.[27] Энэ дүгнэлтээс үзвэл ажил хаях эсхүл бусад үндсэн эрхэд тавьж буй аливаа хязгаарлалт хэр өргөтгөсөн буюу тохироогүй байвал тухайн эрхийг зөрчинө гэсэн үг. Хоёрт, Үндсэн хуулийн цэц дараах дүгнэлт, тогтоолоороо улс төрийн нам шинээр байгуулах, намын нэрийг чөлөөтэй сонгох, хэрэглэх эрхийг хамгаалсан:

> 1.Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон хязгаарлалт хийсэн нь иргэдийн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхэд халдсан шинжийг агуулжээ. Намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж үзвэл дээрх хуулиар тогтоосон хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон байна.[28]

Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх гэдэг бол тухайн зорилгодоо хүрэхээс хэтрүүлэн хязгаарлаж болохгүй гэсэн үг юм. Цэцээс тохирсон

[26] Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд буй “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт 5400-27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь уг гэмт хэргийн онц хүнд шинжид тохирохгүй ял шийтгэл юм. “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж” (2016), §9; “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит зургаа дахь илтгэлийг хэлэлцээд гаргасан Хүний эрхийн хорооны дүгнэлт” (2017), §21.

[27] Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 6, 2005.09.29; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 1, 2005.11.14.

[28] Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 2, 1993.04.21.

байх зарчмыг агуулгаар нь хэрэглэсэн энэ мэт тохиолдол бий ч уул зарчмыг бүрэн гүйцэд, нарийвчлан тайлбарлаж үндсэн эрхийн хязгаарлалттай холбоотой маргаан бүр дээрээ хэрэглэдэг жишиг тогтоох нь нэн чухлаар тавигдаж байна.

Туйлын эрхээс бусад үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь хууль ёсны аль нэг зорилгод хүрэхэд тохирсон, зайлшгүй байх зарчим бол Монгол Улсад хамгийн их орхигддогийн улмаас үндсэн эрх зөрчигдөхөд хүргэдэг гэдгийг гурван талаас нь харуулъя.

Нэгд, тохирсон байх зарчмыг зарим хууль тогтоомжид тусгасан ч шүүхээс эсхүл бусад этгээдээс хэрэглэх нь бага. Жишээлбэл, шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх төдийгүй үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тухайн нөхцөлд тохирсон, тодорхой хүрээ, хугацаатай байх зэрэг шаардлагыг нэг мөр хангахаар хуульчилсан.[29] Гэвч, Ковид-19 цар тахлын үед чөлөөтэй зорчих, сурч боловсрох зэрэг үндсэн эрхэд тавьсан хязгаарлалт нь эдгээр шаардлагыг, ялангуяа тохирсон, зайлшгүй байх нөхцөлийг хангаагүй гэж үзэхээр тохиолдол олон гарсан[30] ч эдгээр зөрчлийг уул шаардлагын үүднээс шүүх хянан үзэж шийдвэрлэсэн нь ховор байна.[31]

Хоёрт, үндсэн эрхэд хязгаарлалт тавьсан хууль тогтоомжид тохирсон байх зарчмыг тусгахгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай,[32] Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай[33] зэрэг хуулийн төсөл хэлэлцэгдэж байхад уул зарчмыг тусгах санал өгөгдөж байсан ч хүлээж аваагүй юм. Тохирсон байх зарчмыг хуульчлаагүйгээс үндсэн эрхийн зөрчил гарч байна. Жишээлбэл, Нийслэлийн засаг даргын 2017.01.09-ний А/17 дугаар захирамжаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай болон Улаанбаатар хотод орон сууц худалдан авснаас бусад хөдөө, орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг” 2018.01.01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр зогсоосон бөгөөд Нийслэлийн засаг даргын 2017.12.27-ны А/1042 дугаар захирамжаар уул хугацааг 2020.01.01 хүртэл сунгасан нь орон нутагт оршин суугч иргэдийн “түр буюу байнга оршин суух газраа сонгох” эрхийг хязгаарласан байна. Үндсэн хуулийн 16.2-т заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эсхүл бусад үндсэн эрхийг хамгаалахад зайлшгүй тохиолдолд оршин суух газраа сонгох эрхийг зөвхөн хуулиар хязгаарлахыг үгүйсгэхгүй. Гэвч, Нийслэлийн засаг даргын 2017 оны А/17, А/1042 дугаар дугаар захирамжууд нь байнга оршин суух газраа сонгох эрхийг хязгаарлахыг зөвшөөрсөн хуулийн тодорхой үндэслэлгүйгээр гарсан. Мөн, энэ хязгаарлалт нь Нийслэлийн оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны

---

[29] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10-р зүйлийн 10.9, 10.10 дахь хэсэг; Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11-р зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг.

[30] Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл (ХЭҮК, 2020).

[31] Жишээлбэл, тохирсон байх зарчмыг дараах маргаан дээр хэрэглэх боломжой бөгөөд шаардлагатай байсан ч шүүх уул зарчмын талаар дурдаа ч үгүй байна: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, Дугаар 12, 2022.05.03.

[32] “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх шүүмж,” Нээлттэй Нийгэм Форум, 2017.05.02

[33] “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас өгсөн зөвлөмж” (2020), §78; Nomin & Advocates, “Хувь хүний нууц, холбогдох мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин болон практикийн судалгаа,” судалгааны тайлан (2021 оны 1 сар)

бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах зорилготой байсан ч уул зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байсан эсэх нь эргэлзээтэй байв. Учир нь, "Нийслэл хотод байнга оршин суух шилжилт хөдөлгөөнийг зогсоосон шийдвэр нь хотод шинээр шилжин ирэгсдийн тоог дорвитой бууруулж чадаж байна уу, аль эсвэл хотын бүртгэлгүй оршин суугчдын тоог хязгаарлаж чадаж байна уу гэдэг нь тодорхойгүй" бөгөөд энэ хязгаарлалтаас болж шилжин ирсэн иргэд "Хотод албан ёсоор оршин суух бүртгэлгүйн улмаас хорооноос мэдээлэл авах, сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй болдог," "тогтвортой ажлын байртай болоход хүндрэлтэй байдаг"[34] зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байна. "Шилжилт хөдөлгөөнийг зогсоосон нэг жилийн хугацаанд буюу 2017 оны 11 дүгээр сарын байдлаар орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар 9567 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11552-оор цөөн байсан" гэдэг.[35]

Гуравт, хууль тогтоомж дахь тохирсон байх зарчмыг зөрчсөн шинжтэй заалтууд байна. Жишээлбэл, халдашгүй, чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, чөлөөтэй зорчих, эвлэлдэн нэгдэх зэрэг үндсэн эрх, эрх чөлөөнд хэт өргөн, хэт ерөнхий, хэт бүрхэг хязгаарлалт одоогийн олон хуулиар тавиад зогсохгүй Шашин шүтэх эрх чөлөөний тухай, Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдэд оруулсан байна.[36] Эдгээрээс жишээ болгож цөөнийг нь танилцуулъя. Юуны өмнө, Иргэний улсын бүртгэлийн тухай 2018 оны хуулийн 12.4-т "Иргэн өөрийн нэрийг нэг удаа өөрчилж болно" гэж заасан нь иргэн өөрийн нэрийг нэгээс илүү удаа өөрчлөхгүй байх ерөнхий хориглолт байна. Хувийн халдашгүй байх эрхийн чухал хэсэг болох хувийн онцлог шинжээ тодорхойлох, холбогдох шийдвэр гаргах эрхийг ерөнхийд нь ингэж хязгаарлаж буй нь аль хууль ёсны зорилгод үйлчилж буй эсэх тодорхойгүй, тэдгээр зорилгын аль нэгд хүрэхэд зайлшгүй, тохирсон биш байна. Мөн, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу тайван жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг Засаг дарга бүртгүүлэхээс татгалзах боломжтой тогтолцоо бол үнэндээ зөвшөөрлийн тогтолцоо мөн. Энэ тогтолцоо нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам гэсэн чухал ашиг сонирхлыг хамгаалахад тохирсон, зайлшгүй арга хэмжээ биш учраас жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчдөг.[37]

Улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх зэрэг шашны байгууллагын үйл ажиллагаа явуулахыг холбоо, санд хориглож, уг хориглолтыг зөрчвөл Зөрчлийн хуулиар торгох төдийгүй татан буулгахаар хуулийн төсөлд зохицуулжээ.[38] Холбоо, сан нь тайван жагсаал, цуглаан хийх зэрэг улс төрийн намын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн[39] эсхүл үйл ажиллагаандаа аль нэг шашны сургаалаас тайлбарлаж хэрэглэсэн бол татан буугдаж, торуулах эсхүл урвуулан ашиглагдах эрсдэлтэй байна. Эдгээр хориглолт Үндсэн хуулийн 19.3-т заасан аль

[34] Гэр хорооллын зураглал төв, Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа оролцоонд тулгуурласан чанарын судалгаа (Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, 2018), vii, 55.

[35] "Нийслэлд ирэх шилжилт хөдөлгөөнийг 2020 он хүртэл зогсооно," https://zasag.mn/news/view/18720

[36] О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа) (УБ 2021).

[37] О.Мөнхсайхан, "Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт," "Ардчиллын хөгжил – Иргэдийн оролцоо" ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл (УБ, 2017), 91-108.

[38] Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 9.1, 31.1.3, 31.4; Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7.1, 24.1.3, 24.2, 24.4.

[39] Жагсаал, цуглаан хийх нь улс төрийн намын үйл ажиллагаа мөн. Улс төрийн намын тухай хуулийн 14.1.2-д зааснаар нам нь жагсаал, цуглаан болон бусад үйл ажиллагааг хуулийн хүрээнд санаачлан зохион байгуулах зэрэг эрхтэй.

зорилгод үйлчилж буй эсэх ойлгомжгүй, хэт ерөнхий тул урвуулан ашиглагдах боломжтой, Үндсэн хууль болон олон улсын стандартад нийцэхгүй байна. Төр хууль ёсны зорилгод хүрэхэд эвлэлдэн нэгдэх эрхийг хуулиар хязгаарлаж болох боловч хамгийн бага хязгаарлах замыг сонгох үүрэгтэй. “Хүний эрхийн Европын шүүхийн олон удаагийн шийдвэрийн дагуу хуулийг ноцтой зөрчсөн эсхүл хүчирхийлэл үйлдэх сүрдүүлсэн зэрэг үйл ажиллагаанд холбоо оролцох зэрэг тохиолдолд түүнийг хориглох, татан буулгах нь хамгийн сүүлийн арга зам байх хэрэгтэй,” “тохирсон байх зарчим нь жижиг зөрчилд хориглох, татан буулгах арга замыг хэрэглэж ерөөсөө болохгүй.”[40]

1.4 Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх

Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол “эрх чөлөө” гэж заасан. Эрх чөлөөний зарчим бол үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, үндсэн эрхийг зайлшгүй тохиолдолд хязгаарлаж болох ч тэрхүү хязгаарлалт нь тухайн эрхийн агуулгыг бүрэн үгүйсгэхгүй байх, хуулийн талаарх өөрөөр тайлбаруудаас үндсэн эрхэд илүү нийцэнийг нь хэрэглэх зэрэг олон утгыг багтаадаг. Мөн, хуулиар илэрхий хориглоогүй бол тухайн эрхийг эдэлнэ гэсэн презүмц (presumption - презумци)[41] үйлчлэх ёстой. “Хуулиар хориглоогүй бүхэн зөвшөөрөгдөнө” гэсэн үг. Эрх чөлөө бол байнга хөгжих өргөн агуулгатай зарчим тул түүнийг энд дурдсан жишээгээр хязгаарлагдаж болохгүй.

Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх нөхцөлийн зөрчигдөж байсан жишээ олон бий. Тухайлбал, цаазаар авах ял нь хүний амьд явах, хүний нэр төр халдашгүй байх, эрүүл шүүлтээс ангид байх эрхийн агуулгыг бүрэн үгүйсгэдэг байсан учраас уул ялыг бүрэн халахыг Монгол Улсын Үндсэн хууль шаарддаг. Иймд, цаазаар авах ялыг түдгэлзүүлж, улмаар Эрүүгийн хуулиас халсан нь чухал шинэчлэл болсон юм.[42] Мөн, Үндсэн хуулийн цэц дараах дүгнэлт, тогтоолоороо нам сонгуульд оролцох эрхийн цөмийг хамгаалсан юм:

> 2.Аливаа нам үүсэн байгуулагдаж Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байхад түүнийг 18 сарын дараа төрийн сонгуульд оролцуулахаар хуульчилсан нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна. Улс төрийн намууд Улсын Дээд шүүхэд бүртгүүлж гэрчилгээ авснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд энэхүү үйл ажиллагааны гол хэсэг нь улс төрийн сонгуульд оролцох явдал мөн.

Сонгох, сонгогдох, эвлэлдэн нэгдэх эрхийн хүрээнд багтах үйл ажиллагааны гол хэсэг нь улс төрийн сонгуульд оролцох явдал. Үүнийг үгүйсгэх нь уул эрхийн зөрчил болно гэсэн үг.

1.5 Ялгаварлан гадуурхахгүй байх

Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь хэнийг ч ялгаварлан гадуурхсан шинжтэй байж болохгүй. Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол “тэгш байдал,” уг хуулийн 14-р зүйлд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхлаас ангид байх эрхийг

---

[40] OSCE/ODIHR and Venice Commission, *Guidelines on Freedom of Association* (2015), 45.

[41] Энэ ойлголтыг илэрхийлсэн Монгол үг байхгүй учраас Монгол хэлний галигт тохируулан буулгах саналтай байна.

[42] О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хууль ба цаазаар авах ял,” Эрх зүй №3 (43), (МУИС-Хууль зүйн сургууль 2018), 1-63.

хамгаалсан. Иймд, хүний үндсэн эрхийг ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүрт эдлүүлэх ёстой. Тодруулбал, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Төр өөрөө ийм ялгаварлан гадуурхал үйлдэж болохгүй төдийгүй бусад хувь хүн, хуулийн этгээдээс үзүүлж буй ялгаварлан гадуурхлыг зогсоох үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэхгүй бол ялгаварлан гадуурхлаас ангид байх эрхийг зөрчинө.

Үндсэн эрхийн хязгаарлалт нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байвал Үндсэн хуульд харш гэж Үндсэн хуулийн цэц хэд хэдэн удаа шийдвэрлэсэн. Жишээлбэл, шашин шүтлэг,[43] нас,[44] ажил, албан тушаал,[45] хөрөнгө чинээ[46] зэрэг дурдагдсан шинжээр ялгавар гадуурхсан заалтыг Үндсэн хуулийн 14-р зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэж байжээ. Мөн, Үндсэн хуулийн 14-р зүйлийн 2 дахь хэсэгт дурдагдаагүй шинжээр ч ялгаварлан гадуурхсан хязгаарлалтыг хийж болохгүй юм. Жишээлбэл, Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5-д "… хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан… бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасны "... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан..." гэсэн хэсэг нь "хөгжлийн бэрхшээлтэй хүний жагсаал, цуглаанд сайн дураараа нэгдэх, оролцох эрхийг хязгаарлах боломжийг бүрдүүлэхээр байх" тул Үндсэн хуулийн 1.2-ын "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", 10.2-ын "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ," 14.1-ийн "...хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна," 14.2-ын "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна," 16.16-ын "...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй," 19.1-ийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх…" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж Цэц шийдсэн.[47] Энэ дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалаад зогсохгүй Үндсэн хуулийн 14.2-т нэрлэн заагаагүй шинжээр ч хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Тиймээс, хөгжлийн бэрхшээл төдийгүй бэлгийн чиг баримжаа, биеийн жин зэрэг шинжээр нь хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй.

1.6 Хараат бус шүүхээр хянагддаг байх

Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т "шударга шүүхээр шүүлгэх" эрхтэй гэж заасан. Энэ нь хүний эрхийг хязгаарласан аливаа арга хэмжээ хуульд заасан үндэслэл, журмаар авагдсан уу, үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам гэсэн чухал ашиг сонирхлыг хамгаалахад тохирсон (зайлшгүй) уу зэргийг шүүхээр хянуулах гэсэн агуулгатай.

Үндсэн эрхэд шүүхийн бус замаар халдах нь хууль дээдлэх зарчмыг зөрчинө гэж Цэц шийдсэн. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 57-р зүйлийн 57.6 дахь хэсгийн

---

43 Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 02, 1994.01.12.

44 Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 04, 1996.05.29; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2005.12.14; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 01, 2010.03.24. Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 07, 20.

45 Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 02, 1998.02.24; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2005.12.14; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 02, 2012.02.15; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 03, 2014.03.12; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 12, 2015.09.30.

46 Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт, 01, 1998.01.28; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 01, 1998.06.17; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 03, 2002.11.13; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2006.06.15.

47 Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 07, 2017.11.29.

“Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум буюу сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан байв. “Хөрөнгийг улсын орлого болгох тухай шийдвэрийг Сонгуулийн төв байгууллага шууд гаргаж байгаа нь бусдын өмчлөх эрхэнд шүүхийн бус замаар халдсан” учраас УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 57-р зүйлийн 57.6 дахь хэсэг нь Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсгийн “…шударга ёс, …хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн гэж Цэц 2006 онд шийдвэрлэсэн.[48] Цэцийн энэ шийдвэрийн үр дүнд УИХ-ийн сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийг “Сонгуулийн ерөнхий хороо нь холбогдох хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 40.7, 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох тухай нэхэмжлэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд гаргах бөгөөд шүүх уг асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ” гэж 2006.06.16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулжээ.

Дээрх шийдвэртээ Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт буй шударга ёс болон хууль дээдлэх зарчим нь өмчлөх эрхэд шүүхийн бус замаар халдахыг хориглодог гэж Цэц дэлгэрүүлэн тайлбарлажээ. Хөрөнгийг улсын орлого болгох асуудал нь Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-ын өмчлөх эрхийг хязгаарлаж буй тул шүүхээр шийдвэрлэгдэх ёстой гэж шийдсэн гэсэн үг. Өмчлөх эрхтэй нэгэн адил түвшинд Үндсэн хуулиар хамгаалагдсан бусад үндсэн эрхийг хязгаарлах эсэхийг ч зөвхөн шүүх шийднэ, үгүй бол шударга ёс, хууль дээдлэх зарчим зөрчигдөнө. Өмчлөх эрх болон бусад үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль заасан үндэслэл, журмаар зүй ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй хэмжээнд хийгдсэн эсэхийг зөвхөн хараат бус, төвийг сахисан, шударга шүүх л шийдвэрлэх зохистой. Иймд, шударга ёс болон хууль дээдлэх зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах эсэхийг шүүх шийдвэрлэх буюу уг асуудал шүүхийн хяналтад байхыг шаарддаг гэсэн ерөнхий зарчмыг Цэц хүлээн зөвшөөрснөөрөө ач холбогдолтой.

Туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хууль ёсны зорилгод хүрэхэд тохирсон, зайлшгүй тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болдог бөгөөд уул хязгаарлалт нь үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хараат бус шүүхээр хянагддаг байх шаардлагатай. Өгүүлэлд танилцуулсан эдгээр зургаан нөхцөл бол үндсэн эрхийг хязгаарлахад Монгол Улсын Үндсэн хуулиар тавьж буй наад захын гол нөхцөлүүд. Үндсэн хууль эдгээр зургаан нөхцөлийг зургуулааг зэрэг хангаснаас бусад тохиолдолд үндсэн эрхийг хязгаарлахыг хориглодог бөгөөд аль нэгийг нь хангаагүй бол үндсэн эрхийн зөрчил болох магадлалтай. Хүний туйлын эрхээс бусад үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахад энэ зургаан нөхцөлийг бүгдийг нь бүрэн хангасан байх ёстой. Гэвч, халдашгүй чөлөөтэй байх, шударга шүүхээр шүүлгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, чөлөөтэй зорчих, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх, сонгох, сонгогдох зэрэг эрхийг зөрчиж буй суурь шалтгааны нэг нь үндсэн эрхийг хязгаарлахад Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу заавал баримтлах гол нөхцөлүүдийг хангаагүйгээс үүддэг.

[48] Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 5, 2006.05.31.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
3. Улс төрийн намын тухай хууль

Ном товхимол, гарын авлага, судалгааны материалууд:

1. Д.Гангабаатар, “Тэнцвэрийн зарчим ба Үндсэн хуулийн эрх зүй,” Эрх зүй, 2016 №1, Цуврал 33
2. О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт,” Ардчиллын хөгжил – иргэний оролцоо Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл дотор (2017), 91-108.
3. О.Мөнхсайхан, “Хууль дээдлэх ёс: ерөнхий хандлага ба Монгол,” Эрх зүй №4 (52) (МУИС-Хууль зүйн сургууль 2020), 1-63
4. Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Улаанбаатар, 2006), 67; Б.Чимид, “Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг,” 2009, 5.
5. О.Мөнхсайхан, “Хууль дээдлэх ёс: ерөнхий хандлага ба Монгол,” Эрх зүй №4 (52) (МУИС-Хууль зүйн сургууль 2020), 1-63.
6. Д.Баярцэнгэл, С.Баярцогт, Л.Дашням, Ж.Уртнасан, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 17, 1991.11.28, 81, 107-117.
7. Н.Лүндээжанцан, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 93; Л.Цог, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 17, 1991.11.28, 110.
8. О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь,” Хүний эрх (ХЭҮК, 2016), 13-22.
9. О.Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь,” Эрх зүй №2 (38) (МУИС-Хууль зүйн сургууль 2017), 1-38
10. Монгол Улсын Үндсэн хуулийг баталсантай холбогдуулан АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан дээр Ерөнхийлөгч П.Очирбатын хэлсэн үг, 1992.01.13, 4.
11. Нийслэлд ирэх шилжилт хөдөлгөөнийг 2020 он хүртэл зогсооно,” https://zasag.mn/news/view/18720
12. О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа) (УБ 2021).
13. О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт,” “Ардчиллын хөгжил – Иргэдийн оролцоо” ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл (УБ, 2017), 91-108.
14. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 9.1, 31.1.3, 31.4; Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7.1, 24.1.3, 24.2, 24.4.
15. О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хууль ба цаазаар авах ял,” Эрх зүй №3 (43), (МУИС-Хууль зүйн сургууль 2018), 1-63.
16. Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 01, 02, 04, 05 ,07
17. Гамшгаас хамгаалах тухай хууль
18. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл (ХЭҮК, 2020).

19. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, Дугаар 12, 2022.05.03.
20. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх шүүмж,” Нээлттэй Нийгэм Форум, 2017.05.02
21. “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас өгсөн зөвлөмж” (2020), §78; Nomin & Advocates, “Хувь хүний нууц, холбогдох мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин болон практикийн судалгаа,” судалгааны тайлан (2021 оны 1 сар)
22. Гэр хорооллын зураглал төв, Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа оролцоонд тулгуурласан чанарын судалгаа (Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, 2018), vii, 55.

Гадаад хэлээр

1. Proportionality: New Frontiers, New Challenges, edited by Vicki C. Jackson and Mark Tushnet (Cambridge University Press, 2017); Warner Heun, The Constitution of Germany: A Contextual Analysis, Constitutional Systems of the World (Hart Publishing, 2011), 42-43, 195-197; David P. Currie, The Constitution of the Federal Republic of Germany, 1st ed. (University of Chicago Press, 1995), 307-310.
2. P.N. Bhagwati and Reed Brody, “Assistance to the Government of Mongolia Relating to the Draft Constitution” (UN Centre for Human Rights (Advisory services and technical cooperation), June 1991), 4–5; Герман Шварц, “Монголын Их цаазын төслийн тухай,” 1991.07.18, 1; Э.Бат-Үүл, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 86.
3. Nihal Jayawickrama, The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence, 1st ed. (Cambridge University Press, 2003), 193-194.
4. John Finnis, Natural Law and Natural Rights (Oxford University Press, 1980), 215-218.
5. Hertzberg v. Finland, Communication No. 61/1979, HRC 1982 Report, Annex XIV, individual opinion of Torkel Opsahl.
6. International IDEA, “Limitation Clauses,” November 2014, 5.
7. P.N. Bhagwati and Reed Brody, “Assistance to the Government of Mongolia Relating to the Draft Cnstitution” (UN Centre for Human Rights (Advisory services and technical cooperation), June 1991), 5; Б.Чимид, АИХ-ын хуралдааны протокол, Дугаар 16, 1991.11.27, 89.
8. David P. Currie, The Constitution of the Federal Republic of Germany, 1st ed. (University of Chicago Press, 1995), 309.
9. OSCE/ODIHR and Venice Commission, Guidelines on Freedom of Association (2015), 45.

БҮЛЭГ 2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ

СЭДЭВ 1. ПРОКУРОРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

1.1 Прокурорын мэргэжлийн тухай ойлголт
1.2 Прокурорын хяналт, зорилго, ач холбогдол
1.3 Прокурорын үйл ажиллагааны зарчмууд, тэдгээрийн үзэл баримтлал
1.4 Прокурорын байгууллагын тогтолцоо, онцлог тал

СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ

2.1 Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт
2.2 Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт
2.3 Шүүхэд төрийг төлөөлөх
2.4 Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт
2.5 Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь


СЭДЭВ 1. ПРОКУРОРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

1.1 Прокурорын мэргэжлийн тухай ойлголт[1]

Францын прокурор (procureur) хэмээх үг нь “procurer” гэх үйл үгнээс үүссэн нэр үг юм. Энэ үйл үг нь латин хэлний “procurare” гэх үгнээс гаралтай. Франц энэ үйл үг нь Монголоор “хүргэх, олгох, хангах” гэж орчуулагдана. Гэхдээ латин үйл үг нь Францаар “procurer” гэх үйл үгний утгыг илэрхийлэхээс илүүтэй Францаар “diriger”, “soigner”, ”s›occuper de” гэсэн удирдах, асрах, халамжлах, элбэрэл, арчлах, ажиллах, гүйцэтгэх, хийх гэсэн утгатай үгээр буудаг. Латин “procurare” гэх үг нь оросоор “управлять, ведать, чем-либо, заботиться” гэсэн утгыг илэрхийлнэ. Монголоор “удирдах, захирах, эрхлэх” (управлять), “мэдэх, эрхлэх, захирах” (ведать), “халамжлах, санаа тавих, элбэрэх, арчлах” (заботиться) гэж орчуулагдана.

Германаар “Staatsanwalt” англиар “prosecutor” гэх бөгөөд “procurare” гэх латин үгнээс прокурор хэмээх нэр үг эх үүсэлтэй ажээ.

1.2 Прокурорын хяналт, зорилго, ач холбогдол



[1] Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа, 2022 он

Прокурор нотлох баримтыг өөрийн мэдлэг чадвар, оюун санаа, хүсэл зоригийн чанаруудад тулгуурласан дотоод итгэлээрээ үнэлэх нь сэтгэл зүйн өвөрмөц үйл явц юм.

Прокурорын дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага ч биш хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг зөв тодорхойлж эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар хуульчийн мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил бөгөөд уг итгэл үнэмшлээ хуульд нийцүүлж гаргасан шийдвэрээр баталгаажуулж байдаг[2].

Аливаа үйл баримтад /хүсэлт, гомдол, зөрчлийн болон эрүүгийн хэргийн материал, шүүх хуралд оролцож дүгнэлт гаргах, хүний эрхийн хяналт шалгалт гэх мэт/ прокурорын хяналт гэж ойлгоно.

Шүүх эрх мэдлийн байгууллагын нэр хүндийн нэг гол шалгуур нь прокурорын шийдвэрийн бодит үндэслэл буюу прокурор дотоод итгэлд тулгуурлаж тухайн үйл баримтад өгч буй хууль зүйн шинжлэх ухааны онол, арга зүй, хуулийн хэрэглээг хослуулан гаргасан хууль зүйн дүгнэлт бөгөөд уг шийдвэрийн хүчин чадал нь тухайн шийдвэрийн хөдөлбөргүй байдал, шийдвэр хэлбэрэлтгүй хэрэгждэгт оршдог. Энэ утгаараа прокурор нь тухайн шийдвэрлэж буй асуудлын нөхцөл байдлыг таамгаар хуульд нийцүүлэгч бус нийгмийн шударга ёсыг бодитойгоор хэрэгжүүлэгч, түүний бодит баталгаа болж байдаг.

1.3 Прокурорын үйл ажиллагааны зарчмууд, тэдгээрийн үзэл баримтлал

Прокурорын тухай хуульд зааснаар прокурор үйл ажиллагаандаа дараах 5 зарчмыг баримтална:[3]

1. Хуулийг нэг мөр хэрэглэх;
2. Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах;
3. Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;
4. Хараат бус, бие даасан байх;
5 .Ил тод, нээлттэй байх.

➢ **Хуулийг нэг мөр хэрэглэх /Прокурорын тухай хуулийн 4 дүгээр зүйл/**

4.1.Прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангана.

4.2.Прокурорын үйл ажиллагааг хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, аргачилсан зааврааар нарийвчлан зохицуулна.

Прокурор шийдвэр гаргахдаа тухайн үйл баримтыг эрх зүйн онол, олон улсын гэрээ конвенц болон салбар хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм зэрэгт тулгуурлан дүгнэлт хийх бөгөөд, хуулийн зүйл, заалтыг хуулж бичих нь шийдвэр ойлгомжгүй болох эрсдэлийг бий болгодог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Улсын Ерөнхий прокурорын баталсан аргачилсан зааварт прокурорын шийдвэрийн төрөл, үндэслэл, агуулгыг тусгасан байдгийг анхаарвал зохино.

Хуульд нийцээгүй буюу хууль зөрчиж гаргасан эрх зүйн актын талаар дүгнэлт хийхдээ тухайн акт нь ямар хуулийн ямар зүйл хэсэг эсхүл хуулийн ямар зарчимтай

[2] Б.Өнөрмаа, “Шүүгчийн дотоод итгэл ба нотлох баримтыг үнэлэх ажиллагаа” 2018 он. https://www.mglbar.mn/news/2640

[3] Прокурорын тухай хууль, 2017 он

зөрчилдөж байгааг үндэслэл бүхий тайлбарлан нотолсон байна. Энэ нь тухайн үйл баримтад хамаарах эрх зүйн зохицуулалтыг эх сурвалж, агуулгаар нь тайлбарлахад орших бөгөөд энэ нь прокурорын шийдвэрийн үндэслэл хэр бодитой болсон эсэхийг харуулдаг, гарах шийдвэрийн суурь нь болдог.

Талууд нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэх эсхүл нотлох баримтаас гарах дүгнэлтийн талаар харилцан өөр байр суурьтай бол прокурор эдгээр асуудлыг дүгнэж, ямар шийдвэрт хүрсэн тухай заана. Талуудын үндэслэлийг шийдвэрт тэр бүр бүхий л нотлох баримтыг иш татах шаардлага байдаггүй бөгөөд эдгээрийн зарим нь ач холбогдолтой байхад зарим нь ач холбогдол багатай байна. Гэвч, тодорхой нөхцөл байдалд хэрэгт талуудын гаргасан нотлох баримтууд харилцан эсрэг байр суурьтай байвал алийг нь хэрхэн, ямар шалтгаанаар ач холбогдолтой эсхүл үнэн зөв байх боломжтой гэж үзэж байгааг шийдвэртээ зааж, прокурор эсрэг тэсрэг байр сууринаас аль нэгийг сонгох үүрэг хүлээнэ. Тухайлбал, хэрэв нэг гэрчийн мэдүүлгийг нөгөө гэрчийн мэдүүлгээс илүүд үзэж байгаа бол прокурор өөрийн шийдвэрт тухайн мэдүүлэг нотолгооны хувьд ач холбогдолтой гэж үзсэн үндэслэлээ бичнэ. Шийдвэрт тусгагдсан нотлох баримтын үнэлгээ нь нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэх, мөн нотлох баримтын эзлэх хувийн жинг харгалзан үзнэ.

Ялангуяа хууль эрх зүйн орчин нөлөөлсөн бол тухайн хуулийг зүйл хэсгийг агуулгатай нь тогтоолд тусгаснаар тухайн шийдвэрийг итгэл үнэмшилтэй харагдуулна.

- **Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах / Прокурорын тухай хуулийн 5 дугаар зүйл /**

5.1.Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авна.

Прокурорын шийдвэр гаргахдаа[4] :

-аливаа үйл баримтын мөн чанар, тухайн үйл баримтад холбогдогч, оролцогч, хамааралтай хүмүүсийн эсрэг тэсрэг сонирхлын агуулга, сэдэлт, зорилгыг танин мэдэж,

-үйл баримтыг бий болгосон шалтгаан, нөхцөл болон шууд ба шууд бус нөлөөлөл, хүчин зүйл,

-гэм буруутайд тооцогдсон хүн, нөгөө талд хохирогч эсхүл хохирогчийн зүй бус харьцаа, үйлдлээс шалтгаалсан нөхцөл байдлыг бүхэлд нь авч үзэн дүгнэлт гаргах нь хохирогч иргэний нэхэмжлэгчийг зөв тогтоох, сэжигтэн, яллагдагч хуульд заасан эрхээ бүрэн эдлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг бүрэн тогтоох, түүнийг гэм буруутай хүн, хуулийн этгээдээс гаргуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлдэг.

Прокурорын хуульд заасан чиг үүрэгт иргэн, хуулийн этгээд, хэргийн оролцогчтой харилцах мөн хууль сахиулах байгууллагын ажилтан, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэр, хүний эрхийг хязгаарлах объектуудад хяналт шалгалт хийх ажиллагаа хамаарах бөгөөд энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

- **Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх /Прокурорын тухай хуулийн 6 дугаар зүйл/**

[4] Б.Өнөрмаа, “Шүүгчийн дотоод итгэл ба нотлох баримтыг үнэлэх ажиллагаа” 2018 он. https://www.mglbar.mn/news/2640

6.1.Прокурор дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцна. Прокурор дээд шатны прокурорын хууль ёсны шийдвэр, даалгаврыг заавал биелүүлнэ.

6.2.Дээд шатны прокурор прокурорын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх, хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, буцаан авах эрхтэй.

6.3.Хуульд өөрөөр заагаагүй бол дээд шатны прокурорын тодорхой бүрэн эрхийг Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр бусад прокурорт шилжүүлж болно.

6.4.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор, аймаг, нийслэл, дүүрэг, сум буюу сум дундын, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурорыг дээд шатны прокурор гэж ойлгоно.

Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвхөн хуульд захирагдах ба дээд шатны прокурорын өмнө ажлаа тайлагнахаас гадна дээд шатны прокурорын хууль ёсны шийдвэр, даалгаврыг биелүүлнэ. Мөн прокурорын байгууллагын хэрэгжүүлж буй бодлого, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална.

- **Хараат бус, бие даасан байх / Прокурорын тухай хуулийн 7 дугаар зүйл /**

7.1.Прокурор шийдвэрээ хуульд нийцүүлэн хараат бусаар гаргана.

7.2.Прокурорын шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад нь хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

7.3.Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд албан тушаалтан, хүн, хуулийн этгээд хууль бусаар нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Прокурор шийдвэр гаргахдаа зөвхөн хуульд захирагдах бөгөөд өөрийн дотоод итгэлээр нотлох баримтад тулгуурлан шийдвэрээ гаргана. Прокурорын хараат бус байдал нь прокурорын хувьд хангагдах ёстой эрх төдийгүй биелүүлэх, мөрдөх ёстой үүрэг, хариуцлага юм.

Улс төрийн нөхцөл байдал, цахим орчин дахь мэдээлэл зэрэг нь прокурорын хараат бус байдалд шууд бусаар нөлөөлөх эрсдэлтэй хүчин зүйлд тооцогддог бол шууд нөлөөлөх хүчин зүйлд хувийн харилцаа, ашиг сонирхол, ёс зүй багтдаг.
Прокурор хараат бус байх нь тухайн прокурорын мэргэжлийн ур чадвар ёс зүйгээс шууд хамааралтай юм.

- **Ил тод, нээлттэй байх /Прокурорын тухай хуулийн 8 дугаар зүйл /**

8.1.Хуулиар нууцлахаар тогтоосноос бусад асуудлаар гаргаж байгаа прокурорын шийдвэр ил тод байна.

8.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх болон хуулиар хориглосноос бусад тохиолдолд прокурор, түүний зөвшөөрснөөр холбогдох албан тушаалтан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, шийдвэрлэлтийн талаар олон нийт, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгч болно.

Прокурорын шийдвэр ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхдээ хувь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хүний хувийн мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байхад анхаарах нь зүйтэй.

“Хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч,

хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;[5]


“Хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;[6]

“Эрүүл мэндийн мэдээлэл” гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг;[7]

“Хөрөнгийн мэдээлэл” гэж мэдээллийн эзний өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эд хөрөнгийн талаарх мэдээллийг ойлгоно[8].

1.4 Прокурорын байгууллагын тогтолцоо, онцлог тал





[5] Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он, 4 дүгээр зүйл
[6] Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он, 4 дүгээр зүйл
[7] Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он, 4 дүгээр зүйл
[8] Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он, 4 дүгээр зүйл

СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ

2.1 Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.36 дахь хэсэгт зааснаар "*эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж*

- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах,
- түүнд прокурор хяналт тавих,
- яллагдагчийг шүүхэд шилжүүлэх,
- эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг " ойлгоно гэж заасан байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь[9]

- гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх,
- гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах,
- гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх,
- хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
- зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.

Дээрх зорилтыг хангах гол субъект нь прокурор бөгөөд прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг удирдан чиглүүлэгч байна.

Прокурорын тухай хуульд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд дараах хяналт тавина[10]: Үүнд:

1. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах байгууллагад ирсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;
2. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;
3. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх;
4. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангасан эсэх;
5. прокурорын зөвшөөрөлтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл, шаардлага байгаа эсэх;
6. таслан сэргийлэх арга хэмжээ авах, дуудан ирүүлэх, баривчлах, албадан ирүүлэх үндэслэл, шаардлага байгаа эсэх;
7. гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх хууль зүйн үндэслэл байгаа эсэх.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих дээрх нийтлэг эрхээс гадна прокурорын хянан шалгах ажиллагаа гэсэн эрх байдаг. Энэ эрхийг ЭХХШТХ-ийн 4.3 дугаар зүйлд тусгайлан хуульчилсан байдаг.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл оролцогчийн гаргасан гомдлоор, эсхүл өөрийн санаачилгаар гэрч, хохирогч,

[9] ЭХХШТХ, 2017 он, 1.1 дүгээр зүйл.

[10] Прокурорын тухай хууль, 2017 он, 14 дүгээр зүйл

сэжигтэн, яллагдагчаас биечлэн мэдүүлэг авах, шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилтыг давтан хийх, мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг хянан шалгах ажиллагаа явуулж болно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих прокурорын бүрэн эрхийг Прокурорын тухай хуулийн 15 дугаар зүйлд хуульчлахаас гадна ЭХХШТХ-ийн 4.1 дүгээр зүйлд нарийвчлан тодорхойлсон байдаг. Мөн

- УЕП-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/189 тоот тушаалаар батлагдсан “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”,
- УЕП-ын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/14 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар” -ыг дагаж мөрдөнө.

2.2 Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар «зөрчил шалган шийдвэрлэх» гэж

- зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт,
- зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.

Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн зорилт нь[11]

- зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож,
- зөрчлийг шалгах,
- зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах,
- энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Прокурорын тухай хуульд зааснаар прокурор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дараах хяналт тавина. [12] Үүнд:

1. зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;
2. зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;
3. зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх;
4. зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа эсэх;
5. эрх хязгаарлах арга хэмжээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;
6. эрх бүхий албан тушаалтан албадлагын арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрхийг Прокурорын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуульчлахаас гадна ЗШТХ-ийн 2.2 дугаар зүйлд нарийвчлан тодорхойлсон байдаг. Мөн

Улсын ерөнхий прокурорын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/77 тоот тушаалаар батлагдсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”,

[11] Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2107 он, 1.1 дүгээр зүйл
[12] Прокурорын тухай хууль, 2017 он, 11 дүгээр зүйл

- 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/94 тоот тушаалаар батлагдсан “Зөрчлийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг тооцох журам”,
- Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/28, А/84 тоот тушаалаар батлагдсан “Зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө орлого, эд зүйл, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”,
- Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/81, А/232 тоот тушаалаар баталсан “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журам”,
- Улсын ерөнхий прокурорын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/55 тоот тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай тушаал”-ыг дагаж мөрдөнө.

2.3 Шүүхэд төрийг төлөөлөх

Прокурор нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүхийн өмнө нотлох үүрэг хүлээх бөгөөд шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцохдоо ЭХХШТХ-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ[13].

Прокурорын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар прокурор хуульд заасан тохиолдолд дараах шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно:

1. зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх;
2. эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх;
3. захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх.

Мөн хуульд прокурорын шүүхэд төрийг төлөөлөх бүрэн эрхийг дараах байдлаар баталгаажуулсан[14]. Үүнд:

1. шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд санал, дүгнэлт гаргах;
2. шинжлэн судлах нотлох баримтыг танилцуулах, шүүх хуралдааны дарааллын талаар санал гаргах;
3. хуульд заасан үндэслэлээр шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
4. шүүгдэгч, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээчээс асуулт асуух;
5. нотлох баримт шинжлэн судлах;
6. шүүхэд нотлох баримт гаргаж өгөх;
7. яллах, яллахаас татгалзах;
8. шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах санал гаргах;
9. оролцогчийн давж заалдах, хяналтын журмаар гаргасан гомдолд хариу тайлбар гаргах;
10. шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл бичих, буцаан авах;
11. шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх тухай дүгнэлт, хүсэлтийг шүүхэд гаргах;
12. шүүхэд нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдол гаргах;
13. хуульд заасан бусад.

Прокурор шүүхэд төрийг төлөөлөхдөө Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль болон

- УЕП-ын дэргэдэх зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Шүүх

[13] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

[14] Прокурорын тухай хууль, 2017 он 21 дүгээр зүйл

хуралдаанд улсын яллагчийн мэтгэлцэх аргачлал”,
- Улсын ерөнхий прокурорын 2021оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 тоот тушаалаар баталсан “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”,
- 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/66 тоот тушаалаар баталсан “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”-ыг дагаж мөрдөнө.

2.4 Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар прокурор ял эдлүүлэх ажиллагаанд дараах хяналт тавина:

1. хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;
2. ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;
3. ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
4. баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог нь цагдан хоригдсон, баривчлагдсан, хорих ял эдэлж буй хүмүүсийн эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах бөгөөд эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэргээх, албан тушаалтанд хариуцлага тооцуулах мөн хорих, баривчлах үйл ажиллагаанд мөрдлөг болгож буй хэм хэмжээ, албан тушаалтны гаргасан шийдвэр хуульд нийцсэн эсэхийг хянах, хорихоос өөр төрлийн ялын биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах зэрэг юм.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрхийг Прокурорын тухай хуульд дараах байдлаар нарийвчлан зохицуулсан. Үүнд.

1. ял эдлүүлэх байгууллага, албадах байр, түр саатуулах, баривчлах, цагдан хорих байр, хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ямар ч цагт саадгүй нэвтрэх;
2. ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээ, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаатай холбогдуулан албан тушаалтны гаргасан шийдвэр, бусад баримт бичигтэй танилцах, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, уг асуудлыг шалгах, шалгуулахаар холбогдох байгууллагад шилжүүлэх;
3. ялтан, цагдан хоригдсон этгээдтэй ганцаарчлан, биечлэн уулзах, шаардлагатай бол ялтан, цагдан хоригдсон этгээдээс тайлбар авах;
4. ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээ, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаатай биечлэн танилцах, шалгах, илэрсэн зөрчлийг арилгуулах;
5. шаардлагатай тохиолдолд зохих мэргэжлийн байгууллагыг хяналт, шалгалтад оролцуулах;
6. ял шийтгүүлсэн, цагдан хоригдсон этгээд, бусад этгээдийн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх;
7. шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан санал, ял эдлүүлэх, хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлтийг шүүхэд гаргах, шүүх хуралдаанд оролцох;
8. ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээ, цагдан хорих таслан сэргийлэх арга

хэмжээтэй холбогдуулан байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай баримт бичиг, тодорхойлолт, тайлбар гаргуулан авах;

9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж түр саатуулагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон хүнийг даруй суллах;
10. хуульд тусгайлан заасан тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
11. шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоолыг хуульд заасан хугацаанд ирүүлэхийг шүүхээс шаардах;
12. ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, орон байр, өмчийн халдашгүй байдал, захиран зарцуулах эрхийг хөндсөн ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих;
13. шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбоотой санал, хүсэлт, дүгнэлтийг хянаж шийдвэрлэх;
14. ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг хянах;
15. ял эдлүүлэх ажиллагааны явцад гаргасан зөрчил, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар прокурорын шаардлага бичих;
16. мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад ялтан шилжүүлэх зөвшөөрөл олгох;
17. харуул хамгаалалтгүй ажиллах хоригдлын материалыг хянаж зөвшөөрөл олгох, гэрээгээр ажиллах хоригдлын талаарх саналтай танилцах;
18. олон улсын гэрээний дагуу хорих ял эдэлж байгаа гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх, гадаад улсад ял эдэлж байгаа Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах саналыг хянаж шийдвэрлэх, шүүх хуралдаанд дүгнэлт гаргах;
19. цагдан хоригдсон этгээдийн өрөөг солих зөвшөөрөл олгох.

Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа холбогдох хуулиас гадна

- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 252 тоот тушаалаар батлсан “Хорих байгууллагаас ялтныг шилжүүлэх журам”
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 тоот тушаалаар батлсан “Хорих байрны дотоод журам”
- Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/158, А/76 тоот тушаалаар батлсан “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”
- Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А-236, А/104 тоот тушаалаар батлсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам”
- Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 тушаалаар батлсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”
- Улсын ерөнхий прокурорын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/116 тоот тушаалаар батлсан “Ял эдлүүлэх ажиллагаанд прокурорын хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”-ыг мөрдлөг болгоно.

2.5 Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь

Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын

хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар иргэний болон захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцож, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалдаг.

Улсын Ерөнхий прокурорын 2019 оны А/28 дугаартай тушаалаар Улсын Ерөнхий Прокурорын Газар, түүний харьяа прокурорын газруудын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дотор “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба”-ыг бий болгосон.

Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно”, 20.4 дэх хэсэгт “Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно” гэж заасны дагуу хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэрэгт прокурор хохирол шаардсан нэхэмжлэл гаргах үндэслэл буюу эрх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7.8, Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-т зааснаар давхар олгогдсон байдаг.

Прокурор хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулан авах эрхтэй.

Прокурор ямар тохиолдолд төр,нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх үү гэдэгт тухайлбал 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албанаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан Зөвлөмж №12-ыг анхаарах нь зүйтэй. Жишээ нь Эрүүл мэндийн даатгалын санд учирсан хохирлыг гаргуулахтай холбоотой ажиллагааны талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагыг эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад нэхэмжлэгчээр тогтоож, холбогдох баримт мэдээлэл, учирсан хохирлын үнийн дүн, эрүүл мэндийн даатгалын сангийн зорилго, агуулгын талаар мэдүүлэг авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж зөвлөсөн байдаг.[15]

[15] Дэлгэрэнгүйг УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албанаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан Зөвлөмж №12-ыг үзэх

Хавсралт 1.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР ЗӨВЛӨМЖ № 12

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход анхаарах асуудал болон Улсын дээд шүүхийн Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаас 2022 оны сүүлийн хагас жилийн байдлаар гарсан зарим тогтоолыг судлуулах үүднээс зөвлөмж болгон хүргүүлж байна.

Нэг. Эрүүл мэндийн даатгалын санд учирсан хохирлыг гаргуулахтай холбоотой ажиллагааны талаар

Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас эрүүл мэндийн даатгалын санд учирсан хохирлыг бодитой тодорхойлох, эрүүл мэндийн даатгалын байгууллагыг нэхэмжлэгчээр тогтоох ажиллагааг гүйцэтгэж, хэрэгжилтэд прокурор хяналт тавих хуулийн зохицуулалттай тул эрүүгийн хэрэгт прокурорыг иргэний нэхэмжлэгчээр тогтоох нь хуулийн агуулгад нийцсэн оновчтой арга биш гэж үзэхээр байна. Эрүүл мэндийн даатгалын сан хариуцсан байгууллага нь улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж, даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, төр, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулах чиг үүрэгтэй тул гэмт үйлдлийн улмаас эрүүл мэндийн даатгалын санд учирсан хохирлыг НӨХӨН төлүүлэх ажиллагаанд тухайн байгууллагыг биечлэн оролцуулах шаардлагатай юм. Түүнчлэн прокурорыг иргэний нэхэмжлэгчээр тогтоож мэдүүлэг авч байгаа нь түүний хувийн мэдээллийг хэргийн оролцогч нарт нээлттэй болгож байна. Иймд эрүүл мэндийн даатгалын байгууллагыг эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад нэхэмжлэгчээр тогтоож, холбогдох баримт мэдээлэл, учирсан хохирлын үнийн дүн, эрүүл мэндийн даатгалын сангийн зорилго, агуулгын талаар мэдүүлэг авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй.

Хоёр. Нотлох бариmтад тооцох, түүнийг үнэлэх асуудлын талаар

Хяналтын шатны шүүхээс зохигч нарын хооронд гэрээ байгаагүй тохиолдолд хэргийн уйл баримт, бусад баримтуудад дүгнэлт хийн, маргааныг шийдвэрлэсэн. Улсын Их хурлын 2005 оны 48 дугаар тогтоолоор батлсан Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, Засгийн газрын 2006 оны 153 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хорооны 2006.10.19-ний өдрийн 631 дугаартай тогтоолоор “А” ТӨҮГ-ын үнийг бүрэн төлж, өмчлөх эрхтэй болсон үндэслэлээр Төрийн өмчийн хорооны 2006.12.14- ний өдрийн 712 дугаар тогтоолоор “А” ТӨҮГ-ын өмчлөх эрхийг “М” ХХК-д шилжүүлэн олгож, 2007.01.17-ны өдөр “А” ТӨҮГ /ЦОГЦОЛБор/-ыг “М” ХХК-д хүлээлгэн өгсөн актын Өглөг хэсэгт “А” ТӨҮГ нь ...газарт 16,757,100 төгрөгийн өртэй болохыг тусгажээ. “М” ХХК болон ...газар нь харилцан тооцоо нийлж, 2015.01.31-ний өдрийг дуустал хугацаанд өгч авалцсан зүйлээ нэг бүрчлэн нийлж, “М” ХХК 18,723,677 төгрөгтэй өртэй гарсныг баталсан байх бөгөөд дээрх өглөгт 2006.12.14-ний өдрийн 712 дугаар тогтоолоор өмчлөх эрхийг шилжүүлэн авсан “А” ТӨҮГ-ын 16,757,144 төгрөгийн өр багтсан болох нь авлагын дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдсэн үйл баримт тогтоогджээ.

Анхан шатны шуух хэрэгт цугларсан баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлсний үндсэн дээр зохиогчийн хооронд үйлдэгдсэн Тооцооны үлдэгдлийн баталгааг Тооцоо нийлэх гэрээ гэж дүгнэн, нэхэмжлэгч нь гэрээний үүргийн

гүйцэтгэлийг шаардах эрхтэй гэж дүгнэснийг буруутгах үндэслэлгүй. Тооцоо нийлэх гэрээгээр талууд хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцох бөгөөд тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээнэ, тооцооны үлдэгдлийг гэрээнд заасан хугацаанд төлөх бөгөөд тооцоог хааснаар тооцооны үлдэгдлийг төлөхийг шаардах эрх үүснэ, тооцооноос үүссэн үлдэгдлийг төлснөөр тооцоо нийлэх гэрээний шаардлагыг хангасанд тооцно гэж Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1-466.3-т тус тус зохицуулжээ. Хуулийн дээрх зохицуулалтаар хариуцагч «М” ХХК 18,723,677 төгрөгийн тооцооны үлдэгдлийг төлөх үүрэгтэй байх боловч шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд, хэрэгт цугларсан баримтад тулгуурлан хэргийг шийдвэрлэж, хариуцагчаас 16,757,100 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь заалтад нийцсэн, хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалтыг зөрчөөгүй байх тул үлдэгдэл 1,606,533 төгрөгийн өглөгийн талаарх нотлох баримтыг огт үнэлээгүй гэх хариуцагчийн гомдол үндэслэлгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т бичмэл нотлох баримтыг шүүхэд эхээр нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө, 25 дугаар зүйлийн 25.2.2-т шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг хэргийн оролцогч өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх үүрэгтэй гэж тус тус зохицуулсан. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон, хариуцагчийг ...газарт 16,757,1 мянган төгрөгийн өглөгтэйг нотолсон “А” ТӨҮГ-ыг хүлээлцсэн тухай акт нь нотариатаар гэрчлэгдсэн байх ба Тооцооны үлдэгдлийн баталгааны үндэслэл болох Авлагын дэлгэрэнгүй бүртгэл хэрэгт эх хувиар авагдсан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасан нотлох баримтын шаардлага хангасан байна. Иймд шүүх шаардлага хангаагүй нотлох баримтыг үнэлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн талаарх хариуцагчийн гомдол үндэслэлгүй.” (УДШ 2022.09.29. №00877)

Гурав. Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр халсны улмаас төрд учирсан хохирлыг гаргуулах иргэний хэргийн талаар

Хяналтын шатны шүүх аймгийн Орон нутгийн өмчийн газрыг төлөөлөн прокуророос хариуцагч З.М-д холбогдуулан Ц.Ц-ийн ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговрыг байгууллагаас төлсний улмаас учирсан гэм хорын хохирол 6,835,325 төгрөгийг гаргуулахаар нэхэмжилснийг хариуцагч эс зөвшөөрч маргасныг хянан хэлэлцэж, шийдвэрлэсэн. “Хэргийн баримтаас үзэхэд хариуцагч З.М нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа 2017.10.12-ны өдөр тус газрын ...нягтлан бодогч Ц.Ц-г ажлаас чөлөөлсөн, Ц.Ц-г урьд нь эрхэлж байсан ажилд нь эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговорт 6,835,325 төгрөгийг түүний ажиллаж байсан байгууллагаас гаргуулж, олгохоор шийдвэрлэсэн 2018.06.18-ны өдрийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж биелэгджээ.

Анхан болон давж заалдах шатны шүүх “...З.М нь ажилтныг ажлаас чөлөөлөх шийдвэр гаргах эрхийнхээ хүрээнд ажилтныг ажлаас чөлөөлөх тухай тушаал гаргасан нь эрх зүйн хувьд алдаатай байсныг шүүх тогтоосон, ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг тухайн байгууллагаас гаргуулан олгохоор шийдвэрлэсэн нь З.М-г хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр байгууллагад гэм хор учруулсан гэж үзэх үндэслэл болохгүй. З.М нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа эрх зүйн хувьд алдаатай шийдвэр гаргаж байгууллагад эд хөрөнгийн хохирол

учруулсан, талуудын хооронд үүссэн маргаанд Хөдөлмөрийн тухай хууль хэрэглэнэ гэж дүгнэн, хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт зааснаар хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилтан эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээх бөгөөд энэхүү хязгаарлагдмал хариуцлагын хэмжээ нь тухайн ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтэрч болохгүй гэж зааснаар байгууллагад учруулсан хохиролд түүний нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний буюу 872,764 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч байгууллагад олгож, нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож» шийдвэрлэхдээ маргааны үйл баримтад хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй байна.

Хариуцагч З.М нь ажилтныг ажлаас чөлөөлөх шийдвэр гаргах эрхийнхээ хүрээнд ажилтныг ажлаас чөлөөлөх тухай тушаал гаргасан нь эрх зүйн хувьд алдаатай байсныг шүүх тогтоосон, шүүхийн шийдвэр биелэгдсэн, хариуцагч З.М- аас 6,835,325 төгрөгийг гаргуулж, аймгийн Орон нутгийн өмчийн газарт олгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангах нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д нийцнэ. Өөрөөр хэлбэл, хариуцагч нь үүргийг түр орлон гүйцэтгэгч байх хугацаандаа ажилтан Ц.Ц-г ажлаас халахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын буруу шийдвэр гаргасан нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон байх тул хариуцагч нь тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд асуудлыг эрх зүйн үндэслэлтэй шийдвэрлэх ёстой бөгөөд хууль дээдлэх нь төрийн албаны үйл ажиллагааны үндсэн зарчим юм. «...сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.03.02-ны өдрийн 133/ШТ2020/00001 дугаар тогтоол гарсны дараа газар нь 2021.01.26-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн прокурорын газарт «...санхүүгийн тайланд хийсэн аудитаар .6,835,325 төгрөгийн авлага үүсгэсэн тул төрд учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаанд прокурорыг оролцуулах» хүсэлт гаргаснаар прокурор шүүхэд нэхэмжлэл гаргасан нь хууль зөрчөөгүй байна.»

№001/ХТ2022/00971) (УДШ 2022.10.21. ШҮҮХЭД ТӨРИЙГ ТӨЛӨӨЛӨХ ХЭЛТСИЙН ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ АЛБА 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном товхимол, гарын авлага.

1. Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа, 2022 он
2. Б.Өнөрмаа, “Шүүгчийн дотоод итгэл ба нотлох баримтыг үнэлэх ажиллагаа” 2018 он. https://www.mglbar.mn/news/2640
3. Прокурорын тухай хууль, 2017 он
4. Б.Өнөрмаа, “Шүүгчийн дотоод итгэл ба нотлох баримтыг үнэлэх ажиллагаа” 2018 он. https://www.mglbar.mn/news/2640
5. УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албанаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан Зөвлөмж №12

Хууль тогтоомж.

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2107 он, 1.1 дүгээр зүйл
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
4. Прокурорын тухай хууль, 2017 он 21 дүгээр зүйл

БҮЛЭГ 3. ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙ

СЭДЭВ 1. ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН НЭР ХҮНД, ЁС ЗҮЙ БА ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛОО ХАМГААЛАХ ОРЧИН ЦАГИЙН СОРИЛТ

1.1 Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт
1.2 Нийгмийн ёс зүйн тойрог, үнэт зүйлс, ёс зүйн хүрээ

СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ БА ХАРИЛЦАА ХАНДЛАГА

2.1 Прокурорын мэргэжлийн ёс зүйн хариуцлага ба шударга ёс
2.2 Хуульч, прокурорт нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлага

СЭДЭВ 3. ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

3.1 Ашиг сонирхлын зөрчилдөөн
3.2 Нийгмийн болон мэргэжлийн ёс зүйн тойргоос үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилдөөн
3.3. Гадаад орны туршлага.

СЭДЭВ 1. ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН НЭР ХҮНД, ЁС ЗҮЙ БА ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛОО ХАМГААЛАХ ОРЧИН ЦАГИЙН СОРИЛТ

1.1. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд ёс зүй, ёс суртахуун ба прокурорын ёс зүйн талаар суурь ойлголттой болгож, прокурорын ёс зүйн зарчмууд, чиг хандлага, хэрэглээ, ёс зүйн зөрчлийг тодорхойлох, тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх хуульч прокурорын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах тэр дундаа ёс зүй, ёс суртахууны үндэс, ойлголтын талаар дэлгэрэнгүй авч үзнэ.

Хуульчийн гаргасан алдаа нь ёс зүйн зөрчил мөн үү гэдгийг зөв тодорхойлохын тулд ёс зүйн дүрэмд ёс зүйн шаардлагаа зөв тодорхойлох нь юу юунаас илүү чухал.

Сэдвийн тэргүүнд “Ёс суртахуун” ба “Ёс зүйн” тухай ойлголтыг авч үзье.

“**Ёс зүй**” хэмээх ойлголт нь эртний грекийн “**Ethos**” гэдэг үгнээс гаралтай бөгөөд хамтран амьдрах орон байр, оршин амьдрах газар гэсэн утгыг илэрхийлж байжээ. Хожим энэ ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг гэх мэт утга агуулгаар баяжиж тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлэх болсон байна. Ёс зүй /этика/ бол нийгмийн тодорхой тогтолцоо дахь хүмүүс өөрсдийн авир үйлдэл, харилцан хамаарлыг тохируулахын тулд аяндаа сайн дурааараа баримталдаг янз бүрийн хэм хэмжээний цогц, өөрөөр хэлбэл, ёс суртахууныг судлах зүйлээ болгодог философийн бүрэлдэхүүн мөн. Нийгмийн харилцаа төлөвшин хөгжихөд зан заншил, уламжлал, улс төр, шашин, эрх зүй зэргийг ашиглаж ирсэн аж. Ёс суртахуун (“ёс суртахуун”, “зан суртахуун” - mos moral, мораль) - хүмүүс өдөр тутмын амьдралын явцад өөрсдийн харилцааг сайн дурын зан аашийнхаа үндсэн дээр зохицуулж байдаг янз бүрийн хэм хэмжээний цогц юм.[1]

Этика буюу “**ёс зүй**” нь тухайн шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар, мораль буюу “ёс суртахуун” нь энэхүү салбарын судлагдахуун болжээ. Ёс зүй нь

[1] Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ

зан суртахууны бодит үйл явцыг судална. Ёс суртахууныг хүний үүсэл хөгжилтэй холбон авч үздэг бөгөөд хүн нэгэнт байгаль, нийгмийн бүтээгдэхүүн болохоор түүнд зан араншингийн шинжүүд тодорхой хэлбэрээр ил далд байдлаар оршиж, шаардлагатай тохиолдолд илрэн гарч байдаг онцлогтой. Хүн өөрийн үйлдлийн учир холбогдлыг зөв ухааран ойлгож, уур хилэн, бүдүүлэг авираа нийгмээс олж авсан соёлоороо далдлан дарж байдаг. Ёс суртахууныг хүмүүс ямар нэг албадлагагүйгээр өөрсдөө шууд тогтоож уламжлал болгон ирсэн учраас нийгмийн харилцаанд бодитой үйлчилж хүчтэй нөлөө үзүүлдэг. “Ёс зүй” ба “ёс суртахуун” нь нийгмийн харилцаа төлөвшин хөгжих, хуучирч үеэ өнгөрөөх, үүсч бий болох, тэр нь хэрхэн батжин бэхжихэд нөлөө үзүүлдэг чухал хэрэгсэл юм.

Ёс зүйг “ёс зүйн шинжлэх ухаан бол харилцааны тухай, орших ахуйн тухай, зохицон оршихуйн тухай амьдралын утга учрын тухай гүн ухаан бөгөөд ёс зүйг онолын мэдлэгээс ангид биеэ хэрхэн авч явах тухай “практик ухаан”, “ёс зүй бол хүмүүс хоорондын харилцаа, энэ харилцаанаас үүдэн гарах “үүрэг”-ийн тухай шинжлэх ухаан юм”[2]. /П. Гольбах 1723-1789/ гэж, мөн “хүнд юуг хийх, юунаас татгалзах хэрэгтэйг танихад /сайн, мууг ялгахад/ тусалдаг зүйл бол ёс зүй юм” / эртний гүн ухаантан Аристотель/ гэж энгийнээр тодорхойлсон байдаг. Тэгвэл Италийн философич Аббаямо гэгч хүн “Ёс зүй бол хүний тухай асуултуудын хариу нь байдаг” гэж тодорхой бөгөөд товч тодорхойлсон байдаг. Ёс зүй нь нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд хүмүүс хоорондын харилцаа түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй нийгэм бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буйгаар тодорхойлогддог бол хуульчийн ёс зүй гэдэг нь хуульчдад олон нийтийн эрх ашиг, үүрэгт холбогдох шийдвэрийг итгэл найдвартайгаар даатгаж байгаа үйлдлийн хэм хэмжээ, хуульч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд түүний зан үйлд нийгмийн зүгээс тавьж буй ёс суртахууны тусгай шаардлага юм. Албаны болон мэргэжлийн ёс зүй” гэж бусдын нэрийн өмнөөс, тэдний эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулахаар эрх /эрх мэдэл/ олж авсан этгээд, эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлын дээгүүр тавьж, энэ зан суртлаа албаны /мэргэжлийн/ үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг ойлгоно” хэмээн тодорхойлжээ.

Ёс зүйг судлах нь хүний ёсны ухааныг судалж байгаа явдал бөгөөд нэгдүгээрт танин мэдүүлэх, хоёрдугаарт хүмүүжүүлэх, гуравдугаарт бүтээх ач холбогдолтой бөгөөд ёс зүйг эрхэмлэх, ёс зүйн ойлголтуудыг судалж, мэдсэнийгээ бусдад түгээх, тулгарсан асуудалд ухаалаг хариултыг олж, оновчтой шийдвэр гаргаж явах нь хүн байхын учир утга юм.

Эрх зүй ба ёс зүйн харилцан уялдааны тухай ойлголт.

“Ёс суртахуун “нь эрх зүйгээс өмнө үүсэж нийгмийн харилцааг зохицуулж ирсэн ба “зан үйлээр дамжин амьдрал ахуйд нэвтэрч, бүрэлдэн тогтсон хувь хүний зүгээс нийгэм болон олон түмэнтэй харилцах, тэдний өмнө хариуцлага хүлээх, биеэ авч явах зэрэг олон талын харилцааг зохицуулсан хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ” буюу “бичигдээгүй хууль” юм. Нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын түвшин, амьдралын хэв маяг, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогддог бол эрх зүй гэж “төрөөс тогтоосон ба түүний албадлагын хүчээр хангагдан хэрэгжих, нийтээр заавал дагаж мөрдөх (позитив эрх зүй), эсхүл төр ба хуулиас дээгүүр оршин байдаг байгаль, хүний оюун ухаан, зайлшгүй шаардлагаас үүдэгдэн гардаг (жам ёсны эрх зүй) нийгмийн хэм хэмжээний (зан үйлийн журмын) тогтолцоо” - г хэлдэг. Эрх зүй, ёс суртахуун хоёр нийгмийн харилцааг зохицуулах нийтлэг шинжтэй ч эрх зүй нь төрөөс тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин

[2] /П. Гольбах 1723-1789/

хэрэгжиж, зөрчигдөх тохиолдолд төрийн албадлага хэрэглэн, хуулийн цээрлэл хүлээж байдаг бол ёс суртахуун нь олон нийтийн сэтгэл зүйгээр илэрч тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгждэг.[3] Ёс зүйн сургаалууд хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад янз бүрийн үзэл урсгалуудыг өөртөө багтааж хөгжиж ирсэн түүхтэй. Тухайлбал: Эртний Грекийн “ёс зүйн оргил” Аристотелийн хувьд “этик бол зан суртахууны тухай практик шинжлэх ухаан бөгөөд этикийн гол зорилго бол яавал сайн үйл бүхий байхыг хүмүүст сургахад оршдог” гэж үздэг байжээ.[4]

Хуулийг шинэчлэгч Философич Жэрэми Бентам “Ёс суртахуун ба хуулийн зарчмууд” номдоо /1789/ “Нийгэм, улс төрийн шийдвэр нь аль болох их аз жаргалтай болоход чиглэгдэх ёстой” хэмээсэн.[5] Ийм шийдвэрийн ёс суртахууны үнэт чанар нь аз жаргал, сэтгэл ханамжийг дагуулдаг ашигт чанар ба үр дүнтэй холбогддог аж. “Ашигт чанарыг” удирдлага болгодог нийгэмд /утилитари гэдэг нь “ашиг” гэсэн утгатай латин үг/ хувь хүмүүсийн эрх ашгийн зөрчлийг зөвхөн сэтгэл ханамжийн зарчмаар удирдлага хийсэн хууль тогтоогчид шийдвэрлэнэ. Хүн бүрийг аз жаргалтай болгох боломжгүйгээс хойш олонхын эрх ашгийг дээдэлж, цөөнхийг таягдахаас аргагүй” гэсэн агуулга бүхий үзэл баримтлал. Ёс зүйн релятивист байр суурь нь “нэг хүнд үнэн зүйл нөгөө хүнд худал байж болно” гэж үздэг үзэл агаад ийм релятивист байр суурь нь зөв, буруу гэсэн ёс суртахууны баримтлалыг илэрхийлдэг ажээ.

Нийгэм, хувь хүн, хуульчийн мэргэжлийн ёс зүйн гурван тойргийн онолоор ёс зүйн хүрээг тодорхойлох нь Чех математикч Курт Годэлийн “гурван тойргийн онол” нь ёс зүйн дүрмээр зохицуулагдахгүй асуудлыг хэрхэн ёс зүйн асуудал болгон зохицуулж болохыг харуулсан онол юм. Ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалж хуульчид ёс зүйн дүрмээр хязгаарлагдахгүйгээр илүү өргөн хүрээнд сэтгэж ёс зүйг дагаж мөрдөх хэрэгтэй болдог. К.Годэлийн нээлтээр бол “ямар ч ёс зүйн тогтолцоо бүх асуудлыг шийдэж чадахгүй. Тухайн асуудлыг шийдэж чадахгүй тогтолцоог хүчингүй тогтолцоо гэж болохгүй” гэж үзэх явдал юм.

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн асуудалтай холбоотой онолын агуулгыг Америкийн “Бар”-ын Холбооны мэргэжлийн сахилгын загвар дүрэмд “Хуулийн мэргэжлээр ажиллахад зөрчилтэй үүрэг хариуцлага тулгардаг. Хуульчийн үйлчлүүлэгчийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, нийт эрх зүйн тогтолцооны өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, амьдрахад хангалттай мөнгө олонгоо үнэнч шударга хүн хэвээр үлдэх сонирхлын хоорондох зөрчлөөс ёс зүйн бүх хэцүү асуудал гарч ирдэг. Мэргэжлийн сахилгын дүрэм ийм зөрчлийг шийдэх нөхцөлийг тусгасан байдаг. Эдгээр дүрмийн хүрээнд мэргэжлийн эрхтэй холбоотой олон хэцүү асуудал гарч ирдэг. Ийм асуудлыг дүрмийн үндэс болсон зарчмуудыг баримтлан мэргэжлийн болон ёс суртахууны мэдрэмжтэй дүгнэлт хийх замаар шийдэх ёстой” гэж тусгасан байдаг.[6]

Хувь хүний ёс зүйн үнэт зүйлс гэдэг нь нийгэм сайн гэж хүлээж авсан, сайн сайхан үр дүн гарах, бусад хүмүүс дагаж дуурайвал зохих биеэ авч явах байдал, бодол санаа, зан чанар юм. Тухайлбал: Итгэл даах чадвар, чин үнэнч харилцаа, зарчимч, найдвартай байдал, аливаад чин сэтгэлээсээ хандах, нууцыг хадгалах, эелдэг

---

[3] ‘Richterzeitstudien’ Cf. Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.II,1974 pp.60 et seq.; Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.I,1974 pp.182 et seq.; G.Griebeling, Die Arbeitszeit des Richters, DRiZ 71pp.228 et seq; R.Zwiesele&R. Bender, ‘Betriebswirtschaftliche Methoden und Vorschlage zur Verbessung der Justizorganisation’; 12. R. Depre et al., Etude de faisabilite de la mise en euvres d’un instrument de mesure de la charge de travail destine au siege, p.3.

[4] Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ

[5] Философич Жэрэми Бентам “Ёс суртахуун ба хуулийн зарчмууд

[6] Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ

боловсон чанар, ёс журам, хүлцэл, бие даасан байдал, чадварлаг, тэсвэртэй байх, хэрсүү ухаан, ил тод, алагчлахгүй байх, халамжтай хандах, өгөөмөр сэтгэлтэй байх гэх мэт үнэт зүйлс нь ёс зүйн суурь ухагдахуун болдог төдийгүй мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний ч эх сурвалж болдог тул хуульчид ёс зүйн дүрэмд тусгагдаагүй үнэт зүйлсийг ч хувь хүнийхээ хувьд мөрдөх нь зүйтэй.

Хуульчид хууль хэрэгжүүлэхдээ:

1. Хэм хэмжээний агуулгыг буруу ойлгох
2. Андуурах
3. Онолын мэдлэг дутах
4. Тайлбар шаардлагатай, практик тогтоогүй хэм хэмжээг өөрийн дотоод итгэл, оюуны дүгнэлтэд тулгуурлан үндэслэл болгож гаргасан шийдвэр нь буруу байх
5. Үүрэгт ажилдаа хайнга, хайхрамжгүй хандсанаас мэргэжлийн алдаа гаргадаг нь дээд шатанд залруулагддаг байна.

Ёс зүйн дүрмээр тодорхойлогдсон хуульчийн бусадтай харилцах харилцаанд биеэ хэрхэн авч явах горимыг зөрчсөн ёс зүйн зөрчил гэж үзэх нь зүйтэй. Жишээ нь: Шүүх хуралдааны явцад шүүгдэгч Л гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй, үйлдлээ илт худал ярьж байгаад прокурор бухимдаж, өөрийн сэтгэл хөдлөлөө хяналтаа алдаж, шүүгдэгч Л-ийг “чи өөрийгөө хэн гэж бодов, чам шиг хүн эцэст нь өөрийгөө хохироосноо ойлгодог юм.” гэж уурласан байна. Үүнээс гадна тухайн мэргэшлийн ёс зүйн дүрэмд тухайлан заагдаагүй ёс суртахууны бусад зөрчил гаргасан хуульчид нөлөөллийн ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуудал ёс зүйн дүрмүүдэд, тухайлбал, шүүгч, прокурор, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд тодорхой зохицуулагдаагүй байдаг. Тухайлбал, өмгөөлөгчийн мэргэжлийн “мэдлэг, чадвар”-гүйгээс хууль хэрэгжүүлэхдээ алдаа гаргасан тохиолдолд “ёс зүйн зөрчил” - д тооцон сахилгын хэрэг үүсгэх бус харин дүгнэлт гарган, ямар шалтгаанаар уг алдаа гарсан, уг алдааг арилгах ямар арга зам байгааг тогтоох шаардлагатай болно. Та ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа хоёрын талаар дүгнэлт хийнэ үү.

1.2 Нийгмийн ёс зүйн тойрог ба мэргэжлийн ёс зүйн тойрог

Нийгэмд сайн хэмээн хүлээж авдаг, сайхан үр дүн гарах, хүмүүс дагаж дуурайвал зохих биеэ авч явах байдал, бодол санаа, зан чанар бол нийгмийн үнэт зүйлс байдаг. Энэхүү үнэт зүйлсээс хувь хүн өөрийгөө олж сайн зан чанаруудыг эрхэмлэж өөрийн төлөвшлийг олдог. Ингэхдээ зан суртахууны эерэг ба сөрөг ойлголтуудаар ёс зүйн ба ёс зүйн бус үнэлэмжийг бусдаас авч өөрийгөө, ажил хэргийн нэр хүндээ үнэлүүлдэг.

Мэргэжлийн хувьд дагаж мөрдөх ёс зүйн шаардлага, дүрэм, журам ч бас нийгмийн үнэт зүйлсэд суурилсан байдаг. Ямар ч мэргэжлээр ажилласан “мэргэжлийнхээ үүрэг, хариуцлагыг ухамсарлаж, мэргэжлийн онцлог дагаж мөрдөх шаардлагыг биелүүлэх ёстой” болдог. Нийгмийн тойргоос гарсан сайн чанарууд, тухайлбал, зориг, тэвчээр, энэрэнгүй байх, даруу зан, шударга байх, өөрийгөө үл хайрлах, хүндэтгэлтэй байх гэсэн чухал үнэт зүйлс нь муу үр дагавартай хэцүү сонголтуудаас гарах арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Ёс зүйн бус асуудлууд: “Ёс зүйг зөрчих үйлдлийг хийлгэхэд дотроос нь өдөөж байдаг хүчин зүйлс. Тухайлбал, хайрлах, үзэн ядах, өрөвдөх, өнгө мөнгөнд шунах, нэр төр, атаархал, хардалт зэрэг хамаарна. Эдгээр ёс зүйн бус хүчин зүйлс нь ёс зүйг зөрчихөд хүргэдэг байна. Хуульч мэргэжлийн хүрээнд дагаж мөрдөх ёс зүйн шаардлагаар шударга байх, хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэх, хараат бус байх, хэн нэгний нөлөөнд автахгүй, хувийн харилцаа тогтоохгүй байх, хэрэв хувийн

харилцаатай, садан төрлийн холбоотой, хэргийг шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ төрвөл хуульд заасны дагуу татгалзах зэрэг шаардлагуудаар ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх арга механизмыг тодорхойлсон байдаг. Гэтэл өөрөө хүссээр ийм байдалд орох нь хуульчийн ёс зүй зөрчсөн, үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй асуудал мөн. “Сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн сонирхол нийтийн сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал” гэж тодорхойлсноос үзвэл: “Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь албаны болон мэргэжлийн ашиг сонирхлоос амин хувийн ашиг сонирхлыг илүүд үзсэнээр бий болдог ёс зүйн бус асуудал юм”. Жишээ нь: Прокурор Д-гийн оюутан ахуйн найз нэг ангид хамт сурч байсан О нь Д-тэй уулзаж түүний дүүгийн холбогдсон хэрэг өөр дээр нь байгаа, мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж, ялагдагчаар татах санал гаргасан байгаа дүүг минь харж үзэхийг хүсэж, гуйгаад найздаа уулзаагүй удсан учраас гэж гарын бэлэг өгсөн байна. Прокурор найзтайгаа олон жил уулзаагүй, ганц удаа гуйж байхад хэмээж түүнийг гуйлтыг биелүүлж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэжээ.

-Прокурор ашиг сонирхлын зөрчилд орсон уу? Ийм тохиолдолд найзыгаа гомдоох уу, эсвэл хуульчийн ёс зүйн хүрээнд дагаж мөрдөх хууль дүрмээ баримтлах уу гэдэг асуудал тулгарахад “хуульчийн ёс зүйг даган мөрдөх” эр зориг л хэрэгтэй. Нийгмийн сэтгэл зүй хүлээн зөвшөөрдөггүй гэхдээ хуульчид дагаж мөрдөх тойргийнхоо хүрээнд заавал дагаж мөрдөхөөс аргагүй тийм хүнд байдал ацан шалаанд ч ордог. Тухайлбал, өмгөөлөгчийн хувьд мэргэжлийн дагаж мөрдөх ёс зүйн шаардлагаар үйлчлүүлэгчийн эрх ашгийг тууштай хамгаалах, нууцыг хадгалах үүрэгтэй. Гэтэл нийгмийн сэтгэлгээ гэмт хэрэгтнийг үзэн ядаж, өмгөөлөгчийг өмгөөлж хамгаалах ёсгүй мэтээр ойлгож болно.

СЭДЭВ 2. ХУУЛЬ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ БА ХАРИЛЦАА ХАНДЛАГА

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд хуульч прокурорын ёс зүй түүнд хүлээлгэх хариуцлага, шударга ёс нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлагын талаар тодруулан авч үзэж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадвар, хандлага төлөвшүүлэх юм.

2.1 Хуульчийн ёс зүйн хариуцлага ба шударга ёс

Ёс зүй нь нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд хүмүүс хоорондын харилцаа түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй нийгэм бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буйгаар тодорхойлогддог ба хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах ёстой ч бүрэн төгс боловсрогдсон ёс зүйн дүрэм гэж үгүй тул дүрмийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байх нь зүйтэй.

Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн зөрчлүүд

Аливаа мэргэжил өөрийн ёс суртахуунтай байдаг ба мэргэжлийн ёс зүй нь мэргэжил тус бүрийн гүйцэтгэх үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан мэргэжлийн ёс зүй болж өөр өөрийн өвөрмөц зохицуулалттай болдог.

Прокуроруудын нийтлэг алдаа нь харилцааны соёл, албан тушаалаа ашиглан танил найз нөхдөдөө туслах, албан тушаалаа ашиглан амины ажилдаа ашиг хонжоо гаргах зэрэг байгаа боловч энэ талаар бодит мэдээлэл зохих газар ирдэггүй тул прокуроруд хууль зөрчдөг, авлига авдаг гэсэн ойлголт олон нийтийн дунд байна.

Үүнээс гадна Улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод, хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс гаргасан судалгаанд прокурор бусдад дарамт үзүүлсэн, хэрэг дарагдуулсан, үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон, ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, ажилдаа согтуу ирсэн, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ жолоо барьсан, бусдаас архи нэхсэн, бусдыг хэл амаар доромжилсон, бусдаас шан харамж авсан, татвар төлөөгүй зэрэг зөрчил гарсан тохиолдлуудын талаар авагдсан байна.

Үүнд: Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжлийн алдаанаасаа илүү ёс зүйн алдаа гаргах нь олон байдаг ба энэ нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдэг тул үүнээс ёс зүйг чухалчлах, ажил амьдралдаа баримталж байх шаардлага үүдэн гарч байна.

Прокурорын ёс зүйн дүрэмд: “хэргийг харьяаллын дагуу шүүхэд шилжүүлэх үед прокурор хэргийн оролцогч, өмгөөлөгчидтэй харилцахдаа ямарваа ялгавартай байдал гаргахгүйгээр хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга зөв шийдвэрлэх итгэл үнэмшил төрүүлж чадахуйц мэдлэг, харилцааны соёлтой байх явдал нь прокурор бүрийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байвал хэм хэмжээ юм” гэж заасан байдаг. Шүүхийн хэлэлцүүлгийн үед прокурор шүүх хуралдаанд оролцогчид руу муухай харах, дохих, зангах, загнах, доромжлох, хууль бус асуулт тавих, хариулахыг шаардах, нэг дор олон төрлийн үйл хөдлөл хийх, утсаар ярих, өөр хэрэг, ном сонин унших, нойрмоглох, асуудалд хайхрамжгүй хандах зэрэг олон төрлийн зөрчил гаргадаг нь өөрт нь анзаарагддаггүй боловч хөндлөнгөөс ажиглагсад, шүүх хуралдаанд оролцогчдод мэдэгдэхүйц байдлаар илэрч, энэ нь прокурорыг харилцааны соёлгүй, ёс зүйгүй гэх зэрэг үнэлэмж өгөх үндэслэл болдог.

Ёс зүйтэй байх, ёс зүйн шаардлагыг дагаж мөрдөх явдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль болон “Прокурорын ёс зүйн дүрэм”-ээр хэм хэмжээчилсэн ба прокурор мэргэжлийн ёс зүйн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн дүрмийн зарчим, шаардлагыг зөрчсөн үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэдэг.

2.2 Хуульч, прокурорт нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлага.

Хуульч ч өөрийн эрх, үүргээ хэрхэн ухамсарлах, үйл ажиллагаандаа ямар сэтгэлээр хандах нь “ёс зүй”-тэй холбоотой тул шударга ёсыг тогтоохын тулд юуны өмнө “ёс зүй”-тэй байх, өөрт халгүй гэж дээд удирдлагын үүрэг даалгаврыг л биелүүлэх байдлаар ажлаа гүйцэлдүүлдэг хуучин хэвшмэл арга барилаас ангижирч, үйл ажиллагаандаа хүнлэг, энэрэнгүй ёс, шударга ёсны зарчмыг дээдлэн, хуульчийн хувьд хүлээсэн үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлаж, сэтгэхүй, оюун ухаанаа хөгжүүлж, идэвх санаачилгатай байж, ажлын шинэлэг арга барилд суралцах ёстой.

Прокурор ёс зүйн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн дүрмийн зарчим, шаардлагыг зөрчсөн үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг хянах, түүнчлэн ял эдлүүлэх болон гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцож яллах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагаандаа нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, гадны нөлөөнд үл автах, хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах, хуулийг хүндэтгэж чанд сахих зарчмыг

удирдлага болгон баримтлах ёстой.

СЭДЭВ 3. ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурорын ёс зүйн зөрчил, ашиг сонирхлын зөрчил, нийгмийн болон ёс зүйн тойргоос үүдэх ашиг сонирхол, мэргэжлийн хариуцлагын талаарх зарим орнуудын туршлагын тодруулан авч үзнэ.

3.1 Ашиг сонирхлын зөрчилдөөн.

Иргэд төрийн байгууллага, албан тушаалтнаас шударга бөгөөд өндөр тогтоосон хэм хэмжээнд стандартад нийцсэн үйлчилгээг хүсэн хүлээдэг. Прокурор нь нэг талаас төрийн, нөгөө талаас иргэдийн итгэлийг хүлээх болдог. Хариуцлагагүй хуульч хүмүүст хэтэрхий их хор хохирол учруулах учраас хуульч туйлын хариуцлагатай, ёс зүйтэй байх нь чухал юм. Үүрэг, хариуцлагаа ухамсарлах нь ёс зүйтэй байхын бас нэг хэмжүүр. “Үүрэг нь хувь хүнээс бусдын болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт юм. Үүргээ ухамсарлах нь хүн өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаандаа ямагт бодолтой, ухаалаг хандахад нөлөөлдөг”. Хуульчийн мэргэжлийн хариуцлагын гол зангилаа бол эрх мэдэл дор хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх явдал учир хуульчид өөрт олгогдсон эрх мэдлээрээ өөртөө давуу байдал олгох зүй бус шийдвэр гаргах бус шударга ёсыг сахигч байх ёстой. Нийгэм, олон нийтийн зүгээс ч ийм байхыг шаарддаг. Шударга ёс алдагдахад хуульчид, хуулийн байгууллагынханд итгэх итгэл алдагдахад хүрнэ. Иймд төр эрх зүйн тусламжтайгаар шударга ёсны наад захын түвшинг хадгалах, хуульчдыг ёс зүйтэй байлгах, нийгэмд шударга ёсыг тогтоон төлөвшүүлэх нь чухал.

Шударга ёс нь хүн нийгмийн харилцаанд үнэн бодитой, зохистой хандах зүй ёсны шаардлага, шударга ёс нь хүний амин хувийн ашиг, сонирхлыг бусдын буюу нийгмийнхтэй зөв тэнцвэртэйгээр уялдуулах, нийтлэг чиг шугамд үндэслэгдсэн эрх зүйн зарчим тул хуульчийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага бол шударга ёсыг сахих явдал. Хуульч мэргэжлийн хүрээнд явуулах ажиллагаагаа хувийн сонирхлоос зааглаж, хуулийг хэрэглэх эрх мэдлийнхээ хүрээнд хүний эрхийг хамгаалан хангах үүргийг нийгмийн өмнө хүлээж, тэрхүү мэргэжлийнхээ хувьд өндөр хариуцлагатай байх, хувь хүнийхээ зан байдлыг хатуу хянах үүрэг ноогдох ба тэр нь ёс зүйн хувьд тавигдах шаардлагаар хангагддаг.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтод төрийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх албаны чиг үүрэгтэй нь харшлахыг ойлгодог. Үүнээс байнга зайлсхийж, өөрийн болон төрийн байгууллагынхаа нэр хүндийг эрсдэлд оруулахгүй байх шаардлага төрийн албан тушаалтнуудад тавигддаг.

Манай улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод 2005 оны 4 дүгээр сарын 29-нд нэгдэн орсон. Энэхүү конвенцоор ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгон хэрэгжүүлэх амлалт авсан. Энэ зорилтын хүрээнд 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг батлан, хэрэгжүүлж байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчил, нийтийн алба, нийтийн ашиг сонирхол, нийтийн албан дах ашиг сонирхлын зөрчил зэрэг нэр томьёо, тодорхойлолтууд нь ойлголтын болон хэрэглээний түвшинд шинэ зүйл юм.

Хэрэв албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн сонирхлын үүднээс хандаж олон нийтийн итгэл найдварыг хөсөрдүүлбэл энэ нь нийгмийн шударга ёсыг ганхахад хүргэнэ. Түүнчлэн, тухайн албан хаагч өөрийн бөгөөд гэр бүлийн гишүүн, ойрын хамаатан,

төрөл садны хүмүүсийн эрх ашигт бага ч гэсэн үйлчилсэн, тэр нь төр, нийтийн эрх ашигт өчүүхэн төдий хохирол учруулаагүй байсан ч өндөр ёс суртахуунтай зарим улсад үүнийг ашиг сонирхлын зөрчилд тооцдог байна.[7]

3.2. Нийгмийн болон ёс зүйн тойргоос үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилдөөн.

Нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил нь авлигын сүүдэр, шалтгаан болдгийн хувьд улс орны эдийн засгийн хөгжил, ядуурлыг бууруулах, сайн засаглалыг хөгжүүлж, ардчиллыг бэхжүүлэхэд томоохон бэрхшээл учруулдаг байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтын үндсэн гол агуулга, зарчим нь "Төрийн албан тушаалтны шууд болон шууд бус хувийн болон санхүүгийн сонирхол нь үнэн зөв, бие даасан шийдвэр гаргахад нь нөлөөлөхөөр байвал тухайн асуудлаар албан байр суурια илэрхийлж болохгүй" байх явдал юм.[8]

Ашиг сонирхлын зөрчил.

"Ашиг сонирхлын зөрчил" гэдгийг нийтийн албан тушаалтан албаны чиг үүргээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал хэмээн тодорхойлсон.[9] Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн хувьд нэг талаас олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг, нөгөө талаас хувийн сонирхол хоорондоо зөрчилдөхийг ашиг сонирхлын зөрчил хэмээн ойлгож болно.

Нийтийн ашиг сонирхол.

"Нийтийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэл хэмээн тодорхойлсон[10]. Албан тушаалтны хашиж байгаа ажил, алба бол зөвхөн нийтийн ашиг сонирхолд чиглэж байх ёстой. Өөрөөр хэлбэл, "Нийтийн ашиг сонирхол /public interest/ гэдэг нь хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрсдийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байлгах үүрэгтэй.

Хувийн ашиг сонирхол.

"Хувийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ. Хувийн ашиг сонирхол /private interest/ гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүний хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг багтаан ойлгоно гэж судлаачид тэмдэглэдэг. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуу байдал бий болгохыг зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал,

---

7 Private gain from public loss: "How Thailand copes with corruption from conflict of interest" by Medhi Krongkaew, p.2.

8 Транспэрэнси Интэрнэйшнл, Авилгалын эсрэг сурвалж бичиг, Улаанбаатар, 2003 он, 132 дахь тал.

9 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

10 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль

өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно гэж үздэг.

Хамаарал бүхий этгээд.

Нийтийн алба хашиж байгаа хүний таны эцэг, эх, төрсөн ах, дүү, мөн гэр бүлийн гишүүн, таны эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, эгч, дүү тантай “Хамаарал бүхий этгээд” юм. Үүнд хамтран амьдрагч болон бусад нэгдмэл сонирхолтой этгээд ч мөн таны хувьд хамаарал бүхий этгээд болно.[11] “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 3 дугаар бүлэгт албан тушаалтан өөрийн хамаарал бүхий этгээдийнхээ хувийн ашиг сонирхолд нийцүүлэн үүсгэж болзошгүй харилцааг 12 төрлийн хориглолт, хязгаарлалт тус бүрээр зохицуулсан.

Ёс зүйн зөрчлийн тухай ойлголт: Ёс зүйн зөрчлийн нийтлэг ойлголт ёс зүйн нийтлэг, тусгай хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг ойлгоно.

Ёс зүйн зөрчил ба эрх зүйн зөрчил, ялгаатай болон нийтлэг тал.

Эрх зүйн зөрчил (анг.violation of law; ор. правонарушение) - ямар нэгэн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлийг тэмдэглэсэн төрлийн шинжтэй ухагдахуун. Дараах эрх зүйн зөрчил байдаг: иргэний (бие махбодод болон иргэний буюу байгууллагын эд хөрөнгөд гэмт хор учруулсан), захиргааны (жишээ нь, замын хөдөлгөөний журам зөрчсөн), сахилгын зөрчил (ажлын цаг хийдүүлсэн). Эрх зүйн зөрчлийн нэлээд аюултай төрөл нь гэмт хэрэг. Эрх зүйн зөрчилд иргэний, захиргааны, сахилгын ба эрүүгийн хариуцлагыг хуулиар тогтоосон байдаг. Захиргааны эрх зүйн зөрчил (англ. administrative offence / violation, ор. административное правонарушение) - тодорхой улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүй зөрчсөн, захиргааны хариуцлага хүлээлгэхээр хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүй. Захиргааны эрх зүйн зөрчлийн үндсэн шинж: эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэмд хор уршигтай, гэм буруутай, захиргааны шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэхүй.[12]

Сахилгын зөрчил (англ. disciplinary offence, ор. дисциплинарный проступок) дагаж мөрдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан, хууль зөрчсөн, гэм буруутай ажилтны хөдөлмөрийн буюу албан ажлын сахилгын зөрчил.

Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил (анг. constitutional vioation, ор. конституционное правонарушение) - Үндсэн хуулийн заалтыг (хэм хэмжээг) зөрчсөн ба ингэхдээ гэмт хэрэг, захиргааны, иргэний ба сахилгын эрх зүйн зөрчлийг бүрдүүлээгүй, үндсэн хуулийн эрх зүйн субъектийн гэм буруутай зан үйл ба үндсэн хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Эрүүгийн эрх зүйн зөрчил (англ. criminal action (acts), ор. преступное действие) эрүүгийн эрх зүйд эрүүгийн хуулиар хориглосон хэрэг үйлдсэн, эрүүгийн хууль зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй юм.

Ёс зүйн зөрчил ба эрх зүйн зөрчлийн нийтлэг тал нь ямар нэгэн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл бол ялгаатай тал нь эрх зүйн зөрчил нь нийтлэг субъекттэй бол ёс зүйн зөрчил нь тусгай субъекттэй байдаг. Эрх зүйн зөрчилд

[11] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

[12] Хуульчийн ёс зүй гарын авлага

хүлээлгэх иргэний, захиргааны, сахилгын болон эрүүгийн хариуцлагыг хуулиар тогтоосон байдаг бол ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тухайн хуульчийн мэргэшлийн ёс зүйн дүрмээр тогтоодог.

Прокурор ёс зүйн зөрчил гаргах нь иргэд, олон нийт, иргэний нийгмийн зүгээс прокурорт итгэх итгэлийг алдагдуулах, прокурорын байгууллагын нэр хүндийг бууруулах сөрөг үр дагавартай тул прокурорын ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулахад прокурорын ёс зүйн дүрэм оршдог.[13]

Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт нь прокурорын албаны үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлж, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх; прокурорын ёс зүй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, прокурорт итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх; прокурорын хараат бус байдлыг хамгаалахад оршдог.

Прокурор хууль, байгууллагын дотоод журам, прокурорын мэргэжил, ёс зүйн дүрэм зөрчсөн, эсхүл хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг сахилгын шийтгэл оногдуулдаг.[14]

Сахилгын шийтгэлийн төрлүүд:

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- зэрэг дэв бууруулах;
- албан тушаал бууруулах;
- ажлаас халах.

Прокурорын гаргасан гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэхийг тухай бүр Улсын Ерөнхий прокурорын газраас мэдээлэл авч, судалдаг ба сүүлийн жилүүдэд зөрчил гаргасан прокуроруудын тоо багассан ч хялбаршуулсан журмаар хянан, шийдвэрлүүлсэн зөрчил өссөн байна. Судалгаанаас үзэхэд прокуророуд согтууруулах ундааны зүйлс хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Мөн хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн бусад зөрчлүүдээс дурдвал:

- Тээврийн хэрэгслийг зорчих хэсэг дээр түр, удаан зогсоох журам зорчиж хөдөлгөөнд саад учруулсан
- Тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 10-50 хүртэл хувиар хэтрүүлсэн
- Тээврийн хэрэгсэл жолоодох үед хөдөлгөөнт утас хэрэглэсэн
- Замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг зөрчиж зүүн гар тийш эргэсэн, эсхүл буцаж эргэсэн зэрэг болно.[15]

Ийм учраас прокуроруудУлсын ерөнхий прокурорын албан даалгавар, прокурорын ёс зүйн дүрмийг уншиж, судлах ёс зүйн хэм хэмжээг мөрдөж хэвших, бусад зөвлөмж, мэдээллийг судалж, ёс зүй, сахилга хариуцлагаа сайжруулан, прокурорын нэр хүндийг өндөрт өргөж, бусдад үлгэр дуурайлал болох шаардлагатай юм.

[13] Прокурорын ёс зүйн дүрэм
[14] Прокурорын тухай хуульд зааснаар
[15] Прокурор, ажилтны гаргасан зөрчлийн талаарх судалгаанд үндэслэв.

3.3. Гадаад орны туршлага

3.3.1 Америкийн нэгдсэн улсын хувьд

Хуульч болох үе шат, цаашид ажил, мэргэжилд нь мэргэшүүлэх үйл явц АНУ-ын хуульч бэлтгэх үе шат, явц, ирээдүйн хуульчдад тавьдаг шаардлага нь хөгжиж буй манай улсын хуульч бэлтгэх, цаашид ажил, мэргэжилд нь мэргэшүүлэх үйл явцаас ихээхэн ялгаатай. Тухайлбал, Монгол Улсад хуульчийн эрх олгож байгаа хүнээ хувь хүний түвшинд нягталж, судлах дорвитой арга ажиллагаа байхгүй. Хууль зүйн сургууль төгссөн, хуульчийн шалгалтдаа тэнцсэн (тэнцсэн бол оноог харгалзан үздэггүй), зохих төлбөр хураамжаа төлсөн, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл, ял шийтгэл эдэлж байгаагүй бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг цуцлах шалтгаан гарах хүртэлх хугацаанд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгодог. Энэ нь цаашлаад шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах замыг нээж өгдөг. Харин АНУ-ын хувьд хуульчийг хүнийх нь хувьд маш нарийн, нухацтай судалж, зан байдлын хувьд хуульчаар ажиллаж чадах эсэхийг нь шалгадаг.

Тухайлбал, сургуульд суралцаж байхдаа сургуулийн дотоод дүрэм, журам зөрчсөн эсэх, санхүүгээ зохицуулах чадварын хувьд хэр вэ гэдгээс эхлээд зүй бус авиртай байсан эсэх, төлөгдөөгүй өр төлбөртэй эсэх, замын хөдөлгөөнд хэрхэн оролцдог болох зэрэг хувь хүнийхээ хувьд хуульч байх шаардлагыг хангасан эсэхийг нь маш нарийн шалгаж тогтоодог. Ийнхүү шалгалтыг давсан боловч хувь хүний зан байдлын хувьд хуульчийн мэргэжилд үл тохирох, мэргэжлийн нэр хүндэд халтай байж мэдэх этгээдийг хуульч болохоос нь өмнө зогсоодог байна. Мөн прокуророор ажиллах хуульчдад хуульчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагад чухал ач холбогдол өгч, өндөр түвшинд авч үздэг. Энэ хүрээнд мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг хуульчийн шалгалтын нэг бүрэлдэхүүн төдий бус, харин бие даасан шалгалтаар үнэлдэг бөгөөд түүнд тэнцэх хувь ч харьцангуй өндөр (76-86%) юм. Мөн уг шалгалтыг прокурорын мэргэжлийн шалгалтаас өмнө өгөх бөгөөд ингэснээр мэргэжлийн ёс зүй, хариуцлагын талаар ойлголт төсөөлөлгүй хүн ажиллах эрхгүй болдог байна.

Мэргэжлийн хариуцлагын шаардлага

АНУ-ын хувьд Висконсин, Пуэрто-Рикогоос бусад бүх мужид Мэргэжлийн хариуцлагын муж хоорондын шалгалт өгсөн байх шаардлага тавьдаг. Барын шалгагчдын Үндэсний конференц хэмээх байгууллага тус шалгалтыг жилд гурван удаа зохион байгуулдаг байна. Шалгалтад оролцогч нь олон хариулттай нийт 60 гаруй асуултыг хоёр цагийн хугацаанд бөглөдөг. Тэнцэх оноо нь мужуудаар ялгаатай бөгөөд 75-86 хувиар тогтоодог. Оноог зөв хариултын тоогоор тооцно. Агуулгын хувьд хуульчийн мэргэжлийн дүрэм (6-12%), хуульч үйлчлүүлэгч хоорондын харилцаа (10-16%), үйлчлүүлэгчийн нууц хадгалах (6-12%), ашиг сонирхлын зөрчил (12-18%), мэргэжлийн чадвар, зохисгүй байдал, хуульчийн хүлээх иргэний эрх зүйн хариуцлага (6-12%), шүүхэд төлөөлөх болон өмгөөллийн бусад үйл ажиллагаа (10-16%), үйлчлүүлэгчээс бусад этгээдтэй харилцах, хэлцэл хийх (2-8%), бусад үйл ажиллагаанд оролцох (4-10%), үйлчлүүлэгчийн болон бусдын хөрөнгийг итгэмжлэн хадгалах, бусад өмч хөрөнгийн харилцаа (2-8%), хууль зүйн үйлчилгээнд бусадтай харилцах (4-10%), хуульчийн олон нийтийн өмнө болон эрх зүйн тогтолцооны өмнө хүлээх үүрэг (2-4%), шүүгчийн сахилга, ёс зүй (2-8%) зэрэг байна. Хуульчийн эрх авах хүсэлт гаргахаасаа өмнө дээрх шалгалтыг өгсөн байх бөгөөд зарим мужид шалгалт өгснөөс хойш таван жилийн хугацаанд уг шалгалтын дүнг хүчинтэйд

тооцдог.[16] Цаашид 5 жил тутамд ажиллах эрхийн шалгалт өгдөг байна.

Зан байдал, тохирох байдлын шаардлага

АНУ-ын ихэнх мужид прокурор болоход өндөр ёс суртахуунтай байхыг шаарддаг бөгөөд энэ үүднээс шалгуулагчийг хүнийх нь хувьд судалж үздэг. АНУ-ын нийт 51 мужаас 41-д нь прокурор хүний зан байдлын тодорхой стандартыг зааж өгчээ. Тухайлбал, дөрвөн мужид өмнө нь хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй.[17] Зан байдлын шалгуур тавьдаг мужуудаас Калифорнийн туршлагыг сонгож судалсан бөгөөд тус муж нь ёс суртахууны төлөвшлийг зургаа хүртэлх сарын хугацаанд судалдаг байна. Уг судалгаа урт хугацаанд үргэлжилдэг учраас оролцогч нь хуулийн сургуульд суралцаж байх хугацаандаа хүсэлтээ өгч болдог ажээ. Калифорни мужийн Барын дүрмийн 4.40-д **“ёс суртахууны сайн чанар”** гэдэгт чигч, шударга, итгэл даахуйц, хариуцлагатай, хуульд хүндэтгэлтэй хандаж сахидаг, бусдын эрх болон шүүхийн процессыг хүндэтгэдэг байх гэж заасны дагуу мужийн Барын холбооноос оролцогчийн түүхийг дээрх чиглэлээр судалдаг.[18]

Хуульчийн шалгалт амжилттай өгч, мэргэжлийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, ёс зүйтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх чадавхтай хуульчийг болохоор прокурорын мэргэжлийн шалгалт өгч, өөрийн мэдлэг, сахилга хариуцлага, ёс зүй, шударга, итгэл даахуйц, хариуцлагатай чадвараараа шалгарсан хуульчид прокуророор томилогдон, тангараг өргөн ажилладаг байна.

Мөн прокуророор ажиллахдаа өөрийн мэргэжлийн хүрээнд дараах мэдлэгийн хүрээг илүү гүнзгийрүүлэн судалж, өөрийг хөгжүүлэхийг шаарддаг байна. Үүнд:

а. Материаллаг болон процессын эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
б. Хууль зүйн дүн шинжилгээ, үндэслэл гаргах, хууль зүйн судалгаа, асуудал шийдвэрлэх, хууль зүйн агуулгаар бичгийн болон аман хэлбэрээр харилцах, мэтгэлцэх, илтгэх чадварыг хөгжүүлэх;
в. Эрх зүйн тогтолцооны болон иргэнийхээ өмнө мэргэжлийн ёс зүй, сахилгын зохих үүрэг хариуцлагыг хэрэгжүүлж ажиллах;

Прокурорууд ажлаа төлөвлөхдөө мэргэжлийн ур чадвар, ёс зүйн бусад шаардлага, шалгуурыг хангахад шаардагдах мэргэжлийн ур чадвар (Жишээ нь, зөвлөх, мэдүүлэг, тайлбар авах, хэлэлцээр хийх, үйл баримт нотлох, дүн шинжилгээ хийх, шүүх хуралдаанд яллах байр суурьтай оролцох, баримт бичиг боловсруулах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, хууль зүйн ажлын зохион байгуулалт, менежмент, хамтран ажиллах, өөрийгөө үнэлэх, соёлын хувьд зохих шаардлага хангах гэх мэт)-уудад мэргэшихэд анхаарч төлөвлөдөг байна.

[16] National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020, p. 26 https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FComp Guide2020_021820_Online_Final.pdf

[17] National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020, p. 26 https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FComp Guide2020_021820_Online_Final.pdf

[18] https://www.calbar.ca.gov/Admissions/Moral-Character/Factors-and-Conduct

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Прокурорын тухай хууль
3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Ном, товхимол, гарын авлага, бусад.

1. Философич Жэрэми Бентам “Ёс суртахуун ба хуулийн зарчмууд”
2. Хуульчийн ёс зүй гарын авлага
3. Транспэрэнси Интэрнэйшнл, Авилгалын эсрэг сурвалж бичиг, Улаанбаатар, 2003 он, 132 дахь тал.
4. Прокурорын ёс зүйн дүрэм
5. Улсын ерөнхий прокурорын газрын Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын хэлтсээс гаргасан судалгаа \Прокурор, ажилтны гаргасан зөрчлийн талаарх судалгаа 2023 оны хагас жилийн байдлаар\

Гадаад хэлээр

1. ‘Richterzeitstudien’ Cf. Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.II,1974 pp.60 et seq.; Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.I,1974 pp.182 et seq.; G.Griebeling, Die Arbeitszeit des Richters, DRiZ 71pp.228 et seq;
2. R.Zwiesele&R.Bender, ‘Betriebswirtschaftliche Methoden und Vorschlage zur Verbessung der Justizorganisation’; 12. R.Depre et al., Etude de faisabilite de la mise en euvres d’un instrument de mesure de la charge de travail destine au siege, p.3.
3. Private gain from public loss: “How Thailand copes with corruption from conflict of interest” by Medhi Kroenke, p.2.

Цахим эх сурвалж

1. National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020, p. 26 https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FComp Guide2020_021820_Online_Final.pdf
2. https://www.calbar.ca.gov/Admissions/Moral-Character/Factors-and-Conduct

БҮЛЭГ 4. ПРОКУРОРЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

СЭДЭВ 1. ХАРААТ БУС БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

1.1 Прокурорын хараат бус, бие даасан байдлын тухай ойлголт
1.2 Прокурорын хараат бус бие даасан байдлын эрх зүйн үндэс
1.3 Прокурорын хараат бус байдлын бүрдэл хэсэг
1.4 Прокурорын нөлөөллийн мэдүүлэг

СЭДЭВ 1. ХАРААТ БУС БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурорын хараат бус байдал, хараат бус байдал ба хариуцлагын харилцан хамаарлын талаар системтэй суурь ойлголт өгөхийг зорьсон бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бусдын нөлөөнд автахгүй гаргах талаар тодорхой авч үзсэн болно.

1.1. Прокурорын хараат бус, бие даасан байдлын тухай ойлголт

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцан хяналт тэнцвэртэй, чиг үүрэг нь халдашгүй дархан, бие даасан удирдлага, зохион байгуулалттай болохыг үзэл баримтлалын төвшинд тодорхойлсны зэрэгцээ шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг тодорхойлсон байдаг. Прокурорын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн байгууллага болохын хувьд прокурорын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан.

Ардчилсан улсын шүүгч, прокурорын талаарх Бордогийн тунхаглалд[1] дараах агуулгыг тусгасан (үндсэн баримт бичиг) байдаг. Үүнд:

1. Шударга, төвч, үр нөлөөтэй шударга ёсны тогтолцоогоор баталгаажсан эрх зүйт ёсыг төлөвшүүлэх нь нийгмийн эрхэм ашиг сонирхол юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд шүүгч, прокурор нь хувь хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангуулж, нийтийн дэг журмыг сахиулдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны шаардлага нь яллах болон цагаатгах талд адил эрх хэмжээ байх, шүүхийн хараат бус байдал хангагдсан байх, төрийн эрх мэдлийг хуваарилсан байх, шүүхийн шийдвэр эцсийн бөгөөд хуулийн хүчин төгөлдөр байх зэрэг байдаг.
2. Шүүгч, прокурорын онцгой бөгөөд эрхэм чиг үүргийн хэрэгжилт нь шударга, төвийг сахисан, үр нөлөөтэй шударга ёсны тогтолцоог баталгаажуулахад чухал үүрэгтэй. Шүүгч, прокурор нь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хараат бус байдлын баталгаагаар хангагдах ёстой бөгөөд энэ хүрээнд өөр хоорондоо хараат бус байх явдал адил тавигдана.
3. Бүтэц зохион байгуулалтын, үйл ажиллагааны, материал, хүний нөөцийн зэрэг хангалттай нөөц хөрөнгийг шударга ёсны тогтолцоонд зориулж хуваарилах ёстой.
4. Шүүгч, шүүхийн иргэдийн төлөөлөгч нь прокуророос шилжүүлж ирсэн хэрэг маргааныг яллах, цагаатгах тал болон бусад хөндлөнгийн элдэв нөлөөнөөс ангид зохих ёсоор шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.
5. Хуулийн хэрэгжилтийг хангах, зарим тохиолдолд шүүхийн өмнө шатанд өөрийн

[1] Энэ тунхаглал нь тайлбар, тэмдэглэлтэй. Тунхаглалыг Европын Шүүгчдийн Зөвлөлдөх Зөвлөл, Европын Прокурорууд ын Зөвлөлдөх Зөвлөлөөс байгуулсан ажлын хэсэг хамтран Францын Бордо хотод боловсруулсан бөгөөд (ЕШЗЗ, ЕПЗЗ-өөс) Словенийн Бордо хотод 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр албан ёсоор батлан гаргасан.

итгэл үнэмшилдээ тулгуурласан эрх хэмжээг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа нь прокурорын эрх зүйн байдлыг хуулиар аль болох өндөр түвшинд, шүүгчидтэй адил байдлаар тогтоохыг шаарддаг. Прокурор нь шийдвэр гаргахдаа хараат бус, бие даасан байж, чиг үүргээ шударга, обектив, төвийг сахисан байдлаар хэрэгжүүлэх ёстой.

6. Прокурорын хараат бус байдлын хувьд дараах минимум стандартыг хангана. Үүнд:
   - Ажил, албан тушаал, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь прокурорын байгууллагын гаднаас ирэх аливаа хөндлөнгийн эх сурвалжтай нөлөөллөөс ангид байх;
   - Сонгон шалгаруулж томилох, ажил мэргэжлийн хувьд хөгжих, шилжүүлэх тохиолдолд зөвхөн хуульд заасны дагуу өөртэй нь зөвшилцөж шийдвэрлэх зэрэг ажил албан тушаал нь хэвээр хадгалагдахтай холбоотой, цалин хөлс зэрэг баталгааг хуулиар олгосон байх.
7. Эрх зүйт ёс засагладаг, прокурорын байгууллага нь босоо удирдлагын тогтолцоотой улсад прокурорын үр нөлөөтэй ажиллагааг хангах явдал нь байгууллага доторх эрх хэмжээ, хариуцлагатай байдал, хариуцлагын ил тод байдлыг хангахтай шууд холбоотой. Прокурорт өгч буй аливаа чиглэлийг холбогдох хууль тогтоомж, тавигдах шалгуур шаардлага нь олон нийтэд нээлттэй ил байдаг зөвлөмж, зааварчилгаанд үндэслэн бичгийн хэлбэрээр өгөх ёстой. Яллах, яллахаас татгалзах тухай прокурорын шийдвэрийг гагцхүү төвийг сахисан, объектив хяналтаар хянана. Ямар ч тохиолдолд хохирогчийн ашиг сонирхлыг хангахыг эрмэлзэх ёстой.
8. Шударга ёсны тогтолцоог зохих ёсоор нь төлөвшүүлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүхий л мэргэжилтэн. алба хаагчид нийтлэг хууль зүйн зарчим, ёс зүйн үнэт зүйлийг баримтлах явдал чухал. Менежментийн зэрэг чиглэлийг агуулсан сургалтад оролцох нь шүүгч, прокурорын үүрэг байх ёстой. Ийм сургалтыг оролцогчдын хараат бус, төвийг сахих зарчмыг хангахуйц байдлаар тогтмол зохион байгуулж, холбогдох үнэлгээг тухай бүр хийж байх нь зүйтэй. Шаардлагатай тохиолдолд шударга ёсыг хангах эрхэм дээд ашиг сонирхлын тулд тодорхой нийтлэг асуудлаар шүүгч, прокурор, бусад хуульчдын сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж болно.
9. Хэвлэл мэдээллийг байгууллагад хууль, шүүхийн тогтолцооны үйл ажиллагааны талаар олон нийтэд хүргэх хангалттай хэмжээний мэдээ мэдээллийг саадгүй олж авах нөхцөлийг бүрдүүлэх нь мөн нийгмийн ашиг сонирхол юм. Эрх бүхий байгууллагын зүгээс энэ төрлийн мэдээ мэдээлэл. ялангуяа хуулийн дагуу гэм буруутайд тооцохоос нааш гэм буруугүйд тооцох шүүгдэгчийн эрх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй оролцогчдын шударгаар шүүлгэх эрх, хувийн болон гэр бүлийн амьдралын нууцын асуудлыг нухацтай харгалзсаны үндсэн дээр хэвлэл мэдээллийн байгууллагад хүргэж байвал зохино. Шүүх, прокурорын байгууллага аль аль нь хэвлэл мэдээлэлтэй харилцах сайн туршлага, зөвлөмжийг агуулсан дүрэм боловсруулж гаргасан байвал зохино.
10. Прокурорын цуглуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж байгаа мэдээ баримт сэлтийн агуулга, эх сурвалж нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах зорилгын тулд тодорхой байх, шүүгч, хэргийн оролцогч талууд зэрэгт нээлттэй байх ёстой.

1.2. Прокурорын хараат бус, бие даасан байдлын эрх зүйн үндэс

Прокурорын байгууллагыг гагцхүү хуульд үндэслэн байгуулах ба бие даасан, хараат бус байдалтай байна. Ардчилсан нийгэмд парламент, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын аль нь ч тодорхой хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл өгөх эсхүл прокурорын шийдвэрийг өөрчлүүлэхээр саад бэрхшээл учруулах зэргээр үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлөх эрхгүй.[2]

Хараат бус байдал:

"Прокурор, шүүгчийн хараат бус байдлыг нэг талаас шүүгч аливаа дарамт, нөлөөллөөс ангид байдлаар зөвхөн баримт нотолгоо, хуульд тулгуурласан шийдвэр гаргах эрх чөлөөгөөр хангагдсан байхыг хараат бус байдал гэнэ" хэмээн ерөнхий байдлаар тодорхойлсон байдаг. Харин зарим судлаач уг тодорхойлолтыг улам бүр дэлгэрүүлэн, "шийдвэрийн хараат бус байдал";"салбарын хараат бус байдал"; "удирдлагын хараат бус байдал"; "хувийн хараат бус байдал" гэх зэргээр ангилж авч үзсэн байна.[3]

> Прокурорын тухай хуулийн 7 дугаар зүйл.Хараат бус, бие даасан байх
>
> 7.1.Прокурор шийдвэрээ хуульд нийцүүлэн хараат бусаар гаргана.
>
> 7.2.Прокурорын шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад нь хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.
>
> 7.3.Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд албан тушаалтан, хүн, хуулийн этгээд хууль бусаар нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Хуульчийн хувьд шийдвэр гаргалт ялангуяа прокурорын хувьд хараат бус байх, бие даасан байх гэсэн тусдаа ойлголт, ухагдахуун бөгөөд үүнийг ялгаж олгох нь чухал. Өөрөөр хэлбэл хараат бус байдал нь нөлөөллийн шинж чанартай ойлголт бол бие даасан байдал нь статусын шинж чанартай ойлголт гэдгийг анхаарвал зохино.

Бие даасан байдал: гэдэг нь (хэргийн онол болон олон улсын баримт бичгүүдийг[4] шүүн үзвэл)

- Прокурорын байгууллагын төсөв, үйл ажиллагаа бие даасан шинжтэй байх ба бусад байгууллагын үйл ажиллагаанаас ангид, хамааралгүй байхыг ойлгох ёстой.

Товчхондоо бие даасан байдал нь Прокурорын байгууллагад, хараат бус байдал нь тухайн прокурорт хамааралтай агуулга юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд прокурорын гүйцэтгэх үүрэг голлох байр суурьтай. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн өмнө эрх тэгш байх, гэр бүрүүгүйд тооцогдох, шударгаар шүүлгэх, гэсэн суурь зарчмуудыг дээдэлж, тэдгээрт үйл ажиллагаагаа нийцүүлж байхыг шаарддаг. Ингэснээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударга, үндэслэлтэй байх, иргэдийг гэмт хэргээс үр ашигтайгаар хамгаалж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлнө.

Прокурорын үүргийн тухай НҮБ-ын удирдамжид[5] зааснаар прокурор эрүүгийн

---

[2] Ардчилсан улсын шүүгч, прокурорын талаарх Бордогийн Тунхаглалын 8, 9 дэх хэсэг.

[3] https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2018/Shuugchiin%20bodlogiin%20sudalgaanii%20tailan.pdf

[4] "Шүүхийн хараат бус байдал (Judicial independence)Олон улсын баримт бичиг. Н.Лүндэндорж нар хянан тохиолдуулсан. 2019 он 145-161 дэх тал.

[5] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон зөрчил гаргагчтай харьцах асуудлаарх НҮБ-ын 8-р Их хурлаар батлагдсан. 1990.

хэргийг мөрдөн шийдвэрлэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх гүйцэтгэдэг ба, тэр дундаа эрүүгийн хэрэг үүсгэх, хуулиар зөвшөөрөгдсөн үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, дээрх ажиллагаа хуулийн дагуу явагдаж эсэхэд хяналт тавих, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилд хяналт тавих, нийтийн ашиг сонирхлын төлөөлөгчийн хувьд бусад чиг үүргийг гүйцэтгэх ёстой.[6] Прокурор хуулийн дагуу үүргээ шударгаар, тасралтгүй түргэн шуурхай биелүүлж хүний нэр төрийг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалахыг урьтал болгоно.[7] Прокурор дараах чиг үүргийг онцгойлон анхаарах ёстой. Үүнд:

- өөрийн чиг үүргийг алагчлалгүйгээр гүйцэтгэж, улс төрийн итгэл үнэмшил, нийгмийн гарал, яс үндэс, соёл, хүйс бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдлаас зайлсхийнэ:
- нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, тал бүрээс нь бодитойгоор тогтоож, сэжигтэн болон хохирогчийн байдлыг зохих ёсоор харгалзан, хэрэгт хамаарах яллах, цагаатгах баримтыг бүрдүүлэх ёстой:
- хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх явцад болон шүүх эрх мэдлийн сонирхол өөрөөр байхыг шаардаагүй бол мэргэжлийн нууцыг хадгалах:
- Хохирогчийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед тэдний санал, нөхцөл байдлыг хянан үзэх, хохирогчид өөрийн эрхтэйгээ танилцах нөхцөлийг хангах[8] зэрэг болно.

Хүний эрхийг хангах үүрэгтэй нь холбоотойгоор прокурор төрийн албан хаагчдын үйлдэж байгаа гэмт хэрэг, тэр дундаа хүний эрхийг зөрчсөн гэмт хэрэгт онцгой анхаарах хэрэгтэй ба эрүүдэн, шүүх, харгис хэрцгийгээр, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжилсон бусад хэлбэрээр олж авсан аливаа нотлох баримтыг ашиглахаас татгалзах ёстой.[9]

Прокурорын тухай хуулийн 56 дугаар зүйл.Хараат бус байдлын баталгаа

56.1.Прокурорын бүрэн эрхийг энэ хуульд зааснаас өөр үндэслэл, журмаар хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглоно.

56.2.Хуульд зааснаас бусад тохиолдолд прокурорыг чөлөөлөх, халах, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд томилохыг хориглоно.

56.4.Прокуророос хяналт тавьж байгаа болон шийдвэрлэсэн хэргийнх нь талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авахаар шаардахыг хориглоно.

56.6.Прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос бусад этгээдэд хэргийн талаар мэдээлэл өгөх үүрэг хүлээхгүй.

56.7.Прокурорт хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Шүүгч, прокурор аль аль нь хариуцсан чиг үүргээ шударга, төвийг сахисан, объектив, нэгдмэл (consistently) байдлаар хэрэгжүүлэх бөгөөд хүний эрхийг хүндэтгэж хамгаалахын төлөө тууштай ажиллах, шударга ёсны тогтолцооны хурдан шуурхай, бүтээмжтэй ажиллагааг хангахын төлөөх бүхий л арга хэмжээг авах ёстой.

Прокурор нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ итгэл үнэмшлээрээ (боломж олгох зарчим) болон заавал яллах гэсэн хоёр тогтолцооны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Аль

[6] Мөн удирдамжийн 11-р зарчим.

[7] Мөн удирдамжийн 12-р зарчим.

[8] Мөн удирдамжийн 13-р зарчим.

[9] Прокуроруудын үүргийн тухай НҮБ-ын удирдамжийг бүхэлд нь болон 10-16-р зарчмуудыг үзнэ үү. Мөн Прокурорын үндсэн эрх, үүргийн тухай ойлголт, мэргэшлийн хариуцлагын тухай стандарт. Прокуроруудын олон улсын нийгэмлэг. 1999 он.

ч тохиолдолд прокурор нь зөвхөн нийгмийг төлөөлж ажилладаггүй бөгөөд хувь хүмүүст холбогдох онцлог чиг үүрэгтэй. Тухайлбал, шударга ёсоор хандах үүрэг нь чиглэдэг яллагдагч, эрх, эрх чөлөөг нь хангуулах ёстой гэмт хэргийн хохирогч зэргийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн харгалзаж чиг үүргээ хэрэгжүүлдэг.[10]

Прокуророос чиг үүргээ хэрэгжүүлэх гарцаагүй нөхцөл нь хараат бус байдал бөгөөд прокурор хуулийн хүрээнд болон нийгмийн хүрээнд гүйцэтгэх чиг үүргийг бэхжүүлж өгөх төдийгүй шударга ёсны тогтолцоо шударга, үр нөлөөтэй ажиллаж шүүхийн хараат бус байдал хэрэгжих үндсэн тулгуур нь юм. Иймд шүүгчдийн хараат бус байдлыг хадгалж хамгаалах угтвар нь болдог прокурорын хараат бус байдал нь тэдний эрх дарх бус, харин нийтийн болон хувь иргэний ашиг сонирхлыг хамгаалдаг шударга, төвийг сахисан. үр нөлөөтэй шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх баталгаа нь билээ.

Заавал болон итгэл үнэмшлээрээ яллах зэрэг прокурорын чиг үүргийг улс орнууд өөрийн төрийн эрх мэдлийн институт, прокурорын байгууллагын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эзлэх байр суурийг харгалзан өөр өөрөөр тодорхойлжээ.

Эрх зүйн байдал нь ямар байхаас үл шалтгаалаад прокурор нь ял шийтгэл сонсгох эсхүл бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг гэдгээс үл хамааралд хараат бус байдлын хэрэгжихүйц баталгаагаар бүрэн дүүрэн хангагдана. Босоо удирдлагын тогтолцоотой эсэхээс үл хамааран прокурорын хариуцлагатай байдлыг төлөвшүүлж, эрүүгийн хэргийг дур зоргоор эсхүл тэгш бус байдлаар үүсгэж яллахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой ойлгомжтой, ил тод зөвлөмж, зааварчилгааг гарган мөрдүүлнэ. (Тунхаглалын 9 дэх хэсэг)

Прокурорт өгөх аливаа чиглэл заавар нь зөвхөн бичгийн хэлбэртэй байх бөгөөд хуульд нийцсэн, олон нийтэд нээлттэй тавигдсан прокурорын байгууллагын зааварчилгааны дагуу бичигдсэн байна.

1.3. Прокурорын хараат бус байдлын бүрдэл хэсэг

Прокурорын хараат бус байдлыг шүүхийн хараат бус байдалтай нэгэн ижил түвшинд авч үздэг. Сэжигтэн, яллагдагч, хохирогч аль ч оролцогчийн, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаар нөхцөл байдлыг үнэлэх, хангаж хамгаалах зэрэг прокурорын чиг үүргийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар, түүнчлэн шүүгч, прокурорын ажил үүргийн зааг ялгааг нарийвчлан тодорхойлсон нөхцөлд л үр нөлөөтэй хэрэгжүүлж болно. Эрх зүйт ёсонд суурилсан ардчилсан аливаа тогтолцоонд прокурорын үйл ажиллагааны бодлогыг тогтоодог арга хэрэгсэл нь зөвхөн хууль юм.

Монгол Улсад прокурорын хараат бус байдал нь Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа, 59 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа, 60 дугаар зүйл. Нийгмийн баталгаа, 61 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа, 62 дугаар зүйл. Прокурорын иргэний эрхэд тавих хязгаарлалт гэсэн зүйл хэсгүүдээр баталгааждаг. Гарын авлагын энэхүү хэсэгт тус заалтуудын тухай гэхээсээ илүүтэй харин хараат бус байдлын тухай ойлголтыг нэмэгдүүлэх, түүнийг хэрхэн хангах талаар авч үзэх болно.

[10] Ардчилсан улсын шүүгч, прокурорын талаарх Бордогийн Тунхаглалын тайлбар, зөвлөмж

Анхаарах зүйл: Прокурорын хяналтын үйл ажиллагаа явуулахад хараат бус байдалд нөлөөлөхүйц дарамт, шахалт, үйл ажиллагаа, хууль бус үйлдэлтэй байнга тулгарч байдаг бөгөөд түүнийг шийдвэрлэх дадал, биеэ зөв авч явах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх эрэг хандлагатай байх нь чухал.

Прокурорын хараат бус байдлыг **албаны** болон **хувийн** хараат бус байдал хэмээн ангилж болохоор байна.

А/ Албаны хараат бус байдлын талаар:

Албаны хараат бус байдалд ***үйл ажиллагааны хараат бус байдал, шийдвэрийн хараат бус байдал*** хамаарна.

ЭХХШТхуулийн холбогдох зүйл заалтын дагуу прокурорууд мөрдөн шалгах ажиллагааны үед хүний эрхийг хангаж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцдог. ЭХХШТ хуулийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд мөрдөн шалгах үе шатанд прокурорт тодорхой эрх олгож, үүрэг хүлээлгэсэн байдаг.

Прокурорын бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ прокурорын эрх зүйн хэлбэрээр шийдвэр гаргадаг бөгөөд хууль зөрчсөн үйл баримтыг арилгах, урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр гаргаж, зөвшөөрөл олгоход чиглэгддэг. Сүүлийн үед Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх явцад оролцогчдоос болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр хяналт тавьж буй хэрэгтэй нь гаргасан шийдвэртэй нь холбогдуулан худал мэдээлэл тараах, нэр хүндэд нь халдах мэт хууль бус нөлөөллийн шинжтэй асуудлууд гарч байна. Иймд прокурорууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцахдаа мэдрэмжтэй байх, шаардлагатай бол хурдан няцаах арга хэмжээ авах, нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зэрэг ур чадвар, дадал эзэмших шаардлагатай.

Прокурорт ирэх хөндлөнгийн нөлөөллийн талаар (төсөөлөл) судалгаанд[11] иргэдийн хувьд прокурорт удирдах албан тушаалтан, сайд дарга нар, УИХ-ын гишүүд ихээхэн нөлөөлдөг гэсэн төсөөлөл өндөр байна.

Харин дунджаар прокурорууд 70.6 нь хэргийн яллагдагч, шүүгдэгч, зөрчлийн холбогдогч иргэнээс ирсэн хууль бус нөлөөлөл гэж хариулсан байна. Оролцсон прокурорын тоотой харьцуулж үзэхэд ААНБ, Захиргааны байгууллагаас ирсэн тохиолдол орон нутагт илүү өндөр байна. Хууль бус нөлөөлөлд үзүүлсэн хариу үйлдлүүд ихэвчлэн дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Зохисгүй үйлдлээ зогсоохыг шаарддаг;
- Дарга, удирдах албан тушаалтанд нь мэдэгддэг;
- Дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсвэл шийдвэрлэх эрх бүхий байгууллагад албан ёсоор өргөдөл, гомдол гаргадаг;
- Авлигатай тэмцэх газарт мэдээлдэг;
- Ямар нэг арга хэмжээ авдаггүй;

Улс орон бүр прокурорын бие даасан хараат бус байдлыг хууль тогтоомждоо хуульчлан зааж практик дээр хамгаалдаг. Прокурорын хараат бус байдалд нөлөөлөх гаднын нөлөөлөл нь маш олон хэлбэртэй байдаг. Төр, засгийн албан тушаалтнууд, эсхүл хэрэг маргааны оролцогч талуудын зүгээс тодорхой хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар прокурорт тушаал заавар өгөх зэргээр нөлөөлөх оролдлогууд ч байдаг. Дээрх тохиолдлуудаас нийтлэг гардаг үйлдэл, эс үйлдэхүй нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

[11] "Прокурорын байгууллагын шударга байдлын судалгаа" судалгааны тайлан 2018 он

- Боловсон бус, зохисгүй харьцах;
- Доромжилж нэр хүнд гутаах;
- Үл тоомсорлосон, үл хайхрах
- Бие махбодод халдах /цохих, өшиглөх, түлхэх г.м/;
- Хуурч мэхлэх, худал мэдээлэл өгөх замаар хэрэг маргааны шийдвэрлэлтэд нөлөөлөхийг оролдох;
- Ёс зүйн болон процессын хууль, дүрэм, журмыг зориуд зөрчих, саад учруулах байдлаар хэрэг асуудлын шийдвэрлэлтэд нөлөөлөхийг оролдох;
- Мөнгө, эд хөрөнгө өгч хэрэг, асуудлыг тодорхой байдлаар шийдүүлэх санал тавих;
- Хамт ажиллагсад, удирдах албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдох;
- Айлгах, сүрдүүлэх, дарамтлах байдлаар хэрэг, асуудалд нөлөөлөхийг оролдох;
- Хэрэг, асуудлыг тодорхой байдлаар шийдэхийг гуйсан, ятгасан, тайлбарлаж; ойлгуулахыг оролдох.

Дээрх тохиолдолд прокуророос дараах алхмуудын аль нэгийг хийж болно. Үүнд:

- нөлөөллийн мэдүүлэг гаргах;
- прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан зөрчлийн шинжтэй бол хууль сахиулах байгууллагад уг асуудлыг шилжүүлэх; (Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсний дараа гарах шийдвэр)
- төрийн албан хаагчийг заналхийлэх гэмт хэргийн шинжтэй бол уг асуудлыг хууль сахиулах байгууллагад шилжүүлэх; (Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсний дараа гарах шийдвэр)
- хэвлэл мэдээллийн албаар, хэвлэлийн төлөөлөгчөөр дамжуулан зөвтгөл хийх, мэдэгдэл гаргах, тайлбар хийх
- Монголын Хуульчдын Холбооны Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороонд эрхээ хамгаалуулахаар хандах зэрэг болно.

Цагдаагийн байгууллагад хандах, мэдээлэл өгөх

Тодорхой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж, тухайн хэрэгт яллагдагчаар татах тогтоолыг баталж, яллах дүгнэлт үйлдэж, анхан шатны шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцдог. Гэтэл энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан буруу мэдээлэл түгээх, тодорхой бус эх сурвалжаас “авлига авсан, нөгөө талд үйлчилдэг” гэх мэтээр дайрч давшлах тохиолдолд ямар хариу арга хэмжээ авахаа прокурор мэддэггүй ба сэтгэл зүйн хувьд дарамтад орж стресстдэг.

Зөрчлийн тухай хууль

15.6 дугаар зүйл.Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах

1.Хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь прокурорт санаатайгаар саад учруулсан, эсхүл доромжилсон, эсхүл эрх чөлөөнд нь халдсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хараат бус байдалд нөлөөлөх оролдлогын дийлэнх нь Зөрчлийн тухай хуулийн 15.6-д заасан зөрчлийн үйлдэл, эс үйлдэхүй байдаг ба иймэрхүү хууль бус үйлдэл, доромжлолд ямар нэгэн хариу өгөхгүй байх эсхүл прокурорыг үйл ажиллагаатай нь холбогдуулан тайлбар авч, дотоод хяналт шалгалт явуулах зэргээр хараат бус байдлыг сулруулах зэрэг зохисгүй байдлууд гардаг.

Хэрэв прокурорын хараат бус байдалд нөлөөлөх оролдлого, гүтгэлэг, доромжлол, заналхийлэл нь гэмт хэргийн шинжтэй бол тухайн үйлдэл эс үйлдэхүйг шалгуулахаар цагдаагийн байгууллагад үйл баримтын хамт шилжүүлэх ба тухайн гомдол мэдээлэлд өөр прокурор хяналт тавих ёстойг анхаарах нь зүйтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах нь

Нийгэмд нэр нөлөө бүхий этгээдүүдийн хэргийг шалгах явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан хуулийн байгууллага улс төрийн зорилгоор хилсээр яллаж байгаа мэт ойлголтыг олон нийтэд төрүүлж, ард иргэд нийгэмд хууль хяналтын байгууллага хэн нэгэн эрх мэдэл бүхий албан тушаалтны ашиг сонирхлын үүднээс буруугүй хүнийг буруутан болгож, ял шийтгэл оногдуулдаг мэтээр буруу ташаа мэдээлэл өгч байгаа нь чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа прокурорыг үүрэгт ажлаа хэвийн явуулахад нь сөргөөр нөлөөлж байна.[12]

Аль ч тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй тухайн прокурор шууд өөрөө харьцах нь ихээхэн эрсдэл дагуулдаг ба ажлын стресс, сэтгэл зүйн байдлаас шалтгаалан хатуу ширүүн ярих, уурлах зэрэг сэтгэл хөдлөлөө барих чадваргүй болдог. Иймээс хэвлэл мэдээллийн алба, ажилтнаар дамжуулан зөвтгөсөн, прокурорын хараат бус байдлыг хамгаалсан мэдээлэл, танилцуулга нийтэд чиглэн өгөх нь үр дүнтэй.

Жишээ 1: 2023 оны 8 дугаар сард Facebook –ийн Dens.mn хэмээх пэйж хуудсанд *“Бургас хядаач,* сошиалын ногоон малгайт Шадар сайд маань намайг заавал Эрүүгийн ялтан хэвээр үлдээмээр байна гэжээ! Хүслийг нь гүйцэлдүүлэгч ..... дүүргийн прокурор Э.Б гэдэг эмэгтэй. Үндсэн хууль ямар хамаатай юм. Нотлох баримтгүй ч би чамайг бодлоороо яллуулна гэж ам бардам хэлдэг нэгэн. Надад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн ял өгсөн...Шэйр хийж өгнө үү. Баярлалаа. Сэтгүүлч Т.Ш” гэж бичээд тухайн прокурорын зургийг, бүтэн нэртэй тавьжээ.

Асуулт: Хэрэв та тухайн прокурор байсан бол ямар арга хэмжээ авах вэ ?

Ихэнх тохиолдолд прокурорын хянаж байгаа, эцэслэн шийдвэрлэгдээгүй тодорхой гэмт хэрэгтэй холбоотой байдаг учраас хуульчийн ёс, мэргэжлийн дүрэм, ЭХХШтХ-д заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалыг хадгалах зохицуулалтад баригдаж маш товч мэдээлэл өгөөд, *“дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй байна.”* гэх зэргээр хариултыг өгөх нь хангалтгүй байдгийг анхаарах нь зүйтэй. Хэдийгээр дээрх зохицуулалт, үүрэгт баригдаж хэргийн талаар мэдээлэл өгөх боломжгүй байсан ч гэсэн прокурорын хувьд алдаа гаргаагүй, хараат бус байдалд халдаж байгаа талаар тодорхой мэдээлэх нь ач холбогдолтой юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцахдаа дараах асуудлыг анхаарна.

- Шууд өөрөө биечлэн харьцахгүй (хариу урвал үзүүлэхгүй) байх;
- Харьяалах цагдаагийн байгууллагаар албан бусаар дамжуулан (үүрэг өгөх байдлаар) хэвэл мэдээллийн хэрэгсэлд байгаа мэдээ, мэдээллийг устгуулахыг шаардахгүй байх;
- Нийтийн сүлжээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр хариу өгөхдөө дээд шатны албан тушаалтан болон хэвлэл мэдээллийн албаны туслалцааг авах;
- Мэдэгдлийг албан ёсоор хийх;
- Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам, Мэргэжлийн дүрэм, Ёс зүйн дүрмийг баримтлах.

[12] Шударга байдал ба Олон нийтийн итгэл- хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн. 2020 он, Хяналтын прокурор Р.Батнасангийн илтгэлээс.


Аюулгүй байдлыг хангах нь

Прокурорын тухай хуульд прокурор аюулгүй байдлаа хамгаалж Цагдаагийн байгууллагад хандаж туслалцаа авахаас гадна хуульд заасан нэг бүрийн тусгай хэрэгслийг эзэмших, хэрэглэх эрхтэй байдаг. (Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйл) Ихэнх прокурорын газруудад нэг бүрийн тусгай хэрэгсэл буюу цахилгаан бороохой, нулимс асгаруулагч гэх мэт нэг бүрийн тусгай хэрэгсэл байдаггүй, байсан тохиолдолд далд Ерөнхий прокурорын өрөөнд, шуурхай хэрэглэх боломжгүй нөхцөлд хадгалдаг. Прокурор аюулгүй байдлаа хангахын тулд дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

- Шүүх хуралдаанд бэлтгэхдээ эрсдэлийг тооцоолох;
- Анхаарал татсан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ирсэн, аюул учруулж болзошгүй оролцогчид буюу тэдгээрийн хамаарал бүхий этгээд, ар гэр оролцож байгаа шүүх хуралд цагдаагийн байгууллагын туслалцаа, хүч хэрэгслийн талаар санал солилцож бэлтгэх;
- Албаны тээврийн хэрэгсэл буюу прокурорын байгууллагын автомашинаар шүүх хуралд хүргүүлж, авхуулах (ихэнх тохиолдолд прокурорын албан унаа нь зөвхөн ерөнхий прокурор ашигладаг нь зохисгүй бөгөөд албаны тээврийн хэрэгсэл гэдгийг анхаарах)
- Шаардлагатай бол нэг бүрийн тусгай хэрэгслийг биедээ авч явах, үндэслэл үүссэн бол хэрэглэх;
- Хуульд заасан үндэслэл үүссэн тохиолдолд прокурорыг гэрч хохирогчийн хамгаалалтад авхуулах.

Жишээ 2: 2019 онд тодорхой эрүүгийн хэрэгт хяналт тавьж байгаатай холбогдуулан хэрэгт Прокурорын байгууллагын хүсэлтийн дагуу .....тодорхой хугацаанд (тухайн хэргийг шийдвэрлэж дуустал) прокурорыг гэрч хохирогчийн хамгаалалтад авсан (биечилсэн хамгаалалт) кейс байдаг.

Аймаг (орон нутагт) Эрүүгийн цагдаагийн алба, Улаанбаатар хотод ЦЕГ-ын Гэрч хохирогчийг хамгаалах газар тус чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Практик хэрэглээнд

- Зарим тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй шүүгч, прокурор, мөрдөгч нарын аюулгүй байдлыг ханган хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Практикт прокурорыг хэрхэн гэрч хохирогчийн хамгаалалтад авах талаар мэдээ, мэдээлэл багатай байдаг ба дараах нөхцөлийг харгалзан үзэж хамгаалалтын төрөл, хэлбэрийг тогтоодог.

1. гэрч, хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;
2. хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;
3. гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;

4. нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;
5. хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;
6. хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;
7. бусад нөхцөл.

Эрх ашгаа хамгуулахаар хандах

Өмнө нь дурдсан прокурорын хараат бус байдалд нөлөөлөх ян бүрийн оролдлогууд нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй; хуульч мэргэжлийн нэр хүндэд илтэд халдсан, нийтийн өмнө гутаасан, сэрдсэн шинжтэй тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг гаргахаас гадна Монголын хуульчдын Холбооны Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороонд эрхээ хамгаалуулахаар хандаж болно. Энэ хороо нь хуульчийн эрх ашгийг хамгаалж тодорхой мэдэгдэл гаргах, хуульд заасны дагуу зөвтгөл тайлбар хийх замаар хуульч мэргэжлийн нэр хүндийг хамгаалдаг. Мөн бусад хуульчийн тухайлбал өмгөөлөгч, шүүгчээс нөлөөлөх оролдлого нь тухайн мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах дүрмийг зөрчсөн бол холбогдох субъектэд (Монголын Өмгөөлөгчийн Холбооны мэргэжлийн зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэх мэт) хариуцлага тооцуулахаар хандаж болно.

Б/ Прокурорын хувийн хараат бус байдал

Прокурорын хараат бус байдлыг зөвхөн прокурорын албан тасалгаанд бус амьдралынх нь бүх орчинд авч үзэх ёстой. Хувийн хараат бус байдал нь хариуцлагаас нуугдах арга хэрэгсэл болох ёсгүй. Прокурорыг томилох, чөлөөлөх, албан тушаал ахиулах, бууруулах ажиллагаа нь зөвхөн хуульд заасан хүрээнд явагдах учиртай.

Прокурорыг томилох, прокурор болоход тавих шаардлага нь прокурорын хувийн хараат бус байдлыг хангах эхлэл юм. Үндсэн хууль болон Прокурорын тухай хуулиар боловсрол, нас, мэргэжлээрээ ажилласан жил, ял шийтгүүлж байгаагүй, хуульчийн сонгон шалгаруулалтад орж гэрчилгээ авсан зэрэг ерөнхий шаардлагыг тавьж байна. Прокурорын тухай хуулиар прокурорт тавих хувийн хараат бус байдлын шаардлагыг хуульчлаагүй, харин прокурорын үйл ажиллагаанд хориглох зүйл, иргэний эрхийн хязгаарлалт зэргийг тодорхойлжээ.

Жишээ 3:

Нэгэн прокурорыг прокурор болохоос нь өмнө ан хийж байгаа зургийг нийтийн сүлжээнд прокурор хувцастай авхуулсан зурагтай нь зэрэгцүүлэн нийтэлж, ийм хүн байж болох уу гэсэн утгатай оруулжээ. Энэ тохиолдолд ёс зүйн дүрэм зөрчсөн асуудлаар албаны шалгалт явуулж сануулах арга хэмжээ авсан.

Жишээ 4:

Прокурор О нь таньдаг хүний гуйлгаар фейсбүүкт прокурорын байгууллагын нэрийн өмнөөс ашиглагдаж болохуйц улс төр, гадаад харилцааны шинжтэй нийтлэлийг share хийжээ.

Асуулт: Энэ нь прокурорын ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх. Ажлын байрнаас бусад газарт баримтлах ёс зүйн хэм хэмжээний асуудалд дүгнэлт хийнэ үү

Прокурорын хувийн хараат бус байдал нь тухайн хүний төлөвшил, дотоод чанараас хамаарна. Тухайлбал мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүйн хэв шинж, зан чанар, задлан шинжлэх, нэгтгэх дүгнэх, ёс зүйн хэм хэмжээг баримталдаг, зохист байдлыг ямагт эрхэмлэдэг зэргийг дурдаж болно. Ийм хувийн болон мэргэжлийн

чанарыг прокуророос шаардахын тулд:

- Прокурорын мэргэжлийн дүрэм
- Прокурорын ёс зүйн дүрэм үйлчилдэг ба эдгээрийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий зөвлөл ажилладаг.

Дээрх дүрмээс гадуур прокурорт хариуцлага хүлээлгэж болохгүй бөгөөд хууль хэрэглээний талаар санал солилцох, нийгмийн идэвхтэй бусад үйл ажиллагаанд оролцох, мэргэжлийн нийтэд тустай үйл ажиллагаанд оролцож гишүүн болох (Монголын Хуульчдын Холбоо, Прокуроруудын Холбоо гэх мэт) зэргээр үйл ажиллагаа явуулж болдог.

Прокурорын нөлөөллийн мэдүүлэг

Прокурорын хараат бус байдлыг хангах, хууль бус нөлөөллөөс сэргийлэх зорилгоор Прокурорын нөлөөллийн мэдүүлэг гаргах журам”-ыг Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/88 дугаар тушаалаар батлсан байдаг.

“Нөлөөллийн мэдүүлэг” гэдгийг иргэн, албан тушаалтан, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс прокурорын хараат бус, бие даасан байдалд хууль бусаар нөлөөлсөн, нөлөөлөхийг завдсан талаар прокуророос мэдүүлсэн баримт бичгийг ойлгоно.

Тус журамд зааснаар прокурор дараах тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг гаргана:

1. Хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт өгөхийг завдсан;
2. прокурор, түүний хамаарал бүхий этгээдэд албан тушаал, давуу байдал бий болгохоор санал болгосон;
3. прокурорт дарамт, шахалт үзүүлсэн;
4. прокурорыг доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн;
5. прокурорын бие, орон байр, уналга, албан тасалгаанд халдсан, халдаж болзошгүй нөхцөл байдал үүссэн;
6. хэрэг, материалын шийдвэрийн талаар урьдчилан хэлэлцэхийг санал болгосон, шийдвэрийн талаар зааварчилга өгсөн.

Прокурор тус журамд заасан нөлөөлөл гарсан талаар нөлөөллийн мэдүүлэг гаргаагүй нь түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэл болохоор заажээ.

Прокурор нөлөөллийн мэдүүлэг бичсэн тохиолдолд өөрийн ажиллаж буй прокурорын газар, хэлтсийн дээд шатны прокурорт даруй хүлээлгэн өгч, энэ тухай нөлөөлсөн этгээдэд мэдэгдэнэ.

Дээд шатны прокурор нь нөлөөллийн мэдүүлэгтэй танилцаж, баримт цуглуулах, тайлбар, тодорхойлолт гаргуулах зэрэг шаардлагатай ажиллагааг ажлын 3 хоногийн дотор гүйцэтгүүлж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- зөрчлийн шинжтэй бол Цагдаагийн байгууллагад шилжүүлэх;
- гэмт хэргийн шинжтэй бол мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- прокурорт нөлөөлсөн гэх үндэслэл тогтоогдоогүй бол хүлээн авахаас татгалзах.
- Дээд шатны прокурор нь хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг гаргасан прокурорын аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагад хүсэлт гаргана.
- Нөлөөллийн мэдүүлэг гаргасан прокурор нь нөлөөлсөн гэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзэж хүлээн авахаас татгалзсан бол дээд шатны прокурорт

гомдол гаргаж болно.

- Прокурор нөлөөллийн мэдүүлэг гаргасан тохиолдолд түүнийг хүлээн авсан дээд шатны прокурор нь Улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн даргын нэр дээр “Гарт нь” гэж хаяглан хуулбарыг хүргүүлнэ.

Прокурорт дээд шатны, эсхүл бусад прокурор хууль бусаар нөлөөлсөн бол нөлөөллийн мэдүүлгийг Улсын Ерөнхий прокурорт гаргана. Нөлөөллийн мэдүүлгийг хүлээн авах, шилжүүлэх, хадгалах үүргийг Улсын Ерөнхий прокурорын газарт Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газарт тухайн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, Сум буюу сум дундын прокурорын газарт сум дундын ерөнхий прокурор тус тус гүйцэтгэнэ.

Жишээ 6:

Нөлөөллийн мэдүүлгийн тухайд Нийслэлийн прокурорын газар, дүүргийн прокурорын газруудаас жилдээ дунджаар 1-2 тохиолдолд хяналтын прокурор гаргасан байх ба түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж хариу мэдэгдсэн тохиолдол байхгүй байна.

Хэрэв дээд шатны прокурор нөлөөллийн мэдүүлэг гаргасан тохиолдолд нөлөөллийн мэдүүлгийг Улсын Ерөнхий прокурорын газарт Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газарт тухайн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, Сум буюу сум дундын прокурорын газарт тухайн аймгийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч нөлөөллийн мэдүүлгийг хүлээн авч шийдвэрлэнэ.

Прокурор нөлөөллийн мэдүүлэг гаргасан тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг, түүний шийдвэрлэлтийг Улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэс бүртгэж, хагас, бүтэн жилээр дүнг Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн
А/88 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ (загвар)

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Прокурорын газрын нэр	
1.2	Прокурорын овог, нэр, албан тушаал	
1.3	Хянан шийдвэрлэж буй хэрэг, материалын дугаар	
Хоёр. Нөлөөллийн хэлбэр, арга		
2.1	Нөлөөллийн хэлбэр /Журмын 2.1.1-2.1.6 дахь хэсгийг сонгож бичих/	Нөлөөлсөн арга /хэн, хэрхэн нөлөөлснийг дурдах бичих/
Гурав. Тусгай мэдээлэл		
3.1	Нөлөөлөх оролдлого давтагдсан байдал	
3.2	Гэрчлэх этгээдийн тухай мэдээлэл	
3.3	Нотлох баримтын талаар	

Нөлөөллийн мэдүүлэг гаргасныг холбогдох этгээдэд мэдэгдсэн тухай тэмдэглэх хэсэг .....
.....
.....
.....

Мэдүүлэг гаргасан:

..... прокурор ..... /...../

..... оны ..... сарын .....ны .....өдөр

Нөлөөллийн мэдүүлгийг хүлээн авсан:

..... орлогч прокурор ..... /...../

..... оны ..... сарын .....ны .....өдөр

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Шударга байдал ба Олон нийтийн итгэл- хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн. 2020 он, Хяналтын прокурор Р.Батнасангийн илтгэлээс.
2. Прокурорын байгууллагын шударга байдлын судалгаа" судалгааны тайлан 2018 он
3. Судалгаа прокурорт ирж буй хөндлөнгийн бодит нөлөөллийг тоон үзүүлэлтээр хэмжсэн байна.
4. Прокуроруудын үүргийн тухай НҮБ-ын удирдамжийг бүхэлд нь болон 10-16-р зарчмуудыг үзнэ үү. Мөн Прокурорын үндсэн эрх, үүргийн тухай ойлголт, мэргэшлийн хариуцлагын тухай стандарт. Прокуроруудын олон улсын нийгэмлэг. 1999 он.
5. Ардчилсан улсын шүүгч, прокурорын талаарх Бордогийн Тунхаглалын тайлбар, зөвлөмж
6. "Шүүхийн хараат бус байдал (Judicial independence)Олон улсын баримт бичиг. Н.Лүндэндорж нар хянан тохиолдуулсан. 2019 он 145-161 дэх тал.
7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон зөрчил гаргагчтай харьцах асуудлаарх НҮБ-ын 8-р Их хурлаар батлагдсан. 1990.
8. Ардчилсан улсын шүүгч, прокурорын талаарх Бордогийн Тунхаглалын 8, 9 дэх хэсэг.
9. https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2018/Shuugchiin%20bodlogiin%20sudalgaanii%20tailan.pdf
10. Энэ тунхаглал нь тайлбар, тэмдэглэлтэй. Тунхаглалыг Европын Шүүгчдийн Зөвлөлдөх Зөвлөл, Европын Прокуроруудын ЗөвлөлдөхЗөвлөлөөс байгуулсан ажлын хэсэг хамтран Францын Бордо хотод боловсруулсан бөгөөд (ЕШЗЗ, ЕПЗЗ-өөс) Словенийн Бордо хотод 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр албан ёсоор батлан гаргасан.

БҮЛЭГ 5. ХЭРГИЙН БҮРДЭЛ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧДЫН ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ НОТЛОХ БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙГ БЭХЖҮҮЛСЭН БАЙДАЛ

1.1. Эрүүгийн хэргийн нотлох баримт, баримтат мэдээллийн тухай ойлголт
1.2. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, үнэлэх

СЭДЭВ 2. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ, БУСАД ОРОЛЦОГЧООС ГАРГАСАН ГОМДОЛ, ХҮСЭЛТ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАЖ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

2.1. Гомдол хянаж, шийдвэрлэх нь
2.2. Хүсэлт хянаж шийдвэрлэх нь
2.3. Прокурорын тогтоол үйлдэхэд анхаарах зарим асуудал
2.4. Гомдол, хүсэлтийн дагуу хэрэг, материал хянах
2.5. Хариу мэдэгдэх хуудас үйлдэх тухай

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд хавтаст хэрэгт бэхжүүлэх, тусгах, хавсаргавал зохих нотлох баримтуудыг бүрэн мэдэх болон түүнд анхаарах асуудлуудын талаар авч үзнэ.

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ НОТЛОХ БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙГ БЭХЖҮҮЛСЭН БАЙДАЛ

1.1 Эрүүгийн хэргийн нотлох баримт, баримтат мэдээлэл

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг тогтоохын тулд мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн гэмт хэргийг хэн, хэзээ, хаана, яаж үйлдсэн, гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, холбогдогчийн хувийн байдал зэрэг нотолбол зохих байдлуудыг нотлох баримтаар эргэлзээгүй тогтоосон байна.

“Нотлох баримт” гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг хэлнэ. Харин баримтат мэдээлэл нь эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, оролцогчийн мэдүүлэг, хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.

Иргэд, байгууллагаас төрийн байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.

Бичмэл нотлох баримтыг эх хувиар нь, хэрэв эхийг авах боломжгүй бол прокурор, мөрдөгч тэмдэглэл үйлдэж хуулбарлан авах ба нотлох баримт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлд заасан шинжтэй байвал эд мөрийн баримтаар тооцно.

Хохирогч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж

өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор хэрэгт тусгах ба түүнийг олж авсан эх сурвалжийг зааж чадаагүй бол дангаараа нотлох баримт болохгүй. Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааны баримтыг нотлох баримтаар тооцохгүй.

Цахим нотлох баримтад цахим төхөөрөмж, системээр хадгалагдаж, дамжуулагдсан аливаа нотлох баримтыг хамааруулна. Жишээлбэл: и-мэйл, сошиал медиа бичлэг (мессеж, видео, фото, аудио, бичлэг, цахим бүртгэл г.м)

Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалгуулахаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах, тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгөх эрхтэй ба оролцогчийн гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт тусгаж, нотлох баримтаар тооцож болно.

Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, эд зүйл, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан, түүнчлэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх, эсхүл хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлийг эд мөрийн баримтад тооцож болно.

1.2. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, үнэлэх

Мөрдөгч мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг хуульд заасан аргаар нотлох баримтыг цуглуулж, цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ.

Мөрдөн шалгах зарим ажиллагааг тэмдэглэл үйлдэхээс гадна заавал дуу-дүрсний бичлэгээр давхар бэхжүүлэхээр хуульчилсан нь техник, технологийн ололт, давуу талыг өргөн ашиглах, прокурор, шүүх техникээр баталгаажсан, хөдөлшгүй баримтад тулгуурлаж шийдвэрээ гаргах боломжтой юм.

Мөрдөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, бусад оролцогчоос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар, шинжээчээс гаргасан дүгнэлтийнх нь талаар тайлбарлуулах, эсхүл тодруулах зорилгоор мэдүүлэг авч болно.

Тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч, прокурор, өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгч, хуульч, хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагч, өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон нь тогтоогдсон хүн, эмчилгээ хийж байх явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар мэдэх болсон сэтгэл зүйч, өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогчоос гэрчийн мэдүүлэг авахгүй.

Оролцогч нь мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тухайн мэдүүлэг дангаараа нотлох баримт болохгүй тул гэмт хэрэг үйлдэгдэх үед хэргийн газарт байснаас бусад гэрчээс мэдүүлэг авахдаа эх сурвалжийг заавал тодруулна. Мэдүүлгийн эх сурвалж гэж мэдүүлэг өгөгч хэргийн талаар мэдэх болсон бодит үндэслэл, шалтгааныг ойлгоно.

Гэмт хэрэгт сэжиглэх илт үндэслэл буй бол хүнийг гэрчээр байцааж болохгүй

бөгөөд гэрчийг байцааж байх үед мэдүүлгээс тийм үндэслэл илэрсэн даруйд байцаалтыг зогсоож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулан, зөвхөн зөвшөөрсөн тохиолдолд хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахдаа эхэлж ямар хэрэгт сэрдэгдэж, эсвэл яллагдаж байгааг заавал мэдэгдэх ба учир битүүлэг байдлаар байцаах, мэдүүлэг өгөхийг шаардаж болохгүй.

Яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг нь хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн тогтооход ач холбогдолтой хэдий ч дангаараа яллах үндэслэл болохгүй тул мэдүүлгийн агуулга, бүрэн дүүрэн байдал, зөрүү байгаа эсэхийг шинжлэн судалсны эцэст бусад нотлох баримтууд, тухайлбал гэрч, яллагдагч, шүүгдэгч нарын мэдүүлэгтэй харьцуулан үзэх замаар шалгана. Мэдүүлэгт дурдсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бөгөөд зөрүүгүй байдлыг хангах зорилгоор туршилт, үзлэг, шинжилгээ хийх, нэмж гэрч байцаах, нүүрэлдүүлэн байцаах зэрэг тодорхой ажиллагаануудыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

Эмчилгээ хийж байх явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар мэдэх болсон сэтгэл зүйчийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй харилцах явцад хийгдсэн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг нь хэргийн нотлох баримт болохгүй ба тэдгээрийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу нотлох баримтад тооцож болно. Түүнчлэн сэжигтэн, яллагдагчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн гэрчийн мэдүүлэг авч болно.Шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгөх боломжгүй гэрч, хохирогч, шинжээчээс мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүх хуралдаанаас өмнө дуу-дүрсний бичлэг ашиглан мэдүүлэг авч болно.

Шаардлагатай тохиолдолд бага насны хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулахгүйгээр мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн мэдүүлгийн дуу-дүрсний бичлэгийг шинжлэн судална. Энэ нь талуудын тэгш эрхийг хангах, мэтгэлцэх нөхцөл бүрдүүлэх, оролцогчдын цаг хугацааг хэмнэх, бага насны хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг бодитой хамгаалах, ингэснээр шүүхийн ажиллагаа хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай явагдах боломж бүрдэнэ.Мөрдөгч, прокурор нь хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор хууль тогтоомж хэрэглэх, түүний зүйл, хэсэг, заалтыг тайлбарлуулахаас бусад бүх асуудлаар шинжилгээ хийлгэж болно.

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн арван зургадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг (16.3, 16.5)-ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар”-т ...“шинжээчийн дүгнэлт” гэдгийг “Шүүх, прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу шинжлэх ухаан, техник, урлаг, үйлдвэрлэлийн салбарт эзэмшсэн тусгай мэдлэгийнхээ хүрээнд эрх бүхий байгууллага, этгээдээс томилсон мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, мэргэшсэн ажилтны бичгээр гаргаж буй үнэлэмж”-ийг ойлгоно.

Техник, аюулгүй ажиллагааны дүрмүүд нь эрх зүйн хэм хэмжээг агуулдаггүйн зэрэгцээ тусгай мэдлэгийн хүрээнд боловсруулагдсан байдаг тул барилгын үйлдвэрлэл, нягтлан бодох бүртгэл, замын хөдөлгөөний дүрэм зэрэг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, чанарын стандартын шаардлагууд зөрчигдсөн эсэх талаар шинжилгээ хийлгэнэ. Эдгээр асуудалд шинжилгээ хийх эрх бүхий этгээд хууль хэрэглэх асуудал гэж үзэж шинжилгээ хийхээс татгалзах эрхгүй. Энэ чиглэлээр мөрдөгч тусгай мэдлэг эзэмшсэн бол магадалгаа гаргаж болно.” гэж заасныг анхаарч хэрэгжүүлбэл зохино.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлд заасан

шинжилгээг шинжээч томилж хийлгэх шаардлагагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоох боломжтой, эсхүл өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд шийдвэрлэх боломжтой тохиолдолд магадалгаа гаргах ба мөрдөгчийн магадалгааг шинжээчийн дүгнэлттэй адилтган үзнэ.

Мөрдөгч, прокурор шинжээчийн дүгнэлтийг зөвшөөрөөгүй үндэслэлийг гаргасан шийдвэртээ заавал тусгана. Шинжээчийн хэд хэдэн дүгнэлт, мөрдөгчийн магадалгаа гарсан тохиолдолд прокурор шийдвэр гаргахдаа эдгээрийг нотлох баримтаар тооцсон болон тооцоогүй үндэслэлээ шийдвэртээ ойлгомжтой бичнэ.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар мөрдөгч нууц ажиллагааны магадалгаа үйлдэж, прокуророор баталгаажуулж хавтаст хэрэгт тусгах ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нь нууц байна.

Мөрдөгч, прокурор нь нотлох баримтыг тал бүрээс нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар хянаж үзсэний үндсэн дээр хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлсэн эсэх, нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр үнэлэх ба хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгохгүй.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсхүл хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнх нь эсрэг албадан мэдүүлэг, тайлбар авах, хүч хэрэглэн гэм буруугаа хүлээхийг тулган шаардаж, хууран мэхэлж, хууль бус хөнгөлөлт амлаж, хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлсэн бол нотлох баримтаар тооцохгүй.

Эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны явцад зөвхөн сэжигтэн, яллагдагч, хохирогчийн төдийгүй түүнд татагдан оролцож буй бүх хүний эрх ашиг хөндөгддөг бөгөөд иргэний эрх, эрх чөлөө, халдашгүй дархан байдалд зөвхөн Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлалт тогтооход анхаарч ажиллана.

СЭДЭВ 2. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ, БУСАД ОРОЛЦОГЧООС ГАРГАСАН ГОМДОЛ, ХҮСЭЛТ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАЖ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Зорилго. Энэхүү хэсэгт хэргийн оролцогчдын хүсэлт, гомдлыг шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэх мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд анхаарах зарим асуудлуудын талаар тодорхой дурдсан болно.

Иргэн, хуулийн этгээд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогчоос прокурорт хандаж гаргасан хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;

Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан “Прокурорын байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хянан шийдвэрлэх заавар”, “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар” болон бусад хууль тогтоомж, журмын холбогдох заалтыг баримтална.

Прокурор хүлээн авсан гомдол, хүсэлт, мэдээлэл нь харьяаллынх бус байвал хуулбарлан авч, шийдвэрлэвэл зохих байгууллагад эх хувийг даруй шилжүүлнэ. Гомдол, хүсэлтэд гэмт хэргийн талаар мэдээлэл дурдагдсан тохиолдолд хуулбарлан авч, эх хувийг эрх бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад шалгуулахаар албан бичгээр даруй шилжүүлж, гомдол, хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэх ба гомдол, хүсэлт, мэдээллийг хууль зүйн үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхгүй.

Гомдол, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан холбогдох хэрэг, материалыг татах тухай тогтоол, албан бичгийг хүргүүлнэ. Тогтоол, албан бичигт хэрэг, материалыг ирүүлэх боломжит хугацааг тусгах ба гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг хэрэг, материалыг прокурорын газарт хүлээн авсан өдрөөс эхлэн тоолно. Хэд хэдэн хэрэг, материал татан хянаж байгаа тохиолдолд сүүлийн хэрэг, материал ирсэн өдрөөс гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг тоолно.

Прокурор гомдол, хүсэлт, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагаанд туйлын хариуцлагатай хандаж, хэргийг хянах нэрийн дор оролцогчдыг хясан боогдуулах, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхгүй удаашруулж хүнд суртал гаргах, гаргасан хууль ёсны, үндэслэлтэй гомдол, хүсэлтийг хүлээн авч хангахгүй байх зэргээр эрхийг нь зөрчин чирэгдүүлэхгүй байхад анхаарч, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах бөгөөд гомдол, хүсэлт, мэдээлэлд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг чандлан хадгална.

2.1 Гомдол хянаж шийдвэрлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.

Мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг тухайн хэрэг, материалд хяналт тавьж байгаа прокурор, прокурорын шийдвэр, ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурор тус тус хянаж шийдвэрлэнэ.

Прокурор нь гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд тухайн хүн нь гомдол, хүсэлт гаргах хуульд заасан эрх бүхий оролцогч мөн эсэхийг хянана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар «оролцогч»-д сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг, «бусад оролцогч»-д гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг тус тус хамааруулна.

Мөн хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн уг ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд нь прокурор, мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гомдол гаргах эрхтэй болохыг хуульчилсныг анхаарах шаардлагатай.

Прокурор хүлээн авсан гомдлыг 14 хоногийн дотор хянаж шийдвэрлэх ба нэмэлт баримт материал гаргуулах, тайлбар авах зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд дээд шатны прокурорт танилцуулж, хянаж шийдвэрлэх хугацааг сунгуулж, гомдлыг 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. (Гомдлыг хянах хугацааг сунгах тухай, ПХ-1.16 тогтоолын загвар)

ПХ-1.16

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Гомдлыг хянах хугацааг сунгах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэх ажиллагааны явц байдалтай ..... прокурор .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр танилцаад ОЛСОН нь:

..... /оролцогч/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан ..... /гомдлын утга/ гэсэн гомдлыг ..... прокурор ..... нь ..... оны ..... сарын .....-ны өдөр хүлээн авчээ.

Гомдлын дагуу ..... дугаартай хэрэг /материал/-ийг татаж, ... оны ..... сарын .....-ны өдөр хүлээн авч хянасан байх ба гомдлыг хянаж шийдвэрлэх хугацаа ..... оны ..... сарын .....-ны өдөр дуусч байна.

..... прокурор ..... нь .....-ны гомдлыг хүлээн авснаас хойш .....
.....
..... /гомдлыг үндсэн хугацаанд хянаж шийдвэрлээгүй шалтгааныг бичих/ шалтгаанаар үндсэн хугацаанд хянаж шийдвэрлээгүй байна.

Цаашид .....
.....
.... /нэмэлт ямар материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах шаардлагатай байгааг бичих/ тулд гомдлыг хянах хугацааг сунгах үндэслэлтэй байх тул Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлыг хянах хугацааг ..... оны ..... сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын .....-ны өдрийг хүртэл ..... хоногоор сунгасугай.

2. Гомдлыг хянаж шийдвэрлэх хугацааг сунгасан тухай гомдол гаргасан .....-д мэдэгдсүгэй.

3. Тогтоолыг гомдлын материалд хавсаргасугай.

.....ПРОКУРОР ..... (.....)

(гарын үсэг) (нэр)

Прокурор шаардлагатай тохиолдолд гомдол гаргасан хүнтэй биечлэн уулзаж, санал гомдлыг сонсох, холбогдох хүн, байгууллага, албан тушаалтнаас тайлбар, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, хэрэг, материалыг хянах, танилцах зэргээр гомдолд дурдсан асуудлыг нэг бүрийг хянана.

Гомдлыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээн авч, мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагааг хүчингүй болгосон тохиолдолд энэ талаар тухайн тогтоолд тусгана. Харин гомдлыг хүлээн авах үндэслэлтэй бөгөөд мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох ямар нэг шийдвэр гаргаагүй тохиолдолд “Гомдлыг хүлээн авах тухай” тогтоол үйлдэнэ.

ПХ

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Гомдлыг хүлээн авах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлын дагуу ..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай хэрэг /материал/-ийг ..... оны ..... сарын .....-ны өдөр хянаад ОЛСОН нь:..... /оролцогч/ .....-аас..... оны... сарын...-ны өдөр гаргасан .....:...../гомдлын утга/ гэсэн гомдлын дагуу ..... дугаартай эрүүгийн хэрэг /материал/- ийг хянахад, мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан .....

.....

.....нотлох баримтуудаар

.....

.....

...../тогтоогдсон нөхцөл байдал, прокурор ямар хууль зүйн дүгнэлт өгснийг бичих/ нөхцөл байдал тогтоогдож байна.

Иймд .....-ны гомдлыг хүлээн авч, ...

.....

.....

.....

...../хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар бичих/ үндэслэлтэй байна гэж дүгнэв.

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.12, 2.14 дэх хэсэг, 15.7 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч/ .....-аас гаргасан .... /товч утга/ гэсэн гомдлыг хүлээн авч, ...шийдвэрлэсүгэй.

2. Энэ тухай гомдол гаргагч .....-д мэдэгдсүгэй.

3. Энэ шийдвэрийг гомдол гаргагч ..... нь эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор ..... прокурорын газрын ..... прокурорт гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

Гомдлыг хүлээн авах үндэслэлгүй тохиолдолд Гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай (ПХ-1.17 тогтоолын загвар) тогтоол үйлдэж, гомдол гаргасан хүнд бичгээр хариуг мэдэгдэнэ.

ПХ-1.17

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлын дагуу ..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай хэрэг /материал/-ийг ..... оны ..... сарын .....-ны өдөр хянаад ОЛСОН НЬ:..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны Эрүүгийн хуулийн ..... дугаар зүйлийн ..... дахь хэсгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулсан .... /товч утга/ гэх хэрэг /материал/-ийг ..... прокурорын газрын ..... прокурор .....-ны ..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... дугаартай тогтоолоор

..... /шийдвэрийн үндэслэлийг бичих/ үндэслэлээр .... /гаргасан шийдвэрийг бичих/ шийдвэрлэсэн байна.

..... /оролцогч/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан ..... /гомдлын утга/ гэсэн гомдлын дагуу холбогдох хэрэг /материал/-ийг хянахад, мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан .....

..... нотлох баримтуудаар .....

..... /тогтоогдсон нөхцөл байдал, прокурор ямар хууль зүйн дүгнэлт өгснийг бичих/ нөхцөл байдал тогтоогдож байх тул .....-ны гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх үндэслэлтэй байна гэж дүгнэв.

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.12, 2.14 дэх хэсэг, 15.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч/ .....-аас гаргасан .... /товч утга/ гэсэн гомдлыг хүлээн авахаас татгалзсугай.

2. Энэ тухай гомдол гаргагч .....-д мэдэгдсүгэй.

3. Энэ шийдвэрийг гомдол гаргагч ..... нь эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор ..... прокурорын газрын ..... прокурорт гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

1.2 Хүсэлт хянаж шийдвэрлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлт гаргах эрхтэй бөгөөд прокурор хүсэлтийг хянаад хангах үндэслэл тодорхой бол даруй, шалгах шаардлагатай тохиолдолд түүнийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хангах эсэхийг шийдвэрлэж хариуг өгнө.

Хүсэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол “Хүсэлтийг бүрэн хангах тухай” (ПХ-1.13 тогтоолын загвар), эсхүл “Хүсэлтийг хэсэгчлэн хангах тухай” (ПХ-1.14 тогтоолын загвар) тогтоол үйлдэнэ.

ПХ-1.13

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ....
сарын .....-ны өдөр Дугаар ..... хот, сум

Хүсэлтийг бүрэн хангах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай материал /хэрэг/-ыг ..... /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан хүсэлтийн дагуу хянаад ОЛСОН нь:..... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан ..... гэсэн хүсэлтийг хянахад, ... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ямар ач холбогдолтой байгааг бичих/ үндэслэл тогтоогдож байх тул хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч, бусад оролцогч/ .....-аас гаргасан ..... гэсэн хүсэлтийг бүрэн хангасугай.

2. Энэ тухай хүсэлт гаргасан .....-д мэдэгдсүгэй.

3. Гаргасан хүсэлт, шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, материалыг холбогдох хэрэг /материал/-д тусгасугай.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

ПХ-1.14

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Хүсэлтийг хэсэгчлэн хангах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай материал /хэрэг/-ыг ..... /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан хүсэлтийн дагуу хянаад ОЛСОН нь:

..... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан ..... гэсэн хүсэлтийг хянахад, ... гэх хэсгийг..... .... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ямар ач холбогдолтой байгааг бичих/ үндэслэлээр хэсэгчлэн хангах нь зүйтэй байна гэж дүгнэв.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас гаргасан ..... гэсэн хүсэлтийг хэсэгчлэн хангасугай.

2. Энэ тухай хүсэлт гаргасан .....-д мэдэгдсүгэй.

3. Гаргасан хүсэлт, шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, материалыг холбогдох хэрэг /материал/-д тусгасугай.

4. Хүсэлтийг хангаагүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн болон бусад ажиллагааны үед хүсэлт, гомдол дахин гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй болохыг дурдсугай.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

Хүсэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолгүй, хангах үндэслэлгүй бол “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” тогтоол (ПХ-1.15 тогтоолын загвар) гаргана.

ПХ-1.15

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Хүсэлтийг хангахаас татгалзах тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай материал /хэрэг/-ыг ..... /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан хүсэлтийн дагуу хянаад ОЛСОН нь:..... /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас гаргасан ..... гэсэн хүсэлтийг хянахад,..... ..... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолгүй гэж үзсэн үндэслэлийг тодорхой бичих/ үндэслэл тогтоогдож байх тул хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд/ .....-аас гаргасан ..... гэсэн хүсэлтийг хангахаас татгалзсугай.

2. Энэ тухай хүсэлт гаргасан .....-д мэдэгдсүгэй.

3. Гаргасан хүсэлт, шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, материалыг холбогдох хэрэг /материал/-д тусгасугай.

4. Хүсэлтийг хангаагүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн болон бусад ажиллагааны үед хүсэлт, гомдол дахин гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй болохыг дурдсугай.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

Гомдлыг хянан шийдвэрлэх прокурор нь шаардлагатай гэж үзвэл прокурор, мөрдөгчийн шийдвэрийн биелэлтийг гомдлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд түр түдгэлзүүлж болно (Гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэрийн биелэлтийг түр түдгэлзүүлэх тухай, ПХ-1.18 тогтоолын загвар).

ПХ-1.18

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны ..... дугаар ..... сарын .....-ны өдөр Дугаар .... хот, сум

Гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэрийн биелэлтийг түр түдгэлзүүлэх тухай

..... прокурорын газрын ..... прокурор ..... би, ... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлын дагуу ..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... дугаартай хэрэг /материал/-ийг ..... оны ..... сарын .....-ны өдөр хянаад ОЛСОН нь:

..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага/-ын мөрдөгч, ... цолтой .....-ны Эрүүгийн хуулийн ..... дугаар зүйлийн ..... дахь хэсгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ..... /хэргийн утга/ гэх хэрэг /материал/-ийг ..... прокурорын газрын ..... прокурор .....-ны ..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... дугаартай тогтоолоор..... ..... /шийдвэрийн үндэслэлийг бичих/ үндэслэлээр ..... /гаргасан шийдвэрийг бичих/ шийдвэрлэжээ.

..... /оролцогч/ .....-аас ..... оны ..... сарын .....-ны өдөр гаргасан ..... /гомдлын утга/ гэсэн гомдлын дагуу холбогдох хэрэг /материал/-ийг хянахад, мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан ..... . нотлох баримтуудаар ..... /тогтоогдсон нөхцөл байдал, прокурор ямар хууль зүйн дүгнэлт өгснийг бичих/ нөхцөл байдал тогтоогдож байна.

Иймд .....-ны гомдлыг шийдвэрлэх хүртэл ..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, Прокурорын газар/-ын ..... /мөрдөгч, прокурор/ .....-ны ..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... /шийдвэрийн нэрийг бичих/ шийдвэрийн биелэлтийг түр түдгэлзүүлэх шаардлагатай байх тул Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ..... /оролцогч/ .....-аас гаргасан гомдлын дагуу ..... /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурорын газар/-ын ..... /мөрдөгч, прокурор/ .....-ны ..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... шийдвэрийн биелэлтийг ..... оны ..... сарын .....-ны өдрийг хүртэл түр түдгэлзүүлсүгэй.

2. Энэ шийдвэрийн талаар мөрдөгч /прокурор/ ....., гомдол гаргасан ..... нарт мэдэгдсүгэй.

.....ПРОКУРОР ..... (.....)
(гарын үсэг) (нэр)

1.3 Прокурорын тогтоол үйлдэх

Прокурорын шийдвэрт гомдлыг хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзсан, хүсэлтийг бүрэн, хэсэгчлэн хангасан, эсхүл хангахаас татгалзсан үндэслэл шалтгааныг эргэлзээ төрүүлэхээргүй байдлаар ойлгомжтой, тодорхой бичнэ. Өөрөөр хэлбэл гомдол, хүсэлтэд дурдсан асуудал нэг бүрийг хэрэг, материалд цугларсан нотлох баримтуудад тулгуурлан хууль, эрх зүйн зохицуулалттай уялдуулан бодитой дүгнэлт хийж, үндэслэлийг шийдвэртээ логик дэс дараалалтай тайлбарлаж бичнэ.

Өнөөгийн практикт зарим шинэ залуу прокурорууд гомдол, хүсэлтэд дурдсан асуудал нэг бүрийг хянаж, үндэслэлтэй дүгнэлт хийн шийдвэрлэхгүй байгаагаас оролцогч гомдол гаргах, прокурорын шийдвэр иргэд, олон нийтийн дунд шүүмжлэлд өртөх явдал гарч байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна. Үүнтэй холбоотойгоор зарим жишээнүүдийг дурдахад:

1) Прокурорын хяналтад шүүхэд шилжүүлэх санал гарган ирүүлсэн эрүүгийн хэргийн яллагдагч С-аас прокурорт хандаж гаргасан "...дахин шинжилгээ хийлгэх, хохирогчийн мэдүүлгийг газар дээр нь шалгуулах, хөрш О-г гэрчээр асуулгах мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх" тухай хүсэлтийг хяналтын прокурор хянаад, "...хэрэгт нотолбол зохих байдлуудыг тогтоосон, мөрдөн шалгах нэмэлт ажиллагаа хийлгүүлэх шаардлагагүй байна" гэж дүгнэн, хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэн, энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр хариуг мэдэгдсэн байна.

Дээрх тохиолдолд яллагдагчийн хүсэлтэд гурван төрлийн мөрдөн шалгах тодорхой ажиллагаа хийлгүүлэх талаар дурдсан байхад, прокурор ямар учраас хийлгэх шаардлагагүй гэж үзсэн үндэслэлийг асуудал нэг бүрээр тодорхой дүгнэлт хийгээгүй, бөөндөж шийдвэрлэсэн нь ойлгомжгүй, буруу байна.

2) Өмгөөлөгч А-аас гаргасан "...орцны камерын бичлэгт үзлэг хийж, хэрэгт нотлох баримтаар хавсаргуулах, хохирогчоос дахин мэдүүлэг авахад өмгөөлөгчийг оролцуулах" тухай хүсэлтийг хяналтын прокурор хянаад, "...камерын бичлэгийг нотлох баримтаар хавсаргуулах нь хэрэгт ач холбогдолтой, харин хохирогчийн зүгээс болсон асуудлын талаар өмнө нь тодорхой мэдүүлэг өгсөн байх тул дахин мэдүүлэг авах шаардлагагүй" гэж дүгнэн, хүсэлтийг хангах тухай тогтоол үйлдсэн байна.

Дээрхээс үзэхэд, прокурор өмгөөлөгчийн хүсэлтэд дурдсан хоёр асуудлын нэгийг хангаж, нөгөөхийг хангахаас татгалзсан байх бөгөөд энэ тохиолдолд "Хүсэлтийг хэсэгчлэн хангах тухай" тогтоол үйлдэж, түүнд үндэслэлийг тусгаж бичих байжээ.

3) Иргэн Х-аас прокурорт хандаж "...мөрдөгч Д нь намайг гэрчээр асууна гэж дуудаж, 4 хоногийн турш өдөр бүр өрөөнийхөө үүдэнд хүйтэн коридорт суулгаж, миний бие "бага насны хүүхдийг харах хүнгүй тул явмаар байна" гэж хэлэхэд "хохь чинь шүү, амаа хамхиад дуугай сууж бай, чамайг эндээс явах үгүйг би шийднэ" гэх зэргээр хэл амаар доромжлон сүрдүүлж, миний эрхийг зөрчин эрүүдэн шүүсэн, хэрэгт нэг талыг барьж хувийн сонирхлоор хандаж байх тул түүнийг сольж өгнө үү. Би бусдыг зодож гэмтэл учруулаагүй тул намайг холбогдуулан шалгаж байгаа хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэсэн гомдол гаргажээ.

Гомдлыг хяналтын прокурор хүлээн авч, холбогдох эрүүгийн хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас татаж хянаад, гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн. Ингэхдээ тогтоолд "...мөрдөгч Д-г энэ хэрэгт хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй тул хэргээс татгалзан гаргах үндэслэлгүй. Хэрэгт одоогоор мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байх ба цугларсан нотлох баримтаар танд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл тогтоогдоогүй байна, энэ шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй" гэж дурджээ.

Дээрх тохиолдлоос үзэхэд, хэрэгт хяналт тавьж буй прокурор иргэн Х-ын гомдолд дурдсан "мөрдөгч 4 өдрийн турш хүйтэн коридорт өрөөнийхөө үүдэнд суулгасан, хэл амаар доромжлон сүрдүүлж, эрхийг зөрчин эрүүдэн шүүсэн" гэх асуудлын талаар нягталж шалгаагүй, ямар дүгнэлт хийсэн нь тодорхойгүй, гомдлыг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд хуймгаа хандсан байна.

Зүй нь прокурор "гомдол гаргагчийг айлган сүрдүүлж, эрүүдэн шүүсэн" гэх асуудлын талаар тухайн хүн болон мөрдөгчөөс тодруулж тайлбар авч, уг асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол харьяа мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх хүртэл арга хэмжээ авах ёстой байсан. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Прокурор нь мөрдөгчөөр оролцож болохгүй тухай асуудлыг өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтээр шийдвэрлэх ба энэ шийдвэр эцсийн байна." гэж

тодорхой заасан байхад, гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай тогтоолд дээд шатны прокурорт гомдол гаргах эрхийг зааж өгсөн нь хуульд нийцээгүй байна.

4) Өмгөөлөгч Н-аас прокурорт хандаж "...прокурор ямар нотлох баримтаар П-г буруутгаж байгаа нь тодорхойгүй, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолд нотлох баримтын талаар нэг ч өгүүлбэр байхгүй, түүнчлэн миний үйлчлүүлэгчийг 3 цагийн өмнө гэрчээр асуусан мэдүүлгийг өөрийнх нь эсрэг яллах талын нотлох баримт болгон ашиглаж, яллах дүгнэлтэд тусгасан нь хууль зөрчсөн байх тул прокурорын шийдвэрүүдийг хүчингүй болгож өгнө үү..." гэсэн агуулга бүхий гомдол гаргасан.

Гомдлыг нэгжийн дээд шатны прокурор хянаад "...яллагдагч П-ын гэм буруутай үйлдэл хэрэгт цугларсан нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдсон, прокурорын шийдвэр үндэслэлтэй байна" гэж дүгнэн, гомдлыг хүлээн авахаас татгалзаж, энэ тухай бичгээр хариу мэдэгджээ.

Дээрх тохиолдлоос үзэхэд, өмгөөлөгчийн гомдолд хэргийн бүрдэл талаас гэхээсээ илүүтэй прокурорын шийдвэр хуульд заагдсан шаардлага хангахгүй байгаа талаар дурдсан. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Прокурор тогтоолын тодорхойлох хэсэгт тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлох баримтын жагсаалт, нотлох баримт тус бүрд тусгагдсан мэдээллийн хэр хэмжээг тогтоож тусгана." гэж тодорхой заасан байхад, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай прокурорын тогтоолд нотлох баримтуудыг тусгаагүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт "Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй.", 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг, тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, ...шийдвэр гаргана:" гэж заасныг зөрчин, яллагдагчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас 3 цагийн өмнө гэрчээр асуусан мэдүүлгийг өөрийнх нь эсрэг нотлох баримт болгон ашиглаж, прокурорын яллах дүгнэлтэд тусгасан нь хуульд нийцээгүй байна.

Гэтэл нэгжийн дээд шатны прокурор дээр дурдсан асуудлуудад үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй, прокурорын шийдвэрүүдийг хуулийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авалгүйгээр хэргийн нотлогдсон байдлыг дурдаж шийдвэрлэсэн нь гомдлыг хянаж шийдвэрлэх ажиллагаанд туйлын хариуцлагагүй хандсан гэж дүгнэхээр байна.

1.4 Гомдол, хүсэлтийн дагуу хэрэг, материал хянах

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлд мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг танилцуулж, тэмдэглэл үйлдэнэ. Оролцогч хавтаст хэргийн материалтай танилцаад мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол гаргавал энэ тухай тэмдэглэлд тусгаж, мөрдөгч нь хүсэлт, гомдлыг хүлээн авч хангах, эсхүл хэрэгсэхгүй болгож, энэ тухай шийдвэр гаргах бөгөөд хүсэлт, гомдлыг хэрэгсэхгүй болгосон мөрдөгчийн шийдвэртэй холбогдуулан прокурорт гомдол гаргах эрхийг заасан.

Практикт зарим мөрдөгч дээрх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахгүй, оролцогчийн хуульд заасан эрхийг хангахгүй, нөгөөтэзгүүр

прокурор хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлэхгүй, гомдол, хүсэлтийг үндэслэлтэй шийдвэрлэхгүй байгаагаас шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчоос гомдол гаргах тохиолдол гардаг.

Иймд прокурор гомдол, хүсэлтийн дагуу хэрэг, материалыг хянахдаа түүнд дурдсан асуудал нэг бүрийн дагуу сайтар хянаж, ялангуяа нэг асуудлаар удаа дараа гомдол гаргасан шалтгаан, нөхцөлийг зайлшгүй тогтоон, холбогдох арга хэмжээг авч, хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэхэд анхаарна.

Түүнчлэн гомдол, хүсэлтэд дурдсан асуудлаар хязгаарлахгүй мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэх, мөрдөгч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэр хүний эрхийг зөрчсөн, эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарласан эсэх, хууль зүйн үндэслэлтэй эсэх талаар хэрэг, материалыг бүхэлд нь хянаж, шаардлага, мэдэгдэл, даалгавар, албан бичиг хүргүүлэх зэргээр оролцогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах арга хэмжээг авна.

Гомдол, хүсэлт, тэдгээрийг шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох материалыг эрүүгийн хэрэг, материалд тусган хавсаргаж, хуулбарыг Мэдээлэл лавлагаа хариуцсан ажилтанд шилжүүлнэ.

Гомдолд хавсаргаж өгсөн баримт нь холбогдох эрүүгийн хэрэг, материалд хэдийнээ авагдсан байвал хавтаст хэрэгт давхардуулан тусгах шаардлагагүй бөгөөд энэ тохиолдолд прокурор тухайн ижил баримтыг гомдлыг шийдвэрлэсэн материалд үдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэн, хувийг гомдлыг шийдвэрлэсэн материалын хамт хэргийн материалд хавсаргана.

1.5 Хариу мэдэгдэх хуудас үйлдэх

Хариу мэдэгдэх хуудсанд гомдол, хүсэлт гаргагчийн овог, нэр, хаяг /оршин суугаа газрын болон цахим шуудан/, утасны дугаар, шийдвэрийн үндэслэлийг гомдол, хүсэлтэд дурдсан асуудал нэг бүрээр тодорхой, ойлгомжтой, аль болох иргэдэд ойлгогдохуйц энгийн үг хэллэгээр бичиж, шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргах эрх, хугацааг зааж өгнө.

Оролцогчоос прокурорт хандаж хэд хэдэн асуудлаар тусдаа гомдол, хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд хариу мэдэгдэх хуудсанд өөрийнх нь гаргасан гомдол, хүсэлтийн утга агуулгыг бичихгүй байвал зохино.

Практикт зарим прокурор гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг хариу мэдэгдэх хуудсанд тодорхой, ойлгомжтой бичихгүй, хэт товч байдлаар тусгаснаас үүдэн оролцогч нараас нэг асуудлаар дахин гомдол гаргах тохиолдол цөөнгүй гардаг. Тухайлбал, хяналтын прокурор Болд нь анх Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаарх мэдээлэл гаргасан иргэн Г-ын гаргасан гомдлыг шийдвэрлэхдээ "...та эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш байх тул хэргийн талаар тодорхой мэдээлэл өгөх боломжгүй байна" гэсэн хариу мэдэгдэх хуудас өгчээ.

Хуульч биш, жирийн иргэний хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлсон "оролцогч"-д ямар хүмүүс хамаарахыг тэр бүр нарийн мэдэхгүйгээс хууль хяналтын байгууллага хэргийг зориуд шалгахгүй, нуун дарагдуулж байгаа мэт хардлагыг тухайн хүнд төрүүлж болно. Энэ тохиолдолд прокурор хуульд юу гэж заагдсан байдаг, ямар учраас хэргийн оролцогч биш гэж үзэн, хэргийн талаар мэдээлэл өгөх боломжгүй байгаа үндэслэлийг ойлгомжтой тайлбарлаж бичих ёстой байсан.

Зарим прокурор хяналтад шийдвэрлүүлэхээр ирүүлсэн, ялангуяа олон хавтас бүхий эрүүгийн хэргийг хүлээн авч хянах явцад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг шийдвэрлэх хуульд заагдсан хугацаа дууссан тохиолдолд "хэргийг хянаж байгаа" талаар дурдаад, гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай тогтоол үйлдэж, хариу мэдэгдэх тохиолдол гардаг. Зүй нь прокурор "хэргийг одоогоор хянаж байгаа ба бүрэн хянаж дууссаны дараа гомдолд дурдсан асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой" талаар гомдол гаргагчид бичгээр хариуг өгч, улмаар хэргийг бүрэн хянасны дараа гомдолд дурдсан асуудлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэж, дахин бичгээр хариуг өгвөл зохино.

Гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн прокурорын шийдвэрийг гомдол, хүсэлт гаргагчид хуульд заасан хугацаанд мэдэгдэхгүй, эсхүл гомдол гаргах хугацааг тодорхой заагаагүйгээс шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргах оролцогчийн эрхийг хязгаарлах, хуулийн хугацааг хэтрүүлэн гомдол гаргах, үүнээс улбаатайгаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах, бусад оролцогчийн зүгээс "прокурор хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авч шийдвэрлэн нэг талд үйлчилсэн" мэт хардлагыг төрүүлэх зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж болзошгүй байдалд анхаарах шаардлагатай.

Прокурор шаардлагатай тохиолдолд гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл, нотолгоо, хууль хэрэглээний талаар гомдол, хүсэлт гаргасан хүнд тайлбарлаж өгнө. Ингэхдээ оролцогчидтой ялгавартай байдал гаргахгүйгээр хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга, зөв шийдвэрлүүлэх итгэл үнэмшлийг төрүүлж чадахуйц харьцааны соёлтой байх хэрэгтэй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Прокурорын тухай хууль
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
3. Улсын ерөнхий прокурорын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Прокурорын байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хянан шийдвэрлэх заавар"
4. 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар"

БҮЛЭГ 6. ХАВТАСТ ХЭРЭГ ХЯНАХ АРГА ЗҮЙ, ХЭРГИЙН ТҮҮВЭР ХИЙХ АРГАЧЛАЛ

СЭДЭВ 1: ХЭРЭГТ ХЯНАЛТ ТАВИХ

1.1 Хэргийг ажиллагааны явцад хянах
1.2 Хэрэг бүртгэлтийн хэргийг хянах
1.3 Мөрдөн байцаалтын хэргийг хянах

СЭДЭВ 2: ХЭРГИЙН ТҮҮВЭР ХИЙХ АРГАЧЛАЛ

2.1 Хэргийг ажиллагааны явцад хянах арга зүй
2.2 Сайн туршлага

СЭДЭВ 1. ХЭРЭГТ ХЯНАЛТ ТАВИХ

Зорилго: Энэхүү сэдвийн хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокуророос гаргах шийдвэр нь хууль зүйн үр дагавар үүсгэж байдаг учраас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокурор хэргийг хянахдаа хэрэгт авагдсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн дүүрэн, нягт нямбай судалж, өөрийн мэдлэг, дадлага туршлагаар олж авсан эрх зүйн ухамсрыг удирдлага болгон мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, тогтоогдсон нөхцөл байдалд хууль зүйн дүгнэлт хийж, үндэслэлтэй шийдвэр гаргах асуудлыг хөндөнө.

1.1 Хэргийг ажиллагааны явцад хянах

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж прокурорын хяналтын үндсэн чиг үүргийг тодорхойлсон.

Прокурор нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект юм.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас эхэлж, хэргийг шалгаж шийдвэрлэн дуусах хүртэлх бүхий л явцад байнга, тасралтгүй хэрэгжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бусаар хязгаарлах явдлыг гаргуулахгүй байхад чиглэнэ.

Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчийн хэрэгжүүлж буй ажиллагаа, шийдвэрт нь хяналт тавьж, хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийг хүчингүй болгож, хариуцлага тооцуулах үүрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйл “Прокурорын бүрэн эрх” 4.2 дугаар зүйл “Прокурорын үүрэг”, Прокурорын тухай хуулийн 14 дүгээр зүйл “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт” –д тус тус хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явц дахь прокурорын эрх, үүргийг тодорхойлсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй

байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.[1]

Иймд прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хяналтаа хэрэгжүүлэхдээ прокурорын зөвшөөрлөөр[2] болон мөрдөгч бие даан явуулах[3] мөрдөн шалгах ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж нотлох баримт цуглуулж, бэхжүүлж байгаа эсэхийг тогтмол хянаж байх нь зүйтэй.

Мөрдөгч нотлох баримтыг хууль бус арга хэрэгслээр цуглуулж бэхжүүлэхийг хуулиар хориглосон бөгөөд ийнхүү цуглуулсан нотлох баримт нь нотолгооны ач холбогдлоо алдана. Практикт мөрдөгч нар санаатай болон санамсаргүй байдлаар процесс ажиллагааны журам зөрчих явдал нэлээдгүй байдаг.

Иймд прокурор мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлэгч субьект болохын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоолоор баталсан тайлбар, Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан заавар, журмыг сайтар судалж, нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшх хугацаанд процесс хуулийг хэрэглэхтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас 3 удаагийн тайлбар гаргаад байна. Үүнд:

- УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.01.12 №04 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай”[4]
- УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.04.14 №16 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг(§16.3, §16.5)-ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар[5]
- УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.05.08 №24 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай”[6]

Улсын ерөнхий прокурорын 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/67 дугаар тушаалын хавсралтаар “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”[7] -г баталсан.

Мөн Улсын ерөнхий прокурорын 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/66 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам””[8] -г баталсан. Энэхүү журам нь мөрдөгчөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах мөрдөн шалгах ажиллагааны дэг, горимыг тогтоосон.

Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэрэг бүртгэлтийн болон

---

1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он 1.1 дүгээр зүйл

2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он 22.1 дүгээр зүйлийн 4 дахь хэсэг

4 УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.01.12 №04 https://supremecourt.mn/files/20231/0_1675246430.pdf

5 УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.04.14 №16 https://supremecourt.mn/files/20236/0_1688722121.pdf

6 УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.05.08 №24 https://supremecourt.mn/files/20236/0_1690534717.pdf

7 \\10.33.0.213 Прокурорын байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан. \\10.33.0.213 Удирдамжын баримт бичиг - 2022.

8 \\10.33.0.213 Прокурорын байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан. \\10.33.0.213 Удирдамжын баримт бичиг - 2022.

мөрдөн байцаалтын хэргийг ажиллагааны явцад нь өөрийн санаачилгаар эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос (хохирогч, яллагдагч, тэдгээрийн өмгөөлөгч) гаргасан гомдол, хүсэлтийг үндэслэн хянана. Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэргийг прокурор хянаж байгаа тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, тогтоогдсон нөхцөл байдал, хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийж, улмаар цаашид хийгдэх ажиллагааны талаар мөрдөгчид заалт чиглэл өгч даалгавар бичиж, даалгаврын биелэлтийг тооцно.

Зарим үед туршлагагүй, шинэ залуу мөрдөгч нар тухайн шалгаж буй хэргийн зүйлчлэл, хэргийн талаар нотолбол зохих байдлаа бүрэн ойлгож мэдрээгүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэт өргөн хүрээнд явуулж, хэрэгт ач холбогдолгүй нотлох баримтуудыг цуглуулж, бэхжүүлэх зэргээр мөрдөн шалгах ажиллагааг удаашруулах явдал гардаг учраас прокурор хэргийг ажиллагааны явцад хянаж, амаар болон бичгээр заалт чиглэл өгч, мөрдөн шалгах ажиллагааны цар хүрээг хумьж, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримтуудыг хэрэгт тусгуулж байх нь чухал.

Ажиллагааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нар гомдол, хүсэлтийг гаргаснаар хэргийг ажиллагааны явцад хянах шаардлага бий болно. Оролцогчоос гаргасан гомдол, хүсэлтэд дурдсан асуудал бүр үндэслэлтэй байхгүй ч тухайн асуудлыг нягтлахын тулд аль болох гомдол, хүсэлт гаргагчтай биечлэн уулзаж санал, хүсэлтийг нь сонсож, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөж байгаа эсэх, мөрдөгч алдаа, зөрчил гаргаж байх эсэхэд хяналтаа хэрэгжүүлнэ.

Ажиллагааны явцад хэрэг хянах нь дараах ач холбогдолтой. Үүнд

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;
2. Мөрдөн шалгах ажиллагааг аль болох богино хугацаанд явуулж, хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэх.

Зарим нэгжийн удирдлагууд байгууллагын ажлын үзүүлэлт болгож, 7 хоног, сард төдий хэмжээний даалгавар бичсэн байх, нийт бичсэн даалгаврын тэдэн хувь нь ажиллагааны явцад хэргийг хянаж даалгавар бичсэн байх гэх мэтээр прокуроруудад үүрэг болгодог. Энэ тохиолдолд прокурорууд ажиллагааны явцад хэргийг хянаж байгаа боловч мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлж, хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлөхүйц чанартай даалгавар бичих бус нэр төдий тоо хөөсөн үр дүнгүй, чанаргүй олон тооны даалгавар бичиж гажуудал үүсгэж байгааг анхаарах нь зүйтэй.

1.2 Хэрэг бүртгэлт явуулсан хэргийг хянах:

Хэрэг бүртгэлтийн үе шат бол нотлох баримт цуглуулах үе шат бөгөөд энэ шатанд гэмт хэрэг гарсан эсэхийг шалгаж тогтооно. Тийм учраас гэмт хэрэг гарсан байж болзошгүй гэсэн үндэслэлээр үүссэн үр дагавар нь хэргийн зүйлчлэлийг тогтоож, хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгадаг.

Хэрэг бүртгэлтийн явцад явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнгээр буюу хэрэгт тусгагдсан нотлох баримтуудаар хүн, хуулийн этгээд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн гэх нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татсан хүн, хуулийн этгээд нь хаана байгаа нь тодорхой бол мөрдөгч хүн тус бүрээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт ирүүлнэ. Зарим мөрдөгч нар олон холбогдогч нартай хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг хамтатган нэг санал ирүүлэх тохиолдол гардаг бөгөөд энэ буруу юм.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай ирүүлсэн хэргийг прокурор хянахдаа мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэгт тусгагдсан нотлох баримтуудаар тухайн хүн, хуулийн этгээдэд холбогдох хэргийн үйл баримт хангалттай нотлогдож тогтоогдсон эсэхэд хууль зүйн дүгнэлт хийж шийдвэр гаргана.

Хэрэг бүртгэлтийн шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргийн талаар нотолбол зохих байдал нотлогдсон байна. Үүнд:

- гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал);
- гэмт хэргийг хэн үйлдсэн;
- гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, шалгаж, бэхжүүлсэн нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоох бөгөөд **“ХЭН, ХЭЗЭЭ, ХААНА, ХЭРХЭН ЯАЖ, ҮЙЛДСЭН”** (5W 1H) гэсэн асуултад хариулж чадахуйц байгаа бол та эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах шийдвэр гаргана.



Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын тогтоол нь хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх хуулийн шаардлагад нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтын талаар болон хууль зүйн дүгнэлтийг тогтоолд бичнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “үйл баримт” гэсэн үг хэллэг байхгүй, гэвч хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, түүгээр батлагдаж байгаа үйл баримтыг зөв тодорхойлсон байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад чухал ач холбогдол бүхий хууль зүйн дүгнэлт болдгийг анхаарах нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг бүр өөр хэдий ч хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд өмнө нь мөн төрлийн хэргийн шинжийг хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн практикийг судлах нь хууль зүйн үндэслэлтэй, зөв шийдвэр гаргахад дөхөм болдог учраас залуу прокурорууд хэргийн зүйлчлэлийн талаарх болон хууль хэрэглээний талаарх практикийг Улсын дээд шүүхийн цахим хаяг https://www.supremecourt.mn/, шүүхийн шийдвэрийн цахим сан https://shuukh.mn/ -аас судлах шаардлагатай.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хүний халдашгүй чөлөөтэй байхын эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг зэрэг нь хохирогчтой хэрэг байхад зарим мөрдөгч нар хохирогчоо тогтоож, мэдүүлэг аваагүй, хохирлын хэмжээг тогтоогоогүй атлаа таамгаар хэргийн зүйлчлэлийг тогтоож, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт ирүүлэх явдал байдаг. Энэ төрлийн хэргүүд нь хохирогчтой хэрэг учраас гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийг хохирогчоор тогтоосны дараа прокуророос эрүүгийн хэрэг

үүсгэж яллагдагчаар татах шийдвэр гаргах нь зүйтэй.

Практикт мөрдөгч нар гэмт хэрэгт холбогдуулан шууд нэр заасан, эсхүл хамаарал бүхий нотолгоо бий болсон хүнд худал мэдүүлбэл хуулийн хариуцлага хүлээлгэхээр хууль сануулж гэрчийн мэдүүлэг авах, улмаар уг мэдүүлгээ эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналынхаа үндэслэл болгож оруулж ирдэг.

Ийнхүү гэрчийн мэдүүлэг авах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан "..өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно" гэснийг ноцтой зөрчсөн зөрчилд тооцогдох тул эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолд гэрчийн мэдүүлгийг тусгаж, тогтоолын үндэслэл болгож болохгүй.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг(§16.3, §16.5)-ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбарыг батлан гаргасан. Энэхүү тайлбарын 1 дэх хэсгийн 1.1-т "Гэмт хэрэгт сэжиглэх илт үндэслэл буй бол хүнийг гэрчээр байцааж болохгүй ба гэрчийг байцааж байх үед мэдүүлгээс тийм үндэслэл илэрсэн даруйд байцаалтыг зогсоох ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулан зөвхөн зөвшөөрсөн тохиолдолд хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна." гэж тайлбарласан байгааг анхаарах нь зүйтэй.

Хэрэг бүртгэлтийн явцад гэмт хэрэг үйлдэгдээгүй, эсхүл тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдвол мөрдөгч хэрэг бүртгэлтийг хаах[9] саналтай хэргийг прокурорт ирүүлнэ.

Хэрэг таних гэдэг ойлголт практикт байдаг. Энэ сэтгэлгээний ойлголтыг прокурор өөртөө суулгана. Эрүүгийн эрх зүйн онолын түвшинд олж авсан мэдлэгээ практикт Эрүүгийн хууль хэрэглэх байдлаар бататгаж, хэргийг зөв зүйлчлэх, хэрэг таних чадварыг өөртөө суулгадаг. Тийм учраас мөрдөнгийн чиглэлээр олон жил ажилласан дадлага туршлагатай прокуроруудад "хэрэг таних" ур чадвар аль хэдий бий болсон, суусан байдаг.

Хаах тухай саналтай ирүүлсэн хэргийг прокурор хянахдаа хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үндэслэл болсон *"... гэмт хэрэг гарсан байж болзошгүй"* гэх нөхцөл байдлыг мөрдөн шалгах ажиллагаагаар тал бүрээс бүрэн дүүрэн шалгаж, тогтоосон эсэх, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдолд дурдсан асуудал, хохирогчоор тогтоогдсон этгээдийн мэдүүлэгт дурдсан асуудлыг бүрэн гүйцэд шалгаж, улмаар хэрэг бүртгэлтийн явцад гэмт хэрэг үйлдэгдээгүй, эсхүл тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдсон гэж үзвэл хэрэг бүртгэлтийг хаах тухай шийдвэр гаргана.

Жишээлбэл: Иргэн Бат том оврын тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа зам тээврийн осол гаргаж, 2 хүний авто машиныг мөргөж, нийт дүнгээр 100 гаруй сая төгрөгийн хохирол, 2 хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл[10] учруулжээ.

Мөрдөгч дээрх хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх хэсгээр зүйлчлэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, улмаар хэргийг хаах тухай санал гаргасан.

---

[9] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он 30.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

[10] Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Гэмтлийн зэрэг тогтоох журам" https://legalinfo.mn/mn/detail/10777

Прокурор хэргийг хянаад "...мөрдөгч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх хэсэг "жолооч зам тээврийн осол гаргаж, бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан"-ээр зүйлчлэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгалтын ажиллагаа явуулсан боловч 2 хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан байна. Тухайн гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид эд хөрөнгийн хохирол дангаар хамаарахгүй, харин уг заалтад "Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол ..." гэмт хэрэг гэж тооцохоор заасан байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан", эсхүл "эд хөрөнгөд хохирол учруулсан" үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тодорхойлж заагаагүй тул иргэн Б.Г-ийн үйлдсэн авто тээврийн хэрэгсэл жолоодох үедээ осол гаргаж, бусдын автомашиныг мөргөж, эд хөрөнгөд хохирол учруулсан, хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

Иргэн Батын дээрх үйлдэл нь гэмт хэрэг үйлдсэнд тооцогдохгүй боловч хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөний дүрэм, журмыг зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах боломжтой, мөн бусдад учруулсан хохирлыг Иргэний хуульд заасан журмаар шийдвэрлүүлэх нь зүйтэй" гэсэн хууль зүйн дүгнэлтийг хийж, хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэг бүртгэлтийг хааж байгаа боловч прокурорын зүгээс хэргийг хянахдаа энэ хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон иргэн, хуулийн этгээд иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж, хохирол төлбөрөө барагдуулах боломж нөхцөлийг нь хангаж, шаардлагатай баримтуудыг хэрэгт хавсаргасан байх нь чухал.

1.3. Мөрдөн байцаалтын хэргийг хянах:

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа ЭХХШтХ-д заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ. [11]

Мөрдөн байцаалт явуулж дуусгасан хэргийг шийдвэрлүүлэхээр мөрдөгч хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлдэг.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтуудад тулгуурлан мөрдөгч хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх хуульд заасан үндэслэл[12] бий болсон гэж үзвэл эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай саналыг прокурорт ирүүлнэ.

Прокурор хэргийг хянахдаа мөрдөгчийн гаргасан саналын үндэслэл нь нотлох баримтад үндэслэгдсэн эсэхийг хянана. Тухайлбал сэжигтэн, яллагдагч нас барсан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох саналт гаргасан тохиолдолд нэгдүгээрт тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтаар хангалттай нотлогдож тогтоогдсон байх ёстой, хоёрдугаарт нас барсан талаарх улсын бүртгэлийн байгууллагаас олгосон нас барсны гэрчилгээ[13] хэрэгт хавсаргагдсан эсэх заавал нягтална.

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай ирүүлсэн хэргийн хувьд мөн адил

[11] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 31.1 дүгээр зүйл
[12] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
[13] Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он, 13 дугаар зүйл

тухайн хүүхэд гэмт хэрэг үйлдсэн болох нь хангалттай нотлогдож тогтоогдсон байх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нар нь хариуцах үүрэг хүлээсэн эсэх, иргэний хариуцагчаар татсан эсэх, гэмт хэрэг гарсан цаг хугацаа, яллагдагчаар татагдсан этгээдийн төрсөн он сар өдөр, насны байдал нь бүрэн тогтоогдсон байх ёстойг анхаарах нь зүйтэй.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргах нь харьцангуй бага байдаг. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх буюу эрүүгийн хариуцлагыг нөхөн хүлээлгэх хугацааг Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд гэмт хэргийн хүнд, хөнгөн, ялын төрөл, хэмжээнээс хамааран ялгавартай тогтоосон бөгөөд уг хугацаа дууссан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй ба энэ нь тухайн этгээдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдог. Гэмт хэргийг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан журмын дагуу тоолно.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэснийг практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 11 дугаартай тогтоолоор албан ёсны тайлбар[14] гаргасан.

Гэмт хэргийн шинжгүй үндэслэлгүй хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт ирүүлсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тусгасан яллах талын нотлох баримтыг няцаан үгүйсгэсэн нотлох баримт бий болсон эсэх, эсхүл яллах талын нотлох баримтыг цуглуулахдаа хууль зөрчсөний улмаас тухайн нотлох баримт нотолгооны ач холбогдолгүй болсон эсэх зэргийг хянаж, нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоож, хууль зүйн дүгнэлтийг зөв хийж хэргийг шийдвэрлэх нь зүйтэй.

Хэргийг бүхэлд нь хянаж хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах бөгөөд прокурорын тогтоолд мөрдөн шалгах ажиллагааны явцад шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан, битүүмжилсэн эд хөрөнгө байгаа эсэх, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга тухайлбал Монгол Улсын хилээр гарах эрхийг хязгаарласан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх, эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл байгаа эсэх зэргийг хянаж, энэ талаар тогтоолд дурдаж, шийдвэр гаргах учиртай.

Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт ирүүлж байгаа хэргийн хувьд прокурор хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг үнэлж, өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдвэр гаргана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргийн талаар нотолбол зохих байдал нотлогдсон эсэх, яллагдагчийн гэм буруугийн асуудлыг шүүхээр хянан шийдвэрлүүлэхэд мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтууд нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, ямар нэгэн эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал бий болгоогүй байх нь чухал.

Шүүхэд шилжүүлэх саналтай ирүүлсэн хэргийн хувьд прокурор хянавал зохих асуудал :

- оролцогчийг хэргийн материалтай танилцах боломжоор хангасан эсэх, танилцаад гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн эсэх;

- гэмт хэргийн шинжийг бүрэн нотолсон эсэх;
- хэргийг ХБ, ЭХҮЯТТ тогтоолыг хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах үндэслэл байгаа эсэх;
- ЭХХШтХ-ийн 16.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх;
- Эрүүгийн хууль болон ЭХХШтХ- зүйл, хэсэг, заалтыг зөв хэрэглэсэн эсэх;
- ТСАХ хэрэглэхдээ хууль зөрчсөн эсэх;
- гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан эсэх;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх зэргийг нягтлах шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт нотлох баримтыг тодорхойлж, түүнийг цуглуулах, бэхжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчихгүй байх болон хэрхэн үнэлж, хууль зүйн дүгнэлт хийхийг тодорхойлсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.9 дүгээр зүйл буюу “Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулах” хуулийн зохицуулалттай. Хэргийг хянах явцад яллах дүгнэлт үйлдэх үед тогтоолд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлага бий болдог.

Мөрдөн байцаалтын шатанд яллагдагчаар татаж буруутгасан хэргийн зүйлчлэлийг прокурор хөнгөрүүлэх, хүндрүүлэх эрхтэй боловч тэрхүү хүндрүүлэн өөрчилсөн хэсгээ танилцуулж, улмаар яллагдагчийн хуулиар эдэлбэл зохих эрхийг нь хангасны эцэст хэргийг шүүхэд шилжүүлэх ёстой.

Жишээ: Шүүхэд шилжүүлэх саналтай ирүүлсэн хэргийг прокурор хянаад Г.Б-ийг архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ буюу 2018 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын төвд үйл ажиллагаа явуулдаг “Дамбо” дэлгүүрийн орчимд Б.Н, Б.Ц нартай хувийн таарамжгүй харьцааны улмаас маргалдаж, улмаар авч явсан 4 литрийн савтай бензинээ тэдэн рүү цацаж, онц харгис хэрцгийгээр, олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар галдан шатаасны улмаас Б.Ц-ыг алсан үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2, 2.6-д заасан гэмт хэрэгт,

Б.Н- г алахыг завдсан үйлдэлд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2, 2.6-д зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Прокурор яллах дүгнэлт үйлдэх үедээ Г.Б-ийг ялыг хүндрүүлж ял өөрчлөн сонсгох тогтоол үйлдэж, тогтоолыг танилцуулсан боловч түүнээс мэдүүлэг авалгүйгээр яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлсэн.

Энэ хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэж шийтгэх тогтоол гаргасан боловч, давж заалдах шатны шүүх гомдлоор хэргийг хянан хэлэлцээд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.9 дүгээр зүйл буюу “Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулах” тухай хэм хэмжээ нь прокурорын эрх хэмжээтэй холбоотой асуудлыг зохицуулснаас бус бусад уг хуульд заасан журмын дагуу явагдах ажиллагааг хязгаарлах үндэслэл болохгүй. Мөрдөн байцаалтын шатанд яллагдагчаар татаж буруутгасан хэргийн зүйлчлэлийг прокурор хөнгөрүүлэх, хүндрүүлэх эрхтэй боловч тэрхүү хүндрүүлэн өөрчилсөн хэсгээ танилцуулж, улмаар яллагдагчийн “ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх” эрхийг эдлүүлээгүй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гэж

дүгнэн” хэргийг прокурорт буцааж шийдвэрлэснийг хяналтын шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэж байсан байна. Энэ шийдвэрийг [15]та бүхэн шүүхийн шийдвэрийн цахим сангаас дэлгэрэнгүйгээр уншиж танилцах боломжтой.

Прокурорын яллах дүгнэлтэд тусгах яллах талын нотлох баримтууд нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, шалгаж, бэхжүүлсэн процессын алдаа, зөрчилгүй байх ба хууль зөрчиж цуглуулсан нотлох баримт нь нотолгооны ач холбогдлоо алддаг болохыг анхаарах хэрэгтэй.

Прокурорын яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох, хавсралт гэсэн 3 хэсгээс бүрдэх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлд яллах тавигдах хуулийн шаардлагыг тодорхойлсон.

Яллах дүгнэлтийн тогтоох хэсэгт тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хамааралтай, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлж авсан нотлох баримтуудыг дурдах бөгөөд мэдүүлгэн нотлох баримтуудыг дурдахдаа тухайн үйлдлийг нотолж буй хэсгийг хэсэгчлэн иш татан оруулж, бусад нотлох баримтын тухайд дүгнэлт хийсэн байдлаар бичих, харилцан зөрүүтэй нотлох баримтуудын аль нь үнэн зөв, алиныг нь буруу гэж үзсэн, ямар нотлох баримтуудаар нотлогдон эсхүл үгүйсгэгдэж байгаа, хэд хэдэн үйлдэлтэй бол нотлох баримтуудыг үйлдэл тус бүрээр дүгнэж бичих нь зүйтэй байдаг.

Хэрэг бүртгэлтийн явцад гэрчээр мэдүүлэг өгсөн хүнийг, мөрдөн шалгах ажиллагаагаар нотлогдсон үйл баримтад тулгуурлан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдолд, түүний гэрчээр өгсөн мэдүүлгийн нотлох чанар үгүйсгэгдэх тул уг хүний гэрчийн мэдүүлгийг яллах, цагаатгах талын нотлох баримт болгон үнэлэхгүй байх, яллах дүгнэлтэд нотолгооны ач холбогдолтойгоор тусгахгүй байх шаардлагатай. Энэ талаарх шүүхийн практик тогтсон, албан ёсны тайлбар гарсан гэдгийг прокурорууд анхаарах хэрэгтэй.

Прокуророос гаргаж буй бүхий л эрх зүйн хэлбэр ялангуяа хэргийн оролцогч нарт гардуулах яллах дүгнэлт, хэрэгсэхгүй болгох тогтоол, хэрэг бүртгэлтийг хаах тогтоол, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тогтоол зэрэг нь товч, оносон үг хэллэг бүхий ойлгомжтой, орчин үеийн эрх зүйн ухамсар, мэдлэгийн түвшинд хууль зүйн дүгнэлт хийсэн байдлаар бичигдсэн байх шаардлагатайн гадна хэл зүй, өгүүлбэр зүйн дүрмийн хувьд алдаагүй, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд [16] нийцсэн байвал зохино.

Тогтоолд дурдсан бүх асуудал өөр хоорондоо харилцан уялдаатай, учир зүйн холбоотой бичигдсэн байх учиртай бөгөөд бие биеэ үгүйсгэсэн, зөрчилтэй дүгнэлт хийж болохгүй.

[15] УДШ-ийн 2019 оны 475 дугаар тогтоол

[16] Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралт

СЭДЭВ 2. ХЭРГИЙН ТҮҮВЭР ХИЙХ АРГАЧЛАЛ

2.1 Хэргийн түүвэр хийх арга зүй

Хэргийн түүвэр хийх арга зүй прокурор нэг бүрт өөр өөр байдаг бөгөөд яг тухайлсан байдлаар тэгж хийх ёстой, ингэх ёстой гэсэн тогтоосон зүйл байхгүй. Гэхдээ хэрэг хянаж байгаа бол танд хэргийн түүвэр тэмдэглэл байх ёстой бөгөөд энэ нь хэргийн материалыг бүхэлд нь хуулбарлах асуудал биш юм.

Ихэнх прокурор хэргийн түүвэр тэмдэглэлийг дараах байдлаар хийдэг.

- Процесс ажиллагаа
- Нотлох баримт
  - яллах
  - цагаатгах
- Зөрчил
- Шийдвэрлэх арга зам
- Цаашид хийгдэх ажиллагаа, анхаарах асуудал

Процесс ажиллагааны тэмдэглэл хэсэгт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан үеэс эхлэн яллах дүгнэлт үйлдэх үе шат хүртэлх гол гол процесс ажиллагаануудыг тэмдэглэнэ. Тухайлбал:гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл гаргасан огноо, ХБ нээсэн огноо зүйлчлэл, ХБ явуулсан нийт хугацаа, ЭХҮЯТ тогтоолын огноо, зүйлчлэл, МБ явуулсан хугацаа, прокурорын зөвшөөрлөөр хэрэгт хийгдсэн МША-нууд, прокурорын гаргасан шийдвэрүүд гэх мэт

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч яллах болон цагаатгах талын нотлох баримтуудыг аль алиныг цуглуулах үүрэгтэй. Хэргийн түүвэр тэмдэглэлдээ тухайн хэрэгт ач холбогдолтой, хамааралтай нотлох баримтууддаа яллах болон цагаатгах байдлаар нь ангилан бичнэ. Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлж байгаа хэргийн хувьд хэргийн түүвэр тэмдэглэл нь шүүх хуралдааны явцад ашиглах гол баримт болдог. Сүүлийн үед прокурорууд техник технологийн өөрчлөлттэй холбоотойгоор хэргийн гол гол нотлох баримтуудыг гэрэл зургаар бэхжүүлж, файл болгон хадгалж, хяналтын ажилдаа ашиглах болсон. Ингэхдээ нууцлалаа хадгалах нь чухал бөгөөд тодорхой хугацааны дараа файлаа устгах хэрэгтэй. Төрийн болон албаны нууц, хувь хүний нууцтай холбоотой нотлох баримтуудад хянамгай хандах нь чухал.

Прокурор бүрт хэргийн түүвэр хийх арга, аргачлал суусан байдаг бөгөөд хэрэг хянасан прокурорын хувьд тухайн түүвэр тэмдэглэл нь танд өөрт ашиглагдах тэмдэглэл болно. Зарим прокурор хэргийн түүврийг маш дэлгэрэнгүй хийж байхад зарим нь товч хэлбэрээр хийдэг. Хэргийн түүвэр тэмдэглэлийг гараар дэвтэрт бичих, мөн компьютерт бичиж файл хэлбэрээр хадгалах аль нь ч байж болох бөгөөд аль ч тохиолдолд түүвэр тэмдэглэл нь таны хяналтын ажилд нь ашиглагдана.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он 22.1 дүгээр зүйлийн 4 дахь хэсэг
2. УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.01.12 №04 https://supreme-court.mn/files/20231/0_1675246430.pdf
3. УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.04.14 №16 https://supreme-court.mn/files/20236/0_1688722121.pdf
4. УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2023.05.08 №24 https://supreme-court.mn/files/20236/0_1690534717.pdf
5. Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэмтлийн зэрэг тогтоох журам” https://legalinfo.mn/mn/detail/10777
6. УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол 2022.03.09№11 “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар”
7. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он, 13 дугаар зүйл
8. УДШ-ийн 2019 оны 475 дугаар тогтоол
9. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралт

БҮЛЭГ 7. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН ТООЦООГ ГАРГАХ АРГА ЗҮЙ

СЭДЭВ 1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН ЯЛГААГ ТОДОРХОЙЛОХ;

1.1. Гэмт хэргийн хохирлын талаарх ойлголт, хэрэглээ
1.2. Гэмт хэргийн хор уршгийн талаарх ойлголт, хэрэглээ
1.3. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг тодорхойлох нь

СЭДЭВ 2. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН ТООЦООЛЛЫГ ГАРГАХ ТУХАЙ

2.1. Хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол
2.2. Мал хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол
2.3. Залилах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол
2.4. Албан тушаалын гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол
2.5. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол
2.6. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

СЭДЭВ 1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН ЯЛГААГ ТОДОРХОЙЛОХ

Гэмт хэргийн хохирол, хор уршгийг зөв тогтоох нь гэмт хэргийн зүйлчлэл, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл, хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд ач холбогдолтой байдаг.

1.1. Гэмт хэргийн хохирлын талаарх ойлголт, хэрэглээ

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн хохирол, хор уршгийн талаарх ойлголт, томьёолол тодорхой бус, Улсын Дээд Шүүхийн тайлбарыг баримталж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирол, хор уршиг”-ийн талаар тодорхой заасан байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно” гэж хохирлыг томьёолж тодорхойлсон.

Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас шууд учирч зөрчигдөж буй Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлыг ойлгохоор байна.

Гэмт хэргийн хохирлын хэмжээг “их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; “үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; “бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээгээр тогтоосон.

Судлаачид, гэмт хэргийн хохирлыг тодорхойлохдоо гэмт хэргийн улмаас үүсэж буй алдагдал, гарз, сүйрэл, хөнөөл бөгөөд нөхөн төлөгдөх шинжтэй байна. Хохирол нь тооцож, хэмжиж болохуйц ба эрх зүйн зөрчил, үр дагаврын шалтгаант холбоо ойрхон бөгөөд хүчтэй байх гэсэн шинжүүдтэй байхаар нийтлэг байдлаар үзсэн байна.

1.2. Гэмт хэргийн хор уршгийн талаарх ойлголт, хэрэглээ

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно” гэжээ.

Хор уршиг нь хохирол учруулснаас үүссэн арилгах болон нөхөн төлөх боломжтой, мөн боломжгүй, ирээдүйд үр дагавар нь бий болох, гинжин хэлхээ мэт үргэлжлэн бий болох сөрөг үр дагавар байна.

Тодруулбал, эд хөрөнгө устгаж бүр мөсөн үгүй болсон, гэмтээсэн учраас урьдын төлөвт аваачих боломжгүй болсон, иргэний эрүүл мэндэд хохирол учруулснаас эрхтнээсээ хагацсан, сохор дүлий болсон, ураг зулбасан, хүүхэд дутуу төрүүлсэн, байнгын тахир дутуу, сэтгэл мэдрэлийн эдгэршгүй өвчтэй болсон, ойр дотнынх нь хүмүүсийн амь нас хохирсон, өөрт нь болон ойр дотнынх нь хүмүүст хүнд гэмтэл учирсан, эсхүл амьжиргааны эх үүсвэрээс салсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал үүссэн, халдварт өвчин тархсан, амиа хорлосон гэх мэт үр дагаврууд бий болохыг ойлгохоор байна.

1.3. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг тодорхойлох нь

Дээрхээс үзэхэд хохирол, хор уршгийн ялгааг дараах байдлаар тодорхойлохоор байна. Тухайлбал,

- Аливаа үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэрэг мөн эсэхийг шийдвэрлэхэд учирсан хохирол, түүний хэмжээ нь гол үндэслэл, шалгуур болдог.
- Зарим төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинжийн хувьд нийгэмд аюултай хор уршиг нь гэмт хэргийг зүйлчлэхэд чухал үүрэгтэй.
- Хохирол нь гэмт хэрэг болон эрх зүйн зөрчлийг хооронд ялгах шинж болно.
- Гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинжээр хор уршгийг заагаагүй тохиолдолд түүнийг хүндрүүлэх нөхцөл байдал гэж үздэг.

СЭДЭВ 2. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН ТООЦООЛЛЫГ ГАРГАХ ТУХАЙ

2.1. Хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Хохирогчийн мэдүүлэгт дурдсан эд хөрөнгийн шинж байдлыг нарийвчлан шалгах ба бусад бичгийн нотлох баримтаар түүний мэдүүлгийг нотолсны эцэст хохирлын тооцооллыг гаргах, (Эд зүйл шинэ, хуучин хэмжээ, элэгдэл хорогдлыг нотлох баримтаар тогтоох),

Хохирлын хэмжээг бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно. эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, шинжээчийн дүгнэлтээр бодит хохирлыг тооцно. (Үнэлгээний байгууллагаар гаргуулах),

Хохирогчийн мэдүүлгээр хохирлыг тогтоохгүй, харин алдсан эд зүйлтэй холбоотой баримтыг гаргуулж, шинжийг тодорхойлсон байх бөгөөд хавтаст хэрэгт авагдсан бусад нотлох баримттай тохирч байгаа эсэхэд прокурор дүгнэлт хийж, хянах.

Олон үйлдэлтэй хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцооллыг EX-CEL программ ашиглаж, тусгай томьёогоор математик аргачлалд оруулж гаргах нь хэргийн оролцогч нарт ойлгомжтой байна.

Хулгайлах гэмт хэргийн улмаас хор уршиг учирч болно. Жишээ нь: иргэн Б нь 2023 оны 07 дугаар сарын 10-аас 11-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 12 дугаар

хорооны нутаг дэвсгэр 25 дугаар байрны автомашины зогсоолоос өөрийн өмчлөлийн Тоёота приус-41 маркийн 45-65 УАА улсын дугаартай тээврийн хэрэгслээ хулгайд алдсан байна.

Гэмт хэргийн хохирол нь 32,000,000 төгрөгийн үнэлгээ бүхий тээврийн хэрэгсэл байх бөгөөд алдагдсан тээврийн хэрэгслийг эрж хайсантай холбоотой 1,500,000 төгрөгийн зардал гарсан болох нь нотлох баримтаар тогтоогдож, иргэн Б нь 1,500,000 төгрөгийг нэхэмжилсэн нь гэмт хэргийн улмаас учирсан хор уршигт хамаарч байна.

Зарим алдагдсан эд зүйлийн онцлог шинж байдлаас шалтгаалан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гаргуулах. Үүнд: Соёлын өвтэй холбоотой эрүүгийн хэргийн хувьд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгайлан хамгаалсан соёлын өв байх ёстой. Энэ тохиолдолд үнэлгээг соёлын өв талаас нь мэргэжлийн байгууллагаар, эрх бүхий албан тушаалтнаас баталсан журмын дагуу гаргуулна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.1, 25.2, 25.3, 25.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг.

2.2. Мал хулгайлах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Хохирогчоос алдсан малын зүс, нас, үүлдэр, таних содон шинж, бод мал, бог малын аль нь болохыг тодруулж мэдүүлэг авах, алдсан мал нь гойд ашиг шимт мал мөн эсэхийг шалгасны дараа мэргэжлийн холбогдох байгууллагын үнэлгээ, шинжээчийн дүгнэлтээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг тогтоолгоно.

(мэргэжлийн холбогдох байгууллага гэдэгт морины шинж буюу хурдан морины үүлдэр, омгийг тодорхойлоход ач холбогдолтой, мөн гойд ашиг шимт малыг тогтоох)

Мал хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь үнэлгээ бүхий хулгайлагдсан мал байна. Хулгайлагдсан малыг эрж хайх, тээвэрлэх, бусдаар маллуулсан гэх хохирогчоос гаргасан зардлууд нь баримтаар нотлогдож байвал гэмт хэргийн улмаас үүссэн үр дагавар буюу гэмт хэргийн хор уршигт тооцно.

Жишээ нь: иргэн А нь 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр “Гарьдын гол” гэх газраас хурдан удмын улсын наадамд түрүүлж байсан хээр морио хулгайд алдсан байна.

Уг гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь хурдан морины үнэлгээ 50,000,000 төгрөг, иргэн А нь 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хурдан хээр морио иргэн Б-д 150,000,000 төгрөгөөр худалдан борлуулахаар бичгээр гэрээ байгуулж, урьдчилгаа 60,000,000 төгрөгийг авсан болох нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон байна. Энэ тохиолдолд А-ийн нэхэмжилсэн морины үнийн зөрүү 90,000,000 төгрөгийг гэмт хэргийн улмаас учирсан хор уршигт тооцохоор байна.

2.3. Залилах гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Хохирогчийн мэдүүлэгт дурдсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан байдлыг нарийвчлан шалгах ба бусад бичгийн нотлох баримтаар түүний мэдүүлгийг нотолсны эцэст хохирлын тооцооллыг гаргах,

Хохирлын хэмжээг бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно. Харин шууд бус хохирлыг энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд түүгээр хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүй.

Хохирогч нь өөрт зайлшгүй орох байсан орлогоо Иргэний хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй бөгөөд ийнхүү гаргасан нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй нь хамтатган шийдвэрлэнэ. Иргэний нэхэмжлэлийн тооцоог бүрэн хийх боломжгүй бол хуульд зааснаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ гаргахыг хохирогчид мэдэгдэнэ.

Бусдын өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан тохиолдолд уг эрхээр баталгаажсан эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр бодит хохирлыг тооцно. (УДШ-ийн 51 дугаартай тогтоол),

Залилах гэмт хэргийн хувьд, олон хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагчтай, үнийн дүн өндөр байдаг тул EXCEL программ ашиглаж, тусгай томьёогоор математик аргачлалд оруулж тооцоог гаргана.

Хохирлын тооцоо нь хавтаст хэрэгт байгаа нотлох баримтад үндэслэсэн, хохирол, хор уршигтай холбоотой ач холбогдол бүхий мэдээллийг багтаасан байх ёстой гэдгийг анхаарна.

Хохирлын тооцоог зөв хийгээгүй нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтад “яллаж байгаа гэмт хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай нотлох баримт”, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 5.5 дахь заалтад “хохирол, хор уршгийн талаарх мэдээлэл” гэж тус тус заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр шүүхээс хэрэг прокурорт буцах шалтгаан, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөл болдог.

Тохиолдол № 1,

Иргэн А нь 2019 оны 12 дугаар сард Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт иргэдэд “Америкийн нэгдсэн улсын виз гаргаж өгнө” гэж хуурч, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж их хэмжээний мөнгө залилан авсан гэмт хэргийн хохирлын тооцоог дараах байдлаар гаргасан.

ХОХИРЛЫН ТООЦОО /ХАВСРАЛТ/

№	ЭХ Дугаар Хохирогч Нийт хохирол	Хохирогчийн регистрийн дугаар: Нөхөн төлөгдсөн хохирол	Үлдэгдэл	Харьцсан данс /ХХК/	Огноо	2020.06.29 шилжүүлсэн	мөнгө
1	2005009950453 460000 285000	[redacted]		[redacted]	2019.03.14	180000	745000
		[redacted]		2019.05.24	503000		
		бэлнээр	2019.06	62000			
2	2005009960452 746000	[redacted]		[redacted]	2019.03.11	180000	746000	0
		[redacted]		2019.07.03	62000		
		[redacted]		2019.07.05	504000		
3	2005009970451	[redacted]	бэлнээр	2019.03.25	180000	180000	0	180000
4	2005009980450 273000	[redacted]		[redacted]	2019.03.24	501000	743000	470000
		бэлнээр	2019.03.10	180000			
		[redacted]		2019.06.19	62000		
5	2005009990454 223000	[redacted]		[redacted]	2019.05.23	503000	683000	460000
		[redacted]		2019.03.14	180000		
6	2005010010448 742840 0	[redacted] 742840		[redacted]		2019.03.25	500840
		[redacted]		2019.06.19	62000		
		бэлнээр	2019.02	180000			

2.4. Албан тушаалын гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Албан тушаалын гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцооллыг гаргахад анхаарах асуудал;

Албан тушаалын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна Төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллын

үнэлэмжийг сулруулах зэрэг бусад хор уршиг учруулдаг онцлогтой.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн хохирол, хор уршгийг гэмт хэргийн зүйчлэл тус бүрээс хамаарч өөр байдлаар тодорхойлох. Үүнд:

Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн хувьд, хууль бус үйлдлийн улмаас шууд учирсан үр дагавар буюу хууль бус гэрээний үнийн дүнгээр тодорхойлно.

Тохиолдол № 1,

С.М- болон В.Б- нар нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, тендер шалгаруулалтыг хууль бусаар зохион байгуулж, гэрээ байгуулагдаагүй байхад үнийг шилжүүлсэн, мөн техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй техникийг албан ёсоор хүлээн авсан баримт бүрдүүлэхийг эрх олгогдсон этгээдээс шаардаж, тэдэнд хууль бусаар нөлөөлж (57,000,000 төгрөг) их хэмжээний хохирол учруулснаас гадна хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтад оролцож ажил, бараа, үйлчилгээг нийлүүлэх эрхийг шударгаар олж авбал зохих аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх ашиг, түүнчлэн төрийн үйл ажиллагааны хууль ёсны байдалд хор уршиг учруулсан байх тул тэдний үйлдэл эрх мэдэл, албан тушаалын гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж үзнэ. (УДШ 2018.10.24 №465),

Тохиолдол № 2,

Шүүх Ж.Р-оор нөхөн төлүүлэх хохирлын хэмжээг түүний үйлдсэн гэмт хэргийн хохиролд тооцож буруу дүгнэлт хийсэн, мөн шүүгдэгч Ж.Р, түүний өмгөөлөгч Л.Н нар нь авто чиргүүл болон барилга байгууламжийн үнэлгээний дүнг эс зөвшөөрч, маргаж буй хэдий ч шүүгдэгч Ж.Р-ийн албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас учруулсан хохирлын хэмжээ нь шинжээчийн тогтоосон үнэлгээний дүнгээс хамаарч өөрчлөгдөхгүй, харин Ж.Р-ийн авто чиргүүл болон барилга байгууламжийн төлбөрт хууль бусаар шилжүүлсэн 89.900.000 төгрөг болон 250.000.000 төгрөгийн дүнгээр тодорхойлогдоно.

Шүүх хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гаргасан иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ шүүгдэгч Ж.Р-ийн авто чиргүүл болон барилга байгууламж худалдаж авахаар шилжүүлсэн мөнгөн дүнгээс шинжээчийн тогтоосон үнэлгээний дүнг хасаж, зөрүүг шүүгдэгч Ж.Р-оос гаргуулснаас гадна шүүгдэгч Ж.Р-ийн гэмт хэрэг үйлдэх замаар олсон хууль бус орлогыг хурааж, улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн нь хуульд нийцсэн гэж дүгнэв. (УДШ 2019.07.08 №366),

Хохирлын тооцоог дараах байдлаар гаргаж болно. Үүнд:

Тохиолдол № 3,

Онцгой байдлын ерөнхий газрын албан тушаалтан А нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөртөө давуу байдал бий болгож 540,000,000 төгрөгийн их хэмжээний хохирол учруулсан гэх хэргийн хохирлыг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

ЭРҮҮГИЙН 17000000 ДУГААРТАЙ ХЭРГИЙН ХОХИРЛЫН ТООЦОО /2014 ОН/

2020 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

	1	2	Нийт
Нийт төсөв	200 сая төгрөг Ой хээрийн түймэр унтраах зориулалттай автомашин /Hyundai Fire fighting truck/		2 ширхэг автомашин
Нэг автомашин нийлүүлэх үнэ	100 сая төгрөг	100 сая төгрөг	200 сая төгрөг
Нэг автомашины нийлүүлсэн үнэ	Ханш 1.76 төгрөг х 50 сая вон =88,000,000 төгрөг	Ханш 1.76 төгрөг х 50 сая вон = 88,000,000 төгрөг	176,000,000 төгрөг
Тээвэрлэлтийн зардал	1,045,079.545455 вон 1,839,339.99 төгрөг	1,045,079.545455 вон 1,839,339.99 төгрөг	3,678,679.98 төгрөг
Татвараас чөлөөлсөн байдал	Нэмэгдсэн өртгийн татвар 10 хувь буюу 8,983,934 төгрөг чөлөөлсөн Гаалийн татвар 5 хувь буюу 4,491,967 төгрөг төлсөн	Нэмэгдсэн өртгийн татвар 10 хувь буюу 8,983,934 төгрөг чөлөөлсөн Гаалийн татвар 5 хувь буюу 4,491,967 төгрөг төлсөн	Чөлөөлсөн татвар-17,967,868 төгрөг Төлсөн татвар-8,983,934 төгрөг
Нийт зардал	Нэг автомашины үнэ 89,839,340 төгрөг Татвар 4,491,967 төгрөг Нийт-94,331,307 төгрөг	Нэг автомашины үнэ 89,839,340 төгрөг Татвар 4,491,967 төгрөг Нийт-94,331,307 төгрөг	188,662,614 төгрөг
Хохирол	5,668,693 төгрөг	5,668,693 төгрөг	11,337,386 төгрөг

Хохирлын тооцоо гаргасан: Мөрдөгч, комиссар Б.Бат

ЭРҮҮГИЙН 170000000 ДУГААРТАЙ ХЭРГИЙН ХОХИРЛЫН ТООЦОО
/2016 ОН/

2020 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

	1	2	Нийт
Нийт төсөв	340 сая төгрөг. Ой хээрийн түймэр унтраах зориулалттай автомашин /Hyundai Porter/		2 ширхэг автомашин
Нэг автомашин нийлүүлэх үнэ	170 сая төгрөг	170 сая төгрөг	340 сая төгрөг
Нэг автомашины нийлүүлсэн үнэ	Ханш 1.76 төгрөг 60 сая вон =105,600,000 төгрөг	Ханш 1.76 төгрөг 60 сая вон =105,600,000 төгрөг	211,200,000 төгрөг
Тээвэрлэлтийн зардал	2,329,932.5 вон 4,100,680.32 төгрөг	2,329,932.5 вон 4,100,680.32 төгрөг	8,201,360.64 төгрөг
Татвараас чөлөөлсөн байдал	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгт нэг автомашины үнийг 10 сая вон гэж мэдүүлсэн боловч гаалийн байцаагч 12,329,932,5 воноор буюу 21,700, 681.20 төгрөгөөр үнэлж татвар тооцсон байна. Нэмэгдсэн өртгийн татвар 10 хувь буюу 2,170,068.12 төгрөг чөлөөлсөн. Гаалийн татвар 5 хувь буюу 1,085,034.06 төгрөг төлсөн	Нэмэгдсэн өртгийн татвар 10 хувь буюу 2,170,068.12 төгрөг чөлөөлсөн Гаалийн татвар 5 хувь буюу 1,085,034.06 төгрөг төлсөн	Чөлөөлсөн татвар-4,340,136,24 төгрөг Төлсөн татвар-2,170,068.12 төгрөг Татвараас зайлс-хийсэн -10,560,000
Нийт зардал	Нэг автомашины үнэ 109,700,680.32 төгрөг Татвар 1,085,034.06 төгрөг Нийт-110,785,714.38 төгрөг	Нэг автомашины үнэ 109,700,680.32 төгрөг Татвар 1,085,034.06 төгрөг Нийт-110,785,714.38 төгрөг	211,571,428.76 төгрөг
Хохирол	59,214,285.62 төгрөг	59,214,285.62 төгрөг	118.428.571.24 төгрөг

Хохирлын тооцоо гаргасан: Мөрдөгч, комиссар Б.Бат

2.5. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүндэвтэр, хүнд гэмтэл буюу хохирол учирсныг Шүүхийн шинжилгээний байгууллагаар гаргуулж тогтоолгоно. (Эд хөрөнгийн хохирлыг хор уршигт тооцон шийдвэрлэж байх талаар

УДШ-ын тогтоол гарсан байна)

Гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд учирсан хохирлын эмчилгээтэй холбоотой зардал, тээврийн хэрэгсэлд тогтоогдсон эвдрэл, түүний засварлахад гарсан зардал, хөдөлмөрийн цалин хөлстэй холбоотой гэх мэт бусад төлбөрийг гэмт хэргийн хор уршигт тооцно.

Жишээ нь: Гадаад улсын иргэн С нь 2018 оны 11 дүгээр сарын 20-ноос 21-нд шилжих шөнө Төв аймгийн Сэргэлэн сумын Хайрхан 2 дугаар багийн нутагт Улаанбаатараас Өмнөговь явах чиглэлийн асфальтан замын 201/71 дүгээр шонгийн ойролцоо “Тоёота ланд круйзер-200” маркийн 04-38 УБЕ улсын дугаартай тээврийн хэрэгсэл жолоодож явах үедээ Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт буюу Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 10.12. өөдөөс яваа тээврийн хэрэгсэлтэй зөрж өнгөрөхөд хүндрэлтэй буюу боломжгүй байвал саадыг тойрон гарах тээврийн хэрэгслийн жолооч зам тавьж өгнө. 12.2.Харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд жолооч өөрийн үзэгдэх хүрээн дотор тээврийн хэрэгслээ зогсоох боломжтой хурдыг сонгож явна. 12.3.Жолооч хөдөлгөөнд аюул, саад тулгарахыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна. 18.3. хэрэв жолоочийн нүд гялбах зорчих баримжаа алдвал дохионы гэрлээ асааж, эзэлж явсан эгнээгээ өөрчлөхгүйгээр хурдаа хасаж буюу зогсоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж М.Фусо маркийн 75-37 ӨМӨ улсын дугаартай тээврийн хэрэгслийн араас мөргөж зам тээврийн осол гаргасны улмаас Ж нас барж, Б, Д нарын эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэмт хэргийн улмаас 1 хүний амь нас хохирч, 2 хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан байна.

2.6. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн хохирол, хор уршгийн тооцоолол

Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулж, халдагдсан газар, газрын хэвлий байх бөгөөд хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.

Гэмт хэргийн улмаас байгаль орчны нөхөн сэргээхтэй холбоотой зардал нь хор уршигт тооцохоор байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Эрүүгийн хууль. 2015 он
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2015
3. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн хуулийн тусгай ангийн тайлбар. 2023 он
4. www.shuukh.mn
5. Улсын дээд шүүхийн тайлбар. 2009 он

БҮЛЭГ 8. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ХИЙХ

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ХӨТЛӨН ЯВУУЛЖ БУЙ СУБЪЕКТҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ЭРХ, ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ БУЮУ ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ.

1.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид, тэдний эрх зүйн байдлын талаарх ойлголт, нийтлэг болон ялгаатай эрх хэмжээ, онцлог шинж;
1.2 Нотлох баримтын хууль ёсны байдал, хүрэлцээтэй хангалттай эсэх;
1.3 Үйл баримтын талаарх ойлголт;

СЭДЭВ 2. ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ШИЙДВЭР ГАРГАХ ДАДАЛ, ЧАДВАР.

2.1 Хууль хэрэглээ, нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар үнэлж, дүгнэх;
2.2 Тохиолдол шинжлэх, түүнийг шийдвэрлэсэн сайн жишээ
2.3 Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн алдаа буюу хууль хэрэглээний зарим алдаа зөрчлийн талаар

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ХӨТЛӨН ЯВУУЛЖ БУЙ СУБЪЕКТҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ЭРХ, ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ БУЮУ ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ

Зорилго. Хууль зүйн дүгнэлт хийх ерөнхий сэдвийн хүрээнд прокурорууд та бүхэнд хүний эрхийг хамгаалах, халдашгүй байдлыг зөрчихгүйгээр аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцын заалтыг хэлбэрэлтгүйгээр хангаж, энэ шалгуураараа Монгол Улсын Үндсэн хуульд даяар олноо зарлан тунхагласан “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх” зарчимд нийцэж байдаг талаар болон тэр дундаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд зааснаар хүний халдашгүй байх, эд хөрөнгөө захиран зарцуулах, чөлөөтэй зорчих гэх мэт зарим халдашгүй эрхэд халдах боломжийг төрийн албан хаагчдад олгож байдгаараа онцлог тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ “хууль ёсны байх” зарчимд нийцэж байгаагаас хүний эрхийг зөрчихгүй байх хэмжүүр тодорхойлогдох талаар дэлгэрүүлэн ойлголт өгөхийг зорьсон болно.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгавар болгоход чиглэсэн шүүгч, прокурор, мөрдөгчийн шийдвэрүүд нь ямагт хүний эрхийг хязгаарлах, хүний эрхийг хязгаарласан шийдвэрийг зогсоох, эсхүл зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэж байдгаараа хууль ёсны, үндэслэл бүхий байх шаардлагад нийцэх учиртай тул тэр дундаа прокурорын шийдвэрийн жишээн дээр аливаа шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтад хийсэн дүгнэлт, харьцуулалт, хууль тогтоомжийн агуулгыг тайлбарласан байдал, шийдвэр бүхэлдээ эргэлзээгүй, ойлгомжтой тодорхой байх хэмжүүрийг нэг мөр ойлгон хэрэглэхэд дөхөм болгох үүднээс сэдвийн хэрэгцээг тодорхойлж байна.

2015 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн агуулга, мөн чанар, ялангуяа хууль хэрэглээний асуудалд мэргэжлийн үүднээс хандах, хүний эрхийг зөрчихгүй байх, нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах ажиллагаа, түүний үр дүнд бий болсон баримтат мэдээлэл буюу нотлох баримтыг үнэлж, зөв дүгнэлт хийх чадвар эзэмшихэд оршино.

1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид, тэдний эрх зүйн байдлын талаарх ойлголт, нийтлэг болон ялгаатай эрх хэмжээ, онцлог шинжийн тухай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлж буй субъектүүд (хүн-албан тушаалтан)-ын үйл ажиллагаа, эрх үүргийн хэрэгжилт нь хууль ёсны байж гэмээнэ үр дүнд нь бий болж буй нотлох баримт, шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй бөгөөд хүчин төгөлдөр байх шаардлагыг хангах суурь болж байх учиртай.

МУИС-ийн багш, доктор Д.Баярсайханы “Эрүүгийн процессын эрх зүй” сэдэвт бүтээлд: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүрэг гэдэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах үндсэн чиглэл бөгөөд энэ нь тухайн процессын үе шатанд ямар ажил, үүрэг хамаарагдах эсэх асуудалтай ихээхэн холбоотой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүрэг нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх болон оролцогчдын эрх үүрэг, үйл ажиллагааны зорилго, чиглэлээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл ЭХХШ ажиллагааны оролцогч болон уг үйл ажиллагааг эрхлэн явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуулийн хүрээнд явуулах ажиллагааны ерөнхий чиглэл гэж үзэж болохоос гадна эрх зүйн процессын шалгуур, үе шатны онцлог шинжээр нь:

А. Нийтлэг чиг үүрэг;
Б. Тодорхой чиг үүрэг;
В. Тусгайлсан чиг үүрэг гэж ангилан ялгаж болно.

А. Нийтлэг чиг үүрэг нь эрүүгийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн ерөнхий чиг үүрэг юм.

Б. Тодорхой чиг үүрэг: а) Шүүхээс өмнөх шатны чиг үүрэг, б) шүүхийн шатны чиг үүрэг гэж ангилж болох бөгөөд энэ нь тодорхой процессын агуулгаар нь авч үзвэл:

1. Хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг
2. Өмгөөлөх чиг үүрэг
3. Яллах чиг үүрэг
4. Хэргийг шийдвэрлэх чиг үүрэг гэж ангилдаг.[1] гэжээ.

Товчхондоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг **эрхлэн явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтны** эрх зүйн байдал, чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэх тухай асуудал юм.

Үндсэн сэдэв маань “Хууль зүйн дүгнэлт” учраас эдгээр субъектүүд ямар чиг үүргийг хэрэгжүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцсон бэ эгдгийг шийдвэр гаргахдаа хэрхэн үнэлж дүгнэж буй асуудал сэдвийн гол нь болох юм.

Иймд дараах дэд сэдвийн хүрээнд асуудлыг авч үзье.

1. Мөрдөгчийн үйл ажиллагаа
2. Прокурорын үйл ажиллагаа,
3. Өмгөөлөгчийн үйл ажиллагаа
4. Шүүгчийн үйл ажиллагаа

Мөрдөгчийн үйл ажиллагаа:

Ерөнхийдөө мөрдөгчийн үйл ажиллагаа нь шүүхээс өмнөх шатны чиг үүрэгт хамаарах эрх, үүрэг, мөн нотлох баримт цуглуулах, зарим талаар эрх хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааны нийлбэр цогц бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

[1] Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Улаанбаатар хот. 2020 он. 59-60 дахь талд.

тухай хуулийн 1-32 хүртэлх бүлгүүдэд заасан хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэсэн 2 дэд хэсэг бүхий мөрдөн шалгах олон төрлийн ажиллагаа
- түүнийг хэрэгжүүлж буй байгууллагын харьяалал,
- мөрдөгчийн эрх хэмжээнд нийцсэн эсэх гэсэн хүрээ, хязгаарт дүгнэлт хийх хэрэгцээ бий болох юм.

Прокурорын үйл ажиллагаа:

Энэ нь хянах, шийдвэрлэх, мөрдөн байцаалтын онцгой ажиллагаа гэсэн 3 хэлбэрээр явагдах үйл ажиллагаануудын нийлбэр цогц юм.

Өмгөөлөгчийн үйл ажиллагаа:

Өмгөөлөгч өөрөө нотлох баримт бүрдүүлэх төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд оролцохгүй боловч хүсэлт гаргах замаар нотлох баримт гарган өгч хавтаст хэрэгт хавсаргуулах, хүсэлт, гомдол гаргах замаар мөрдөгч, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт шууд бусаар оролцож байдаг өвөрмөц онцлог бүхий хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөтлөн явуулагч субъект юм.

Шүүгчийн үйл ажиллагаа:

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33-40 дүгээр бүлэг бүхэлдээ хамааралтай, хэлэлцүүлэг, хуралдаан гэсэн 2 үндсэн төрлөөр явагдах үйл ажиллагаа юм.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол онцлог нь шүүгч дангаараа ямар ч үйл ажиллагаа явуулдаггүй, харин талууд, оролцогчдыг байлцуулж, тэдний санал, дүгнэлт, байр суурийг шүүх үнэлж, дүгнэх замаар хэрэгждэг явдал болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, бусад оролцогчид тэдний эрх зүйн байдлын талаар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар оролцогч» гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг ойлгоно. «Бусад оролцогч» гэж гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг ойлгоно.[2]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид:

- Яллагдагч,
- Хохирогч,
- Иргэний нэхэмжлэгч,
- Иргэний хариуцагч болон

Бусад оролцогчид:

- Шинжээч
- Мэргэжилтэн
- Орчуулагч
- Хэлмэрч
- Гэрч
- Хөндлөнгийн гэрч

Хууль ёсны төлөөлөгч нар нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан хэрэгжүүлэхгүй тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7-9 дүгээр бүлэгт заасан эрх зүйн байдалтайгаар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог.

[2] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2017 он

1.2. Нотлох баримтын хууль ёсны байдал, хүрэлцээтэй хангалттай эсэх

Сэдвийн зорилго. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд бий болж буй баримтат мэдээлэл, түүний агуулга, нотлох чадвар, нотолгооны ач холбогдол, нотлох баримтыг хэрхэн үнэлэх, шийдвэрийн үндэслэл болгох шалгуурын талаар танин мэдүүлэхэд оршино.

Нотлох ажиллагаа гэдэг нь хянан шийдвэрлэж буй хэрэгт хамааралтай болж өнгөрсөн үйл явдлыг нотлох баримтад тулгуурлан хуульд заасан үндэслэл, журмын дагуу сэргээн дүрсэлж, бодит үнэнийг тогтоох танин мэдэхүйн үйл явц.[3] бол, нотлох ажиллагааны үр дүн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээлэл” юм.

Баримтат мэдээлэл буюу нотлох баримт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт заасан нийтлэг шаардлагад бүхэлд нь нийцсэн байх учиртай боловч, тэр дундаа “нотлох баримт”-д тавигдах мөн хуулийн 16.1 дүгээр зүйлд заасан “тусгайлсан шаардлага-д нийцсэн байх ёстой.

Нотлох баримтыг үнэлэх нь нотлох баримтын хүрэлцээ, хангалттай байдал, хамаарал, уялдаа холбоо, тэдгээрийн эх сурвалжийг магадлан, нотлох баримт бүрд илэрсэн нөхцөл байдал, агуулгыг харьцуулан шинжлэн судалж, хэргийн бодит байдал болон шийдвэр гаргахад хангалттай эсэхийг тогтоох оюун санаа, логик үйл ажиллагаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийн бодит байдлыг тогтоох зарчмыг тодорхойлсон ба мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээ авч, яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоож, нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалган хянаж, шүүх талуудын мэтгэлцээний үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй.

Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтуудын нийлбэрт тулгуурлан хууль, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр нотлох баримтыг үнэлж, хэргийн үйл баримтыг бодит байдалд нийцүүлэн сэргээн тогтоох хуулийн зохицуулалттай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд нотлох баримтыг үнэлэх бөгөөд аль ч шатанд хуульд заасан нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, нотлох баримтаар тооцохгүй байх үндэслэл, журмыг баримтлан шийдвэрлэдэг.

Нотлох баримтыг үнэлэхдээ үйл явдлын мэдээлэл, түүний агуулга болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулсан, бэхжүүлсэн байдал, арга хэлбэр, эх сурвалжийг магадлан нэгдмэл байдлаар цогцоор нь тодорхойлдог. Харин хуульд заасан үндэслэл, журам зөрчиж цуглуулсан, бэхжүүлсэн баримт, мэдээлэл болон эх сурвалж нь тодорхой бус баримт, мэдээллийг нотлох баримтаар тооцож, түүнд агуулсан мэдээллийг бусад нотлох баримттай харьцуулж дүгнэх нь хэргийг бодит байдлыг тогтооход сөрөг үр дагавартай юм.

Мөн хавтаст хэрэгт авагдсан ямар ч нотлох баримт дангаараа хэргийн үйл баримтыг урьдчилан тодорхойлон нотолж чадахгүй, бусад нотлох баримтаас давуу чанарыг илэрхийлдэггүй бөгөөд нотлох баримт, түүнд агуулагдсан үйл явдал, мэдээлэл, нөхцөл байдлын аль нэгийг үнэлэхгүй орхигдуулах, үл тоомсорлох, эх сурвалж, харилцаа хамаарлыг шалгахгүй байх нь хэргийн үйл баримтыг сэргээн

[3] Б.Батзориг, Б.Туяа “Нотолгооны онол, арга зүй” сургалтын гарын авлага 2008 он

тогтооход хүндрэл учруулдаг.

Нотлох баримтыг хууль, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр үнэлэх гэдэг нь дан ганц өөрийн дотоод итгэл, хууль хэрэглээний практик, хууль хэрэглэх ур чадвар, дадал туршлагад тулгуурласан итгэл үнэмшлийг илэрхийлэхгүй бөгөөд хууль тогтоомжийг чанд сахиж, эрх зүйн онолд нийцүүлэн нотлох баримтыг үнэлэх ур чадвар, мэргэшилтэй холбоотой ойлголт юм. Тодруулбал, нотлох баримтыг үнэлэх субъектийн хараат бус, бие даасан байдлыг хангаж, баталгаажуулсан эрх зүйн зохицуулалтын илэрхийлэл гэж үзэхээр байна.

Нотлох бариmтын хүрэлцээтэй байдал:

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд дурдсан тухайн үйл явдал, нөхцөл байдал болон хэргийн үйл баримтыг сэргээн тогтооход шаардлагатай нотлох баримтын хэмжээ, хязгаарыг тодорхойлон, нэг бүрчлэн шалган тогтоож, цуглуулсан нотлох баримтуудыг нэгтгэн дүгнэх ажиллагааг илэрхийлдэг.

Нотлох баримтын хүрэлцээг (нотлох баримтын хэмжээ, хязгаар) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүхээс тогтоох бөгөөд нотлох баримтын хүрэлцээтэй байдлыг бүрдүүлэх нь гэмт үйл явдал, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон байдал, арга хэлбэрийг сэргээн дүрслэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Гэмт хэргийн үйл явдлыг бүрэн шалгах нь хэргийн үйл баримтыг зөв ангилж, үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай бүх нөхцөл байдлыг бүрэн, бодитой тогтооход ач холбогдолтой. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацааг зөв тогтоох нь гэмт үйл явдлын эхлэл, төгсгөлийг тодорхойлохоос гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцох, Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдах эсэхийг шийдвэрлэх, бусад гэмт хэргийг үйлдсэн эсэхийг нотлох, үгүйсгэх нөхцөлийг бүрдүүлдэг онцлогтой.

- Жишээ: Б.Б нь арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй О.Х-г хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орж хүчиндсэн хэрэгт шинжээчийн *“...хохирогчийн охин хальс бүтэн, мөн дотоожноос илэрсэн эр бэлгийн эс Б.Б-ын ДНХ-тэй тохирохгүй байна”* гэсэн дүгнэлтээр хязгаарлаж, хохирогчийн охин хальс нь бэлгийн харьцаанд орсон тохиолдолд урагдахгүй байх боломж бий эсэх, ДНХ бүтэц нь өөрчлөгдөх тохиолдол байдаг эсэх, хэргийн газраас хураан авсан дотоожийг шүүх шинжилгээний байгууллагад хүргүүлсэн ажиллагаа нь холбогдох журмын дагуу явагдсан эсэхийг шалгаж тодруулаагүйн улмаас хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Нотлох бариmтын хангалттай байдал:

Нотлох баримтыг олж авах, цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэх, түүнд агуулагдах мэдээлэл, үйл баримтын эх сурвалж нь тодорхой эсэх, хэргийн үйл баримтыг нэг бүрчлэн, бүрэн сэргээн тогтоох нөхцөл бүрдсэн эсэхэд бүхэлд нь дүгнэх ойлголт юм. Тодруулбал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэх, нотлох баримтын эх сурвалж, мэдээллийн агуулгын хангалттай байдлыг судалж, хүлээн зөвшөөрсөн нотлох баримтуудыг тодорхойлох бөгөөд тэдгээрийг харьцуулан, хэргийн үйл баримтыг сэргээн тогтоох ажиллагааг илэрхийлдэг.

Нотлох баримт бүрд дүн шинжилгээ хийх, бусад нотлох баримтуудтай харьцуулах, үүнтэй холбогдуулан нотлох баримтыг баталгаажуулсан, үгүйсгэсэн нэмэлт нотлох баримтыг олж авахад чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа хийлгүүлэх зэрэг арга хэлбэрээр хийгддэг цогц ажиллагаа юм.

– Жишээ: М.Д нь зочид буудлын 1 давхрын ресторан үүдний заалны хэсэгт

“..эхнэр Н-ын гараас татаж, хүзүүнээс зуурч, хамт буудал оръё гэж татаж чангаалаа...” гэх шалтгаанаар хохирогч Б.Б-тай хэрүүл маргаан үүсгэж, улмаар түүнийг цохиж биед нь хөнгөн хохирол санаатай учруулсан хэрэгт хэрэг үйлдэгдэх цаг хугацаанд байсан гэрч А.Б нь мөрдөн байцаалтын шатанд “...М.Д нь хохирогч Б.Б-г цохисныг харсан...” гэж мэдүүлсэн атлаа шүүхийн хэлэлцүүлэгт *“...Маргаан болохын хувьд болсон, гэхдээ М.Д нь Б.Б-г цохисон эсэхийг мэдэхгүй, хараагүй...”* гэж мэдүүлжээ. Гэрч А.Б-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгийг бусад нотлох баримтуудаар давхар нотлоогүйн улмаас хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Нотлох бариmтын харилцаа хамаарал:

Нотлох баримтын хамаарал гэдэг нь хуульд заасан эх сурвалжаас олж авсан аливаа мэдээлэл нь тухайн эрүүгийн хэрэгт хамааралтай, хүлээн зөвшөөрөгдөх шинж чанартай, түүнд агуулагдсан үйл явдал, мэдээлэл, нөхцөл байдал болон бусад нотлох баримтын мэдээлэл, өгөгдөл хоорондын уялдаа холбоо, гинжин хэлхээг илэрхийлнэ.

Нотлох баримтын хамаарлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд үнэлдэг. Хамааралтай байдлыг үнэлэхийн тулд нэг нотлох баримтаар тогтоогдсон үйл явдал, мэдээлэл, нөхцөл байдал нь бусад нотлох баримтаар баталгаажсан, эсхүл үгүйсгэгдсэн эсэх, мөн мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан сэргээн дүрсэлж, хэргийн үйл баримтын талаарх хувилбар болон зайлшгүй шалгаж тогтоох үйл явдал, нөхцөл байдал хоорондын хамаарал, уялдаа холбоог тодорхойлох шаардлагатай.

Нотлох баримт хууль ёсны байх шалгуур:

Нотлох баримт хууль ёсны, хүчин төгөлдөр байх гэдгийн шалгуурыг прокурор тодорхойлохдоо дараах асуудалд анхаарлаа хандуулж заавал шалгаж үнэлэх нь зүйтэй. Үүнд:

-Тухайн нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь хуулиар эрх олгогдсон уу?

– Жишээ: Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчөөс мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хавтаст хэрэгт Баян-Өлгий аймгийн харьяалалтай боловч Ховд аймагт отроор нүүдэллэн түр оршин сууж буй гэрчээс мэдүүлэг авах ажиллагааг мөрдөгч, прокурорын өөр орон нутагт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэх даалгаваргүйгээр Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын хэсгийн төлөөлөгч гүйцэтгэсэн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь зөв байсан уу?

-Нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдсан уу? Эсхүл зөрчилтэй ажиллагаа байсан уу?

– Жишээ: Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд “...бариул хэсэг нь 10 см, ажлын хэсэг нь 23 см хутга ширээний зүүн талд байлаа.” гэсэн өгүүлбэр дурдсан боловч түүнийг хураасан талаар үзлэгийн тэмдэглэлд дурдагдаагүй, хэн, хаанаас, ямар аргаар, хэзээ хураан авсан нь тодорхойгүй, “Эд мөрийн баримтыг хураан авч хавтаст хэрэгт хавсаргах тогтоол” үйлдээгүй боловч шинжилгээ хийлгэх мөрдөгчийн тогтоолтой, мөр судлалын шинжилгээ хийж, яллагдагчийн гарын хурууны хээ илэрсэн тухай шинжээчийн дүгнэлтэд дурдагдсан хутга хавтаст хэргийн хамт прокурорт шилжиж ирсэн тохиолдолд энэ нь хүчин төгөлдөр нотлох баримт болох эсэх?

-Нотлох баримт нь жинхэнэ үү?

Тухайн бичгийн болон бусад нотлох баримт нь жинхэнэ эсэх нь хэргийн үйл баримтыг нотлоход чухал ач холбогдолтой. Эд мөрийн баримт нь тухайн эх сурвалжаас авсан жинхэнэ нь мөн эсэх, санаатай болон санамсаргүй байдлаар солигдсон эсэх, анхны эх хэлбэрээрээ байгаа эсэхийг үнэлэх ёстой.

- Жишээ 1: Гэрч Э-ээс мэдүүлэг аваагүй талаар яллагдагчийн өмгөөлөгч гомдол гаргасан атал гэрч Э-ээс мэдүүлэг авсан тэмдэглэл хавтаст хэрэгт хавсаргагдсан бол хэрхэн үнэлэх?
- Жишээ 2: Гэрч А, гэрч Б нарын мэдүүлгийн тэмдэглэлүүдэд үг үсэг, цэг таслал, утга агуулгын хувьд хувьд зөрүүгүй болох нь нүднээ илт харагдаж байгаа тохиолдолд, 2 өөр хүний мэдүүлгийн хэлбэр, агуулгын хувьд өчүүхэн ч зөрүүгүй байдлыг прокурор хэрхэн үнэлэх?
- Жишээ 3: Шүүх хуралдааны Эд мөрийн баримтыг шинжлэн судлах үед эд мөрийн баримтаар хураагдсан модыг харуулж, "...хүний толгой руу цохисон мод мөн эсэх"-ийг тодруулахад, яллагдагч: "миний хэрэглэсэн мод биш, мөрдөгч модоо аваад ир гэхээр нь түлээн дотроос сугалаад авч ирж өгсөн мод байна" гэсэн.

-Нотлох баримт хүчин төгөлдөр эсэх:

Зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу бүрдүүлж цуглуулсан, нотлох баримт хүчин төгөлдөр, харин түүнийг цуглуулах, бэхжүүлэх явцад хэрэглэсэн арга, үйлдэл, үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлсэн албан тушаалтан нь эрх, үүргийн зөрчилтэй байсан гэх мэтээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, журмыг зөрчсөн бол нотлох баримт нь хүчин төгөлдөр байдлаа алдана.

Нотлох баримт хүчин төгөлдөр байх шаардлагад нийцэхгүй тохиолдолд түүнийг шийдвэрт хэрхэн тусгах, дүгнэх нь шүүгч, прокурорын эрх хэмжээний асуудал байдаг.

Прокурорын хувьд хүчин төгөлдөр нотлох баримтын шаардлага хангахгүй байгаа шалтгааныг дурдах, яллах, цагаатгах үндэслэл болгоогүй талаараа өөрийн шийдвэрт дурдах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг бол шүүхийн хувьд нэгдүгээрт: шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шүүхэд хэлэлцүүлэх нотлох баримтын жагсаалтаас хасах, хоёрдугаарт: шүүхээс гарах эцсийн шийдвэртээ тухайн нотлох баримтыг хууль зөрчсөн, эсхүл нотлох баримтын шаардлага хангаагүй, эсхүл шүүх хуралдаанаар хэлэлцүүлээгүй талаар дүгнэлт хийж, шийдвэрийн үндэслэл болгоогүй болохыг дурдаж шийдвэрлэх боломжтой байдаг.

Эдгээр шалгууруар нотлох баримтын хууль ёсны байх шаардлага үнэлэгдэнэ.

1.3 Үйл баримтын талаарх ойлголт

Сэдвийн зорилго. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд цугларсан нотлох баримтуудаар сэргээн дүрслэгдэж буй дүр зураг буюу үйл баримтын талаар танин мэдүүлэхэд оршино.

Үйл баримтын тодорхойлолт: Товчхондоо нотлох баримтаар юуг илэрхийлж, юуг тодорхойлж буй талаар хуульч өөрт хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу өөрийн дотоод итгэлээр сэргээн дүрсэлж буй сэтгэлгээний үйл явц юм.

Хамгийн гол хуулиар тавигдах шаардлага бол хуульч субъектив хандлагатай байхыг шууд хориглоно. Нөгөө талаас таамаглалд тулгуурлаж болохгүй.

Байгалийн үзэгдэл, хүний хүчний үйлчлэл буюу үйлдэл, эс үйлдэхүйн шинж байдлыг сэргээн дүрслэх, төсөөлөх замаар хууль зүйн фактыг тодорхойлно.

Үйл баримтыг сэргээн дүрслэх нь нэгэнт тархи, сэтгэлгээний үйл явц учраас энэ

хэсэгт сэргээн дүрслэгдэж буй үйл явдал, үзэгдлийн шинж байдал, мөн чанарыг тодорхойлохыг эрхэм болгохоос тэр үйл явдал нь гэмт хэрэг мөн эсэх талаар дүгнэхгүй. Учир нь энэ нь 4 дэх сэдэвт хамаарах юм. Үйл баримтын талаарх ойлголтыг өөртөө төлөвшүүлэх үүднээс дараах асуултуудад хариулт өгөх байдлаар мэдлэгийн хүрээг тэлнэ үү.

Шигтгээ 3.1	Үйл баримтыг сэргээн дүрслэх ойлголтын асуулт:

- Үйл баримт нь байгалийн үзэгдэл үү, хүний үйлдэл, эс үйлдэхүй юу?
- Үйлдэл, эс үйлдэхүйг хэн, хэзээ, хаана, ямар арга, хэлбэрээр бий болгосон болох?
- Үйлдэл эс үйлдэхүйн улмаас ямар үр дагавар, хохирол, хор уршгийг бий болгов?
- Үйлдэл, эс үйлдэхүй, бий болсон үр дагаварт шалтгаант холбоо байна уу?
- Үйл баримтын эхэлсэн, дууссан цаг
- Хууль эрх зүйн ухамсрыг удирдлага болгон, үйл баримтыг бүхэлд нь сэргээн дүрсэлж, тодорхойлсон байх

2.1 Хууль хэрэглээ, нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар үнэлж, дүгнэх

Сэдвийн зорилго. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар сэргээн дүрслэгдсэн үйл баримт нь гэмт хэрэг мөн эсэхийг хууль хэрэглэж, нэгтгэн дүгнэх талаар танин мэдүүлэхэд оршино.

Нотлох баримт харьцуулан шинжлэн судалж, нотлогдсон үйл баримтын хэмжээнд үнэлэх, дүгнэх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, хууль ёсны байх, бодит байдлыг тогтоох зарчмыг нэг мөр хэрэгжүүлэх, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд талуудын мэтгэлцэх, тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлдэг.

Өмнөх сэдвүүдийн хүрээнд бид 3 зүйлд анхаарал хандуулсныг сэргээн саная. Эдгээр нь:

- Хянан шийдвэрлэх ажиллагааг хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан хуульд заасан үйл ажиллагаа явуулж цуглуулсан уу?
- Дээрх ажиллагааны үр дүнд бий болсон баримтат мэдээлэл хууль ёсны, хүчин төгөлдөр мөн үү?
- Нотлогдсон үйл баримтыг сэргээн дүрслэх үр дүнд хүрсэн үе шат юм.

Харин энэ сэдвийн хүрээнд нотлох баримт, нотлогдсон үйл баримт, хууль тогтоомжийн хэрэглээний талаарх “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа”-ны талаар авч үзнэ.

Хууль зүйн зохицуулалтууд:

Нөхцөл байдлыг нэгтгэн, хууль зүйн агуулгаар үнэлж дүгнэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлд “...хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана.” гэсэн бий.

Харин хууль зүйн дүгнэлт хийх, шийдвэр гаргахад хамааралтай нийтлэг хэм хэмжээг мөн хуулийн 16.2 дугаар зүйлд “Нотолбол зохих байдал” гэсэн нэртэйгээр

томьёолсон.

Хэдийгээр шүүхийн шийдвэрийн үндэслэлд тавигдах тусгайлсан хэм хэмжээ боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 2 дахь заалтад дурдсан:

“2.1.гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, хугацаа, арга, гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээ, шинжийг тогтоосон хэргийн талаарх нөхцөл байдал;

2.2.шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэргийг шийдвэрлэж байгаа бол шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр;

2.3.шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм бурууташд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох бариmтын агуулга, шүүх тухайн нотлох бариmтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл;

2.4.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт;

2.5.хэд хэдэн шүүгдэгчээс заримыг нь цагаатгасан, эсхүл шүүгдэгчийг яллаж байгаа зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллах нотлох бариmтыг үгүйсгэсэн үндэслэл, тэдгээрийг нотлох бариmтын агуулга” гэсэн шалгуур нь хэрэг хянан шийдвэрлэж буй шийдвэрт тусгавал зохих ихээхэн чухал агуулгуудыг тодорхойлсон байдаг.

2015 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд прокурор шийдвэр гаргахдаа хэрхэн хууль зүйн дүгнэлт хийх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй боловч энэ нь ялангуяа прокурорын голлох шийдвэрүүд болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн:

- 30.14 дүгээр зүйлд заасан “Хэрэг бүртгэлийн хэргийг хаах”,
- 32.5 дугаар зүйлд заасан “Хэргийг хэрэгсэхгүй болгох”,
- 32.10 дугаар зүйлд заасан “Яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх” гэсэн шийдвэрүүдийг гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлд заасан “Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг” гэсний 2 дахь заалтыг харгалзаж болохгүй гэсэн үг биш гэж үздэг.

Хуульчид тавигдах шаардлага:

– Хууль хэрэглээний чадвар
– Логик сэтгэлгээ

Хууль хэрэглээний арга барил:

Прокурорын шийдвэрт хууль зүйн дүгнэлт хийхдээ:

- Үйлдэл, эс үйлдэхүйг хэрхэн гэмт хэрэг үзэж буй үндэслэл юм.

Тухайн үйлдэл үйлдэхүй нь яг хууль, тогтоомжийн ямар тодорхой хэм хэмжээ, эсхүл хэний, ямар эрхийг, хэрхэн зөрчсөний улмаас гэмт хэрэг болж буй бүхий л шинжийг тоочиж дүгнэнэ.

Энэ хүрээнд дараах 3 асуудлыг дүгнэсэн байвал зохино.

А) хууль, дүрэм журам зөрчсөн шалгуур

Б) үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг бус болохыг тодорхойлох шинж

В) Үндсэн шинжид хохирол учрахыг шаардахгүй, эсхүл хохиролтой гэмт хэргийн аль нь болох

- Үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол учирсан нь гэмт хэрэг болох:

Тухайн гэмт хэрэг нь ямар учраас хохирол шаардаж буй болон нэгэнт бий болсон бие махбод, эд хөрөнгийн хохирлын төрөл, хэмжүүр, хэмжээ, сэргээгдэх боломжтой эсэх, эсхүл сэргээгдсэн эсэх.

- Гэмт хэргийн эхлэх, үргэлжлэх, дуусгавар болох цаг хугацаа:

Гэмт хэргийн эхлэл, төгсгөлийн хугацааг зөв тодорхойлсон гэмт хэрэг болж буй тухай үйлдэл , эс үйлдэхүйн шинжийг илүү тодорхой болгохын зэрэгцээ, хөөн хэлэлцэх хугацаа тооцох, ял хариуцлага оногдуулахад харгалзах чухал үзүүлэлт болно.

– Гэмт хэргийн зүйлчлэл
– Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тодорхойлох
– Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэрэглээ
– Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль, тогтоомжийг хэрхэн зөв сонгож хэрэглэх

- Эрүүгийн хууль тогтоомж

Хууль хэрэглээ, нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар үнэлж, дүгнэхийн талаарх ойлголтыг өөртөө төлөвшүүлэх үүднээс дараах асуултуудад хариулт өгөх байдлаар мэдлэгийн хүрээг тэлнэ үү.

Шигтгээ 4.1	Хууль хэрэглээ, нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар үнэлж, дүгнэх сэдвийн хүрээнд асуулт:

- Гэмт хэргийн тодорхойлолтыг дурдана үү?
- Хууль хэрэглээний чадамж хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой эсэхийг тодорхойлно уу?
- Хэрэгцээт хууль, тогтоомжийг ямар эх үүсвэрээс хайх вэ?
- Хэрэгцээт хууль, тогтоомжийг хэрхэн тодорхойлох вэ?
- Хууль хэрэглээнд логик сэтгэлгээ ямар ач холбогдолтой вэ?

2.2. Тохиолдол шинжлэх, түүнийг шийдвэрлэсэн сайн жишээ

Тохиолдол №1

-Г нь өөрийн гэртээ найз А-ийн хамт архи ууж, согтуугаар дуу чимээ ихтэй байсан тул хөршүүдээс нь Цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн.

-Дуудлагаар очсон цагдаагийн албан хаагчид “Г-г А-ийн хамт гэрээс нь авч явж, эрүүлжүүлэх тул хамт явахыг шаардсан. Харин Г нь би өөрийн гэрт байгаа учраас хамт явах шаардлагагүй хэмээн цагдаагийн алба хаагч Ж-тэй маргасан. Ж гэрээс нь авч гарахаар Г-ийн биед хүрэхэд эсэргүүцэн, ноцолдож Ж-ийн албаны хувцсыг урж, гэмтээсэн.

-Мөрдөгчөөс иргэн Г-д “Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн” үндэслэлээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал ирүүлсэн.

Прокурор хэрхэн шийдвэрлэх вэ?

Прокурорын шийдвэрт:

(Нотлогдсон үйл баримтыг хууль зүйн агуулгаар нэгтгэн дүгнэх):

... мөрдөгчийн зүгээс Г- үйлдэлд Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал гаргаж ирүүлсэн боловч мөрдөн шалгах ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл журмын дагуу хураан авч эд мөрийн баримтаар тооцсон цагдаагийн албаа хаагчийн энгэрийн камерын бичлэг, гэрч нарын мэдүүлгээр иргэн Г нь дуудлага, мэдээллийн дагуу очсон цагдаагийн албаа хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн гэж үзэх нөхцөл байдал үгүйсгэгдэж байна.

Учир нь тухайн үед болсон үйл явдлыг баримтжуулсан цагдаагийн албан хаагчийн албаны энгэрийн камерын дуу дүрсний бичлэгээс үзэхэд цагдаагийн албан хаагч ахлагч Ж, Д нар нь дуудлага, мэдээллийн дагуу ... дүүргийн ... дугаар хороо, ... хороллын 8 дугаар байрны 7 тоотод оршин суудаг иргэн Г-ийн гэрт очоод хууль ёсны ямар нэгэн тодорхой шаардлагыг тухайн айлд байсан хэн нэгэнд тавиагүй буюу Цагдаагийн албаны тухай хууль, журмын дагуу ажиллаагүй байна гэж прокурор дүгнэв.

Цагдаагийн албан тухай хуулийн 22 дугаар зүйлд **Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагын талаар заасан байх ба уг зүйлийн 22.1-т “** Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.” , 22.2-т “ Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.”, 22.5-т “ Цагдаагийн алба хаагч, үүргээ гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.”, 22.6-т “Цагдаагийн алба хаагч үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн албан тушаал, цол, нэрийг хэлж, шаардсанаар өөрийн албаны үнэмлэхийг үзүүлнэ.”, 22.9-т “Цагдаагийн алба хаагчийн ажиллагаа тус бүрийн хамрах хүрээ нь тухайн ажиллагааг хэрэгжүүлэх хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдана” гэж заасан байна.

Гэтэл ахлагч Ж, Д нар нь уг хуулийн заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна иргэн Г-ийн орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг авахгүй шууд нэвтэрч, улмаар цагдаагийн байгууллага руу дагаж явах талаар гэртээ байгаа, тодорхой зөрчил гаргаагүй хүнд шаардлага тавьж, хэрүүл маргааны шинжтэй үг хэллэг хэрэглэн, харилцан хэрэлдсэн, ноцолдсон үйлдлийг хууль ёсны шаардлага гэж үзэх үндэслэлгүй болно.

Цагдаагийн албан тухай хуулийн 23 дугаар зүйлд цагдаагийн албан хаагчаас тавих шаардлагын талаар заасан байх ба уг зүйлийн 23.1-т “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно”, 23.2-т “ Нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнийг олон нийтийн газрыг тодорхой хугацаанд орхин явахыг шаардаж болно.”, 23.3-т “ Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах, тээврийн хэрэгсэл,

явган зорчигчийн хөдөлгөөнд учирсан саадыг арилгах зорилгоор хүнийг тодорхой байр, газрыг орхин явахгүй байх, эсхүл өөр газар шилжин байрлахыг шаардаж болно.” гэжээ.

Хавтаст хэрэгт авагдсан хохирогч, гэрч нарын мэдүүлэг, камерын дуу дүрс бүхий бичлэг зэрэг нотлох баримтуудаас үзэхэд цагдаа нарыг дуудлага, мэдээллийн дагуу хэргийн газар очиход 7 тоот айлд илтэд гэмт хэрэг, зөрчил гарсан гэж үзэх нөхцөл байдал бий болоогүй, хэдийгээр Г, Д нар нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байдалтай байсан боловч олон нийтийн газарт байгаагүй, харин гэртээ байсан, хэн нэгний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрах нөхцөл байдлыг үүсгээгүй байжээ.

Энэ тохиолдолд цагдаагийн албан хаагчид нь иргэн Г, Д нарыг заавал цагдаагийн байгууллага руу явах шаардлага тавьж байгааг хууль ёсны шаардлага гэж үзэх боломжгүй байна.

Цагдаагийн албан тухай хуулийн 28 дугаар зүйлд цагдаагийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ бусдын “Орон байр, бусад газарт нэвтрэн орох” үндэслэлийн талаар заасан байх ба уг зүйлийн 28.1-т зааснаар цагдаагийн албан хаагч хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн талаарх гомдол, мэдээллийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах эрхтэй боловч 28.2-т “ Цагдаагийн албан хаагч доор дурдсанаас бусад тохиолдолд бусдын орон байранд оршин суугч, эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр нэвтрэн орохыг хориглосон заалтыг зөрчиж, иргэнээс зөвшөөрөл авалгүй гэрт нь нэвтрэн орох үндэслэл бий болоогүй байхад иргэн Г- ийн гэрт орж болох эсэхийг асуухгүйгээр шууд орсон үйлдлийг “хууль ёсны” гэж прокурор дүгнэх боломжгүй юм

Тохиолдол №2

-Гэрч Н-ийн мэдүүлгээр А-г гэмт хэрэг үйлдсэн хүн мөн эсэхийг таньж олуулах ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны үед гүйцэтгэсэн боловч шүүх хэргийг прокурорт буцаахдаа даалгасан заалтын дагуу дахин мөрдөн байцаалт явуулахдаа таньж олуулах ажиллагааг 2 дахь удаагаа гүйцэтгэсэн.

-Гэрч Б нь тухайн гэмт хэрэг үйлдэгдэх цаг хугацаанд хэргийн газарт байсан хүмүүсийн байршлыг тодорхойлсон мэдүүлэг өгсөн.

-Хохирогчийн биед ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үхэлд хүрэх гэмтэл учирсныг шинжээчийн дүгнэлтээр тодорхойлсон.

-Хохирогчид гэмтэл уруулах боломжтой багаж хэрэгслийг А хэрэглэж байсан үйл баримт мөрдөн шалгах ажиллагаагаар нотлогдсон.

Прокурорын шийдвэрт:

(Нотлох бариmтын шаардлага хангасан, хангаагүй нотлох бариmтыг хэрхэн үнэлж дүгнэх, мөн нотлох бариmтыг хангалттай, хүрэлцээтэй гэж дүгнэх боломж):

... 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гэрч Н-ээр хүн таньж олуулах мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар таньж олох гэж байгаа хүнийг ямар шинж тэмдэг, онцлогоор нь таньж чадахыг урьдчилан асуухад “хамгаалалтын хувцас, малгай өмссөн байсан учраас нүүр, царай нь харагдахгүй байсан ба харин бусдаасаа содон намхан байсан. Бусад алба хаагч нараасаа илтэд намхан алба хаагч байсныг нь анзаарч харсан” гэсэн бөгөөд 6 гэсэн тоон дугаар барьж зогсож байсан эрэгтэйг зааж, дээр хэлсэнчлэн бусдаасаа хамгийн намхан байсан” гэж яллагдагч А-г таньсан байна.

... Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн ... захирамжаар хэргийг прокурорт буцаахдаа “гаднах байдлаараа адил төстэй хоёроос дээш хүний хамтаар таньж олуулах гэж байгаа хүнд харуулна” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэж, зөвтгөх талаар дурджээ.

Гэтэл хүн таньж олуулах ажиллагаа нь цорын ганц удаа явуулдаг онцлог бүхий мөрдөн шалгах тодорхой ажиллагаа бөгөөд тухайн үйл явдал болсон цаг хугацаа, орон зайд албан үүрэг гүйцэтгэж байсан ... дугаар ангийн 6 албан хаагчаас өөр, тухайн түймэр ажиллагаанд оролцоогүй хүнийг, шүүгчийн захирамжид дурдсанчлан “гаднах байдлаараа төстэй 2 буюу түүнээс дээш хүн”-ийг оролцуулах байдлаар гүйцэтгэвэл нотлох баримт цуглуулах ажиллагааны зорилт, хүрээг зөрчинө гэж дүгнэсэн болно. Нөгөөтээгүүр “Хүн таньж олуулах ажиллагаа”-г нэгээс дээш удаа гүйцэтгэх нь танигчаар, танигдаж буй хүний гадаад байдал, онцлог шинжийг нүдлүүлэх үр дагаврыг бий болгож, мөрдөн шалгах ажиллагааны нотлох чадварыг алдагдуулах сөрөг үр дагавартайг харгалзсан болно.

Гэвч хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамжид даалгасанчлан таньж олуулах ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдөр дахин гүйцэтгэсэн боловч прокурорын хувьд 2 дугаар хавтаст хэргийн 187-189 дэх талд байгаа “Таньж олуулах ажиллагааны тэмдэглэл”, хавсаргасан баримтат мэдээллүүдийг яллах болон цагаатгах нотлох баримт болгож, аливаа хууль зүйн дүгнэлт хийгээгүйг дурдаж байна.

Харин 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гүйцэтгэсэн 1 дүгээр хавтаст хэргийн 52-55 дахь талд байгаа “Таньж олуулах ажиллагааны тэмдэглэл”, хавсаргасан баримтат мэдээллүүдийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрдүүлж, цуглуулсан нотлох баримт болгон авч үзэж, уг ажиллагаагаар нотлогдож буй үйл баримтыг (яллагдагч А-ийн үйлдлийг), гэрч Б-ийн 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр өгсөн, 01 дүгээр хавтаст хэргийн 196-197 дэх талд буй “...орилох үед номер 2-т ажиллаж байсан дэд ахлагч А нь Ж бид хоёрын ажиллаж байсан байшингийн доор хаалганы хажууд зогсож байсан ба номер 1-т ажиллаж байсан О байшин дотор ажиллаж байсан” гэсэн мэдүүлгийн тэмдэглэл, мөн шинжээчийн 853 дугаартай дүгнэлттэй харьцуулан үнэлж дүгнэхэд, яллагдагч А гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх үндэслэл батлагдаж, уг үйлдэл нь гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж дүгнэсэн болно.

2.3. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн алдаа буюу хууль хэрэглээний зарим алдаа, зөрчил

Судалгаанаас үзэхэд Шүүхээс Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн болон хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн үндэслэлийг судалж, үр дүн гаргасан байна. Судалгааны дүнгээс үзэхэд:

Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн дараах алдаа зөрчил:

Зөрчил 1:

Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” байдлыг шийдвэрлэхдээ гэмт хэргийн объектив талын шинжийг буруу тогтоох алдааг цөөнгүй гаргаж байна.[4]

Тодруулбал: Гэмт хэрэг үйлдэж амьдралын эх үүсвэрийг бүрдүүлэх нь

[4] https://www.supremecourt.mn/files/20238/0_1695113132.pdf, https://www.supremecourt.mn/files/20236/0_1690534717.pdf, https://www.supremecourt.mn/home?page=advice&id=15&pr=0&tp=list

тогтвортой хугацаанд давтагддаг амьдрал, зан төлөвийн хэвшил ойлголт бөгөөд энэхүү нөхцөл байдлыг тогтоон тодорхойлохдоо гэмт хэрэг үргэлжлүүлэн үйлдсэн хугацаа болон учруулсан хохирлын хэмжээг анхааран үзэх ёстой, өөрөөр хэлбэл, бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор, хууль бус аргаар өөрийн болгож, амар хялбар аргаар ашиг олох боломжийг байнга эрэлхийлж, үүнийг амьжиргаагаа залгуулах бодит эх үүсвэр болгосон харьцангуй тогтвортой үйлдлийн нэгдэл юм. Үйлдлүүдийн тооны хувьд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан “байнга” гэсэн шинжийг хэлбэрийн талаас хангаж буй боловч тэдгээр нь хулгайлсан эд зүйлээ өөрийн болон гэр бүл, бусад хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааны хэрэгцээг хангах үндсэн эх сурвалж болгоогүй, түүнчлэн өөрийн ба тэдгээрийн эрхэлдэг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зэрэг ашиг олох зорилготой үйл ажиллагааны эх үүсвэр, хэрэгсэл болгон ашиглаагүй байх тул хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох “амьжиргааны эх үүсвэр болгосон” гэх шинжээр хүндрүүлэн зүйлчлэх үндэслэлгүй болно.

Зөрчил 2:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дугаар зүйл /Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх/-ийг баримтлан шүүгдэгчид хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхдээ ямар нэг тодорхой үндэслэлд тулгуурлаагүй, энэ талаар огт дүгнэлт хийгээгүй зөрчлүүд байна. Тухайлбал:

“…үйлдсэн хэрэгтээ гэмшиж байгаа, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн” гэж дурдсан боловч тэдний гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн байдал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан эсэх талаар үндэслэл бүхий хууль зүйн дүгнэлт хийхгүй орхигдуулсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүхийн хэлэлцүүлэгт гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тухай мэдүүлэг нь бусад нотлох баримтаар тогтоогдоогүй бол дангаараа шүүгдэгчийг гэм буруутайд тооцох үндэслэл болохгүй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.” гэж заасан бөгөөд хохирогч гэм хорын хохирол нэхэмжлэхээс татгалзсан явдал нь тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн гэж дүгнэх үндэслэл болохгүй.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бодитой нөхөн төлөөгүй байхад анхан шатны шүүхэд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж шийдвэрлүүлэхээр шилжүүлэх нь буруу юм. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэнд тооцогдоно.

Анхан шатны шүүх прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгчийн гэм бурууг хянан хэлэлцэж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хавтаст хэрэгт авагдаж, шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн нотлох баримтуудыг үндэслэн хэргийн үйл баримтыг тогтоож, түүний үйлдсэн хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаарч байгааг зөв тайлбарлан зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэм буруугийн хэлбэр, хэмжээ, хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан торгох ял оногдуулж Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн байна.

Иймд прокурор эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчимд нийцүүлэх, ял болон албадлагын арга хэмжээний зохилдлогоог зөв тооцоолох, нэг гэмт хэрэгт нэг ял оногдуулах зарчимд харшлах үр дагавар үүсгэж болохоор нөхцөл байдал үүсгэхгүй байх, Эрүүгийн хуулийг зөв хэрэглэхэд анхаарах шаардлагатай.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд тодорхой төрлийн ял сонгон оногдуулахын зэрэгцээ үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ давхар хэрэглэсэн тохиолдолд тухайн хүн шүүхээс оногдуулсан ялыг нэгэнт биеэр эдэлсэн, эсхүл биелүүлсний дараагаар албадлагын арга хэмжээг зөрчсөн гэх үндэслэлээр ял оногдуулах эсэх асуудал нь дээр дурдсан эрүүгийн эрх зүйн суурь зарчимтай зөрчил үүсгэхээр байна. Энэхүү агуулгын үүднээс авч үзвэл эрүүгийн хариуцлагын төрөл болох үүрэг хүлээлгэх арга хэмжээг гагцхүү тухайн шүүгдэгчид ял оногдуулалгүйгээр тэнссэн тохиолдолд хэрэглэх, ингэхдээ хэрэгжих хугацааг тэнссэн хугацаатай ижил, эсхүл 19 тэрхүү хугацааны дотор байхаар тооцох ёстой гэж тайлбарлаж хэрэглэх нь Эрүүгийн хуулийн зорилго, түүний нийтлэг зарчмуудад нийцэх болно.

Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага оногдуулах нийтлэг үндэслэл, журам, түүний зорилго, холбогдох хэм хэмжээний агуулгыг буруу тайлбарлаж, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн буюу хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн зөрчил гаргаж байна.[5] Тухайлбал:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйл “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх...”-ийг хэрэглэх үндэслэл бүрдсэн эсэх талаар огт дүгнэлт хийдэггүй, зөвхөн мөн хуулийн 6.5 дугаар зүйл “Эрүүгийн хариуцлага хөнгөрүүлэх нөхцөл байдал”-ийг дурдан ял шийтгэлийг хөнгөрүүлж шийдвэрлүүлэхээр үндэслэл гаргасан нь үндэслэлгүй бөгөөд ямар ч хууль зүйн дүгнэлт хийгээгүй нь гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцсэн, мөн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор багтсан байх хууль ёсны зарчмыг хангахын зэрэгцээ тухайлан сонгон оногдуулж буй ялын төрөл, түүний хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар, хэрэг үйлдэгдсэн тодорхой нөхцөл байдал болон гэмт хэрэгтний хувийн байдалд хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан байхыг шаарддаг. Хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг чанд баримтлан хэрэгжүүлэхдээ, үүнд хамаарах нийтлэг зарчим нэг бүрийн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийн цогц нэгдлийг илэрхийлж чадахуйц дүгнэлт хийсний үндсэн дээр ял оногдуулах санал гаргах нь шударга ёсны зарчмын агуулга, Эрүүгийн хуулийн зорилгод нийцдэг болно.

[5] https://www.supremecourt.mn/files/20231/0_1675246430.pdf

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилэн найруулсан/. 2015 он
3. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. 2017 он
4. Монгол Улсын Ерөнхий прокурорын 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлсан Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар
5. Монгол Улсын Ерөнхий прокурорын 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/66 тоот тушаалаар батлсан Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх аргачилсан заавар
6. ХайнрихШоллер“Хуульзүйндүгнэлтболоншүүхийншийдвэргаргахзаримасуудал” /ХБНГУ-ын хууль зүйн доктор, профессор, МУИС-ийн хүндэт доктор/ 2015 он

Судалгааны материал, эх сурвалж

1. “Прокурорын шийдвэр боловсруулах арга зүй” судалгааны тайлан. Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн. 2023 он

Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээлүүд:

1. Авхиа.Ж, Б.Ганболд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн тайлбар. Улаанбаатар хот, 2002 он
2. Баярсайхан.Д Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ, 2012 он
3. Баярсайхан.Д Эрүүгийн процессын эрх зүй. Улаанбаатар хот. 2020 он
4. Ганболд.Б. ”Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол”. Улаанбаатар хот, 2001 он
5. Жанцан.С.”Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” /Гэмт хэргийн тухай сургаал/. Нэгдүгээр боть. Улаанбаатар хот, 2010 он
6. Нарангэрэл.С. ”Эрх зүйн эх толь бичиг”. Улаанбаатар хот, 2008 он
7. Жанцан.С, Бат-Эрдэнэ.Б, Нямсүрэн.Ч, Ганбат.Ч, Цэрэнбалтав.Б, Доржготов.Б, Батсайхан.Д, Нямжав.С, Дамирансүрэн.М. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Улаанбаатар хот, 2013 он
8. Ганболд.Ч. “Эрүүгийн процесс дахь сэжигтний эрх зүйн байдлын зарим тулгамдсан асуудал”. Улаанбаатар хот, 2020 он
9. Ганболд.Г. “Хууль зүйн дүгнэлт”, Улаанбаатар хот, 2022 он

БҮЛЭГ 9. НОТОЛБОЛ ЗОХИХ БАЙДАЛ, НОТЛОХ БАРИМТЫН ЭХ СУРВАЛЖИЙГ ШАЛГАХ, НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ

СЭДЭВ 1. НОТОЛГОО, НОТЛОХ БАРИМТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН БА НЭМЭЛТ ШИНЖ

1.1. Нотлох баримтын тухай ойлголт
1.2. Нотлох баримтын шинж, тэдгээрийн ангилал, төрөл

СЭДЭВ 2. НОТЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮЕ ШАТ

2.1. Хууль зөрчиж цуглуулсан нотлох баримтыг хэрхэн шийдвэрлэх
2.2. Нотлох баримтын хангалттай хүрэлцээтэй байдал
2.3. Нотлох баримтыг үнэлэх дотоод итгэл

СЭДЭВ 1. НОТОЛГОО, НОТЛОХ БАРИМТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН БА НЭМЭЛТ ШИНЖ

Зорилго. Энэхүү сэдвийн хүрээнд нотлох үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэглэх ур чадвар дээшлүүлэхийн тулд нотолгоо, нотлох баримтын тухай ойлголтын хүрээ, мэдлэгийг тэлэхийн тулд онцлог болон ангиллын талаар авч үзэх болно.

1.1. Нотлох баримтын тухай ойлголт

Гэмт хэрэг нь өнгөрсөн цаг хугацааны үйл явдал байдаг бөгөөд гэмт хэргийн бодит байдлыг шууд тодорхойлох боломжгүй. Харин гэмт хэрэг болж өнгөрсөн газарт тодорхой ул мөр үлдэх тул түүнийг илрүүлж, шинжилж судалсны үндсэн дээр хэргийн бодит нөхцөл байдлыг сэргээн дүрслэх боломжтой. Мөрдөгч, прокурор, шүүгчийн хувьд нотлох баримтад тулгуурлан гэмт хэрэг хэзээ, хаана, хэрхэн, хэн үйлдсэнийг тогтоодог.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримтад тооцохоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан.

Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу- дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бусад баримтаар тогтоогддог.

Аливаа нотлох баримтын агуулга нь нотолбол зохих нөхцөл байдлын талаарх мэдээлэл бөгөөд түүний эх сурвалж нь хүн, биет зүйлс зэрэг хэргийн нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий мэдээлэл тээгч объект байна.

1.2. Нотлох баримтын шинж, тэдгээрийн ангилал, төрөл

Нотлох баримтын шинж чанарыг учир холбогдлын болон зохицол нийцлийн гэж хоёр хэсэгт хуваан авч үзэх боломжтой.

Нотлох баримтын учир холбогдлын шинж нь хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл

байдлыг тогтоох чадварыг хэлнэ. Уг нотлох баримт нь ямар мэдээлэл агуулсан, нотолбол зохих нөхцөл байдалтай хэр зэрэг уялдаж байгаагаар тодорхойлогддог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх нотлох баримтууд учир холбогдлын шинжийг илэрхийлж байдаг.

Нотлох баримтын зохицол нийцлийн шинж нь нотлох баримтыг хуулийн хүрээнд бүрдүүлсэн байхыг ойлгодог. Дараах шалгуурыг хангасан нотлох баримтыг зохицол нийцэлтэйд тооцдог.

- Эрх бүхий субъект цуглуулсан,
- Эх сурвалж нь тодорхой,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрдүүлсэн,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон хэлбэр, агуулгатай,

Дээрх шалгуурыг хангаагүй тохиолдолд тухайн нотлох баримтыг хууль зүйн хүчин чадалгүйд тооцох үндэслэл бүрдэнэ.

Мөрдөгч, прокурор, шүүгч нь нотлох баримтыг агуулга, хэлбэр, эх сурвалж, нотолбол зохих байдалтай уялдаж байгаагаар нь тэдгээрийг ялгаж ангилах нь хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдолтой бөгөөд дараах байдлаар ангилна.

- Шууд ба шууд бус
- Анхдагч ба үүсмэл
- Яллах ба цагаатгах
- Биет зүйлсийн гэж ангилна.

Шууд нотлох баримт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шууд зааж буй мэдээллийг агуулдаг. Тухайлбал гэрч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг таньж шууд заах,

Шууд бус нотлох баримт нь хууль зүйн хувьд бие даасан бус, туслах, эсвэл завсрын шинжийг агуулсан нөхцөл байдлыг заана. Тухайлбал гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдийн явсан чиглэлийг харсан гэрчийн мэдүүлэг, хэргийн газар дээр үлдсэн гарын мөр гэх мэт.

Учир нь гэмт хэрэг гарсан газарт сэжигтэн тохиолдлоор байсан, сэжигтний бие болон хувцас дээрх ул мөр нь хохирогчид тусламж үзүүлэх явцад үүссэн, сэжигтний гарын мөр тухайн гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш үүссэн байх боломжтой байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шууд нотлох баримтгүй тохиолдолд шууд бус нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоож болно.

Жишээлбэл: гэрч С.Батын “ 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 21 цагийн үед Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо 30 дугаар байрны 2 дугаар орцноос гарч ирэхэд хөрш айлын Б.Дорж нь А.Болдыг орцны үүдэнд хутгаар хутгалаад 30 дугаар байрны баруун талаар гүйгээд яваад өгсөн” гэсэн мэдүүлэг нь шууд нотлох баримт болно.

Харин гэрч Б.Баярын “ 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 21 цагийн үед Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо 30 дугаар байрны баруун талд сууж байхад Б.Дорж нь 30 дугаар байрны баруун талаар гүйж байгаад ертөнцийн зүгээр хойшоо гүйгээд явж байсан” гэсэн мэдүүлэг нь шууд бус нотлох баримт юм.

Анхдагч нотлох баримт нь хэргийн нөхцөл байдлын талаарх бодит баримт, мэдээллийг анхны эх сурвалжаас авсан нотлох баримтыг ойлгодог.[1] Гэмт хэрэг үйлдэгдэх үйл явцыг шууд харсан гэрч, хохирогчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, шинжээч, мэргэжилтний дүгнэлт, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийн эх хувь хамаарна.

Харин үүсмэл нотлох баримтын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын хувьд дам сонсож мэдсэн зүйлд түшиглэн өгсөн мэдүүлэг болон гэмт хэргийн биет мөрийн тусгасан хэв, загвар, дардас, баримт бичгийн хуулбар зэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад бүрдүүлсэн нотлох баримтууд хамаарч болно. [1]

Жишээлбэл тухайн хэргийн үйл явцыг хараагүй боловч бусад этгээдээс дам сонссон гэрчийн мэдүүлгийг ойлгож болно.

Яллах нотлох баримт нь гэмт хэргийг илрүүлэх, сэжигтэн болон яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн болохыг нотолсон талаарх баримтууд багтдаг.

Цагаатгах нотлох баримтын хувьд яллагдагчийг гэм буруугүй болохыг нотолсон, оногдуулах ял шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлсэн баримтууд юм.

Биет зүйлсийн нотлох баримтын хувьд гэмт хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдол бүхий эд зүйлс хамаарна. Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад эд зүйлс, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан түүнчлэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх, эсхүл хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлийг тооцдог.

Дээр дурдсан нотлох баримтуудын тусламжтайгаар өнгөрсөн үйл явдлыг бүхэлд нь бус хэсэгчлэн сэргээх боломжтой. Харин хэргийн үйл явдлыг бүхэлд нь сэргээхийн тулд хэрэгт авагдвал зохих баримт сэлтийг бүрэн цуглуулж, тэдгээрийг тал бүрээс нь нягталж шалгасан байх шаардлагатай байдаг тул нотлох баримт дараах шаардлагыг хангасан байвал зохилтой.

➢ *Мэдүүлэгт анхаарах зүйл.*

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1, 25.2, 25.3, 25.4 дүгээр зүйлүүдэд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэх
- Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/66 дугаартай тушаалаар батлагдсан “ Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэх

Тухайлбал:

- Улсын Ерөнхий прокурорын баталсан “Мэдүүлэг авах өрөөний журмын шаардлага хангасан өрөөнд мэдүүлэг авсан эсэх
- Мэдүүлэг өгч буй этгээдэд эрх, үүргийг тайлбарлаж өгсөн эсэх
- Мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг тайлбарласан эсэх
- Гэрч, хохирогч, шинжээч, мэргэжилтэн нарт худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар сануулсан эсэх
- Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд шөнийн цагаар мэдүүлэг авсан эсэх
- Мэдүүлэг авах үед хөтөлж, тулгаж мэдүүлэг авсан эсэх
- Хуульд заасан хугацааны дотор мэдүүлэг авсан эсэх
- Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа үнэн зөв мэдүүлэхийн учрыг тайлбарлаж, түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулсан эсэх

➢ *Эд мөрийн бариmтад анхаарах зүйл:*

- Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйлс мөн эсэх
- Гэмт хэргийн замаар бий болсон мөнгө, эд зүйлс мөн эсэх

[1] Эрүүгийн шалган шийдвэрлэх ажиллагаа УБ, 2020 он 73-р тал

- Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдолтой бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлс мөн эсэх
- ЭХХШтХ-н 24.4 дүгээр зүйлд заасан журмын дагуу эд мөрийн баримтыг хураан авсан эсэх
- Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/66 дугаартай тушаалаар батлагдсан “ Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ын 5.5 дугаар зүйлд заасны дагуу эд мөрийн баримтыг хураан авах ажиллагаа явагдсан эсэх

3. Баримт бичигт анхаарах зүйл:

- Хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдол бүхий баримт бичгийг төрийн байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтнаас албажуулж ирүүлсэн эсэх
- иргэнээс гаргаж өгсөн баримт бичгийг тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргасан эсэх
- ЭХХШтХ-н 24.5 дугаар зүйлд заасны дагуу баримт бичгийг гаргуулан авсан эсэх
- Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/66 дугаартай тушаалаар батлагдсан “Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ын 5.6 дугаар зүйлд заасны дагуу баримт бичгийг гаргуулан авсан эсэх
- Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэгт анхаарах зүйл:
- Шинжилгээг хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу тогтоосон эсэх
- Шинжилгээний арга, аргачлал зохих шаардлага стандарт нийцсэн эсэх
- Шинжээч асуултад бүрэн дүүрэн хариулт эсэх
- Шинжээчийн дүгнэлтийг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх
- Шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнд хийгдсэн эсэх

Тухайлбал: гадны нөлөөтэй болон амиа хорлосон эсэхэд Шинжилгээ хийлгэх ажиллагаа нь ЭХХШтХ-н 27 дугаар бүлэг, Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/66 дугаартай тушаалаар батлагдсан “ Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ын 9 дүгээр бүлэгт заасны дагуу хийгдсэн эсэхэд анхаарна.

➢ Мөрдөгчийн магадалгаанд анхаарах зүйл:

Мөрдөгчийн магадалгаа нь ЭХХШтХ-н 27.11 дүгээр зүйл, Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/66 дугаартай тушаалаар батлагдсан “ Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ын 10.3 дугаар зүйлд заасан шаардлага, нөхцөлийг хангасан эсэх,

Мөрдөгчийн магадалгааг гол төлөв эдийн засгийн гэмт хэргүүдэд гаргуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой.

СЭДЭВ 2. НОТЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮЕ ШАТ

Нотлох үйл ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, гэм буруутай этгээдийг олж тогтоосноор хязгаарлагдаагүй,тухайн гэмт хэргийг шинжлэх ухааны үндэстэй зүйлчлэн ангилах үндэслэл, ял шийтгэлийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, гэмт хэрэг гарсан шалтгаан тодорхойлох үйл баримтын цогц юм. Нотолгооны үйл явц нь нотлох баримт, түүний эх сурвалжийн тусламжтайгаар явагддаг учир энэ хоёр ойлголтын агуулгыг харилцан холбоотойгоор авч үзвэл зохино. Өөрөөр хэлбэл нотлох ажиллагааны үнэлэмж нь нотлох баримтаас шалтгаална.

Нотолгооны үйл явц нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж шийдвэрлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий субъектүүдээс тухайн хэргийн

үйл явдлыг тогтооход ач холбогдолтой баримт сэлт, мэдээллийг олж цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх үйл ажиллагаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдлыг тогтоох шаардлагатай. Үүнд:

- Гэмт хэрэг гарсан байдал / гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал /,
- Гэмт хэргийг хэн үйлдсэн,
- Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр,
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал,
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар хэр хэмжээ,
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл

Гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа нь гэмт хэргийн үйлдлийг тодорхой болгох, уг үйлдэлтэй цаг хугацаа болон орон зайн хувьд зэрэгцэн өрнөсөн үйлдлээс тусгаарлах, тэдгээрийн дарааллыг тогтоох,гэм буруугүй болохыг нотлох болон үгүйсгэх, яллагдагчийн өмгөөлөх эрхийг хангах зэрэг боломжийг бий болдог. Түүнчлэн гэмт хэрэг гарсан цаг хугацааг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоосноор хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тогтоох ач холбогдолтой.

Гэмт хэргийн үйлдлийн арга нь гэмт хэргийн шинж болохоос гадна эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болдог.

Харин Эрүүгийн хуульд заасан бусад байдал нь гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр, гэмт хэргийн улмаас үүссэн хууль зүйн үр дагавар хамаарч болох юм.

Нотолбол зохих байдалд *гэмт хэргийг хэн үйлдсэнийг* тогтоох нь чухал ач холбогдолтой. Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн хариуцлагыг хүн, хуулийн этгээдэд хүлээлгэхээр зохицуулсан. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, зарим тодорхой төрлийн эрүүгийн хэрэгт 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Гэмт хэргийн сэдэлт, зорилго нь гэм буруугийн хэлбэрээр илэрхийлэгддэг. Гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй гэсэн хоёр хэлбэрт хуваагддаг. Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно.

Харин Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан бол болгоомжгүй гэмт хэрэгт тооцно.

Аливаа болгоомжгүй гэм буруу нь гэм буруутай этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн эцэст гарч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдэж байсан хэдий ч түүнийг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсгөөр найдах, эсхүл үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдээгүй боловч хэрэг үйлдсэн нөхцөл байдалтай холбон үзэж тэрхүү хор уршгийг гарч болно гэдгийг урьдчилан мэдэх ёстой, боломжтой байх буюу хайхрамжгүй хандах гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг. Санаатай гэмт хэргийн тухайд, гэм буруутай этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгэмд аюултай болохыг урьдаас мэдсээр атлаа хүсэж хийсэн, эсхүл тэр хор уршигт зориуд хүргэсэн байдгаараа дээрх гэм буруугийн болгоомжгүй хэлбэрүүдээс ялгагддаг.

Санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэснийг гэм буруугийн холимог хэлбэр гэнэ.

Хэдийгээр сэдэлт санаа зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээд санаа зорилгоо илэрхийлснээр тогтоогддог боловч тухайн гэмт үйлдлийн шинж аргаас хамаарч ямар сэдэлт, зорилготой байсныг тогтоох боломжтой.

Ялангуяа нууц далд аргаар үйлдэгддэг албан тушаалын хэргийн хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 28 дугаар зүйлд “Энэхүү конвенцод заасан гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүн болох ухамсар, санаа, зорилгыг бодит үйл баримтын нөхцөл байдлаас дүгнэн гаргаж болно.” гэж заасан.

Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал

Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:

- тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн;
- гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн, бусад туслалцаа үзүүлсэн, учруулсан хохирлыг төлсөн;
- бие махбодын, сэтгэл санааны албадлагын, эд хөрөнгийн, албан тушаалын, бусад байдлаар эрхшээлд орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн;
- өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан;
- нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангид дээрх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож болохгүй.

Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:

- бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;
- энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;
- нийтэд аюултай аргаар үйлдсэн;
- өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;
- албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотны хүний эсрэг үйлдсэн;
- хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;
- онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
- гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.

Дээрх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй. Шүүх Эрүүгийн хуульд заасан нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг хориглоно.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар хэр хэмжээ

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх

чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно. Харин гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцдог.

“ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно гэж хууль тогтоогч Эрүүгийн хуульд абстракт тайлбарыг тусгасан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирлын хэмжээнээс хамаарч 3 төрөлд хуваана. Үүнд:

“их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

“үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

“бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг.

Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршгийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг мөнгөн дүнгээр тооцож, тогтоох ёстой.

Монголын эрүүгийн эрх зүйн онол ба практикт 2015 оны Эрүүгийн хуулиас өмнө гэмт хэргийн хор уршгийг нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн үр дүнд тодорхой гэм хор учирсныг үзэж, тэрхүү гэм хорыг материаллаг ба материаллаг бус гэж ангилж ирсэн. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүсэн үр дагавар гэсэн нь ойлгомжгүй болгосон.Өөрөөр хэлбэл гэмт хэргийн хор уршгийг хохирол дотор багтаахыг оролдож, бүр тодруулбал хохирол нь хор уршгаасаа өргөн хүрээтэй байна гэж үзжээ.

Жишээлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлд заасан Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал,ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хохирол учирсны зэрэгцээ эмчилгээнд 5 сая төгрөг зарцуулжээ.Энэ нь Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3 дахь хэсэгт зааснаар “бага хэмжээний хохирол”-д тооцогдоно. Ингэхлээр чухам аль нь гэмтэл ба хохирол болохыг зааглан ялгахад нэлээдгүй асуудал үүсгэхээр байгааг анхаарах ёстой.

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт үйлдэл нь бусад хүчин зүйл нөлөөлөлтэй шууд шалтгаан холбоотой байх нөхцөл байдлыг ойлгодог.

Нотлох ажиллагааны үе шат

Нотолгооны үйл явц нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн нотлох баримтыг олж тогтоох, түүнийг бэхжүүлж авах, шалгах, үнэлэх арга замын хувьд ялгаатай байдаг учраас дараах үе шаттайгаар авч үздэг.

- Нотлох баримтыг цуглуулах
- Нотлох баримтыг бэхжүүлэх
- Нотлох баримтыг шалгах
- Нотлох баримтыг үнэлэх

Нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаа нь хоорондоо нягт уялдаа холбоотой процесс ажиллагаа юм.Жишээлбэл хүний амь нас хохирсон хэргийн газраас бууны сум олдсон гэхэд түүний үзлэгийг тэмдэглэлд тусгаж,эд мөрийн баримтаар хураан авснаар нотлох баримт болно. Харин тухайн сум хэрэгт

холбоотой эсэх нь кримналистик болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээний дүгнэлтээр тодорхойлогддог.

Нотлох баримтыг цуглуулах ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гол төлөв хийгддэг ажиллагаа боловч шүүхийн шатанд хийгдэж болно.

Нотлох баримт цуглуулах арга нь тухайн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн гэмт этгээдийг түргэн шуурхай илрүүлэхэд ач холбогдолтой байж болох эд зүйл, бичиг баримт, мэдээ, мэдээллийг эрж хайх, олж илрүүлэх, зорилгоор хуулийн хүрээнд явуулж байгаа хууль, танин мэдэхүйн шинжтэй үйлдэл, арга барилын систем юм.[2]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаа журамлаж зохицуулсан боловч дор дурдсан хэлбэрээр р нотлох баримтуудыг цуглуулж болно. Үүнд:

- Мөрдөн шалгах аргаар нотлох баримтыг цуглуулах / хэргийн газрын үзлэг, шинжээчийн дүгнэлт, байцаалтын явцад авсан мэдүүлэг /
- Нотлох баримтыг гаргуулж авах, гаргаж өгөх замаар гэсэн 2 хэлбэрээр цуглуулж болно.

Нотлох баримт цуглуулах гэж хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаарх баримт, мэдээллийг бүрдүүлж буй ажиллагааг ойлгоно.

Нотлох бариmтыг бэхжүүлэх нь нотлох баримтыг хадгалах, хамгаалах, түүнийг шалгах, үнэлэх урьдчилсан нөхцөл болдог. Нотлох баримтыг бэхжүүлэх гэдэг нь тухайн хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлтийг тогтоох тохиолдолд төдийгүй өөр шаардлагатай нотлох баримт байхгүйг батлахын тулд нэгэн адил явагдана.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ. Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэж болно.

Нотлох баримтыг бэхжүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Нотлох баримтыг бэхжүүлэхэд хэрэглэсэн багаж, техник хэрэгслийн нэр, марк, хүчин чадал гэх мэт гол үзүүлэлтүүдийг тэмдэглэсэн байх,
- Нотлох баримтыг бэхжүүлсэн албан тушаалтны нэр, хугацаа, тоо хэмжээ, дагалдах хэрэгслийн техникийн үзүүлэлт
- Нотлох баримтыг бэхжүүлсэн үйл явц нь алдаагүй ойлгомжтой, засвар өөрчлөлтийг тухайн үед нь хийсэн байх,
- Хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан, оролцогчдын нэр хаяг тодорхой, тэд гарын үсгээ зурж баталгаажуулсан байх гэх мэт

Нотлох бариmтыг шалгах гэдэг нь хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн дүүрэн нягтлан шалгах, үнэлэхэд чиглэсэн ажиллагааг ойлгодог [3].

Нотлох баримт шалгах ажиллагааг дараах аргаар явуулж болно. Үүнд:

- Цугларсан нотлох баримтыг хэрэгт авагдсан бусад нотлох баримттай харьцуулан жиших

[2] Б.Галдаа. Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал 2008 он 94-94-р тал

[3] Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа УБ, 2020 он 69-р тал

- Нотлох баримтын эх сурвалжийг тогтоох
- Шалгаж буй нотлох баримт үндэслэлтэй эсэхийг баталж болон үгүйсгэж байгаа бусад нотлох баримтыг олж тогтоох

Нотлох баримт шалгах ажиллагааны зорилго нь өмнөх нотлох баримтыг нягтлах замаар шинээр нотлох баримт олж авахад оршино.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана” гэж нотлох баримтыг шалгах аргыг тодорхойлж өгсөн.

Жишээлбэл гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хутгыг мөрдөгч хэргийн газраас хураан авч эд мөрийн баримтаар тооцсон байна гэж бодъё. Гэвч тухайн хутгыг хэргийн газрын үзлэг болон хураан авсан тэмдэглэлд тусгасан эсэхийг магадлах замаар нотлох баримтыг шалгаж болно.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл оролцогчийн гаргасан гомдлоор, эсхүл өөрийн санаачилгаар гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас биечлэн мэдүүлэг авах, шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилтыг давтан хийх, мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг хянан шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримтыг шалгаж болно.

Нотлох баримтыг үнэлэх гэдэг нь нотлох баримтын агуулга, хэлбэрийг задлан болон нэгтгэн дүгнэх аргад тулгуурлан нотлох баримтын учир холбогдол, зохицол нийцэл, бодит байх,шинжийг нэгтгэн дүгнэх замаар шийдвэр гаргахад чиглэсэн оюуны үйл ажиллагааг ойлгоно.

Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, цугларч байгаа нотлох баримт нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой эсэхийг хянаж үнэлнэ.

Шүүх, прокурор, мөрдөгч нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуульчилсан.

Шийдвэр гаргах субъект нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэхэд дор дурдсан баталгаа байх шаардлагатай.Үүнд:

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцэх зарчимд суурилсан байх,
- тодорхой шийдвэр гаргахад ямар нэгэн үүрэг, хариуцлага дагалдахгүй байх
- нотлох баримт үнэлэх явцад ямар нэгэн дүрэм, журамд захирагдахгүй байх
- нотлох баримт хүчинтэй эсэхийг урьдчилан тогтоохгүй байх
- шийдвэр гаргахад ямар нэгэн албадлага, дарамт шахалт нөлөөгүй байх

Нотлох баримтыг үнэлэхэд мэргэжлийн ур чадвар, логик сэтгэлгээ, өргөн мэдлэгтэй байх шаардлага үүсдэг.

2.1. Хууль зөрчиж цуглуулсан нотлох баримтыг хэрхэн шийдвэрлэх:

Болж өнгөрсөн гэмт хэргийг сэргээн дүрслэх, хэргийн бодит байдал болон үйл баримтыг тогтооход нотлох баримт чухал ач холбогдолтой. Гэвч нотлох баримт нотлох чадвараа алдах, хууль зүйн үр дагавар үүсгэх боломжгүй тохиолдол гардаг.

Нотлох баримт дараах тохиолдолд нотлох баримтын шинж чанараа алдана. Үүнд:

- Нотлох баримтыг хууль бус арга хэрэгслээр цуглуулж бэхжүүлсэн
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг зөрчсөн
- ЭХХШтХ-д заасны дагуу оролцогчоос прокурор, мөрдөгчид гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг олж авсан эх сурвалжийг зааж хэлээгүй бол.

Хууль зөрчиж авсан нотлох баримтуудыг дараах байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөвтгөх боломжтой. Тухайлбал: хууль зөрчиж авсан мэдүүлгийг зөвтгүүлэхээр дахин мэдүүлэг авах, хууль зөрчиж шинжээч томилсон бол шинжээчийн дүгнэлтийг хууль ёсны гэж үзэх бөгөөд шинжээч томилсон тогтоолыг хүчингүй болгох, эд мөрийн баримтыг хураан авах ажиллагаа нь хууль зөрчсөн тохиолдолд эд мөрийн баримтаар тооцсон тогтоолыг хүчингүй болгох эсхүл нотлох баримтаар үнэлэхгүй.

Дээр дурдсан 3 нөхцөл байдлууд нь шүүх хэргийг хянан хэлэлцэх үед илэрвэл шүүхээс нотлох баримтаар тооцохгүй байх Прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, эсхүл бүхэлд нь болон зарим хэсгийг нотлох баримтаар тооцохгүй байх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

Жишээлбэл мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа гэрчээс мэдүүлэг авахдаа худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар сануулалгүй мэдүүлэг авсан бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж нотлох баримтыг бүрдүүлсэн гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд гэрчээс дахин мэдүүлэг авах замаар нотлох баримтыг бүрдүүлж болно.

2.2. Нотлох баримтын хангалттай хүрэлцээтэй байдал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдал нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг шалгаж, тогтооход зайлшгүй шаардлагатай нийтлэг нөхцөл байдлуудыг тодорхойлсон.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүд үйлдэгдэхдээ өөр өөр цаг хугацаа, орон зайд, дахин давтагдашгүй үйлдлийн шинж чанараар үйлдэгддэг учраас тухайн хэргийн нөхцөл байдалтай уялдуулан ямар нотлох баримт цуглуулах, нотлохын баримтын хангалттай хүрээлцээтэй байдлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн үнэлэмжээр илэрхийлэгдэнэ.

Хэрэг тус бүр өөр өөрийн онцлогтой тул нотлох баримтын хангалттай хүрэлцээтэй байдлыг хатуу журамлан тогтоох боломжгүй юм. Харин нотлох баримтын хангалттай хүрэлцээтэй байдлыг онолын мэдлэг, ур чадвар, ажлын туршлага, логик сэтгэлгээний чадавхаас хамаарч хэргийн нөхцөл байдалд тохируулан хангалттай хүрэлцээтэй байдлыг мөрдөгч, прокурор, шүүгч тогтооно.

2.3. Нотлох баримтыг үнэлэх дотоод итгэл

Нотлох баримтыг үнэлэх ажиллагаа нь хуульчийн дотоод итгэлтэй шууд холбоотой Дотоод итгэл нь хуульд заасан журам, арга хэрэгслээр нотлох баримтыг цуглуулсан, бэхжүүлж шалгасан арга ажиллагааны дүнд хэрэгт авагдсан бүх нотлох баримтын хамааралтай, ач холбогдолтой, хангалттай, үнэн зөв, эргэлзээгүй байдлыг бүхэлд нь хянан үзсэнээр бүрэлдэн тогтоно.

Нотлох баримтыг дотоод итгэлээр үнэлэхэд мөрдөгч, прокурор, шүүгчийн эрх зүйн ухамсар шууд холбоотой. Иймээс мөрдөгч, прокурор, шүүгч хууль зүйн өндөр боловсролтой, хууль дээдлэх эрх зүйн ухамсартай, хууль тогтоомжийн агуулгыг

тайлбарлах өргөн мэдлэгтэй ихээхэн чухал ач холбогдолтой.

Нотлох баримтыг үнэлэхэд 2 үндсэн шаардлагыг гол болгон авч үзнэ.

1. Хэргийн бүх байдлыг бүхэлд нь тал бүрээс нь бүрэн гүйцэд бодит байдлаар хянасны эцэст тухайн субъектийн ухамсарт бий болсон итгэл үнэмшил нь иргэний ардчилсан нийгмийн хуулийн агуулгад нийцсэн, хууль эрх зүйн хэм хэмжээг удирдлага болгосон байвал зохилтой.
2. Нотлох баримтыг үнэлэх дотоод итгэл нь тухайн хэрэгт хуульд заасан нөхцөл журмын дагуу авагдсан бүхий л нотлох баримт бүрийг чөлөөтэй, бие даасан байдлаар аль нэгэн байгууллага, албан тушаалтнаас үл шалтгаалан хэрэгт хамааралтай нотолгооны зүйл бүрийг зөв танин мэдэж өөрийн итгэл үнэмшилд тулгуурлаж хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргахад чиглэсэн мэдлэгийн илрэл болсон байх явдал юм.

Дээрхээс үзвэл нотлох баримтыг дотоод итгэлээр үнэлэх гэдэг нь ямар нэгэн гадны албадлага шахалтаас ангид, чөлөөтэй байж урьдаас хөтөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар нэгэн нотлох байж болохгүйгээр нотлогдвол зохих нөхцөл байдлуудыг нотлох баримттай харилцан нягт уялдаатайгаар зөвхөн өөрийн итгэл үнэмшлээр бодит дүгнэлт хийхийг хэлнэ.

Шүүхийн өмнөх шатанд прокурор, шүүх хуралдааны шатанд шүүгч нотлох баримтыг үнэлэмжийг тодорхойлж, хэргийг шийдвэрлэнэ.

Нотлох баримтыг бодитой үнэлэх дотоод итгэл нь дараах зүйл дээр үндэслэгдсэн байх шаардлагатай. Үүнд:

- Хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу цугларсан нотлох баримтыг үндэслэсэн байх,
- Зохих журмын дагуу бэхжүүлэн авсан, тухайн хэрэгт хамааралтай нотлох баримтад тулгуурлах,
- Хуулийн дагуу зохих ёсоор шалгагдсан үнэн зөв баримт бүрийг нэг бүрчлэн авч үзсэн байх
- Хэрэгт хуулийн дагуу авагдсан яллах болон цагаатгах бүхий л нотлох баримтыг нэгтгэн харьцуулсан дүгнэлт хийх боломжтой нотлох баримтад үндэслэсэн байх
- Нотлох баримт бүр нь тухайн хэргийн нөхцөл байдлыг тогтооход агуулгын хувьд ач холбогдолтой, хамааралтай байх
- Нотолгооны анхдагч эх сурвалж тодорхой байх
- Нотлох баримтыг цуглуулахдаа эрүү шүүлт тулгах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэсэн эсэхийг нягталж шалгасны үндсэн дээр үнэлэх шаардлагатай.

Нотлох баримтыг үнэлэх хууль эрх зүйн ухамсар, дотоод итгэл нь хууль зүйн дагуу авагдсан нотлох баримтад бодитой тулгуурласан, хуулийнхаа заалтыг удирдлага болгосон байх ёстой.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Бүрэнтөгсийн Галдаа /хууль зүйн ухааны магистр/ “Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал” 2008 он
2. Х.Нямбаатар, Л.Батжав, Т.Оюунчимэг, Ч.Нямсүрэн, Б.Цолмон, Р.Баярмагнай, Д.Батгэрэл, А.Шинэбаяр, Э.Идэрцог, Б.Мөнхсэргэлэн, Ч.Отгонсүрэн “Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” 2020 он
3. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган “Монгол Улсын эрүүгийн эрх зүй, үзэл баримтлал,

уламжлал, сургамж: 2019 он

4. С.Нарангэрэл “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” 2021 он
5. Улсын Ерөнхий прокурорын 2020 оны 07-р сарын 17-ны өдрийн А/67 дугаартай “хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар” 2020 он

БҮЛЭГ 10. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

СЭДЭВ 1. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД

1.1.Таслан сэргийлэх арга хэмжээний ойлголт
1.2.Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, ангилал

СЭДЭВ 2. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ АЖИЛЛАГАА

2.1. Шүүхийн зөвшөөрлөөр хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээний төрөл
2.2 Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний онцлог, анхаарах асуудал
2.3. Шүүхийн зөвшөөрлөөр таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагаа
2.4. Өсвөр насны хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх ажиллагааны онцлог
2.5. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах нь

СЭДЭВ 1. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД

1.1.Таслан сэргийлэх арга хэмжээний ойлголт

Зорилго. Таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг хууль зүйн үндэслэлтэй, тохируулан хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх үүднээс таслан сэргийлэх арга хэмжээний тухай ойлголт, түүнийг сонгон хэрэглэх үндэслэл, журам мөн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхтэй холбоотой хүний эрхийг хангах асуудлын талаар авч үзэх болно.

Таслан сэргийлэх арга хэмжээ нь нэг талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангаж, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлдэг бол нөгөө талаас хүний эрхийг хязгаарласан албадлагын арга хэмжээ, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэн чухал хэсэг билээ. Таслан сэргийлэх арга хэмжээг зөв сонгон хэрэглэх, түүний хууль зүйн үндэслэлийг тодорхойлох, хуульд заасан журмыг чанд баримтлах шаардлагатай.

Таслан сэргийлэх арга хэмжээний ойлголт: Академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ “Таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь хуульд заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын албан тушаалтан болон шүүхээс яллагдагчид хэрэглэх эрүүгийн процессын нөлөөллийн хэрэгсэл гэж тодорхойлоод зорилго нь 1) яллагдагчийг гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг таслан зогсоох ба дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, 2) яллагдагч шүүх болон прокурорын дуудсан цагт хүрэлцэн очих шаардлагыг хангуулах, 3) Яллагдагчийг мөрдөн байцаалт болон шүүхээс оргон зайлах явдлыг таслан зогсоох ба урьдчилан сэргийлэх, 4) яллагдагчаас хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулахгүй байлгах, 5) шүүхийн шийдвэрийг биелүүлэх” гэж тодорхойлжээ.[1]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авна гэж заасан байна. Таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь яллагдагч, шүүгдэгчид хэрэглэх албадлагын арга хэмжээ болохын зэрэгцээ түүнийг гагцхүү хуульд заасан үндэслэл, нөхцөлийг харгалзан, хуульд заасан журмын дагуу

[1] С.Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхийн толь бичиг. Уб., 2021. 380 дахь тал.


авах эсэхийг шийдвэрлэдэг.

1.2.Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, ангилал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар таслан сэргийлэх арга хэмжээ нь хувийн баталгаа гаргах; тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх; хязгаарлалт тогтоох; барьцаа авах; цагдан хорих; цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах гэсэн төрлүүдээс бүрдэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх үе шат, хэрэглэж буй субъект зэргээр нь ангилах боломжтой.

Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх үе шатаар нь:



Шүүхийн өмнөх шатанд прокурор цагдан хорих, хязгаарлалт тогтоох, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх /шүүхийн зөвшөөрөл хүссэн/ талаар үндэслэл бүхий саналыг шүүхэд хүргүүлэх, шүүх саналыг хүлээн авч талуудын шүүхэд мэдүүлэх, мөн мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлж шүүхийн хэлэлцүүлгийн үндсэн дээр дээрх гурван төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эсэх талаар шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэр нь шүүгчийн захирамж хэлбэртэй байна.

Шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагаанд прокурор өөрөө шийдвэр гаргах, гаргасан шийдвэрт хяналт тавих хэлбэрээр хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бол шүүхийн шатанд шүүх хуралдаанд санал гаргах байдлаар оролцоно. Шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд шүүх хөндлөнгийн байр суурьтайгаар оролцох тул таслан сэргийлэх арга хэмжээний талаар оролцогч нарын саналд тулгуурлан шийдвэр гаргана.

Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж буй субъектээр нь:



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөгч, прокурор, барьцаа авах, цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын тогтоолоор авна. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий оролцогч болохын хувьд таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл, таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт, яллагдагчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж зэрэгт сонгон хэрэглэж буй таслан сэргийлэх арга хэмжээ тохирсон эсэхэд хяналт тавьж, шүүхэд таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх талаар санал гаргах зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлэн оролцоно.

Таслан сэргийлэх арга хэмжээг дангаар болон давхардуулан хэрэглэх шинжээр нь:

Дангаар хэрэглэх ТСАХ	Давхардуулан хэрэглэх ТСАХ
Цагдан хорих	*Хувийн баталгаа*
Барьцаа авах	*Хязгаарлалт тогтоох*
Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах	*Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх*

Практикт нэг болон хэд хэдэн яллагдагч нарын үйлдсэн эрүүгийн хэргүүдийг нэгтгэн шалгах ажиллагааны үед өөр өөр эрүүгийн хэрэгт нэг яллагдагчид авагдсан таслан сэргийлэх арга хэмжээнүүд давхцах тохиолдол бий болно. Энэ үед давхардуулан хэрэглэж болохгүй таслан сэргийлэх арга хэмжээнүүд давхардах процесс ажиллагааны зөрчил бий болж болзошгүй нөхцөл үүсдэг тул прокурор хэргүүдийг нэгтгэхдээ авагдсан таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг урьдчилан шалгах нь зүйтэй юм.

Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ

Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ нь хамгийн хөнгөн төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ бөгөөд нийтлэг байдлаар түгээмэл хэрэглэж байна.

Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр авна. Яллагдагч шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх талаар хувийн баталгааг бичгээр гаргаж, гарын үсэг зурна.

Хувийн баталгаа гаргасан яллагдагч ажил эрхлэлтийн байдал, байнга оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн хаяг өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх гэж байгаа талаар шүүх, прокурор, мөрдөгчид даруй мэдэгдэнэ. Шүүх, прокурор, мөрдөгч яллагдагчид хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчвөл таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг тайлбарлана. Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчих нь яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг чангатган өөрчлөх үндэслэл болно.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ

Барьцаа авах гэдэг нь яллагдагч, шүүгдэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд

барьцааг улсын орлого болгох нөхцөлтэйгөөр хэрэглэдэг таслан сэргийлэх арга хэмжээний төрөл юм. Прокурор, шүүх яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө тухайлбал орон сууц, автомашин зэргийг барьцаалах боломжгүй юм. Барьцааг яллагдагч өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно. Энэ тохиолдолд барьцаалуулагчид яллагдагч үүргээ зөрчвөл барьцааг улсын орлого болгох нөхцөлийн талаар танилцуулж тайлбарлах шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бусдын өмнөөс барьцаа гаргахыг хориглоно.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн өндөр хөгжилтэй улс орнуудад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг орлуулах үр дүнтэй арга, альтернатив сонголт бүхий хувилбараар хэрэглэж байна.

Барьцааны хэмжээг тогтооход практикт нэлээдгүй маргаантай асуудлууд үүсэх тохиолдолд бий. Тухайлбал яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч нарын хувьд хэт өндөр барьцаа шаардсан талаар гомдол гаргах асуудал байсаар байна. Харин барьцааны хэмжээг яллагдагчийн хувийн байдлыг харгалзахгүйгээр хэт багаар тогтоох нь таслан сэргийлэх арга хэмжээг зөрчих, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах үндэслэл болдог.

Уг таслан сэргийлэх арга хэмжээг тодорхой хэмжээний барьцаа нь тухайн яллагдагч, шүүгдэгчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд зохих ёсоор оролцож, төлөв томоотой байлгах бодит материаллаг баталгаа болж чадна гэж үзсэн тохиолдолд сонгон хэрэглэнэ. Ийм ч учраас барьцааны хэмжээг хуульд тусгайлан тодорхойлж заагаагүй бөгөөд түүний төрөл хэмжээг гэмт хэргийн ангилал, яллагдагч, шүүгдэгчийн хувийн болон эд хөрөнгийн байдлыг нь харгалзан прокурор, шүүх тогтооно.[2] 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөн барьцааны хэмжээг тогтоохдоо яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан тогтооно гэж хуульчилжээ.

Прокурор барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ барьцааны хэмжээг тогтоох нь нэн чухал асуудал болох талаар дурдсан билээ. Барьцааны хэмжээг тогтооход яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинжээс гадна хувийн байдал буюу тодруулбал эд хөрөнгийн байдал, цалин орлого зэрэг нь чухал ач холбогдолтой юм.

Яллагдагчийн эд хөрөнгийн байдлыг тодруулахдаа ажлын газрын тодорхойлолт, цалингийн тодорхойлолт, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, хадгаламж, хадгаламжийн хүү, бонд, үнэт цаас, хувьцаа, крипто вальют зэргийн орлого, яллагдагчийн өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл зэргийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу холбогдох байгууллагаас гаргаж ирүүлсэн лавлагаа, банкны дансны хуулга зэрэгт үндэслэн тогтоож болно.

Харин яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж тухайлбал өмчлөх эрх, эдийн засаг, албан тушаалын гэмт хэргүүдийн хувьд нуугдмал хөрөнгийг олж илрүүлэх ажиллагаа нь нэлээдгүй ярвигтай бөгөөд нуугдмал хөрөнгийн хэмжээг олж тогтоосны үндсэн дээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх, барьцааны хэмжээг тогтоох шийдвэр гаргах нь зүйтэй.

Яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж гэдэгт барьцааны хэмжээг тогтооход гэмт хэрэг үйлдэж олсон орлого, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан үзэх зайлшгүй шаардлага гарна. Тухайлбал мөнгө угаах гэмт

[2] Г.Баясгалан, Ж.Бямбаа нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. Уб., 2003. 79-80 дахь тал.

хэрэг үйлдэж 2 тэрбум төгрөгийн орлого олсон яллагдагчид 200 сая төгрөгийн барьцаа байршуулж таслан сэргийлэх арга хэмжээ авах нь зохимжгүй юм. Мөн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж 10 сая долларын хохирол бусдад учруулсан яллагдагчид 100 сая төгрөгийн барьцаа байршуулах таслан сэргийлэх арга хэмжээ авах нь энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээний зорилго, үндсэн агуулга болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохих ёсоор оролцож, төлөв томоотой байлгах бодит материаллаг баталгаа болж чадах нь эргэлзээтэй тул барьцааны хэмжээг дээрх байдлаар авч хэрэглэхээс татгалзах нь зүйтэй.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг яллагдагч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч гаргах боломжтой бөгөөд энэ тохиолдолд дээр дурдсан баримтыг оролцогч өөрөө гаргаж ирүүлэх боломжтой боловч прокурор бүрэн гүйцэд, үнэн зөв, үндэслэл бүхий баримт мэдээлэл эсэхийг хянан шалгаж, шийдвэр гаргахдаа дүгнэлт өгөх шаардлагатай юм.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг яллагдагчид хүлээлгэнэ.

Барьцааны мөнгийг тусгай дансанд байршуулна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум буюу сум дундын прокурорын газар нь барьцааны мөнгийг хүү, шимтгэлгүйгээр байршуулах тусгай данстай байна. Барьцааны мөнгийг бэлнээр хүлээн авах, арилжааны болон өөр бусад зорилгоор ашиглахыг хориглодог. Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.[3]

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг болон барьцаа өгсөн яллагдагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оршин суугаа газраасаа түр явах болсон, эсхүл дуудсан цагт хүрэлцэн ирэх боломжгүй болсон бол энэ тухай шүүхийн шатанд шүүхэд, мөрдөн байцаалтын явцад прокурорт, эсхүл мөрдөгчид урьдчилан мэдэгдэх үүргээ зөрчсөн тохиолдолд барьцааны мөнгийг үл маргах журмаар улсын орлого болгоно.

Мөн барьцаалуулагч нь өөрийн үүргээсээ татгалзаж барьцааны мөнгийг буцаан авах хүсэлт гаргасан нь яллагдагчид авсан барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорих үндэслэл болно.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, барьцааг буцаан олгоно.

Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээ

Яллагдагч, шүүгдэгчээр татагдсан цэргийн алба хаагчийг цэргийн ангийн удирдлагад прокурор, шүүхийн шийдвэрээр хянан харгалзуулахыг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээ гэнэ. Цэргийн ангийн удирдлага цэргийн алба хаагчийг мөрдөгч, прокурор, шүүхээс дуудсан цагт ирүүлж байх үүрэг хүлээнэ. Энэ таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн цэргийн албан хаагчид хэрэглэнэ.

Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээг

[3] Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурор, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Дугаар 58, А/87, 203 тушаал, захирамж. Уг тушаалын хавсралтаар батлагдсан Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журам.

хэрэглэхэд яллагдагч гэмт хэрэг хамтран үйлдсэн бусад оролцогч нартай уулзах, харилцах, харилцаа холбоо тогтоож мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулах боломжийг хязгаарлаж таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа цэргийн ангийн удирдлагад энэ талаар анхааруулах, прокурорын шийдвэрт тусгайлан тусгах шаардлагатай. Прокурорын шийдвэрт энэ талаар урьдчилан зааж, анхааруулаагүйн улмаас цэргийн ангид эргэлт, уулзалтаар очихдоо гэмт хэрэг хамтран үйлдсэн оролцогч нар нь уулзах, харилцаа тогтоох зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болох тохиолдол үүсч байна. Цэргийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт зайлшгүй цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх шаардлага үүссэн, эсхүл цэргийн ангид байлгах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад саад учруулах бодит үндэслэлүүд бүрдсэн тохиолдолд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүйгээр өөр тохирох төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх нь зүйтэй.

СЭДЭВ 2. ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ АЖИЛЛАГАА

2.1. Шүүхийн зөвшөөрлөөр хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээний төрөл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөн байцаалтын явцад тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх; хязгаарлалт тогтоох; цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн зөвшөөрлөөр авна. Харин эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үед шүүхэд бүх төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх бүрэн эрх хуулиар олгогджээ.

Аливаа хэлбэрээр хүний хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих, эрх чөлөөтэй байх үндсэн эрхэд хязгаарлалт тогтоож буй таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн хяналтанд оруулсан нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд тун шинэлэг зохицуулалт болжээ.

Мөрдөн байцаалтын явцад шүүх дээрх 3 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эсэх талаар шийдвэр гаргах үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх, хугацаа сунгах тухай прокурорын санал, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтэнд үндэслэнэ. Өөрөөр хэлбэл шүүх өөрийн санаачилгаар таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой шийдвэр гаргахгүй. Энэ нь шүүхийн хөндлөнгийн хараат бус байх зарчимд үндэслэгдсэн байдаг.

Прокуророос шүүхийн зөвшөөрлөөр таслан сэргийлэх арга хэмжээ авахаар санал гаргахдаа тухайн саналд таслан сэргийлэх арга хэмжээ авах хууль зүйн үндэслэл, түүнийг нотлох баримтууд зэргийг тусгасан байх шаардлагатай.

Прокурорын саналын хэлбэрийг аргачилсан зааврааар тогтоож өгсөн байдаг бөгөөд прокурор таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хууль зүйн үндэслэлийг бодит фактад тулгуурлан дүгнэлт хийж бичихдээ хууль зүйн үндэслэлийг нотолж буй нотлох баримтуудыг дурдаж, шаардлагатай бол нотлох баримтуудын агуулгыг дэлгэрэнгүй бичнэ.

Жишээлбэл яллагдагч оргон зайлсан үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналд яллагдагчийг оргон зайлсан болохыг нотлох баримтууд цагдаагийн байгууллагын санд эрэн сурвалжлалт зарласан лавлагаа, эрэн сурвалжлах ажиллагаа явуулсан баримтууд, мөрдөгчийн тэмдэглэл, цагдаагийн

албан хаагчийн илтгэх хуудас, шаардлагатай тохиолдолд гэрчийн мэдүүлэг зэрэг прокурорын саналын үндэслэлийг нотолсон буюу дараах нотлох баримтуудаар яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх үндэслэл бүрдсэн болохыг прокурорын саналд зайлшгүй тусгах шаардлагатай. Прокурорын санал хэт ерөнхий бичигдэх, хийсвэр үндэслэл, таамаглал, сэжиглэлд тулгуурласан байж болохгүй. Мөн зайлшгүй нууцалбал зохих мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, нотлох баримт биш бол шүүхэд болон оролцогч нарт шүүхийн хэлэлцүүлэгт оролцохдоо танилцуулж мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, мөн яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулах шийдвэрийн үндэслэлийг мэдэж байх, мэдээлэл авах эрхийг хангаж оролцох нь зүйтэй юм.

Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний төрөл юм. Энэ таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр авна.

Энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг яллагдагч, шүүгдэгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, ажил албан тушаал, хуулийн этгээдийн болоод аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа зэрэг нөхцөл байдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээ юм.

Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ нь тухайлбал авлига, албан тушаалын гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг, албан тушаалын байдлаа ашиглаж гэмт хэрэг үйлдэх зэрэг тухайн яллагдагчийн хөдөлмөрлөх, ажил албан тушаал эрхэлж буй байдал нь гэмт хэрэг үйлдэх нөхцөл болсон, ажил, албан тушаалын байдлаа ашиглаж гэмт хэрэг үйлдсэн байх нь энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх үндэслэл болно. Мөн хуулийн этгээдийн холбогдсон эрүүгийн хэрэгт хуулийн этгээдийн үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх байдлаар хэрэгжүүлэх боломжтой. Мөн яллагдагчийн хувийн байдал, эрхэлж буй ажил, албан тушаал нь үйлдсэн гэмт хэргийн төрлөөс хамаарахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад саад болохуйц нөхцөл байдал бий болсон, бий болж болзошгүй бодит үндэслэл байгаа бол энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх боломжтой.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хуулийн этгээдийн холбогдсон эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр хуульчилсантай холбоотойгоор хуулийн этгээдэд хэрэглэж болох таслан сэргийлэх арга хэмжээний ганц төрөл нь тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ юм. Үүний эрх зүйн үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг энэ зүйлд заасны дагуу түдгэлзүүлж болно” гэж зааснаас харж болох юм.

Прокурор, эсхүл мөрдөгч шүүхийн шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ. Шүүхийн шийдвэрийг хүлээн авсан байгууллага, хуулийн этгээд нь хэрхэн хэрэгжүүлсэн тухайгаа уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор прокурор, мөрдөгчид мэдэгдэнэ. Тодорхой үйл

ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зорчих хөдөлгөөн, харилцаанд хориглолт, хязгаарлалт тогтоож хэрэгжилтэд нь хяналт тавьж буй шүүхийн зөвшөөрлөөр авах албадлагын арга хэмжээний төрөл юм.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь үндсэн 3 төрлөөр хэрэглэгдэх боломжтой. Үүнд Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах буюу гадаад улсад зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явахыг хориглох буюу тогтоосон бүс нутгаас тухайлбал Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гарч явахыг хориглох, тухайн дүүрэг, хорооноос гарч явахыг хориглох гэх мэт тодорхой бүсчлэлээс гадагш зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, тодорхой газар очих буюу нэрлэн заасан бүс нутаг, тодорхой байршил, объектод очих нэвтрэх зэргийг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгах буюу шүүхийн шийдвэрт заагдсан маршрутаар зорчих хөдөлгөөнийг гүйцэтгэхийг даалгах замаар хэрэгжихээс гадна, тодорхой хүнтэй уулзах, харилцахыг хориглох буюу шүүхийн шийдвэрт нэрлэн заасан хүмүүстэй уулзах, харилцахыг хориглох зэргээр хэрэгждэг.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналд тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг даалгах тохиолдолд бүсчлэлийг хэрхэн тодорхойлох, бүсчлэлийг зөв тодорхойлсноор энэхүү таслан сэргийлэх арга хэмжээний зорилтыг хэрхэн хангах талаар дүгнэлт хийх шаардлагатай. Бүсчлэлийг хэт явцуу тогтоох нь оролцогчийн хуулиар хамгаалсан эрхийг зөрчих нөхцөл байдал үүсэх бол хэт өргөн хүрээтэй тогтоох нь таслан сэргийлэх арга хэмжээний зорилтыг хангаж чадахгүй нөхцөл байдалд хүргэнэ.

Тодорхой газар очихыг хориглох хязгаарлалт тогтоох тохиолдолд яллагдагчийг очихыг хориглож буй байршил, объектын ач холбогдлыг үнэлж тухайлбал гэмт хэргийн ул мөрийг баллах, нотлох баримтыг нуух, устгах, гэрч, хохирогчийг дарамтлах, тэдгээрт нөлөөлөх зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлнэ. Тухайлбал гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирогчийн оршин суугаа газар, эсхүл ажлын байранд очихыг хориглох гэх зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой юм. Тодорхой хүнтэй уулзахыг хориглох хязгаарлалт тогтоох саналд прокурор уулзах, харилцахыг хориглох хүмүүсийн нэрсийг тодорхой зааж өгөх шаардлагатай. Учир нь шүүхийн шийдвэр заавал биелэгдэх ёстой ба биелүүлэхэд ойлгомжтой байх хуулийн шаардлагад нийцсэн байх учиртай. Түүнээс эрүүгийн … дугаар хэргийн бүх гэрчүүдтэй уулзахыг хориглох гэх мэт байдлаар тодорхойгүй санал гаргах нь мөрдөн шалгах ажиллагааны үед яллагдагч, түүний өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцаагүй ямар хүмүүс гэрчээр оролцож байгааг мэдэхгүй байх боломжтой. Гэтэл гэрчүүдтэй уулзахыг хориглох гэж ерөнхий байдлаар санал гаргах нь таслан сэргийлэх арга хэмжээг ухамсаргүйгээр зөрчих нөхцөл байдалд яллагдагчийг хүргэх, эрх зүйн байдлыг нь дордуулж таслан сэргийлэх арга хэмжээг чангатган өөрчлөх үндэслэл ч болж болно. Тодорхой хүнтэй уулзахыг хориглох гэдэгт мөн өмгөөлөгчтэйгөө уулзахыг хориглох гэх мэтээр биелэгдэх боломжгүй хориглолт тогтоох боломжгүй, мөн нэг гэрт хамт амьдардаг хүмүүстэйгээ уулзахыг хориглох, мөн хөдөлмөрлөх үүргээ хэрэгжүүлэх

явцад зайлшгүй харилцаа тогтоох хүмүүстэйгээ уулзахыг хориглох хязгаарлалт авагдах боломжтой эсэхийг прокурорын шалгаж байж саналаа гаргах учиртай.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих этгээдүүдийг хэрхэн тогтоох талаар прокурор өөрийн саналдаа тусгаж байх нь зүйтэй. Хяналт тавих этгээдүүдийг зөв тодорхойлох нь хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах чухал нөхцөл юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэрт заасан бол хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих байгууллага нь яллагдагчид хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавина гэж заасан байна. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг 2021 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн, цахим гав (electronic monitoring tag) төхөөрөмжийг зөвхөн ял эдлүүлэх ажиллагаанд бус мөн таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа хэрэглэдэг туршлага зорчих эрхийг хязгаарлах ялыг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудад нэгэнтээ хэрэгжээд багагүй хугацааг өнгөрүүлжээ. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэглэх боломж, эрх зүйн орчныг нэгэнт хуульчилсан тул хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэх боломж нөхцөл тун удахгүй бүрдэх нь тодорхой болоод байна. Иймд прокурор хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ авах саналдаа шаардлагатай тохиолдолд хяналтын төхөөрөмж хэрэглэх, мөн яллагдагчид хяналтын төхөөрөмжийг хэрэглэх боломжийг судлан саналдаа тусгах шаардлага үүсэн бий болж байна. Тухайлбал яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан хяналтын төхөөрөмж хэрэглэх боломжтой эсэх, хяналтын төхөөрөмжийн сүлжээ бүхий хэсэгт амьдарч, ажил хөдөлмөр эрхэлж байгаа эсэх зэргийг судлан тогтоох шаардлагууд үүсэх юм.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь хэдийгээр яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэгддэг боловч энэхүү таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх хуулийн үндэслэл, түүнийг нотлох баримтууд, хэрэглэх шаардлага, бодит ямар саад учруулах нөхцөл байдал эсхүл хязгаарлалт тогтоохгүй бол гэмт хэрэг дахин үйлдэгдэж болзошгүй талаарх үндэслэл бүхий сэжиг таамаг байгаа талаар прокурор өөрийн саналдаа дурдах нь зүйтэй. Түүнээс бус урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх учраас хэрэгцээ шаардлагыг нь нотлох шаардлагагүй гэх хандлага байж болохгүй юм.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь яллагдагч, шүүгдэгчийн чөлөөтэй зорчих, бусадтай харилцах боломжид хязгаарлалт, хориглолт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид тогтоогдож Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхэнд шууд хязгаарлалт тогтоодог тул аль болох эрхийн зөрчил, хязгаарлалтыг бага байх түвшинд хязгаарлалтын хэмжээ, хүрээ, мөн хугацааг сонгох мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулахад анхаарах нь зүйтэй юм.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн холбогдсон эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болсон тохиолдолд прокурор уг хязгаарлалтыг хүчингүй болгох тухай саналаа шүүхэд даруй гаргаж шийдвэрлүүлэх учиртай. Практикт тухайлбал Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн холбогдсон эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол хэрэгсэхгүй болсон боловч прокурор шүүхэд даруй хандаж хязгаарлалтыг хүчингүй болгуулаагүйн улмаас тухайн хүн Монгол Улсын хилээр гарахаар хил нэвтрэх үед хязгаарлалт хүчингүй болоогүй талаар мэдэж цаг хугацаа, онгоцны тийз захиалсан мөнгө зэргээр хохирох, улмаар эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж буй прокурор, шүүхэд гомдол гаргах явдал түгээмэл ажиглагдаж байна.

2.2 Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний онцлог, анхаарах асуудал

Таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн хатуу төрөл бөгөөд яллагдагчийн эрх чөлөөг шүүхээс мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах нөлөөллийн арга хэмжээ юм.[4] Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн бусад таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх боломжгүй тохиолдолд хэрэглэнэ.[5]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хуульд заасан тодорхой үндэслэл бий болсон бол хөнгөн, хүнд зэрэг гэмт хэргийн ангилал хамаарахгүйгээр хэрэглэх, эсхүл тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээнээс хамааруулан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх гэсэн үндсэн хоёр төрлийн зохицуулалтыг агуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хөнгөн, хүнд гэмт хэрэгт хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх боломжтой байхаар хуульчилжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дараах үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар заажээ. Үүнд:

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;
- шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
- урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй гэх үндэслэлүүдийг хуульчилсан байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах өөр нэг бие даасан үндэслэл нь тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээнээс хамааруулан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн авч болохоор байгаа юм.

Шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэлийн нийт шийдвэрт эзлэх хувь (2018-2022)[6]-тай танилцахад дийлэнх тохиолдолд хэрэглэж буй голлох үндэслэлүүдэд тулгуурлан тайлбар хийвэл:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас болон эрүүгийн хариуцлага хүлээхээс зайлсхийсэн, байнга оршин суух хаягаа өөрчилсөн, дуудсан цагт хүрэлцэн

[4] С.Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Уб., 558 дахь тал.

[5] Г.Баясгалан, Ж.Бямбаа нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. Уб., 2003. 81 дэх тал

[6] Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. Уб., 2023. 44-45 дахь тал.

ирээгүй, урьдчилан мэдэгдэхгүйгээр гадаад улсад болон өөр орон нутагт шилжсэн, удаан хугацаагаар зорчсон, утасны дугаараа солих, дуудсан цагт бэлэн байх үүргээ биелүүлэхгүй байх зэрэг үйлдлүүдээр илэрч болно. Оргон зайлахыг завдах нь бодит үйлдлээр илэрнэ.

Оргон зайлсан гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд эрүүгийн хариуцлага хүлээхээс зайлсхийж, мөрдөн шалгах, прокурорын хяналт, шүүхийн шатнаас бүрмөсөн оргон зугтаасан, байнга оршин суух хаягтаа байхгүй байх, гадаад улс, өөр бусад орон нутагт зорчиж удаан хугацаагаар амьдрах, дуудсан цагт хүрэлцэн ирэх зэрэг яллагдагчийн үүргийг зөрчсөн идэвхтэй үйлдлээр илэрнэ. Оргон зайлсан болохыг нотлох баримтаар тогтоосон байвал зохино. Тухайлбал яллагдагч байнга оршин суугаа хаягтаа байхгүй, амьдрахгүй байгаа болохыг тогтоох, гэрчийн мэдүүлэг, хорооны засаг даргын болон холбогдох байгууллагын тодорхойлолт, цагдаагийн байгууллагын санд эрэн сурвалжилсан талаарх баримт, мөрдөгч эрэн сурвалжлах ажиллагаа явуулсан тухай баримтууд, мөн гадаад улсад эрэн сурвалжлах ажиллагаа явуулахаар интерполд хандсан зэргээр эрэн сурвалжлах идэвхтэй ажиллагааг хийж гүйцэтгэсэн зэргийг нотолсон нотлох баримтуудыг наад зах нь шаардах юм. Иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх ойлголт бага байдаг, мөн хэт хайхрамжгүй үйлдлээсээ болж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүрэлцэн ирэхгүй байх тохиолдлууд байж болох бөгөөд оргон зайлахыг завдсан, оргон зайлсан санаа зорилго, идэвхтэй үйлдэл, бодит үндэслэл байгаа эсэхэд дүгнэлт өгөх зайлшгүй шаардлагатай.

Гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа гэх үндэслэл нь нийт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийн 2020 онд 17.8%, 2021 онд 22.6%, 2022 онд 23.7% тус тус эзэлсэн нь хамгийн түгээмэл хэрэглэж буй үндэслэлийн тоонд орж байна. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэдэг нь ямар нэгэн сэжиглэл, таамаглалд тулгуурласан байж болохгүй бөгөөд прокурор, шүүгчийн субъектив үнэлэмж бус харин объектив шалгуурт нийцэж баримтаар тогтоогдсон байх ёстой. Тухайлбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед дахин гэмт хэрэг үйлдсэн, тэнсэх хугацаанд, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд, шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг эдэлж байхдаа дахин гэмт хэрэг үйлдсэн зэргээс гадна яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэх гэж байгаа талаар мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримтад мэдээлэл, мөн гэрч, хохирогч, гэмт хэрэг хамтран үйлдсэн яллагдагчийн мэдүүлэг зэргийг дурдаж болно. Яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, олонлог зэргээс хамаарч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг дээрх үндэслэлээр авч болох боловч ийнхүү авах шалгуур нь бодит үндэслэл, шалгуур, баримтад тулгуурлах шаардлагатай. Ихэвчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, үргэлжилсэн үйлдэлтэй өмчлөх эрхийн эсрэг /хулгайлах, залилах г.м./ гэмт хэргүүд зэрэгт гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, шалтгаан, шинж, гэмт үйлдэлдээ хандаж буй хандлага, яллагдагчийн хувийн байдал /урьд ижил төрлийн гэмт хэрэгт ял шийтгэл эдэлж байсан давтамж/ зэргийг харгалзан үзнэ.

Урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн гэх үндэслэл нь яллагдагчид цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байх урьдач нөхцөлийг шаардана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хувийн баталгаа гаргах, хязгаарлалт тогтоох, барьцаа авах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээгээр яллагдагчид хүлээлгэсэн үүрэг, хориглосон, хязгаарласныг зөрчсөн идэвхтэй үйлдэл байна. Тухайлбал хориглосон газарт очсон, Монгол Улсын хилээр гарах оролдлого хийсэн, уулзахыг хориглосон хүнтэй уулзсан, урьдчилан

мэдэгдэхгүйгээр байнга оршин суух газраасаа түр болон удаан хугацаагаар явсан, дуудсан цагт хүрэлцэн ирээгүй, аливаа бусад хэлбэрээр процесс ажиллагаанд саад учруулсан зэргийг дурдаж болох юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах бие даасан үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчилжээ.

Дээрх үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг гагцхүү хорих ялын доод хэмжээг 8 жил түүнээс дээш хугацаагаар тогтоож өгсөн эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан хүн, шүүгдэгчид хэрэглэх боломжтой. Тухайлбал хүнийг алах, бага насны хүүхэд хүчиндэх, эх орноосоо урвах зэрэг онц ноцтой гэмт хэргүүд дээрх ангилалд хамаардаг. Гэхдээ хорих ялын доод хэмжээг 8 жил түүнээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн бүрт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх ёстой гэсэн үг биш юм. Ийнхүү хэрэглэхдээ үйлдсэн гэмт хэргийн шинж, яллагдагчийн хувийн байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэх шаардлагатай юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байна. Мөн хуулийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “хэргийн ээдрээ” төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол шүүх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй гэж заасан бол 3 дахь хэсэгт Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/, 19.6/Хорлон сүйтгэх/, 29.5/Төрлөөр устгах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэж хуульчилжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өсвөр насны яллагдагчийн хувьд өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 3 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 6 сараас хэтэрч болохгүй гэж цагдан хорих нийт хугацааг насанд хүрсэн яллагдагчийнхаас бага байхаар тогтоож өгчээ.

Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

Шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно. Прокурор сэжигтнээр шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан талаарх шийдвэрийг шүүхэд хуульд заасан хугацаанд заавал хүргүүлж, мэдэгдэх үүрэгтэй. Сэжигтнийг яллагдагчаар татан үргэлжлүүлж цагдан хорих шийдвэр гарч буй тохиолдолд шүүх баривчилсан баримтыг үндэслэн цагдан хорих хугацаанд баривчилсан хугацааг оруулан тоолох тухай захирамждаа дурдана.

Сэжигтнийг баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллана гэж заасны дагуу сэжигтнийг сулласан тохиолдолд шүүгчид мэдэгддэггүй, суллагдсан сэжигтнийг яллагдагчаар татан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар шүүхэд санал ирүүлэхдээ саналын хамт, эсхүл хэрэгт сулласан талаарх баримтыг хавсаргаагүй зэрэг нөхцөл байдлаар шүүх ямар хугацаанд баривчилсан талаар дүгнэлт хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг тул прокурор сулласан талаарх баримтыг хэрэгт хавсаргаж байхыг анхаарах нь зүйтэй.

Олон улсын туршлагад хэргийн ээдрээ төвөгтэй байдал гэх үндэслэлийг хэрэглэх тохиолдол байдаг ч цагдан хорих ерөнхий зохицуулалт гэж үзэж шүүхээр нөхцөл байдлыг нэг бүрчлэн хэлэлцэж шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл хоригдох хугацаа уртсах тусам үндэслэлийг нотлох шаардлага өндөрсөнө гэсэн зарчим баримталдаг. Энэ үндэслэлийн талаар хуульчдын дунд ч нэг мөр ойлголт тогтоогүй байна. Харин тухайн нөхцөл байдлыг нэг бүрчлэн хэлэлцэж нотлох нь хүний эрхийг хязгаарлах үндэслэл болох ёстой. Судалгаанд оролцсон шүүгчид хэргийн ээдрээ төвөгтэй байдал гэх ойлголтод “хүнд гэмт хэрэг байх”, “гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал”, “холбогдсон хүний хувийн байдал”, хохирол хор уршгийн шинж чанар”, “нотлох ажиллагаанд цаг хугацаа их шаардагдах”, “мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл” зэргээр тайлбарласан бол прокурорууд “олон үйлдэлтэй, олон оролцогчтой”, “нийслэл болон орон нутаг дамжсан”, “шалгах ажиллагаа их, хэргийн хамрах хүрээ өргөнтэй”, “зүйлчлэлийн хувьд маргаантай”, “гэрч хохирогчид нөлөөж болзошгүй”, “гэм буруугийн хувьд маргаантай”, “урьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй”, “хэргийг түргэн шуурхай илрүүлэх, шалгах боломжгүй”, “мөрдөн шалгах ажиллагаанд аливаа хэлбэрээр саад учруулж байгаа”, “яллагдагчийн хувийн байдал”, “гэмт хэргийн шинж, нотолбол зохих байдлыг хангалттай бүрэн тогтооход учирч буй хүндрэл” зэргээр тайлбарлажээ. Харин өмгөөлөгчид “олон оролцогчтой”, “олон үйлдэлтэй, нийслэл, дүүрэг, аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин үйлдэгдсэн”, “илэрхий төвөгтэй нөхцөл байдал тогтоогдсон”, “нотлох ажиллагаа их шаарддаг” зэрэг үндэслэлүүдийг дэвшүүлсэн байна.[7]

Судлаачийн хувьд хэргийн ээдрээ төвөгтэй байдал гэх ойлголт нь хууль зүйн техникийн хувьд дангараа бус яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлага гэх ойлголттой хамтатган хэрэглэгдэх бөгөөд нэн тэргүүнд яллагдагчид анх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэл арилсан эсэхэд дүгнэлт хийх шаардлагатай. Хэргийн нотлогдвол зохих байдлууд, яллагдагчийн гэм буруу, тэр дундаа яллагдагч хэргээ хүлээхгүй байх, хэрэгт нотолбол зохих байдлууд тогтоогдохгүй байх, өргөн цар хүрээ бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд цаг хугацаа их шаардагдах зэрэг нь яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэх, хугацааг сунгах үндэслэл байж болохгүй гэж үзэж байна. Харин яллагдагчид авсан

[7] Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. Уб., 2023. 64-65 дахь тал.

цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зайлшгүй үргэлжлүүлэх, түүний хугацааг сунгах шаардлагыг нотолж, яллагдагчид цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх саад учруулах, яллагдагч дахин гэмт хэрэг үйлдэх, оргон зайлах зэрэг нөхцөл байдлууд бий болох бодит эрсдэлийг нотолсон баримт, мөн хууль хэрэглээнд тулгуурласан байх ёстой гэж үзэж байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглох зохицуулалтын хувьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, суллагдсан яллагдагчид урьд нь цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглоно гэж заасан. Энэ нь хуулийн нэг үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй гэсэн үг биш харин цагдан хорих үндэслэл, шалтгаан, түүнийг нотолсон баримтыг дахин хэрэглэхгүй гэсэн агуулга юм. Жишээлбэл яллагдагч А-г хулгайлах гэмт хэрэгт холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байх үед Б-н гэрт хууль бусаар нэвтэрч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаад сулласны дараа В-н гар утсыг хулгайлсан үйлдэл хийсэн бол дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа үндэслэлээр дахин авах боломжтой юм.

2.3. Шүүхийн зөвшөөрлөөр таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно гэсний дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь мөрдөгчийн саналыг үндэслэн прокуророос цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах саналыг шүүхэд гаргах ба шүүх саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчид мэдэгдэж шүүхийн хэлэлцүүлгийг хийж яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэж байна.

Прокуророос таслан сэргийлэх арга хэмжээ авахаар санал гаргахдаа шүүхэд шүүхийн хэлэлцүүлэгт бэлтгэх боломжит хугацааны дотор саналаа хүргүүлэх, тэр дундаа шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, өмгөөлөгч, хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагч, хуульд заасан тохиолдолд орчуулагч, хэлмэрч, өсвөр насны яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч зэрэг оролцогчдын шүүхийн хэлэлцүүлэгт оролцох эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай. Гагцхүү цагдан хорих бус хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хувьд ч шүүхэд саналаа хүргүүлэхдээ шүүхийн хэлэлцүүлэгт бэлтгэх хугацаа олгоогүйгээс шүүхийн хэлэлцүүлэг хойшлох, яллагдагч Монгол Улсын хилээр гарч оргон зайлах тохиолдол ч бий болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн зөвшөөрлөөр авах таслан сэргийлэх арга хэмжээг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тусгайлан зааж хуульчлаагүй тул мөн хуулийн 2.2 дугаар зүйлд заасан шүүхийн нийтлэг харьяаллын талаарх зохицуулалтыг хэрэглэнэ. Мөн зүйлд зааснаар шүүхийн харьяаллыг “Хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ”, “Гэмт хэрэг нь хэд хэдэн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлчийн гэмт хэрэг үйлдэгдсэн газрын харьяалах шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ”, “Гэмт хэрэг нэг шүүхийн харьяалах газар эхэлж, нөгөө шүүхийн харьяалах газарт төгссөн бол

төгссөн газрын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ", "Эрүүгийн хэргийн оролцогч, гэрчийн олонх байгаа газарт, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжийн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн шүүхийн харьяаллыг прокурорын саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоож болно" гэж зааж өгсөн байна.

Практикт мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон прокурорын хяналтын харьяаллыг прокурорын байгууллага тогтоож байгаа бол шүүхийн харьяаллыг хуульд заасан гэмт хэрэг гарсан газрын шүүх шийдвэрлэхээр эргэлзээгүй, ойлгомжтойгоор зааж өгсөн тул Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоосноос бусад тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг газар нутгийн зарчимд тулгуурлан гэмт хэрэг гарсан газрын шүүхэд хүргүүлэх шаардлагатай. Ийнхүү шүүхийн харьяаллыг буруу тогтоож прокурор саналаа хүргүүлснээс харьяаллын бус шүүх саналыг хүлээн авахаас татгалзах, шийдвэрлэхгүй байх, шүүхийн харьяаллын талаар оролцогч нар маргах зэрэг нөхцөл байдал үүсэж цаг хугацаа алдах, яллагдагч оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зэргээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтууд алдагдахад хүрдэг байна.

2.4. Өсвөр насны хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх ажиллагааны онцлог

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэрэгт процесс ажиллагаа явуулах тусгай журмыг хуульчилжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлд заасан журмаар явагдах өсвөр насны яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг хаалттай явагдана. Хэлэлцүүлэгт өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна. Хэдийгээр өсвөр насны яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч хүрэлцэн ирээгүй нь шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлд зааснаар өсвөр насны яллагдагч оролцох процесс ажиллагааг өмгөөлөгчгүй явуулж огт болохгүй.

2.5. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах нь

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Прокурор, оролцогч энэ хуулийн 12.3, 13.1, 13.2, 13.5, 13.7, 14.4, 14.5, 14.13, 19.2, 19.3 дугаар зүйл, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргаж болно гэж заажээ. Энэхүү гомдол гаргах зохицуулалт нь анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн шийдвэрт хамаарахгүй. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үед тодруулбал таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой гаргасан шийдвэрт оролцогч гомдол гаргах эрхгүй юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч данган гаргасан шийдвэрийн талаарх гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр эцсийн байна. Гомдол гаргагч гомдлыг хянан шийдвэрлэхэд оролцож, гомдлын үндэслэл, нотолгоо, шаардлагатай баримт бичгийг гаргаж танилцуулах эрхтэй. Гомдол гаргагч шүүхэд хүрэлцэн ирээгүй нь шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй. Шүүх гомдлыг хянан шийдвэрлээд гомдлыг хангаж, шүүхийн шийдвэрийг өөрчлөх; гомдлыг

хангахгүй орхих шийдвэрийн аль нэгийг гаргана. Шүүхээс баривчлах зөвшөөрөл олгосон шийдвэрт гомдол гаргах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуульчлаагүй тул баривчлах зөвшөөрөл олгосон захирамжид гомдол гаргахгүй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном товхимол, гарын авлага, судалгааны материал:

1. С.Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхийн толь бичиг. Уб., 2021. 380 дахь тал.
2. Г.Баясгалан, Ж.Бямбаа нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ., 2003. 79-80 дахь тал.
3. Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурор, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Дугаар 58, А/87, 203 тушаал, захирамж. Уг тушаалын хавсралтаар батлагдсан Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журам.
4. С.Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Уб., 558 дахь тал.
5. Г.Баясгалан, Ж.Бямбаа нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. Уб., 2003. 81 дэх тал.
6. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. Уб., 2023. 44-45 дахь тал.
7. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. Уб., 2023. 64-65 дахь тал.

БҮЛЭГ 11. ШҮҮХ ХУРАЛДААНД БЭЛТГЭХ, ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭН

СЭДЭВ 1. ХЭРГИЙГ ХЯНАХ, ШҮҮХ ХУРАЛДААНД БЭЛТГЭХ ҮЕ ШАТАНД АНХААРАХ АСУУДЛУУД

1.1. Прокурор шүүх хуралдаан, мэтгэлцээнд бэлтгэхийн ач холбогдол
1.2. Хэргийн бүрдэл хангагдсан эсэхийг хянах
1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн аливаа зөрчлийг мөрдөгч гаргасан эсэхийг хянах
1.4. Хэргийн онол боловсруулах буюу прокурорын яллах дүгнэлт үйлдэх нь
1.5. Хэргийн түүвэр хийх

СЭДЭВ 2. ШҮҮХ ХУРАЛДААНД УЛСЫН ЯЛЛАГЧ ЯЛЛАХ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2.1. Шүүх хуралдаанд асуух асуултуудаа урьдчилан бэлтгэх
2.2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх
2.3. Мэдүүлгээс бусад нотлох баримтуудыг шинжлэн судлахад бэлтгэх
2.4. Улсын яллагчийн дүгнэлтийн үг бэлтгэх
2.5. Шүүх хуралдаанд бэлтгэх бусад зүйлс

СЭДЭВ 1. ХЭРГИЙГ ХЯНАХ, ШҮҮХ ХУРАЛДААНД БЭЛТГЭХ ҮЕ ШАТАНД АНХААРАХ АСУУДЛУУД

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд шүүх хуралдаанд бэлтгэхэд улсын яллагчийн анхаарах шаардлагатай асуудлууд, хэргийг хянахад гаргадаг алдаануудын талаар авч үзнэ.

1.1 Прокурор шүүх хуралдаан, мэтгэлцээнд бэлтгэхийн ач холбогдол

Прокурорын байгууллагын тухай хуульд заасан прокурорын гүйцэтгэх чиг үүргүүдээс “Прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно” гэсэн чиг үүрэг хамгийн чухал бөгөөд хамгийн хариуцлагатай нь билээ. Өөрөөр хэлбэл прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргүүдийг гүйцэтгэхдээ илүү нэг талын шинжтэй, давуу эрхтэй, удирдсан, захирамжилсан байдалтай оролцдог бол эрүүгийн шүүх хуралдаанд оролцохдоо хөндлөнгийн байр суурьтай шүүхийн өмнө мэтгэлцэгч талуудын нэг тал нь болж оролцдог, түүнчлэн нөгөө талтайгаа ижил эрх эдэлдэг, мөрдөн байцаалтын шатанд гаргасан түүний шийдвэр хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шүүхээр дүгнүүлдэг тул илүү хариуцлагатай, илүү ур чадвар шаардсан байдгаараа онцлогтой юм[1].

Монгол Улсад шүүн таслах ажиллагааг талуудын мэтгэлцээний үндсэн дээрээс явуулдаг.

Хараат бус хөндлөнгийн шүүгчийн өмнө шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг талууд өрсөлдөх хэлбэрээр нотолдог, маргаан шийдвэрлэх ажиллагааны нэгэн төрлийг мэтгэлцээн гэдэг[2].

---

[1] “Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтын гарын авлага 38 дахь тал, УЕПГ, 2018

[2] “Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтын гарын авлага 39 дэх тал, УЕПГ, 2018

Мэтгэлцээний нэг тал болох улсын яллагчийн шүүх хуралдаанд оролцох хэлбэр нь идэвхтэй, эсрэг талтайгаа өрсөлдөх байдлаар мэтгэлцэж оролцох ёстой нь эндээс урган гарч байна.

Манай эрх зүйн тогтолцоогоор шүүх хуралдаанд оролцож байгаа прокурор өмгөөлөгчөөс юугаараа давуу вэ? гэдэг асуулт гарч ирнэ. Энэ нь:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьсан;
- Прокурорын яллах дүгнэлт үйлдсэн;
- Хэргийг өөрийн дотоод итгэл дээр тулгуурласан шийдвэрийн дагуу шүүхэд ирүүлсэн гэх мэт байдлуудаараа давуутай.

Эндээс өмгөөлөгч ямар байж мэтгэлцээнд оролцон, энэ давуу эрхтэй яллагчтай мэтгэлцэх вэ? гэвэл мэдээж ур чадвартай байж мэтгэлцэнэ. Тэгвэл энэ ур чадвартай өмгөөлөгчтэй прокурор яаж мэтгэлцэх вэ?, бас л ур чадвартай байж мэтгэлцэнэ гэсэн ойлголт гарч ирж байна.

Өөрөөр хэлбэл мэтгэлцээн нь зөвхөн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурласан байхаас гадна, мэтгэлцээнд оролцогчийн мэдлэг, чадвар, хуримтлуулсан туршлага, илтгэх ур чадвар, өөртөө итгүүлэн үнэмшүүлэх чадвар, тодорхой аргачлал /байцаалт явуулах тактик, уран ярих чадвар гэх мэт/ зэрэг дээр тулгуурлан явагддаг учир эдгээр ур чадваруудыг аль болохоор бүгдийг нь эзэмшсэн байх нь хамгаас чухал юм.

Мэтгэлцээн анхан шатны шүүхэд жинхэнэ утгаараа хэрэгжих нь тодорхой билээ. Учир нь энэ шатанд хэргийг ямарваа нэгэн байдлаар шийдвэрлээгүй байдаг тул талууд хэрхэн өөрсдийгөө ойлгуулах, яаж мэтгэлцэх зэрэг нь тодорхой бус байдаг, түүнчлэн ямар асуулт тавих, ямар тайлбар дүгнэлт хийх зэрэг нь мөн тодорхойгүй байдаг тул талууд бүх талаар мэтгэлцэж өөртөө давуу байдал бий болгох нь эн тэргүүний зорилго нь болдог.

Шүүх хуралдаанд бэлтгэлтэй оролцох нь амжилт авчрах нэг үндэс болдог. Шүүх хуралдаанд бэлтгэхдээ дараах зүйлүүдийг анхаарсан байвал зохино. Үүнд:

1. Хэргийн бүрдэл бүрэн хангагдсан эсэхийг хянах;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн аливаа зөрчлийг мөрдөгч гаргасан эсэх;
3. Хэргийн онол боловсруулах /яллах дүгнэлт үйлдэх/;
4. Хэргийн түүвэр хийх;
5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх;
6. Шүүх хуралдаан ашиглах техник хэрэгсэл, бусад зүйлсийг бэлтгэх;
7. Шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчээс асуух асуултуудаа урьдчилан бэлдэх;
8. Мэдүүлгээс бусад нотлох баримтыг шинжлэн судлахад бэлтгэх;
9. Улсын яллагчийн дүгнэлтийн үг бэлтгэх зэрэг болно.

1.2 Хэргийн бүрдэл хангагдсан эсэхийг хянах:

Хэргийг дутуу хянах, хэргийн бүрдэл дутуу хэргийг шүүхэд шилжүүлсэн хэрэг прокурорт буцах, хэрэгсэхгүй болгогдож цагаатгагдах шалтгаан нөхцөл болдог. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанууд хэрэгт бүрэн хийгдсэн эсэхийг заавал хянах ёстой. Үүнд:

- гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;
- гэмт хэргийг хэн үйлдсэн;
- гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх,

хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Гэмт хэрэг гарсан байдал хангалттай тогтоогдсон эсэх, гэмт хэргийг хэн үйлдсэнийг илрүүлсэн эсэх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, гэм буруугийн сэдэлт, санаа зорилгыг зөв тогтоосон эсэх, яллагдагчийн хувийн байдлыг тогтоох ажиллагаа бүрэн хийгдсэн эсэх, хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг тогтоосон болох, хохирлын хэр хэмжээг зөв тогтоосон эсэх талаас нь нарийвчлан хянах ёстой.

Ялангуяа шүүгдэгчид хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээг зөв тогтоох тухайлбал эд хөрөнгийн хариуцлага хүлээх чадвар, чадамжтай эсэхийг тогтоосноор эд хөрөнгөтэй болох нь тогтоогдвол торгуулийн ялын санкци хэрэглэж болохыг урьдаас мэдэх боломжтой болсноор ял биелэх боломж нь эндээс урган гардгийг анхаарах хэрэгтэй.

1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн аливаа зөрчлийг мөрдөгч гаргасан эсэхийг хянах

Мөрдөгчөөс хэргийг шалгах үедээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчих зөрчлүүд гаргах нь түгээмэл байдаг.

Процессын зөрчил гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, хүний эрхийг хөндсөн буюу хязгаарласан, зөрчсөн, нотлох ажиллагааг хууль бусаар хийсэн ноцтой зөрчил дутагдлууд байдаг бөгөөд хуулиар хориглосон үйлдлийг хийсэн эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй үйлдэл гэж товчхондоо тодорхойлж болно. Практикт мөрдөгч хууль зөрчсөн олон зөрчлийг гаргадаг. Хэдийгээр ихэвчлэн ажлын ачаалал их, орон тооны хүрэлцээ дутуу зэргээс шалтгаалж аргагүйгээс мөрдөгч хууль зөрчсөн мэт харагддаг ч прокурор хууль зөрчсөн аливаа зөрчилд нүд дасаж, тоохгүй орхиж болдоггүй. Учир нь хэрэг шүүхээр шийдвэрлэгдэх үед процессын зөрчилд тооцогдоод нотлох баримтад тооцогдохгүй болдог сөрөг үр дагавар үүсдэг. Жишээлбэл гэмт хэрэгт холбогдсон этгээдийг гэрчээр байцааж, гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн мэдүүлгийг хэргийн гол нотлох баримт болголоо гэхэд шүүхээс нотлох баримтад тооцохгүй байх боломжтой.

Өөрөөр хэлбэл зөрчлийг засуулалгүйгээр хэргийг шүүхэд шилжүүлснээс шүүх хэргийг шийдвэрлэлгүйгээр прокурорт буцаадаг зөрчлүүд нийтлэг байдаг. Жишээлбэл сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүнийг гэрчээр асуухдаа гэр бүлийн гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаагүйн улмаас гэр бүлийн гишүүний эсрэг мэдүүлэг өгсөн, шинжээчийн дүгнэлт гаргахдаа мөрдөгчийн тогтоолд дурдсанаас өөр бүрэлдэхүүн дүгнэлт гаргасан, хэрэгт холбогдсон этгээдээс гэрчээр мэдүүлэг авахад хэргээ хүлээн мэдүүлсэн, энэ нь өөр нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй зэрэг зөрчилтэй нотлох баримтуудыг прокурор гол нотлох баримтаа болгосныг шүүхээс нотлох баримтаар тооцохгүйд хүрдэг, улмаар хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг тохиолдлууд гардаг билээ.

Иймээс ямар ч тохиолдолд хэргийг хянаад хууль зөрчсөн аливаа зөрчил илэрвэл прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд зөрчлийг засуулах, засагдах боломжгүй тохиолдолд нотлох баримтаас хасах шийдвэр гаргах, мөрдөгчид хариуцлага тооцуулах зэрэг ажиллагааг хийсний үндсэн дээрээс хэргийг шүүхэд шилжүүлдэг байх хэрэгтэй.

1.4 Хэргийн онол боловсруулах буюу прокурорын яллах дүгнэлт үйлдэх нь

“Хэргийн нөхцөл байдал, үйл баримтууд, тэдгээрт хамаарах хуулийн заалтуудыг

сайтар судалж үзсэний үндсэн дээр өөрт ашигтай шийдвэр гаргуулахын тулд сонгож авсан хувилбаруудын хамгийн оновчтойг нь хэргийн онол гэнэ[3]."

Прокурорын хувьд хэргийн онол нь прокурорын яллах дүгнэлт юм. Шүүх хуралдаанд прокурорын хэргийн онол тодорхой байдаг. Харин өмгөөлөгчийн хувьд хэргийн онол нь юу вэ? гэвэл тухайн хэрэг маргааны жинхэнэ дүр зураг нь чухам юу байсан бэ гэдгийг шийдвэр гаргагчид ойлгуулахад чиглэгдсэн хувилбар нь юм. Жишээлбэл: Прокурор санаатайгаар бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр алсан гэсэн яллах дүгнэлт үйлдсэн байхад өмгөөлөгч аргагүй хамгаалалтын үүднээс биеэ хамгаалж хүний амь хохироосон гэсэн хувилбарыг сонгож өмгөөлөхийг ойлгоно. Хэргийн онолоо гаргахын тулд талууд хэргийг маш нарийн, нягт, нямбай уншиж, тал бүрээс нь сайтар судалж байж гаргах ёстой.

Хэргийн онол нь:

- ойлгомжтой, тодорхой байх
- хуулийн холбогдох заалтуудад нийцсэн байх
- нотлох баримтуудаар батлагдсан байх
- эсрэг талын байж болох няцаалтад тэсвэртэй байх
- үнэмшилтэй байх гэсэн шаардлагуудыг хангасан байвал зохино.

Ойлгомжтой тодорхой байх *гэдэг нь улсын яллагчийн зүйлчилж байгаа Эрүүгийн хуулийн зүйл хэсэг нь хэргийн утгад таарсан байх ёстой.*

Хуулийн холбогдох заалтуудад нийцсэн *гэдэг нь холбогдогчийн үйлдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хангасан байхыг ойлгоно.*

Нотлох баримтуудаар батлагдсан байх *гэдэг нь холбогдогчийн үйлдсэн гэмт хэрэг нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтуудаар нотлогдсон байх ёстой.*

Эсрэг талын байж болох няцаалтад тэсвэртэй байх *гэдэг нь тухайн хэргийг дүгнэхдээ хэрвээ би өмгөөлөгч бол ямар байдлаар тухайн хэргийг үнэлэх вэ гэдгийг ямагт урьдаас тооцоолох хэрэгтэй болдог. Ингэснээр эсрэг талын хууль зүйн дүгнэлтийг иймэрхүү байдлаар няцаана гэсэн таамаглалыг прокурор заавал боддог байх хэрэгтэй. Тиймээс прокурорын шийдвэр нь, хэргийн зүйлчлэл нь хууль ёсны бөгөөд үндэслэлтэй гарснаар эсрэг талын няцаалтад тэсвэртэй байдаг.*

Үнэмшилтэй байх *гэдэг нь прокурорын хууль зүйн дүгнэлт нь нотлох баримтуудаар нотлогдсон, гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан байхаас гадна тухайн хэргийг үйлдсэн гэх итгэл үнэмшил төрөхүйц байхыг ойлгоно.*

Прокурорын яллах дүгнэлт үйлдэх аргачлал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд прокурорын яллах дүгнэлт хэрхэн бичих аргачлалыг тодорхой заагаагүй байдаг.

Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж, улмаар мөрдөн байцаалтыг дуусган ирүүлсэн хэргийг хянаад гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бөгөөд шүүхээр гэм бурууг тогтоолгох нь зүйтэй гэж үзвэл хэрэгт прокурорын яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлдэг.

Хэдийгээр хуульд шууд заагаагүй боловч прокурорын яллах дүгнэлт нь шүүхийн

[3] "Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх нь" сургалтын гарын авлага 48 дахь тал, УЕПГ, 2018

тогтоолын нэгэн адил хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх ёстой.

Хууль ёсны байх: Прокурорын яллах дүгнэлт нь хуулийн бүх шаардлагад нийцсэн байх ёстой. Прокурорын хэрэглэж байгаа хууль нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа, Үндсэн хуульд нийцсэн байх нь дамжиггүй юм. Түүнчлэн эрх зүйн зарчмуудад нийцсэн байх ёстой. Тухайлбал шударга ёсны, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх зарчим зэрэг болно.

Үндэслэлтэй байх: Прокуророос хэргийг хянах явцдаа мөрдөн байцаалтаар цугларсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжилсний үндсэн дээр гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэсэн дотоод итгэл төрж улмаар энэ дотоод итгэлийн үндсэн дээрээс яллах дүгнэлт үйлдэх нөхцөл бүрддэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэнийг нотолж байгаа үндэслэлтэй нотлох баримтуудад дүгнэлт хийж яллах дотоод итгэл төрж байгаа нь яллах дүгнэлтийг үндэслэлтэй болгодог байна.

Хэргийг хянахдаа нотлох баримтуудыг тал бүрээс нь авч үздэг хэдий ч нэгэнт дотоод итгэл нь яллах нь зүйтэй гэж үзсэн бол прокурорын яллах дүгнэлт нь зөвхөн яллах талын нотлох баримтуудаас бүрдэх ёстой болдог.

Хэдийгээр хуульд зөвхөн яллах талын баримтуудыг оруулсан байхаар зохицуулаагүй боловч нь энэ шүүх хуралдаанд прокурор нь улсын яллагчаар оролцож шүүгдэгчийг яллах ажлын үндсэн чиг үүргээс нь урган гарч байгааг анхаарах нь зүйтэй.

Прокурорын яллах дүгнэлтийн бүтэц:

Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох хэсэг, хавсралтаас бүрдэнэ[4].

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тэмдэглэх хэсэгт ямар зүйлс агуулагдсан байхыг заасан.

Тэмдэглэх хэсэгт яллагдагчийн овог, эцгийн нэр, нэр, биеийн байцаалттай холбоотой мэдээллүүд, түүний үйлдсэн хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, арга, сэдэлт, санаа, зорилго, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай зарим нотлох баримт зэргийг дурдана.

“Хэргийн товч агуулга” гэдэгт тухайн гэм буруутай этгээд Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэргийг хэзээ, хаана үйлдсэн, уг гэмт хэрэгт хамтран оролцогчоор оролцсон эсэх, уг гэмт хэрэг нь төгссөн эсэх, гэм бууругийн ямар хэлбэртэй болох зэргийг хамруулсан байвал зохино.

“Зайлшгүй шаардлагатай зарим нотлох баримт” гэдэгт яллагдагчийн гэм бурууг нотолж байгаа зайлшгүй шаардлагатай нотлох баримтуудын товчлолыг ойлгоно. Эрүүгийн хэрэгт цугларсан бүх нотлох баримтуудыг яллах дүгнэлтэд тусгах боломжгүй бөгөөд тухайн прокурор өөрөө гол гэж үзсэн яллах талын нотлох баримтуудаа товчлон авсан байх ёстой. Энд нэг анхаарах зүйл бол үйлдэл тус бүрийг нотолж байгаа нотлох баримтуудаас оруулсан байх ёстой. Жишээлбэл 20 удаагийн үйлдлээр бусдыг залилсан талаар яллах дүгнэлт бичихдээ хохирогч Доржийг залилсан үйлдлийг нотолсон нотлох баримтуудыг орхигдуулж болохгүй бөгөөд эдгээр 20 үйлдэл тус бүрийг нотолсон нотлох баримтууд яллах дүгнэлтээс харагдах ёстой. Өөрөөр хэлбэл Доржийг залилсан гэж бичсэн атлаа хэрхэн залилсан талаарх нотлох баримтууд яллах дүгнэлтээс харагдахгүй бол энэхүү үйлдэлд нь яллах дотоод итгэл прокурорт төрөөгүй байна гэж үзэж болно.

Гэхдээ яллах талын мэдүүлэг өгч байгаа гэрчийн мэдүүлгийг бүгдийг нь бүрэн эхээр нь хуулбарлах биш, харин мэдүүлгийн яг аль хэсэг нь яллах баримт болж

[4] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

байна, тэр хэсгийг нь хуулбарлан буулгах хэрэгтэй. Ингэхдээ мэдүүлгийн утга, найруулгыг өөрчилж болохгүйг анхаарах нь зүйтэй.

Яллах дүгнэлт бол прокурорын гол шийдвэр тул хуульчийн ур чадварыг харуулсан, хууль хэрэглэж үндэслэлээ гаргадаг, нотлох баримтуудаа дүгнэж бичдэг байх нь зүйтэй. Үүнд нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж бэхжүүлж авсан, хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлдэг болох, харилцан зөрүүтэй нотлох баримтуудын алийг нь үнэн зөв гэж үзсэн үндэслэлээ дүгнэх, буруу гэж үзсэнээ үгүйсгэх байдлаар бичих шаардлагатай бөгөөд яллах дүгнэлт нь товчхондоо яллаж байгаа баримтуудыг дүгнэж байгаа прокурорын шийдвэр юм.

Нотлох баримтуудыг жагсаан бичсэний дараа дээрх нотлох баримтуудаар гэм буруутай нь тогтоогдож байх тул гэж дүгнэх явдал нийтлэг байна. Энэ нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "*Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно*", Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ", Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй" гэсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байна. Иймд гэмт хэргийг үйлдсэн гэх үзэх үндэслэлтэй байх тул гэх маягаар бичиж байх нь зүйтэй.

Яллах дүгнэлтийн тогтоох хэсэг нь бүтцийн хувьд ямар байх, юу юу агуулагдаж байхыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт нэг бүрчлэн заасан байдаг.

Тогтоох хэсэг бол хамгийн чухал хэсэг бөгөөд яллагдагч ямар гэмт хэрэг үйлдсэн, тэр нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт нийцэж байгаа, хэргийг хаанахын шүүхэд шилжүүлэх зэрэг зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгасан байна. Энд анхаарах ёстой нэг зүйл бол яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн хэд хэдэн яллагдагчтай бөгөөд яллагдагч нарын үйлдсэн гэмт хэргүүд нь өөр өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байгаа бол Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг нэг бүрийг нэг бүрчлэн бичсэн байх ёстой байдаг. Өөрөөр хэлбэл эндээс ямар хэрэг үйлдсэн, энэ нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсгээр зүйлчлэгдэж байгаа нь тодорхой харагдах ёстой.

Түүнчлэн яллах дүгнэлтийн доод хэсэгт үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, зэрэг дэв зэргийг тодорхой тусгах ёстой.

Яллах дүгнэлтийн хавсралт хэсэгт юу хамаарахыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан байдаг. Үүнд:

1. шүүх хуралдаанд шинжлэн судлах нотлох баримт;
2. шүүх хуралдаанд мэдүүлэг авахаар дуудах оролцогч, бусад оролцогчийн нэр;
3. яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, хугацаа, холбогдох мэдээлэл;
4. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, нөхөн төлөгдсөн байдал;
5. яллагдагч тус бүрийн хариуцах хохирлын хэмжээ;
6. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, битүүмжилсэн эд хөрөнгө, эд мөрийн баримт;
7. хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа бол яллагдагчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээний талаарх санал зэргийг тусгана.

Хавсралт хэсэгт таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх, түүний хугацаа, эд мөрийн баримт, битүүмжилсэн эд хөрөнгийн талаарх тодорхойлолт, иргэний нэхэмжлэл, түүнийг хангах талаар авсан арга хэмжээ, шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулбал зохих гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч болон бусад оролцогчдын талаарх санал зэргийг заавал тусгасан байвал зохино.

“Эд мөрийн баримт, битүүмжилсэн хөрөнгийн талаарх тодорхойлолт” гэдэг нь тухайн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан ямар ямар эд зүйлсийг хэргийн хамт шилжүүлж байгаа, хэрвээ хэргийн хамт шилжүүлэх боломжгүй байгаа бол хаана хадгалж байгааг, битүүмжилсэн ямар ямар эд хөрөнгө хаана, ямар байдалтай байгаа болохыг тодорхой тусгасан байвал зохино.

“Иргэний нэхэмжлэл, түүнийг хангах талаар авсан арга хэмжээ” гэдгийг гэмт хэргийн улмаас хохирогч, иргэний нэхэмжлэгчид ямар хэмжээний хохирол учирсан, яллагдагч төлсөн эсэх, хэдий хэмжээний төлбөр төлбөл зохих зэргийг тусгах ёстой.

“Шүүх хуралдаанд зүйлшгүй оролцуулбал зохих гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч болон бусад оролцогчдын талаархи санал” гэдэг нь улсын яллагчаас шүүх хуралдаанд ямар арга тактиктай оролцох гэж байгаа арга зам нь бөгөөд мэтгэлцээнд өөртөө давуу тал олж авах боломж тул эдгээрийг оролцуулах талаар шүүхэд хүсэлт гаргаж байгааг ойлгоно.

1.5 Хэргийн түүвэр хийх

Хэргийг хянахдаа түүвэр хийж унших нь нотлох баримтуудыг бодитойгоор үнэлэх, хэргийг тал бүрээс хянахад ихээхэн тус дөхөм болдог.

Хэргийн түүвэр хийж унших, хянах талаар хууль тогтоомжид заасан ямар нэг зохицуулалт байдаггүй ч хуульчдын дунд хэргийн түүвэр хийх ажиллагаа үе уламжлагдсаар ирсэн билээ.

Манай тогтолцоогоор эрүүгийн хавтаст хэрэг нэг л байдаг тул хэргийн түүвэр хийж унших нь маш олон талын ач холбогдолтой байдаг. Үүнд:

1. Шүүх хуралдаанд бэлтгэх, мэтгэлцээнд ашиглахад хамгийн их ач холбогдолтой байдаг. Шүүх хуралдаанд хэрхэн яаж оролцох, ямар асуулт асуух, нотлох баримтууд хавтаст хэргийн хэддүгээр хуудсанд байгаа, хэрхэн мэдүүлсэн болох, юуг нотолж байгаа зэргийг тодорхой харж дүгнэлт хийж болдог.
2. Хэргийг хянах явцад мөрдөгчөөс ямар алдаа, зөрчил гаргасан, түүнийг хэрхэн засуулах, эсхүл нотлох баримтаас хасуулах зэргээр ямар арга хэмжээ авах арга замыг зааж өгдөг.
3. Шүүх хуралдаанд хэрхэн яаж оролцох, ямар асуулт асуух, нотлох баримтууд хавтаст хэргийн хэддүгээр хуудсанд байгаа, хэрхэн мэдүүлсэн болох, юуг нотолж байгаа зэргийг тодорхой харж дүгнэлт хийж болдог.
4. Хэрэгт хийгдээгүй байгаа дутуу ажиллагаануудыг хэргийн түүврээс харах бүрэн боломжтой бөгөөд энэ нь прокуророос нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр прокурорын даалгаварын заалт нь болдог.
5. Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол, эсэргүүцэл бичихэд тус дөхөм болдог зэргээр түүврийг тал бүрээс нь ашиглаж болдог байна.

Нотлох баримтуудыг судалж дүн шинжилгээ хийхдээ эсрэг талдаа ашигтай байгаа нотлох баримтуудыг ч бас сайтар анхаарах нь чухал, түүнчлэн энэ тохиолдолд прокурор нь хэрвээ би өмгөөлөгч байсан бол ямар хувилбараар өмгөөлөл явуулах, ямар үед нь ямар нотлох баримтад гол анхаарлаа хандуулах вэ гэдгийг урьдаас төлөвлөсөн байх нь чухал байдаг. Ингэснээр бодит үнэнд тулгуурласан шийдвэр гаргахаас гадна шүүх хуралдаанд эсрэг тал нь ингэж хэлбэл би ингэж няцаалт өгнө

гэдгийг урьдчилан таамаглаж бэлтгэсэн байх ёстой.

Хэргийн түүврийг тухайн прокурор өөрт амар байдлаар ямраар ч хийж болдог. Тухайлбал хүснэгтээр хийх, түүвэрчлэн бичих, гол гол нотлох баримтуудыг хуулбарлан авах зэргээр хийж болохын зэрэгцээ хамгийн чухал нь хэргийн нэгэн адил нууцлалыг ямагт хангаж байх учиртай.

Хэрэг шүүхэд шилжээд шийдвэрлэгдэхгүй удаашрах, улсын яллагч солигдох зэргээр хэргийн нотлох баримтыг мартах, дахин унших зайлшгүй шаардлага гардаг тул хэргийн түүвэр нь цаг ямагт прокурорын зайлшгүй хэрэгцээт зүйлс байсаар ирсэн. Прокурорын ажлын гол үүрэг нь тухайн прокуророос хэргийн материалтай сайтар танилцсан байх, нягт нямбай байхыг тогтмол шаарддаг тул хэргийн түүврийг тогтмол ашигласаар ирсэн билээ. Хамгийн чухал нь хэргийн түүвэр хийснээр тухайн хэргийн материалтай системтэй танилцахад тус дөхөм болохын зэрэгцээ шүүх хуралдаанд өргөнөөр ашигладаг давуу талтай.

СЭДЭВ 2. ШҮҮХ ХУРАЛДААНД УЛСЫН ЯЛЛАГЧ ЯЛЛАХ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2.1. Шүүх хуралдаанд асуух асуултуудаа урьдчилан бэлтгэх

Аливаа зүйлд урьдаас бэлтгэнэ гэдэг амжилт олохын эх үндэс болдог.

Шүүх хуралдаанд талууд хэдий чинээ бэлдэнэ төдий чинээ амжилтад хүрэх нь дамжиггүй юм.

Асуултыг зөв сонгож асуух нь маш чухал байдаг. Өөрөөр хэлбэл асуулт асуух чадварыг эзэмшээгүйгээр мэтгэлцээнд ялалт байгуулна гэж санах ч хэрэггүй. Асуулт бол мэтгэлцээн дэх довтолгооны гол зэвсэг нь байдаг. Иймээс асуулт тавих дараах тактикуудыг мэдсэн байвал зохино.

1. Цаг гарздахгүйн тулд хэрэгт хөдөлбөргүй, гарцаагүй нотлогдсон зүйлийг дэлгэрэнгүй асуухгүй байх;
2. Зорилгогүй, эргэлзээтэй асуулт тавихгүй байх / өөрөөр хэлбэл юу гэж хариулахыг нь гадарлаагүй байж өөрийгөө унагах асуулт тавихгүй байх/;
3. Асуулт нь хэргийнхээ онол руу чиглэсэн байх;
4. Мэдүүлгийг өөрийнхөө хяналтандаа авсан байх;
5. Асуултын дарааллыг логиктой тавих;
6. Асуултуудаа урьдчилан бэлтгэсэн байх;
7. Асуултанд хэрхэн хариулахыг урьдчилан таамагласан байх;
8. Асуулт тавих хэв маягийг тааруулсан байх /өөрөөр хэлбэл дуугаа чангаруулан зандрах маягаар асуух, эсвэл зөөлөн намуун дуугаар асуух, өөрт ашигтай өгсөн хариултыг дэмжих, толгой дохих гэх мэт/.

Нээлттэй асуулт: Энэ нь мэдүүлэг өгч байгаа этгээдээр мэдэж байгаа зүйлийнх нь талаар дэлгэрэнгүй яриулахаар асуусан асуулт юм. Жишээлбэл: 5 сарын 10-ны өдөр юу болсон бэ? Та ярьж өгнө үү гэх мэт. Энэ асуултыг өөрийн талд ашигтай, тодорхой мэдүүлэг өгч байгаа этгээдэд тавих нь ач холбогдолтой.

Хагас нээлттэй асуулт: Нээлттэй асуултыг бодвол хариултын хүрээг нь ямар нэгэн байдлаар хязгаарлаж асуусан асуулт юм. Гэхдээ харьцангуй чөлөөтэй байдаг. Жишээ нь: та тэр өдөр хаалгаар орж ирээд юу харсан бэ? Энэ асуултыг мөн өөрийн талд ашигтай мэдүүлэг өгч байгаа этгээдээс асуух нь зохимжтой байдаг.

Хаалттай асуулт: Хариултыг явцуу хүрээнд хязгаарласан бөгөөд зөвхөн

өөртөө ашигтай зүйлийг хэлүүлэх буюу сонирхсон зүйлээ хэлүүлэхэд чиглэгддэг асуултыг хаалттай асуулт гэнэ. Жишээлбэл: Дулмааг хэн хутгалсан бэ? Энэ асуултыг эсрэг талд ашигтай мэдүүлэг өгч байгаа этгээдийг байцаахдаа хэрэглэх нь дээр байдаг.

Асуулт тавих хэлбэрээр нь:

- хөтөлсөн асуулт /байцааж байгаа этгээдээрээ өөрийнхөө хүссэн хариултыг хэлүүлэхэд чиглэгдсэн асуулт. Жишээ нь: Та орж ирэхдээ Болд гартаа хутга барьсан байсныг харсан тийм үү?/
- хөтлөгүй асуулт /хариултыг өөрийнхөөрөө өгөхийг нь зөвшөөрсөн асуулт. Жишээ нь: Тэнд юу болсон бэ?/
- тулгасан асуулт /шууд хамааруулан асуусан асуулт. Өөрөөр хэлбэл энэ нь өөрийнхөө хүссэн агуулгатай хариултыг заавал хүлүүлэх гэсэн зүй бус асуулт юм. Жишээ нь: Та Батыг алсан уу?/
- лавласан асуулт /дахин тодруулан асуусан асуулт. Жишээ нь: Та сая Долгорыг мөнгөтэй явж байхыг харсан гэж хэлэв үү дээ?/
- баталгаажуулсан асуулт /өмнө нь яригдсан зүйлийг дахин давтуулж, баталгаажуулах маягаар асуусан асуулт. Жишээ нь: Та өмнө нь мэдүүлэхдээ хохирогчийг согтуу байсан гэж хэлж байсан, хэдий хэмжээний согтолттой байсныг нь та дахин хэл дээ?/
- хувилбаргүй асуулт /зөвхөн нэг зүйлийн талаар хариулт шаардсан асуулт. Жишээ нь: Та тэнд Доржийг харсан уу?/
- хувилбартай асуулт /хэд хэдэн зүйлүүдээс аль нэг хувилбарыг нь сонгож хариулах боломжтой асуулт. Жишээ нь: Та тэнд Дорж, Бат, Тулга нарын хэнийг нь харсан бэ?/
- жишээ татсан асуулт /Байцааж байгаа хүндээ жишээ гаргаж өгч өөрт ашигтай мэдүүлэг авах зорилгоор асуудаг асуулт. Энэ хэлбэрийг шинжээч нараас асуух нь илүү тохиромжтой байдаг. Тухайлбал: миний нэг танил ямар нэгэн байдлаар гэмтэл аваагүй мөртлөө бүдүүн гэдэс нь цоорсон байдаг, тэгвэл та яагаад хохирогчийн бүдүүн гэдэсний цооролтыг гэмтлээс үүссэн гэж үзэж байгаа юм бэ?/
- өдөөн хатгасан асуулт /эсрэг талд ашигтай мэдүүлэг өгч байгаа этгээдийг унагах зорилгоор асуусан асуулт. Жишээ нь: Та дахиад л миний асуултанд тодорхой хариулт өгсөнгүй, гэтэл өмнө нь та үүнээс өөрөөр мэдүүлсэн байдаг?/
- хариулт шаардахгүй асуулт /мэдүүлэг өгч байгаа этгээдийн сэтгэл зүйд нөлөөлөх гэсэн асуулт бөгөөд хариулт шаарддаггүй. Жишээ нь: Гэрчүүд таныг тэр өдөр тэнд байж байсан гээд байдаг, гэтэл та байгаагүй гээд байдаг, сонин л юм/ гэх мэт асуултын олон хэлбэрүүд байдаг.

Тэгэхээр шүүх хуралдаанд орж байгаа улсын яллагч асуултын эдгээр олон хэлбэрүүдийн талаар сайн мэдлэгтэй, асуух цаг үеэ олж асуудаг чадвартай байх, оновчтой хэрэглэдэг байх зэрэгт суралцсан байх шаардлагатай. Үүнээс гадна мэдүүлэг өгч байгаа этгээдээр дүгнэлт өгүүлсэн асуулт тавихыг мэтгэлцээнд хориглодог. Жишээ нь: Энэ хэргийн талаар та ямар дүгнэлт хийж байна? гэсэн асуулт асуух нь зохимжгүй юм.

Асуултыг урьдчилан бэлтгэлгүйгээр шүүх хуралдаанд гэнэт асуух нь заримдаа логикгүй, үр дүнгүй, хүсээгүй хариултаа авахад хүргэдэг. Гэнэтийн асуулт тавих нь хуульчийн ур чадвар, авхаалж самбаа, түргэн сэтгэх ур чадвар зэргээс ихээхэн шалтгаалдаг бөгөөд бүх хүнд ийм авьяас тэр болгон заяадаггүй тул шүүх хуралдаанд

тавих асуултаа урьдчилан бэлдэж орох нь үргэлж зөв байдаг.

Гэхдээ нэгэнт бэлдсэн асуултуудыг шүүх хуралдаанд хэрэглэхгүй байх ч тохиолдол гардаг. Гэхдээ урьдчилан бэлтгэж байгаа нь тухайн хуульчийг олон талаас нь цаг хугацаанд шахагдалгүйгээр бодуулж, зөв шийдвэр гаргахад ямагт тус дөхөм үзүүлдэг.

Шүүх хуралдаанд асуух асуултыг хэргийн үндсэн шинжид нийцүүлэн асуухаас гадна тодорхой тактиктай асуух нь зүйтэй. Тухайлбал:

Авлигын гэмт хэрэгт холбогдсон хүмүүс нь голдуу улс төр, хууль зүйн мэдлэгтэй, хэлэмгий, цэцэн хүмүүс байдаг тул олон юм асуухаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл өөрийнх нь мэдүүлгээр нотлох биш харин нотлох баримт шинжлэн судлах ажиллагааг сайн хийх хэрэгтэй.

Асуулт асуухдаа өөр лүү нь шууд чиглэсэн, өөрөөр нь бурууг хүлээлгэх гэсэн асуултаас зайлсхийх хэрэгтэй.

Харин эрхэлж байсан ажил, албан тушаал, албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны чиг үүрэг, юу хориглосон байдаг гэх зэргээр алсаас тойруу асуух нь зүйтэй. Жишээлбэл:

- Та энэ хэрэгт буруугүй гэж байна. Энэ байгууллагад тушаал гаргах цор ганц эрхтэй хүн бол ТА. Тэгвэл би танаас биш өөр хэнээс энэ асуултыг асуувал зохилтой юм бол? /Ажилтай нь холбогдуулаад ямар нэгэн алдаа гаргасан талаар л хариулт авахад асуултаа чиглүүлэх, Яллах дүгнэлтэд буруутгасан гэмт хэргийн шинжийг л тодруулж асуух. Тухайлбал урвуулан ашигласан гэдгийг ер нь та юу гэж ойлгодог вэ? /цаад санаа нь хуулийн мэдлэгтэй хүн тул үүнийг тооцоолсон гэдгийг гаргаж харуулахын тулд/
- Хавтаст хэрэгт байгаа зарим гэрчүүд шууд өмөөрсөн мэдүүлгүүд өгсөн байдаг тул тухайн гэрчтэй ямар харьцаатайг асуух.
- гэрчийн мэдүүлгийг үгүйсгэхийн тулд Өмнөх өгсөн мэдүүлгийг бусад нотлох баримттай харьцуулах замаар асуух гэх мэт.

Үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж буруутгаж байгаа бол

- Та өөрийнхөө хөрөнгөөр авсан гэдгээ яаааааг одоо нотлоод өг дөө? Өнөөдрийг хүртэл та тийм баримт гаргаж өгөөгүй ч гэсэн одоо танд боломж олгоё. Хамгийн гол нь баримт гаргаж өгөхийг та ойлгож байгаа байх гэх мэт.

Мансуурах сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт дараах байдлаар асуух болно. Үүнд:

- Та яагаад энд зогсож байгаагаа мэдэх үү?
- Та хүн ууттай юм харж бай гэхээр нь тэр хүнд туслах л санаатай хараад үлдсэн чинь мансууруулах бодис байсан юм байна гэж хэлээд байна уу?
- Ямар ч ноцтой зүйл үлдээсэн байж болно. Жишээлбэл хар тамхи, цөмийн зэвсэг, хорт бодис гэх мэт юу ч байж болно. Тэгсэн ч та харж хандаад, хамгаалаад, энд тэнд аваачиж өг гэж өөрт чинь зааж, зааварлаад байхад нь сайхан сэтгэлээр юу болохыг нь ч мэдээгүй байж зөөж өгсөн байна гэж би ойлголоо. Би зөв ойлгож уу?
- Таныг удирдаад, зааж, зааварласан юм бол тэр хүн таны удирдлага юм уу? Ажил хэргийн хувьд ямар харьцаатай хүмүүс юм бэ Та хоёр?
- Та тийм завтай, хийх ажилгүй, мөн өөрийгөө хохироон байж хүнд туслахад бэлэн байдаг хүн юм уу?
- Та хүргэж өгсний дараа юу болохыг мэдсэн гэх атлаа авсан гэх хүн өгөхөөр нь нэг л сорсон гэж байгаагаа тодорхой тайлбарлана уу?
- Тэгвэл та хар тамхи гэдгийг мэдэж байсан юм биш үү?

- Та өөрийгөө зөв зүйл хийсэн гэж бодож байна уу? Эсхүл буруу зүйл хийсэн үү?
- Танд ингэх ямар шалтгаан байсан юм бэ?
- Та буруу гэдгийг нь мэдэж л байсан байна шүү дээ. Яагаад хийхгүй байж болоогүй юм бэ?
- Мансууруулах бодис хэзээнээс хэрэглэж эхэлсэн юм бэ? .....гэх мэтээр асуултаа урьдчилан бэлтгэх байх нь зүйтэй.

2.2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээс өмнө талуудын гаргасан хүсэлт, гомдлоор болон шүүгчийн санаачилгаар зайлшгүй тогтоосон байх шаардлагатай шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа юм[5].

Урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго нь шүүхээр эцэслэн шийдвэрлэх боломжгүй буюу мөрдөн байцаалтын шатанд хийгдвэл зохих ажиллагаанууд бүрэн хийгдсэн эсэх, яллагдагчийн эрх зөрчигдсөн талаар гаргасан хүсэлт, гомдлын дагуу хуульд заасан асуудлыг хэлэлцэж, хэргийг прокурорт буцаах шаардлагатай эсэхийг шийдвэрлэдэг, хэргийг бүх оролцогчидтойгоор, шүүх хуралдааны бүх үе шат дарааллаар хэлэлцүүлэхгүйгээр зөвхөн талуудын хүсэлтийн дагуу болон шүүгчийн санаачилгаар тухайн асуудлаар хэлэлцдэг, шүүх хуралдааны өмнөх хэлэлцүүлэг юм.

Урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй[6].

Прокурор урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэж эрүүгийн хэргээс шаардлагатай нотлох баримтыг хуулбарлах, хэргийн түүвэр хийх зэргээр асуудал нэг бүрээр урьдчилан бэлтгэсэн байх нь зүйтэй.

Прокурор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохдоо эрүүгийн хэргээс шаардлагатай нотлох баримтыг хуулбарлах, түүвэр хийх, хууль тогтоомжийг судлах зэргээр дараах асуудлыг урьдчилан бэлтгэсэн байна[7].

1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг 3-аас доошгүй өмнө мэдэгдсэн эсэх;
2. Прокурорын яллах дүгнэлтэд үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан эсэх, яллагдагчид яллах дүгнэлт гардуулах ажиллагаа хуулийн дагуу хийгдсэнийг нягтлах;
3. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг түдгэлзүүлэх, прокурорт буцаах, харьяалах шүүхэд шилжүүлэх үндэслэлд дүгнэлт хийх;
4. Шүүх хуралдаанд дуудах оролцогч, шинжлэн судлах нотлох баримт болон таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл, саналыг бэлтгэх;
5. Хэрэгт нотолбол зохих байдлыг бүрэн гүйцэт шалгасан, нотлох баримтыг хууль, журмын дагуу цуглуулж,бэхжүүлсэн байдлыг дүгнэх;
6. Хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянах;
7. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулж, яллагдагчийн

[5] "Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх нь" сургалтын гарын авлага 70 дахь тал, УЕПГ, 2018

[6] УЕП-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 дугаартай тушаалаар батлагдсан "Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар"-ын 2.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

[7] УЕП-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 дугаартай тушаалаар батлагдсан "Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар"-ын 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг

“Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх” эрхийг хэрхэн хангасан болон Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгт буруутгасан, уг гэмт хэргийн шинжийг хангасан байдал, яллагдагчаар татах тогтоолын үндэслэлд дүгнэлт хийх;

8. Яллагдагчийн өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангасан талаарх баримт, мэдүүлэгт тулгуурлан үндэслэлийг тодруулах;

9. Шүүх хуралдааны товын талаарх саналд үндэслэлийг тодорхой дурдах;

10. Шүүгчийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулж буй үндэслэл, оролцогчийн гаргасан хүсэлт, гомдолтой урьдчилан танилцаж дүгнэлт хийх зэргийг анхаарч шүүх хуралдаандаа бэлтгэл ханган оролцох хэрэгтэй юм.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохдоо өмгөөлөх талын гаргасан хүсэлт, гомдол нь яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд байгаа эсэх, прокурор, өмгөөлөгч, оролцогчийн гаргасан санал, хүсэлт, гомдлын хүрээнд шүүх урьдчилсан хэлэлцүүлэг явуулж байгаа эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан үндэслэлийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг нягтална.

2.3. Мэдүүлгээс бусад нотлох баримтуудыг шинжлэн судлахад бэлтгэх нь

Шүүх хуралдаанд ирж мэдүүлгээ өгсөн шүүх хуралдааны оролцогчоос бусад мэдүүлэг, бусад бүх нотлох баримтуудыг шүүх хуралдаанд хэлэлцэх зайлшгүй шаардлагатай бөгөөд нотлох баримтуудыг шүүхэд танилцуулахыг мэдүүлгээс бусад нотлох баримтыг шинжлэн судлах шат гэж нэрлэдэг. Энэ бол их чухал үе шат бөгөөд хавтаст хэрэгт байгаа нотлох баримтуудын дийлэнх нь энэ үе шатанд хэлэлцэгддэг тул прокуророос энэ шатанд заавал урьдчилан бэлтгэсэн байхыг шаарддаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Дүгнэлтэд шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг ашиглахгүй”, 16.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно” гэж заасан.

Энэ заалтуудыг ухаж ойлгоход улсын яллагч яллах талын нотлох баримт болгож байгаа нотлох баримт бүрийг шүүх хуралдаанд заавал хэлэлцүүлэх үүрэг үүсэж байна. Практикт олон хавтаст хэрэгтэй, олон үйлдэл, холбогдогчтой хэргүүдэд бүхий л нотлох баримтуудыг нэг бүрчлэн шүүхэд танилцуулах боломж муу байдаг. Иймээс прокуророос нотлох баримтуудыг шүүхэд танилцуулахад тодорхой хэмжээний системчлэл хэрэгтэй байдаг.

Адил ойролцоо нотлох баримтуудыг нэгтгэн танилцуулах, цагаатгах талын нотлох баримтуудыг хэрхэн үгүйсгэж байгаагаа энэ шатанд дурдах тул эмх цэгцтэй, логиктой хүргэхийн тулд заавал урьдчилан бэлтгэсэн байх ёстой.

Мэдүүлгээс бусад нотлох баримтад:

- Шүүх хуралдаанд дуудагдаж ирээгүй ч мөрдөн байцаалтын шатанд авагдсан гэрч, хохирогчийн мэдүүлгүүд;
- Шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн ч мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгээс өөрчлөгдсөн мэдүүлэг;
- Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг;
- Мөрдөгчийн магадлагаа;
- эд мөрийн баримт;;
- үзлэг, нэгжлэг, туршилтын тэмдэглэлүүд
- мөрдөн шалгах ажиллагааны дүн;

- бичмэл нотлох баримтууд хамаарах бөгөөд дээр дурдсаны дагуу улсын яллагч өөрийн нотлох баримт болгосон нотлох баримт бүрийг танилцуулах үүрэгтэй тул хэрхэн яаж, танилцуулахаа заавал урьдчилан бэлтгэсэн байх ёстой.

2.4. Улсын яллагчийн дүгнэлтийн үг бэлтгэх

Шүүх хуралдааны хамгийн оргил үе шат бол шүүмжлэл хэлэх буюу улсын яллагчийн дүгнэлт хэлэх үе шат билээ. Тиймээс ялалтад хүрэхийн тулд дээр дурдсанчлан асуултуудаа урьдаас бэлтгэхийн нэгэн адил улсын яллагчийн дүгнэлтэд хэлэх үгээ урьдаас бэлтгэх нь мөн л амжилтын үндэс болдог.

Шүүх хуралдаанд шүүмжлэлийг хэрхэн урлагтайгаар хэлэх талаар бид хойно авч үзэх болно. Тиймээс илтгэл тавихын тулд урьдаас бэлтгэсэн байх шаардлагатай болдог.

Магадгүй шүүх хуралдаан дээр таны бодсоноос өөрөөр шүүмжлэл хэлэх шаардлага ч гарч ирж болох юм. Гэхдээ та өөр нэг хувилбарын талаар аль хэдийнээ бодсон тул дахиж цаг алдахгүйгээр өөрөөр сэтгэхэд тус болох нь лавтай.

Бэлдэж өөрийн болгосон үгээ сандарч тэвдэлгүйгээр шийдвэр гаргагчид хэрхэн хүргэх нь хэр бэлтгэснээс шалгаалдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

Улсын яллагчийн дүгнэлтийг:

1. Гэм буруугийн шүүх хуралдаанд
2. Эрүүгийн хариуцлагын шүүх хуралдаанд тус тус хэлэхээр бэлтгэх ёстой.

Улсын яллагчийн дүгнэлтэд зүйр цэцэг үг, эрдэмтэн мэргэдийн сургаал, эрх зүйн онолын сургаал зэргийг иш татан хэлэх нь дүгнэлтийг итгэл үнэмшилтэй болгодог тул энэ талаар судлах, ном зохиол уншиж эшлэл олж авах зэргээр бэлтгэх шаардлагатай болдог.

Мөн улсын дээд шүүхийн тайлбар, хяналтын шатны шүүхийн шийдвэр зэргээс иш татах, яллах ажиллагаандаа өргөн хэрэглэдэг тул прокурор тухайн хэрэгтэй ижил төстэй хэргүүдийн шүүхийн шийдвэрийг тогтмол уншиж судлан яллах үйл ажиллагаа буюу дүгнэлт хэлэхдээ ашиглах нь чухал үр дүнтэй байдаг.

Дүгнэлт бол зөвхөн мэдээлэл дамжуулж байгаа явдал биш бөгөөд бүх агуулгаараа ятгалга байдаг онцлогтой тул өөрийнхөө хэргийн онолоо итгүүлэхийн тулд оролцогчдыг өөрийнхөө ярианд анхааруулах бүх аргуудыг эзэмшсэн байх нь чухал байдаг. Дүгнэлтэд дараах зүйлүүдийг анхаарсан байвал зохино.

- биеэ авч явах байдал /үг хэлэхдээ эсрэг талтайгаа соёлтой, ёс зүйтэй харьцах, сандарсан, тэвдсэн байдал гаргахгүй байх/
- дууны өнгө хэлбэлзэл /илтгэх урлагт нэг өнгийн дуу хоолойгоор ярих нь хүмүүсийн анхаарлыг төдийлөн татдаггүй гэж үздэг төдийгүй үгний үнэ цэнийг буруулдаг учраас чанга, зөөлөн ярихыг хослуулах/
- ярианы хурд /хэт хурдан дуржигнуулах, хэт удаан ярих зэрэг нь сонсогчдыг ойлгохгүй байлгах болон залхаахад хүргэдэг тул ярианы хурдыг тохируулан ярьж сурах, зарим тохиолдолд түр зогсосхийх, анхаарал хандуулах шаардлагатай зарим үгийг дахин давтах/
- үг хэллэг /хуульч хүн хууль зүйн хэллэгээр үгээ оновчтойгоор илэрхийлэх нь ач холбогдолтой байдаг. Тэр ч байтугай хүмүүсийн хэлсэн үгнээс эшлэл хийх, зүйр цэцэн үгийг тохируулан хэрэглэх зэрэг нь үр дүнд хүргэдгийг анхаарах/
- хөдөлгөөн, дохио зангаа /Илтгэх урлагт зөвхөн үг хэллэг биш дохио зангаа, хөдөлгөөний хувиарлалтыг тохируулан хэрэглэх нь мөн л үр дүнтэй байдаг. Шаардлагатай гэж үзвэл үзүүлэн хэрэглэх /хэргийн газрын үзлэгийн зургаар гэх

мэт/, босож явах зэрэг нь бусдын анхаарлыг татахад чухал байдаг. Гэхдээ нэг ижил төрлийн дохио зангааг байнга давтах, танхимд хэт чөлөөтэй босож явах зэргээс зайлсхийвэл зохино./

- харааны хуваарилалт /дүгнэлт хэлж байхдаа зөвхөн нэг тийшээ харах буюу доошоо хараад байх нь өөртөө итгэлгүй, сул доройн шинж тул хараагаа зөв хуваарилах нь ач холбогдолтой байдаг. Тухайлбал шүүгдэгчийн талаар ярьж байхдаа шүүгдэгч рүү харах, шүүгчид хандаж байгаа бол шүүгч рүү харах гэх мэт/
- анхаарал хандуулахыг зориуд хүсэх /Жишээ нь: Одоо миний хэлэх гэж байгаа энэ үгэнд та бүхэн анхаарлаа хандуулна уу/
- гэнэтийн асуулт тавих /Жишээ нь: Энэ хүн хэрвээ өөрийгөө хамгаалаагүй байсан бол өдийд шүүгдэгч биш хохирогч болчихсон, магадгүй амьд байхгүй байх байсан даа./
- сэдвээ өөрчлөн өөр асуудал руу шилжих /Жишээ нь: Шүүгдэгчийн талаар сая ярилаа. Одоо тэр үед хохирогч ямар байдалтай байсан талаар одоо яръя гэх зэргээр анхаарал суларч байсныг дахин сэргээх гэх мэт/

Дүгнэлт хэлэхэд дээрх зүйлсийг анхаарах шаардлагатай бөгөөд өмнө дурдсанчилан урьтаж бэлтгэл хангасан байх нь дүгнэлтийг илтгэх ур чадвартайгаар хэлэхэд тус дөхөм болох нь дамжиггүй юм.

Гэм буруугийн шүүх хуралдаанд хэлэх улсын яллагчийн дүгнэлт нь удиртгал, хэргийн байдал, нотолгоо, хууль зүйн үндэслэл гэсэн бүтэцтэй байна[8].

Удиртгал хэсэгт хэнд холбогдох хэргийн шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байгаа, хуулийн үндэслэл, баримлах хуулийн зүйл хэсгийг;

Хэргийн байдал хэсэгт шүүгдэгч нь хаана, хэзээ, ямар хэрэг үйлдсэн, гэмт хэргийн шинж, гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа, зорилго, шалтгаан нөхцөл, учруулсан хор уршиг, хохирол, нөхөн төлбөр, хохирогч, шүүгдэгчийн хувийн байдал зэрэг;

Нотолгоо хэсэгт хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг нь хэрэгт цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгийн үед шинжлэн судлагдсан нотлох баримтад тулгуурлан, хэргийн бодит байдал, үйлдэл, эс үйлдэхүй, үйл баримт, тогтоогдсон нөхцөл байдалд хууль зүйн дүгнэлт хийх;

Хууль зүйн үндэслэл хэсэгт хэргийн зүйлчлэл, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг журамласан үндэслэл, үйлдэл, эс үйлдэхүй, арга хэлбэр, хамтран оролцсон байдалд эрүүгийн хууль тогтоомжид нийцүүлэн хууль зүйн дүгнэлт хийх зэргийг тус тус бичнэ.

Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх “Улсын яллагчийн дүгнэлт”-д дараах зүйлийг тусгана[9].

1. Ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
2. Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршиг, нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэм буруугийн хэлбэр, хамтран оролцсон байдал, төгссөн, завдсан, бэлтгэсэн зэргийг харгалзан

[8] УЕП-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 дугаартай тушаалаар батлагдсан “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын 2.3 дугаар зүйлийн 21 дэх хэсэг

[9] УЕП-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 дугаартай тушаалаар батлагдсан “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын 2.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээ, тусгай ангид оногдуулахаар заасан ялын хүрээнд шударга ёсны зарчимд нийцүүлэн эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг оновчтой сонгосон байна. Ялын төрөл, хэмжээг сонгосон үндэслэл, дүгнэлтийг заавал тусгах;

3. Албадлагын арга хэмжээ, эрх хасах ялын төрөл, хэмжээ;
4. Шүүгдэгч тус бүрээр төлүүлэх гэмт хэргийн хохирол, хор уршиг, нөхөн төлбөрийн хэмжээ;
5. Иргэний нэхэмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн хангах, эсхүл хэрэгсэхгүй болгох, жич нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээх;
6. Баривчилсан, цагдан хорьсон хугацааг ял оногдуулахад тооцох;
7. Эд мөрийн баримтыг хэрхэх;
8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг шүүгдэгчээс гаргуулах эсэх;
9. Шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хэвээр үлдээх, хүчингүй болгох эсэх, таслан сэргийлэх арга хэмжээг давхардуулан авсан тохиолдолд хүчингүй болгож, шаардлагатай бол эрх бүхий байгууллагад мэдэгдэх талаар санал гаргах;
10. Хураагдсан, битүүмжилсэн эд хөрөнгө, хөрөнгө хамгаалах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, шүүгдэгчид авах албадлагын арга хэмжээтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх

2.5 Шүүх хуралдаанд оролцоход бэлтгэх бусад зүйлс

- Холбогдох хууль, дүрэм, журам, олон улсын гэрээ, конвенци, хэргийн түүвэр, тэмдэглэлээ авах;
- Хувцаслалтаа тохируулах /улсын яллагчийн нөмрөг, цагаан цамц зангиа зэргээ бэлтгэх, эдгээр нь үрчлээгүй, хиргүй байхад анхаарах, ялангуяа гуталны өнгө хар байхаас гадна албаны гутал өмсөх/;
- Шүүх хуралдаанд хэрэглэх зөөврийн компьютер зэрэг ухаалаг хэрэгслийг цэнэгтэй байлгах арга хэмжээг авах;
- Шүүх хуралдаанд хэрэглэх үзүүлэнг урьдчилан бэлтгэх ;
- Өөрийгөө бэлдэх. Үүнд: айдас сандралаа даван туулах, гэм буруугийн болон ял шийтгэл оногдуулах шүүх хуралдаанд хэлэх дүгнэлт;
- Цагийн менежментийг зөв тооцоолох;
- Шүүх хуралдааны бэлтгэлийг урьдчилан хангуулсан эсэхийг шалгах гэх мэт.

Шүүх хуралдаан бол улсын яллагчаас ихээхэн мэдрэмж шаарддаг бөгөөд нөгөө талаараа улсын яллагч сэтгэл судлаачийн адил шүүгдэгчийн хувийн байдал, зан чанарт нь тааруулан асуулт асуух, яллах нь үр дүнтэй байдаг.

Үүнээс гадна шүүгчийн хэрэгт хандаж буй хандлага, тухайн улсын яллагчийн үйл хөдлөл, яллах арга барилыг хэрхэн дүгнэж буй зэргийг урьдаас мэдэрч аль болох түүнд нийцүүлэх байдлаар яллах ажиллагаагаа явуулах нь шүүхээс түүнд ашигтай шийдвэр гарахад нөлөөлдгийг дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл улсын яллагч зөвхөн нэг арга барилаар яллах бус өөр өөр арга барилаар /шүүгчийн зан байдалд нийцүүлэх/ яллах мэдрэмжид суралцах хэрэгтэй.

Өмгөөлөгчтэй харилцах, өмгөөлөгчийг няцаах зэрэг нь мөн л улсын яллагчаас мэдрэмж шаарддаг бөгөөд эдгээрийг урьдаас тооцоолж, шүүх хуралдаанд хэрхэн хандах вэ гэдгийг бүхий л талаас нь тооцож, шүүх хуралдааны бэлтгэлийг хангах нь шүүх хуралдаанд ялалт байгуулахад чухал дөхөм болдгийг анхаарна уу.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. “Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтын гарын авлага УЕПГ, 2018
2. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр “Шүүх хуралдаанд талууд оролцож мэтгэлцэх нь” судалгааны тайлан, 2008
3. “Шүүхийн мэтгэлцээн”Д.Зүмбэрэллхам, УБ, 2002
4. “Сэжигтэн, яллагдагч, гэрчийн мэдүүлэг нотлох баримт болох нь” Б.Батзориг, Д.Зүмбэрэллхам, УБ, 2006
5. “Нотолгооны онол” Б.Батзориг, УБ, 2013
6. “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол” Х.Батчимэг, Д.Мөнхтуул, Ц.Одончимэг, УБ, 2008
7. “Монгол хэлний товч тайлбар толь” Я.Цэвэл, УБ, 1966
8. “Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл” Б.Галдаа, УБ, 2012
9. “Байцаалт, түүний онцлог” Б.Бат-Эрдэнэ, УБ, 1994
10. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
11. Эрүүгийн хууль, 2015
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015
13. Прокурорын тухай хууль, 2017
14. УЕП-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 дугаартай тушаалаар батлагдсан “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”

БҮЛЭГ 12. ЯЛЫН ЗОРИЛГО, ЯЛЫГ НЭМЖ НЭГТГЭХ АРГАЧЛАЛ

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОЙЛГОЛТ, ОНОГДУУЛАХ ХЭМ ХЭМЖЭЭ

1.1. Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт
1.2. Эрүүгийн хариуцлагын зорилго, хүлээлгэх үндэслэл
1.3. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх
1.4. Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

СЭДЭВ 2. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЖ НЭГТГЭХ АРГАЧЛАЛ

2.1. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах
2.2. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОЙЛГОЛТ, ОНОГДУУЛАХ ХЭМ ХЭМЖЭЭ

Зорилго. Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт, хуульд зааснаар эрүүгийн хариуцлагыг үр нөлөөтэй, тохируулан хэрэглэх, арга барилтай болж ялыг нэмж нэгтгэх аргачлалд суралцуулах юм.

1.1 Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт.

Эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл мөн бөгөөд гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрүүгийн хуульд заасан ял, **албадлагын арга хэмжээгээр хязгаарлалт** тогтоож байгаа төрийн албадлагын онцгой арга хэмжээ.

Эрүүгийн хариуцлагын нарийн тодорхойлолт нь газар нутаг бүрд харилцан адилгүй байдаг ч ерөнхийдөө гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээхийн тулд гэмт хэрэгтэн юу хийж байгаагаа, энэ нь буруу гэдгийг ойлгох ёстой гэсэн үг юм.

Эрүүгийн загвар хуульд эрүүгийн хариуцлага гэдэг нь санаатай, болгоомжгүй үйлдлээр эрүүгийн хуулийг зөрчсөн тохиолдолд үүсдэг арга хэмжээ гэж тодорхойлсон.[1] Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэм буруутайд тооцохын тулд санаатай, болгоомжгүй үйлдэл хийснийг нотлохоос гадна эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл байгаа эсэхийг харгалзсан байх ёстой гэжээ.

1.2 Эрүүгийн хариуцлагын зорилго

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.[2]

Эрүүгийн хуульд заасан ял болгон өөртөө гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөөнд ямар нэг хэмжээгээр хязгаарлалт тогтоосон агуулга бүхий цээрлэлтэй байдаг. Ялын цээрлэл нь ялтны эрхийг хязгаарлах байдлаар хэрэгждэг учир үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшиж, улмаар хүмүүжих гэсэн эрмэлзлийг төрүүлдэг нийгэм-эрх зүйн ач холбогдолтой.[3]

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх зорилго нь нийгмийн шударга

[1] Model Codes for Post-Conflict Criminal Justice. https://www.usip.org/publications/model-codes-post-conflict-criminal-justice

[2] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйл.

[3] Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ II боть. Уб., 2014. 136 дахь тал.

ёсны илэрхийлэл бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхийн зэрэгцээ гэмт хэрэг үйлдэж, бусдад учруулсан эд материалын болон сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, төлүүлэхэд чиглэгдсэн олон хэм хэмжээ Эрүүгийн хуульд тусгагдан хэрэгжиж байгаагаар хангагдаж байдаг.[4]

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго нь Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлд нэрлэж заасан нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн амин чухал эрх ашгийг эрүүгийн хуулийн хамгаалалтад авах нь нэг талаас энэрэнгүй ёсны зарчмын тод илрэл байдаг бөгөөд нөгөө талаас хүн, түүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалж байгаагаар бодит байдлаар хэрэгжиж байдаг.[5]

Ялтныг цээрлүүлж, эрхийг нь хязгаарлах замаар үйлдсэн гэмт хэрэгт гэмшүүлж байгаа нь агуулгаараа хүмүүжүүлэх зорилгыг хангахад чиглэгдэнэ. Ялтан үйлдсэн гэмт хэргийн хортой үр дагаврыг бүрэн ухамсарлан ойлгож, нийгэмд тогтсон хууль ёс, дэг журмыг чанд сахидаг, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, иргэнийхээ үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, шударга, зарчимч, нийгмийн идэвхтэй гишүүн болон хүмүүжсэнээр эрүүгийн хариуцлагын энэ зорилго хангагдана.[6]

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэхээр зохицуулсан бөгөөд шүүх эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан ял дээр нэмж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, эмнэлгийн чанартай, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний төрлийг сонгож хэрэглэнэ.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

Шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзана.

Шүүх тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, шүүгдэгчийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлын талаар бодитой зөв дүгнэлт хийж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шударга ёсны зарчимд нийцнэ.

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ гэдэг нь эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлаас гадна гэмт хэрэг үйлдэгдэх үеийн объектив болон субъектив нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, субъектын гэмт хэрэг үйлдсэн үеийн сэтгэл санааны байдал, хохирогчийн хууль бус, зүй бус үйлдэл, гэмт санаа, зорилгыг хэрэгжүүлсэн арга, гэмт хэрэгт хамтран оролцсон байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хохирлыг төлсөн, гэм хорыг арилгасан, гэм буруугаа ойлгон гэмшсэн байдал зэрэг гэмт хэргийн болон шүүгдэгчийн нийгэмд аюултай байдлыг багасгасан объектив болон субъектив шинжтэй цогц нөхцөл байдал юм.[7]

---

[4] Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 146 дахь тал.

[5] Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 146 дахь тал.

[6] Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 147 дахь тал.

[7] Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010.

Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал гэдэгт гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон үйлдсэний дараа хийж байсан ажил, сурч байсан сургууль, иргэний үүрэгтээ хандах хандлага, зан төлөв, дадал зуршил, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар, өөрийн болон өрхийн орлого, төлбөрийн чадвар, гэр бүлийн байдал, ам бүлийн тоо, асрамжинд байдаг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний тоо, гэр бүлийн харилцаанд эзлэх байр суурь, нэр хүнд, урьд ял шийтгэл эдэлж байсан, төрөөс олгосон шагнал урамшуулал зэрэг өргөн асуудал хамаарна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал гэдэгт гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, байгалийн гамшиг тохиолдсоноос эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалж чадахгүй болсон нөхцөл байдал, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байсан байдал, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөл, хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан, хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн, санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж гэмт хэрэг үйлдсэн зэрэг субъектив нөхцөл байдал хамаарна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд заасан дараах нөхцөл байдлыг эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцно:

- тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн;
- гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн, бусад туслалцаа үзүүлсэн, учруулсан хохирлыг төлсөн;
- бие махбодын, сэтгэл санааны албадлагын, эд хөрөнгийн, албан тушаалын, бусад байдлаар эрхшээлд орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн;
- өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан;
- нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн.

Хэрэв Эрүүгийн хуулийн тусгай ангид эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд заасан дараах нөхцөл байдлыг эрүүгийн хариуцлагын хүндрүүлэх нөхцөл байдалд тооцно:

- бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;
- Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;
- нийтэд аюултай аргаар үйлдсэн;
- өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;
- албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотны хүний эсрэг үйлдсэн;
- хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;
- онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
- гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.

Хэрэв Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт

169 дэх тал.

хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.

Түүнчлэн Эрүүгийн хуульд заагаагүй нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг хориглоно.

Тохиолдол:

Б нь Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2, мөн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдож Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Б-г хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулахдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 20 жил хорих ял, мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 720 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус шийтгэж, 2021 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.1, 4.2 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б-т оногдуулсан 720 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ялыг өршөөн хэлтрүүлж, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 20 жил хорих ялыг хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэснийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Улсын дээд шүүх шүүгдэгчийн өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсэгт “Шүүгдэгч Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 17 жил хорих ял шийтгэсүгэй” гэсэн өөрчлөлт оруулсан.[8]

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан, хугацаатай хорих ялын дээд хэмжээг оногдуулах үндэслэл нь тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хүндрүүлэх шинжүүдэд гэм буруутай этгээдийн үйлдэл хамгийн дээд хэмжээнд нийцсэн байх явдал юм.

Хууль тогтоогч хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан хоёр тохиолдлыг онцгойлон хүндрүүлэн үзэж 12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорьж шийтгэхээр заасан бөгөөд ийм ялаар шийтгэгдвэл зохих нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн шинж байдлыг Эрүүгийн хуулийн адил зүйл, хэсгээр зүйлчлэгдэх боловч илүү хөнгөн бусад тохиолдлоос зөв зааглах нь Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчим хэрэгжих бодит баталгаа болно.

Хүчиндэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4-т заасан хоёр бүрэлдэхүүний аль нэг, эсхүл аль алиныг хангахаас гадна тухайн зүйлийн бусад хэсэгт заасан шинжүүдийг давхар агуулж буй бол хорих ялын хэмжээг хүндрүүлж оногдуулах үндэслэл болно.

Иймээс хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4-т заасан бага насны хүүхдийн эсрэг, хохирогчийн амь насыг хохироож үйлдэх тохиолдлоос гадна зүйлчлэлд нөлөөлөхгүй боловч хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх тухайн зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, 16 насанд хүрээгүй хүнийг, бүлэглэн, жирэмсэн болгож, ураг зулбуулан, бэлгийн замын халдварт өвчин халдааж, харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдэх, хохирлын хэмжээ, хохирогчдын тоо их байх, зэрэг онц ноцтой үр дагаврууд

[8] УДШ. 2022.06.15 №119 тогтоол.

харгалзан шүүгдэгчийн биечлэн эдлэх ялыг тогтоож байх нь чухал юм.

Хэд хэдэн хүндрүүлэх бүрэлдэхүүн, эсхүл бүх хүндрүүлэх шинжээр хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хорих ялын дээд хэмжээгээр эсхүл бүх насаар нь хорих ялыг оногдуулах үндэслэл болно.

Дээрхи хэргийн шүүгдэгч Б-ийн хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг нэг бүрэлдэхүүнээр үйлдсэнээс гадна гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хүчний хэмжээ, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн зэргийг харгалзан үзэж, хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр анхан шатны шүүхээс оногдуулсан 20 жилийн хорих ялыг 17 жил болгон хөнгөрүүлсэн өөрчилсөн.

2002 оны Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлд “эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн” гэж анх удаа тодорхойлсон бөгөөд 2015 оны Эрүүгийн хуульд тусгайлсан тодорхойлолт оруулаагүй боловч эрүүгийн хариуцлагын тухай олон зүйл хэсэгт заасан байдаг. (Эрүүгийн хуулийн 1.2, 2.2, 3.1, 8.1, 9.1, 10, 13, 14.1, 14.2, 14.5, 16.1, 20, 37 гэх мэт)

2002 оны Эрүүгийн хуульд “Эрүүгийн хариуцлагын төрөл” гэсэн нэр томьёо, ойлголтыг анх хуульчилж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт “Эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хүлээлгэнэ”[9], мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэсэн төрөлтэй байна” гэж заасан.

Харин 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “Эрүүгийн хариуцлага” гэх нэр томьёог хасаж, үүний оронд “ял, албадлагын арга хэмжээ” гэх эрүүгийн хариуцлагын хоёр бие даасан институцийг тус тусад нь тодорхойлсон нь эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчимд нийцээгүй, эдгээрийг харилцан уялдаатай нэг зорилтын дор хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах нөхцөлийг бүрдүүлсэн гэж болно[10]. Тиймээс Монгол Улсын Их Хурал 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн батлаж, шинэчлэн найруулсан дээрх Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх хугацааг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулж, холбогдох нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр оруулсан байна.

Уг нэмэлт өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ”[11] гэж заажээ.

Түүнчлэн, эрүүгийн хариуцлагын Эрүүгийн хуулиар тогтоосон төрөл болох ял, түүний төрөл хэмжээг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.2-5.7 дугаар зүйлд, ял оногдуулах нийтлэг зарчим, үндэслэл, журмыг ерөнхий ангийн 6.1-6.15 дугаар зүйлд хуульчилсан бол албадлагын арга хэмжээ, түүний төрөл болох эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах, хэрэгжүүлэх журам, нөхцөлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1-7.6 дугаар зүйлд заасан.

Эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэх бөгөөд гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн

---

[9] Монгол Улсын Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. Уб., 2002. №5.

[10] Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. Уб., 2016. 2 дахь тал.

[11] Монгол Улсын Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. Уб., 2016. №7.

хариуцлага хүлээлгэдэг.

Эрүүгийн хуульд[12] зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба хуульд нэрлэж заасан нийгмийн хор аюул ихтэй, түгээмэл үйлдэгддэг 12 гэмт хэргийг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан "Хүнийг алах", 11.1 дүгээр зүйлд заасан "Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах", 12.1 дүгээр зүйлд заасан "Хүчиндэх", 17.1 дүгээр зүйлд заасан "Хулгайлах", 17.2 дугаар зүйлд заасан "Дээрэмдэх", 17.8 дугаар зүйлд заасан "Эд хөрөнгө устгах, гэмтээх", 20.7 дугаар зүйлд заасан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах", 20.16 дугаар зүйлд "Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах", 26.1 дүгээр зүйлд заасан "Цахим мэдээлэлд хууль бусаар халдах", 26.2 дугаар зүйлд заасан "Кибер орчинд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах", 26.3 дугаар зүйлд заасан "Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах", 29.8 дугаар зүйлд заасан "Террор үйлдэх") үйлдсэн 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин энэ хэсэгт зааснаас өөр гэмт хэрэг үйлдсэн 14 насанд хүрсэн хүүхдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй.

Гэмт хэрэг үйлдэх үед 18 насанд хүрээгүй байсан хүний насыг тогтоохдоо хуульд заасан шаардлагыг хангаж, төрсөн он, сар, өдрийг (цаг минут) Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон төрсний гэрчилгээг баримтлан тогтооно.

Шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ял оногдуулах насанд хүрээгүй болох нь тогтоогдвол шүүх түүнд холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Тохиолдол:

12 настай Б нь Баянзүрх дүүргийн .. дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Н" хотхоны .. дугаар байрны В1 давхарт байрлах автомашины зогсоол дотор 2021 оны .. дугаар сарын ..-ны өдөр хутгыг зэвсгийн чанартай хэрэглэн 7 настай хохирогч А-ийн толгой, хацар, хүзүү, нуруу, гар хэвлий хэсэгт хутгалж гэмтээн эрүүл мэндэд нь хүнд хохирол санаатай учруулсан, мөн хутгыг зэвсгийн чанартай хэрэглэн 13 настай хохирогч Б-ын хамар, эрүү, зүүн чих, баруун шанаа, хүзүүний баруун, зүүн хоёр хажуу хэсэг, хүзүүний ар хэсэг, цээжний баруун, зүүн хэсэг, баруун суга, нуруу, зүүн сарвуу, баруун гарын алга, бугуйнд хутгалж, хохирогчийн биед 40 газар нийт 58 шарх, 4 ширхэг зулгаралт үүсгэж, онц харгис хэрцгийгээр алсан гэмт хэрэгт тус тус холбогдон Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т заасан гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтад заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэрэгт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлсэн.

Шүүх хэргийг хэлэлцээд Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дахь заалтад заасан биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж зэвсэг хэрэглэн эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан хүнийг онц хэрцгийгээр алах гэмт хэрэг үйлдсэн гэм бурууташд тус тус тооцож, Б-д холбогдуулан .. дүүргийн Прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтад зааснаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.13

[12] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйл.

[13] БЗДЭХАШШүүх 2022.11.21 №1720 Шт.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хуулийн этгээдийн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзана.[14]

Эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.

Хуулийн этгээдэд 10-400 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял оногдуулах бөгөөд шүүх эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах шаардлагатай гэж үзвэл торгох ял дээр нэмж эрх хасах, татан буулгах, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангиад заасан тохиолдолд 1 жилээс 8 жил хүртэл хугацаагаар нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах, мөн татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх ба хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг мөн татан буулгаж болно.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарвал улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэнэ.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол дор дурдсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ:

- бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
- бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
- хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
- хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
- компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид.

Хэргийг хянан шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор санаатайгаар татан буулгасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд, үндэслэлгүйгээр аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээд, эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр

[14] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг.

шилжүүлсэн бусад хуулийн этгээдээс нөхөн гаргуулна.

Хуулийн этгээдэд хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан, тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь хариуцлага хүлээлгэхэд эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах боломжгүй, шударга ёсны зарчимд нийцэхгүй бол шүүгч гэмт хэрэг үйлдэгдэх үед тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Түүнчлэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн гэмт хэргийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 найман насанд хүрээгүй буюу өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилго нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэнэ.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Харин гэмт хэрэг үйлдэх үедээ 14 хүрсэн ба 18 насанд хүрээгүй байсан хүн шийтгэх тогтоол гарах үед 18 насанд хүрсэн бол хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахгүй.

Шүүхээс 18 насанд хүрсэн бөгөөд онцгой тохиолдолд тухайлбал, оюун санаа, сэтгэхүйн хөгжлийн хувьд өсвөр насны хүүхдийн хэмжээнд, юмс үзэгдлийн мөн чанар, үр дагаврыг ухамсарлан ойлгох чадвар сул энэ нь шинжээчийн дүгнэлт, бусад нотлох баримтаар батлагдсан[15] 21 насанд хүрээгүй хүнд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно.

Өсвөр насны хүнд[16] нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял шийтгэнэ.

Өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулж, уг ялыг өдөрт 3-аас дээшгүй цагаар, нийт 120-360 цагаар тогтоох[17] ба уг ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.[18]

Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг

[15] УДШ 2019.06.05 №254 тогтоол.
[16] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйл.
[17] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйл.
[18] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 8.4 дүгээр зүйл.

үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулж, ялыг хоёр дахин багасган[19] Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг эдлүүлэх бөгөөд хорих ял эдэлж байхдаа 18 насанд хүрвэл эдлээгүй үлдсэн хорих ялыг 21 нас хүртэл Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэх эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Шүүх анх удаа Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 8 жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээ авч болно.

Шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, өмнө оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

Харин шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

Өөрөөр хэлбэл, шинээр үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтоох ба хэд хэдэн төрлийн ял оногдуулсан бол уг ялыг Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйлд заасан журмаар нэгтгэх, эсхүл тус тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

Мөн оногдуулсан ялыг нэмж нэгтгэхдээ нийт ялын хэмжээг тухайн төрлийн ялын дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 8 жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж 1-3 жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.

Өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгана.

Өөрөөр хэлбэл, нийгмийн хор аюул багатай, хөнгөн, хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр засарч хүмүүжих боломж олгох, түүнийг хүмүүжүүлэх үйл хэрэгт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, хамт олон, төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах зорилгын үүднээс хэрэглэнэ.

СЭДЭВ 2. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЖ НЭГТГЭХ АРГАЧЛАЛ

2.1 Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах[20]

Шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа үйлдсэн гэмт хэрэг тус бүрд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял оногдуулж, уг ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно.

Хэд хэдэн гэмт хэрэгт хэд хэдэн төрлийн ял оногдуулсан бол хөнгөн ялыг хүндэд

[19] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 8.5 дугаар зүйл.

[20] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйл.

нь нэмж нэгтгэх, эсхүл тус тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэж болно. Тухайлбал, торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг, нийтэд тустай ажил хийлгэх ялын 8 цагийг, зорчих эрхийг хязгаарлах ялын 1 хоногийг хорих ялын 1 хоногт тооцно.

Тохиолдол:

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б-г хүнийг захиалгаар алахыг завдсан, мөн хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдэхийг завдсан, мөн дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтад зааснаар 8 жил 1 сар хорих ял, мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг зааснаар 5 жил 1 сар хорих ял, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 2 жил хорих ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч Б-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтад зааснаар оногдуулсан 8 жил 1 сар хорих ялд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 5 жил 1 сар хорих ялыг, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 2 жил хорих ялыг тус тус нэмж нэгтгэн нийт биечлэн эдлэх хорих ялыг 15 жил 2 сарын хугацаагаар тогтоож, уг хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.[21]

Хэд хэдэн гэмт хэрэгт оногдуулсан нэг төрлийн ялыг нэмж нэгтгэсэн ялын нийт хэмжээ нь тухайн бүлэгт заасан хамгийн хүнд ялтай гэмт хэргийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

Мөн хэд хэдэн бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг нэмж нэгтгэсэн нийт хэмжээ нь хамгийн хүнд ялтай бүлгийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

Тохиолдол:

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Е-г зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулан бусдыг элсүүлсэн, мөн цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулан үйлдсэн, мөн мөнгө угаах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулан үйлдсэн, залилах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулан үйлдэхийг завдсан гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.1-д зааснаар 8 жил хорих ял, мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 8 жил хорих ял, мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 3 жил хорих ял, мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр

[21] БЗДЭХАШШүүх 2022.05.09 №667 Шт.

зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар 4 жил хорих ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэгт заасныг баримтлан оногдуулсан хорих ялыг нэмж нэгтгэн нийт 12 жилийн хугацаагаар тогтоож шийдвэрлэсэн.[22]

2.2. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах23

Ялтан оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинээр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон бол тухайн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно.

Хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялуудыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.9 дүгээр зүйлд заасан журмын дагуу нэгтгэж, нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтоох нь шүүхэд заавал хэрэглэхийг үүрэг болгосон (императив) шинжтэй хэм хэмжээ юм.

Харин хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэмж нэгтгэхдээ нийт ялын хэмжээг тухайн төрлийн ялын энэ хуулиар тогтоосон дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй бөгөөд нэмж нэгтгэсэн ялын нийт хэмжээ өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын эдлээгүй үлдсэн хэмжээнээс их байна.

Тохиолдол:

Шүүгдэгч Э нь урьд 3 удаагийн ял шийтгэлтэй, хамгийн сүүлд 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр шүүхээс Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 248 цаг нийтэд тустай ажил хийлгэх ял, мөн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 жил хорих ял, 17.1 дүгээр зүйлийн 2.1-д зааснаар 2 жил хорих ялаар тус тус шийтгүүлж, оногдуулсан ялуудыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялыг 3 жил 1 сар 1 хоног хорих ялаар тогтоож, 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр эдлээгүй үлдсэн 10 сар 07 хоног хорих ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон.

Улмаар Э нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэмт хэрэг тус тус үйлдэж анхан шатны шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн Э-гийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, гэм буруугийн хэр хэмжээ, хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан түүнд хуульд заасан ялын төрөл, хэмжээний дотор зохих ялыг сонгон оногдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 18 жил хорих ял, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар 2 жил хорих ял, Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 4 сар зорчих эрхийг хязгаарлах ял, Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 6 сар зорчих эрхийг хязгаарлах ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1, 2, 2.3, 3, 4 дэх хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Э-д оногдуулсан ялуудыг нэмж нэгтгэн, нийт эдлэх хорих ялын хэмжээг хуулиар тогтоосон хорих ялын дээд хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр 20 жилийн хугацаагаар тогтоож, уг ялыг хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

[22] БЗДЭХАШШүүх 2020.10.21 №1833 Шт.

[23] 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйл.

Улсын дээд шүүх хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсэгт “үргэлжилсэн үйлдлээр, ...Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан” гэснийг тус тус хассан өөрчлөлт оруулсан.[24]

- Шүүгдэгч Э хохирогч О-г 12 настай байхад, мөн 15 настай үед хүчиндсэн үйлдлүүд нь нэг хохирогчийн эсрэг боловч тус тусдаа өөр өөр цаг хугацаа, орон зайд үйлдэгдсэн, өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг (бага насны хүүхэд хүчиндэх) болон мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д (арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх) заасан гэмт хэргийн шинжийг тус тус агуулсан бөгөөд прокуророос дээрх нэг төрлийн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүнд зүйл, хэсэгт нь нэгтгэж зүйлчилж, яллах дүгнэлт үйлдсэн.

- Эрүүгийн эрх зүйд үргэлжилсэн нэг гэмт хэрэг гэдэгт ерөнхий нэг зорилгын хүрээнд хэд хэдэн удаагийн төсөөтэй үйлдлээр нэгдмэл нэг гэмт хэрэг үйлдэхийг ойлгодог.

Гэмт хэрэг үйлдэх санаа зорилго нь тус тусдаа үүсэж, өөр өөр цаг хугацаа, орон зайд үйлдэгдсэн, тус бүрдээ гэмт хэргийн шинжийг хангасан хэд хэдэн удаагийн үйлдлээр хүчээр бэлгийн харьцаанд орсон үйлдлүүдийг үргэлжилсэн нэг гэмт хэрэгт тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй. Прокуророос Э-г Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллагдагчаар татахдаа 2019 болон 2022 онд үйлдсэн хүчиндэх гэмт хэргүүдийг үргэлжилсэн нэг гэмт хэрэгт хамааруулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамласан нь тухайн зүйл хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно” гэж хуульчилсан үргэлжилсэн нэг гэмт хэргийн шинжид тохироогүй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан хэд хэдэн гэмт хэргийн шинжийг нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байвал хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэнд тооцно” хэмээн нийлмэл гэмт хэргийн шинжийг тодорхойлсны дагуу шүүгдэгч Э-ийн 2022 оны 02 дугаар сарын 25-наас 26-нд шилжих шөнө хохирогч Ө-г гэртээ эх, охины хамт унтаж байхад гэрийнх нь хаалгыг нүдэж, цоожийг эвдэн орж, “ална” хэмээн заналхийлж, Д, Ө нарын биед заазуур хэрэглэн хөнгөн зэргийн гэмтэл учруулсан үйлдэл нь “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэргээс гадна өөр гэмт хэргийн шинжийг агуулсан эсэхийг шалган үзэхэд Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлд заасан “Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох” гэмт хэргийн шинжийг давхар агуулсан байх ба Э-ийн Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан орон байрны халдашгүй байдлыг зөрчин хохирогч О-гийн гэрт зөвшөөрөлгүй нэвтэрч, бусдын халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдаж дурааараа авирласан үйлдэлд хууль зүйн дүгнэлт хийгээгүй, Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллагдагчаар татаж, яллах дүгнэлт үйлдэж прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүх шүүгдэгчийн гэм бурууг хянан хэлэлцсэн.

Хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн хувьд орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн үйлдлийг хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон хуульчилсан тул энэ төрлийн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлийг давхар зүйлчлэх шаардлагагүй.

[24] УДШ 2022.11.30 №178 тогтоол.

Прокуророос Э-ийн хохирогч С-ын өмчлөлийн байшингийн цонхыг хагалан орж, уг байшинд О-г хүчиндсэн үйлдэл нь хүчиндэх гэмт хэргээс гадна бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох гэмт хэргийн шинжийг давхар агуулсан гэж дүгнэн тухайн үйлдэлд Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татаж, яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь хэргийн бодит байдалтай нийцсэн.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

А.Монгол хэлээр

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. Уб., 2016.

Ном, товхимол

1. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ II боть. Уб., 2014.
2. Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан. Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010.
3. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.11.21 №1720 Шт.
4. Улсын Дээд Шүүхийн 2019.06.05 №254 тогтоол.
5. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.05.09 №667 Шт.
6. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.10.21 №1833 Шт.
7. Улсын Дээд Шүүхийн 2022.11.30 №178 тогтоол.

Б.Гадаад хэлээр

Цахим эх сурвалж.

1. Model Codes for Post-Conflict Criminal Justice. https://www.usip.org/publications/model-codes-post-conflict-criminal-justice

БҮЛЭГ 13. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

СЭДЭВ 1. Олон улсын эрх зүй ба Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

1.1. Олон улсын эрх зүй ба Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт
1.2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

СЭДЭВ 2. Олон улсын эрүүгийн эрх зүй ба хамтын ажиллагаа

2.1. Мөрдөн шалгах ажиллагааны харьяалал, прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэл
2.2. Хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүн (нотлох баримтаар тооцох эсэх)

СЭДЭВ 3. Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай

3.1. Өнөөгийн нөхцөл байдал
3.2. Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх албан бус арга хэрэгсэл
3.3. Гадаад орнуудын сайн туршлага

СЭДЭВ 1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

1.1. Олон улсын эрх зүй ба Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт

Дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг хангах болон улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар улсуудын харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний тогтолцоог “Олон улсын эрх зүй” гэж нэрлэдэг.[1] Хэдий энэ тодорхойлолт нь явцуу боловч олон улсын эрх зүйн үндсэн шинжийг агуулж байгаа бөгөөд олон улсын эрх зүй нь маш нарийн тогтолцоотой үзэгдэл болсныг илэрхийлж байна. Олон улсын эрх зүйн системийг бүрдүүлж буй хэм хэмжээ нь хууль зүйн хүчин чадалтай бөгөөд тэд нь хэрэгжүүлэх өөрийн гэсэн механизмтай. Мөн дээрх тодорхойлолт нь олон улсын эрх зүйн үндсэн чиг үүрэг болох улс хоорондын харилцааг зохицуулах үүргийг харуулж чадсан юм.

Нэр томьёоны тухайд: Ромын эрх зүйд jus gentium буюу ард түмний эрх зүй гэх ойлголт байжээ. Дараагаар энэ нэр томьёог jus inter gentes буюу ард түмэн хоорондын эрх зүй болгон өөрчилжээ. Өнөө үед олон улсын эрх зүйг англи хэлээр international law, франц хэлээр droit international гэж хэлж тогтжээ. Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүй хоёр бие даасан эрх зүйн салбар хэдий ч энэ хоёр нь хоорондоо нягт холбоотой, тухайлбал олон улсын эрх зүй нь үндэсний хэм хэмжээ бий болгоход нөлөөлөх, үндэсний хэм хэмжээ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ бий болоход нөлөөлдөг. Жишээ нь: 1948 оны Хүний эрхийн бүх нийтийн тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын 1966 оны Пактын хүний эрхийн заалтууд олон улсын Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг. Мөн 1998 онд батлагдсан Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэмд үндэсний эрүүгийн эрх зүйн олон зарчим тусгагдсан байдаг.[2]

Олон улсын эрх зүй нь нийгмийн харилцааны маш онцгой төрлийг буюу тусгаар тогтносон улсуудын харилцааг зохицуулдаг. Ийм ч учраас олон улсын эрх зүйг бий болгох болон түүний үйлчлэх механизм нь улсын дээгүүрх бус улс хоорондын

[1] Олон улсын эрх зүй гарын авлага
[2] Бекяшев К.А. Олон улсын нийтийн эрх зүй. М. 1998. S.541-507.н

шинжийг агуулсан байдаг. Түүний хэм хэмжээг улс хоорондын зөвшилцлийн замаар бий болгодог. Улс хоорондын харилцаанд улс, олон улсын байгууллага, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж буй үндэстнүүд оролцдог[3].

Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн чиг үүрэг нь улс хоорондын харилцааг зохицуулах байдаг тул, дээрх субъектүүд олон улсын нийтийн эрх зүйн бүрэн сүбьект байж чадахгүй. Харин олон улсын хувийн эрх зүйгээр гадаадын элемент бүхий эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцааг зохицуулдаг тул, түүний сүбьект нь төр, хуулийн этгээд, хувь хүн юм. Мөн дээрх тодорхойлолтод олон улсын эрх зүйн үндсэн шинж болох дэлхийн энх тайвныг хангах болон олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих бүхий олон нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим тусгалаа олсон байна.

Зарим судлаачид олон улсын эрх зүйн тогтолцоонд эрх зүйн хэм хэмжээнээс гадна бусад хэм хэмжээг багтааж, түүнийг илүү өргөнөөр тодорхойлдог. Олон улсын эрх зүйд «эрх зүйн реализмын»[4] шинжийг ногдуулсан байдаг. Түүнийг баримтлагчид, М.Каплан, Н. Катценбах нар олон улсын эрх зүйг хэм хэмжээний нийлбэрийн хувь бус процесс хэмээн ойлгодог. Харин «улс төрийн хандлага бүхий үзэл санааг дэмжигч нар олон улсын эрх зүйг эрх мэдлийн шийдвэр гаргах бүхий процесс гэж тодорхойлсон байдаг. Олон улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь олон улсын нийтийн эрх зүйн эх сурвалж болох олон улсын гэрээ ба олон улсын заншил юм.[5]

1.2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 18 дугаар зүйлийн 13 дахь заалт дахь:

Монгол Улсын Олон улсын 2 талт гэрээ, нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцийн “Гэрээний тал” буюу “Төв байгууллага”-ын статусыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон тухайд.

“Оролцогч улс бүр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, түүнийг биелүүлэх, эсхүл биелүүлэх эрх бүхий байгууллагуудад уг хүсэлтийг шилжүүлэх, холбогдох эрх, үүрэг бүхий төв байгууллагыг томилно. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тусдаа тогтолцоо бүхий тусгай бүс буюу нутаг дэвсгэртэй оролцогч улс тухайн бүс буюу нутаг дэвсгэрийн хувьд холбогдох **адил үүргийг гүйцэтгэх тусгай төв байгууллагыг томилж болно**. Төв байгууллагууд хүлээн авсан хүсэлтийг хурдан, зохих журмаар биелүүлэх буюу шилжүүлэх явдлыг хангана. Хэрэв төв байгууллага хүсэлтийг биелүүлэхээр эрх бүхий байгууллагуудад түүнийг шилжүүлбэл эрх бүхий байгууллага хүсэлтийг хурдан, зохих журмаар биелүүлэх явдлыг хангахад тэрбээр дэмжлэг үзүүлнэ. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг соёрхон баталсан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн буюу баталсан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгөхдөө энэ зорилгоор **томилсон төв байгууллагын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ**. **Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлт болон түүнтэй холбоотой аливаа мэдээллийг оролцогч улсуудаас томилсон төв байгууллагуудад шилжүүлэн өгнө**.” гэсэн Төв байгууллагын асуудал юм.

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнүүдэд төв байгууллагыг Хууль зүйн

[3] Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.
[4] Ю.М. Колосов. Е.S. Кривчиков. Олон улсын хууль. М. 2000 он
[5] М.Дүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ., 1999. 313-331 дэх тал.

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Хууль зүй, дотоод хэргийн яам хэмээн тодорхойлсон байдаг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, ялангуяа мөрдөн шалгах ажиллагаанд төрийн захиргааны байгууллагыг татан оролцуулахад хүргэж, ингэснээрээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ төрлийн чиг үүрэггүй байгууллагыг үүрэгжүүлэн нэгтгэж, хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдалд шууд сөрөг нөлөө үзүүлэхэд хүрдэг. Тухайлбал:

-Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас гадаадын тодорхой улсад хүргүүлэхэд, хүсэлтийг хүлээн авагч талаас “гэрээний төв байгууллага нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам тул танай хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй” гэсэн хариуг ирүүлж, ингэснээрээ нэг хүсэлтийг зарим тохиолдолд 2 удаа явуулах, эсхүл огт хариу ирэхгүй байдалд хүргэж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал хангагдахгүйд хүрч байна.

Үүний шалтгааныг тодорхойлбол:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа”-г Прокурорын байгууллага хариуцах үндэсний хуулийн зохицуулалт нь Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлд тусгагдсан атлаа Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалд “эрх зүйн туслалцаа” мөн адил хамаарахаар байгаа нь хуулийн давхардлыг бий болгож байна.

1.2.1 Нотлох баримт цуглуулах орчин үеийн арга, видео хэлбэрээр мэдүүлэг авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж:

-Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 18 дугаар зүйлийн 18 дахь заалт:

-“Хэрэв аливаа нэг этгээд нь оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд оролцогч нөгөө улсын шүүхийн байгууллагуудад гэрчийн буюу шинжээчийн хувьд хэрэг хэлэлцэхэд байлцах шаардлагатай бол хүсэлт гаргагч оролцогч нөгөө улсын нутаг дэвсгэрт тухайн этгээдийг биечлэн байлцуулах боломжгүй буюу хүсэхгүй тохиолдолд оролцогч эхний улс оролцогч нөгөө улсын хүсэлтээр **видео бичлэг ашиглан дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмуудтай нийцүүлэн боломжийн хэрээр хэрэг хэлэлцэн явуулахыг зөвшөөрч болно**. Оролцогч улсууд хэрэг хэлэлцэх ажиллагааг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын шүүхийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан хүсэлт гаргагч оролцогч улсын шүүхийн байгууллагаар удирдан гүйцэтгүүлэх талаар тохиролцож болно.” гэжээ.

-Үүнээс үзэхэд Монгол Улсын хилийн чанадад байгаа аль ч улсын, эсхүл харьяалалгүй иргэний оршин суугаа улсын Шүүх засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага нь аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хүнийг видео бичлэгээр буюу тодруулбал цахим хэлбэрээр оролцуулах боломжийг тодорхойлсон байна.

-Гэтэл Монгол Улсын Олон улсын гэрээний дээрх заалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дэх “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан **энэ хуулийн дагуу явагдана**.” гэсэн зарчмын заалттай мөн адил зөрчилдөж байгаа тул үндэсний хуулийн холбогдох заалт буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлд багахан нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

1.2.3 Апостилийн талаар:

Апостиль конвенц буюу "**Гадаад орны албан баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай Гаагийн конвенц"** нь Гаагийн Олон Улсын Хүний Эрхийн Хурлаар боловсруулсан олон улсын гэрээ юм. Энэ гэрээгээр, гэрээнд нэгдэн орсон нэг улсад олгосон албан баримт бичигт, мөн гэрээнд нэгдэн орсон нөгөө /өөр улсад хууль эрх зүйн хүчинтэй байх гэрчилгээг олгож болно. Энэ гэрчилгээг **апостиль гэрчилгээ** гэдэг.

Тодорхойлолт. Апостиль гэдэг нэр нь латин хэлний *post illa* гэдгээс гаралтай ба францаар "*эцсийн тэмдэглэл"* гэсэн утгатай. Олон улсын энэ гэрчилгээ нь олон улсын гэрээнд нэгдсэн, тухайн орны хуулиар олгогдсон нотариатын эрхтэй ижил эрхтэйгээр үйлчлэх ба баримт бичгийг хүлээн авч буй орны нотариатын баримтыг орлоно.

Монгол Улс нь 2008 оны 12 дугаар сард уг гэрээнд нэгдэн орсон ба 2010 оны 11 дүгээр сараас Гадаад харилцааны яам Монгол Улсад үйлдэгдсэн бичиг баримтад апостиль гэрчилгээг олгож байна.

Гадаад харилцааны сайдын 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/42 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгох журам"-аар дээрх конвенцийн гишүүн улсуудад хэрэглэгдэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн албан ёсны баримт бичгийг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгох харилцааг зохицуулж байна.

Журмын 1.2-т: "1.2.4. Шүүх, прокурорын байгууллага"-ын баримт бичиг хамаарна гэж заасан.

Олон улсын аливаа гэрээ хэлэлцээр нь харилцан эрх тэгш байх зарчимд тулгуурладаг тул Апостилийн журмаар гадаад улсын төрийн байгууллагаас ирүүлсэн баримтат мэдээллийг Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хуулийн этгээд, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичиг, эрүүгийн хэрэгт ач холбогдолтой баримтат мэдээллийг тухайн **төрийн байгууллагаас үнэн зөвийг баталгаажуулж ирүүлсэн тохиолдолд нотлох баримт болно**." гэсэн агуулгад нийцэхгүй, нотлох баримтаар тооцохгүй гэж үзэх нь хууль хэрэглээний алдаа болно.

1.2.4 Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилтийн хүрээнд хамаарах асуудлын талаар

Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын 40 зөвлөмжийн "G" хэсэг буюу "Олон улсын хамтын ажиллагаа" гэсэн хэсэгт:

Зөвлөмж 35 (Recommendation 35). Тусгай зөвлөмж I, Олон улсын арга хэрэгслүүд

Зөвлөмж 36 (Recommendation 36). - Тусгай зөвлөмж V. Эрх зүйн харилцан туслалцаа

Зөвлөмж 37 (Recommendation 37). Эрх зүйн харилцан туслалцаа

Зөвлөмж 38 (Recommendation 38). Эрх зүйн харилцан туслалцаа: Хөрөнгө царцаах, хураах гэсэн,

Мөн

Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын:

Шууд хэрэгжилт 2 (immediate outcome 2)-т: **Олон улсын хамтын ажиллагаа** гэсэн агуулгууд тус тус тусгагдсан бий.

Эдгээр зөвлөмж, шууд хэрэгжилтийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсад огт зохион байгуулагдаагүй байгаа нэг зүйл бол Зөвлөмж 37-д дурдсан "Эрх зүйн харилцан туслалцаа" гэсэн хэсэг дэх:

“(b) Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх механизмтай байх. Улс орнууд хүсэлтийг шилжүүлж, биелүүлэх төв байгууллагатай байвал зохино. Хүсэлтийг хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүднээс хүсэлтийн удирдлагын системтэй байвал зохино.” гэсэн хэсэгт зайлшгүй анхаарал хандуулах хэрэгтэй.

Тодруулбал:

Энэхүү заалт нь миний тайлангийн “Гуравдугаар асуудлын хүрээнд” гэсэн хэсгийн 3 гэсэн заалтад тусгагдсан Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, Олон улсын гэрээн дэх “Төв байгууллага”-ын асуудлыг оновчтой шийдэхийг зөвлөсний зэрэгцээ “**Хүсэлтийн удирдлагын систем**”-ийг бий болгохыг зөвлөсөн байдаг.

Өөрөөр хэлбэл Прокурорын байгууллагын Цахим бүртгэлийн системд хүсэлтийн удирдлагын асуудлыг тусгаж, хяналттай болгох, эсхүл нэгэнт Төв байгууллагын асуудал бүрэн шийдэгдээгүй, цэгцлэгдээгүй өнөөгийн нөхцөлд:

-Улсын Ерөнхий прокурорын газар

-Хууль зүй дотоод хэргийн яам,

-Гадаад харилцааны яам,

-Хүсэлт гаргасан, эсхүл гадаадаас ирсэн хүсэлт, даалгаврыг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Мөрдөх эрх бүхий байгууллагуудын хамтарсан Цахим мэдээллийн санг бий болгож, хүсэлтийн хөдөлгөөн, хэрэгжилт, үр дүнг явцын болон эцсийн байдлаар нь тооцдог байх боломжийг бий болгох замаар Зөвлөмжид заасныг хэрэгжүүлэх боломжтой.

Бодит бус тохиолдлоор жишээ авъя: Австри улсаас ирүүлсэн Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг тухайн улсын Хууль зүйн асуудал эрхэлсэн байгууллагаас Монгол Улсын Гадаад харилцааны яамаар дамжуулан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлснийг Улсын ерөнхий прокурорын газар дамжуулан хүлээн авч, Эрүүгийн цагдаагийн албаны Мөрдөх нэгжид шилжүүлэн мөрдөн шалгах тодорхой ажиллагаа гүйцэтгүүлж байгаа тохиолдолд тухайн хүсэлтийн дагуу хийгдэж буй ажиллагааны явц үр дүнгийн талаар “Хүсэлтийн удирдлагын систем”-ээс холбогдох ажилтнууд нь мэдээллийг шууд авдаг байх боломж бүрдүүлэх явдал юм.

Энэ нь Монгол Улсаас гадагш явуулсан Эрх зүйн харилцан туслалцаа авах хүсэлтийн хөдөлгөөнд мөн адил гүйцэтгэлийн хяналт тавих, явц, үр дүнгийн талаар мэдээлэл шуурхай авах, үр дүнд чиглэсэн шуурхай арга хэмжээ авахад илүү хялбар боломжийг бий болгох тул туйлын чухал ач холбогдолтой үйл ажиллагаа байх нь гарцаагүй гэж үзэж байна.

СЭДЭВ 2. ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1 Мөрдөн шалгах ажиллагааны харьяалал, прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэл

Энэхүү сэдвийн хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг шуурхай, хялбар болгох боломж бий эсэх, түүнийг хэрхэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болох талаар өгүүлэх болно.

2.1.1 Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажиллагаа

-Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцид

2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр,

-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улс аливаа тайлбаргүйгээр нэгдэн орж, Монгол Улсын Их Хурлаас тус тус соёрхон батлсан нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, нотлох баримт шилжүүлэн авах, өгөх, хөрөнгө буцаах ажиллагаанд үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил эх сурвалж болгон шууд хэрэгжүүлэх боломжтой эрх зүйн албан ёсны, хүчин төгөлдөр хэм хэмжээ тогтоосон актууд болно.

Гэвч ялангуяа эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэдэг шүүгч, прокурорууд дунд Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэж шийдвэр гаргах дадал зуршил, хууль зүйн хэрэглээ төлөвшөөгүй байгааг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байна.

Шүүгч, прокурорууд Олон улсын гэрээг үндэсний хууль, тогтоомжийн нэгэн адил хэрэглэж заншаагүй, хууль хэрэглээний практик тогтоогүйгээс Мөрдөх эрх бүхий байгууллагын алба хаагчид дагаж хэрэглэхгүй байх, хэрэглэх боломжгүй мэтээр ойлгоход хүрдэг.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалтад:

-Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэргийг үйлдсэн этгээдийн мөрдөн байцаалттай холбогдуулан хуулийн эрх хэмжээг өөрийн дотоодын хуульд зааснаар хэрэглэх, тийм гэмт хэрэг үйлдэхийг шаардлагатай хэлбэрээр таслан зогсоох болон тэдгээр гэмт хэргийн хувьд **хууль хэрэгжүүлэх арга хэмжээг илүү үр дүнд хүргэх нөхцөлийг хангахыг эрмэлзэнэ**. гэж, харин

13 дугаар бүлэгт: -Албадан хураах буюу Хөрөнгө хураах ажиллагаа явуулах зорилгоор олон улсын хамтын ажиллагаа явуулах,

14 дүгээр бүлэгт: -Албадан хураасан гэмт хэргийн орлого буюу эд хөрөнгийг захиран зарцуулах,

18 дугаар бүлэгт: -Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зохицуулалтыг бүхэлд нь,

18-р заалтад видео бичлэгээр мэдүүлэг авах ажиллагаа

19 дүгээр бүлэгт: -Хамтарсан мөрдөн байцаалт гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Эдгээр зохицуулалтын хэрэгцээ, шаардлага өнөө цагт нэн тэргүүний ач холбогдолтой боловч “Хамтарсан мөрдөн байцаалт”-ыг дурдсан Монгол Улсын Олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн хэрэглэх боломжтой талаар илэрхийлэхийг хүслээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 19 дүгээр зүйлд:

- “Оролцогч улсууд **нэг буюу түүнээс олон улсад мөрдөн байцаалт, мөрдөн мөшгөлт буюу шүүхийн ажиллагаа явуулах**, холбогдох эрх бүхий байгууллагууд хамтарсан мөрдөн байцаах байгууллага байгуулж болох асуудлаар хоёр буюу олон талт хэлэлцээр байгуулан хамтарсан мөрдөн байцаалт явуулж болно. Холбогдох Оролцогч улсууд нутаг дэвсгэрт нь тийм мөрдөн байцаалт явагдах Оролцогч улсын бүрэн эрхт байдлыг бүрэн дүүрэн хүндэтгэх нөхцөлөөр хангана.” гэжээ.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Мөрдөх эрх бүхий байгууллагууд энэхүү конвенцид нэгдэн орсон аль ч улсын Мөрдөх эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах ерөнхий зохицуулалт байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 48 дугаар зүйлийн “Хууль сахиулах талаар хамтран ажиллах” гэсэн хэсгийн (b) заалтад ч хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар зохицуулсан бий.

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эх сурвалж болгохдоо үндэсний хууль тогтоомжийг илтэд зөрчихгүй байх нь гол болгоомжлолыг байнга бий болгож байдаг. Тухайлбал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:

- “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан **энэ хуулийн дагуу явагдана**.” гэж зааснаас үзэхэд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу цуглуулсан нотлох баримтыг үнэлэх агуулгыг шууд илэрхийлж байгаа юм.

Хуулийг хэрхэн хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой, эсхүл хуулийн аль хэсэгт ямар зохицуулалтыг нэмж, өөрчилснөөр хүрч болох үр дүнгийн талаар дараах зүйлсийг дурдаж болохоор байна.

Мөрдөн шалгах ажиллагааг хамтран явуулах дотоодын байгууллагыг шийдвэрлэх:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харъяалал” гэсэн Хоёрдугаар бүлгийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад:

“Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын харьяаллыг Улсын ерөнхий прокурор, хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний шийдвэрээр тогтооно.” гэсэн хэсгээс,

“Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын харьяаллыг **Улсын ерөнхий прокурор, ... тогтооно**.” гэсэн хэсгийн агуулга нь Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн гэмт хэргийг шалгах мөрдөх эрх бүхий байгууллагын харьяаллыг зөвхөн Монгол Улсын Ерөнхий прокурор тогтоох эрх олгосон буюу тодруулбал хэм хэмжээ тогтоосон заалт болно.

Энэхүү эрх олгосон зохицуулалтыг үйлдэл үйл ажиллагаа болгож журамласан зохицуулалт нь мөн хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь заалтад:

-“Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах **хэд хэдэн байгууллагын эрх хэмжээнд харьяалагдах гэмт хэрэгт** хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.” гэсэн нь нэгээс дээш тооны Мөрдөх эрх бүхий байгууллага хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах, тэдний хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх олгох шийдвэрийг прокурор гаргах хууль зүйн зохицуулалт юм.

Харин мөн хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь заалтад:

- “Энэ хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулж болно.” гэсэн заалтын агуулгаас үзэхэд

Үндэсний Мөрдөх эрх бүхий 3 байгууллага гурвуулаа, эсхүл хоёр нь хамтарсан

мөрдөн шалгах ажиллагааг прокурорын шийдвэрийн дагуу явуулж болох зохицуулалт боловч уг ажиллагааг Монгол Улсын хилийн дотор, эсхүл гадна явуулах асуудлыг тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй нь асуудлыг бий болгож байна.

Шийдвэрлэж болох нэг хувилбар нь:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь заалтад:

-“Энэ хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулж болно.” гэсэн заалтыг,

-“Энэ хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг **дотоод, гадаадад** хамтран явуулж болно.” гэсэн багахан нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд аливаа эргэлзээтэй байдлууд үгүйсгэгдэж, шууд утгаараа Монгол Улсын хилийн дотор ч гадна ч мөрдөн шалгах ажиллагааг хамтран явуулж болох боломж нь Монгол Улсын Олон улсын гэрээний заалттай бүрэн нийцэх боломжтой гэж үзэж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны харьяалал, прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэл:

Дээрх хууль зүйн зохицуулалтуудаас нэгтгэн дүгнэж үзэхэд Монгол Улсын Ерөнхий прокурор нь үндэсний Мөрдөх эрх бүхий байгууллагад мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг даалгаж эрхтэй, харин өөр улсын Мөрдөх эрх бүхий байгууллагад Монгол Улсын Мөрдөх эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг даалгах эрх огтоос олгоогүй, олгох ч боломжгүй гэдэг нь ойлгомжтой.

Иймд прокуророос гарах Мөрдөн шалгах ажиллагааны харьяалал тогтоох шийдвэрт “...*аль нэгэн тодорхой улсыг дурдах*... улсын адил эрх бүхий Мөрдөх байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг Монгол Улсын Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газар”-т даалгаж, харин тухайн байгууллагууд дахь Мөрдөх эрх бүхий нэгж нь прокуророос даалгасан заалтын хүрээнд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 19 дүгээр зүйлд зааснаар “...**хоёр буюу олон талт хэлэлцээр байгуулан** хамтарсан мөрдөн байцаалт” явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам шийдвэрлэгдэнэ.

2.2. Хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох хууль зүйн үндэслэл

Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажиллагааг хууль зүйн хувьд дурдсан аргаар шийдвэрлэсэн тохиолдолд уг ажиллагааны үр дүн болох нотлох баримтыг хэрхэн Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт заасан “нотлох баримт”-аар тооцох вэ гэсэн асуудал зайлшгүй тулгарна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “.. **энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу** олж авсан аливаа баримтат мэдээллийг” зөвхөн хууль ёсны нотлох баримт гэж үзэх,

-мөн хуулийн, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...энэ хуулийн **Дөчин хоёрдугаар бүлэгт** заасан үндэслэл журмаар **гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг** нотлох баримтаар тооцож болно.” гэсэн зохицуулалтууд нь хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтаар үнэлэх боломжийг шууд хязгаарлаж байгаа юм.

Энэ асуудлыг шийдвэрлэж болох бас нэгэн хувилбар нь:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "...энэ хуулийн **Дөчин хоёрдугаар бүлэгт**" гэсэн хэсгийг,

-"...энэ хуулийн **Хоёр, Дөчин хоёрдугаар бүлэгт**" гэсэн өөрчлөлтийг тусгаснаар үндэсний хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээний заалтыг уялдаа холбоог сайжруулж, үндэстэн дамнаж үйлдэгдсэн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү шуурхай, бодитой болгох сайн үр дагаврыг бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

СЭДЭВ 3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

3.1 Өнөөгийн нөхцөл байдал

Одоогоор эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр хоёр талт гэрээг 19 улс орны Засгийн газартай, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай гэрээг 6 улстай, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх тухай гэрээ 6 улстай хоёр талт гэрээг тус тус байгуулсан бөгөөд эдгээрийг практикт хэрэгжүүлэн ажиллаж байна. Тодруулбал, Авлигын эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд буюу 2018, 2019 онд Хонгконг, Беларусь, Макаотай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр шинээр гэрээ байгуулсан байна.

Дээрх хоёр талт гэрээний дийлэнхийг хуучин социалист тогтолцоотой байсан Ази, Европын орнуудтай тухайн цаг үед байгуулсан тул орчин цагийн эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны төрөл, хэлбэрээс хоцрогдсон, хэт ерөнхий заалттай байгаа юм. Энэ дутагдалтай байдал нь НҮБ-аас баталсан болон бүс нутгийн шинжтэй Авлигын эсрэг конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц зэрэг олон талт гэрээ, конвенцуудад тусгагдсан тусгайлсан тодорхой заалтуудаар нөхөгдөн хэрэгжиж байна.

Монгол Улс НҮБ-аас баталсан хүний эрхийн 43, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбарын 22, дипломат консулын эрх зүйн 4, гэмт хэрэгтэй тэмцэх 25 конвенци, протоколд нэгдэн орсон бөгөөд ийнхүү нэгдэн орсноор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, албан тушаалын болон хар тамхитай холбоотой, хүн худалдаалах зэрэг үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын төвшинд өргөн хүрээнд, үр дүнтэй хамтран ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн гэж хэлж болно. Авлигын эсрэг конвенцийн заалтад тулгуурлан уг конвенцийн гишүүн орнуудтай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хийх боломжтойгоос гадна Монгол Улсын Засгийн газар бусад оронтой байгуулсан хоёр талт гэрээ, хэлэлцээрийн дагуу энэ ажиллагааг хийж байна. Мөн ямар нэг гэрээ байгуулаагүй улс орнуудтай Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу, харилцан ижил төрлийн туслалцаа үзүүлэх амлалт өгч, баталгаа гаргах замаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлж буй туршлага бий.

3.2 Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх албан бус арга хэрэгсэл

Дэлхий нийтэд дараах 2 хамтын ажиллагаа түгээмэл хэрэглэгдэж байна. Үүнд:

1. Албан ёсны буюу Эрүүгийн эрх зүйн талаар харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа (MLA)
2. Албан бус буюу 2, эсхүл хэд хэдэн талт шууд харилцаа (цахим шуудан, интернэт харилцааны сувгууд, телефон утас гэх мэт), мөн Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээ, сувгуудыг ашиглах.

Үүнээс шалтгаалж миний тайланд дараах 3 хүрээнд асуудлыг авч үзэх болно.

1. Албан ёсны буюу Эрүүгийн эрх зүйн талаар харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа (MLA)
2. Албан бус буюу 2, эсхүл хэд хэдэн талт шууд харилцаа (цахим шуудан, интернэт харилцааны сувгууд, телефон утас гэх мэт), мөн Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээ, сувгуудыг ашиглах.
3. Гуравдагч боломжийн талаар:

- Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажиллагаа, үр дүнг нотлох баримтаар үнэлэх боломж
- Монгол Улсын 2 талт болон Олон улсын гэрээний Төв байгууллагын асуудал
- Нотлох баримт цуглуулах орчин үеийн арга, видео хэлбэрээр мэдүүлэг өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломж:
- Апостилийн баримт бичгийг нотлох баримтаар тооцох боломж
- Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын зөвлөмж, шууд хэрэгжилтэд дурдсан болон бусад асуудал юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг журамлах ерөнхий зохицуулалтыг, харин Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт хэрэгжүүлэх субъектын эрх зүйн байдлыг тодорхойлохдоо:

-“Прокурорын төв байгууллага нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар дараах ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага байна” гэсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг асуудал нь:

-“...олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол” гэсэн утга агуулга бөгөөд учир нь Монгол Улсын 2 талт “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ”-нүүдэд **гэрээний тал нь**

-Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хууль зүйн яам (....)

-Прокурорын байгууллага (ОХУ) гэх мэтээр зөрүүтэй заасан байдгаас Монгол Улсын Прокурорын байгууллага нь ихэнх тохиолдолд гадаадын ижил эрх бүхий байгууллагатай шууд харилцаж, эрх зүйн харилцан туслалцаа авах боломжгүй болдог.

Дурдсан шалтгаанаас улбаатайгаар Эрх зүйн туслалцааны хүсэлт явах болон буцаж ирэх зам:

-Мөрдөх эрх бүхий байгууллага

-Монгол Улсын Ерөнхий прокурорын газар

-Хууль зүйн дотоод хэргийн яам

-Гадаад харилцааны яам

-Хүсэлтийг хүлээн авах улс дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар

-Хүсэлтийг хүлээн авагч улсын Гадаад харилцааны яамаар дамжин тухайн улсын эрх бүхий аль нэг байгууллагад хүрэх болдог.

Албан бичиг хэргийн хувьд энэ нь ямар нэгэн хуулбар бус эхээрээ, дипломат шуудангаар хүрнэ.

Дээрх замаас үзэхэд Гадаад улсын эрх бүхий байгууллага хүртэл мөрдөгчийн гараас гарсан даалгавар нь хамгийн багадаа 7 шат дамжиж очих газраа хүрээд, хэрэв даалгавар нь орчуулгын алдаагүй, шаардлага хангасан бол мөрдөн шалгах тодорхой ажиллагааны үр дүн нь дээрх замаар буцаж ирдгээс хугацаа алдах, хэрэг шийдвэрлэгдэхгүй байх асуудал үүсдэг.

Албан бичиг баримтыг эхээр нь, гарын үсэгтэйгээр (зарим тохиолдолд тамгатай) ирүүлэхийг Монгол Улсын төрийн аль ч байгууллага шаарддаг.

Монгол Улсын Мөрдөх эрх бүхий байгууллагуудын мөрдөгчдийн дунд гадаад хэлтэй мөрдөгчид цөөнгүй байдаг тул гадаад улсын адил эрх бүхий шаардлагатай байгууллагын албан ёсны хаяг руу и-мэйл бичих зэргээр шууд харилцаа үүсгэж чаддаг.

Ялангуяа Авлигатай тэмцэх газар энэ чиглэлээр маш шуурхай, үр дүнтэй ажиллаж чаддагийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас Эрүүгийн цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар, Интерполын үндэсний товчоо нь тодорхой гадаад улсын Үндэсний Цагдаагийн байгууллага, Интерпол, Европол, Хар тамхитай тэмцэх чиглэлийн зэрэг олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны суваг, сүлжээтэй, харин Тагнуулын байгууллага нь өөрийн чиглэлээр гадаад хамтын ажиллагааг шуурхай, үр дүнтэйгээр тус тусдаа зохион байгуулж чадаж байна.

Харин Мөрдөн шалгах, яллах чиг үүргийг дагнан хэрэгжүүлж, шүүхээс өмнөх шатны хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан чиглүүлж буй Прокурорын байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт заасан зөвхөн албан ёсны буюу “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа”-д илүү анхаарал хандуулж байна.

Орчин үеийн өндөр хурдацтай хөгжлийн цаг үед Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг 2 үе шаттайгаар хэрэгжүүлдэг нийтлэг арга барил нэгэнт тогтсон байна.

1 дүгээр үе. Урьдчилан мэдээлэл олох, солилцох

2 дугаар үе. Урьдчилан цуглуулсан мэдээллийг шилжүүлэн авах буюу “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа” (MLA) юм.

Монгол Улс дахь Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа нь 2 дугаар үеийг **“харанхуйгаар хэрэгжүүлэх”** хэлбэрээр явагдаж байна гэж дүгнэж болохоор байгаа. Тодруулбал: Гадаадын аль улсын, ямар байгууллагаас ямар нотлох баримтыг хэрхэн авах талаар даалгавар, хүсэлтийг урьдчилан судлах, мэдээлэл солилцохгүйгээр шууд хүргүүлж байгааг ийнхүү нэрлэхээс өөр аргагүй байдалд хүргэж байгаа юм.

Харин Авлигатай тэмцэх газрын хувьд шилжүүлэн авах мэдээлэл, нотлох баримтын эх сурвалжийг олсон, эсхүл урьдчилан харилцсан үр дүндээ тулгуурлан, аль улсын, ямар байгууллагаас юу авахыг төлөвлөж прокурорт танилцуулдаг, зарим тохиолдолд эрх зүйн туслалцааны албан ёсны хүсэлт Прокурорын байгууллагаар дамжин очсон улсын холбогдох байгууллагатай хүсэлтийн мөрөөр харилцаа үүсгэдэг, эсхүл харилцаа үүсгэхийг бүх талаар хичээдэг нь илүү сайн үр дүнд хүргэж байгаа.

Харин гадаад улсын эрх бүхий байгууллагууд руу Монгол Улсын Мөрдөх эрх бүхий байгууллагаас хүсэлтийн дагуу харилцахад, гэрээний тал нь прокурор бус ХЗДХЯ байгаа гэсэн шалтгаанаар харилцахаас татгалзаж, хүсэлт хүргүүлсэн Монгол Улсын Прокурорын байгууллагатай эргэж холбогдох, мэдээлэл солилцох, тодруулах зэргээр эргэж холбогддог. Гэвч гадаадын эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд нь Монгол Улсаас шууд харилцаа үүсгэхийг оролдсон тохиолдол бүрд шууд татгалздаггүй болохыг дурдах нь зүйтэй.

Тодорхой хэрэгт хяналт тавьж буй гадаад хэлтэй прокурор нь нотлох баримт болон бусад шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг олох зорилгоор гадаад улсын ижил эрх бүхий байгууллага болон олон улс, бүс нутгийн сүлжээ рүү шууд

хандах боломжийг дэлхий нийтээр маш түгээмэл ашиглаж байна.

Одоогоор прокуроруудад тулгарч буй гол бэрхшээл бол:

-Гадаад хэл

-Харилцааны арга хэрэгслийг мэддэггүй явдал юм.

Гадаад хэлний хувьд хувь хүн өөрийгөө хөгжүүлэх нь нэн тэргүүний асуудал.

Прокурорын байгууллагаас 2021 оноос эхлүүлэн англи хэлний шаталсан хөтөлбөрүүдийг зохион байгуулж байгаа бөгөөд сургалтад хамрагдсан прокурорууд гадаад харилцаанд шууд тэнцэхүйц хэлний мэдлэг, дадлага олж авах нь чухал байна.

Харилцааны арга хэрэгсэл гэдэгт олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын жагсаалтыг авч үзэж болно.

Энэ төрлийн мэдээллийн хамгийн баталгаатай эх сурвалжид Дэлхийн банкны СтАР (StAR) санаачлагаас хэвлүүлсэн Хөрөнгө буцаах ажиллагаа-Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага[6] номыг дурдаж болно. Уг бүтээлд тодорхой улс, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, тэдэнтэй харилцах сувгууд буюу албан ёсны вебсайт, цахим хаяг эх сурвалжуудын талаарх мэдээллүүдийг дараах байдлаар нэгтгэсэн байна. Тодруулбал:

Stolen Asset Recovery (StAR) Initiative

- StAR website: https://star.worldbank.org/
- StAR, Asset Recovery Guides (country-wise): https://star.worldbank.org /ArabForum/asset-recovery-guides
- StAR, Beneficial Ownership Guides (country-wise): https://star.worldbank.org /content/beneficial-ownership-guides
- StAR publications: https://star.worldbank.org/?q=publications&keys =&sort_by=field_date_value&sort_order=DESC&items_per_page=20
- StAR Asset Recovery Watch Database: https://star.worldbank.org/corruption -cases/?db=All

World Bank Group

- World Bank: https://www.worldbank.org/
- Financial Integrity Unit: https://www.worldbank.org/en/topic /financialmarketintegrity

United Nations

- United Nations: https://www.un.org/en/
- United Nations Office on Drugs and Crime (UNODC): https://www.unodc.org/
- United Nations Mutual Legal Assistance (MLA) Request Writer Tool (for criminal justice system practitioners only): https://www.unodc.org/mla/
- UNODC TRACK platform (Tools and Resources for Anti-Corruption Knowledge): https://www.unodc.org/unodc/en/corruption/track.html
- UNODC Documents, Publications, and Tools: https://www.unodc.org/unodc /en/corruption/publications.html
- UNODC International Money Laundering Information Network (IMOLIN): https://www.

[6] "Brun, Jean-Pierre, Anastasia Sotiropoulou, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson. 2021. Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, second edition. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1616-1. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO"

imolin.org/

- UNODC SHERLOC (Sharing Electronic Resources and Laws on Crime): https://sherloc.unodc.org/cld/v3/sherloc/

Financial Action Task Force (FATF) on Money Laundering

- FATF: http://www.fatf-gafi.org
- FATF 40 Recommendations: https://www.fatf-gafi.org/publications /fatfrecommendations/documents/fatf-recommendations.html

Basel Institute on Governance

- Home page: https://www.baselgovernance.org/

International Conventions, Treaties, and Agreements

(year instrument adopted / year entered into force)

International Instruments

- United Nations Convention against Corruption (UNCAC): https://www.unodc .org/unodc/en/treaties/CAC/
- United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances, 1988: http://www.unodc.org/unodc/en/treaties/illicit -trafficking.html
- United Nations Convention against Transnational Organized Crime (UNTOC) https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html
- Organisation for Economic Co-operation and Development Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (OECD Anti-Bribery Convention): http://www.oecd.org/daf/anti -bribery/ConvCombatBribery_ENG.pdf
- Multilateral Convention on Mutual Administrative Assistance in Tax Matters, OECD and Council of Europe: https://www.oecd.org/tax/the-multilateral -convention-on-mutual-administrative-assistance-in-tax-matters -9789264115606-en.htm
- Inter-American Convention against Corruption, Organization of American States (OAS): http://www.oas.org/en/sla/dil/inter_american_treaties_B-58 _against_Corruption.asp
- Inter-American Convention on Mutual Assistance in Criminal Matters, OAS: https://www.oas.org/juridico/english/treaties/a-55.html

Regional Instruments

- Commonwealth of Independent States (CIS) Convention on Legal Assistance and Legal Relations in Civil, Family and Criminal Matters (Minsk Convention, 1993/1994): http://www.cisarbitration.com/2017/02/03/minsk-convention-on -legal-assistance-and-legal-relations-in-civil-family-and-criminal-matters/
- African Union Convention on Preventing and Combating Corruption (2003/2006): https://au.int/sites/default/files/treaties/36382-treaty-0028 _-_african_union_convention_on_preventing_and_combating_corruption_e.pdf
- Southern African Development Community (SADC) Protocol against Corruption (2001/2003): https://www.sadc.int/documents-publications/show/
- SADC Protocol on Mutual Legal Assistance in Criminal Matters (2002/2007): https://www.sadc.int/documents-publications/show/807
- Treaty on Mutual Legal Assistance in Criminal Matters (2004, Association of

Southeast Asian Nations [ASEAN] Legal Instruments): https://asean.org/storage /2020/02/20160901074559.pdf; http://agreement.asean.org/home/index/2.html

European Union (EU) and Council of Europe (COE) Conventions

- Council of Europe Treaty Office: https://www.coe.int/en/web/conventions/
- COE Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime (1990), revised as the Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime and on the Financing of Terrorism (2005): https://www.coe.int/en/web/conventions/full -list/-/conventions/treaty/198
- Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (European Convention on Human Rights, 1950/1953): https://www.echr.coe.int /pages/home.aspx?p=basictexts
- Convention on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (Convention of Lugano, 2007): https://eur-lex .europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A22007A1221%2803%29
- 1968 Brussels Convention on Jurisdiction and the Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (Brussels Convention, 1968/1973): https://eur -lex.europa.eu/legal-content/GA/TXT/?uri=CELEX:41968A0927(01)
- European Convention on Mutual Assistance in Criminal Matters (1959/1962): https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/030; with two additional protocols:
- 1978/1982: https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions /treaty/099
- 2001/2004: https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions /treaty/182
- Convention drawn up on the basis of Article K.3 (2) (c) of the Treaty on European Union on the fight against corruption involving officials of the European Communities or officials of Member States of the European Union (1997): https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A419 97A0625%2801%29
- COE Criminal Law Convention on Corruption (1999/2002): https://www.coe .int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/173#:~:text=The%20 Criminal%20 Law%20Convention%20on,the%20prosecution%20of%20 corruption%20offences
- COE Civil Law Convention on Corruption (1999/2003): https://www.coe.int /en/web/conventions/full-list/-/conventions/treaty/174

EU and COE Regulations, Directives, and Decisions

- EU legal documents: https://eur-lex.europa.eu/homepage.html
- Council of the European Union Framework Decision 2003/577/JHA on the Execution in the European Union of Orders Freezing Property or Evidence: https://www.ejn-crimjust.europa.eu/ejn/libcategories.aspx?Id=24; and Corrigendum to Council Framework Decision 2003/577/JHA: https://eur-lex .europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32003F0577; https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX-%3A32003F05 77R%2801%29
- Council of the European Union Framework Decision 2005/212/JHA of 24 February 2005 on Confiscation of Crime-Related Proceeds, Instrumentalities and Property: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/NIM /?uri=CELEX:32005F0212
- Council of the European Union Framework Decision 2006/783/JHA of 6 October 2006 on the Application of the Principle of Mutual Recognition to Confiscation Orders: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/NIM /?uri=CELEX%3A32006F0783

- Council Decision 2007/845/JHA of 6 December 2007 Concerning Cooperation between Asset Recovery Offices of the Member States in the Field of Tracing and Identification of Proceeds from, or Other Property Related to, Crime: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32007D0845
- Council Regulation (EC) No. 44/2001 of 22 December 2000 on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT /?uri=CELEX%3A32001R0044
- Council Regulation (EC) No. 1206/2001 of 28 May 2001 on Cooperation between the Courts of the Member States in the Taking of Evidence in Civil or Commercial Matters: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL /?uri=CELEX%3A32001R1206
- Regulation (EU) No. 1215/2012 of the European Parliament and of the Council of 12 December 2012 on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (recast Brussels I Regulation): https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX:32012R1215
- Directive 2014/42/EU of the European Parliament and of the Council of 3 April 2014 on the Freezing and Confiscation of Instrumentalities and Proceeds of Crime in the European Union: https://eur-lex.europa.eu/legal-content/EN /TXT/?uri=CELEX-%3A32014L0042
- Regulation (EU) 2018/1805 of the European Parliament and of the Council of 14 November 2018 on the Mutual Recognition of Freezing Orders and Confiscation Orders: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32018R1805

G-8 Best Practice Principles

- G-8 Best Practice Principles on Tracing, Freezing and Confiscation of Assets: https://www.justice.gov/sites/default/files/ag/legacy/2004/06/03/G8_Best _Practices_on_Tracing.pdf
- G-8 Best Practices for the Administration of Seized Assets: https://docplayer.net/16960901-G8-best-practices-for-the-administration-of-seized-assets.htm

EU, Council of the European Union, and COE Websites

Main sites

- Official website of the European Union: http://europa.eu/index_en.htm and European Council/Council of the European Union: https://www.consilium .europa.eu/
- Mutual Legal Assistance (COE): https://www.coe.int/en/web/transnational -criminal-justice-pcoc/mutual-legal-assistance

Civil and commercial matters

- European Justice, European Judicial Network in civil and commercial matters: https://e-justice.europa.eu/content_european_judicial_network_in_civil_and _commercial_matters-21-en.do
- European Commission, Civil Justice: https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/civil-justice_en
- European Justice, European Judicial Atlas in civil matters (practical information on judicial cooperation in civil matters): https://e-justice.europa.eu/content _european_judicial_atlas_in_civil_matters-321-en.do
- European Justice, Taking Evidence, national information and online forms concerning Regulation No. 1206/2001: https://e-justice.europa.eu/content _taking_evi-

dence-374-en.do

Criminal matters

- European Justice, European Judicial Network in criminal matters: https://e-justice.europa.eu/content_ejn_in_criminal_matters-22-en.do
- EUR-Lex, Glossary of Summaries of EU Legislation on Police and Judicial Cooperation in Criminal Matters: https://eur-lex.europa.eu/summary/glossary /police_judicial_cooperation.html
- European Parliament, Judicial Cooperation in Criminal Matters: https://www .europarl.europa.eu/factsheets/en/sheet/155 /judicial-cooperation-in-criminal-matters
- EUR-Lex, Summaries of EU Legislation on Judicial Cooperation in Criminal Matters: https://eur-lex.europa.eu/summary/chapter/2303.html
- EUR-Lex, Green Paper on Obtaining Evidence in Criminal Matters From One Member State to Another and Securing Its Admissibility, November 2009: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT /?uri=CELEX%3A52009DC0624

Open-Source Intelligence (OSINT) Asset-Tracing Resources

Free Sites (general information, public records, business records, asset tracing, banking records)

- Open Corporates: https://opencorporates.com/ (company registries and company records)
- Open Ownership: https://www.openownership.org/ (beneficial ownership information)
- Opentender: https://opentender.eu/start (procurement data in the EU)
- EveryPolitician: https://everypolitician.org/ (politically exposed person [PEP] data)
- TinEye: https://tineye.com/ (reverse image search)
- FlightAware: https://flightaware.com/ (flight tracker)
- Internet Archive: http://www.archive.org/web/web.php
- SearchSystems.net: http://www.searchsystems.net (“invisible web” search of public records and company records—worldwide)
- Electronic Data Gathering, Analysis, and Retrieval (EDGAR) system: http://www.sec.gov/edgar.shtml (US company records)
- ZoomInfo: http://www.zoominfo.com (people and company finder)
- White Pages: https://people.yellowpages.com/whitepages/ (people finder)
- World Legal Information Institute (WorldLII): http://www.worldlii.org (legislation and court decisions)
- Companies House: http://www.companieshouse.gov.uk (UK company records, insolvency records, persons of significant control)
- Node XL, Social Media Research Foundation: https://www.smrfoundation.org /nodexl/ (social network and media analysis tool)
- SAM.gov, US General Services Administration: https://sam.gov/SAM/pages /public/searchRecords/search.jsf (search engine for records on entities doing business with the US government)
- Court Lookup, Public Access to Court Electronic Records (PACER) (free information on US court websites): https://pacer.uscourts.gov/file-case/court -cmecf-lookup

Subscription Sites

- Dun & Bradstreet: https://www.dnb.com/
- Arachnys: https://www.arachnys.com/
- Refinitiv: https://www.refinitiv.com/en
- TRACE International: https://www.traceinternational.org/
- LexisNexis: http://www.lexisnexis.com (public records, court decisions, media reports, business records, people searches, and so on)
- CompanyDocuments: http://www.companydocuments.com (business records—worldwide)
- CorporateInformation: http://www.corporateinformation.com (company records) Appendix J. Web Resources I 399
- FCPA Tracker: https://fcpatracker.com/ (public disclosures by companies and agencies related to Foreign Corrupt Practices Act [FCPA] investigations)
- Clear (Thompson Reuters): http://www.clear.thomsonreuters.com (public records, company records—worldwide)
- FreeERISA: http://www.freeerisa.com (US employee benefits data)
- Echosec: https://www.echosec.net/features (social media monitoring)
- IBM Security i2 Analyst's Notebook: https://www.ibm.com/products/analysts -notebook (tools for analyzing and uncovering connections and patterns in data)

Media, Civil Society, and Private Sector Resources

- Transparency International: https://www.transparency.org/en/
- Global Witness: https://www.globalwitness.org/en/
- Global Financial Integrity (GFI): https://gfintegrity.org/
- Global Integrity: https://www.globalintegrity.org/
- Public Eye: https://www.publiceye.ch/en/
- International Consortium of Investigative Journalists (ICIJ): https://www.icij.org/
- Organized Crime and Corruption Reporting Project (OCCRP): https://www.occrp.org/en
- Tax Justice Network (TJN): https://www.taxjustice.net/
- Partnering Against Corruption Initiative (PACI) of the World Economic Forum: https://www.weforum.org/communities/partnering-against-corruption -initiative

Specialized Asset Management Offices in Selected Countries

- Belgium: Belgian Central Office for Seizure and Confiscation (COSC), https://ec .europa.eu/avservices/photo/photoByReportage.cfm?sitelang=en&ref=020472
- Canada: Canadian Seized Property Management Directorate, https://www.btb .termiumplus.gc.ca/tpv2alpha/alpha-eng.html?lang=eng&i=&index=alt&srchtxt=SEIZED%20PROPERTY%20MANAGEMENT%20DIRECTORATE
- France: Agency for the Recovery and Management of Seized and Confiscated Assets (AGRASC), http://www.justice.gouv.fr/justice-penale-11330 /agrasc-12207/
- Honduras: Office for the Administration of Seized Property (OABI), https://oabi.gob.hn/
- Italy: National Agency for Seized and Confiscated Assets (ANSBC): https://www.benisequestraticonfiscati.it/

- Netherlands: Asset Management Office of the Dutch Criminal Assets Deprivation Bureau (BOOM), https://www.prosecutionservice.nl/
- Peru: National Seized Property Commission (CONABI), http://www.pcm.gob .pe/etiqueta/comision-nacional-de-bienes-incautados-conabi/
- Portugal: Asset Management Office (GAB), https://igfej.justica.gov.pt/Gabinete -de-Administracao-Bens
- Romania: National Agency for the Management of Seized Assets (ANABI), https:// anabi.just.ro/en/The+mission+and+the+tasks+of+the+Agency
- Spain: Asset Recovery and Management Office (ORGA), https://www.mjusticia .gob. es/cs/Satellite/Portal/es/areas-tematicas/oficina-recuperacion-gestion
- Thailand: Anti-Money Laundering Office (AMLO), http://www.amlo.go.th /index.php/ en/about-amlo/vision-and-mission
- Ukraine: National Agency for Finding, Tracing, and Managing Assets Derived from Corruption and Other Assets, https://arma.gov.ua/en/
- United States: US Marshals Service, https://www.usmarshals.gov/

Practitioner Networks and Resources

- StAR, International Partnerships on Asset Recovery: Overview and Global Directory of Networks: https://star.worldbank.org/sites/star/files/networks-16 -reduced-maps. pdf
- Camden Asset Recovery Inter-Agency Network (CARIN): https://www.carin .network/
- ARIN-SA (Asset Recovery Inter-Agency Network Eastern and Southern Africa): https://new.arinsa.org/
- ARIN-EA (East Africa): https://eaaaca.com/about-arinea
- ARIN-AP (Asia Pacific): http://www.arin-ap.org/main.do
- ARIN-CARIB (Caribbean): https://arin-carib.org/
- ARIN-WCA (West and Central Asia): http://www.arin-wca.org/home
- RRAG (in South America, the GAFILAT Asset Recovery Network, “GAFILAT” being the Financial Action Task Force of Latin America): https://www.gafilat .org/index.php/ es/espanol/18-inicio/gafilat/49-red-de-recuperacion-de -activos-del-gafilat-rrag
- Egmont Group: https://egmontgroup.org/en
- Interpol: https://www.interpol.int/en
- Interpol, Anti-Corruption and Asset Recovery: https://www.interpol.int/en /Crimes/Corruption/Asset-recovery
- Europol: https://www.europol.europa.eu/
- Secure Information Exchange Network Application (SIENA): https://www .europol.europa.eu/activities-services/services-support/information-exchange /secure-information-exchange-network-application-siena
- Aseanapol: http://www.aseanapol.org/
- Ameripol: http://www.ameripol.org/
- OECD Automatic Exchange Portal (for cooperation on tax matters): https://www.oecd.org/tax/automatic-exchange/
- World Customs Organization (WCO): http://www.wcoomd.org/
- Arab Anti-Corruption and Integrity Network (ACINET): http://www .arabacinet.org/in-

dex.php/en/home

- Iberoamerican Association of Public Ministers (AIAMP): http://www.aiamp .info/
- European Judicial Network (EJN): https://www.ejn-crimjust.europa.eu/ejn /ejn_home/EN
- Eurojust: http://www.eurojust.europa.eu/pages/home.aspx
- International Association of Prosecutors: https://www.iap-association.org/
- Bank for International Settlements (BIS): https://www.bis.org/
- International Organization of Securities Commissions (IOSCO): https://www .iosco.org/
- International Association of Insurance Supervisors (IAIS): https://www.iaisweb .org/home

Country-Specific International Cooperation Resources

Australia

- Information on mutual assistance, alternatives to mutual legal assistance, and contact details of central authority: https://www.ag.gov.au/international -relations/international-crime-cooperation-arrangements/mutual-assistance
- International relations, including information on serving legal documents, enforcement of foreign judgments, and bilateral treaties: https://www.ag.gov .au/international-relations
- Department of Foreign Affairs and Trade: https://www.dfat.gov.au/
- Australian Federal Police: https://www.afp.gov.au/
- Attorney-General's Department: https://www.ag.gov.au/
- Australian Transaction Reports and Analysis Centre (AUSTRAC) (financial intelligence unit): https://www.austrac.gov.au/
- Commonwealth Director of Public Prosecutions: http://www.cdpp.gov.au/

Brazil

- Ministry of Justice and Public Security: https://www.gov.br/mj/pt-br
- Ministry of Justice and Public Security, International Legal Cooperation: https://www.justica.gov.br/sua-protecao/cooperacao-internacional
- Ministry of Foreign Relations: http://www.itamaraty.gov.br/
- Financial Activities Control Council (COAF) (financial intelligence unit): http://www.coaf.fazenda.gov.br/
- Legislation Portal: http://www4.planalto.gov.br/legislacao/

France

- Ministry of Foreign Affairs: https://www.diplomatie.gouv.fr/en/
- Ministry of Justice: http://www.justice.gouv.fr/
- Tracfin (financial intelligence unit): https://www.economie.gouv.fr/tracfin
- National Police: https://www.police-nationale.interieur.gouv.fr/Accueil
- FICOBA (repository of bank accounts): https://www.service-public.fr /particuliers/vosdroits/F2233
- Légifrance (official publication of legislation, regulations, and legal information):

https://www.legifrance.gouv.fr/

- Agence Française Anticorruption (AFA): https://www.agence-francaise -anticorruption.gouv.fr/fr

Germany

- Federal Foreign Office: https://www.auswaertiges-amt.de/en
- Federal Ministry of Justice and Consumer Protection: https://www.bmjv.de/DE /Startseite/Startseite_node.html
- Federal Ministry of Justice and Consumer Protection (International Cooperation): https://www.bmjv.de/DE/Themen/IntZusammenarbeit /IntZusammenarbeit_node.html
- Federal Ministry of Justice and Consumer Protection (Europe and International Cooperation): https://www.bmjv.de/DE/Themen/EuropaUndInternationale Zusammenarbeit/EuropaUndInternationaleZusammenarbeit_node.html
- Financial Intelligence Unit: https://www.zoll.de/DE/FIU/fiu_node.html
- Federal Criminal Police (BKA): https://www.bka.de/DE/UnsereAufgaben /Aufgabenbereiche/aufgabenbereiche_node.html
- German legal provisions: http://www.gesetze-im-internet.de/
- National Procedures for Mutual Legal Assistance: https://rm.coe.int /16806b6348

Hong Kong SAR, China

- Department of Justice: https://www.doj.gov.hk/eng/index.html
- List of Mutual Legal Assistance Agreements (Legislative References): https://www.doj.gov.hk/eng/laws/table3ti.html
- Ministry of Foreign Affairs (Office of the Commissioner of the Ministry of Foreign Affairs of the People's Republic of China in the Hong Kong Special Administrative Region): http://www.fmcoprc.gov.hk/eng/
- Independent Commission Against Corruption: https://www.icac.org.hk/
- Joint Financial Intelligence Unit: https://www.jfiu.gov.hk/en/

India

- MLA information, Ministry of External Affairs: https://mea.gov.in/mutual -legal-assistance-in-criminal-matters.htm and https://www.mea.gov.in/emtsp .htm
- Indian Central Bureau of Investigation (investigation assistance, letters rogatory, MLA treaties): http://www.cbi.gov.in/interpol/interpol.php
- Ministry of Law and Justice: https://lawmin.gov.in/
- Directorate of Enforcement: https://enforcementdirectorate.gov.in
- Financial Intelligence Unit: https://dor.gov.in/preventionofmoneylaundering /financial-intelligence-unit-india-fiu-ind
- Ministry of Home Affairs (central authority): https://www.mha.gov.in/
- Ministry of Home Affairs, Internal Security-II Division (also issues policy guidelines on mutual legal assistance): https://www.mha.gov.in/division_of _mha/internal-security-ii-division

Luxembourg

- European Judicial Network (EJN) in Civil and Criminal Matters (information on civil processes, taking of evidence and mode of proof, and service of documents): https://

e-justice.europa.eu/content_taking_of_evidence-76-lu-en .do?member=1

- Ministry of Foreign Affairs: https://maee.gouvernement.lu
- Ministry of Justice: https://mj.gouvernement.lu/
- Luxembourg–Financial Intelligence Unit (FIU-LUX): https://justice.public.lu/fr /organisation-justice/crf.html

Mexico

- Ministry of Foreign Affairs: https://www.gob.mx/sre
- Deputy Attorney General's and Prosecutor's Offices (request and receive MLA requests on criminal matters): https://www.gob.mx/fgr/acciones-y-programas /subprocuradurias-de-la-fgr
- Financial Intelligence Unit: https://www.uif.gob.mx/

Singapore

- Attorney-General's Chambers (central authority, receives MLA requests): https://www.agc.gov.sg/
- Ministry of Foreign Affairs: https://www.mfa.gov.sg/
- Suspicious Transaction Reporting Office (STRO) (financial intelligence unit): https://www.police.gov.sg/Advisories/Crime/Commercial-Crimes/Suspicious -Transaction-Reporting-Office

South Africa

- National Prosecuting Authority (for informal requests): https://www.npa.gov.za/
- Department of International Relations and Cooperation: http://www.dirco.gov.za/
- Department of Justice and Constitutional Development (central authority for formal MLA requests): https://www.justice.gov.za/
- Department of Justice and Constitutional Development (International Legal Obligations, including service of process and treaties): https://www.justice.gov .za/ilr/about.html
- Financial Intelligence Centre (financial intelligence unit): https://www.fic.gov .za/Pages/Home.aspx
- Public Service Commission (anticorruption authority): http://www.psc.gov.za/

Spain

- European Judicial Network (EJN) in Civil and Commercial Matters: https://e-justice.europa.eu/content_about_the_network-431-es-es.do?member=1
- Ministry of Foreign Affairs and Cooperation: http://www.exteriores.gob.es/Portal/ en/Paginas/inicio.aspx
- Ministry of Justice: https://www.mjusticia.gob.es/cs/Satellite/Portal/en/ministerio
- Ministry of Justice (International Affairs): https://www.mjusticia.gob.es/cs/ Satellite/Portal/en/area-internacional
- Financial intelligence unit: https://www.sepblac.es/en/

Switzerland

- Federal Office of Justice, International Legal Assistance (criminal, civil, administrative, legal aid): https://www.rhf.admin.ch/rhf/de/home.html

- Federal Office of Justice: https://www.bj.admin.ch/bj/en/home.html
- Database of Swiss Localities and Courts: https://www.elorge.admin.ch/elorge/
- Federal Department of Foreign Affairs (FDFA): https://www.eda.admin.ch/eda /en/home.html
- Office of the Attorney General of Switzerland (OAG): https://www .bundesanwaltschaft.ch/mpc/de/home.html
- Federal Office of Police (police cooperation): https://www.fedpol.admin.ch /fedpol/en/home.html
- Money Laundering Reporting Office (MROS) (financial intelligence unit): https://www.fedpol.admin.ch/fedpol/en/home/kriminalitaet/geldwaescherei.html

United Arab Emirates (UAE)

- Ministry of Justice: https://www.moj.gov.ae/
- Office of Public Prosecution: https://www.pp.gov.ae
- Central Bank of the UAE, Anti-Money Laundering and Suspicious Case Unit (AMLSCU) (financial intelligence unit): See https://www.centralbank.ae/ar and https://egmontgroup.org/en/content/united-arab-emirates-anti-money -laundering-and-suspicious-cases-unit

United Kingdom

- The UK Central Authority (UKCA), Home Office: https://www.gov.uk /government/organisations/home-office
- Guidance on Mutual Legal Assistance, Home Office: https://www.gov.uk /guidance/mutual-legal-assistance-mla-requests
- Crown Prosecution Service (represents requesting state in court proceedings): https://www.cps.gov.uk/about-cps and https://www.cps.gov.uk/legal-guidance /international-enquiries
- Serious Fraud Office (represents requesting state in court proceedings): https://www.sfo.gov.uk/
- National Crime Agency (NCA) (for investigation cases, asset tracing): https://www.nationalcrimeagency.gov.uk/
- UK Financial Intelligence Unit (within the NCA): https://www .nationalcrimeagency.gov.uk/what-we-do/how-we-work/intelligence -enhancing-the-picture-of-serious-organised-crime-affecting-the-uk

United States

- Department of Justice, Money Laundering and Asset Recovery Section (MLARS): https://www.justice.gov/criminal-mlars
- Office of International Affairs, Department of Justice (central authority): https://www.justice.gov/criminal-oia
- Department of State: https://www.state.gov/
- Department of State, Office of Anti-Crime Programs (INL/C): https://2009-2017.state.gov/j/inl/c/index.htm
- Financial Crimes Enforcement Network (FinCEN) (financial intelligence unit): http://www.fincen.gov/
- Federal Bureau of Investigation (FBI), specialized agency: https://www.fbi.gov/;

https://www.fbi.gov/about/leadership-and-structure/international-operations; and https://www.fbi.gov/investigate/public-corruption

- Department of Homeland Security (DHS), Homeland Security Investigations (HSI), specialized agency: https://www.dhs.gov/

Энэхүү жагсаалтаас үзэхэд гадаад хэлний зохих түвшний мэдлэг, чадвартай, мэдээллийн эх сурвалжийг олж чаддаг бол дэлхийн аль ч ямар ч байгууллагатай Монгол Улсын Прокурорын болон Мөрдөх эрх бүхий байгууллагын ажилтнууд шууд харилцаа үүсгэх, идэвхтэй хамтран ажиллахад аливаа саад бэрхшээл байх учиргүй.

Practitioner Networks and Resources гэсэн хэсэгт дурдагдаж буй -ARIN-AP (Asia Pacific): http://www.arin-ap.org/main.do буюу Ази номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний 6 дахь удаагийн албан ёсны уулзалтыг 2019 оны 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулж байсныг Шүүх засаглал, Хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид маань нийтээр огт мэдээгүй, мэдсэн ч ач холбогдлыг нь өнөөдрийг хүртэл төдийлөн ойлгоогүй хэвээр байсаар байгаа нь харамсалтай.

Үүнд байгууллагуудын уламжлалт хандлага, соёл, хувь хүний идэвхгүй байдал саад болж байгааг зөв оношилж, үүнийг шийдвэрлэх нээлттэй арга замыг сонгох нь чухал байна. Тухайлбал:

2019 онд Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FAT-F)-аас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт (Саарал жагсаалт-Gray list) Монгол Улсыг хамруулах үед Засгийн газраас томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байх үед анзаарсан, үйл ажиллагаандаа анхаарвал зохих зүйлүүдээс дурдвал:

-Ялангуяа шүүхээс өмнөх шатны мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлж, яллах ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын Прокурорын байгууллагатай гадаадын Прокурорын болон Мөрдөх эрх бүхий байгууллагууд, Олон улсын болон бүс нутгийн байгууллагууд шууд харилцах, хамтран ажиллах эрмэлзэлтэй байдаг.

-Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улстай үндэстэн дамнасан гэмт хэргийг шалгах, нотлох зорилгоор албан болон албан бус шугамаар хамтын ажиллагаа явуулахад түүхэн тодорхой цаг хугацаанд тус улсын колони байсан, нөлөөллийн бүсэд хамаарч байсан болон өнөөдрийг хүртэл уламжлалт хамтын ажиллагааны хүрээнд нь багтаж байдаг Австрали, Сингапур, Канад, Энэтхэг, Малайз болон Африк тив далайн орнууд, түүнчлэн АНУ-тай ч шууд хамтран ажиллах боломж бий болдог.

-Европын холбооны гишүүн аль нэг улсын эрх бүхий байгууллагатай үндэстэн дамнасан гэмт хэргийг шалгах, нотлох зорилгоор албан болон албан бус шугамаар хамтын ажиллагаа явуулахад тус холбооны гишүүн аль ч улсаас шаардлагатай мэдээллийг дам байдлаар цаг алдалгүйгээр олж авч болдог арга замыг дурдаж болно.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц (нийтээр Палермогийн конвенц гэж ярьдаг), Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод аливаа тайлбаргүйгээр нэгдэн орсон орны хувьд Монгол Улсын Прокурорын болон Мөрдөх эрх бүхий байгууллагууд тухайн конвенцод нэгдэн орсон аль ч улсын адил эрх бүхий байгууллагуудтай шууд харилцаа үүсгэх боломж нээлттэй байгааг төдийлөн үр ашигтайгаар ашиглаж чаддаггүй явдал манай улсын төрийн байгууллагуудын хувьд байсаар байна.

3.3. Гадаад орнуудын сайн туршлага.

Канад Улс[7]

Эрүүгийн хэргийн дугаар №: R нь Vachon-Desjardins эсрэг, 2022 ONCJ 43

Хэргийн товч утга: Энэ хэрэгт байгууллагын компьютерын системд нэвтрэн мөнгө төлөх хүртэл нэвтрэх эрхийг нь хаах зорилготой компьютерын хортой программ хангамж ашиглан цахим гэмт хэрэг үйлддэг "NetWalker" гэх нэртэй зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг юм. Тэд онцгой байдлын алба, хууль сахиулах байгууллага, эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллага, арилжааны байгууллагуудын цахим хуудас, аппликейшнийг онилж, гэмт хэрэг үйлдэхээр шийдсэн.

Шүүгдэгч Себастьян Вачон-Дежарденсийг 2021 онд АНУ-ын хууль сахиулах байгууллагын гэмт этгээдийг шилжүүлэн авах хүсэлтийн дагуу Канад Улсын хууль сахиулах байгууллагын ажилтнууд баривчилж, цагдан хорих арга хэмжээ авсан. Гэхдээ түүнийг АНУ-д шилжүүлэн өгөөгүй бөгөөд учир нь 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Канад Улсад хар тамхи худалдаалсан гэмт хэрэгт буруутган хууль бусаар олсон эд хөрөнгийг хураах, 54 сарын хугацаагаар хорих ял шийтгэсэн. Ингэж шийтгүүлснийхээ дараа тэрээр 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр "NetWalker" гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд оролцож, компьютерын хортой программ нэвтрүүлсэн талаар мэдүүлсэн байна.

Тодруулбал, "Cegep St. Felicien" коллежоос 999.239, "Continental Casualty Company" ХХК-аас 725.963, "Endoceutics Inc" ХХК-аас 72.503, "Enterprise Robert Thibert Inc" ХХК-аас 289.472, "Travellers Ins" ХХК-аас 417.449, "Robson Carpenter LLP" ХХК-аас 2500, "Ville de Montmagny" зочид буудлаас 206.737 канад долларыг тус тус хууль бусаар авсан гэмт хэрэг үйлдсэн байна. Түүнчлэн, дээрх байгууллагуудад компьютерын программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч "Windward Software Systems Inc" ХХК-д 91.966 канад долларын хохирол учруулсан гэж үзсэн.

Ингээд мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж Канад Улсын мөрдөх байгууллагаас "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц"-ийн 2 дахь зүйлийн "а"-д зааснаар *"Зохион байгуулалттай гэмт бүлэглэл"* гэснийг удирдлага болгон Болгарын Үндэсний мөрдөн байцаах алба, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрууд болон АНУ-ын Холбооны мөрдөх товчоо, Хууль зүйн яамны Компьютерын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Оюуны өмчийг хамгаалах хэлтсүүд рүү эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж нотлох баримт, мэдээлэл цуглуулах, хууль бусаар олсон эд хөрөнгийг хураасан байна. Тухайлбал, 680 биткойн, 15.7 Монеро койн (2700$ тэнцэнэ), оршин сууж байсан газраас нь бэлнээр 299.150 канад доллар, Үндэсний банкны 2 тусдаа сейфт хадгалсан байсан 238.620 болон 98.070 ам доллар, "Caisse Populaire" ББСБ-ын дансанд хадгалж байсан 107.000 канад долларыг тус тус хураан авч чадсан. Койныг бусад руу шилжүүлэх, хөрвүүлэх, хураан авах ажиллагааг Холбооны мөрдөх товчооны нууц ажилтан гүйцэтгэсэн.

Хохирол, ял шийтгэл

Канад Улсын Онтариа мужийн шүүхээс дээр дурдсан аж ахуйн нэгжүүдийн хохирлыг барагдуулах, шүүгдэгчийг хортой программ тараасан, нэвтрэх эрхийг нээхийн тулд мөнгө авсан, тухайн мөнгөөр криптовалют худалдан авч мөнгө угаасан, зохион байгуулалттай гэмт бүлэглэлд элсэн орсон гэмт хэрэгт тус тус

[7] НҮБ-ийн Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (2022 он) цахим эх сурвалж: https://sherloc.unodc.org/cld//case-law-doc/cybercrimecrimetype/can/2022/r_v._vachon-desjardins_2022_oncj_43.html?lng=en&tmpl=sherloc

буруутган 6 жил 8 сарын хугацаагаар хорих ял шийтгэж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүн тул түүний ДНХ-ийн мэдээллийг авч нэгдсэн санд оруулахаар шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр нь НҮБ-ын конвенцод хамаарах гэмт хэрэг үйлдсэн тул хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг хураахаар конвенцын заалтыг удирдлага болгосон.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд хэд хэдэн улс дамнан үйлдсэн гэмт хэргийн хувьд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцыг баримтлан эрх зүйн туслалцааны хүсэлт явуулсан байхаас гадна *“Канад Улсын шүүхээс давхар шүүгдэгчийн олсон хууль бус эд хөрөнгийг хураан авахыг даалгасан захирамж гарсан байсан”* нь хохирол нөхөн төлүүлэхэд ач холбогдолтой ажиллагаа болсон байна.

Перу Улс[8]

Эрүүгийн хэргийн дугаар №: Владимиро Монтесинос болон түүний хамсаатнуудын хэрэг

Хэргийн товч утга: Ноён Владимиро Монтесинос нь Перугийн Ерөнхийлөгч Альберто Фужимори (1990–2000)-ийн хувийн туслах бөгөөд тус улсын Тагнуулын байгууллагын жинхэнэ дарга байсан гэж үздэг. Тэрбээр 2000 оны 09 дүгээр сард сөрөг хүчний конгрессын гишүүнд авлига өгсөн хэргээр томоохон авлигын гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан. Перугийн телевизийн сувгаар уг конгрессын гишүүнд 15.000 ам долларын авлига өгч, өөрийнхөө намаас гарч, Фужиморигийн эвсэлд нэгдэхийг хүссэн видеог нь цацжээ. Хэдэн сарын дараа 2000 оны 11 дүгээр сард Ерөнхийлөгч Фужимори нь огцорч, 2001 оны 6 дугаар сард Монтесиносыг Венесуэлд баривчилсан (түүнийг зугтсанаас 8 сарын дараа). Нэмэлт мөрдөн шалгах ажиллагаагаар тэрбээр авлига, төсвийн хөрөнгө шамшигдуулсан, галт зэвсэг ба мансууруулах бодис наймаалах, хүний эрхийг ноцтой зөрчсөн зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон. Улмаар хэд хэдэн зүйл ангиар яллаж, шийтгэл оногдуулсан юм.

Хууль бус эд хөрөнгө

1990 оноос хойш Монтесинос нь галт зэвсэг хууль бусаар наймаалах 32 удаагийн үйлдэл, төлбөр тооцооноос авлига авсан (худалдан авсан дүн бүрээс 18 хувийг тооцож авч байсан), Перу Улсын нисэхийн авиа компаниудын худалдан авсан гурван нисэх онгоцоос урамшуулал авч байсан (Levi, Dakolias, Greenberg 2007) зэрэг олон гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн. Тэрбээр, хууль бус эд хөрөнгөө Швейцарь, Кеймэн арлууд, Люксембург, Перу, АНУ зэрэг улс орнуудад байршуулсныг тогтоосон.

Швейцар Улсад байршуулсан хууль бус хөрөнгө, стратеги төлөвлөлт

Швейцар Улсад царцааж, битүүмжилсэн 49.5 сая ам.доллартой холбоотой тус улсын мөрдөн шалгах Магистраттай хоёр хувилбарыг хэлэлцсэн. Үүнд, Нэгдүгээрт, Монтесиносын авлигын хэргийг Перуд шүүхээр хянан шийдвэрлэж, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх аргыг ашиглан хөрөнгийг буцаан авах болон Хоёрдугаарт, Швейцарт мансууруулах бодис хууль бусаар хилээр нэвтрүүлсэн болон холбогдох мөнгө угаасан хэрэг (хавсарч үйлдсэн хэрэг)-ийг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх байв. Жич, хоёрдугаар хувилбарыг сонговол Перу нь хураан

[8] Дэлхийн банкны Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан хоёр дахь хэвлэл, 2021” хуудас 33, цахим эх сурвалж https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/34843/9781464816161.pdf?sequence=5&isAllowed=y

авсан хөрөнгийн тодорхой хэсгийг Швейцартай хуваалцах шаардлага үүсэх байв.

Иймээс, Перу нь эхний хувилбарыг сонгож, ял тохиролцох арга замыг хуульдаа нэмэлт байдлаар оруулсан. Эрүүгийн хэргийн хөнгөрүүлсэн ял шийтгэл эсхүл шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсний хариуд шүүгдэгч нар нь одоо мэдэгдэж байгаа эсхүл тогтоогдоогүй байгаа гэмт хэрэг, нотлох баримт, гэмт хэргийн улмаас олсон орлого, үндсэн субъектүүдтэй холбоотой гэрчийн мэдүүлэг гаргаж өгөхийг зөвшөөрөх шаардлагатай байсан. Мөн шүүгдэгч нарт гадаадын банкнуудад эзэмшиж байгаа эд хөрөнгийг Перугийн төрийн сангийн данс руу шилжүүлэхийг зөвшөөрч, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурж баталгаажуулах шаардлага тавьсан. Улмаар энэхүү бичиг баримтыг ашиглаж, олон сая ам.долларыг хураан авав. Улмаар, Швейцар болон Перу Улсын үр дүнтэй хамтын ажиллагааны үндсэн дээр нийт 77 сая ам.долларыг Перу руу шилжүүлж чадсан байна.

Кеймен арлуудад орших хууль бус хөрөнгө

Тус улсад байршуулсан хөрөнгийн хувьд Перу Улс нь тус улсын өмгөөлөгчийг ажиллуулж, 33 сая ам.долларыг Перу Улсын банк руу шилжүүлэхэд дэмжлэг авчээ. Мөн тэд Кеймен арлуудын Санхүүгийн тагнуулын албатай уулзаж, туслалцаа эрэлхийлсэн. Улмаар санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэдэн сар гүйцэтгэсний дараа уг хөрөнгийг Кеймен арлууд руу огт шилжүүлээгүй, харин Перу Улсын банканд байсаар байгааг тогтоосон. Зөөл өгөх авах схемийг ашиглан Кеймен арлууд руу мөнгө шилжүүлсэн мэт халхавч үүсгэсэн ч үнэн хэрэгтээ Перугийн банкны дансанд байсаар байгааг тогтоосон. Улмаар уг хөрөнгийг царцааж, хураан авсан байна.

АНУ-д байршуулсан хууль бус хөрөнгө

Перу Улсын эрх бүхий байгууллагууд нь Холбооны мөрдөх товчоотой хамтран Монтесинос болон түүний хамсаатан ноён Виктор Венеро Гарридогийн залилан, авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, 20.2 сая ам.долларыг царцааж, Гарридог түүний орон сууцнаас нь баривчилсан (INL 2005). Мөн Монтесиносын 30 сая ам.долларыг өөрийнхөө нэр дээр эзэмшиж байсан этгээдээс уг хөрөнгийг хураан авсан. АНУ-ын Флорида болон Калифорни мужид болсон шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааны үндсэн дээр хөрөнгө хураан авч, уг хөрөнгийг бүхэлд нь Перу руу буцаасан. *“АНУ болон Перу Улсын хооронд байгуулсан Хөрөнгө буцаан олгох гэрээ”*-ний дагуу уг хөрөнгийг хохирогчдын хохирлыг барагдуулах, тус улсад авлигатай тэмцэх хүчин чармайлтад зарцуулахаар тохиролцсон бөгөөд уг ажиллагааг ил тод нээлттэй байдлаар хэрэгжүүлэхээр тохиролцсон (INL 2005).

Перуд байршуулсан хууль бус хөрөнгө

Перуд нийт 60 гаран сая ам.доллартой тэнцэх үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, усан онгоц, бусад төрлийн эд хөрөнгийг битүүмжилж, хураан авсан. Энэхүү ажиллагаагаар нийт 180 орчим эрүүгийн хэргийн 1200 шүүгдэгчийг шүүхээр хянан шийдвэрлэсэн юм.

Нийт хураан авсан хөрөнгийн дүн

Эцсийн дүндээ нийт 250 сая ам.долларыг Швейцар, АНУ, Перугийн дотоодын банкнуудаас хураан авсан.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

1. Ю.М. Колосов. E.S. Кривчиков. Олон улсын хууль. М. 2000 он
2. М.Дүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ., 1999. 313-331 дэх тал.
3. Монгол Улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. 2020 он. Улаанбаатар. 442-443 дахь тал

Олон улсын эрх зүй гарын авлага

1. Бекяшев К.А. Олон улсын нийтийн эрх зүй. М. 1998. S.541-507.н
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.
3. Дэлхийн банкны Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан хоёр дахь хэвлэл, 2021" хуудас 33, цахим эх сурвалж

Гадаад хэлээр

1. Brun, Jean-Pierre, Anastasia Sotiropoulou, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson. 2021. Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, second edition. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1616-1. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO"

Цахим эх сурвалж

1. https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/34843/9781464816161.pdf?sequence=5&isAllowed=y
2. НҮБ-ийн Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (2022 он) цахим эх сурвалж: https://sherloc.unodc.org/cld//case-law-doc/cybercrimecrimetype/can/2022/r_v._vachon-desjardins_2022_oncj_43.html?lng=en&tmpl=sherloc

БҮЛЭГ 14. ПРОКУРОРЫН СЭТГЭЛ ЗҮЙ БА ХАРИЛЦАА, ХАНДЛАГА

СЭДЭВ 1: БИЕ ХҮНИЙ БОЛОН ПРОКУРОРЫН СЭТГЭЛ ЗҮЙ

1.1. Бие хүний авир араншин, зан төлөв
1.2. Прокурорын мэргэжлийн тогтсон хандлага, ажлын сэтгэл ханамж
1.3. Түгээмэл тохиолдох сэтгэл зүйн зарим өөрчлөлт

СЭДЭВ 2: ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДТАЙ ҮР НӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦАХ НЬ

2.1. Прокурорын мэргэжлийн сэтгэл зүйн зарим онцлог байдал
2.2. ЭХХША-ны оролцогч нар болон бусад байгууллагын ажилтнуудтай харилцах харилцаа
2.3. Харилцааны ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах арга зам

СЭДЭВ 1: БИЕ ХҮНИЙ БОЛОН ПРОКУРОРЫН СЭТГЭЛ ЗҮЙ

1.1. Бие хүний авир араншин, зан төлөв

Прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх явцын алхам бүрд танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн чухал үүрэгтэй. Прокурорын мэдлэг (хүртэхүй), бие хүний төрөлхийн болон олдмол шинж чанарууд (араншин, зан төлөв), ой тогтоолт, ажлын тогтсон хандлага (ажлын сэтгэл ханамж, ажилдаа үнэнч байх) болон хүмүүс хоорондын харилцаа – эд бүгд танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөний нөлөөнд байна.

Хүмүүс өөр хоорондоо угсаатны гарал, нас, хүйс, бие махбод, гэр бүл, соёл, сэдэлжүүлэлт, тогтсон хандлага, араншин, зан төлөв, оюун ухааны хөгжил, танин мэдэхүйн ур чадвар болон мэдлэг, боловсрол, туршлага, эрүүл мэндээрээ ялгаатай. Бас төсөөтэй. Хүний эдгээр ялгаатай болон төсөөтэй тал прокурорын мэргэжлийн үйл ажиллагаа төдийгүй нийгэм, түүний хөгжилд нөлөөтэй.

Бие хүн (*хоршоо үг*)- нийгмийн бодит байдлыг өөрчлөгч, бүтээгч, үйлдвэрлэгч үйл ажиллагаа, харилцааны гол эзэн, нийгэмших явцад бүрэлдсэн бодгаль хүн. (Монгол хэлний их тайлбар толь)

Бие хүний сэтгэл зүй бол сэтгэл судлалын салбар ухаан. Бие хүний хөгжил, хүмүүс хоорондын сэтгэл зүйн ялгаа, онцлог шинжүүдийг судалдаг. Бие хүний онцлог шинж чанарт авир араншин (темперамент), зан төлөв багтана.

Темперамент: Төв мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагааны тодорхой шинжүүд хүний үйл хөдлөлөөр илрэхийг авир араншин буюу темперамент гэж нэрлэдэг. *Temperamentum* гэдэг латин үгнээс гаралтай. Холимог гэсэн утгатай. Хүний үйл байдлын ерөнхий тодорхойлолт, зан араншин, зан чанар юм. Төрөлхийн буюу генотип шинжтэй.

Темперамент меланхолик, флегматик, сангвиник, холерик гэсэн 4 янз байдаг.

Шинжүүд:

Холерик *– эрс, хурц, огцом түргэн, түрэмгий;*

Флегматик *– тайван, удаан, шаргуу, тэвчээртэй;*

Сангвиник *– сэргэлэн, хөөрөнги, баясгалантай, хөдөлгөөнтэй, халамжтай;*

Меланхолик – сул, түгшимтгий, шийдвэр муутай;

Сайн эсвэл муу темперамент гэж үгүй. Аль аль нь давуу болон сул талтай. Дангаараа бус холимог шинжтэй ч аль нэг нь давамгайлдаг.

Төв мэдрэлийн үйл ажиллагаа ба темперамент хоорондын холбоо:

1. Хүчтэй, тогтворгүй, түргэн (холерик) Тогтворгүй экстраверт–гэнэтийн огцом зантай, хувирамтгай, хөөрүү, тогтож ядсан
2. Хүчтэй, тогтвортой, түргэн (сангвиник) Тогтвортой экстраверт-яриа, хариуцлагатай, нийцтэй, хөгжилтэй, халамжтай
3. Хүчтэй, тогтвортой, удаан (флегматик) Тогтвортой интроверт–тайван, дөлгөөн, амгалан (эв эеийг хичээсэн), нухацтай
4. Сул, тогтворгүй, удаан (меланхолик) Тогтворгүй интроверт–сэтгэл түгшимтгий, олон ааштай, үгээ нөөсөн, гутранги

Мэдрэлийн эсийн түлхэц хурдтай, хүчтэй, тогтворгүй хүмүүс хэт идэвхтэй, дасан зохицох чадвар сул, түрэмгий авиртай тул харилцааны асуудал, сэтгэл зүйн хямрал, сахилга хариуцлага, ёс зүйн зөрчилд өртөмтгий байх талтай.

Олон хүн өөрийн темпераментийг сургалт, ном, зөвлөх үйлчилгээнд суурилан тодорхойлсон байх нь элбэг. Темпераментыг хэмжих сорилууд байдаг ч зан төлөвт суурилан тодорхойлж болно.

Зан төлөв бол олдмол, фенотип шинжтэй, ааш араншингийн багцаа, дүн нуруу юм. Төрж өссөн орчин, цэцэрлэг сургууль, найз нөхөд, мэдээллийн хэрэгсэл зэрэг тодорхой хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөн дор бүрэлдэн тогтдог. Ухамсар, ёс суртахууны төлөвшил, тогтсон хандлага, дотоод итгэлээс гадна тодорхой нөхцөлд асуудлыг шийдэх чадвар, нийцтэй, мэриймтгий, нээлттэй, хаалттай гэх зэрэг шинжүүдийн нийлбэр, дадал зуршил юм. Эдгээр шинжүүдийн холилдоон, харилцан үйлчлэлээс хүмүүсийн цор ганц, онцлог байдал бий болно.

Темперамент, зан төлөвийг тодорхойлох аргууд:

Бие хүний сэтгэл зүйн үнэлгээ, оношилгооны хэрэгслүүд их. Сэтгэл зүйн мэргэжлийн хүний тусламжтай өөрөө өөрийгөө таньж мэдэх, хуульчийн ажил мэргэжил, ахуй амьдралын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрийгөө тохируулах, өөрчлөх, хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Хоёр үндсэн хандлагаар өөрийн зан төлөвөө ойлгож, тодорхойлж, хөгжүүлж болно.

Нэг. Зан төлөвийн шинжүүдэд үндэслэн бие хүний хэв маягийг (хэв шинж) тодорхойлох;

Бие хүний хэв маяг бол тодорхой нөхцөлд илрэх шинжүүдийн цогц юм. Сэтгэл зүйн мэргэжлийн хүний тусламжтай Айзенкийн, Кеттеллийн гэх мэт стандарт сорил бөглөж тодорхойлдог.

Тодорхой шалгуур үзүүлэлтийн дундаж, түүнээс дээш эсвэл бага үр дүнд суурилан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны тохироц, чанарыг тодорхойлох боломжтой.

Хоёр. Өөрийгөө “бүхэлд” нь хүрээлэн байгаа гадаад, дотоод орчин болон тэдгээрийн хөдөлгөөн, харилцан үйлчлэлийн хүрээнд тодорхойлж, ойлгоход чиглэнэ. Хүмүүнлэгийн үзэл баримтлал, зарчимд суурилна. Ажил, гэр, найз нөхөд, танихгүй хүмүүстэй харьцах харилцаа, хүсэл, туйлын хүсэл, сонирхол, зорилго, чиглэл, ажил амьдралын төлөвлөгөө гэх зэрэг хэрэгцээ – сэдэл, дотоод түлхцийн хүрээнд өөрийгөө мэдэж, ойлгох явдал юм.

Тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ямар аргуудыг яаж ашиглаж байгаа нь бие хүний сэтгэл зүйн бүрдэл хэсгүүдийн нэг бөгөөд мэргэжлийн, ёс суртахууны хүрээнд тавигдах аливаа шаардлагыг биелүүлэх, арга хэрэгслүүдийг оновчтой, үр дүнтэй

ашиглах нь хатуу мэдлэг, ур чадвар, туршлага, тодорхой дадал зуршил, шинжүүдийг шаарддаг.

Өнөө үед зан төлөвийн дараах шинжүүдийг чухалд тооцож байна.

1. Нийтэч -гадагшаа чиглэсэн, нөхөрсөг, өөртөө итгэлтэй, шийдэмгий, идэвхтэй, эрч хүчтэй, баяр хөөртэй, адал явдалд дуртай, өөдрөг, хөгжилтэй, урам зоригтой, элэгсэг, дотно;
2. Нийцтэй – итгэлтэй, бусдыг уучилдаг, шулуун шударга, тусч, дотно, дуулгавартай (гөжүүд, зөрүүд биш), төлөв түвшин (сагсуу, онгироо биш), уяхан/эелдэг;
3. Мэриймтгий - ур чадвартай /ур өгөөжтэй/, эмх цэгц / зохион байгуулалт сайтай, үнэнч, хичээнгүй (хэнэггүй биш), ололт амжилт руу чармайдаг / нягт нямбай/, хичээл зүтгэлтэй, хариуцлагатай, хувийн сахилга бат сайтай (залхуу биш), эргэцүүлж бодомтгой (ойворгон биш);
4. Невротик- айдас, сэтгэлийн түгшүүртэй, бачимдуу, тэвдэмтгий, ууртай, дайсагнасан, уцаартай, гутранги, бүрэг, бэргэмтгий, ойворгон /дүнсгэр баргар, эмзэг /өөртөө итгэлгүй байдал;
5. Нээлттэй - шинэ санаа, туршлагад нээлттэй, зохиож, дүрсэлж бодох, гоо сайхан, урлагийн чиг хандлагатай, үйлдэл хийдэг, өргөн хүрээний сонирхолтой, баяр хөөр, сайхан мэдрэмж хайдаг, өөрийн гэсэн үнэт зүйлтэй, сониуч, зохион бодох/дүрсэлж харах/, гоо сайхны мэдрэмжтэй/урлаг, уран сайханч, оролцоотой, юм юманд сонирхолтой, мэдрэмж, сэтгэл хөдлөл сайтай;

Дээрх чухал 5 шинжээс *нийцтэй, мэриймтгий* чанар хуульч мэргэжлийн хүмүүст нэн чухал. Бусадтай нийцгүй, зорилго чиглэлгүй эсвэл тогтворгүй экстраверт хэв маягийн хуульчид сахилгын хорооны сахилга хариуцлагын шийтгэл авах болон ёс зүйн зөвлөлөөр орох эрсдэлтэй.

1.2 Прокурорын мэргэжлийн тогтсон хандлага, ажлын сэтгэл ханамж

Ажлын сэтгэл ханамж бол ажилтны тогтсон хандлагыг хэмжих хэмжигдэхүүн юм.

Тодорхойлолтууд: Ажлын сэтгэл ханамж бол ажилд үзүүлэх сэтгэл зүйн хариу үйлдэл юм. (Parasuraman & Simmers 2001)

Edwin A. Locke (1976) - Ажлын сэтгэл ханамж бол “хэн нэгэн ажлаа, туршлагаа үнэлсний үр дүнд бий болох тааламжтай, эерэг сэтгэл хөдлөлийн төлөв байдал мөн.”

Ажлын сэтгэл ханамж бол хүмүүсийн ажил дээрээ таалдаг зүйл. (Spector (1997: 2)

Хүмүүс суурь (хоол, хувцас, орон байр г.м) хэрэгцээнээс авахуулаад дээд (зорилгоо биелүүлэх, өөрийгөө идэвхжүүлэх г.м) хэрэгцээгээ хэр хангаж байгаагаас тухайн хүний ажлын сэтгэл ханамж хамаарна. Маслоу (Maslow, 1954)

1950-иад оны сүүлээр “Тогтсон хандлага бол тодорхой хүмүүс, бүлэг, үзэл санаа болон бусад зүйлсийн талаарх үнэлгээ, харьцангуй тогтвортой мэдрэмж, итгэл үнэмшил юм” гэсэн тодорхойлолт гарч сэтгэл ханамжийн 2 хүчин зүйлийн онол бий болсон. (Herzberg, Mausner, Peterson, and Capwell, 1957)

Ажлын орчин, хангамж, харилцаа, дэмжлэг, байгууллагын бодлого, бүтэц зохион байгуулалт, соёл, удирдах хэв маяг, шийдвэр, албан тушаалын томилгоо, цалин урамшуулал зэрэг тухайн ажлын гадаад хүчин зүйлсийг эрүүл ахуйн хүчин зүйлс гэж нэрлэдэг. Эрүүл ахуй нь анагаах ухааны нэр томьёо бөгөөд сэргийлэх, орчны гэсэн утгатай. Эрүүл ахуйн хүчин зүйлс нь ажлын байрны стресс, архаг стресс, стрессийн

шалтгаант сэтгэл зүйн болон зарим халдварт бус өвчнүүд (зүрх судас, нуруу, астма) бий болоход нөлөөлнө.

Тухайн ажил, түүний агуулга, ачаалал бол сэдэлжүүлэгч хүчин зүйлс. Ижил албан тушаал, ачаалалтай 2 ажилтны сэтгэл ханамж өөр өөр гардаг. Ачаалал бол тухайн ажилтны ажлын зохион байгуулалт, цагийн хуваарилалт, бие хүний хэв маягтай холбоотой сэдэлжүүлэгч хүчин зүйл юм. Гадагшаа чиглэсэн хүмүүс гаднаас, дотогшоо чиглэсэн хүмүүс өөрөөсөө сэдэлжүүлэлт хайдаг. Хуульчид өөрийн ямар туршлагаа яаж ашиглан, юу хийх нь хамгийн их сэдэлжүүлэгч хүчин зүйл болно. Тогтсон хандлага, ажлын сэтгэл ханамж сахилга хариуцлагатай холбоотой. Сахилга хариуцлага бол тооцоо. Тооцоо бол үнэт зүйл. Өдөр, 7 хоногийн ажил, уулзалт, шүүх хуралдааны үр дүнгээ өөрөө тогтмол тооцож, өөрийн үр ашгаа байнга хэмжин, нэмэгдүүлэхийг зорьдог зуршилтай болбол туршлагажих, ачаалал багасгах өөрт тохирсон аргаа олох, ажлаа хугацаандаа хийж амжих зэрэг сайн талтай. Ажлын арга барил нь тухайн нөхцөл байдалд тохирч байгаа эсэхийг тооцож, уян хатан шинж чанартай, төвлөрсөн байвал ажилдаа сэтгэл ханамжтай байна. Гэвч тухайн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтаас шалтгаалан ажилтнууд сэтгэл ханамжгүй эсвэл хоёрдмол байдалтай байх нь элбэг.

Тогтсон хандлага, зан үйлд нөхцөл байдал, цаг хугацаа нөлөөлнө.

Тогтсон хандлага, зан үйл хоорондоо тохирохгүй байдлыг танин мэдэхүйн **диссонанс** гэдэг. Диссонанс амьдралд элбэг тохиолдоно. Жишээлбэл, зөрчлийн хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүрэгтэй прокурор өөрөө зөрчил гаргах, архи тамхины хор уршгийг мэдэх мөртлөө хэрэглэх, зарим бараа бүтээгдэхүүний мууг мэдсээр байгаа хэрнээ худалдаж авах гэх мэт.

Үйлдэл, хандлагын хоорондын зөрүүг багасгах аргууд:

1. Хандлагаа өөрчлөх. Жишээлбэл, зөрчил гаргаж байгаа хуульч өөрийн гаргаж байгаа зөрчлөө хүлээн зөвшөөрөх. Ихэнх хуульчид “хуурамч бардамнал”-аас болоод сахилга хариуцлагын зөрчлөө хүлээн зөвшөөрч чаддаггүй. Хүлээн зөвшөөрөх нь хандлагаа өөрчлөх анхны алхам болно. Архи, тамхины хор уршгийг мэдсээр байгаад хэрэглэж байвал шууд болих. Тамхиа шууд унтраах гэх мэт.
2. Хандлага, зан үйлийг дэмжих шинэ мэдээлэл эрж хайх, олж авах, унших. Мэдлэгтэй болох. Жишээлбэл, тамхи татдаг хүн тамхи татах зуршлын хор уршгийн нотолгоо, нотлох баримт цуглуулах гэх мэт.
3. Тоохгүй орхих эсвэл хоёр нүүр гаргах (Хандлага, зан үйл хоёр тохирч байгаа мэт царайлах нь тохирохгүй байгаа байдлыг багасгана.)

1.3 Түгээмэл тохиолдох сэтгэл зүйн зарим өөрчлөлт

Бие хүний сэтгэл зүйн хямрал, оюун ухааны самуурал

Сэтгэл зүйн хямрал янз янз, бас ярвигтай. Бүрэн дүүрэн ойлгох арга байхгүй. Хүмүүс яагаад хямарч самуурдаг, яаж түүнийг багасгах, засах тухай олон урсгал чиглэл бий.

Төрөлхийн конструктив буюу өөрөө өөртөө тусалдаг эсхүл диструктив буюу өөрөө өөрийгөө хямраадаг эсхүл орчин нөхцөл, нийгмийн харилцан үйлчлэлийн нөлөөн дор бий болсон, сурсан зан үйл гэж үздэг. Хүмүүс олон төрлийн шалтгааны улмаас өөр өөр нөхцөл байдалд янз янзаар хямардаг. Хямралын зарим нэг гол шалтгаан сэтгэл зүйн гэхээсээ илүүтэй философийн суурьтай. Орчин үеийн дараах философи, логик позитивизмын үүднээс “үнэн бол туйлын бас жинхэнэ биш. Нөхцөл байдлын нотолгоо, баримтыг хүн хайна, олно. Дараа нь олсон баримт, нотолгоонд суурилан дүгнэлт хийнэ. Үнэн бол түр зуурынх. Тухайн үед таамаглалаа нотолж болох ч

үгүйсгэж бас болно.” (Karl Poopper, 1985) Логик позитивистүүд Popper (1985), Bartley (1984), Mahoney (1991), Derrida (1976), Feyerband (1975), Gergen (1995) зэрэг сэтгэгчид “факт” “үнэн” -ийг хүмүүс тогтоодог. Обьектив “үнэн” бодит байдал байхгүй гэж хэлж, заадаг. Хүмүүсийн сайн муу, зөв буруу, ёс суртахуунтай, суртахуунгүй зэрэг нь хувь хүн болон нийгмээсээ шалтгаална. Универсал үнэн гэж үгүй. Түүнийг эрж хайх боломжгүй. Ёс зүйн итгэл үнэмшил конструктив мөн чанартай. (Georgy Kelly, 1955)

Ингэх “ёстой”, тэгэх “ёстой”, ийм “шаардлага”, тийм “шаардлага” хэмээн байнга өөрийгөө хянах болон тухайн хүний суурь итгэл үнэмшил, бодит амьдрал хоорондын зөрүү сэтгэл зүйн хямралын шалтгаан болно. (Albert Ellis, 1958)

Сэтгэл хямраадаг бодлууд:

- Аймаар эсвэл гамшиг болгох: “ Ямар аймаар юм бэ?” “Гамшиг”
- Би тэсэхгүй. Би тэсч чадахгүй. “ Би ... г тэсэхгүй.” “Тэгэхийг/ ингэхийг тэсч чадахгүй.”
- Хэт ерөнхийлэх: “Орлогч намайг тэгж хэлж байгаа юм чинь ерөнхий бас тэгж бодож байна гэсэн үг. Ер нь прокурорууд тэгж бодож байгаа.”, “бүх хуульчид, бүх прокурорууд, бүх эрэгтэйчүүд, бүх эмэгтэйчүүд, ер нь ...”
- Шууд дүгнэлт хийх: “Хэрэв тэр намайг тэгэх юм бол би .... ”
- Сөрөг, муу тал дээр төвлөрөх ”... “
- Эерэг байдал, эерэг талыг үгүйсгэх : “Намайг өрөвдөөд л тэгж байгаа юм.”
- Сайн зүйлийг дээд зэргээр багасгаж, бууруулах, доогуур үнэлэх, хамгийн доод түвшинд хүргэх: “Өнөөдрийн шүүх хуралдаан гоё боллоо. Яагаад ч юм би их сайн байсан. Уг нь сайн биш л дээ. Цаадуул чинь намайг муу л гэцгээж байгаа”
- Өөр дээрээ тусгах: “ .... завгүй гэнэ. Үнэндээ бол надтай уулзах дургүй л гэсэн үг”
- Хуурмаг байх: “ Энэ удаа худлаа сайхан загнаад л өнгөрье. Үнэндээ бол яршиг л байна.”
- Төгс байх: “ Би ёстой шал тэнэг алдаа гаргасан. Тийм байх ёсгүй ш дээ. Яасан ч болохгүй...”[1]

Дээр дурдсан бодлууд хортой. Бодол, сэтгэл санааны байдал хоорондоо холбоотой. Үйл явдалд өгөх тухайн хүний тайлбараас сэтгэл санааны байдал хамаарах боломжтой юу? Үйл явдлууд сэтгэл санааны хямралд шууд хүргэх боломжтой юу эсвэл бодлоор, оюун санаагаар дамжих уу?

ТУЙЛДАЛТ

Туйлдалт бол сэтгэл зүйн өвчнөөр албан ёсоор ангилагдаагүй ч сэтгэлийн хямралын шалтгаан нөхцөл болдог. Архаг стрессийн шалтгаантай. Ихэнх тохиолдолд туйлдалт бол ажил, гүйцэтгэлийн тухай логик үгүй, иррационал бодолд (сэтгэл зүйн стресс) үзүүлэх хариу урвал юм.[2]

Туйлдсан хүмүүс бусдын болон өөрийн зовлон, гомдлыг тоохоо байж хөндий, механик байдлаар асуудлыг шийднэ.[3]

Хүнтэй ажилладаг хүмүүс туйлдахад дараах шинж тэмдгүүд илэрнэ.

---

1 Albert Ellis, Catarine Maclaren. (2004) Rational Emotive Behavior Therapy. 2th ed. Pp 35-36

2 Richard Blonna. Coping with stress in a changing world. 2005. 3th ed. p.141)

3 Anderson, K.N., Anderson, L.E&Glanze, W.D 1994 Mosby’s medical, nursing, and 3. allied halth dictionary. 4th ed.(Rev.ed.). St Louis:Mosby

- Үйлчлүүлэгчид, харилцагчид, хэргийн оролцогчдыг тоохоо байна.
- Асуудлыг хөндий, механик байдлаар шийдэх хандлагатай.
- Ажлаа хийхдээ зүрх мохох, гутранги болох, заяа төөрөгт даатгах байдал нэмэгдэнэ.
- Сэдэлжүүлэлт, хичээл зүтгэл, ажилд оролцох байдал буурна.
- Хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдээ дургуй болох, сөргөөр харах, уурлах, тээршаах
- Өөрийн ая тух, ажлын нийгмийн хамгааллын талаар зовних, санаашрах
- Алдаагаа үйлчлүүлэгчид болон системд тохомтгой болох
- Өөрчлөлт, өсөлт хөгжилд хөшингө, бүтээлч байдлаа алдах

Туйлдалт 4 үе шаттай.

1. Урам зориг - өөрийнхөө тухай, ажлынхаа тухай болон бусдад тус дэм үзүүлэх боломжийн тухай эерэгээр, өөдрөгөөр харах нь багасах
2. Зогсонги байдал - хувийн болон байгууллагын өсөлт хөгжил, дэвшил байхгүй болох, бүх зүйл бахь байдгаараа байгаа санагдах
3. Бухимдал - Юу ч хийх боломжгүй, хэн ч ямар ч оролдлого хийхгүй гэж бодох
4. Идэвхигүй болох - тоохоо байх, өөрийн хувийн ая тухаа илүү анхаарах

СЭТГЭЛИЙН ТҮГШҮҮР

Сэтгэлийн түгшүүр бол тодорхой шалтгаангүйгээр хямрах, бүдэг бадаг тэгсэн мөртлөө яагаад байгаа нь мэдэгдэхгүй, хэцүү мэдрэмж.

Сэтгэлийн түгшүүрийг ерөнхий болон тодорхой гэж ангилдаг. Тодорхой сэтгэлийн түгшүүр нь тодорхой зүйл, үйл явдал, нөхцөл байдал байна.

Ерөнхий сэтгэлийн түгшүүр: бодит бус байнгын түгшүүртэй, төвлөрч чадахгүй, бие хөшиж хөвчирсөн байдалтай, уурламхай, уцаартай, цочимхой байна. Амьсгал богиносох, зүрхний цохилт түргэсэх, хүчтэй цохилох, гар хүйтэн, хөлстэй, ам хатах, гүйлгэх, нүүр халуу оргих, огиудас хүрэх, дотор муухайрах, булчин зангирах, бие хөндүүр болох, хамаг бие өвдөх, царай сааралдуу өнгөтэй болох зэрэг шинжүүд илэрнэ.

Биологийн нэгдмэл байдал (хоол, шингэн, секс) болон тухайн хүний өөрийнх нь аюулгүй байдал (бусдаар хүлээн зөвшөөрүүлэх, өөрөө өөрийгөө хүндлэх, байр сууриа гээх) алдагдахад сэтгэлийн түгшүүр үүснэ. Түвшингээр нь ялгадаг.

Бага зэргийн сэтгэлийн түгшүүр - айдас, эргэлзээ, бууртай юм шиг мэдрэмж төрөх, алмай болох, улигт бодолд автах зэргээр илэрнэ.

Анхаарахуйц хэмжээний, гүнзгий түвшний сэтгэлийн түгшүүр - байж болох хамгийн таагүй, эвгүй мэдрэмж төрөх, түүнээс аль болох түргэн салахыг хүсэх байдлаар илэрнэ.

ФОБИ БУЮУ АЙДАС

Дэд хэв шинжийн 5 төрлийн өвөрмөц айдас байна.

Амьтны төрлийн – тодорхой амьтан, шавьж (нохой, муур, аалз гэх мэт)

Байгалийн төрлийн – байгалийн ямар нэгэн тодорхой үзэгдэл, орчноос (өндрөөс айх, шуурга, аянганаас айх, уснаас айх гэх мэт)

1. Цус, тариа, гэмтэл бэртлийн – цус, тариа, аливаа харсан гэмтэл бэртэл, шарх гэх мэт
2. Нөхцөл байдлын – лифтэнд, гүүрэн дээгүүр явахаас, онгоцоор нисэхээс, жолоо барихаас гэх мэт

3. Бусад – унахаас, өвдөхөөс, амьсгал нь боогдохоос гэх мэт

Айдас нь ядрах, дотор муухайрах, огиудас хүрэх, чичрэх, салганах, хөлс гарах, сандарч тэвдэх байдалтай болгоно.

САНДРАЛ ТЭВДЭЛТ

Ойролцоогоор 10 минутын дотор гэнэт маш хүчтэй айх, сандрах, тавгүй болох. Нэг сарын дотор 4 болон түүнээс дээш удаа тасралтгүй айх, сандрах байдалд орох. Дахин сандарч тэвдэхээсээ байнга айсан, санаа зовсон байдалтай байх.

Доорх жагсаалтаас хамгийн багадаа 4 шинж үзэгдвэл сандрал, тэвдэлттэй гэнэ.

- Амьсгаа богиносох
- Зүрх түргэн, хүчтэй цохилох
- Цээжээр өвдөх
- Дотор муухайрах
- Амьсгаа боогдох
- Толгой эргэх
- Гар чимчигнэх, жирвэгнэх
- Хөл чичрэх
- Нүүр халуу дүүгэх
- Бие арзайх
- Хөлрөх
- Бодит бус байдал мэдрэх
- Салгалах, чичрэх
- Огих
- Гүйлгэх
- Галзуурахаас эсвэл үхэхээс айх[4]

Дараах 3 шинж тэмдэг нийтлэг байна. Үүнд:

1. Гэнэтийн байх (ямар нэгэн зүйл, дотоод гадаад шалтгаан нөхцөл байдлаас хамаарахгүй, гэнэт тохиох)
2. Нөхцөл байдлын (ж нь: илтгэл тавих, олон хүнтэй газар эсхүл давчуу, жижиг орон зайд байх гэх мэт.)
3. Нөхцөл байдлын дэвсгэр дөр болох байдлын (... хавдраар өвдөх удамшлын дэвсгэртэй, ... суурь дэвсгэртэй гэх мэт.)

ГЭМТЭЛ- СТРЕССТҮҮЛЭГЧТЭЙ ХАМААТАЙ ЭМГЭГҮҮД:

ХУРЦ СТРЕССИЙН ЭМГЭГ

- Нэг эсхүл хэсэг хүмүүс үхлийн, хүнд гэмтлийн эсхүл бэлгийн хүчирхийллийн бодит үйл явдлыг:
  1. Гэмтлийн үйл явдал (үйл явдлуудыг) шууд туулсан
  2. Тухайн үйл явдал (үйл явдлууд) тохиолдсон хүний дэргэд байсан гэрч
  3. Тухайн үйл явдал (үйл явдлууд) гэр бүл эсвэл дотны найзад тохиолдсоныг мэдсэн хүн
  4. Гэмтлийн үйл явдлын (үйл явдлуудыг) таагүй мэдээлэлтэй дахин дахин эсхүл хэтэрхий нарийвчилсан байдалтай, дэлгэрэнгүй танилцаж байгаа хүн (жишээлбэл, тухайн зүйлийн талаар анхны мэдээлэл хүлээн авагч, холбогдогч, мэдээлэл цуглуулагч, хүүхдийн хүчирхийллийн дэлгэрэнгүй

[4] Richard Blonna. Coping with stress in a changing world. 2005. 3th ed. p.141)

тодорхойлолт бүрдүүлж байгаа цагдаагийн ажилтан)

Илрэх шинж тэмдгүүд:

“Санагдах” – гэнэт өнгөрсөнд тохиолдсон стресстэй үйл явдал дахин болж байгаа юм шиг эсхүл тухайн үед болсон явдал, мэдэрсэн зүйл дахин болж байгаа юм шиг санагдах – (жишээлбэл, харах, сонсох, үнэртэх зэрэг сэрэл мэдрэмжийн болон биемахбодод болсон зүйлийг дахин санах, бодогдох);

- Тухайн болсон үйл явдлыг хэн нэгэн хөндөхөд сөрөг сэтгэл хөдлөл хүчтэй мэдрэх;
- Өөрөөсөө, өөрийн биемахбод, эргэн тойрны эд зүйлээс хол хөндий санагдах, юм санахгүй байх (ой санамжгүй болсон мэт санагдах);
- Тухайн болсон үйл явдлыг санагдуулах бодол, мэдрэмж болон хүрсэн зүйлээс зайлсхийх;
- “Супер болгоомжтой”, хамгаалалттай, байнгын аюулаас сэрэмжилсэн байдалтай байх;
- Санамсаргүй дуу чимээнд огло үсрэн харайх, айж цочих
- Бусад рүү орилж хашгирах, зандчих хэмжээнд хүртэл уурлах, хэрэлдэх, зодолдох, юм цохих, шидэх, эвдэж сүйтгэх;

ГЭМТЛИЙН ДАРААХ СТРЕССИЙН ЭМГЭГ

Хурц стрессийн үйл явдал болсноос хойш 30 хоногийн дараа хурц стрессийн шинж тэмдгүүд илэрч байвал гэмтлийн дараах стрессийн эмгэгт тооцно. Хурц стрессийн эмгэг бол гэмтлийн дараах эмгэг бий болох эрсдэлт хүчин зүйл юм.

СЭТГЭЛ САНААНЫ БАЙДЛЫН ЭМГЭГҮҮД:

Гурван эмгэг багтана. Сэтгэл гутрал, дистимик болон хоёр туйлт эмгэг.

СЭТГЭЛ ГУТРАЛ

Сэтгэл гутрал нь гутранги байдал болон бараг бүх төрлийн үйл ажиллагаанд сонирхолгүй болох эсвэл юунаас ч таашаал авахгүй байдлаар илэрнэ. Доод тал нь 2 долоо хоногийн хугацаанд бараг өдөр бүр доорх шинж тэмдгүүдээс 4 болон түүнээс дээш илэрч байвал сэтгэл гутралтайд тооцно.

Шинж тэмдгүүд:

- Хоолны дуршил болон жин, нойрны өөрчлөлт
- Сэтгэц-биеийн хөдөлгөөний үйл ажиллагаа (хөдөлгөөн, координат, эв дүйтэй байдал, хүч, хурд, уян хатан шинж)
- Эрч хүч сулрах
- Ямар ч хэрэггүй юм шиг мэдрэмж төрөх
- Буруутай мэдрэмж төрөх
- Юм бодож чадахгүй байх
- Анхаарал төвлөрөхгүй байх
- Шийдвэр гаргаж чадахгүй байх
- Үхэл болон амиа хорлох талаар бодох
- Үхэх болон амиа хорлохоор завдах, төлөвлөгөө боловсруулах

Хүнд хэлбэр нь өдөр тутмын ердийн амьдрал, үйл ажиллагаанд оролцож чадахгүй байдалд хүрнэ. Урьд өмнө таашаал авдаг байсан зүйлээс огт таашаал авахаа болих, юунд ч санаа тавихаа болино. Дунджаар 4 сар болон түүнээс дээш хугацаагаар үргэлжилнэ. Амиа хорлолт, сэтгэл гутрал 2 хоорондоо хамааралтай.

ДИСТИМИК ЭМГЭГ

Энэ эмгэг нь архаг сэтгэл гутралд хамаарна. Зөөлөн хэлбэрийн, бага зэргийн сэтгэл гутралтай байдал 2 жилээс илүү хугацаанд үргэлжилнэ (бага болон өсвөр насныханд 1 жил). Өдөр тутмын амьдрал үйл ажиллагаанд оролцох ч хийх ёстой, байх ёстойгоос маш бага түвшинд хийнэ, байна. Байнгын ядрах, цөхөрсөн байдалтай, аливаа шийдвэр гаргахдаа хүндрэл, бэрхшээлтэй, өөртөө итгэх итгэл бага, өөрийгөө дорд үзсэн байдалтай, анхаарлын төвлөрөлт муу. Хоолны дуршил огт байхгүй эсвэл хэт идэх, нойр нь огт хүрэхгүй эсвэл хэт унтах байдалтай байна.[5]

ХОЁР ТУЙЛТ ЭМГЭГ

Гол шинж нь нэг бол хэт хөөрөх, нэг бол сэтгэл гутрах байдалтай байна. Дээд зэргийн эрч хүч, хурд, үр бүтээл болон бараг унтахгүй шинж чанараар хэт хөөрлийн байдал илэрнэ. Өөртөө хэтэрхий их итгэлтэй, шинэ санаа оноо маш хурдан орж гарна, хурдан сэтгэнэ, тогтворгүй, анхаарал нь амархан сарнина, ууртай. Сэтгэл гутралын байдал нь 2 долоо хоног болон түүнээс дээш хугацаанд бүх юманд сонирхолгүй болох, таашаал авахаа болих болон гутранги байдалтай байна.[6]

АМИА ХОРЛОЛТ

Түр зуурын асуудлын бүр мөсөн шийдэл. Цөхрөнгөө, аргаа барсан нөхцөл байдалд байгаагаар өөрийгөө мэдрэх, асуудлыг шийдэх эсвэл багасгах аргыг олж харахаа болих, ганцаардах, ичих болон цөхрөлттэй холбоотой. Нас, сэтгэцийн болон биологийн зарим эмгэг, асуудлууд эрсдэлт хүчин зүйлст хамаарна.

Биологийн зарим асуудал гэдэгт серотонин багасах, өсөлтийн даавар болон кортикотропин ялгаруулах хүчин зүйлс хамаарна.

НИЙГМИЙН ЭСРЭГ БИЕ ХҮНИЙ ЭМГЭГ

Гаднаасаа төлөв харагддаг ч бусдын эрх, нийгмийн болон ёс суртахууны хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй, голдуу эрүүгийн гэмт хэрэгтнүүд байдаг. Энэ өвчний шалтгааныг бүрэн тогтоож чадаагүй байгаа. Өнгөрсөнд хийсэн олон судалгаанаас удамшил 38%-69%, нийгэмших үйл явцын зарим агентүүдийн асуудлаас тухайлбал, гэр бүлийн амьдралын сэтгэл хөдлөлийн харилцааны асуудлаас үүдэлтэй байж болзошгүй гэж таамагладаг. Тэдний олонх нь өнчин, хаягдмал, хүүхэд ахуй үедээ гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, зан авирын, анхаарал дутмагшлын хам шинжийн эмгэгээр 15 нас хүртлээ оношлогдож байсан онцлогтой.

Зарим судалгаанд шалтгааныг нь стресс, гэр бүлийн салалт, үе тэнгийнхний харилцааг дурдаж байна. Генетикийн шинж чанартай нилээн нотолгоо байна. Окситоцин рецепторын гений (OXTR) өөрчлөлт нийгмийн эсрэг зан үйлийн эмгэг, үе тэнгийнхий девиант холбоод өргөн хүрээгээр нөлөөлж байна. Нийт хүн амын 1-4%-ийг эзэлдэг. Голдуу эрэгтэйчүүд байх бөгөөд эмэгтэйчүүдээс 3-5 дахин их ийм эмгэгтэй байна. Мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэхтэй нэлээд хамааралтай. Боловсрол, оюун ухааны хөгжилтэй урвуу хамааралтай. Оюуны ухааны коеффициент бага, дөнгөж унших түвшний боловсролтой хүмүүсийн дунд их тархсан. Гэмт хэрэгтнүүдийн болон тархвар зүйн түүврийн төлөөллийн нас өндөрсөх тутам нийгмийн эсрэг зан үйлийн эмгэгийн тархварын үзүүлэлт буурч байгаа судалгаа байна. Насжилттай хамааралтай бие хүний онцлог шинжийн өөрчлөлт болон нас баралтын түвшин өндөр.[7]

---

[5] American Psychiatric Association. (2000). diagnostic and statistical manual of mental disorders. 4th ed.,

[6] DeLisi M, Drury AJ, Elbert MJ. The etiology of antisocial personality disorder: The differential roles of adverse childhood experiences and childhood psychopathology. Compr Psychiatry. 2019 Jul; 92:1-6. [PubMed]

[7] Fragkaki I, Cima M, Verhagen M, Maciejewski DF, Boks MP, van Lier PAC, Koot HM, Branje SJT, Meeus

Бие хүний бусад эмгэг :

- Нарцисс бие хүний эмгэг (Нийгмийн эсрэг бие хүний эмгэгийн зарим шинж тэмдгүүд давхцана. Ашигч, хүнийг ашигламтгай, өрөвдөх сэтгэлгүй. Гэвч хэрцгий түрэмгий биш. Бас луйвар хийдэггүй.)[8]
- Бордерлайн бие хүний эмгэг - Borderline personality disorder (В багцын эмгэг тул шинж тэмдгүүд давхцана. Бусдын бодол, үйлдэлд нөлөөлөх чадвар сайн. Гэвч тайтгаруулж, аргадна. Авьяас, итгэл найдварыг дэмжинэ.)
- Мансууруулах бодис хэрэглэх эмгэг (гэнэтийн огцом зантай. Гэнэт архи ууна. Хариуцлагагүй)

СЭДЭВ 2: ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДТАЙ ҮР НӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦАХ НЬ

2.1 Прокурорын мэргэжлийн сэтгэл зүйн зарим онцлог байдал

Прокурорын сэтгэл зүйн онцлог шинж чанар нь эрх зүйн сэтгэлгээ болон түүний үнэт зүйлс, аливаа салбар эрх зүйн зориулалт, мөн чанарыг хэр танин мэдсэн, өдөр тутмын албан харилцааны зорилго, зарчим, үе шат, журам, онцлогийн хүрээнд бий болсон ухамсрын төлөвшил, танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлтэй холбоотой. Эдгээрээс гадна эрх зүйн харилцааны субъектүүд, тэдгээрийн онцлог, төрлүүд, объект – түүний төрөл, онцлогоос шалтгаалан харилцах харилцааны харилцан үйлчлэл бас хамаатай. Харилцаанд хувь хүн, иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан, төрийн эрх мэдлийн субъектүүд болон эрх мэдлийн бус оролцогчид, олон нийттэй харилцах харилцаа багтана. Прокурорын сэтгэл зүйд нэг талаас өөрийнх нь эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагааны хүрээ, баримтлах зарчим гэх зэрэг ажил, мэргэжилтэй нь хамаатай хүчин зүйлс нөгөө талаас зан чанарын төрөлхийн болон олдмол зарим шинжүүд, бие хүний хэв маяг, тогтсон хандлага, үнэт зүйл, “Би” үзэл баримтлал, дотоод итгэл, сэдэлжүүлэлт, сэтгэлийн хөдөлгөөн, оюун ухаан, танин мэдэхүйн хөгжил, ур чадвар, туршлага, хэрэгцээ шаардлага болон нийгмийн бусад үүрэг ролиуд нөлөөлнө.

Прокурорын сэтгэл зүйн онцлогийг танин мэдэхүйн болон нийгмийн сэтгэл зүйн зарим үндсэн ойлголтын хүрээнд авч үзье.

Танин мэдэхүйн сэтгэл зүй: Мэдээллийг боловсруулах үйл явц, анхаарал, үг, нэр томьёоны хэрэглээ, ой тогтоолт, хүртэхүй, тусгай мэдлэг шаардсан асуудлын шийдэл, шийдвэр гаргалт болон бодол сэтгэхүйг хувь хүний түвшинд авч үздэг салбар ухаан юм. (Gerrig and Zimbardo 2002). Аливаа хуульчийн мэргэжлийн бүхий л үйл ажиллагаа, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагаа, цагаатгах тогтоол, шийтгэх тогтоол, магадлал, шүүгчийн захирамж, прокурорын болон шинжээчийн дүгнэлт зэрэг нь танин мэдэхүйн сэтгэл зүйн үйл явцад суурилна. Нийгмийн танин мэдэхүй бол хуульч мэргэжлийн сэтгэл зүйн үндсэн ойлголтод хамаатай.

Прокурорын аливаа шийдвэр бол хоёр болон түүнээс дээш хувилбаруудаас сонгосон сонголт байдаг. Сонгохдоо а) ур дүн нь тодорхой бус: хэрвээ гэдэг үгтэй хамаатай *болов уу?* эсэх эсвэл б) ур дүн нь тодорхой: жишээлбэл, хэргийн ул мөр

WHJ. Oxytocin Receptor Gene (OXTR) and Deviant Peer Affiliation: A Gene-Environment Interaction in Adolescent Antisocial Behavior. J Youth Adolesc. 2019 Jan;48(1):86-101. [PubMed]

[8] American Psychiatric Association. (2000). The road to burnout. Adapted frpm Miller, L.H. & Smith, A.D. The stress solution. http://helping.apa.org/work/stress

болгон бэхжүүлж авсан сэжигтний хурууны хээ, үсний үлдэц нь гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт болон сэжигтний өөрийнх нь зөвшөөрч өгсөн мэдүүлэгтэй тохирч, нийцсэн үед гарч ирэх үг, үйлдлүүд (тухайлбал, *зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй; дуртай ч дургүй ч , яг таг, "яв цав тохирч байна*" г.м); *аль нь*, в) субъект, объекттой хамаатай *тэр нь, энэ нь; хэрэв тийм бол ...; хэзээ?, хэзээнээс тэр вэ?* гэх зэрэг асуултуудын хариултад үндэслэнэ. Хувилбар бүрийн эцсийн дүгнэлт тухайн хуульчийн дотоод итгэл юм. Мэргэжлийн ур чадвар, ёс зүй, итгэл үнэмшилдээ үндэслэн өөрөө бие дааж тодорхойлж байгаа үнэлэлтийн илэрхийлэл. Дүгнэлт бүр үнэт зүйл, үнэ цэнэ, илүүд/дээрд үзэх; ... -аас *илүүд үзэх; тэгэхийг/ингэхийг илүүд үзэх* -тэй хамаатай. Хуульч бүрийн дотоод итгэл, үнэт зүйлүүд нь түүний хувьд өвөрмөц шинж маягтай байна. Сонголт хийхдээ сонголтынхоо үндэслэл, шалтгааныг эрж хайн шалгаж, хянан шийдвэрлэх, өөрөөр хэлбэл фактыг олж тогтоох, илрүүлэх, хангалттай үндэслэл бүрдүүлэх (**"De facto"**) зарчимд үндэслэнэ.

Прокурор мэдээллийг зөв боловсруулахад 3 хүчин зүйл нөлөөлнө.

Хугацаа: Хуульчдын үйл ажиллагааны үе шат, үйл явц бүхэнд хугацаа заасан байдаг. Хуулиар тогтоосон тодорхой хугацаанд ажлаа амжиж гүйцэтгэх үүрэгтэй. Хором бүрээр хэмжигдэх цаг бол ажлын стресстүүлэгчдийн нэг. Бага хугацаанд их мэдээллийг өндөр түвшинд боловсруулах шаардлага нь анхаарлын төвлөрөлтийг болон нягт нямбай, нарийвчлалтай бодох чадварыг бууруулна. (Hastie, 1981).

Чадамж: Өөр хоорондоо *байж боломгүй / зохицохгүй* нөхцөл байдал, харагдах байдлаараа *таарахгүй / нийцэхгүй* маягтай мэдээллүүдийг боловсруулах нь оюун ухааны чадамж шаардсан ажил. (Fiske, Kinder and Larter 1983).

Сэдэлжүүлэлт: Статус кво-г барих эсвэл хууль зүйн хангалттай үндэслэл бий болгохыг илүүд үзэх хувь хуульчийн дотоод түлхэц өөр өөр зан үйлийг бий болгоно. (Crocker et al. 1984).

"Схем" гэдэг ухагдахуун танин мэдэхүйн сэтгэл зүйн үндсэн ойлголт бөгөөд тодорхой нөхцөл байдал, үйл явдалтай хамаатай мэдээлэл. Үүний тусламжтай хурдан түргэн шийдвэр гаргадаг. Прокурорын мэдлэг, түүний хүрээ хязгаар юм. Схемд тайлбар, жишээ, аналоги багтана. Гурван хэв шинжтэй. 1. Мөрдөн шалгах ажиллагаа схемийн тусламжтай явагдана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон харилцдаг байгууллагын ажилтан, албан хаагчдын гадаад төрхөд үндэслэн бий болж байгаа дүгнэлт бол *хүмүүсийн схем* юм. 2. Тодорхой хүний гүйцэтгэж байгаа үүрэгтэй хамаатай мэдээлэлд суурилан чиг үүргийн схем бүрэлдэнэ. Жишээлбэл, их сургуулийн профессорын дүр төрх, түүний чиг үүргийн схем бол хичээл заах, ном, сурах бичиг, гарын авлага боловсруулахтай холбогдоно. Ямарваа нэгэн бүтээгдэхүүний борлуулалт, илбэ, ид шидтэй холбогдохгүй гэх мэт. 3. Нөхцөл байдал, үйл явдалтай холбогдон оюун санаанд бий болох мэдээллийн тодорхой хүрээ. *Үйл явдлын схем* бол үйл явдал эсвэл түүний давтамжид суурилан хийх *тайлбар*. *Үйл явдлын схем=тайлбар*. Тайлбарт үндэслэн дараагийн үйлдлийн хүлээлт бий болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид болон хамтран ажилладаг байгууллагын ажилтан, албан хаагчдын байнга давтан хийдэг үйлдэлд үндэслэн дараагийн үйлдлийн хүлээлт тайлбарын тусламжтай бий болно. Тайлбар бол бидэнд хэдийн байгаа мэдээллийн хүрээнд хийх мэдээллийн бүтэц юм.

Нийгмийн танин мэдэхүй:

Прототип

Прототип бол тодорхой бүлэг хүмүүсийн онцгой, чухал шинж чанар, төрхийг агуулсан хүний оюун санаан дахь загвар. Хуульчийн прототип, шүүгчийн,

өмгөөлөгчийн, прокурорын прототип, тамирчдын прототип, гэмт хэрэгтнүүдийн прототип гэх мэт тоолж барамгүй их прототип байна. Нийгмийн тодорхой бүлгийн жинхэнэ төлөөлөл, гишүүний нэгийг нөгөөтэй нь харьцуулах байдлаар тухайн бүлэгт нийцэж тохирох эсэхийг прототипээр дамжуулан тодорхойлдог.

Прокурорын дүгнэлт, шийдвэр түргэн гаргах сэтгэхүйн дөт аргууд, нийгмийн танин мэдэхүйн үр нөлөө

Прокурорууд хурдан хурдан шийдвэр гаргах, мэдээллийн хэт ачааллыг багасгахын тулд сэтгэхүйн дөт аргуудыг ашиглан, хэргүүдийг хянан шийдвэрлэдэг. Үүнийг эвристик аргууд гэж нэрлэдэг. Эвристик аргуудыг “хуульд заасан хугацаанд хавтаст хэргүүдийг хянан шийдвэрлэхэд ашиглаж байгаа дүрэм, зарчим” гэж нэрлэж болно. Сэтгэхүйн дөт аргуудыг ашиглах нь цаг хэмнэх, ачаалал бууруулах ашигтай ч тодорхой хэмжээний эндүүрлийг дагуулдаг. Зарим аргууд, үр нөлөө:

Төлөөлүүлэх: Адил төстэй байдлаар нь шүүх эвристик арга: Танихгүй хүнтэй анх харилцахдаа нийгмийн аль нэг бүлгийг төлөөлөх хүмүүстэй адил төстэй шинж хэр байгаагаар харьцуулахыг *төлөөллийн эвристик арга* гэж нэрлэдэг. Төлөөллийн эвристик аргын баримтлах дүрэм: *Өгөгдсөн дурын бүлгийг төлөөлөх гишүүдийн нийтлэг төрхтэй харьцуулагдаж байгаа хүн илүү төстэй байвал тэр хүн тухайн бүлэгт харьяалагдана. Төлөөллийн эвристик арга* алдаанд хүргэнэ. Эндүүрдэг. Эндүүрэл бие хүний онцлог шинжээс үүднэ. Тухайн хүний авир, дадал зуршил, сонирхол, дуртай зүйлс гэх зэрэг нь алдаатай дүгнэлт хийхэд хүргэдэг. Төлөөллийн эвристик аргаар бодож байгаа хүн суурь түвшинтэй хамаатай мэдээллийг анзаарахгүй орхих аюултай. Нийт хүн амд тохиолдох давтамжийг илэрхийлэх үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтийг орхигдуулах чиг хандлагыг ***суурь түвшний эндүүрэл*** гэж нэрлэдэг. (Tverski and Kahnemann, 1973) Жишээлбэл, энэ хүн инженер байх гэж таамаглая. Инженерүүд нийт хүн амын хэдэн хувийг эзлэдэг нь таамаглал дэвшүүлэхэд чухал үзүүлэлт. Харин инженер “физик, математикт сайн, ухаантай, хамгийн чухал мэргэжил” гэх зэргийн үзүүлэлтээр бодох юм бол эндүүрэлд хүргэх эрсдэлтэй.

Түрүүлж санаанд бууснаар дүгнэх эвристик арга: Аливаа зүйлийн хамгийн түрүүнд санаанд орж ирэх байдлаар дүгнэлт хийх чиг хандлагыг *“түрүүлж санаанд буухаар дүгнэх эвристик арга”* гэж нэрлэдэг. Хүн ба юмс, үйл явдлын жишээ хэдий чинээ хурдан санаанд бууна төдий чинээ чухал, түгээмэл зүйл гэж дүгнэж, шүүдэг. Нүдэнд амархан тусах, ой санамжид хадгалагдах, хурдан санагдах юм бүр хамгийн түгээмэл болон чухал зүйл биш юм. Хувь хүмүүсийн мэдрэмжтэй холбогдон ой санамжид түргэн хадгалагдах, буцааж гаргаж ирэх үйл явц нь тухайн зүйлийг хамгийн чухал гэж бодуулдаг. (Schwarz et al., 1991)

Хуурамч зөвшилцлийн үр нөлөө: Олон хүн бусдыг өөртэй нь яг адил, ижилхэн хэмээн бодож, *“бүгд адил*” гэж эндүүрдэг. Харамсалтай нь бодит байдал дээр тийм биш. Ийм эндүүрэл, нэгдүгээрт, хүмүүсийн хүслээс үүдэлтэй. Өөрийн бодол, дүгнэлт, үйлдэл, амьдралын хэв маягтаа итгэх итгэлээ сайжруулахын, зөв эсэхэд эргэлзэх эргэлзээгээ багасгахын тулд хүмүүс өөртэй нь адил эсхүл санал нийлнэ гэж итгэхийг хүсдэг (Mark & Miller, 1987). Хоёрдугаарт, бүхэлдээ биш ч зарим хэсэг нь түрүүлж санаанд бууснаар дүгнэх эвристик аргатай хамаатай. Өөртэй нь санал нийлж байсан, өөрийг нь дэмжиж байсан хэн нэгэн санаанд нь түрүүлж бууснаар “надтай яг адил”, “бусад хүмүүс бас...” гэж эндүүрдэг. Аливаа ажиллагаанд санаа нэг эсэхийг харгалзах чиг хандлагыг “хуурамч зөвшилцлийн үр нөлөө” гэдэг.

Суурь мэдээллийн үр нөлөө: Аливаа мэдээлэлд өмнөх мэдээллийн нөлөөлөх үйл явцыг илэрхийлнэ. Суурь мэдээллийн үр нөлөө прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай нягт холбоотой. Тогтоол, шийдвэр, эрх зүйн хэлбэр бичих мэт

хуульчийн бүхий л үйл ажиллагаанд суурь мэдээллийн үр нөлөө хүчтэй, тогтвортой, автомат байдлаар нөлөөлнө. Энэ үр нөлөө "түрүүлж санаанд буухаар дүгнэх эвристик арга"- ын хэрэглээг ихэсгэдэг. Гадаад орчин, нөхцөлөөс илүүтэй тухайн хүний бодлоос суурь мэдээллийн үр нөлөөний эндүүрэл гарах эрсдэл их. Мөрдөгч, тагнуулын, авлигатай тэмцэх байгууллагууд, цагдаа, прокурор, шүүх, өмгөөлөгчдийн суурь мэдээлэл өөр өөр байна. Эрх зүйн эдгээр субьектүүдийн өдөр тутам сонсдог, уншдаг, үздэг, хардаг мэдээллүүд өөр хоорондоо ялгаатай, өөр өөрийн онцлогтой тул тэдгээр мэдээллүүд түрүүлж санаанд буух замаар хуульчид суурь мэдээллийн үр нөлөөнд автах эрсдэлтэй.

Зөн билгэ, өрөвсгөл хандлагын нөлөө: Эрх зүйн субьектүүдийн мэдээллийг боловсруулах механизм үргэлж *логик-анализд* биш, харин *зөн билгэ, өрөвсгөл хандлагад* суурилдаг онцлогтой. Үүний шалтгаан бол нийгмийн танин мэдэхүй юм. Сэтгэл их хөдөлсөн үед болон бусдын дэргэд хууль зүй-танин мэдэхүйн цогц ажиллагаа явагдахаас илүүтэй сэтгэлийн хөдөлгөөн, зөн билгэ давамгайлдаг. Ийм нөхцөл байдалд прокурор логик-анализыг ашиглахаас илүүтэй зөн билгэ, зөн совингоор дүгнэлт хийх өндөр эрсдэлтэй.

Төлөвлөлтийн эндүүрэл: Бодит амьдрал дээр төлөвлөлтийн эндүүрэл их тохиолддог. Нийгмийн танин мэдэхүйн үндсэн байдал бол хүмүүс аливаа ажлыг төлөвлөхдөө хэт өөдрөгөөр бодох хандлагатай. Судалгаагаар төлөвлөсөн ажлын 43.6%-ийг цагт нь хийж дуусгадаг. (Buehler, 1994) Төлөвлөгөө гаргахдаа яг ижил ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан хугацааг ихэнх төлөвлөгчид эргэн хардаггүй тул *төлөвлөлтийн эндүүрэл* их гарна.

Автомат сонор сэрэмж: Нийгмийн мэдээлэл, цочроогчийн аль сөргийг нь анзаарч ач холбогдол өгөх хүчтэй чиг хандлагыг илэрхийлнэ. (e.g, Shiffrin, 1988) Прокурорууд автомат сонор сэрэмжид өртөх эрсдэлтэй. Сөрөг мэдээлэл биднийг аюулаас хамгаалах, муу муухай зүйлд түргэн хариу үйлдэл үзүүлэхэд чухал (Pratto & John, 1991). Гэвч бидний анхаарлын хүчин чадал хязгаарлагдмал. Нийгмийн сөрөг мэдээллийг шууд анхаарах юм бол сөрөг мэдээллийн ачаалал нэмэгдэхээс гадна тухайн мэдээлэлтэй хамт яваа өөр чухал, үнэ цэнэтэй зүйлийг анзаарахгүй орхигдуулах эрсдэлтэй. Зөвхөн сөрөг мэдээлэлд анхаарах, асуудлыг шийдэх тухай байнга бодох нь гүйцэтгэл, бүтээмжид сөргөөр нөлөөлнө. Судалгаагаар нийгмийн харилцаанд оролцогчид бусдын ууртай царайг маш хурдан олж хардгийг тогтоосон. Бөөн хүмүүсийн дундаас хамгийн түрүүнд ууртай, баргар царайг олж хардаг. Харин ууртай царайтай бөөн хүмүүсийн дундаас аз жаргалтай царайг олохдоо харьцангуй удаан. *(Hansen & Hansen, 1988)*

Эсрэгээр бодох: Болж өнгөрсөн үйл явдал, үйлдэл, төлөв байдлыг "юу байсан байж болох тухай" эсрэг хувилбараар бодох чиг хандлагыг эсрэгээр бодох (контрбаримт) гэнэ. (Byrne, 2005; Roese, 1997). "Юу байсан байж болох тухай" хувилбарыг дуураймлаар оюун санаандаа эсрэгээр төсөөлөн бодох сэтгэхүйн үйл юм. "Олимпийн хүрэл медальтнууд мөнгөн медальтнуудаас илүү аз жаргалтай" гэвэл хүрэл медальтнууд хожигдсон бол ямар байх байсан нь эсрэгээр бодохын жишээ юм. Өнгөрсөн үйл явдлыг эсрэгээр төсөөлөн бодох нь зохицуулалт болон гүйцэтгэлд ашиг тустай.

Шүүх хуралдааны үйл явц, шүүхийн шийдвэрт эсрэгээр бодох их үүрэг гүйцэтгэнэ. Голдуу гэм буруугийн болгоомжгүй хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан гэмтэл, хохирлын хүрээнд эсрэгээр бодохын судалгаанууд хийгддэг. (Wiener & colleagues, 1994 and Cantone, 2020). Хөнгөмсгөөр найдсан эсвэл хайхрамжгүй хандсаны улмаас гэмт хэрэг болгоомжгүй үйлдэж бие махбодын эсвэл сэтгэл зүйн гэмтэл учруулсан яллагдагчийн үйлдлийн үр дагаврыг урьдчилан харах, зайлсхийх боломж болон

хянах боломжуудыг дууpаймлаар эсрэг талаас нь төсөөлөн бодох боломжтой тул иргэдийн төлөөлөгчид, шүүгчид, өмгөөлөгч, мөрдөгч, прокурорууд шууд бус санаатай гэм буруу эсвэл хөнгөмсгөөр найдсан гэм буруугийн ялгааг олоход ашиглах боломжтой. Болсон үйл явдал, үйлдэл, төлөв байдлыг эсрэгээр төсөөлөн бодох арга нь хэргийн зүйлчлэлийг тогтооход ач холбогдолтой. Тодорхой санаатай байсан уу эсвэл тодорхой бус санаатай юу гэдгийг олж тогтоох нь гэмт хэргийн улмаас үүсэх хор уршиг (үр дагавар)-т хандах сэтгэл зүйн байдлыг тодорхойлно гэсэн үг.

Эсрэгээр бодох нь зөвхөн эрх зүйн шалтгаант холбоог тогтооход үзэгдэх үйл явц биш. Шалтгаан-үр дагаврын холбоо байхгүй мөртлөө хүний анхаарал татсан үйл явдал, үйлдэл, төлөв байдлыг эсрэгээр бодно. Тухайн үйл явдал, үйлдэл, төлөв байдал хэм хэмжээ зөрчсөн үед ердийн тохиолдолд ямар байх байсан тухай эсрэгээр бодно. Нотолгооны хүрээнд бас эсрэгээр бодохыг ашигладаг. Өдөр тутмын амьдралд ямар нэгэн нөхцөл, үр дагавар байдлаар илэрнэ. Жишээлбэл, “хэрэв би уншсан бол хуульчийн шалгалтаа давах байлаа” гэх мэт. Эсрэгээр бодох нь үнэлгээний нэг хэлбэр. Бодит байдлын байж болох байсан сайн эсвэл муу хувилбарыг бодно. Сайн хувилбарыг дээшээ чиглэсэн эсрэгээр бодох; муу хувилбарыг доошоо чиглэсэн эсрэгээр бодох гэдэг. (Markman, Gavanski, Sherman, & McMullen, 1993; Roese, 1994) Эсрэгээр бодох зорилготой гүн холбоотой бөгөөд нийгмийн харилцаанд хүний зан үйлийг зохицуулах үүрэгтэй. (Epstude & Roese, in press; Johnson & Sherman, 1990; Markman & McMullen, 2003; Roese, 1997, 2001; Roese & Olson, 1997; Roese, Sanna, & Galinsky, 2005; Segura & Morris, 2005).

Эсрэгээр бодохын уламжлалт тайлбар хэм хэмжээний онолд суурилдаг. (Kahneman & Miller, 1986) Хэм хэмжээний онолоор зөвхөн эсрэгээр бодож шийдвэр гаргавал өрөөсгөл болно. Доошоо эсрэгээр бодохыг фунционал талаас авч үзвэл зан үйлийг зохицуулахад илүү ашигтай, үр нөлөөтэй. Зорилгодоо хүрч чадаагүй үед эсрэгээр бодох идэвхиждэг. Юу хийх ёстой байсан тухай өнгөрсөн үйл явдал, үйлдэл, төлөв байдлыг эргэн харж, эсрэгээр бодон дүн шинжилгээ хийдгээрээ ашигтай. (Markman et al., 1993; Roese, Hur, & Pennington, 1999)

Ид шидийн бодол. Хууль, эрх зүйн тогтолцоо бол ерөнхийдөө хувь хүнийг “ухаалаг” гэж үздэг. Гэтэл хүмүүс ухаалаг бус, “ид шид”, “ер бус”-ын зүйлд итгэмтгий бөгөөд үүнийг зар сурталчилгаа их ашигладаг. Хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаанаас хууль хамгаалдаг ч эрх зүйн тогтолцоо хүмүүсийн онцлог шинжийг харгалзан үздэггүй. Зарим судлаачид “орчин үеийн зар сурталчилгаа иррационал бодлын тодорхой хэлбэр “ид шид” дээр суурилж байна” гэжээ. Ийм хандлага дэлхий нийтээр нийтлэг харагдаж байгаа нь хүний бодол, сэтгэхүйн универсал шинж гэлтэй.

Ид шид бол бага хүчин чармайлтаар их үр дүнг авчрах итгэл үнэмшил. Ид шидийг нийгэм-соёлын талаас нь харвал шашин, мухар сүсгийн шинжтэй шалтгаан – үр дагаврын холбоотой. Шашны зан үйл, мөргөл, бясалгал, транс, золиос, тахил өргөх, шившлэг, хараал, адислал, хорио цээр сахих зэргээр ашиг тус, шийтгэлийн хоорондбайна. Жишээлбэл, азын сахиус, зарим тодорхой зан үйлүүд тухайн хүний хүслийг биелүүлэх эсхүл тодорхой түвшинд зорьсондоо хүрэх магадлалыг нэмнэ гэж итгэдэг.

2.2 ЭХХША-ны оролцогч нар болон бусад байгууллагын ажилтнуудтай харилцах харилцаа

Байгууллагын харилцаа

Голдманы (Goldman) дүрэм:

Голдман гэдэг нь АНУ-ын хамгийн хөгшин, хамгийн том, хамгийн нэр хүндтэй

хөрөнгө оруулалтын банк. Түүний зарим өрсөлдөгчид (Lehman Brothers, Bear Stearns) ипотекийн зээлээр дампуурсан. Зарим нь, ялангуяа (Citigroup, Bank of America, JPMorgan Chase, and Wells Fargo) зэрэг банкууд засгийн газрын дэмжлэгтэйгээр оршин тогтнож байгаа бол Голдман тийм биш. Энэ байгууллага засгийн газраас 10 тэрбум доллар зээлээд 23%-ийн хүүтэй буцаан төлсөн түүхтэй. Голдманаас өөр ямар ч банк ийм үйлдэл хийгээгүй юм байна. Голдманыг агуу компани гэдгийг бүгд хүлээн зөвшөөрсөн. 2010 оны АНУ-ын BusinessWeek сэтгүүлийн хамгийн хүсэмжит ажлын газрын 6-д жагссан. Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын тэргүүн эгнээ, санхүүгийн мэргэжилтнүүдийн хамгийн их хүсдэг ажлын байр. Ажиллагсад нь ажилд анх орсон шигээ л ажилдаа дуртай, хайртай гэжээ. Юу тийм хүчирхэг болгов? Голдманыг агуу болгодог зүйл юу юм бол? Олон хүчин зүйлийн нэг нь, түүний удирдлага. Мөн имейлээр харилцах харилцааны бодлого. Голдманы и-мэйлээр харилцах харилцааны гарын авлага бол АНУ-ын и-мэйл бичих болон цахим харилцааны хамгийн хатуу нэрийн хуудас ажээ. “Ба, бас, болон”-г ашиглах 2 дүрэм гэх зэрэг зүйлс байдаг юм байна.[9]

- Прокурорын нэгж байгууллагын ахлах бүх хяналтын прокурор, ажилтнуудтай аятайхан харьцахыг хичээдэг ч тийм биш юм шиг өөрт нь санагдах;
- Прокурорууд яагаад ERP болон вайбер дээр байгаа чаатаа уншдаггүй юм бол гэж гайхан бодох хэн нэгэн прокурор;
- Шуурхай зөвлөгөөн дээр орлогч зөвхөн өөрөөс нь өө хайгаад байгаа мэт санагдах гэх зэрэг жишээнүүд бүгд байгууллагын харилцаатай хамаатай.

Энэ сэдвийн хүрээнд байгууллага дотор хэрхэн харилцах, харилцааны үйл явц дахь зарим асуудлууд, харилцааны ур чадварын тухай хөндөх болно.

Байгууллагын харилцааг:

- Дээшээ чиглэсэн
- Доошоо чиглэсэн
- Латерал харилцаа
- Бизнесийн харилцаа
- Албан бус харилцаа гэж 5 хэв шинжид хуваадаг.[10]

Эдгээр 5 хэв шинжээс дээшээ, доошоо чиглэсэн болон албан бус харилцааг түлхүү хөндөнө.

Дээшээ чиглэсэн харилцаа: дээд шатны прокурор, удирдлагуудтай харилцах харилцаа;

Доошоо чиглэсэн: доод шатны прокурор, туслах, захиргаа үйлчилгээний ажилтнуудтай харилцах харилцаа;

Латерал харилцаа: ижил түвшний албан тушаалтнууд, прокурор хоорондын харилцаа;

Ажил хэргийн харилцаа: аливаа ажилтай хамаатай мэдээллийг ажилтнууд, удирдлагууд, үйлчлүүлэгч, олон нийт хооронд дамжуулах дамжуулалт;

Албан бус харилцаа: ам дамжсан мэдээлэл, дам яриа юм.

Харилцааны үүргүүд:

---

[9] M. Abelson and C. Winter, “The Goldman Rules,” Bloomberg Businessweek (April 25, 2011), pp. 90–91; L Lavelle, “Best Places to Launch a Career,” Bloomberg Businessweek (June 2010), downloaded June 10, 2011, from http://images. businessweek.com/ ; and L. Story and S. Chan, “Goldman Cited ’Serious’ Profit on Mortgages,” The New York Times (April 25, 2010), pp. Y1, Y25.)

[10] Industrial/organizational psychology: an applied approach. 6th edition. Michael G. Aamodt.

- Хянах (Өөрийн хяналтад байдаг субьектүүд, дээд шатны прокурор, удирдлагууд доод шатны прокурор, туслах, захиргаа үйлчилгээний ажилтнуудтай ажлын байрны чиг үүргийн хүрээнд харилцах харилцаанд илэрнэ)
- Сэдэлжүүлэх (Ажил үүргийн хуваарилалт, ачаалал, үйл ажиллагааны зохицуулалт, ажлын гүйцэтгэл, үнэлгээ, хүн хоорондын харилцаа, хамт олон, ажлын орчин, цалин, урамшууллын хүрээнд)
- Сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэх (Нийгмийн хэрэгцээний хангалт, мэдрэмж, сэтгэл санааны байдал, сэтгэлийн хөдөлгөөний солилцоо)
- Мэдээлэл солилцох (Шийдвэр гаргалттай хамаатай мэдээллийг үнэлэх, тодорхойлох, солилцох)

ДЭЭШЭЭ ЧИГЛЭСЭН ХАРИЛЦАА

Дээшээ чиглэсэн харилцаа бол доод тушаалын ажилтнууд дээд шатны албан тушаалтнуудтай харилцах харилцаа болон нэгж, хэлтсийн дарга нартай харилцах прокурор, туслах ажилтнуудын харилцаа юм. Мэдээжийн хэрэг, хамгийн сайн дээшээ чиглэсэн харилцаа бол ажилтнууд нь удирдлагатайгаа шууд харилцах “нээлттэй хаалга”-ны бодлоготой харилцаа.

Дээшээ чиглэсэн харилцааны сайн бодлого, чанар бол ажилтнуудын сэтгэл ханамжид нөлөөлдөг чухал хүчин зүйл мөн. (Miles, Patrick, & King,1996). Сэтгэл ханамж ажлын гүйцэтгэл, бүтээмж төдийгүй байгууллагын хөдөлмөр, эрүүл ахуй, ажилтнуудын эрүүл мэндэд нөлөөлдөг сэтгэл зүйн хүчин зүйл юм. Гэвч бодит амьдрал дээр, байгууллагын харилцааны “нээлттэй хаалга”-ны бодлого тийм ч тохиромжтой биш байдаг. Хамгийн наад зах нь ажилтан бүр тодорхой удирдлагатай нэг нэгээрээ шууд уулзаад байх бололцоо хязгаарлагдмал. Ялангуяа төвлөрсөн босоо удирдлагатай, ажлын арга нь эрх мэдэлд суурилсан шинж чанартай байгууллага дотор. Хоёрдугаарт, дээшээ чиглэсэн шууд харилцаанд орж асуудлаа ярих, гомдоллох нь доод шатны ажилтнуудын аюулгүй байдалд муугаар нөлөөлөх юм шиг, аюултай юм шиг тэдэнд санагдах, тодорхойгүй байдлаас айх айдас зэрэг сэтгэлийн хөдөлгөөний шалтгаантай.

Дээшээ чиглэсэн харилцааны аргууд:

Цуврал харилцаа

Дээд шатны ерөнхий удирдлагатай уулзах янз бүрийн хүмүүсийн тоог багасгахын тулд байгууллагууд *цуврал харилцааг* ашигладаг. Цуврал харилцаагаар тухайн ажилтны санал хүсэлт, асуудал, өргөдөл, гомдол шат дараалсан албан тушаалтнуудаар дамжин ахлахад, ахлахаас хэлтсийн дарга, хэлтсийн даргаас өөрийн дээд шатны удирдлага руу гэх мэтээр цуварна. Ийм хэв шинжийн харилцаа дээд шатны ерөнхий удирдлагыг хэт их шаардлага, шууд ачааллаас чөлөөлдөг хэдий ч нилээн хэдэн сул тал, дутагдалтай. Тухайн доод шатны албан тушаалтны илэрхийлсэн анхны санаа, агуулга, өнгө аяс нэгээс нөгөө рүү дамжих зуур өөрчлөгдөж болно. Ялангуяа амаар дамжсан тохиолдолд. Энэ тухай тус сэдвийн “хүмүүс хоорондын харилцаа” хэсэгт хөндөх болно. Дараагийн дутагдал бол шүүмжлэл, гомдол тэр болгон цаашаа дамжиж, эзэндээ хүрдэггүй. Хаа нэг цааш дамжина. Удирдлагад муу мэдээ хүргэх нь тодорхой хэмжээний стрессийг дагуулна. (McKee & Ptacek, 2001). Розен болон Тессар 1970 онд муу мэдээг цааш дамжуулах дургүй байдлыг “**таагүй мэдээний үр нөлөөг багасгах”** гэж тэмдэглэсэн байдаг. Энэхүү *таагүй мэдээний үр нөлөөг багасгах* буюу дээд шатны удирдлагад мэдээллийг дамжуулахгүй байдал нь байгууллагын удирдлагын үйл ажиллагааны хувьд сөргөөр нөлөөлж болно. Гэвч ажилтнуудын хувьд арай өөр. Тэдний аюулгүй байдалтай

холбоотой. Аливаа муу мэдээг удирдлагад хүргэхийг хүсдэг хүн ямар ч байгууллага дотор байхгүй байх гэж таамаглаж байна.

Муу мэдээг дээд шатны удирдлагад дамжуулж дуулгахдаа ажилтнууд голдуу зөөлрүүлэх тактик ашигладаг. (Lee, 1993). Хүмүүс муу мэдээг удирдлагадаа хүргэхээс эмээдэг мөртлөө хамт ажилладаг хүмүүст ямар ч асуудал үгүйгээр дамжуулдаг. Ялангуяа байгууллага доторх хүн хоорондын болон ажил хэргийн харилцааны ерөнхий уур амьсгал таагүй, сөрөг тохиолдолд. (Heath, 1996).

Цуврал харилцаанд тухайн албан хаагчдын ажлын өрөөний байрлал их нөлөөтэй. Удирдлагатай ойрхон өрөөнд суух ач холбогдолтой. Нийгмийн харилцаанд ойр ойрхон таарах, уулзах давтамж их нөлөөлдөг. Туршлагатай удирдлага өсөж яваа прокурор, ахлах, орлогч, ерөнхий нарыг хол байрлах нэгжид сэлгэлт хийдэг. Сэлгэлт хийх шалтгаан янз янз ч нэг шалтгаан бол прокуроруудын потенциал эрх мэдлийг багасгахтай холбоотой.

Ажилтнууд үдийн хоол хамт идэх нь шинэ мэдээлэл авахад, албан тушаал ахихад, ажлаа сайн хийхэд зарим талаар тустай хэдий ч байрлал өнөө цагт ач холбогдол муутай болсон. Учир нь хүмүүсийн хоорондын харилцааны суваг (email, message) их болжээ. (Valacich, Parantia, George, & Nunamaker, 1993). Ялангуяа имэйл албан харилцаанд нүүр тулсан уулзалт, ажлын байрны орон зайн ойрхон байрлалын хүчийг сулруулж байгаа.

Тогтсон хандлагын судалгаа

Дээшээ чиглэсэн харилцаанд байгууллагууд үйл ажиллагаагаа үнэлж, сайжруулахын тулд ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг. Жил бүр. Гаднаас ирж авдаг байх шаардлагатай. Сэтгэл ханамжийн судалгаа бол цалин хөлс, ажлын орчин, удирдлагын жил бүрийн үнэлгээ юм. Ажилтнуудад дарга удирдлагуудыг уншиж мэдээсэй гэсэн мэдээлэл, санал гомдлоо илэрхийлэх боломжийг олгодог. Судалгааны тайланд үндэслэн ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна. Мэдээжийн хэрэг тухайн судалгааны үр дүнг удирдлагууд нухацтай авч үзэн, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгадаг бол ийм төрлийн судалгаа үр ашигтай байх болно. Харин эсрэгээрээ, судалгааны үр дүн, тайлангийн мэдээллийг тоохгүй, урьдын адил хэвээр байвал судалгаа хийсний ашиг тус үгүй. Цаашлаад хүн хоорондын итгэлцлийг нэмэхийн тулд байгууллага судалгааны тайлан үр дүнг хамт олонтойгоо бүрэн хуваалцдаг байх шаардлагатай. Хуваалцахдаа зөвхөн зарим нэг хэсэг биш бүхэлд нь хуваалцвал сайн. Хэрэв тухайлбал, ажилтнуудад хамгийн их хамаатай цалин хөлс, ажлын орчин, нийгмийн хамгаалал, харилцааны асуудлыг шийдвэрлэхгүй зөвхөн техникийн шинж чанартай сайн мэдээг хуваалцвал ажилтнууд удирдлагуудад итгэх итгэлээ гээж дахин судалгаанд оролцохгүй, оролцсон ч бөглөхгүй байх магадлал өндөр.

Фокус бүлгийн уулзалт

Гаднаас судлаачид ирж ажилтнуудтай фокус бүлгийн ярилцлага хийх явдал юм. Байгууллагын удирдлага, үйл ажиллагааны тухай санал бодол, санаа оноог цуглуулж дээд удирдлагад мэдээлэх гол зорилготой.

Ажлаас гарах тухай ярилцлага

Ажлаас өөрийн хүсэлтээр гарч байгаа прокурор бол байгууллагын үйл ажиллагаа, зохицуулалт, удирдлагын арга барил, соёлын талаарх мэдээллийн эх сурвалж билээ. Сэтгэл хөдлөлтэй их холбогддог тул байгууллага тухайн ажилтны ажлаас гарч байгаа “бодит” шалтгааныг олохыг хичээж сайн сонсох шаардлагатай.

Саналын хайрцаг

Дээшээ чиглэсэн харилцааг сайжруулах зорилгоор саналын эсвэл гомдлын хайрцаг ажиллуулж болно. Ажилтнууд өөрсдийн нөхцөл байдал, санал сэтгэгдлээ нууцлалтайгаар, аюулгүй байдлаар шууд илэрхийлэх, санал, дуу хоолойгоо дээд удирдлагад хүргэх хэрэгсэл юм. Удирдлага менежерүүд санал, гомдлуудад тухай бүрд нь хариу үйлдэл үзүүлж байх нь зүйтэй.

Гурав дахь талын дэмжлэг

Нэгж хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог хариуцсан ажилтан гэх зэрэг гурав дахь талыг ашиглах нь байгууллагын дээшээ чиглэсэн харилцааг сайжруулах бас нэг арга юм.

ДООШОО ЧИГЛЭСЭН ХАРИЛЦАА

Доод шатны прокурор, туслах, захиргаа үйлчилгээний ажилтнуудтай харилцах харилцаа байгууллагын доторх доошоо чиглэсэн харилцаанд хамаарна.

Доошоо чиглэсэн харилцааны аргууд:

Мэдээллийн самбар

Байгууллага бүрд мэдээллийн самбар байдаг. Гол хэрэглээ нь тухайн ажилтнуудын эрхэлж буй ажил албатай хамааралгүй, өөр төрлийн жишээлбэл, тэтгэлэгт сургалт, аливаа хөнгөлөлт, уулзалт сургалтын тухай гэх мэт мэдээллийг дамжуулах хүрээнд байна. Аливаа бодлого, процедурын өөрчлөлтийг нийтлэхэд төдийлөн тохиромжтой биш. Гэсэн хэдий ч мэдээллийн самбар бол өртөг багатай, ажилтнууд удирдлага, үйлчлүүлэгчид, хэргийн оролцогчид, олон нийт гэх зэрэг өргөн хүрээнд ашиглаж болох давуу тал ихтэй харилцааны хэрэгсэл мөн.

Гарын авлага

Гарын авлагыг дотор нь бодлогын болон ажилтнуудын лавлах гэж 2 ангилна. Бодлогын гарын авлагад байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны зохицуулалт, түүний өөрчлөлтийг нийтэлдэг. Ихэнх гарын авлагууд нилээн өндөр зэрэглэлийн техникийн хэлээр бичигдсэн байдаг нь төдийлөн тустай биш. Хамгийн гол зорилго бол ажилтан, албан хаагчид гарын авлагыг уншиж хэрэглэхэд тохирсон, хатуу хэллэг үгүйгээр, уншихад ойлгомжтой, энгийн байдлаар бичигдвэл түүний ашиглалт, хэрэглээний хүртээмж нь их байх болно. Жил бүр гардаг байх шаардлагатай. Хоёр дахь нь ажилтнуудын лавлах юм. Богино. Хамгийн гол бодлого, дүрэм журам, мэдээллийг багтаасан туслах хэрэгсэл.

Мэдээллийн хуудас

Ажилтнуудын сэтгэл санааны байдлыг хөхүүлэн дэмжих, ажилтан, албан хаагчдын ар гэр, хувийн амьдралд тохиолдох аз жаргалтай, баяртай үйл явдлуудыг хуваалцах зорилготой. Бүл нэмэх, төрсөн өдөр, дэмждэг спортын багийн үр дүн оноог мэдээлэх, баяр хүргэх, ажилтнууд, нэгж, хэлтсүүдийн амжилт, шинэ ажилтнуудыг танилцуулах, байгууллагын өөрчлөлтийн тухай сануулах зэрэг ажилд мэдээллийн сайн эх сурвалж болно. Олон байгууллагын мэдээллийн хуудас хэвлэмэл байдаг ч цахимаар, и-мэйлээр, дотоод сүлжээ ашиглах нь ихсэж байна.

Интранет

Мэдээллийн самбар, хуудас болон байгууллагын гарын авлага, ажилтнуудын лавлах зэрэг нь интранет рүү шилжиж байна. Дотоод сүлжээ, ERP, вайберийг ашиглах нь бичиг хэрэг, хэвлэл, шуудангийн зардлыг ихээхэн хэмнэдэг.

АЖИЛ ХЭРГИЙН ХАРИЛЦАА

Ажилтай хамаатай мэдээллийг удирдлага, прокурор, туслах, үйлчлүүлэгч хооронд дамжуулах дамжуулалт юм. Мемо, утсаар ярих, и-мэйл, дуут шуудан илгээх зэргийг ашиглана.

Санамж бичиг (Мемо эсвэл меморандум)

Ажил хэргийн харилцааны хамгийн нийтлэг хэрэгсэл бол меморандум буюу мемо юм. Мемо богино хугацаанд, олон хүнд, нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээлэл олгодогоороо давуу талтай. Мэргэжлийн хүрээнд их ашиглана.

Гар болон суурин утас

Ажил хэргийн харилцааны өөр нэг хэрэгсэл гар болон суурин утас ашиглах явдал юм. Өмнө цөөн тооны хүмүүс суурин утастай байсан бол өнөө үед гар утсаар ажил хэрэг яригдаж, явагдаж байна гэж хэлж болно. Утсаар харилцахад нүүр царайны хувирал, биеийн байрлал, гар, хөлийн хөдөлгөөн гэх зэрэг хэлэхүйн бус мэдээлэл авахад хязгаарлагдмал. Дуу хоолойны өнгө, ярианы хэмнэл гэх зэргээр тухайн хүний сэтгэл санааны байдал, асуудал болон харилцагчид хандах хандлагыг таамаглах мэдээлэл авах боломжтой. Өөр нэг хязгаарлагдмал зүйл бол утсаар ярьсан яриаг баримтжуулах тал дээр учир дутагдалтай. Чухал ажил хэргийг утсаар ярилгүйгээр имейл ашиглавал хавьгүй дээр. Баримт үлдэнэ.

И-мэйл болон дуут шуудан

Дуут шуудан эсвэл и-мэйлийг голдуу ерөнхий эсхүл цаг үеийн шаардлагатай мэдээлэл солилцох эсхүл асуулт асуухад ашигладаг. И-мэйл нь баримт илгээх, хүлээн авахад хөнгөн, нэгэн зэрэг олон хүнтэй зэрэг харилцах, цагт шахагдсан аливаа албан бичгийн хариуг түргэн шуурхай өгөх боломжтой. Гэвч бичилтийн хэлбэр, үгийн сонголт сөрөг сэтгэл хөдлөл үүсгэх, илгээсэн шууданг авах ёстой хүн нь нээж үзээгүй байх зэрэг сул талтай. И-мэйл илгээсэн хүндээ “мэйлээ шалгах”, “мэйл илгээсэн” тухай мэдэгдэх нь тустай. Нийтэд хэвлэгдэх, ил гарах магадлалтай зүйлийг и-мэйлд бичиж хэзээ ч болохгүй. Ялангуяа эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцогчидтой хамаатай коммент, гомдол, тоглоом наадмаар хэлсэн зүйл гэх мэт.

Уулзалт

Гадны улсын судалгаагаар дундаж ажилтан долоо хоног тутамд 3.34 ажил хэргийн уулзалттай, зарцуулах цаг нь 4.35 байдаг гэсэн тоо баримт байна. Ахлах зэрэглэлийн ажилтнууд 5.5 уулзалтад 6.6 цагийг зарцуулдаг гэжээ.[11]

Оффисын загвар

Ажилтнуудын харилцааг хөхүүлэн дэмжихийн тулд байгууллагуудын 70% “нээлттэй” “задгай” оффис загварыг орчин үед нилээн ашиглаж байна. Энэ загвар нь Баруун Германаас гаралтай. Том, задгай, хана үгүй ажлын өрөө юм. Ажилтнууд тус тусдаа ургамлаар, номын шүүгээгээр, ширээ эсвэл хөнгөн авсаархан хаалтаар тусгаарласан орчинд ажилладаг. Ийм загвар хүмүүс өөр хоорондоо харилцахад, ахлах зэрэглэлийн ажилтнууд шинэ, залуу ажилтнуудад зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангахад хялбар, хүндрэл бэрхшээлгүй байх боломжийг олгодог сайн талтай.

[11] Industrial/organizational psychology: an applied approach. 6th edition. Michael G. Aamodt.

Задгай оффисын нийтлэг 3 загвар байна. Дан (bullpen) загвар – нээлттэй, том зааланд бүх ширээг байрлуулна. Өөр хооронднь номын шүүгээ болон бусад зүйлээр дөрвөлжлөн, дөрвөлжлөн зааглаж ажлын талбайг зохион байгуулсан хэлбэр. Чөлөөт загвартай ажлын талбар нь ажилтан бүр өөр өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар ширээ, сандлаа байрлуулах боломжтой. “Өргөн чөлөө”, “зөөврийн “ гэх зэрэг оффисын загварууд байдаг. Эдгээр загварууд цаг хэмнэсэн, нээлттэй, ажилтан хоорондын харилцааг хөнгөвчилсөн, нэвтрэхэд амар байдлыг чухалчилсан бөгөөд тухайн ажилтны хувийн орон зайг ургамал, аквариум, номын шүүгээ, хувцасны өлгүүр, жижиг тусгаарлагч хана зэргээр шийдсэн байдаг онцлогтой.

АЛБАН БУС ХАРИЛЦАА

Албан бус харилцаа бол ам дамжсан мэдээлэл, дам яриа билээ.

Судалгаагаар 3 янзын хүмүүс байдгийг тогтоожээ. Тэднийг *тусгаарлагчид, холбоочид, мухардуулагчид* гэж нэрлэсэн. Ам дамжсан яриагаар ирж байгаа мэдээллийн 50-иас бага %-ийг хүлээн авдаг хүмүүс бол тусгаарлагчид, тухайн ам дамжсан мэдээний ихэнхийг хүлээн авч, цааш нь бусдад дамжуулдаг хүмүүсийг *холбоочид,* албан бус яриа, ам мэдээний ихэнхийг сонссон, хүлээн авсан боловч цааш дамжуулахгүй, тэдэн дээр ирээд мухардаж, тасарч байвал *мухардуулагчид* гэнэ. Өөр нэгэн судалгаагаар нийт ажилтнуудын 10% нь холбоочид гэжээ. Хэрэв хэн нэгэн ажлаасаа гарч, хувийн бизнес эхлүүлэхээр шийдлээ гэвэл нийт ажилтнуудын 81% энэ мэдээг аль хэдийн мэдсэн байх боловч тэдний 11% нь цааш нь дамжуулах *холбоочид* байх болно. (Stephan P. Robbins & Timothy Judge. 2013)

Ам дамжсан дам яриа хүний нэр төрд халгаатай. Хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөгч. Байгууллагын муу соёлын нэг илэрхийлэл. Ам дамжсан ярианы мухардуулагч байх, муу мэдээ тан дээр ирээд тасардаг байвал сайн. Байгууллагын муу соёлыг таригч, хөхүүлэн дэмжигч, бэхжүүлэгч байхаас зайлсхийх нь зүйтэй.

Ам дамжсан яриа 2 төрөл байна. Хов жив болон цуу яриа. Эд бол бүрэн нотлогдоогүй мэдээлэл юм.

Хов жив: Голдуу хувь хүний ач холбогдолгүй мэдээлэл байдаг.

Цуу яриа : Тухайн харилцаанд орж байгаа хүний амьдрал эсхүл ярианы сэдвийн хүрээнд чухал мэдээллийг агуулна (DiFonzo & Bordia,2006). Ихэнх цуу яриа ажил, албан тушаалын өөрчлөлт, аюулгүй байдал болон байгууллагын нэр хүндтэй холбоотой. Цуу яриа, хов живийг стресс тайлах, сэтгэлийн түгшүүр, байгууллагын алдаанд хэт түрэмгий биш байдлаар хариу үзүүлэх, хяналт тавих, хүч чадлаа мэдрэх хэрэгсэл гэжээ (Kurland & Pelledь 2000). Бас стресстүүлэгч гэж тодорхойлж болно.

ХҮН ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Нэг хүнээс нөгөө рүү харилцааны суваг ашиглан дамжуулах мэдээллийн солилцоог хүн хоорондын харилцаа гэнэ. Хүн хоорондын харилцаанд мэдээллийг илгээгч, хүлээн авагч гэж бий. Амаар эсвэл бичгээр нэг талаас мэдээ илгээгч - аливаа мэдээллийг хураангуйлан (encoding) дамжуулах бөгөөд нөгөө талаас хүлээн авагч - мэдээллийг хүлээн аван тайлах (decoding) үйл явц юм. Харилцаа үр нөлөөтэй байх эсэхэд нөлөөлөх 3 үндсэн асуудал бий.

Асуудал 1: Хэлэхийг, илгээхийг хүссэн санаа болон хэлсэн, илгээсэн санаа хоорондын зөрөө - Тухайн хүний хэлж байгаа, илгээж байгаа санаа өөрийнх нь хүссэн мессаж биш бол үл ойлголцол үүсч болно. Асуудлын шийдэл бол *харилцаанд орохын өмнө юуны тухай ярих, хэлэх, бичихээ сайн бодох; бодсоноо өөрөө хийж үзэх; давтан хийх, засах байдлаар харилцааны ур чадвараа илүү сайн болгоход*

бэлтгэл хийх, суралцах явдал юм. Ажлын байранд ахлах, орлогч, ерөнхий гэнэт дуудан ажлын хүрээний юм асуухад бэлтгэлгүй бол шууд хариулах нь ховор. Сул авиа гаргахаас хэтрэхгүй байх явдал түгээмэл тохиолддог. Ийм учраас таны удирдлага, хамтрагч танаас юу асууж болох, ямар хариулт өгөхөө урьдчилан бодох, харилцах тал дээр дасгал сургуулилалтыг хувираа хийж байвал сайн. Юу гэж хэлэхийг хүсч байгаагаа өөрөө мэдэхгүй бол харилцаа үр нөлөөгүй байх болно. Их хатуу мэдлэгтэй, өндөр боловсролтой хүмүүс харилцааны ур чадвар муутай байх нь элбэг. Харилцааны зөөлөн ур чадвар тэдэнд дутдаг. Жүжигчид, дуучид, тамирчид бэлтгэл сургуулилалт өдөр бүр хийдгийн адилаар прокурорууд ч гэсэн чухал нөхцөл байдалд хэлэхийг хүссэн зүйлээ хэлж чаддаг байхад суралцах, шүүх мэтгэлцээн, шүүх хуралдааны бэлтгэл сургуулилалт хийх нь зүйтэй. Хэргийн оролцогчдын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу мэдэгдэхэд харилцааны ур чадвар бас хэрэгтэй. Олон нийтэд мэдээллийг амаар эсвэл бичгээр өгөх, тогтоол бичих, ярианы болон бичгийн хэл, хүн хоорондын харилцаа өөр өөр ур чадварыг шаарддаг. Байгууллагууд ажилтан, албан хаагчиддаа зориулсан харилцааны сургалт, хөтөлбөрүүдийг боловсруулж, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтэд нь анхаарч ажилладаг.

Асуудал 2: Илгээсэн болон хүлээн авсан мэдээлэл хоорондын зөрөө

Мэдээлэл илгээгч илгээсэн мэдээллээ мэдэж байгаа ч эсрэг талын хүлээн авалтад олон хүчин зүйл нөлөөлдөг. Эсрэг талын хүлээн авалт тухайн хүлээн авагчийн мөн чанар, зан төлөв, сэтгэц-нийгмийн уур амьсгал (сэтгэцийн эмгэг), тухайн үеийн сэтгэл санааны байдал, анхаарлын төвлөрөлт, танин мэдэхүйн ур чадвар, нийгмийн танин мэдэхүйн схем гэх мэт олон зүйлээс шалтгаална. Үүний улмаас ирсэн мэдээллийг сонсохгүй, сонсоогүй учраас ойлгохгүй, ойлгоогүй учраас айж сандрах байдлаас болж бушуу түргэн холдох, явах гэх мэт үйлдлүүд гарснаар харилцаа бүхэлдээ үр нөлөөгүй болох, оролцогчид бие биенээ андуу ташаа ойлгох эрсдэлтэй. Ер нь хүн хоорондын харилцаа маш ярвигтай. Харилцагчдын дотор юу байна, тэр гарна гэдэг. Үүнийг илэрхийлсэн нэгэн араб сургаал бий.

Сургаал:

Нэг хүн аягатай кофе бариад явж байв. Хэн нэгэнтэй мөргөлдсөн тул кофе асгарч, энд тэнд цацагдсан. “Кофегоо асгаа юу” гэхэд нөгөө хүн “хүн мөргөчлөө” гэж хариулжээ.

Хүн түүнийг мөргөсөнд кофе асгарсан юм биш, аяганд кофе байсан тул “кофе” асгаржээ. Хэрэв аяганд сүү байвал сүү, дарс байвал дарс асгарна. Саванд юу байна тэр асгарна. Үүний нэгэн адил, үйл явдалд хүний дотор юу байна тэр гарна. Амьдралын үйл явдал бүрд тухайн хүний дотор байгаа юм л гарна. Нэг ялангуяа онцгой тохиолдолд. Онцгой тохиолдол гэдгийг онцгой байдлын тухай хуульд заасан заалтаар ойлгодоггүй, сэтгэл зүйд. Өдөр тутмын хэвшмэл зүйлээс өөр, юу ч байж болно. Тухайн хүний хувьд онцгой. Зан үйлийн өдөөгч. Өдөөгчид тухайн хүний дотор байгаа зүйл л ил гарна. Уур байвал уур. Ухаан байвал ухаан г.м. Сэтгэлийн түгшүүртэй хүний симпатик мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаатай холбоотой ам их хатаж, шингэн их ууна, шээс ойр ойрхон хүрнэ. Ойр ойрхон нойл явж байгаа хүнийг байгууллагын сэтгэл зүйч “ сэтгэлийн түгшүүртэй” байж магадгүй гэж харна. Хартай даргын хувьд тухайн хүн ажил хийдүүлэгч эсвэл өөр ямар нэгэн муу зүйл хийгч. Уг хүн нь өөрөө зовж шаналагч. Амралт, ариун цэврийн өрөө нь түүнд авралын газар байж болно. Нэг орон зай, талбай, үйл явдал хүмүүсийн сэтгэхүйд ийнхүү өөр өөрөөр тусах нь хэвийн. Үүнээс болж үл ойлголцол, зөрчил гардаг.

Асуудал 3: Хүлээн авсан мэдээлэл болон түүний тайлал, тайлбар

Харилцааны асуудлууд мэдээллийг дамжуулж буй харилцааны сувгаас шалтгаалж

бас үүснэ. Яг ижил мэдээлэл ямар суваг ашигласнаас болж (амаар, бичгээр, нүүр царай, гар хөлийн хөдөлгөөн, биеийн байрлалаар, хоёрдогч, гуравдагч талаар гэх зэрэг) өөр өөрөөр тайлагдаж болно. Жишээлбэл, ажлын шүүмжийг нүүр нүүрээ харах, бичгээр хэлэх, ганцаараа байхад эсвэл хүний дэргэд зэрэг нь өөр өөрөөр тусна. Дуу авиа (хашгирах, орилох, зөөлөн дуугарах) өөр өөр хариу үйлдлийг бий болгоно. Тохиромжтой бус сувгаар илгээсэн мэдээллийн тайлал, тайлбар бас өөрчлөгдөнө.

Дуу чимээ: хүрээлэн буй орчны дуу чимээ мэдээлэл хүлээн авахад нөлөөлнө.

Нэр хүнд: мэдээлэл илгээж буй хүний нэр хүнд хүлээн авч буй хүнд ямраас тухайн мэдээллийн хүлээн авалт, тайлал, тайлбар бас шалтгаална. Эсвэл мэдээлэл хүлээн авагчийн нэр хүнд илгээгчийн хувьд ямраас бас илгээх мэдээллийн шинж чанар шалтгаална.

Хэлэхүйн бус дохио: Харилцаанд үгээс илүүтэй хэлэхүйн бус байдал их нөлөөтэй. Жишээлбэл, тодорхой прокурорын санал бодол их чухал гэж хэлж буй ахлах өөр тийш харж байвал “тийм ч их чухал биш” гэсэн утгыг тээнэ. “Сонсож байна “ гэсэн үг нь “залхуутай байна” гэсэн хэлэхүйн бус тайлбартай байж болно. Хүмүүс хэлэхүйгээс илүүтэй хэлэхүйн бус мэдээллийг илүү анхаарч, ач холбогдол өгдөг. Харилцааны хэлэхүйн бус дохиог 5 айд хуваана. Үүнд: биеийн хэл, пара хэл зүй, орон зайн ашиглалт, цаг хугацааны ашиглалт, хувцас, эдлэл хэрэглэл болон эмх цэгц, байрлал-эд өлгийн зүйл (artifact) багтана.

Биеийн хэл: их бие, нүүр царайны хөдөлгөөн, биеийн байрлалаар харилцах.

Шүүх хуралдаан дээрх прокурорын бие, нүүр царайны хөдөлгөөн, биеийн байрлал олон мэдээллийг шүүгч, өмгөөлөгч, хэргийн оролцогч, олон нийтэд өгдөг. Өөд өөдөөсөө нүд нүдээ харах нь харилцан хүндэтгэлийг илэрхийлэх бол ташуу харах, харц буруулах зэрэг нь өөр утгыг илэрхийлнэ. Олон оролцогчтой шүүх хуралдаан дээр зарим прокурорууд сонсоод байгаа эсвэл унтаад байгаа нь мэдэгдэхгүй нүдээ аньсан байдалтай, сандлаа налан суусан харагддаг. Зарим прокурорууд сандарч тэвдэж байгаа нь, зарим нь нэг хэвийн ийм л байдаг гэсэн өнгө аястай байх нь илт байдаг. Давуу байдлыг яриа таслах, сандал дээр хазгай суух, харилцагч руу хэт ойртох болон бусад нь зогссон байхад ганцаараа суусан зэргээс харж болно. Нүд харилцаанд онцгой байр суурь эзэлдэг эрхтэн. Нүдээрээ холбоо тогтоох, харцаа буруулах, харц тулгарах, нүдээ томруулах, онийлгох, анивчих гэх мэт нүдний хөдөлгөөн янз янзын утгыг нөхцөл байдал бүрд өөр өөрөөр илэрхийлнэ.

Биеийн хэл маш хэрэгтэй боловч яг ижил дохио өөр өөр соёл, нөхцөлд янз янзын утгатай гэдгийг ойлгох нь чухал. Ийм учраас болгоомжтой байх хэдий ч хэлэхүйн бус дохио бүрийг унших гэж хичээсний хэрэггүй юм.

Орон зайн ашиглалт:

Орон зай ашиглаж байгаа байдал нь хүмүүс хоорондын харилцааны мэдрэмж, бие хүний онцлог шинжийн хэлэхүйн бус дохио юм. Давуу байдалтай, эрх мэдэлтэй хүмүүс бусдаас илүү том орон зайг эзэлдэг бөгөөд бусад хүмүүс тэднээс хол зогсох, суух, байрлах, гэхдээ нилээн ташуу байдалтай байдаг зэргээс доод тушаалын ажилтнууд дээд тушаалынханд том орон зай олгодгийг харж болно. Эрх мэдэлтэй нэгэн илүү чөлөөтэй хөдлөх, бусдад ойрхон явж очиж байгаа байдлаар илэрнэ. Хүн хоорондын харилцаанд орон зайн ашиглалт хэр нөлөөлдгийг харуулсан нэгэн түүх байдаг. АНУ-ын Нью Иоркийн Янкинүүд гэх спортын клубын эзэн Георги Стейнбреннертэй өөр нэг спортын агент гэрээ хийх болжээ. Гэрээ хийгч Стейнбреннерийн оффист явж ороход нэг зүйл анзаарагдаж. Стейнбреннер маш урт ширээний төгсгөлд суусан байна гэнэ. Эсрэг талд нь гэрээ хийх агентын суух жижигхээн сандал байна гэнэ.

Гэрээ хийгч агент сандал ширээний хэмжээ, орон зайн байрлалаас Стейнбреннер давуу эрхтэйгээ илэрхийлж буйг ойлгон сандлаа түүн рүү дөхүүлэн тавьж, ойртон очиж суужээ. Өөрийн энэ зальтай үйлдлээрээ агент тамирчинтай маш амжилттай, сайн гэрээг хийж чадсан гэдэг. Том барилга, том өрөө, том орон зай, байрлал зэрэг нь хүмүүс хоорондын хэлэхүйн бус харилцааг илэрхийлнэ.

АНУ-д дотно харилцаа, хувийн, нийгмийн болон олон нийтийн гэж харилцааны орон зайн 4 гол хэмжээ байдаг (Hall, 1963). Дотно харилцааны зай нь хосууд, эхнэр нөхөр, гэр бүлийн хүмүүсийн хүрээнд байх ба ойролцоогоор 46 см, хувийн харилцааны зай 46-122 см-ийн хооронд байх бөгөөд найзууд, таньдаг хүмүүс нэвтрэх эрхтэй. Нийгмийн зай нь 122-366 см-н ийн хооронд байх бөгөөд байгууллагын харилцааны орон зайн хэмжээ. Ажил хэргийн холбоотой болон таньж мэдэхгүй хүмүүс хоорондын харилцааны орон зайг илэрхийлнэ. *Олон нийтийн зай* нь 366-762 см хүртэл бөгөөд лекц, сургалт, зөвлөгөөн зэрэг олон хүнийг хамарсан арга хэмжээний орон зайн ашиглалтын хэмжээ гэнэ. Манай орны ихэнх өрх монгол гэрт эсвэл бага орон зайд 2-3 үеэрээ нэг дор амьдрах нь хэвийн тул дээр дурдсан орон зайн хэмжээний ойлголт тодийлөн байхгүй.

Ажлын өрөөний тохижилт бас харилцааны хэлэхүйн бус дохиод багтана. Дээр дурдсан жишээний урт ширээ, түүний байрлал бол эрх мэдэл, нээлттэй байдлыг илэрхийлэх ч ажил хэргийн уулзалтад ирсэн хэн ч байсан тийм ширээнд суухгүй байхыг илүүд үзнэ. (Davis, 1984). Цэвэр, бохир ажлын өрөө, ногоон ургамлын арчилгаа нь ажил ихтэй эсхүл багатай эсхүл тухайн байгууллагын үйлчилгээний албаны ажлыг илтгэнэ.

Цаг ашиглалт:

Цаг ашиглалт хүмүүс хоорондын харилцааны хэлэхүйн бус дохионы нэг юм. Хэрэв удирдлага ажилтантай уулзах цаг товлон, товлосон цагаас өмнө ирж, уулзалтад бэлдэж байгаа бол тухайн удирдлагын ажилтанд хандах хандлага, уулзалтын ач холбогдлыг илэрхийлнэ. Байгууллагын өндөр албан тушаалтай нэгэн хоцроход хүлээн зөвшөөрөх, бага албан тушаалын хүмүүс хоцрохыг (нэг минут хоцорсон ч) хүлээн зөвшөөрөхгүй хандлага харагддаг. Цаг барилт, ашиглалтад бас соёлын ялгаа бий. АНУ, Австри, Канад, Герман, Япон зэрэг орнуудад цаг ашиглалт, цаг барих маш чухал бол Бразил, Мексик, Франц, Саудын Араб зэрэг орнуудад тийм ч чухал биш. (Olofsson, 2004).

Пара хэл зүй: Дууны өнгө, хэмжээ, ярианы хурд, түр зогсоц, түүний үргэлжлэх хугацаа болон давтамж пара хэл зүйд багтана. Хурдан ярьдаг хүний мэдээллийг удаан ярьдаг хүн өөрөөр хүлээн авна. Судалгаагаар хурдан ярьдаг хүмүүсийг илүү ухаалаг, нөхөрсөг, урам зоригтой гэж хүлээн авдаг. (Hecht & LaFrance, 1995) Сул үг их хэрэглэн, гацаж түгдчээд байгаа хүмүүсийг оюун ухааны хөгжил, боловсрол, ур чадвар муу гэх. Янгинасан дуутай нэгнийг сул дорой гэх. Худлаа ярьж байгаа хүн ерөнхий, бага мэдээлэл өгөх мөртлөө нэг үг, өгүүлбэрийг олон дахин давтах, дуу хоолойны өнгө нь тодорхой биш, хоолойны хүчдэлээс шалтгаалан хүчтэй янгинасан байдлаар ярих нь үнэнээ ярьж байгаа хүнээс ялгаатай. (DePaulo et al., 2003). Дууны өнгийн энгийн жижиг өөрчлөлт, үгийн өргөлт харилцаанд мэдээллийн утгыг өөрчлөх хэмжээний хүчтэй. Жишээ: Би Доржийг таны машиныг хулгайлсан гэж хэлээгүй гэж хэлэхдээ “Би” гэдэг үгэн дээр өргөлттэй байвал хэн нэгэн өөр хүн Доржийг таны машиныг хулгайлсан гэж хэлсэн хэмээн ойлгогдоно. Харин “Дорж” гэдэг үгэн дээр өргөлт аван чангаар хэлбэл өгүүлбэрийн утга өөрчлөгдөнө. Дорж биш өөр “хэн нэгэн таны машиныг хулгайлсан” гэх зэргээр ярианы аль үгэн дээр өргөлт байгаагаас утга хамаарна.

Үгийн өргөлт ба утга

Би Доржийг таны машиныг хулгайлсан гэж хэлээгүй. (Хэн нэгэн өөр хүн хэлсэн.)

Би Доржийг таны машиныг хулгайлсан гэж хэлээ**гүй.** (үгүйсгэх)

Би Доржийг таны машиныг хулгайлсан гэж **хэлээгүй.** (Далд утгатай)

Би **Доржийг** таны машиныг хулгайлсан гэж хэлээгүй. (Өөр хүн машин хулгайлсан.)

Би Доржийг таны машиныг **хулгайлсан** гэж хэлээгүй. (түр зээлсэн.)

Би Доржийг **таны** машиныг хулгайлсан гэж хэлээгүй. (Дорж өөр хүний машин хулгайлсан)

Би Доржийг таны **машиныг** хулгайлсан гэж хэлээгүй. (Дорж машинаас өөр зүйл хулгайлсан.) зэргээр өөр өөр утгатай болж байна.

Бичвэр хэлбэртэй байвал бас өөр тайлбартай.

Хувцас, эдлэл хэрэглэл болон эмх цэгц, байрлал: Хэдийгээр бүгд хуулийн байгууллагын хүмүүс ч шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөгчдийн хувцаслалт өөр өөр байдаг. Бүх шагналаа ханандаа өлгөн, үнэтэй том сандалд суух байдал зэрэг нь хэлэхүйн бус дохионы эд өлгийн зүйлд багтана. Өрөөнд ширээ сандлаа хэрхэн байрлуулснаас уулзалтад ирсэн хүний хүртэхүй хамаарна. Өрөөний ширээ сандал нээлттэй эсвэл хаалттай байрлалд байгаа эсэх их чухал. Нээлттэй байрлал тухтай, нөхөрсөг, итгэлтэй, нээлттэй, сонирхолтой болон гадагшаа чиглэсэн байдлыг илтгэнэ. (Campbell, 1979; McElroy, Morrow, & Wall, 1983; Widgery & Stackpole, 1972). Байгууллагад гаднаас орж ирж байгаа хүн дотор байгаа ургамал, цэцэг, цэцгийн савыг их харж, ая тухтай, зочломтгой, элэгсэг, найрсгаар ойлгоно. (Campbell, 1979). Ажлын өрөөний тавилгын байршил, тохижолтод энергийн урсгал гэх мэт зүйлийг харгалзах, Хятадын фэнг шүг их ашигладаг. (e.g., Too, 2009) Тухайлбал, ажлын ширээг өрөөний голд байрлуулахгүй байх, хананаас зайтай байх гэх мэт зүйлс бий. Ажлын өрөөний загвар, тохижилт, байр байдал зөвхөн ая тух биш тухайн ажилтан, албан хаагчийн бусдад хандаж байгаа хандлагыг илэрхийлнэ. Хавтаст хэргүүдийг эмх замбараагүй байрлуулсан байвал хэргийн оролцогч нарт, хамт ажиллагсдад тухайн хэргийг тоохгүй, хариуцлагагүй мэт сэтгэгдэл төрүүлнэ. Тийм биш байсан ч харилцагч тал тэгж хүлээж авдаг. Хэрэв харилцаагаа сайжруулах, үр нөлөөтэй харилцааг эрхэмлэдэг бол өрөөний дотоод зохион байгуулалт, эмх цэгцэд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай.

Ажлын өрөөний тохижилт, байгаа байдал нь тухайн ажилтны бие хүний хэв маяг, зан төлөв, харилцааны талаарх мэдээллийг тээж байдаг. (McElroy, Morrow, and Ackerman (1983) Ахимаг насны, өндөр албан тушаалтай хүмүүс ширээгээ голдуу хаалттай байрлалаар тавина. Гадаадын зарим эрдэмтэд (Zweigenhaft (1976) Cochran, Kopitzke, and Miller (1984) дарга нарын өрөөг тухайн даргын хувийн зан төлөвтэй нь харьцуулсан судалгаа хийжээ. Захирангүй, ололт амжилтад чиглэсэн даргын өрөө чимэглэлгүй, стандарт тавилгаас өөр зүйл байхгүй, харин гадагшаа чиглэсэн, нээлттэй, нийцтэй удирдагчдын өрөөнд амралт зугаалгаар авахуулсан фото зургуудтай, ажил дуусч, тарах цагаа мэдэх цаг байрлуулсан зэрэг ялгаатай байдаг гэжээ. Дотогшоо чиглэсэн, ганцаараа байхыг илүүд үзэх даргын өрөөнд цэцэг, гэрий нь санагдуулах зурсан зураг, зохион байгуулалт сайтай удирдлагын өрөөнд шог хошин зураг байх бөгөөд үүгээрээ тэд эмх цэгц, ажлын хэнээтэй ч хошин шогийн мэдрэмжтэй гэдгээ харуулахыг хүсдэг гэж дүгнэжээ. Харилцааны эд өлгийн зүйлийн дохионд цонх, түүний чимэглэл бас хамаардаг. Цонхтой, цонхгүй өрөө, цонхны тоо, цонхоор харагдах зүйлс, цонх муутай өрөөний тохижилт, чимэглэл хүртэл өөр өөр байдаг тухай, цонхгүй өрөөнд байгалийн зураг, цонхтой өрөөнд хот, байшин барилгын зураг түлхүү байрлуулсан байдаг тухай судалгаа байна (Heerwa-

gen and Orians (1986).

Мэдээллийн хэмжээ:

Хүн тогтоож, санаж чадахаас илүү их хэмжээний мэдээлэл сонсвол тухайн мэдээлэл хүний оюун санаад 3 үе шатаар дамжина. Үүнд: 1. нурааж тэгшлэх; 2. хурцалж ирлэх; 3. өөрийн болгох;

Гадаад жишээ:

Дараахь яриаг болжээ гэж төсөөлье. “Жон Атомс Детройтед автомашины Женерал Флоатерс Корпорацид ажилладаг. Тэр Мягмар гарагт ажилдаа хүрэн цамц, дөрвөлжин хээтэй өмд, цагаан оймс, хар гуталтай иржээ. Урагшаа тонгойж, хөлөө чирч явж байснаа буцаад гараад явчихсан. Халамцуу байсан байхаа. Тэр энэ компанид 25 жил ажиллаж байгаа болохоор дарга нар түүнийг халаагүй. Түр хугацаагаар хэд хоногийн чөлөө өгсөн. Дарга нар яагаад ингэв гэвэл тэр саяхан 8 дахь удаагаа хүнтэй суусан.” Хэрэв та ийм яриа сонсвол яах вэ? “8 удаа хүнтэй суусан гэнээ? гэж шууд дуу алдаж магад.

Ийм үед хүн тухайн мэдээллийг нурааж тэгшлэнэ. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл та мэдээллээс хэрэггүй хэсгийг нь авч хаяна. Дараагийн найздаа ярихдаа юу өмссөн тухай (хүрэн цамц....) хэлэхгүй. Мэдээллийг хурцалж ирлэх гэдэг нь сонирхолтой хэдий ч хэрэггүй мэдээллийг хадгална. Энэ тохиолдолд магадгүй 8 дах удаагаа хүнтэй сууж байгаа нь гол зүйл болно. Дараагийн найздаа тэр гол зүйлийг дамжуулна. Мэдээллийг өөрийн болгоно гэдэг нь тухайн мэдээллийг хүлээж авахдаа өөрийн мэдлэгт суурилан тохируулж өөрчилнө. Жишээлбэл, олон хүмүүс Атом гэдэг хүний нэр хэзээ ч сонсож байгаагүй, харин Адам гэж мэднэ. Үүнтэй адилаар Женерал Флоатерс гэдгийг Женерал Моторс болгон өөрчилнө. Дараагийн удаа хүнд хэлэхдээ Атомыг Адам, Женерал Флоатерсийг Женерал Моторс болгоод дээр нь халамцуу гэдэг үгийг ”согтуу” эсвэл “тасарсан” гэж дамжуулах магадлал өндөр.

Харилцааны хэт ачаалалд үзүүлэх хариу үйлдэл: Харилцааны хэт ачаалалтай, дааж чадах хэмжээнээс хэтэрсэн мэдээлэл авах, дамжуулах тохиолдолд гардаг хариу үйлдлүүд:

Орхих: *Тодорхой төрлийн мэдээллийг санаатайгаар орхих.* Жишээлбэл, завгүй үед утас дуугарах юм бол авалгүйгээр хэргээ унших эсвэл тогтоолоо бичиж дуусгах. Анхаарах зүйл: Энэ арга нь харилцааны хэт ачаалал түр зуурын үед үр ашигтай. Чухал дуудлага, харилцааг авалгүй орхихоос болгоомжлох

Тэмдэглэж авах : Ирж байгаа мэдээлэл бүрд хариу өгөхөд алдаа гаргах эрсдэл ихэсдэг. Санаатай биш ч хэт ачаалалтай үеэр мэдээлэл бүрийг хүлээн авахад хүлээн авалтын алдааг хүн бүр гаргадаг тул бичиж, тэмдэглэх.

Жагсаалт гаргах, эрэмбэлэх: Харилцааны хэт ачааллын үеэр ажлыг чухлаас тийм ч их чухал биш, хүлээх боломжтой хүртэл жагсааж, эрэмбэлэх. Жагсаалт гаргахдаа мэдээллийн ач холбогдол, хугацаа, хаанаас хэнээс ирж байгаа, хаашаа хэн рүү илгээх шаардлагатай, яаралтай, хойшлуулшгүй гэх мэт. Ерөнхийгөөс ирсэн аливаа мэдээлэл эсвэл яаралтай хойшлуулшгүй мэдээлэл жагсаалтын эхэнд байна. Ийм эрэмбэ, жагсаалт гаргах арга нь харилцааны ачаалал түр зуур их үед үр дүнтэй. Хэрэв байнга ачаалалтай байдаг бол жагсаалтын сүүлд байгаа хэсэгт хэзээ ч хүрч очихгүй гэдгийг харгалзан, ажлаа зохицуулах;

Зугатах: Ачаалал хэт их, удаан хугацаагаар үргэлжилсэн бол ажилдаа ирэхгүй байх аргыг олон хүмүүс ашигладаг. Энэ арга байгууллагад ашиг тус муутай ч ажилтны сэтгэцийн болон бие махбодын эрүүл мэндийг хамгаалж, стрессийг бууруулдаг. Оюутнууд энэ аргыг түгээмэл ашигладаг. Хичээл таслах, чөлөө авах,

жилийн чөлөө авах гэх мэт.

Харуул, манаач, жижүүр ашиглах: Байгууллагууд харилцааны хэт ачаалалтай үед жижүүр гарган хамгийн чухал, байгууллагад зайлшгүй шаардлагатай хүнийг нэвтрүүлэн оруулах аргыг хэрэглэдэг. Байгууллагын жижүүр, мэдээллийн ажилтан, нарийн бичиг зэрэг нь ийм аргын жишээнүүд юм.

Олон суваг ашиглах: Ачаалал хэт ихэдсэн үед нэг хүн дээр ачаалал өгөхөөс сэргийлж мэдээлэл хүлээн авах, дамжуулах хүний тоог нэмэх, шинэ ажилтан авах, орон тоо гаргах;

Харилцааны хэт ачааллын дээрх хариу үйлдлүүдийг мэдэж, ойлгох нь чухал. Хэт ачаалалтай үед ажилтнууд дээр дурдсан аргуудыг ашиглаж, ачааллаа бууруулдаг. Зарим аргууд (орхих, зугатах) байгууллагад хор уршигтай. Ийм учраас байгууллага харилцааны ачаалал ихэдсэн үеийн болзошгүй хариу үйлдлүүдийг урьдчилан таамаглаж, сэргийлэх хариу үйлдлийн стратегитай байх шаардлагатай.

Прокурорууд системийнхээ харьяа нэгж байгууллагын гадна орших өөрийн хяналтад байдаг субьектүүдтэй харилцахдаа өөрийн эрх, үүргээс гадна тухайн харилцагчдын эрх зүйн байдал, мэргэжлийн ажиллагааны хүрээ, баримталдаг зарчмуудыг нь сайн мэддэг байх зайлшгүй шаардлагатай. Хяналтын буюу доошоо чиглэсэн харилцаа тул прокурорууд, ялангуяа залуу, туршлага багатай хуульч ихэрхүү байдалтай, хуульд заасан эрх мэдэлдээ эрдэх эрсдэлтэй. Эсвэл хэт болгоомжтой, өөртөө итгэлгүй байж болно. Яг өнөөдрийн байдлаар энэ харилцаанд прокурор давуу байдалтай байгаа тул прокурорын биеэ авч яваа байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Хуульд заасан чиг үүрэг хоорондын давхцал, зөрүү бодит амьдрал дээр элбэг. Иймээс эрх зүйд захирагдах зарчмыг баримтлахаас гадна хүн хоорондын харилцааг эрхэмлэвэл нэн тустай. Тухайн харилцагчийн хувийн авир араншин, зан төлөв, сонсох хэв шинжийг нь ажиглаж ерөнхий багцаа, дүн нуруутай байх, түүнийгээ үр дүнтэй ашиглах ур чадвараа хөгжүүлэхэд анхаарвал сайн. Хүн хоорондын харилцаа механик зүйл биш тул схем, нийгмийн танин мэдэхүйн эндүүрлийн үр нөлөөд автсаны улмаас харилцааны явцад хүчтэй сэтгэл хөдлөлд автуулах үйл явдлууд бишгүй тохиолдоно. Тухайлбал: Харилцаж байгаа субъект Таныг гүтгэж болно. Прокурор таныг мэргэжлийн болон ёс зүйн талаас “муухай” “муу” харагдуулах, гүтгэх байдлаар албан харилцааны зохисгүй тактик ашиглах “хүн чанар муутай” хуульчтай таарах, хамтран ажиллахыг үгүйсгэхгүй. Ийм тохиолдолд сөрөг, хортой сэтгэлийн хөдөлгөөнд хүчтэй автах маш өндөр эрсдэлтэй. Сөрөг, хортой сэтгэлийн хөдөлгөөнд уй гашуу, ичих, уур багтана. Эдгээр сэтгэлийн хөдөлгөөнд автсан үед үг хэлэх, үйлдэл хийж чадахгүй байдалд орох төдийгүй хүний аюулгүй байдалд заналхийлэх (уй гашуугаас болж үхэх, дургүй хүрэх, бухимдал, уураа барьж чадаагүйгээс гэмт хэрэгтэн болох гэх мэт) хор уршигтай. Физиологийн үндэстэй тул сөрөг, хортой сэтгэлийн хөдөлгөөнүүдийг таньж мэдэх, удирдах ур чадварт суралцах, нэн ялангуяа төв мэдрэлийн хүчтэй, түргэн, тогтворгүй шинжтэй прокурорууд онцгой анхаарах хэрэгцээ шаардлагатай тулгарч байна. Хүний сэтгэл зүйг тодорхойлохоос илүүтэй өөрийнхөө авир араншин, зан төлөв, хүн хоорондын харилцааны ур чадварын түвшин, сонсох хэв шинжээ сайн мэддэг байх, хөгжүүлэх нь түлхүү ашигтай. Хүн хоорондын харилцаа л бүх төрлийн ажил, албанд хамгийн их нөлөөтэй. Хүн хоорондын сайн харилцагч байхад бэлтгэл чухал. Бэлтгэлд бүтэлгүйтэх нь бүтэлгүйтлийн бэлтгэл гэж хэлж болно. “Хэрвээ...” нөхцөл байдлыг урьдчилан таамаглаж бэлдэх нь чухал.

Тогтвортой гадагшаа чиглэсэн хэв маягтай прокурорууд гүйцэтгэл муутай байх сул талтай тул ажилдаа төвлөрөх, гүйцэтгэлээ сайжруулах, бүтээмжээ нэмэхэд анхаарах нь зүйтэй. Прокурорууд өөрийн хяналтад байдаг субьектүүдээс гадна

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч, олон нийттэй бас харилцдаг. Эдгээр харилцагчид хуульч мэргэжлийн биш байх, хуулийн байгууллага, прокурор, прокурорын байгууллагаас шударга ёсыг хүсэх ерөнхий чиг хандлагатай тул “шударга ёс” гэдгийг мэргэжлийн бус хүмүүс юу гэж ойлгодог талаар мэдлэгтэй болох, түүнд нь тохирсон үг хэллэгийг ашиглаж сурах, гэнэтийн байдлаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ажилтан тантай харилцахад бэлэн байх бэлтгэлийг хангах хэрэгтэй.

2.3 Харилцааны ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах арга зам

Сонсох

Сонсох бол харилцааны хамгийн чухал ур чадвар.

Сонсох хэв шинжүүд:

Хүн бүр өөр өөрийн гэсэн тодорхой, сонсох хэв шинжтэй. Дараах 6 гол хэв шинж нийтлэг байдаг.(Geier and Downey (1980)

Таваараа, зугаацан сонсогч: “Цагийг зугаатай өнгөрөөх” зантай хүмүүс тэдэнд таашаал төрүүлэх, дуртай үгээ сонсоно. Жишээлбэл, багш зөвхөн сонирхолтой, хөгжилтэй, хошин шог ярьвал сонсох оюутан, сурагч. Ажилтнуудын хувьд ийм хүн ажлын тухай хамгийн сүүлд сонсох хандлагатай.

Инклюзив сонсох: Энэ хэв шинжийн хүн мэдээллийн ард байх гол зүйлийг л сонсоно. Тухайлбал, бүтэн цагийн турш тогтоол хэрхэн буцаж, гологдол гарч байгаа шалтгааны тухай шуурхай зөвлөгөөн боллоо гэж төсөөлбөл, ийм сонсогч “тогтоол буцсан”, “гологдол гарсан” “сайжруулах шаардлагатай” гэдгийг сонсоно. Гол зүйлийг сонсох сайн талтай ч нарийн ширийн зүйлийг сонсохгүй, дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай үед сонсоогүй байх сул талтай.

Гадаад төрхийн сонсогч: Харагдах байдлыг нь харж сонсоно. Тухайн ярьж байгаа зүйл, мэдээлэл дамжуулж байгаа хүний харагдах байр байдал тохирч байвал сайн сонсоно. Жишээлбэл, бизнес, хөрөнгө оруулалтын чиглэлийн сургалтад хамрагдаж байгаа ийм хэв шинжийн хүн тухайн хичээлийг зааж байгаа хүн сайхан хувцасласан, сайн чанарын эд хэрэглэж байвал анхааралтай сонсоно. Өөртөө сайхан хувцас авч чадаагүй хүнээс хөрөнгө оруулалтын тухай сонсох ямар шаардлагатай гэж? Үүнтэй адилаар хэрэв арга хэмжээ их хөгжилтэй байх болно гэж мэдээллээ гэхэд тухайн мэдээллийг дамжуулагч өөрөө хөгжилтэй харагдахгүй бол сонсохгүй гэсэн үг.

Техникийн сонсогч: Ийм сонсогч бүх мэдээллийг дэлгэрэнгүй сонсох ч түүний ард байгаа утгыг бага сонирхоно. Зөвхөн тоо баримт сонсоно. Жишээлбэл, дээр дурдсан “тогтоолын буцаалт”-тай холбоотой мэдээлэл байлаа гэхэд техникийн сонсогч тэдэн хүний тэдэн тогтоол буцсан гэдгийг л сонсоно. Өөрийнх нь тогтоол буцсан байсан ч түүнийг анзаарахгүй.

Эмпатик сонсогч: Харилцагчийн сэтгэл санааны байдал, мэдрэмжийг их анхаардаг. Зургаан төрлийн сонсогчдоос хамгийн их хэлэхүйн бус дохиог анзаарна. Хүний гомдол, бухимдал, зовлонг сонсох цорын ганц сонсогч.

Үл эвлэрэгч сонсогч (нонконформист) Өөрөө санал нийлэх зүйлийг л сонсоно. Ярьж байгаа хүний мэдээлэлтэй санал нийлэхгүй бол сонсохгүй. Мэдээлэл дамжуулагчийг хүчтэй гэж бодсон бол эсхүл эрх мэдэлтэй нэгнийг сонсоно.

Сонсох хэв шинж хүмүүс хоорондын харилцаанд нөлөөлөх нөлөөлөл: .

Өөр өөр сонсох хэв шинжтэй хүмүүс нэг байгууллагад ажиллаж байгаа. Удирдлагууд бас өөр өөр сонсох хэв шинжтэй. Сонсох хэв шинж хүмүүс хоорондын харилцаанд их нөлөөтэй. Жишээ: Нэг прокурор даргадаа өөрийгөө “40 градус

хүртэл халуунтай байна, чөлөө авъя” гэж хэлсэн тохиолдолд өөр өөр сонсох хэв шинж бүхий дарга нар хэрхэн сонсохыг харцгаая.

Хүснэгт 1. Сонсох хэв шинж ба сонсох байдал

д/д	Даргын сонсох хэв шинж	Сонсох байдал
1	Таваараа зугаацан сонсогч	Тухайн ажилтны хэлсэн зүйлийг бага анхаарна. Яагаад гэвэл тэр таагүй зүйл сонсох дургүй. Халуурах, өвдөх бол таагүй зүйл.
2	Инклюзив сонсогч	Хэн, хэдэн градус халуунтай байгааг сонсохгүй. “Халуурсан” гэж сонсоно.
3	Харагдах байдлын сонсогч	Ажилтан халуунтай хүн шиг харагдаж, сонсогдвол сонсоно. Олонх өвчтэй хүмүүс өвчтэй хүн шиг харагддаггүй, бас сонсогддоггүй. Гэвч хүмүүсийн өөр өөр сонсох хэв шинжийг ойлгох, түүнд тохируулан харилцах шаардлага байдаг.
4	Техникийн сонсогч	Бүх үгийг сонсох ч утгыг анзаарахгүй. Хэдэн минутын дараа хэн нэгэн “.... өвдсөн гэсэн үү” гэвэл “Мэдэхгүй ээ. Халуунтай л гэсэн” гэж хариулна.
5	Эмпатик сонсогч	Бие нь таагүй байгаа тул чөлөө авч, гэртээ харихыг хүсэж байна гэдгийг сонсох цорын ганц сонсогч
6	Үл эвлэрэгч “нонконформист”	Бага анхаарна. Хэрэв үнэхээр 40 градус халуурсан бол энд байх боломжгүй. 40 градусын халуунтай хүн үхнэ. Үхээгүй тул худлаа ярьж байна.

Харилцааны ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах хамгийн чухал арга зам бол өөрийн болон бусдын авир араншин, зан төлөв, сонсох хэв шинжийг мэдэх явдал юм. Энэ нь нэгдүгээрт, өөрийнхөө сонсох хэв шинжээ мэдэж байвал бусдыг сонсохдоо юун дээр анхаарахаа мэдэхэд тустай. Хоёрдугаарт, бусдын сонсох хэв шинжийг ойлгож мэдсэнээр тэдэнтэй илүү сайн харилцана. Жишээлбэл, инклюзив сонсогчтой харилцахдаа тэд гол зүйлийг л сонсоно. Дэлгэрэнгүй мэдээлэл, нарийн ширийн зүйлийг анзаарахгүй тул дэлгэрэнгүй бичих, давтан хэлэх хэрэгтэй гэдгээ мэднэ. Сонсох хэв шинжийг яаж мэдэх вэ? Сорил байдаг. Гэвч сорилыг ашиглах боломжгүй тул яриаг нь анхааралтай сонсох шаардлагатай. Хэрэв ярьж байгаа хүн тухайн зүйл өөрт нь ямар санагдсан тухайгаа голдуу ярьж байвал эмпатик сонсогч, дэлгэрэнгүй ярьж байвал техникийн сонсогч гэх мэт. Шуурхай зөвлөгөөн болон бусад үед сонсогч бүрд тохируулан мэдээллээ дамжуулах хэрэгцээ шаардлагатай болж байна. Яриандаа бага зэрэг хошин шог, хөгжилтэй түүхийг таваараа зугаацан сонсогчид, ярианы сэдвийг товчилж, хураангуйлан гол санааг тодотгох байдлаар инклюзив сонсогч, тодорхой тоо баримтыг техникийн сонсогчид, ямар санагдсан юу мэдэрсэн тухайгаа эмпатик сонсогчид, харагдах байдал, хувцаслалтад анхаарах байдлаар харагдах байдлын сонсогч, нухацтай өөртөө итгэлтэй, хүчирхэг байдлыг үл эвлэрэгч (нонконформист) сонсогчид зориулах зэргээр сонсох хэв шинж бүрд тохирсон мэдээллийг хавчуулж дамжуулбал сайн харилцагч байна.

Үр дүнтэй сонсох аргууд:

- Чимээгүй байх
- Нөгөө хүний яриа дуусахыг хүлээх, дуусгах
- Хүний яаж ярьж байгааг биш юу ярьж байгаа дээр төвлөрөх
- Яриаг ойлгосон эсэхээ шалгах асуулт асуух, гэвч ярьж буй хүний яриаг тасартал олон асуухгүй
- Тэвчээртэй, нээлттэй байх. Санал нийлэхгүй байвал яриа дууссаны дараа

өөрийн бодлоо хэлэх
- Ярьж байгаа хүний яриа дууссан үед хэдэн секунд чимээгүй байх. Ингэснээр яриа дууссанд итгэлтэй болж, дараагийн хариу яриаг тайван эхэлж болно. Сонсох чадварт дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

Сэтгэл санааны байдал, сэтгэлийн хөдөлгөөн

Мэдээллийг хүлээн авч, тайлж байгаа хүний сэтгэлийн хөдөлгөөн сонсох байдалд нөлөөлдөг. Ууртай, түгшүүртэй, сэтгэл гутралтай үед сонсохгүй, ойлгохгүй, зөв бодож чадахгүй. Хэзээ хамгийн сүүлд хүнтэй маргасан бэ гэдгээ бодоорой. Яриа ухаалаг байсан уу? Маргаан дууссаны дараа хоёулаа юу юу гэж ярьснаа санаж байна уу?

Танин мэдэхүйн ур чадвар:

Танин мэдэхүйн ур чадвар бол мэдээллийг хүлээн авч, тайлбар өгөхөд нөлөөлдөг өөр нэгэн хүчин зүйл. Мэдээллийг хүлэн авсан ч хангалттай ойлгохгүй байж болно. Яриаг сонсоод байгаа, хүснэгт графикуудыг хараад байгаа мөртлөө ойлгохгүй байж болно.

Өрөөсгөл хандлага:

Тухайн хүний үйлдлийн мөн чанар, онцлог, нөхцөл байдал, гадаад хүчин зүйлтэй холбож үзэлгүй, шууд дүгнэлт хийн буруутгах үйлийг өрөөсгөл хандлага гэнэ. Ухамсаргүй алдаа. Автомат үйл явц. Эвристик арга. Нийгмийн дарамт болон сэтгэлийн хөдөлгөөнөөс үүдэлтэй. Илт хэвийсэн өрөөсгөл хандлага заримдаа сайн байж болно. Тухайн зүйлтэй адилсан, нийтлэг шинжийг тээж, нэгдмэл холбоонд байлгана. Өрөөсгөл хандлага харилцааны мэдээллийг хүлээн авах, тайлахад нөлөөлдөг. Гэвч эндүүрэл дагуулдаг.

Бичих

Тогтоол, тайлан бичих, өргөдөл гомдлын хариу өгөх, журам боловсруулах зэрэг нь бичгийн харилцааны ур чадварт багтана.

Шилэн тунгалаг буюу ёс зүйн харилцаа

Ажилтан, удирдлагын хооронд ажил-амьдралын асуудалд нээлттэй, илэн далангүй, үнэн байх харилцааг хэлнэ. Гэвч ийм төрлийн харилцаанд асуудал бас гардаг. Удирдлагын зүгээс голдуу байгууллагын санхүүтэй холбоотойгоор бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх, цомхотгол хийх шаардлага бага биш тохиолддог. Ийм тохиолдолд нэлээн асуудал үүснэ. Удирдлага шийдвэрээ ажилтнуудад урьдчилан хэлэх шаардлагатай юу, нөхцөл байдал өөрчлөгдөж болзошгүй тул харзнах, ажилтнуудыг стресст оруулахгүй байх, цомхотгол хийх хүсэл үнэхээр байхгүй байгааг нь ажилтнууд ойлгохыг хүсэх гэх зэрэг асуудал үүснэ. Гол асуудал ёс зүйд нийцэж байгаа эсэхэд оршино. Удирдлагын зүгээс цомхотгол хийх эсэх, ямар ямар ажлын байрыг цомхотгох тал дээр тодорхой болсон үед мэдээлбэл ёс зүйд нийцнэ гэж үзэж болно. Гэтэл ажилтнуудын зүгээс тийм биш байж болно. Нэгэнт цомхотголын асуудал гарч ирсэн бол эртхэн хэлж мэдэгдэх нь ёс зүйд нийцнэ гэж үзэж болно. Ялангуяа байр, машин, цалин, хэрэглээ гэх зэрэг зээлтэй хүмүүс өөр ажил эртхэн хайх хандлагатай. Энэ мэтээр ажлын байрны харилцаа нэн төвөгтэй. 2008 онд АНУ-ын байгууллагын хөндлөнгийн судлаач нар ажлын байрны ёс зүйн судалгааг хийхэд ажилтнуудын 84% шилэн, тунгалаг харилцаа ёс зүйтэй ажлын байрыг бий болгоно гэж үзсэн байдаг.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. American Psychiatric Association. (2000). diagnostic and statistical manual of mental disorders. 4th ed.,
2. American Psychiatric Association. (2000). diagnostic and statistical manual of mental disorders. 5th ed.,
3. American Psychiatric Association. (2000). The road to burnout. Adapted frpm Miller, L.H. & Smith, A.D. The stress solution. http://helping.apa.org/work/stress
4. Albert Ellis, Catarine Maclaren. (2004) Rational Emotive Behavior Therapy. 2th ed. Pp 35-36
5. Anderson, K.N., Anderson, L.E&Glanze, W.D 1994 Mosby's medical, nursing, and 3. allied halth dictionary. 4th ed.(Rev.ed.). St Louis:Mosby
6. Cherniss,G (1992) Long term consequences of burnout: An exploratory study.Journal of Organic Behavior, 13(1, pp.1-11
7. Chrousos, GP & Gold, P.W. (1992). The concepts of stress systems disorders: Overview of behavioral and physical homeostasis, JAMA, 267, p.1244
8. Cummins, R. (1990). Social insecurity, anxiety, and stressful events as antrecedents of depressive symptoms. Behavioral Medicine, Winter, pp.161-164
9. Deutsch, P. (1995) On the mysterious leap from mind to body, New York: International Universities Press
10. Everly, G.S. & Lating, J.M. (2002). Aclinical guide to the treatment of the human strss response. New York: Kluwer Academic/Plenum
11. Jones, E., & Wessely, S. (2003). "Forward Psychiatry" in the Military: Its Origins and Effectiveness. Journal of Traumatic Stress, 16(4), 411–419.
12. Rosenfield, AH. (1985) Depression: Dispelling the despair. Psychology today; June, pp.29-34
13. Richard Blonna. Coping with stress in a changing world. 2005. 3th ed. p.141)
14. Richard A. Bryant. Acute stress disorder. What it is and how to treat it. (2016)
15. Stein, M., Miller, A.H., & Trestman, R.L. (1991). Depression, the immune system, health and illness. Arhives of General Psychiatry, 48,pp. 171-177
16. Kristy A. Fisher; Manassa Hany. Antisocial Personality disorder. May 8, 2023. Ncbi. nlm.gov/books/NBK546673,
17. Frank J. Landy., Jeffrey M. Conte. Work in 21st century. An introduction to industrial and organizational psychology. 2013
18. Industrial/organizational psychology: an applied approach. 6th edition. Michael G. Aamodt.
19. Laurie J. Mullins. Management and organizational behavior. With Gill Christy. 11th edition.
20. Gary Groth Marnat. Handbook of psychological assessment. 5th. Edition

Судалгааны цахим өгүүллүүд:

1. Black DW. The Natural History of Antisocial Personality Disorder. Can J Psychiatry. 2015 Jul;60(7):309-14. [PMC free article] [PubMed]
2. Regier DA, Kuhl EA, Kupfer DJ. The DSM-5: Classification and criteria changes. World Psychiatry. 2013 Jun;12(2):92-8. [PMC free article] [PubMed]

3. Brazil IA, van Dongen JDM, Maes JHR, Mars RB, Baskin-Sommers AR. Classification and treatment of antisocial individuals: From behavior to biocognition. Neurosci Biobehav Rev. 2018 Aug; 91:259-277. [PubMed]
4. DeLisi M, Drury AJ, Elbert MJ. The etiology of antisocial personality disorder: The differential roles of adverse childhood experiences and childhood psychopathology. Compr Psychiatry. 2019 Jul; 92:1-6. [PubMed]
5. Fragkaki I, Cima M, Verhagen M, Maciejewski DF, Boks MP, van Lier PAC, Koot HM, Branje SJT, Meeus WHJ. Oxytocin Receptor Gene (OXTR) and Deviant Peer Affiliation: A Gene-Environment Interaction in Adolescent Antisocial Behavior. J Youth Adolesc. 2019 Jan;48(1):86-101. [PubMed]
6. Lenzenweger MF, Lane MC, Loranger AW, Kessler RC. DSM-IV personality disorders in the National Comorbidity Survey Replication. Biol Psychiatry. 2007 Sep 15;62(6):553-64. [PMC free article] [PubMed]
7. Trull TJ, Jahng S, Tomko RL, Wood PK, Sher KJ. Revised NESARC personality disorder diagnoses: gender, prevalence, and comorbidity with substance dependence disorders. J Pers Disord. 2010 Aug;24(4):412-26. [PMC free article] [PubMed
8. Werner KB, Few LR, Bucholz KK. Epidemiology, Comorbidity, and Behavioral Genetics of Antisocial Personality Disorder and Psychopathy. Psychiatr Ann. 2015 Apr;45(4):195-199. [PMC free article] [PubMed]
9. Compton WM, Conway KP, Stinson FS, Colliver JD, Grant BF. Prevalence, correlates, and comorbidity of DSM-IV antisocial personality syndromes and alcohol and specific drug use disorders in the United States: results from the national epidemiologic survey on alcohol and related conditions. J Clin Psychiatry. 2005 Jun;66(6):677-85. [PubMed]
10. Moran P. The epidemiology of antisocial personality disorder. Soc Psychiatry Psychiatr Epidemiol. 1999 May;34(5):231-42. [PubMed]
11. Neumann CS, Hare RD. Psychopathic traits in a large community sample: links to violence, alcohol use, and intelligence. J Consult Clin Psychol. 2008 Oct;76(5):893-9. [PubMed]
12. Simonoff E, Elander J, Holmshaw J, Pickles A, Murray R, Rutter M. Predictors of antisocial personality. Continuities from childhood to adult life. Br J Psychiatry. 2004 Feb; 184:118-27. [PubMed]
13. Harpur TJ, Hare RD. Assessment of psychopathy as a function of age. J Abnorm Psychol. 1994 Nov;103(4):604-9. [PubMed
14. Vachon DD, Lynam DR, Widiger TA, Miller JD, McCrae RR, Costa PT. Basic traits predict the prevalence of personality disorder across the life span: the example of psychopathy. Psychol Sci. 2013 May;24(5):698-705. [PubMed]
15. Black DW, Gunter T, Loveless P, Allen J, Sieleni B. Antisocial personality disorder in incarcerated offenders: Psychiatric comorbidity and quality of life. Ann Clin Psychiatry. 2010 May;22(2):113-20. [PubMed]
16. Falcus C, Johnson D. The Violent Accounts of Men Diagnosed With Comorbid Antisocial and Borderline Personality Disorders. Int J Offender Ther Comp Criminol. 2018 Jul;62(9):2817-2830. [PubMed]
17. Instanes JT, Haavik J, Halmøy A. Personality Traits and Comorbidity in Adults with ADHD. J Atten Disord. 2016 Oct;20(10):845-54. [PubMed]
18. Frick PJ. Early Identification and Treatment of Antisocial Behavior. Pediatr Clin North Am. 2016 Oct;63(5):861-71. [PubMed]

19. Repo-Tiihonen E, Hallikainen T. [Antisocial personality disorder]. Duodecim. 2016;132(2):130-6. [PubMed]

20. Gibbon S, Duggan C, Stoffers J, Huband N, Völlm BA, Ferriter M, Lieb K. Psychological interventions for antisocial personality disorder. Cochrane Database Syst Rev. 2010 Jun 16;(6):CD007668. [PMC free article] [PubMed]

21. Goldstein RB, Dawson DA, Saha TD, Ruan WJ, Compton WM, Grant BF. Antisocial behavioral syndromes and DSM-IV alcohol use disorders: results from the National Epidemiologic Survey on Alcohol and Related Conditions. Alcohol Clin Exp Res. 2007 May;31(5):814-28. [PubMed]

22. Tackett JL, Silberschmidt AL, Krueger RF, Sponheim SR. A dimensional model of personality disorder: incorporating DSM Cluster A characteristics. J Abnorm Psychol. 2008 May;117(2):454-9. [PubMed]

23. Clark DA, Donnellan MB, Robins RW. Antisocial Traits, Negative Emotionality, and Trajectories of Relationship Quality in Mexican-Origin Couples. J Pers Disord. 2020 Aug;34(4):459-479. [PubMed]

24. Coid J, Ullrich S. Antisocial personality disorder is on a continuum with psychopathy. Compr Psychiatry. 2010 Jul-Aug;51(4):426-33. [PubMed]

25. Hare RD, Neumann CS. Psychopathy as a clinical and empirical construct. Annu Rev Clin Psychol. 2008;4:217-46. [PubMed]

26. Charland LC. Science and morals in the affective psychopathology of Philippe Pinel. Hist Psychiatry. 2010 Mar;21(81 Pt 1):38-53. [PubMed]

27. Kendler KS. Philippe Pinel and the foundations of modern psychiatric nosology. Psychol Med. 2020 Dec;50(16):2667-2672. [PubMed]

28. Crego C, Widiger TA. Cleckley's psychopaths: Revisited. J Abnorm Psychol. 2016 Jan;125(1):75-87. [PubMed]

29. Lilienfeld SO, Watts AL, Smith SF, Patrick CJ, Hare RD. Hervey Cleckley (1903-1984): Contributions to the study of psychopathy. Personal Disord. 2018 Nov;9(6):510-520. [PubMed]

30. First MB, Yousif LH, Clarke DE, Wang PS, Gogtay N, Appelbaum PS. DSM-5-TR: overview of what's new and what's changed. World Psychiatry. 2022 Jun;21(2):218-219. [PMC free article] [PubMed]

31. Hopwood CJ, Thomas KM, Markon KE, Wright AG, Krueger RF. DSM-5 personality traits and DSM-IV personality disorders. J Abnorm Psychol. 2012 May;121(2):424-32. [PMC free article] [PubMed]

32. Associations between oxytocin receptor gene (OXTR) polymorphisms, childhood trauma, and parenting behavior. 2020. Megan M. Julian,1,2 Anthony P. King,1,3 Erika L. Bocknek,4 Brody Mantha,1 Marjorie Beeghly,5 Katherine L. Rosenblum,1,2 and Maria Muzik1

33. https://www.nice.org.uk/guidance/cg77/documents/personality-disorders-antisocial scope2#:~:text=ICD%2D%2010%20uses%20the%20term,to%20ASPD%20draft%20scope%20%5BPost

34. https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC9881116/#:~:text=The%20central%20features%20of%20personality,a%20minimum%20of%20two%20years.

35. Personality Disorder Diagnoses in ICD-11: Transforming Conceptualisations and Practice Michaela A. Swales 1 Published online 2022 Dec 15. doi: 10.32872/cpe.9635

36. Obsessive-Compulsive (Anankastic) Personality Disorder in the ICD-11: A Scoping

Review. Julia Gecaite-Stonceine, Christine Lochner, Clara Marincowitz, Naomi A., Fineberg, Dan J,Stein

37. Personality disorders and normal personality dimensions in obsessive-compulsive disorder6 Published online by Cambridge University Press: 02 January 201
38. Application of the ICD-11 classification of personality disorders
39. The antisocial personalities. Lykken, David T.
40. https://www.brosix.com/blog/what-is-lateral-communication/#:~:text=Lateral%20communication%20is%20the%20sharing,level%20coworkers%20regarding%20their%20tasks.
41. https://warbletoncouncil.org/comunicacion-lateral-12926
42. https://legalinfo.mn/mn/detail/11634
43. M.Abelson and C. Winter, “The Goldman Rules,” Bloomberg Businessweek (April 25, 2011), pp. 90–91; L Lavelle, “Best Places to Launch a Career,” Bloomberg Businessweek (June 2010), downloaded June 10, 2011, from http://images. businessweek. com/ ; and L. Story and S. Chan, “Goldman Cited ’Serious’ Profit on Mortgages,” The New York Times (April 25, 2010), pp. Y1, Y25.)

БҮЛЭГ 15. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙ /ЭРҮҮ, ИРГЭН, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ/

СЭДЭВ 1. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ БА ХЭРЭГЛЭХ ОЙЛГОЛТЫН АГУУЛГА

1.1. Хуулийг хэн тайлбарлах, хэрэглэх шаардлага, эрх, хэмжээ.
1.2. Хууль тайлбарлах болон ангиллын асуудал
1.3. Хуулийг хэрэглэх ажиллагааны тухай

СЭДЭВ 2. ХУУЛЬ ТОГТООГЧИЙН ХҮСЭЛ БА ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ

2.1. Хууль тогтоогч
2.2. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах зарчим, үнэт зүйлс, үзэл санаа: Эрх зүйт ёс (rule of law), эрх зүйн зайлшгүй процесс (due process), нийгмийн зөвшилцөл
2.3. Хууль сахиулах ажиллагаа ба DUE PROCESS
2.4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба DUE PROCESS

СЭДЭВ 3. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА БА САЛБАР ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУДЫН ТУХАЙ

3.1. Онолуудын ойлголт, ангилал, төрлүүд
3.2. Эрүү, иргэн, захиргааны зарчмууд
3.3. Цаашид анхаарвал зохих асуудал

СЭДЭВ 1. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ БА ХЭРЭГЛЭХ ОЙЛГОЛТЫН АГУУЛГА

Зорилго. Энэхүү сэдвийн зорилго нь хуулийг тайлбарлан хэрэглэх, түүний ач холбогдол, хууль тайлбарлан хэрэглэхэд баримтлах зарчим, үнэт зүйлсийн талаар дэлгэрэнгүй авч үзнэ.

1.1 Хуулийг хэн тайлбарлах, хэрэглэх шаардлага, эрх, хэмжээ

Эрдэмтэн судлаачид хуулийг тайлбарлах, хэрэглэх гэдгийг бие даасан ойлголт мэтээр тайлбарлаж тус тусад нь авч үзэж бичдэг байсан бол сүүлийн үед энэ 2 харилцан хамааралтай үйл явц буюу салгаж ойлгох боломжгүй гэж ярьж, бичих чиг хандлага бий болжээ. Ямар тохиолдолд хуулийг тайлбарлах шаардлага үүсдэг, хэн түүнийг хэрэглэх эрхтэй гэдгээс хамаарч дээрх 2 үйл явцыг хэрхэн ойлгох үндэслэл бүрдэнэ. Хуулийг уншаад хүн бүр өөр өөрийн ойлголтоор утга агуулгыг нь тайлбарлах боломжтой хэдий ч хэрэглэх гэдэг нь хуулиар эрх олгогдсон этгээдэд хамааралтай байдаг. Тиймээс тайлбарласан этгээд нь хуулийг хэрэглэх эрхтэй эсэхээс энэ 2 үйл явцыг хамтад нь эсвэл тусад нь ойлгох эсэх нь шийдэгдэнэ. Хуулийг тайлбарлах үйл явц нь илт тодорхой бус хэн ч уншаад ямар ч тохиолдолд нэг янзаар ойлгох боломжгүй буюу хэд хэдэн утга, санаа, агуулга бүхий заалт, зохицуулалтыг тодорхой нөхцөл байдалд хэрхэн ойлгож болохыг тодруулж, томьёолох шаардлагаас үүсдэг. Хуулийн тохирох зүйл заалтыг үүссэн бодит үйл баримтад нийцүүлэн оновчтой хэрэглэхийн тулд тайлбарлах шаардлага зайлшгүй бий болдог.

Хуулийг тайлбарлах нь бичмэл хуулийн уламжлалтай эх газрын эрх зүйн тогтолцоотой уг орнуудын хувьд зайлшгүй үйл явц болдог.

Төр, эрх зүйн онолд “хууль хэрэглээ” гэдгийг хууль зүйн факт болон эрх зүйн тодорхой хэм хэмжээний үндсэн дээр хууль зүйн хэргийн талаар шийдвэр боловсруулах, гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх мэдлийн үйл

ажиллагаа гэж тодорхойлдог.

Эрх бүхий этгээдүүд нь тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хуулийг хэрэглэдэг.

Хууль хэрэглэхийг “хууль сахих”, “хууль ашиглах”, “хууль биелүүлэх” гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэсгүй юм. Хууль хэрэглэх нь цаг хугацааны хувьд ч эдгээр ойлголтуудаас өөр үед хэрэгждэг. Хуулийн хэрэгжүүлэх дээрх хэлбэрүүд алдаа, зөрчилтэй явагдсан нөхцөлд хуулийг хэрэглэх шаардлага үүсдэг. Хууль хэрэглэх ажиллагаа нь түүнийг сахих, ашиглах, биелүүлэх ажиллагаатай нэг эгнээнд зэрэгцэн биш харин тэдгээрийн дотор нь оршдог.

Хууль хэрэглэх ажиллагааг доорх шинжээр тодорхойлж болно:

1. Төрийн эрх мэдлийн үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлдэг;
2. Онцлог шинж тэмдэгтэй;
3. Эрх зүйн тодорхой үр дагавар үүсгэхэд чиглэгддэг (субьектив эрх, үүрэг, хариуцлага);
4. Тусгайлан тогтоосон процессын хэлбэртэй байдаг;
5. Хууль зүйн тодорхой шийдвэр гаргаснаар дуусгавар болдог.

Хууль хэрэглэх нь өөртөө үндсэн дөрвөн асуудлыг хамруулдаг:

1. Шийдвэрлэвэл зохих тодорхой тохиолдол, нөхцөлийг хууль зүйн үүднээс задлан шинжлэх;
2. Хэм хэмжээний хүчин чадлыг тодорхойлох;
3. Хэм хэмжээг тайлбарлах;
4. Хэм хэмжээг логик уялдаа холбоотойгоор хөгжүүлэх.

Хууль хэрэглээ нь хэд хэдэн үе шатаас бүрдсэн нарийн үргэлжилсэн ажиллагаа юм. Тэдгээр үе шатыг хэргийн бодит байдлыг тогтоох, хууль зүйн үүднээс дүгнэх, шийдвэр гаргах гэсэн гурван хэсэгт хуваадаг.

Хууль хэрэглээний үр дүнд тодорхой хэрэг хянан шийдвэрлэх практик тогтдог.

1.2. Хууль тайлбарлах болон ангиллын асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхийн дээд байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлохдоо “Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах”-аар тусгасан байна. Хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийн хүрээ хязгаарт багтсан ажиллагаа төдийгүй, эрх зүйн шинжлэх ухаанд чухал байр эзэлдэг суурь ухагдахууны нэг мөн. Хууль зүйн тайлбар бол эрх зүйн актыг амьдралд зөв хэрэглэх зорилгоор түүний агуулгыг тодорхойлох үйл ажиллагаа юм. Хууль тайлбарлах ажиллагаа нь аливаа хуулийн заалт буюу хэм хэмжээнд туссан эрх зүйн харилцааны зохицуулалтыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх зорилготой, эрх зүйн ухамсар, хууль хэрэглээний үндсэн зарчим, зүй тогтолд тулгуурласан, логик дүгнэлт бүхий танин мэдэхүйн ажиллагаа билээ.

Хуулийн тайлбарыг албан ёсны ба албан бус гэж ангилдаг.

Албан ёсны тайлбар нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д зааснаар Үндсэн хуулиас бусад хуулийн Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас гаргасан тогтоол хэлбэртэй байдаг. Албан ёсны тайлбарыг тодорхой бус, салаа утгатай, хоёрдмол санаа агуулсан, хэрэглэхэд хүндрэл учруулсан хуулийн зүйл, заалтыг тухайн хэм хэмжээний агуулгад багтаан, бусад хуулийн болон тухайн хуулийн бусад эс зохицуулалттай харьцуулсны үндсэн дээр гаргана. Албан ёсны

тайлбар нь тухайн хэм хэмжээнд агуулагдаагүй шинэ хэм хэмжээг тодорхойлдоггүй. Албан ёсны тайлбарын төслийг боловсруулах, батлах, тайлбарыг дагаж мөрдөх журмыг Шүүхийн тухай хуулиар зохицуулдаг.

Албан бус тайлбар нь шинжлэх ухааны, онолын, сэдэвчилсэн, дэлгэрэнгүй, үзэл баримтлалын гэх мэт хэлбэртэй байж болох бөгөөд тэдгээр нь хуулийн зохицуулалтыг зөв ойлгож, хэрэглэхэд тус дөхөм болох эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилго бүхий байна.

Хуулийн албан ёсны тайлбар нь хэм хэмжээний /норматив/ ба жишгийн /казуаль/ гэж хуваагддаг.

Хэм хэмжээний тайлбар нь эрх зүйн хэм хэмжээний адил тодорхой бус этгээдийн хүрээнд үйлчлэх бөгөөд тоогоор хязгаарлагдахгүй тохиолдлуудад хамааралтай байдаг. Энэхүү тайлбар нь эрх зүйн тухайн хэм хэмжээтэй салшгүй холбоотой бөгөөд түүнээс салангид хэрэглэгдэх боломжгүй байдаг.

Хэм хэмжээний тайлбар нь эрх зүйн хэм хэмжээг дэлгэрүүлэх, тодорхой болгох зорилготой байдаг бөгөөд энэ утгаараа өөрөө заавал даган мөрдөх, дүрмийн зохицуулалтыг агуулсан хэм хэмжээний шинжтэй байдаг. Тайлбарлаж буй эрх зүйн хэм хэмжээ хэлбэрийн хувьд боловсронгуй бус, ойлгомжгүй, тодорхойгүй хэсэгтэй бол мөн тухайн эрх зүйн актыг хэрэглэх практикийг нэг мөр, тодорхой болгох шаардлагатай тохиолдолд хэм хэмжээний тайлбарыг хэрэглэдэг.

Хэм хэмжээний тайлбар гэдгийг хуульд заасан хэм хэмжээнээс өөр шинэ хэм хэмжээ гэж ойлгох нь алдаатай гэж үзэж байна. Хуулийн тайлбар өөрөө хуулийн адил хэм хэмжээ мөн бол эрх зүйн ижил хэм хэмжээний нэгийг хэрэглэх, нөгөөхийг хэрэглэхгүй байх зарчим Үндсэн хуульд тусгагдахгүй. Хуулийн тайлбар хуульд харшилбал хуулийг хэрэглэх зарчим.

Казуаль тайлбар гэж эрх зүйн хэм хэмжээг тухайн тохиолдолд хамааралтайгаар тайлбарлахыг хэлдэг. Хэм хэмжээний тайлбар нь эрх зүйн тухайн хэм хэмжээтэй салшгүй холбоотой бөгөөд түүнээс салангид хэрэглэгдэх боломжгүй байдаг бол казуаль тайлбар тухайн тохиолдол буюу хэрэг, маргаантай салшгүй холбоотой бөгөөд нийтээр даган мөрдөх шинжийг агуулдаггүй.

Манай улсад Улсын Дээд шүүхээс гаргадаг албан ёсны тайлбар нь дээрх хоёр хэлбэрийн аль алинд нь хамаардаг гэж үзэж байна.

Жишгийн хэлбэртэй тайлбарыг шүүхийн жишиг гэж үзэхийг мөн оновчгүй гэж үзнэ. Тухайн хэргийн талаар гарсан тайлбарыг ижил төрлийн өөр хэргийг шийдвэрлэхэд шүүх судлах, танилцах. шаардлагатай гэж үзвэл дүгнэлт, шийдлийг загвар болгох боломжтой хэдий ч түүнийг заавал дагаж биелүүлэх үүрэггүйгээс гадна түүнээс өөрөөр шийдвэрлэх эрх нь хязгаарлагдаагүй, нээлттэй юм.

Хуулийн тайлбарыг ямар байгууллага, ямар хүрээ хэмжээнд, ямар асуудлаар гаргах талаар эрх зүйн онолд өөр өөр үзэл бодол байдаг. Бусад орны, ялангуяа, постсоциалист орнуудын практикийг ажиглахад засаглал хуваах онолын үндсийг анх удаа улс төр, нийгэм, эдийн засгийн үндэс суурь болгож, шүүх эрх мэдлийг засаглалын нэг салаа мөчир гэж шинээр томьёолоод удаагүй байгаа явдал багагүй маргааныг үүсгэдэг бололтой.

Гэхдээ хуулийн албан ёсны тайлбар хэм хэмжээний хэлбэртэй байсан хэдий ч хууль тогтоох ажиллагааг орлохгүй, эрх зүйн тайлбарын хэм хэмжээ нь хуульд туссан хэм хэмжээнээс ангид байхгүй гэдгийг аль ч чиглэлийн үзэл бодлыг баримтлагчид хүлээн зөвшөөрдөг байна.

Түүнчлэн манай орны эрдэмтэн судлаачдын дунд ч Улсын Дээд шүүхээс гаргадаг албан ёсны тайлбарыг зөвхөн казуаль шинжтэй байх ёстой гэж үздэг явдал бий.

Үүнд Англо-саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудын шүүхийн жишгийн эрх зүй нилээдгүй нөлөө үзүүлдэг бололтой. Монгол Улс эх газрын эрх зүйн тогтолцоотой бөгөөд тэр дотроо Ром-германы эрх зүйн чиглэлийг баримталдаг улс тул бичмэл хууль хэрэглэдгийн хувьд хууль тогтоомж бүрэн төгс төгөлдөр болоогүй, хууль тогтоох болон хууль хэрэглэх, хэрэгжүүлэх ажиллагаа боловсронгуй болж хараахан чадаагүй, эрх зүйн шинэчлэл явагдаж буй өнөө үед хуулийн албан ёсны тайлбарыг шүүхийн дээд байгууллага дээрх хоёр хэлбэрээр гаргах нь ач холбогдолтой бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзнэ.

Нөгөө талаар Англо-саксоны болон эх газрын эрх зүйн системтэй аль ч оронд хууль тогтоогч биш харин хэрэглэгч тэр дотроо шүүхийн дээд байгууллага тухайн хуулийг хэрхэн ойлгох, хэрэглэхийг тодорхойлдог нь эргэлзээгүй үнэн юм.

Эрх зүйн хэм хэмжээний доорх үндсэн шинжийг нэрлэж болно:

- хууль тогтоох байгууллагаас батлагддаг;
- тодорхой бус хүрээнд үйлчилдэг;
- заавал даган мөрдөгдөх шинжтэй байдаг;
- нэг бус удаа хэрэглэгддэг;
- биелүүлээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ авах нөхцөлтэй байдаг.

Хуулийн албан ёсны тайлбарыг шүүхийн дээд байгууллага болох Улсын дээд шүүх баталдаг бөгөөд Улсын Дээд шүүх хууль тогтоох төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч биш юм. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийн тодорхой зүйл, заалтыг хэрэглэхэд хүндрэл учрах, салаа утгаар ойлгох тохиолдолд энэ талаар гарсан Улсын Дээд шүүхийн тогтоолд тусгагдсан тайлбар хуулийн утга санааг ойлгох, хэрэглэх үндсэн бөгөөд гол эх сурвалж болно.

Харин хууль хэрэглэх ажиллагаа явуулдаг мөрдөгч, прокурор, шүүх засаглалын байгууллагуудын хувьд Улсын дээд шүүхийн тайлбар хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгоход тус дөхөм болох учиртай хэдий ч уг тайлбар хуульд харшилбал хуулийг баримтлах талаар Үндсэн хуульд заасан байдаг.

Хууль хэрэглэхийн тулд түүнийг ойлгох, ойлгохын тулд түүнийг тайлбарлах шаардлагатай болдог. Энэ утгаараа хуулийг хэрэглэгч болгон хуулийг тайлбарладаг гэж хэлж болно.

Тус улсын нутаг дэвсгэрт хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарын ач холбогдол, шүүхийн дээд байгууллагаас гаргасны хувьд шүүн таслах ажиллагаанд хууль хэрэглээний өндөр нэр хүндтэй байдгийг үгүйсгэх боломжгүй хэдий ч түүнийг эрх зүйн хэм хэмжээ тогтоосон эрх зүйн эх сурвалж гэж үзэх үндэслэлгүй юм.

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хууль тогтоомжийн боловсронгуй бус байдлыг нөхөх, хууль дахь зөрчлийг арилгах зэрэг албан ёсны тайлбарыг хууль тогтоох ажиллагаа гэж үзэхгүй.

Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар бүхий тогтоол эрх зүйн хэм хэмжээ бий болгодоггүйгээр эрх зүйн эх сурвалж биш юм. Нөгөө талаар тодорхой хэргийн талаарх Улсын Дээд шүүхийн тогтоол ижил төрлийн хэргийг шийдвэрлэхэд харгалзан үзэх жишээ болдог хэдий ч заавал даган мөрдөгдөх жишиг болгодоггүй болно.

Эрх зүйн онолд хуульд тайлбарлах нь ямар хэрэгцээ шаардлагад үндэслэгддэгийг дараах үндэслэл, шалтгаантай холбон авч үздэг. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээнүүд анхлан бүтээгдэж гарахдаа түүний зарчим, заалтууд нь ихэнхдээ хийсвэрлэн томьёологдсон буюу ерөнхий нөхцөл,

нийтлэг горимууд тогтоосон шинжтэйн дээр хууль зүйн тодорхой баталгаа, хэрэгжилтээр дамжиж байж бүрэн хангагдана.

2. Эрх зүйн хэм хэмжээ нь хууль зүйн техник, эрх зүйн соёл, сэтгэлгээг бүтээлчээр ашигласны үр дүнд бий болж үйлчлэх тул зарим талаар хуулийн текст, агуулгыг хувь хүн, иргэн субъект бүр бүрэн гүйцэд ухаж, нэгэн мөр төсөөлж ойлгох боломжгүй.
3. Хууль, хуульчилсан актууд болон олон улсын соёрхон баталсан гэрээ, хуулиуд хоорондоо бүрэн уялдаж авцалдахгүй байх, зөрчилдөх, улмаар эрх зүйн хийдлийн сөрөг, зохисгүй нөхцөл, орчин бий болсон үед тэдгээрийг зөвтгөх, даван туулах шаардлага аяндаа гардаг.
4. Эрх зүйн хэм хэмжээнд тодорхойлогдсон хууль зүйн нэр томьёо ойлголт нь тодорхой бус, зарим ойлгомжгүй заалтуудыг тодруулах, оновчтой болгох зүй ёсны шаардлага тавигддаг.
5. Хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн зөрчлийн хэрэг, тохиолдлыг хянан шийдвэрлэхэд тухайн холбогдох эрх зүйн хэм хэмжээний утга, агуулгыг тодруулах шаардлага аяндаа гардаг.
6. Эрх зүйн хэм хэмжээ нь ерөнхий, нийтлэг, хийсвэр шинж чанарыг илэрхийлдэг боловч нийгмийн харилцааны зохицуулалтын тодорхой нөхцөл байдалд хэрэгждэг г.м.

Ромын эрх зүйд “Аливаа хуулийн тайлбар нь хуулийн заалт, агуулгатайгаа яв цав нийцэж тохирч байх аваас тэрхүү хууль нь үнэнхүү хүчтэй, нэр хүндтэй байж чадна” гэсэн номлол, зарчим олон жил хэрэглэгдэж үйлчилсэн байдаг.

Ер нь хууль тайлбарлах гэдгийг эрх зүйт төрийн шаардлагад нийцүүлэн “эрх зүйг тайлбарлах” гэсэн утгаар авч үзэж, хэрэглэх хандлага байдаг. Хуулийг тайлбарлах танин мэдэхүйн эх сурвалж нь Ромын эрх зүйгээс эх үндэстэй боловч онолын үндэслэл нь позитивист болон нормативист онолын тэр тусмаа эх сурвалжийн болон чиг үүргийн онол, арга зүйтэй салшгүй холбогдож үүсэж хөгжиж ирсэн. Эхэн үедээ хуулийн ойлгомжгүй, тодорхой бус заалтыг тусад нь салган авч үзэж үгчлэн утгачилж тайлбарлах, эсхүл нэр томьёоны талаас нь дэлгэрүүлж, тодорхойлох зэргээр гол төлөв хэм хэмжээний догматик хандлагаар тайлбарлахыг оролдож байв. Харин эдүгээ кэйсийн буюу казуаль талаас нь зориулалт, чиг үүргийг хангах, хэм хэмжээнүүд хоорондын хийдлийг арилгах, тэдгээрийн уялдаа, хамаат талаас нь тодруулж, хуулийн зорилго, агуулгад нийцүүлж тайлбарлах хандлага давамгайлж байна. Ялангуяа хуулийн үг хэллэг ба утгын уялдаа холбоог хангах, хуулийн зорилгыг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэх, хууль тогтоогчийн хүсэл зориг, агуулга, үндсэн зарчмыг алдагдуулахгүй байхад их анхаарах болжээ. Эрх зүйн тайлбар нь хуулийн тайлбараас илүү аналатик түвшинд, хэрэглээний логик аргачлалаар хийгддэгээрээ ялгаатай.

1.3. Хуулийг хэрэглэх ажиллагааны тухай

Нотлох баримтаар тогтоогдсон үйл баримтад тохирсон хуулийг олж хэрэглэхийн тулд тухайн хэргийн нөхцөл байдалд нийцүүлж холбогдох хуулийн утга агуулгыг оновчтой зөв тайлбарлах хэрэгтэй. Хуулийг нэг мөр ойлгох гэдэг нь ямар ч тохиолдолд нэг янзаар ойлгож хэрэглэх гэсэн үг биш. Хууль хэрэглэх гэдэг нь шууд утгаараа хууль зүйн тодорхой асуудал (хэрэг, зөрчил, тохиолдол)-ыг хуульд нийцүүлж, шийдвэрлэхэд чиглэгдсэн үйл явц юм. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргахад чиглэсэн үйл ажиллагааны нэг хэсэг. Хуулийг хэрэглэх нь хуулиар олгогдсон эрх, үүрэг, хариуцлагыг тухайн субъект ухамсарласны үндсэн дээр хууль ёсны эрх, бүрэн эрхийн дагуу олгогдсон боломжийг ашиглаж, хууль тогтоомжийн хэм хэмжээ, нөхцөлүүдийг тухайн шийдэх ёстой тохиолдол асуудалд яв цав тохируулж, хууль

ёсны үйлдэл хийхийг хэлнэ.

Хуулийг хэрэглэх ажиллагаа бол нэг бүрчилсэн шинжтэй буюу ихэнхдээ төрийн эрх бүхий субъектээс хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрх зүйн дагуух ажиллагаа. Тодруулбал, энэ нь нэг талаас эрх зүйн зөрчлийн хэрэг маргааныг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа болдог бол нөгөө талаас хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн процесс ажиллагаа байдаг. Түүнчлэн энэ нь «хуулиар эрх олгогдсон эрх бүхий субъектээс (мөрдөгч, прокурор, шүүгч зэрэг албан тушаалтан) эрх зүйн хэм хэмжээний заалт, зарчмыг ойлгомжтойгоор тодорхойлж, тогтооход чиглэгдсэн эрх зүйн үйл явц төдийгүй эрх зүйн шийдлийг гаргахад чиглэгдсэн эрх зүйн процесс юм".

Жишээ нь: Прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд хяналт тавих, яллах дүгнэлт үйлдэж, эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож дүгнэлт хэлэх, цагаатгах, шийтгэх тогтоолд эсэргүүцэл бичих.

Илт тодорхой хуулийг буюу тайлбарлахгүйгээр хэрэглэх боломжтойгоос бусад хуулийг тодорхой үйл баримтын нөхцөл байдалд нийцүүлэн хэрэглэхэд хуулийг зайлшгүй тайлбарлах шаардлагатай. Хуулийн тайлбарын зорилго, агуулга нь хуулийг зөв хэрэглэхэд чиглэгддэг бол хуулийг хэрэглэхийн агуулга нь зөв ойлгож, тайлбарлахад оршино. Эрх зүйн зарчим, хуулийн хэм хэмжээг харьцуулан тайлбарлах нь хуулийг үндэслэлтэй зөв тайлбарлан, хэрэглэх сонгодог арга болжээ.

Өнөө үед эрх зүйн хэрэглээний арга зүй судлалд Ф.Савигнигийн дөрвөн аргын (үгчлэн утгачлах,түүхчлэн системчлэх,чиг үүрэгчлэх) онолоос гадна «Үндэслэгээний онол» (Ф.Пухта), «Цэвэр хэм хэмжээний онол» (Х.Кельзен), «Чөлөөт уян зарчмын онол» (ЭФуч, Х.Кантров), «Ашиг сонирхлын онол» (П.Хек), "Үнэт зүйлсийн онол» (П.Хек) зэрэг олон талт аргачлал, эрх зүйн баримтлал, чиг хандлага бий болж, шүүх засаглалын байгууллагуудын практикт идэвхтэй хэрэглэгдсээр байна.

1.4. Хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлага

Аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх эрсдэл бий болсон тохиолдолд тухайн харилцааг хэм хэмжээ тогтоосон эрх зүйн хэм хэмжээг хууль тогтоогчоос баталж, түүнийг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх, тайлбарлан хэрэглэх шаардлага үүсдэг. Нийгмийн харилцаа баялаг ба он цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж байгаагаас хамаарч хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлага бий болдог. Мөн зарим хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлага арилж, устдаг байна. Энэ шалтгаан нөхцөл яагаад бий болдгийг тодорхойлох хүчин зүйлүүд гэж байна. Эрх зүй өндөр хөгжсөн оронд Хууль-Үйл баримт-Хэрэглэх гэсэн дараалалтай байх ёстой гэж тодорхойлдог бол бодит байдал дээр Үйл баримт-Хэрэгцээ шаардлага-хууль гэсэн дараалалтай байгаа хуулийн шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлж чадаагүйтэй холбоотой.

Хамгийн ерөнхий нөхцөлөөр авч үзвэл, нэг талаас батлагдаж гарсан хуулиудыг шууд хэрэгжүүлэхэд эрх зүйн хийдэл бий болсноос хамаарч түүнийг даван туулах шаардлагаас урган гарна. Үүссэн үйл баримтыг нарийвчилсан зохицуулсан хууль байхгүй тохиолдолд хамаарал бүхий хуулийг нөхцөл байдалд нийцүүлэн тайлбарлан хэрэглэх болон нэмж хуульчлах. Нөгөө талаас хуулийн заалт, хэм хэмжээ нэг бүрийг нэг мөр, зөв ойлгож, хэрэглэх явдлыг хангуулах хэрэгцээ аяндаа бий болдогтой холбоотой. Хэрэв хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлагыг бодитойгоор мэдэрч, зөв үнэлэхгүйгээр тэдгээрийг харгалзан орхигдуулбал хууль зүйн төдийгүй нийгмийн ноцтой үр дагаварт хүргэдэг. Ялангуяа Үндсэн хуулиас эхлээд органик хуулиудад хуулийн зарим заалт, нэр томьёо нь нэн ойлгомжгүй буюу шууд хэрэглэх

боломжгүй тохиолдолд тухай бүр нь зайлшгүй тайлбарлах шаардлагатай. Хуулийн харилцан уялдаа холбоог хангаж ажиллахад хуулийн тайлбарыг зайлшгүй тайлбарлах хэрэгцээ, шаардлага үүснэ.

Тухайлбал, илт тодорхой заалтыг тайлбарлах шаардлагагүй. Жишээ нь “хориглоно” гэх эс үйлдэхүйг агуулсан хуулийг өөрөөр ойлгох боломжгүй тул тайлбарлах шаардлага үүсэхгүй. Учир нь тухайн хуулиар хориглосон үйлдлийг ямар ч тохиолдолд хийхгүй байхыг үүрэг болгосон утгыг шууд илэрхийлэх буюу өөрөөр ойлгох боломжгүй байна. Харин “болно” гэх үйлдэл, эс үйлдэхүйг агуулсан хуулийг ямар тохиолдолд хэрхэн ойлгож хэрэглэх вэ гэдгийг тайлбарлах шаардлагатай. Учир нь тухайн хуулиар тодорхойлсон үйлдлийг хэзээ, ямар тохиолдолд хийж болох, болохгүй нөхцөл байдлыг хуулийн үндсэн үзэл санаа, зарчим, агуулгад нийцүүлэн бусад хуультай харьцуулан логик арга зүйн талаас тайлбарлаж, хэрэглэнэ.

Хуулийг тайлбарлахад хэн, хэзээ, хэрхэн гэдэг гурван зүйлийг судлах нь чухал. Хэн гэдэгт ямар хуулийг /Үндсэн хууль болон бусад хууль/ хэн тайлбарлах ёстой вэ гэдэг асуултын хариу хамаарах болон харин хэзээ гэдэгт хууль батлагдан гарснаар тайлбарлах уу, эсхүл хуулийг хэрэглэх тохиолдолд тайлбарлах уу гэдэг асуудал буюу хууль тайлбарлах цаг хугацааны баримжааны асуудлыг хөндөнө. Дараа нь хэрхэн яаж тайлбарлах вэ гэдэгт хуулийн текст, нэр томьёоны шууд утгыг баримтлан тайлбарлах уу, эсхүл агуулга, утга санаа, хууль тогтоогчийн хүсэл зоригийг баримтлан тайлбарлах уу гэдэг асуудлыг хамааруулан ойлгоно. Эдгээр нь хуулийг тайлбарлахад зайлшгүй харгалзан үзэх буюу анхаарвал зохих суурь асуудалд тооцогдоно.

Хуулийг хэн тайлбарлах вэ гэдэг асуудал дээр дурдсан албан ба албан бус гэсэн тодорхой ойлголт юм.

Харин хуулийг хэзээ тайлбарлах вэ гэдэг харьцангуй ойлголт. Учир нь эрх бүхий албан тушаалтан нь хүчин төгөлдөр хуулийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад тайлбарладаг бол албан ёсны тайлбар нь хуулийг батлагдсаны дараа хэн хэрэглэх эсэхээс үл хамааран тайлбарладаг. Албан ёсны тайлбар гаргах хугацааг хуульчлаагүй. Тухайн хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхийн тулд хэрэгжиж эхлэхээс өмнө, эсвэл хэрэгжих явцад нь хэдийд тайлбарлах боломжтой. Хэдийгээр бусад төрийн байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад хуульд заасан шийдвэр гаргахдаа хуулийн тодорхой зүйл, заалтыг үндэслэл болгон ишлэх явдал түгээмэл байдаг боловч үүнийг хуулийг хэрэглэж буй явдал хэмээн ташаа ойлгож болохгүй. Учир нь эдгээр шийдвэрийг эс хүлээн зөвшөөрвөл сонирхогч этгээд уг шийдвэрийн талаар маргах боломжтой байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан. Нэгэнт хууль хэрэглэх гэдэг ойлголт эрх бүхий албан тушаалтантай хамааралтай тул хуулийг зөв хэрэглэх талаарх тайлбар буюу шүүхийн албан ёсны тайлбар нь гагцхүү шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдоно.

Тэгвэл хуулийг хэрхэн тайлбарлах вэ гэдэг нь онолын олон талтай ойлголтод хамаардаг. Нийгмийн олон талт харилцааг урьдчилан тааварлаж бүгдэд хуулийг тааруулж бүтээх, бүхнийг хуулиар зохицуулах боломжгүй. Англи-Америкийн эрх зүйн тогтолцоо үүнийг хүлээн зөвшөөрч, тэрхүү орон зайг Common law/ (жишиг, заншил, эрх зүйн нийтлэг зарчим)-оор нөхнө гэдэг. Үүнээс гадна нийгмийн үзэгдэл, харилцааны энэхүү олон талт байдлыг хууль тогтоогч ширхэгчлэн хэм хэмжээ болгон тогтоох бололцоогүй учраас бүрдүүлбэр бүхий нэр томьёо, үг хэллэг ашиглах,

багцлах, хамааруулах, адилтгах зэрэг олон аргыг хэрэглэж хуулийн зохицуулах чадвар, хүрээг өргөтгөдөг. Эл байдлыг хууль хэрэглэгч холбогдох байгууллагаас гаргасан дүрэм, журам, аргачлал, зааврыг тодорхой хэрэг, маргаан дээр, тогтсон арга, арга зүйд тулгуурлан тайлбарлах замаар илрүүлэх, бас хууль төгс төгөлдөр зүйл бус учраас түүний өө сэвийг дарах ажиллагаанд хууль тайлбарлан хэрэглэхийг зорилго оршдог.

Мөн Англо-саксоны Эрх зүйн бүл бүхий орны хууль зүйн Шинжлэх ухаанд шүүх /шүүгч/-ээс тогтоосон хууль буюу judge made law хэмээх ойлголт өргөн тархсан байдаг бөгөөд энэ нь хэргийг хэвшүүлэн шийдэх ёстой салшгүй холбоотой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, тухайн хэргийг шийдэхдээ өмнө нь шийдэж байсан хэргийг иш үндэс /эх сурвалж/ болгон шийддэг. Ижил төсөөтэй хэргийг өмнө нь шийдэж байгаагүй тохиолдолд уг хэргийг уг нөхцөл байдалд тохирсон жишгийг анхлан тогтоох бөгөөд энэхүү шийдвэр нь дараа дараагийн хэргийг шийдэхэд заавал баримтлах шинжтэй болдог.

Харин манай улсын хувьд хууль хэрэглэгч хууль тогтоогч биш гэдэг нь ойлгомжтой бөгөөд judge made law гэсэн ойлголт огт яригдах учиргүй. Хэдийгээр тодорхой хэргийг шийдэхдээ өмнө нь тогтсон практикийг харгалзан үзэх үзэгдэл байдаг ч үүнийг шүүхээс хууль тогтоох буюу law making by judge гэсэн хандлага руу явж байна гэж үзэж болохгүй. Учир нь уг практикийг тогтоосон шүүхийн анхны шийдвэр нь дараа дараагийн хэргийг ижил төсөөтэй шийдэх албан ёсны үндэслэл буюу ишлэл болдоггүй. Иймээс хэрэг шийдэхдээ өмнөх жишгийг харгалзан үзэж буй хандлагыг манай улсын хувьд шүүхээс тогтоосон хуультай бус, харин хууль хэрэглэгчийн дотоод итгэл үнэмшилтэй шууд холбон тайлбарлах нь зүйд нийцэх болов уу. Өөрөөр хэлбэл, уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмнө нь ижил төсөөтэй хэргийг шийдэж байсан туршлага, практикийг харгалзан үзсэн байж болно. Гэвч эрх зүйн актынхаа үндэслэлийг тайлбарлахдаа өмнө нь шийдсэн ижил төсөөтэй хэрэгтэй аль болох ойртуулах буюу таацуулах хандлагыг баримтлахгүйгээр өөрийн дотоод итгэл үнэмшлийг урьтал болгох нь зүйтэй.

Албан ёсны тайлбарын хувьд ч гэсэн нэгэнт хууль хэрэглэгч нь гагцхүү хуульд захирагдах тул ийнхүү гаргасан албан ёсны тайлбар нь аливаа шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох албан ёсны шууд үндэслэл болохгүй. Энгийнээр элбэл албан ёсны тайлбараас иш татан, эсхүл уг тайлбарыг тодорхой заалтыг үндэслэн хэрэг маргааныг шийдвэрлэдэггүй. Энэ утгаараа ч гэсэн шүүхээс албан ёсны тайлбар гаргаж буй ажиллагааг шүүхээс хууль тогтоох буюу law making by judge гэж ташаа ойлгож болохгүй.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэж заасан. Энэ нь албан ёсны тайлбар хуулийг зөрчсөн бол тайлбарыг хэрэглэхгүй гэсэн санаа бөгөөд тайлбар нь хуульд нийцэж байх ёстой гэдгийг ямарваа нэг салаа утгагүйгээр тодорхой заасан зохицуулалт юм. Товчхондоо бол Улсын Дээд Шүүх өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу хуулийг тайлбарлах эрхтэй /үүрэгтэй/ боловч ийнхүү тайлбарлахдаа шинээр хууль тогтоож болохгүй гэсэн үг.

Энэ талаар Ronald Dworkin “Хуулийн эзэнт гүрэн” /1986/ бүтээлдээ “Хуулийг тайлбарлахад тухайн тайлбар нь нэгэнт тогтсон ойлголт болон практиктай яв цав нийцэж байна уу үгүй гэдэг асуудал ач холбогдолтой биш. Харин ийнхүү тайлбарлаж буй этгээд /шүүх/ нь шинээр дүрэм, журам тогтоогоогүй гэдэгтэй итгэлтэй байж ийнхүү шинэ журам тогтоож болохгүй гэдгээ ямагт ухамсарлаж байх нь хамгийн ач холбогдолтой” гэж бичсэн байдаг.

Мөн онолын хувьд хуулийг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ, шаардлагыг объектив

(Хуулиудын тогтворгүй байдал, хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, нийгмийн эрх зүйн ухамсар, соёл төлөвшөөгүй, эрх зүйн шинэтгэлийн талаарх төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй, нийгмийн хөгжлийн түвшин дорой, улс төрийн бодлогын тогтворгүй байдал г.м) ба субьектив (хуулиудын заалт, агуулга, утгын тодорхой бус, ойлгомжгүй байдал, эрх зүйн хэм хэмжээ, зарчмууд бүрэн хуульчлагдаагүй, хууль зүйн хэллэг, нэр томьёоны ойлголт /нэг мөр/ бүрэн цэгцэрч төлөвшөөгүй, эрх бүхий этгээдүүдийн гаргаж буй эрх зүйн акт, шийдвэрийн үндэслэл оновчтой бус, тогтворгүй, хууль тогтоомж дахь эрх зүйн хийдлийн нөхцөл, хүчин зүйл багасаж арилаагүй, шүүх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааны практикийн зохисгүй, оновчтой бус байдал, хууль хэрэглэх болон хуулийг тайлбарлах ажиллагаа процессын эрх зүйн зохицуулалтгүй байх, эрх зүйн хэрэглээний соёл хангалтгүй, хууль зүйн техникийн хөгжил сул г.м) хоёр хүчин зүйлд авч үздэг хандлага байна.

Хуулийг тайлбарлан хэрэглэх нь эрх зүйн хэрэглээний хамгийн голлох хэлбэр тул мөн хууль зүйн аливаа асуудлыг шийдвэрлэхэд тухайн нөхцөл байдал, орчныг сайтар судалсны үндсэн дээр тэрхүү тайлбар шаардлагатай болсон үндэслэл, шалтгааныг тодорхойлсон байх ёстой. Юуны өмнө хуулийг тайлбарлах нийтлэг хэрэгцээ, үндэслэлийг танин мэдэж, судалсны дараа тухайн тодорхой асуудлыг үнэлж тогтоох ёстой.

Мөн хуулийг тайлбарлах өөр нэг чухал шаардлага бол хэрэг маргааны талуудад хуулийн засаглалын мөн чанарыг мэдрүүлэх, ойлгуулах, хуулийн байгууллагад итгэх итгэл, сэтгэл ханамжийг бий болгох явдал. Хууль зүйн шинжлэх ухаанд үнэний тухай асуудал яригддаггүй, харин зөвшилцөл, зүй ёс, шударга ёс гол стандарт болдог учраас туйлын үнэн зөв хэм хэмжээ гэж бас байхгүй. Тиймээс түүнийг тайлбарлан хэрэглэж гаргасан эрх зүйн актууд бас харьцангуй юм. Харин хуулийн байгууллагаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлсэн талуудын сэтгэл ханамж хамгийн гол зүйл. Үүний тулд харьцангуй бодит буюу нотлох баримтаар тогтоогдсон үйл баримтын хэмжээнд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн холбогдох хуулийг оновчтой зөв, тайлбарлан хэрэглэх хуульчийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

Хуульч хүн “энэ хэргийг ингэж шийдвэрлэхээс өөр хууль зүйн боломж байхгүй” гэсэн итгэл үнэмшлийг талуудад төрүүлэхийн тулд тухайн хууль зүйн фактад холбогдох эрх зүйн эс сурвалжийг зөв, бүрэн сонгож, тулган шалгах явцдаа фактыг бус, харин яагаад энэ хэм хэмжээг сонгож авсан, түүгээр тухайн үйл баримтад эрх зүйн дүгнэлт өгсөн үндэслэлийг нотлохдоо уг хэм хэмжээний утга, санаа, зориулалтыг хэл зүй, учир шалтгаан, түүх системлэг байдал зэргээр хөдөлгөөнгүй үндэслэн тайлбарлаж бичих учиртай. Үүний тулд хуульчид тухайн хэм хэмжээнд шууд холбогдох онол, зарчим, улс төрийн бодлого, дээд эрмэлзлийг мэдэхээс гадна түүнд холбогдох байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны болон ажил, амьдралын явцад бий болсон мэдлэг, туршлагад тулгуурлана. Нөгөө талаар хэрэг, маргааны оролцогч талуудын аль алины байр сууринаас тухайн нөхцөл байдлыг харж, мэдэрч байж бодит үйл баримтад нийцүүлэн хуулийг тайлбарлан хэрэглэх чадварыг эзэмших нь чухал.

Хууль нь ерөнхий, нарийвчилсан тодорхой зохицуулалт бага байх тусам хууль хэрэглэгчдээс онцгой чадвар шаарддаг.

Тиймээс хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн гол ур чадвар хэмжүүр нь хууль тайлбарлан хэрэглэх явдал. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий этгээдүүд нь хэрэглэх хууль нь Үндсэн хууль, бусад хуульд нийцэж буй эсэхийг хянахаас гадна тухайн хуулийн утга агуулга, үзэл баримтлалын хүрээнд, хууль зүйн ухааны тайлбар хийх арга, зарчмын дагуу, хуулийн хэллэгээр, бусдад итгэл үнэмшил төрөхүйц үндэслэл логик уялдаа холбоотой бүрэн тайлбарыг хийх үүрэгтэй. Хэргийн үйл баримт, түүний нөхцөл байдлаас хамаарч хуулийг хэд хэдэн янзаар тайлбарлан

хэрэглэж болно. Төсөөтэй хэрэг гэж байдгаас яг адилхан хэрэг гэж байдаггүй тул тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаарч хуулийг тайлбарлан хэрэглэх нь харилцан адилгүй байж болно. Гэхдээ энэ нь хуулийг гуйвуулах буюу үзэл санаа, зарчим, утга агуулгыг алдагдуулна гэсэн үг биш. Дээрх шалтгаан, нөхцөлийг ойлгож мэдэрч хуулийг тайлбарлаж, хэрэглэх чадвар эзэмшээгүй тохиолдолд хуулийн нийгэмд гүйцэтгэх үүргийг алдагдуулах үр дагавартай. Энэ нь ухаагүй хүнд зэвсэг бариулсантай адил.

Хууль хэрэглэгчийн шийдвэр дүгнэлт санал нь тухайн эрх зүйн маргаан бүхий харилцаанд оролцогч нарт хэрэглэж буй хуулиа тайлбарлан өгч буй хууль зүйн акт буюу хэрэг маргааны талаар хууль зүйн дүгнэлт бүхий шийдлийг агуулсан казуаль тайлбар болдог учир хууль ёсны ба үндэслэлтэй байх шалгууртай, таамаглалд үндэслэхийг хориглоно.

Эрх зүйн онолын бүтээлд бичсэнээр хуулийг тайлбарладаг дараах аргууд байна. Үүнд:

1. хэл зүйн (хэл бичиг, өгүүлбэр зүйн цогц дүрмийг ашиглан)
2. логик (логикийн хуулиудын тусламжтай)
3. системчлэх (тухайн салбарын болон бусад салбарын эрх зүйн хэм хэмжээг уялдуулж, эрх зүйн тогтолцоо, эх сурвалжид тулгуурлан)
4. түүхэн (хуулийн тухайн ба өмнөх хэм хэмжээний бий болсон, өөрчлөгдсөн шаардлага, зорилго, үзэл санааг түүхчлэх) зэрэг аргуудыг хэрэглэдэг.

Тайлбарлах зүйлсээр нь:

1. хууль зүйн нэр томъёог
2. хууль зүйн эрх сурвалжаар
3. чиг үүргийн хэрэгжилтийн онцлогоор
4. зорилгоор тус тус тайлбарладаг.

Зарчимд

1. хууль ёсны байх буюу эрх зүйн эх сурвалжуудын утга агуулгыг тооцох,
2. позитив эрх зүйг хүндэтгэх
3. бодитой, оновчтой, хангалттай үндэслэлтэй байх зэргийг хамааруулдаг.

СЭДЭВ 2. ХУУЛЬ ТОГТООГЧИЙН ХҮСЭЛ БА ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ

2.1. Хууль тогтоогч

Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь чухамдаа хууль тогтоогчийн хүсэл зоригийн[1] тухайд хуульд хэр зэрэг ойлгомжтой тусгагдсан эсэхээс ихээхэн хамаарна.

Хууль тогтоогч гэдэг нь Улсын Их Хурал тул түүний хүсэл зоригийг хэлнэ. Хууль тогтоогчийн хүсэл зориг нь тухайн хуулийн үзэл баримтлалд илүү тусгалаа олсон байхаас гадна хуулийг гаргах хэрэгцээ шаардлага, зорилгыг илүү тод илэрхийлсэн байна.

Энэхүү хүсэл зориг нь үзэл баримтлал, зарчим, чиг хандлагыг тусгах бөгөөд хуулийн агуулга, нөхцөлийг тодорхойлно. Хууль тогтоогчийн хүсэл зориг нь хууль тогтоох ажиллагааны явц үр дүнгээр тодорхойлогдож, хуульд тусгагдаж илэрсэн

[1] Хууль тогтоогчийн хүсэл зориг – “Воля законодателя, wills and intention of the makers- Хууль тогтоогч субьект буюу парламентын хүсэл эрмэлзлэл, байр суурь, чиг баримтлалын нийлбэр цогц”. Энэ хуулийн үзэл баримтлал, зорилго, агуулгаар дамжин илэрнэ. (Д.Б)

байна. Хууль ёсны зарчмын нэг чухал агуулга болох хуулийг нэгэн мөр ойлгох шаардлага нь хууль тогтоох ба хууль хэрэглэх үйл явцын хоорондын уялдаа хамааралтай, нэгдмэл (нэг амин сүнстэй) байх процессын агуулгыг илэрхийлнэ.

Тэгвэл хууль тогтоох хүсэл зоригийн агуулгад ямар шаардлага тавигддаг вэ? Үүнд:

1. Хууль тогтоогчийн хүсэл зориг нь ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн байх:
2. Олон улсын гэрээ, эрх зүйн түгээмэл хандлага, суурь зарчимтай уялдсан байх;
3. Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулга, хэм хэмжээг зөрчөөгүй байх;
4. Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгааг хангасан байх;
5. Нийгмийн амьдралын тодорхой, тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байх;
6. Хүний эрхийн зарчим, шаардлагад нийцсэн байх;
7. Хууль тогтоомжид тавигдах шаардлагыг тусгасан байх;
8. Хууль гаргасны дараах үр дагаврыг бүрэн тооцсон буюу эрх зүйн орчныг тогтвортой байх нөхцөлийг хангах г.м.

Дээр дурдсанаас гадна хууль тогтоогчийн хүсэл зориг хуульд тусахдаа өөрийн стандарт шаардлага, нөхцөлийг хангах учиртай ажээ. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн агуулгаас үзэхэд хууль тогтоогч нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, хуулийн төслийн хэл найруулгад тавигдах үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлж, хоёрдмол утгагүй, товч тодорхой ойлгоход хялбараар бичих, нэг нэр томьёогоор өөр өөрөөр илэрхийлэхгүй байх, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн үг хэллэг, нэр томьёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг шаардлагыг хуульчилсан билээ.

Хууль тогтоогчийн хүсэл зориг нь хуулийг хэрэглэх субъектийн үйл ажиллагааны танин мэдэхүйн чухал эх сурвалж болох ёстой. Хуулийг тайлбарлан хэрэглэх үйл ажиллагаа хууль тогтоогчийн хүсэл зоригийн буюу хуулийн агуулгаар хязгаарлагдан тодорхойлох учиртай. Учир нь хууль нь өөрөө хэм хэмжээний утга санаа, зориулалт, чиг үүргийн нарийвчилсан нөхцөлийг хатуу сахихыг шаарддаг. Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаа нь хууль зүйн үйлчлэлийг шууд хангах процесс учраас хууль ёсны бөгөөд бодитой байх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Хууль ёсны гэдэг нь угаасаа тухайн хуулийн зорилго, зарчим, хэм хэмжээг гуйвалтгүй дагаж, сахин хангах явдал юм. Бодитой байх гэдэг нь тухайн хууль үйлчлэхдээ нийгмийн зайлшгүй хэрэгцээ, цаг үеийн шаардлагыг хангаж хэрэгжинэ гэсэн үг. Хуулийг тайлбарлах, хэрэглэх ажиллагаа нь хуулийг «амьдруулж», хэрэгжүүлж буй утгаараа бол хуулийг бүтээх үйл явцын хүрээнд хамаарагдаж байгаа юм. Хууль бүтээх ажиллагаа нь бодлогын цогц асуудал бөгөөд хууль санаачлахаас эхлээд хууль бүрэн хэрэгжих хүртэлх бүх үе шатыг хамардаг байна.

2.2. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах зарчим, үнэт зүйлс, үзэл санаа: Эрх зүйт ёс (rule of law), эрх зүйн зайлшгүй процесс (due process), нийгмийн зөвшилцөл

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах[2]

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах гэдэг нь тайлбарлагчаас эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг тодруулах, нээн харуулах, ойлгох, тайлбарлан таниулах үйл ажиллагаа юм.

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний агуулга,

[2] Ч.Нямсүрэн Эрх зүйн ерөнхий онол 2010 он.

утга санааг тодруулахын тулд ашиглагдаж байгаа сэтгэн бодох арга хэрэгслийн цогц юм. Эрх зүйг тайлбарлах зарчим гэдэг нь бодит байх; тал бүрээс нь бүрэн дүүрэн тайлбарлах; хууль ёсны байх; үндэслэлтэй байх; нэгдмэл байх зэргийг хэлнэ.

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах зүйл гэдэг нь тодорхой тохиолдолд (тохироо) хэрэгжих эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтын зайлшгүй нээн харуулбал зохих учир холбогдол байна.

“Тайлбарлах” (interpretation-зуучлах гэсэн латин гаралтай үг) гэсэн нэр томьёо нь олон утга илэрхийлнэ. Хүмүүнлэгийн шинжлэх ухаанд хүн төрөлхтний соёлын объектуудыг (урлагийн бүтээлийг тайлбарлах зэрэг) танин мэдэх арга буюу янз бүрийн хэл зүйн бичвэрүүдийг (бичгийн эх сурвалжуудыг) ойлгох гэсэн агуулгатай. Эрх зүйн шинжлэх ухаанд тайлбарлах гэсэн нэр томьёо нь эрх зүйн хэм хэмжээг илэрхийлсэн бичвэрүүдийг ойлгох утгаар хэрэглэгдэнэ.

Хуульчийн мэргэжлийн ур чадвар, эрх зүйн соёлын түвшинг тодорхойлох чухал үзүүлэлт бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах чадвар мөн. Энэ байдал нь эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах арга хэлбэрийг хэрхэн эзэмшсэн, мөн тэдний онол практикийн мэдлэгийн хэмжээ хязгаар ямар байгааг харуулна. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг тодруулах, нээн харуулах үйл ажиллагаа юм. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах шаардлага нь дараах байдлуудаар тодорхойлогдоно:

1. эрх зүйн хэм хэмжээ нь ерөнхий, нийтлэг хийсвэр шинж чанарыг илэрхийлдэг боловч тодорхой харилцааг зохицуулахын тулд тодорхой нөхцөл байдалд хэрэгждэг;
2. хууль цаазын янз бүрийн асуудлуудыг шийдвэрлэхэд эрх зүйн хэм хэмжээний утга агуулгыг тодруулах шаардлага гарч ирдэг;
3. эрх зүйн хэм хэмжээг нэг мөр ойлгох, эрх зүйн харилцааны субъектүүдээс эрх зүйн хэм хэмжээг зөв хэрэгжүүлэхэд эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахын үндсэн зорилго оршдог,

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нь хууль, эрх зүйн нэгдлийг хангах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болдог.

Эрх зүйг тайлбарлах зарчим. Эрх зүйг тайлбарлахдаа, бодит байх, тал бүрээс нь бүрэн дүүрэн тайлбарлах, хууль ёсны байх, үндэслэлтэй байх, нэгдмэл байх зэрэг үндсэн зарчмуудыг удирдлага болгоно.

Бодит байх зарчим нь тайлбарлаж байгаа хэм хэмжээний агуулга нь тайлбарлагч-субъектээс эрх зүйн хэм хэмжээний актын текстэд бэхжсэн хэм хэмжээ тогтоогчийн үзэл санаа үнэн зөв, оновчтой тодруулж ойлгохыг шаардана. Энэ агуулгаар тайлбарлагч нь хэм хэмжээг шинээр тогтоож болохгүй.

Бодит ертөнцийн үзэгдлийг тал бүрээс нь бүрэн дүүрэн таних мэдэх нь гүн ухааны зарчмын хувьд тухайн үзэгдлийг зөвхөн өөрийнх нь хувьд биш (бусад үзэгдлээс салангид биш), мөн түүнтэй холбоотой бусад үзэгдлүүдтэй уялдаа холбоо, харилцан үйлчлэлд нь тайлбарлахыг шаардана. Эрх зүйг тайлбарлах хүрээнд тухайн зарчмыг хэрэглэхдээ эрх зүйн нэг хэм хэмжээ бусад хэм хэмжээтэй болон эрх зүйн бусад бодит байдалтай нягт холбоотой үйлчилдэг гэдгийг мартаж болохгүй. Энэ талаар эртний хуульч Цельс: “хуулийг бүхэлд нь авч үзэхгүйгээр хуулийн аль нэг хэсгийг үндэслэн шийдвэр гаргах, хариу өгөх нь буруу зүйл” гэж бичсэн байдаг.

Үүнээс үндэслэн эрх зүйг тайлбарлах явцад мөрдлөг болгох дараагийн журам гарч ирнэ. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахдаа эрх зүйн бүхий л тогтолцоонд тулгуурлах хэрэгтэй юм. Эрх зүйн хэм хэмжээг бусад хэм хэмжээнээс саланги байдлаар төсөөлөх нь ноцтой үр дагаварт хүргэнэ. Эрх зүйн аль ч хэм хэмжээг

Үндсэн хуулийн агуулгаар эхэлж тайлбарлана. Учир нь зүйл заалт нэг бүр Үндсэн хуулийн гол үндэслэл, зарчмын нэг ёсны үргэлжлэл (нарийвчлал, хөгжил, тодруулга, нэмэлт) байдаг. Мөн түүнчлэн үндэсний эрх зүйн нэг бүрэлдэхүүн хэсэг болсон олон улсын гэрээ, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ зарчмууд мөн үүнд хамаарна. Энэ нь үндэсний эрх зүйн зохих хэм хэмжээ нь олон улсын эрх зүйн логик үргэлжлэл, олон улсын эрх зүйн хэм хэмжээний давамгайлах шинжийг харуулах нэг үзүүлэлт болно.

Үндэслэлтэй байх зарчим нь тайлбарлагчийн (интерпретатор) хэм хэмжээг тайлбарласан дүгнэлт нь зөвхөн дотоод итгэл, зөн билгээр биш байхыг шаардана. Энэ нь эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, эрх зүйн тайлбарын олон зууны хуримтлагдсан туршлагад үндэслэнэ. Эцсийн дүнд эрх зүйн хэм хэмжээний ямар нэгэн эргэцүүллийн үнэн зөв байх, эсхүл буруу байх нь түүнийг практикт хэрэглэх явцад батлагдах, эсхүл няцаагдана. Үүнээс үзэхэд танин мэдэхүйн үнэн зөвийн шалгуур нь практик мөн. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах явцад олж авсан мэдлэг нь зөвхөн байж болох магадал бүхий мэдлэг байна. Ийм учраас тайлбарлагдсан хэм хэмжээ бүр үнэн зөв тайлбарлагдсан гэсэн баталгаа байхгүй. Харин үнэн зөв тайлбарлахад эрмэлзэх шаардлагатай. Өмгөөлөгч хүн шүүх хуралдаан дээр тухайн хэм хэмжээг тайлбарлах үед олон хуульчдын мэтгэлцээн дунд үнэн зөв тайлбар гарч ирэхийг үгүйсгэх аргагүй. Тайлбарлах явцад тайлбарын үнэн зөвд дөхөж очих зэрэглэл нь эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тухай онол, тайлбарлах аргын боловсронгуй байдал, түүнийг практикт хэрэглэх чадвараас ихээхэн хамаарна.

Хууль ёсны зарчим нь дараах шаардлагуудаас бүрдэнэ. Хууль ёсны байх гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний тайлбар, ялангуяа норматив тайлбарт нь тайлбарлагдаж буй хэм хэмжээний жинхэнэ утга санаа алдагдаагүй, эрх зүйн шинэ хэм хэмжээ тогтоогдоогүй үед л хүлээн зөвшөөрөгдөнө. Мөн түүнчлэн хууль ёсны байх зарчим нь хууль тайлбарлах үйл ажиллагааг журамласан процедур, түүнийг тогтоосон бүхий л хэм хэмжээг сахихыг шаардана. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хэм хэмжээг хуульд заасан үндэслэл журмын дагуу, хуулиар зөвшөөрөгдсөн субъект, өөрийн бүрэн эрх болон эрх хэмжээний хүрээнд, хуульд заасан хүчин чадлаар тайлбарлана. Жишээ нь, Үндсэн хуулиас бусад хуулийг зөвхөн Улсын Дээд шүүх тайлбарлана. Харин хууль хэрэглэх явцад өгсөн онолын болон энгийн тайлбарыг хэрэг маргаан шийдвэрлэх явцад хэн ч өгч болно.

2.3. Хууль сахиулах ажиллагаа ба DUE PROCESS

“Due process” нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулаагүй, оролцогчийн эрхийг эдлүүлээгүй бол тухайн нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм. Үүнийг зарим судлаач зохистой процесс, зарим нь процесс эрхийн баталгаа мэтээр орчуулан тайлбарлаж байна.

Манай улсын хувьд шүүх хуралдаанаас өмнө мөрдөн шалгах ажиллагаагаар гэмт хэрэг гарсан байдлыг сэргээн дүрслэх нотлох баримтуудыг цуглуулж, бэхжүүлдэг онцлогтой бөгөөд мөрдөгчид тулгуурласан нотолгооны уламжлалтай билээ. Мөрдөн шалгах ажиллагааны үед мөрдөгч оролцогчийн эрхийг бодитойгоор хангасан, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулсан эсэхээс хэргийн бодит байдал салшгүй холбогдоно. Үүнд прокурор хуулийн дагуу хяналт тавих үүрэгтэй.

2.4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба DUE PROCESS

Шүүхийн үйл ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд зааснаар хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоож, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргахад чиглэгдэнэ.

Хэрэг, маргааны талаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн оновчтой, зөв тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдах, гарч буй дүгнэлт, шийдвэр, саналууд хууль ёсны байх шаардлага хангагдана.

Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хууль, Монгол Улсын соёрхон баталж, нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглэхээс гадна Үндсэн хуульд харшлахгүй бол олон улсын нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээг (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй) төсөөтэй хэрэглэж болно.

Хэрэг маргааныг шийдвэрлэж буй шүүх Үндсэн хуулиас бусад хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг хуулийн зүйл, заалтыг оновчтой зөв тайлбарлан хэрэглэхэд ашиглах ба харин тэрхүү тайлбарыг хэрэг, маргааны талаар шийдвэр гаргах үндэслэл болгож баримтлахгүй.

Хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, хэрэгт авагдсан ба шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шүүхээр судлан шинжлэгдсэн нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангана.

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлагад Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим» хамаарна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтууд нь хуульд заасан журмын бэхжигдэж, гэрчлэгдсэн байхаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр тухайн хавтаст хэрэгт авагдсан байна.

Шүүх тогтоол гаргахдаа шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурласан, тэдгээрийг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжилсний үндсэн дээр эрх зүйн дүгнэлт хийсэн, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, хэргийн зүйлчлэлийг зөв тогтоосон, шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон бол гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэм бурууги хэр хэмжээ, ялыг хүндрүүлэх буюу хөнгөрүүлэх бүх нөхцөл байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд хуульд заасан тохирсон ялыг оногдуулсан байх ёстой.

Харин эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.

Шүүгдэгчийн гэм буруутайд тооцох хөдөлбөргүй нотлох баримт байхгүй тохиолдолд таамаглалд үндэслэсэн хэргийг шийдвэрлэж болохгүй бөгөөд шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгана. Энэхүү зарчим алдагдвал прокурор эсэргүүцэл бичиж, дараагийн шатны шүүхээр шийдвэрийн алдааг засуулах эрхтэй.

СЭДЭВ 3. ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Зорилго. Энэхүү сэдвийн зорилго нь Хууль тайлбарлах онолын чиг хандлага, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргын төрлүүд, онцлог, давуу болон сул талын талаарх мэдлэгийг тэлэх зорилготой билээ.

3.1. Онолуудын ойлголт, ангилал, төрлүүд

Эрх зүйн хэрэглээний сонгодог арга зүйн онол. Ф.Савигни (1779-1861)

Эрх зүйн хэм хэмжээнд дөрвөн аргачлалаар тайлбар хийх тухай энэхүү онол нь дүрмийн, логикийн, түүхэн, системт гэсэн аргыг бүтээлчээр зохистой хэрэглэх нөхцөл, зарчмын тухай номлодог. Хуулийн хэм хэмжээг үгийн утга, зорилгын агуулгаар тайлбарлахаас гадна логик элементийн үүднээс уялдаа, холбоо, зүй тогтолт шинжээр ойлгож хэрэглэнэ. Түүнчлэн хууль гаргах түүхэн нөхцөл, шалтгааныг тухайн цаг үеийн шаардлагатай уялдуулж түүхчлэн тайлбарлах ёстой ажээ. Системт хандлагаар бол юуны өмнө тухайн хуулийн зорилгыг түүний дотоод мөн чанартай холбон хуулийн тулгуур суурийг нь гарган ирж, тэр нь тодорхой үед тэрхүү хүрээ хязгаарт тайлбарлах боломжийн тухай өгүүлдэг[3].

Эрх зүйн аргументын онол. Р.Алекс

Эрх зүйн хэм хэмжээний тайлбарт утга зүйн, генетикийн, харьцуулсан, зорилгод чиглэсэн арга зүйг илүү боловсруулахын хамт эмпирик, анализ, норматив үндэслэлийг удирдлага болгон хөгжүүлснээс гадна эрх зүйн үндэслэгээний шалгуурыг гол болгон “аналитик ба норматив хандлагыг чухалчлах[4]” тухайд авч үздэг.

Цэвэр хэм хэмжээний буюу норматив позитивист онол. Х.Кельзен (1881-1973)

Энэ нь хуулийн заалтыг тухайн үг, өгүүлэмжийн утгаар ягштал баримталж шууд ойлгож хэрэглэх тухай бөгөөд хуульд заагдаагүй ойлголтыг хуулийг давж, хуулиас гадуур тайлбарлахыг үгүйсгэдэг. Энэ нь зарим үед “шударга бус хуулийг сохроор дагах” сөрөг үр дагаварт хүргэж байсныг түүхэн эх сурвалж өгүүлдэг. Гэхдээ зарим санааг нь авч хэрэглэх нөхцөлийг үгүйсгэж болохгүй[5].

Нэр томьёоны буюу абстракт тайлбарын онол. Ф.Пухта (1798-1846), B.Windscheild (1817-1892)

Эрх зүйн нэр томьёо, ухагдахууныг тухайлан салган авч үзэж, ойлголтын утгыг дэлгэрүүлж, тодорхойлох, угсруулан холбох, хэрэглэх нөхцөлийг нь томьёолох замаар тайлбарлахад чиглэгдэнэ. Энэ онол хуулийн агуулга, зорилго, зарчмын уялдааг харгалздаггүй, хэт догматик гэсэн үндэслэлээр шүүмжлэлд өртөж, хэрэглээ нь хязгаарлагдаж ирсэн юм.

Ашиг сонирхлын онол. Р.Неск (1858-1943)

Эрх зүйн хэм хэмжээний зорилго, агуулгад аль нэг ашиг сонирхол тусгагдсан байдгийг үндэслэл болгон нийтийн болон хувийн ашиг сонирхлын ямар хандлага хуульчлагдсан эсэхийг илүү анхаарч тайлбарлах явдал юм. Энэ онол эрүүгийн эрх зүйд төдийлөн идэвхтэй хэрэглэгддэггүй боловч Эрүүгийн хуулийг хэрэглэх хүрээнд эрүүгийн шүүхээс гаргах шийдвэрийн агуулгыг тодорхойлоход зарим үед хэрэглэгдэж болно.

Шатлалын буюу эх сурвалжийн онол (Х.Кельзен)

Энэ нь позитивист онолын нэг бүрэлдэхүүн хэсэг боловч эх сурвалжийн онолын баримтлал нь нэг талаас эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний утга, агуулгыг эрх зүйн

---

[3] Адоймэйт, Хэньшэн. Эрх зүйн онол (монгол орчуулга: Г.Дөлгөөн, Ж.Энхбүрд)-УБ.,2017. 59-62 дахь тал

[4] Т.Саруул. Эрх зүй хэрэглэх арга зүй -УБ.,2014.12-14 дахь тал

[5] Ханс Кэльзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол (монгол орчуулга: М.Хатанбаатар)-УБ.,2013.221 дэх тал

олон талт эх сурвалжуудын хэм хэмжээний уялдаа холбоо, хэрэглээний шатлал, хамааралт шинжээр нь авч үзэж тайлбарладаг. Эрүүгийн эрх зүйд хамаарал бүхий олон зэрэгцсэн хууль, хууль тогтоомж, олон улсын гэрээ нэгэн зэрэг үйлчлэх болсон өнөө үед эх сурвалжийн онолын хэрэглээ өргөжин нэмэгдсээр байна.

Дээр дурдсан суурь онолуудаас гадна хууль тогтоогчийн хүсэл зоригийг эцсийн хэмжүүр болгох субьектив онолын зэрэгцээ хуулийн хүсэл зориг, агуулгыг байгаа бодит байдлаар нь шалгуур болгодог объектив онолыг энд мөн дурдаж болно. Түүнчлэн “Чөлөөт эрх зүйн онол” гэж нэрлэгдсэн хуулийн зорилго, агуулгыг өргөжүүлж, түүнд захирагдахгүйгээр шүүгчийн дотоод итгэл, үзэмжээр тайлбарлах боломжийг зөвшөөрч, номлосон зарим үзэл баримтлалыг энд дурдаж болно.

3.2. Эрүү, Иргэн, Захиргааны эрх зүйн зарчмууд

Нийгмийн амьдралын эрх зүйн бодит байдлыг хангаж, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмжийг эрх зүйн зарчим гэнэ. Эрх зүйн зарчим нь түүний зорилго, агуулгыг амьдралд хэрэгжүүлэхэд идэвхтэй нөлөөлдөг хөшүүрэг юм. Энэ нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг тусгаж, төрт ёсны бодит шаардлагад нийцсэн байна. Эрх зүйн зарчим нь хууль зүйн нөлөөлөл бүхий үзэл баримтлал төдийгүй эрх зүйн ухамсар, ёс суртахууны чиглүүлэгч хэм хэмжээнүүдээс бүрдэнэ. Эрх зүйн зарчмын тусламжтайгаар аливаа субъект үйл ажиллагаандаа баримтлах тодорхой чиглэлтэй болдог.

Эрх зүйн зарчмыг эрх зүйн тогтолт шинжээр нь:

1. Хууль ёсны зарчим /Олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан хуульчлагдан тодорхойлогдсон зарчмуудыг хэлнэ/
2. Жам ёсны зарчим /Төрөлхийн эрхийн мөн чанараар нөхцөлдсөн, хүний язгуур эрх ашгийг тусгасан, хуульчлагдаагүй боловч төрөөс хамгаалагдсан зайлшгүй шинжтэй зарчим/ гэж 2 ангилна. Эдгээр зарчмууд нь хоорондоо харилцан нөхцөлдөж уялдан холбогдсон байдаг. Иймд эрх зүйн нэгэн нэгдмэл хүрээнд багтааж уг зарчмуудыг нийтлэг түвшинд авч үзэх нь зүйтэй юм.

Үндсэн зарчим /Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2/

- Ардчилсан ёс,

(Ард түмний тусгаар тогтнол, бүхэн эрхт байдлыг хангаж, төрийн бүхий л үйл хэрэгт иргэдийг аль болох өргөнөөр татан оролцуулах, үндэстэн ард түмний эрх чөлөө, тэгш эрхийн нэгдмэл илэрхийлэл. Ардчилал нь хууль ёстой холбоотой.)

- Шударга ёс,

(Хүн, нийгмийн харилцаанд үнэн, бодитой, зохистой хандах зүй ёсны шаардлагатай. Шударга ёс нь хүний амин хувийн ашиг, сонирхлыг бусдын буюу нийгмийнхтэй нь зөв тэнцвэртэйгээр уялдуулах, нийтлэг голч чиг шугамд үндэслэгдсэн эрх зүйн зарчим.)

- Эрх чөлөө,

(Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон Улсын гэрээ, конвенц зэрэгт заасан эрх, эрх чөлөөг хангах, зөрчихгүй байх)

- Тэгш байдал,

(Хүний гарал, үүсэл, нас, хүйс, арьс, өнгө, нийгмийн байдал, мэдлэг, боловсрол, албан тушаал зэргээр ялгаварлахгүйгээр хууль, шүүхийн өмнө адил тэгш эрх, үүрэгтэй оролцох боломжийг хангах явдал. Тэгш эрх нь шударга ёс, хууль дээдлэх зарчимтай салшгүй холбоотой.)

- Үндэсний эв нэгдлийг хангах,

(Улс орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, нийтийн ашиг сонирхлыг дээдлэх)

- Хууль дээдлэх

(Хуулийн нэр хүндийг эрхэмлэн хүндэтгэж, сахих, эрх зүйн зохицуулалтад хууль тэргүүлэх үүрэгтэй байх, төр, иргэн байгууллага алин боловч, хуулийг нэг мөр дагаж биелүүлэх, түүний өмнө адил тэгш хариуцлага хүлээх, хуульчилсан болон эрх зүйн аливаа акт шийдвэрүүд нь хуульд нийцсэн байх зэрэг шаардлагыг хангах эрх зүйн зарчим.)

Эрүүгийн эрх зүйн зарчмууд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.37 дугаар зүйлд яллах тал гэж прокурорыг хэлнэ гэж заасан ба прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн хэрэгжилтэд хяналт тавин оролцогдог тул дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох нь ач холбогдолтой.

Хуульд үндэслэгдэх, хууль ёсны зарчим;

(Гэмт хэргийн эсрэг явуулах эрүүгийн эрх зүйн тэмцэлд хууль ёсны зарчим шийдвэрлэх ач холбогдолтой. Нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд ял оногдуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан төрөлжсөн Эрүүгийн хуулиар тогтоох шаардлагыг хангахад энэ зарчим чиглэгдэнэ.)

Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим;

(Эрүүгийн хуулийн энэ зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хувьд хэрэгжүүлэх эрх зүйн үндэс юм. Хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал бол түүний амьдралаас салж боломжгүй заяагдмал зүйл мөн бөгөөд хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш байна гэдэг нь хууль тогтоогчийн болон хууль хэрэглэгчийн зүгээс хүн бүрт эрх, үүрэг, хариуцлага гурвыг ямар нэг ялгаваргүй тогтоох, хэрэгжүүлэх явдлаар илэрнэ.)

Шударга ёсны зарчим;

(Энэ зарчим нь эрүүгийн хуулийн шударга байдал, шүүгдэгчид оногдуулж буй ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ оновчтой шударга байхыг бодит илэрхийлэл юм. Эрүүгийн хуульд хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулахуйц аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцсон, хэм хэмжээ нь нийгэм, эдийн засаг, эрх зүйн хувьд хангалттай үндэслэлтэй, нийгмийн шударга ёсны шаардлагад бүрэн нийцсэн байвал сая шударга сайн хууль болно.)

Гэм буруугийн зарчим;

(Нийгэмд аюултай үйлдэл (эс үйлдэхүй), нийгэмд аюултай, хор уршигт үйл ажиллагаа явуулсан, гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн эрх зүйн зарчим. Энэ учраас эрүүгийн эрх зүйд гэм “гэм буруугийн зарчим” хэмээн нэрлэдэг.)

Хүнлэг, энэрэнгүй ёсны зарчим;

(Уг зарчим нь нэг талаас, нийгмийн гишүүдийн аюулгүй байдлыг гэмт хадлагаас хамгаалах зорилтын хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болон энэ тухайд сэжиглэгдэн яллагдаж мөн шүүгдэж байгаа хүний эрхийг хангах гэсэн хоёр агуулгыг нэгэн зэрэг илэрхийлж байдаг өвөрмөц онцлогтой. Хүний тэр тусмаа гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдийн нэр төр,

алдар хүндийг эрүүгийн хуулиар хамгаалах агуулгыг энэ зарчим шууд илэрхийлнэ.)

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим;

(Энэ зарчим нь гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших явдал гаргуулахгүй байх, гэмт хэрэг үйлдсэн этгээд эрт, орой хэзээ нэг цагт түүнийхээ төлөө хариуцлага хүлээж байх бүх нөхцөлийг бүрдүүлэхэд үйлчилнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүр заавал хариуцлага хүлээдэг байх нь Эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн ач холбогдлыг илэрхийлэх гол арга болдог. Хариуцлага гарцаагүй байх зарчим бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлж, хүмүүжүүлэхээс гадна бусад хүмүүс гэмт хэрэг үйлдвэл заавал ийм хариуцлага хүлээнэ гэсэн санамж өгөх ач холбогдолтой. Эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэдэг байх нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын тод илрэл юм.)

Гэм буруутай этгээд өөрөө хариуцлага хүлээх зарчим;

(Энэ зарчим нь хүн бүрийн хувийн эрх, эрх чөлөөний баталгаа юм. Ардчилсан эрх зүйн үйлчилгээнд дан ганц субьектив эсхүл объектив ялгаа гэж байдаггүй тул гэмт хэрэг үйлдсэн нь түүний объектив болон субьектив бүх шинжүүдийн нийлбэрээр шийдвэрлэгддэг учраас гэмт хэрэг үйлдсэн этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчимтай. Эрүүгийн хуулийн энэ зарчим нь нэг этгээдийн бурууг нөгөөд нь хариуцуулдаггүй гэсэн тодорхой агуулгыг илэрхийлнэ.)

Эргэлзээтэй үед яллагдагчийн талд ашигтайгаар шийдвэрлэх зарчим;

(Эрүүгийн хариуцлагыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хэрэглэдэг төрийн албадлагын арга хэмжээ гэж тодорхойлсноос харахад гэм буруутай байх нь гэмт хэргийн заавал байх шинж юм. Харин гэм буруутай эсэх нь эргэлзээтэй тохиолдолд яллагдагчийн талд ашигтайгаар шийдвэрлэх нь хүний эрхийг зөрчихгүй байх нэг үндэс болно.)

Эрүүгийн хууль цаг хугацаа, нутаг дэвсгэрт үйлчлэх зарчим

(Нутаг дэвсгэрт үйлчлэх зарчмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчилнэ. Энэ зарчмыг хэрэглэхэд гэмт хэрэг үйлдсэн газар чухал ач холбогдолтой. Хэрэв гэмт хэргийг хэд хэдэн улсын нутаг дэвсгэр дамжин үйлдсэн бол гэмт хэрэг үйлдэгдэж төгссөн буюу таслан зогсоогдсон улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс үйлчлэх цаг хугацаа хүчингүй болох хүртэлх үеийг эрүүгийн хуулийн гэсэн ойлголтоор илэрхийлэх бөгөөд нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэдэг.)

Иргэний эрх зүйн зарчмууд

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж зааснаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхэд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцох эрх зүйн үндэслэлтэй тул дараах зарчмуудыг мэдэх шаардлагатай.

Тэгш байдлыг зарчим

(Энэхүү зарчим нь иргэний эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын аргыг тодорхойлох гол зарчим болдог. Уг зарчимтай иргэний эрх зүйн бусад зарчмуудыг

холбон тайлбарлахаас гадна бусад зарчмууд ч энэхүү зарчмыг хэрэгжихэд туслах гол хөшүүрэг болдог. Тэгш байдлын зарчим иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдод эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн хувьд адил, тэгш нөхцөл, боломж олгодог. Тодруулбал, иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломж хүн бүрт тэгш олгогдсон байхаас гадна хүлээх үүрэг, үүрэг зөрчсөнөөс болон бусдын эрхийг зөрчсөнөөс үүсэх үр дагавар адил байна. Өөрөөр хэлбэл, тухайн субъектийн хувийн болон нийгмийн байдал нь түүний эдлэх эрх, хүлээх үүрэгт нөлөөлөхгүй юм. Түүнчлэн, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын аль нэг нь нөгөөгөөсөө давуу эрхтэй байж болохгүй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн аль нь ч бие биеэсээ давуу болон сул, илүү эсхүл дутуу эрхтэй байх ёсгүй.)

Бие даасан байдлын зарчим

(Уг зарчим нь гэрээний эрх чөлөөний болон хувийн хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчимтай нягт холбогддог. Энэ зарчмын хүрээнд оролцогч нь биеэ даасан эрх зүйн этгээд учраас өөрийн хүсэл зоригт үндэслэн иргэний эрх зүйн харилцаанд оролцоно. Чөлөөт иргэний нийгмийн гишүүн бол хуульд заасан, эсхүл заагаагүй боловч хуулиар хориглоогүй эрх, үүргийг өөрийн санаачилгаар, сайн дураараа хэрэгжүүлэх эрхтэй. Энэ зарчим иргэний эрх, үүргийг ямар нэг хөндлөнгийн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх агуулгыг давхар илэрхийлдэг.)

Өмчийн халдашгүй байдлын зарчим

(Иргэний эрх зүйн үндсэн зарчмын нэг бөгөөд өмчлөх эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь иргэний эрх зүйн бараг бүх зохицуулалтын бодитой хэрэгжих суурь нөхцөл болдог. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар манай улсад нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалдаг. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг хуульд зааснаас бусдаар хязгаарлаж үл болно”, арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэх зэргээр заасан нь иргэний өмчлөх эрхийн баталгааг Үндсэн хуулийн түвшинд хамгаалж буй хэрэг юм. Ийнхүү өмчлөх эрхийг баталгаажуулахдаа “хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглох” зохицуулалтыг мөн тусгаж өгсөн. Тухайлбал, “төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж зааснаар өмчийн халдашгүй байдлын суурийг тавьсан юм. Өөрөөр хэлбэл, өмчлөх эрхийг хязгаарлах тохиолдлыг зөвхөн хуульчлан тогтоох бөгөөд гэмт хэргийн улмаас олж авсан эд хөрөнгө, эсхүл эрүүгийн ял шийтгэлийн хүрээнд эд хөрөнгийг хураах, улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийн үүднээс хувийн өмчийг нийгэмчлэхээс бусдаар хуульд заагаагүй тохиолдолд төрийн зүгээс иргэний өмчид халдаж болохгүй. Өмчийн халдашгүй байдлыг хүлээн зөвшөөрдөг улс оронд хувийн өмчийг нийгэмчлэх тохиолдолд тухайн өмчлөлийн зүйлийн зохих үнийг төлөх буюу өмчлөгчийн эд хөрөнгөд учруулсан хохирлыг мөнгөн болон бусад материаллаг хэлбэрээр нөхөн төлөх журмыг хуульчлан баталгаажуулдаг. Өмчлөгчид эд хөрөнгө өмчилж байгаатай нь холбогдуулан хуулиар тогтоосон татвар болон нийтийн үйлчилгээний төлбөр төлөх зэрэг үүргийг хуулиар хүлээлгэж болох боловч энэ нь зөвхөн зохицуулалтын шинжтэй үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн, энэхүү зарчмын хүрээнд өмчлөгч өөрийн хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй. Уг агуулга Иргэний хуулийн 101.1 дэх хэсэгт “өмчлөгч хөрөнгөө өөрийн үзэмжээр, чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэж туссан байдаг. Өөрөөр хэлбэл, өмчлөгчийн туйлын эрхийг энэ зохицуулалтаар

тодорхойлсон байна. Харин дээр дурдсан өмчийн халдашгүй байдлын зарчим бүрэн хэмжээгээр хамгаалагдах механизм манай улсад байгаа эсэхэд судлаачид үзэл бодлоо илэрхийлсэн байдаг. Жишээлбэл, хот төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг барилгажуулах зорилгоор газрыг төрөөс үнэлэн авахдаа зах зээлийн бодит үнэ бус, харин хэлбэрийн төдий үнэлж байгаа нь шударга нөхөн олговор биш иргэдийн өмчлөх эрхэд халдаж буй явдал гэж үзсэн.)

Гэрээний эрх чөлөөний зарчим

(Энэхүү зарчмын хүрээнд оролцогч нь гэрээний төрөл, агуулга, гэрээ байгуулах эсэхээ хэнээс ч, түүний дотор төрийн байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар сонгох эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л агуулгаар гэрээ байгуулах эрх чөлөөтэй.

Нөгөө талаас, бусадтай гэрээ заавал байгуулах, эсхүл гэрээндээ тодорхой нөхцөлийг заавал тусгах, тусгахгүй байх зэрэг үүргийг гэрээний сул талыг хамгаалах зорилгоор хуулиар тогтоосон байдаг. Ийнхүү хуулиар тогтоосон шаардлага нь ихэвчлэн нийтийн эрх ашиг, түүний дотор аж ахуй эрхлэгч бус, энгийн иргэдийн эрхийг хамгаалах зорилготой.

Мөн Иргэний хуулийн 202.1 дэх хэсэгт “Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байна.” гэж заасан. Энэхүү заалт нь аж ахуй эрхлэгч өөрийн эдийн засгийн болон мэдлэг, мэдээллийн давуу байдлаа ашиглан нөгөө талдаа шударга бус санал гаргах, хэрэглэгчдэд илт хохиролтой нөхцөл тулгахыг хориглосон агуулгатай юм. Жишээлбэл, цахилгаан, ус, дулаан түгээх үйлчилгээ эрхэлдэг компаниуд өөрт нь хандсан бүхий л этгээдтэй гэрээ байгуулах ёстой бөгөөд агуулгыг ч мөн адил хуулиар тогтоосон шалгуур, хязгаарлалтад нийцүүлэх учиртай.

Энэ нь нэг талаас аж ахуй эрхлэгчийн гэрээ байгуулах эсэх, гэрээний агуулгыг чөлөөтэй тодорхойлох эрх чөлөөг хязгаарлаж байгаа мэт харагдах боловч “хүнлэг, иргэний нийгэм”-ийн тогтолцоонд хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн хамгаалалтын зохицуулалт юм. Үүнтэй холбоотойгоор онолын ахисан төвшинд “стандарт нөхцөл бүхий гэрээ”, “хэрэглэгчийн гэрээ” зэргийг ялган заагласан байдаг. Манай Иргэний хуульд ийнхүү нэр томьёоны хувьд ялган зааглаагүй ч стандарт нөхцөл бүхий гэрээг аж ахуй эрхэлдэггүй иргэнтэй байгуулахад тавигдах ерөнхий хязгаарлалтуудыг тодорхойлж өгсөн байдаг. Тодруулбал, Иргэний хуулийн 202.2 дахь хэсэгт заасан хориглосон нөхцөлүүдийг аж ахуй эрхлэгч хэрэглэгчтэй байгуулсан гэрээндээ тусгавал уг заалт хүчин төгөлдөр бус болно. Иймд энгийн иргэдтэй байгуулж буй стандарт нөхцөл бүхий гэрээний хязгаарлалттай холбоотой заалтыг зөв тайлбарлан хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Энэ нь манай улсад гэрээний эрх зүйн хүрээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалт огт байхгүй гэсэн үг биш, харин уг заалтыг эдийн засгийн шинжилгээ болон зүй ёсны зарчмын харилцан тэнцвэрийг хангах ойлголтын үндсэн дээр зөв тайлбарлан хэрэглэх, шүүхийн практикт хэвшүүлэн, үүнтэй холбоотой гаргасан академик тайлбарыг үндэслэн Иргэний хуульд эсхүл тусгай хуулиар холбогдох зохицуулалтыг дэлгэрүүлэн хуульчлах нь зүйтэй юм.)

Хувийн хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчим

(Уг зарчим иргэний эрх зүйн зохицуулалтын суурь болдог. Хувийн хэрэг гэдэг ойлголт өдөр тутмын ахуйн шинжтэй гэрээ хэлцэл, түүнчлэн аж ахуй эрхлэгчийн гэрээний харилцаа, өмчлөх эрх, оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнг ашиглах зэрэг бүхий 7 төрлийн харилцаанд хамааралтай хэрэглэгддэг. Энэхүү зарчмын

хүрээнд иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь уг харилцаанд зөвхөн өөрийн хүсэл зоригт үндэслэн оролцох эрхтэй юм. Хувийн хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг зөвхөн хууль батлах замаар л хязгаарлаж болох бөгөөд бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох шинжтэй шийдвэрийг аливаа этгээдийн зүгээс гаргасан тохиолдолд тухайн шийдвэр хуулийн хүчин чадалгүй болно. Иргэний хуулийн 1.2 дахь хэсэгт заасан хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим нь “эрх, үүргийг аливаа хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх”, “гэрээний эрх чөлөө” зэрэг зарчмуудтай нягт холбоотой тайлбарлагддаг. Энэхүү зарчим нь хуулийн заалтуудад тодорхой илрэлээ олж, бэхэжсэн байдаг бөгөөд агуулгыг бусад зарчмуудтай холбон тайлбарлах шаардлагатай. Иргэний хуулийн 13.2 дахь хэсэгт хувь хүн өөрийн эрх, үүргээ өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр хэрэгжүүлэх талаар заасан нь хувь хүний эрх чөлөөний гол илрэл болно.)

Зөрчигдсөн эрхийг шүүхээр хамгаалуулах зарчим

(Аливаа этгээд өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр эрхээ хэрэгжүүлэх бөгөөд бусад этгээдийн зүгээс эрхийг нь зөрчсөн тохиолдолд шүүхээр хамгаалагдах боломжгүй байвал иргэний эрх зүйн бусад зарчим буюу тухайлбал, бие даасан, чөлөөт, өмчийн халдашгүй байдлын зэрэг зарчмууд нь хоосон зүйл болж хувирна. Уг зарчим нь итгэлцлийг хамгаалах зарчимтай нягт холбогдон хэрэглэгддэг. Эрх нь зөрчигдсөн этгээд эрхээ өөрөө, эсхүл албан ёсны бус аргаар хамгаалаад эхэлбэл нийгэмд эмх замбараагүй байдал бий болох учраас иргэний эрх зүйн харилцааны тогтвортой байдал, зүй ёсны зарчмыг хангахад шүүхээр хамгаалуулах зарчим гол үүрэг гүйцэтгэдэг байна. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үндсэн арга нь шүүх, арбитрт хандах байдлаар илэрдэг учраас шүүхэд мэдүүлэх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг. Энэхүү үндсэн эрх бодитоор хэрэгжихэд уг зарчим чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд процессын эрх зүйн зарчимтай мөн хамт хэрэгждэг. Жишээлбэл, гэрээний болон гэрээний бус харилцааны үндсэн дээр тодорхой үүрэг хүлээсэн этгээд уг үүргээ өөрөө ухамсарлах, сайн дураар, шударгаар гүйцэтгэхгүй бол шүүхэд хандах замаар төрийн албадлагаар дамжуулан эрхээ хамгаалах боломжийг хуулиар олгодог.)

Итгэлцлийг хамгаалах зарчим

(Энэхүү зарчим нь үгийн шууд утгаар Иргэний хуульд тусгагдаагүй боловч иргэний эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйт ёсны үүднээс хуульд захирагдан амьдрах иргэншсэн нийгмийн гол шинж болох “итгэлцэл” гэх нийгмийн үнэт зүйлийг хамгаалахад чиглэдэг. Нөгөө талаас, уг зарчим нь эрх зүйн үндсэн чиг үүрэг болох нийгэмд тодорхой байдлыг бий болгох, нийгэм, эдийн засгийн харилцаан дахь иргэд хоорондын арилжаа, солилцоо, тохиролцоо нь үр ашигтай байх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Нийгмийн гишүүдийн хооронд харилцан итгэлцэл байхгүй тохиолдолд бие биенээ шалгах, баталгаа шаардах зэрэг олон төрлийн ажиллагааны зардал өсөж, үүнтэй холбоотойгоор бараа таваарын солилцоо, эдийн засгийн харилцаа туйлын өндөр зардалтай, үр ашиг багатай болно.)

Захиргааны эрх зүйн зарчмууд

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-т “гомдол гэж ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг” хэлнэ гэж заасан ба прокурор нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцохдоо дараах зарчмуудыг баримталбал зохино.

Захиргааны байгууллагаас аливаа шийдвэр гаргахдаа буюу үйл ажиллагаандаа

баримтлах зарчмыг Үндсэн хуулийн нийтлэг зарчмаас улбаалан тайлбарлаж, хүрээг нь тодорхойлон хэрэглэх шаардлага зайлшгүй болдог. Захиргааны үйл ажиллагааны зарчмыг гурван үндсэн хэсэгт хувааж үзэх боломжтой.

Нэгдүгээр, Захиргаанаас шийдвэр гаргахдаа буюу үйл ажиллагаа хийхдээ баримтлах зарчмууд байна. Тухайлбал захиргааны шийдвэрийн хэлбэр, үйл ажиллагаа тодорхой байх, Захиргааны шийдвэр үндэслэлтэй байх, Захиргаа дундыг баримтлах, Захиргаа шийдвэрээ үндэслэлтэй гаргах, Захиргаа ил тод, нээлттэй байх, Захиргааны үйл ажиллагаа шаардлагатай тохиолдолд л хийгдэх, зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон байх, Захиргааны үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх, Захиргааны үйл ажиллагаа үр ашигтай-эдийн засгийн хэмнэлттэй байх гэх мэт.

Хоёр дах хэсэгт нь захиргааны шийдвэрээр эрх нь хөндөгдөх иргэд, захиргааны үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг аль болох хангахад чиглэсэн эрх, ашиг сонирхол хөндөгдсөн этгээдийг сонсох, зөвлөгөө өгөх болон мэдээллээр хангах, иргэдийн итгэлийг хамгаалах, эрх зүйн байдлыг нь дордуулахгүй байх, бусдын эрх, эрх чөлөөг хууль бусаар зөрчихгүй байх зэрэг зарчмууд хамаарна.

Гурав дах хэсэг нь захиргааны үйл ажиллагаанд холбогдох гомдлыг оролцогчдоос гаргасан тохиолдолд түүнийг хянан шийдвэрлэх явцад баримтлах зарчмууд байна. Тухайлбал: мөрдөн шалгах зарчим, ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтан өөрөө үйл ажиллагаанд оролцохоос татгалзах, эсхүл бусад оролцогчоос татгалзах боломж олгох гэх мэт. Захиргааны үйл ажиллагааны зарчмын тайлбар, хэрэглээний ач холбогдол зөвхөн захиргааны байгууллагаас шийдвэр гаргахад төдийгүй, урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагааны шугамаар эсхүл шүүхээс нэхэмжлэлийг хянан шийдвэрлэхдээ үндэслэх, харгалзах нэг нөхцөл, шаардлага болдогт оршино.

3.3. Цаашид анхаарвал зохих асуудал.

Хуулийн тайлбар нь хууль тогтоогчийн хүсэл зоригийн илэрхийллийг хэт дэлгэрүүлж, хуульд заагаагүй асуудлаар шинэ хэм хэмжээ тогтоож болохгүй.

Хуулийг тайлбарлан хэрэглэх тодорхой шалтгааныг тогтоохын тулд хуулиудад байгаа заалт, агуулгаас гадна хуулийн (өөрийнх нь) нэр томьёо, Улсын Дээд шүүхийн тайлбар, зөвлөмж зэргээс гадна Монгол Улсын олон улсын гэрээний тайлбар, хууль зүйн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичгүүдийн тайлбаруудыг анхаарч үзэх ёстой. Үүнээс гадна монгол хэлний үгийн болон утгын тайлбар толиудыг судалж, эзэмшсэн байх нь тухайн хэрэгцээг хангах нэг арга болно.

Хуулийг хуулж бичих нь тайлбарлан хэрэглэж байгаа хэрэг биш юм. Энэ нь хуулийг тайлбарлаагүй буюу хууль зүйн дүгнэлт хийгээгүй, үндэслэлээ бичээгүйд тооцогдох эрсдэлтэй.

Прокурорын хуульд заасан чиг үүрэгт иргэн, хуулийн этгээд, хэргийн оролцогчтой харилцах мөн хууль сахиулах байгууллагын ажилтан, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэр, хүний эрхийг хязгаарлах объектуудад хяналт шалгалт хийх ажиллагаа хамаарах бөгөөд энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Энэ үүргийнхээ хүрээнд хүсэлт, гомдолтой холбоотой зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, дүгнэлт гаргах, хүний эрхийг хангах ажиллагааг прокурорын хяналт гэж ойлгоно. Уг ажиллагааны явцад прокурор хууль тогтоомжийн заалтыг зөв ойлгож хэрэгжүүлэх явдал нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

2. Гэмт этгээдийг ял завшуулахгүй байхын гадна гэм буруугүй нэг ч хүнийг хэлмэгдүүлэхгүй байх;
3. Нийт иргэд, хуулийн этгээдээс хуулийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, сэтгэл түвшин амьдрах нөхцөлийг нь хангаж өгдөг.

Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлд заасан яллах дүгнэлтийг үйлдэхдээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад цугласан нотлох баримтын хүрээнд болсон бодит үйл баримтыг өөрийн дотоод итгэл үнэмшлээр тогтоож, тохирох хуулийг яагаад хэрэглэх болсон үндэслэлээ бусдад ойлгомжтой хэлбэрээр бичих шаардлагатай.

Эрүүгийн хуульд нарийвчлан зохицуулаагүй боловч хэргийн үйл баримтад хамааралтай бусад хууль, эрх зүйн актыг оновчтой зөв сонгон авч тайлбарлан хэрэглэх шаардлагатай. Жишээлбэл, Насанд хүрээгүй болон хөдөлмөрийн чадвараа алдсан этгээдийн үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой зөрчлийн болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад гэр бүлийн гишүүн, төрөл садан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэх ойлголтуудыг Гэр бүлийн тухай хуульд тодорхойлсноор ойлгох, хууль бусаар ан агнах гэмт хэргийн хувьд нэн ховор ан амьтан гэх ойлголтыг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр 7 дугаар баталсан жагсаалт, журам батлах тухай (ховор амьтны) тогтоолд тодорхойлсноор ойлгоно г.м.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016

Ном, товхимол, гарын авлага, судалгааны материалууд.

1. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй I, УБ., 2020
2. Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол, УБ., 2010
3. Т.Саруул. Эрх зүй хэрэглэх арга зүй, УБ., 2014
4. Адоймэйт, Хэньшэн. Эрх зүйн онол, (монгол орчуулга: Г.Дөлгөөн, Ж.Энхбүрд) 2017
5. Ханс Кэльзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол, (монгол орчуулга: М.Хатанбаатар) 2013
6. Б.Өнөрмаа. Прокурорын хяналтын онцлог, 2022
7. Шүүхийн Ерөнхий зөвлөл “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл №1, УБ., 2015
8. Шүүхийн Ерөнхий зөвлөл “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл №2, УБ., 2016
9. Шүүхийн Ерөнхий зөвлөл “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл №3, УБ., 2018

БҮЛЭГ 16. ПРОКУРОРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

СЭДЭВ 1. ПРОКУРОР МЭРГЭЖЛИЙН МӨН ЧАНАР БА ОНЦЛОГ

1.1 Прокурорын ажил үүргийн онцлог ба мэргэжлийн хариуцлага
1.2 Мэргэжлийн онцлогийг хувь хүний хөгжилд хувирган мэдлэгээ дээшлүүлэх нь

СЭДЭВ 2. ХУВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ ЗАМААР АЖЛЫГ БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

2.1 Төлөвлөлт
2.2 Цагийн менежментийн тухай
2.3 Цаг төлөвлөх зарчим ба зохимжит арга барил
2.4 Прокурор туслах ажилтантай харилцах асуудал
2.5 Прокурор хууль сахиулах байгууллагын ажилтантай харилцах асуудал

СЭДЭВ 3. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ХУВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Хувийн зохион байгуулалтад зайлшгүй нөлөөлөх зарим асуудлууд
3.2 Гадаад орны сайн туршлага

СЭДЭВ 1. ПРОКУРОР МЭРГЭЖЛИЙН МӨН ЧАНАР БА ОНЦЛОГ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурор мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийгмийн хүрээнд хүлээх ёс зүй, хариуцлага, ажил үүргийн онцлог талууд, мөн чанарын талаарх асуудлыг тодруулан авч үзнэ.

1.1 Прокурорын ажил үүргийн онцлог ба мэргэжлийн хариуцлага

Прокурорын чиг үүрэг, бүрэн эрхийн талаар Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуульд эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг. Прокурор хууль дээдлэх ёс, хуульчийн ёс зүйтэй байхыг гол үнэт зүйл, зарчмаа болгон Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний хязгаарыг давж үл болох бөгөөд хүний эрхийг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх гол үүрэгтэй. Хамгийн гол нь шударга ёс гэдэг нь үр дүнгээр хэмжигддэг үнэт зүйл гэдгийг ойлгох учиртай.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох эрх бүхий, прокурорын байгууллагад томилогдон ажиллаж буй, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой төрлийн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн үүрэгтэй, хууль ёсыг сахиулагч, “хуульч” прокурор нь (Procuro-лат. Анхаарал тавих, хангах, зайлуулах) гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, дахин гаргуулахгүй байхад үйл ажиллагаагаа чиглүүлсээр ирсэн.

Прокурор хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн үйл ажиллагаандаа өндөр хариуцлагатай, сайн зохион байгуулалттай, зүй ёсны хэмжээнд прокурорын ёс зүйтэй, хувь хүнийхээ зан байдлыг хянах үүрэг ноогддог нь прокурорын мэргэжлийн дээгүүр тавигдах шаардлагаар хангагддаг.

Прокурорыг ёс зүйтэй байлгахын тулд ажил, мэргэжлийн онцлогт тохирсон, үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөх хувийн зохион байгуулалттай байх нь зүйтэй. Прокурор ажлаа төлөвлөж, зөв зохион байгуулалттай байснаар ажлын хариуцлагагүй, ёс зүйгүй байх зэрэг прокурорын ёс зүйн дүрмээр тусгайлан хэмжээчилдэг хэм хэмжээг зөрчихгүй байх эерэг талтай. “**Хариуцлагатай байх нь хуульчийн хараат бус байдлын тулгын чулуу бөгөөд хариуцлагаа ухамсарласан хуульч**

өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг” тул хариуцлагын дархлааг өөртөө бий болгох хэрэгтэй юм. Хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах ёстой ч бүрэн төгс боловсрогдсон ёс зүйн дүрэм гэж үгүй тул дүрмийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байхад прокурорын оролцоо чухал юм.[1]

Хүн эрх, үүргээ ухамсарлах, үйл ажиллагаандаа ямар сэтгэлээр хандах нь “ёс зүй”-тэй холбоотой. Хуульчид шударга ёсыг тогтоохын тулд “ёс зүй”-тэй байх, үүний тулд сэтгэхүй, оюун ухаанаа өөрчлөн, шаардлагатай бол хуучин арга барилаас ангижирч, хувийн зохион байгуулалтаа нэмэгдүүлэх шаардлагатай.

Хувийн зохион байгуулалтыг сайжруулах тухайд[2].

- Алсын хараа, тодорхой зорилгуудтай байх;
- Уян хатан байдал, дасан зохицох чадвартай байх;
- Олж мэдсэн зүйлээ ашиглаж чаддаг байхын тул мэдлэгтэй байх. Үүний тулд мэдлэгийг өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд “зайлшгүй, мэдэхэд илүүдэхгүй” гэсэн байдлаар ангилан өөрийгөө хөгжүүлэх;
- Бодлоо хянаж, аливаа зүйлийг сайн зүйлийн болох, бүтэх талаас нь эргэцүүлэн бодож сурах;
- Хандлага нь мэдлэг, чадвар хоёрыг зохион байгуулалттайгаар зөв хэрэглэхэд тусалдаг тул хүнд эерэг талаас нь хандах хандлагыг төлөвшүүлэх;
- Мэдлэгээ хэрэглээ болгох чадвараа хөгжүүлэх ;
- Нийгмийн хүрээнд бүрэлдэн тогтсон нийгмийн ёс зүйн сэтгэлгээ, хувь хүний үнэт зүйлстэй салшгүй хуульчийн ёс зүй буюу нийгмийн зүгээс өөрт тавьж буй тусгай шаардлагыг дагаж мөрдөж хэвших хэрэгтэй.[3]

Нийгмийн амьдралын хүрээнд эмч, инженер, химич, биологич, улс төр судлаач зэрэг өөр өөрийн чиг үүрэг бүхий мэргэжилтнүүд үйл ажиллагаа явуулж, чухал үүрэг гүйцэтгэдэг ч прокурор мэргэжлийн чиг үүргийн хүрээнд төрийн нэрийн өмнөөс хууль хэрэглэн хүнийг цагдан хорих тухай санал гаргах, баривчлах шийтгэх оногдуулах санал гаргуулах, яллах зэргээр эрх, эрх чөлөөнд хуулийн хүрээнд халдах төр, эрх зүйн байр суурь (онцгой эрх) эдлэхгүй учир прокурор нь төр, нийгмийн өмнө онцгой хариуцлага хүлээдэг онцлогтой.

Монгол Улс “Хуульчдын эрх зүйн байдлын тухай хууль”-ийг 2012 онд баталсан бөгөөд хуулийн байгууллагуудаас иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаатайгаар хангах хэрэгжүүлэх, шударга ёсыг тогтооход хуульчдыг нэгтгэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн нэгдсэн тогтолцоог эрхэмлэж, тэдний мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоог ханган хэрэгжүүлэхээр үндсэндээ Америкийн Нэгдсэн Улсын “Бар”-ын системийн туршлагад тулгуурлан баталснаас хойш 11 жилийн хугацаа өнгөрсөн байна.

Прокурор та Америкийн Нэгдсэн Улсын “Бар”-ын системийн туршлагад тулгуурласан холбооны бус нэгдмэл бүтэцтэй, нэгдмэл шүүхийн тогтолцоотой Монгол Улсад хуульч “прокурор” мэргэжлээр ажиллаж, иргэдийн эрх чөлөөг хамгаалан хангахад системийн нэг хэсэг болон ажиллаж буй нэр хүндтэй албаны нэг хэсэг билээ.[4]

Мэргэжлийн хариуцлагын тухайд.


---

1 А.Э.Жалинский. Профессиональная деятельность юриста. Введение в специальность. Изд-во “Бек М. 1997

2 Ronald D. Rotunda and Mighael I. Krauss. Legal Ethics in a Nutshell. 2003 Deboran L. Rhode and David Luban. Legal Ethics, 4th (University Casebook Series). 2004

3 Gallup State of the American Workplace Report

4 АНУ-ын Азийн институтын захирал Жой Спурлок /Техасын Веслайн хууль зүйн их сургууль/



Зураг 1. Мэргэжлийн хариуцлагын зохион байгуулалтын талаарх Олон улсын загвар схем

Прокурор мэргэжлийн хариуцлагын хүрээнд нийгмийн өмнө дараах үүргүүдийг хүлээдэг:

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг
- Прокурорын хяналт тавих үүрэг
- Эрх үйн ухамсар, боловсролын үүрэг
- Шударга байдал, прокурорын хараат бус байдлыг төлөвшүүлэх үүрэг
- Прокурорын хариуцлагатай байх үүрэг
- Ёс зүйн шаардлагад нийцэн ажиллах үүрэг

Үүрэг нь хувь хүнээс бусдын өмнө болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт. Үүргээ ухамсарлах нь хүн өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаандаа ямагт бодолтой, ухаалаг хандахад нөлөөлдөг.[5] Академич Ж.Амарсанаа “Прокурорын ёс зүй ба ажлын зохион байгуулалтын асуудлаар тавьсан илтгэл”-дээ Зураач муу зураг зурсан бол түүнийг хэн ч худалдаж авахгүй, зохиолч тааруу зохиол бичсэн бол хэн ч уншихгүй тус зураач, зохиолч өөрсдөө л эдийн засгийн хохирол хүлээхээс биш өөр хэн ч хохирохгүй. Харин хуульч, прокурор хэзээ ч тийм гологдол гаргах ёсгүй гэж дурдсан байх бөгөөд прокурорын мэргэжлийн хариуцлагын гол зангилаа бол эрх мэдэл дор хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх явдал учир өөрт олгогдсон эрх мэдлээрээ өөрт давуу байдал олгох зүй бус шийдвэр гаргах бус шударга ёсыг[6] сахигч байх ёстой юм. Та дээрх дурдсан ойлголтуудын хүрээнд ажлаа шударгаар, ёс зүйтэйгээр, хариуцлагатайгаар гүйцэтгэж дүүрэн хангалттай үр дүн гаргахын тулд өөрийн хэт амбицтай, эго өндөртэй байдлаар бус төлөвшилтэй байх, төлөвлөлт хийх, зориг, зүтгэл, ухаан бодлоо дайчлах хэрэгтэй билээ.

1.2 Мэргэжлийн онцлогийг хувь хүний хөгжилд хувирган мэдлэгээ дээшлүүлэх нь

Прокурор ажлаа өндөр бүтээмжтэй, үр нөлөө сайтай, чанартай гүйцэтгэхийн тулд прокурорын ажлын шаардлага, онцлог, мөн чанарт тохирсон зан суртахуун, дүр төрхийг өөртөө бий болгон, төлөвшүүлэх, прокурорын ёс зүй, ёс суртахууны боловсролтой байх, цаашлаад мэргэжлийн мэдлэг, ур чадвар тэр дундаа ажил, амьдралаа зөв, ухаалаг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хянах ур чадварыг

[5] Сенека Младщий

[6] Шударга ёсны талаар эртний сэтгэгч Сократ «шударга ёс бол бусдад үйлдэх буян», «сайн хүн гэж шударга хүнийг хэлнэ», «сайн хүн шударга бусыг үйлдэхгүй», Платон «Тор» зохиолдоо: «шударга ёс алтнаас үнэтэй, түүн шиг буян гэж үгүй, шударга бус шиг муу, муухай юм гэж байхгүй», «шударга ёс бол агуу их баялаг» гэсэн байдаг бол Францын хаан Напельон «шударга байх нь хамгийн сайн бодлого юм». Гельвиция «хувь хүмүүсийн үйлдэл нийтийн сайн сайханд ийнцэх нь шударга ёс» гэж тус тус тодорхойлсон байна.

заавал эзэмшсэн байх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд хувь хүний хөгжил гэж их ярих болсон ч өнөөгийн асар их зөвлөгөө, мэдээлэл дундаас яг алийг нь авч хэрэгжүүлбэл үр дүнтэй эсэхэд ажилтнууд эргэлзэх нь бий.

Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө гэдгийг салбарын мэргэшсэн мэргэжилтнүүд "Хүсэл тэмүүлэл, мэдлэг, ур чадвар, өөрийн давуу талд үндэслэн өөрийн бий болгож чадах боломжуудад хүрч, үнэ цэнийг бүтээх, хувь хүний онцгой байдалдаа тохируулан амжилтад хүрэх үйл явцын нарийн, маш тодорхой зураглалыг хувийн хөгжлийн төлөвлөгөө" гэж тодорхойлжээ.

Харин хувийн хөгжлийн төлөвлөгөөнийхөө дагуу ажиллаж, амьдрахын тулд бид аливааг зохион байгуулах, удирдах, зохицуулах чадварт хүссэн, хүсээгүй суралцах шаардлагатай. Хүн бүрт зорилгодоо хүрэх нөөц боломж бий. Гол нь тэрхүү нөөц боломжоо өөрийн чадах хамгийн сайн хэмжээнд зохион байгуулж, улмаар өөрийн амьдралыг удирдан авч явах нь чухал. Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө бол та ажлын байрандаа илүү ахиц, дэвшилтэй байхын төлөөх алхмууд юм. Өөрчлөлт бүрийн ард боломжууд нуугдаж байдаг. Тиймээс өөрийгөө боломжид бэлтгэж, бэлэн байх хэрэгтэй. Олон улсын туршлагаас судалбал хувийн хөгжлийн төлөвлөлт хийх 7 алхам байдаг байна.[7]

Алхам 1. Өөрийгөө бүрэн таних, ойлгох

- Хүсэл тэмүүлэл
- Зорилго /Ойрын ба алсын/
- Өөрийн нөөц баялаг, боломж
- Хувийн хөгжлийн SWOT шинжилгээ (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) буюу өөрийн давуу, сул тал болон өөрт тохиож болох боломж, учирч болох аюулын талаар дүгнэн бичиж, хувь хүний хөгжлийн талаарх бодит үнэлгээг гаргадаг байна.

Энэ нь цааш хувийн стратегиа тодорхойлоход дөхөм болох болно. Хүмүүс өөрийгөө бүрэн ойлгосон үедээ зорилгоо давуулан биелүүлдэг.

Алхам 2. Хувийн хөгжлийн стратегиа сонгох

- Давуу талаа ашиглан боломж руу давших
- Сул талаа давуу тал болгох
- Сул талаа давуу тал болгоод боломж руу давших
- Байгууллагын стратегид нийцүүлэн өөрийг стратегийг бага хэмжээний хувилбараар бүтээх

Прокурор та дээрх стратегийн арга барилаас сонгож, дараах асуултуудад хариулаарай.

- Давуу талаа боломж болгож ашиглахын тулд би юу хийх вэ?
- Сул талаасаа болж боломжийг алдахгүйн тулд би юу хийх вэ?
- Сул талаа өөрчлөн давуу тал болгож эрсдэлд өртөхгүйн тулд би юу хийх вэ?
- Сул талаасаа болж мэргэжлийн болон ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүйн тулд би юу хийх вэ?

Алхам 3. Зорилгоо илүү тодорхой болгох

- Алсын хараагаа тодорхойлох
- Зорилгоо тодорхойлох /Урт хугацааны буюу алсын зорилго/

[7] Ronald D. Rotunda and John S. Dzienkowski. Legal Ethics: The Lawyer's deskbook on professional responsibility, 2005-2006 ed. (AB

- Ойрын зорилго /Нэн чухал ба чухал/

Зорилго тань тодорхой байх ёстой. Жишээлбэл, 10-30 хэрэг, материал нэг өдөрт хянана гэхийн оронд өнөөдөр 5 хэрэг, 5 материал хянаж, шийдвэр гаргана гэж зорих.

Зорилго тань хэмжигдэхүйц байх ёстой. Энэ долоо хоногт сайн ажиллана гэхийн оронд энэ долоо хоногт өдөрт 10 цаг ажиллаж, бүтээмжээ 30 хувиар нэмэгдүүлж, 2******** дугаартай хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд биечлэн оролцох гэх мэт.

Зорилго тань хүрч болохуйц байх ёстой. Тухайлбал, эхний хагас жилийн шилдэг прокурор болно гэхийн оронд өөртөө таарсан зөв арга барилыг олж, үр дүн гаргаж ажиллана гэх мэт

Зорилгоо хэрэгжүүлэх цаг хугацаа тодорхой байх. Энэ жил *** хуулийн хэрэгжилтэд шалгалт, судалгаа хийн үр дүнг олон нийтэд танилцуулна гэхийн оронд сэдэвт судалгааг аравдугаар сар, арван нэгдүгээр сард хийж, гүйцэтгэн үр дүнг нэгтгэнэ гэх мэт тодорхой хугацаа заах.

Алхам 4. Давуу талыг тань даган ирэх боломжуудын жагсаалт гаргах

Алхам 5. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцөө тодорхойлох

Алхам 6. Хувийн хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх аргаа нарийн тодорхойлох

1. Бие даан хэрэгжүүлэх
2. Ментортой ажиллах
3. Суралцах

Алхам 7. Хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах

1. Хүрэх зорилгууд ба хүрэх амжилт
2. Нийгмийн хариуцлага
3. Зан чанарын өөрчлөлт
4. Дадал зуршлын өөрчлөлт /Эрүүл мэнд, сэтгэл санаа/

Та төлөвлөгөөндөө хувийн зан төлөв, хандлагаа хэрхэн өөрчлөх талаар ч тусгах нь зүйтэй. Учир нь амжилттай байна гэдэг зөвхөн хэдэн хэрэг хянах, хэдэн шийдвэр гаргах тухайд тойрсон асуудал биш. Мөн Олон улсад прокуроруудыг зөвхөн ажлаа амжилтай хийж байгаагаар бус өөрийн хувь хүний хөгжил, эрүүл мэнд, сэтгэл санаандаа анхаарч буй байдлыг хүртэл нэн тэргүүнд анзаардаг болсон. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан судалгаагаар ажлын байранд шаардагдаж буй чадваруудыг жагсаан, нэрлэсэн байдаг. Үүнд:

- Ээдрээтэй асуудлын шийдлийг олох чадвар
- Шүүмжлэлтэй сэтгэлгээ
- Бүтээмжит чадвар
- Хүний арга эвийг олох чадвар
- Бусадтай хамтрах чадвар
- EQ-сэтгэлийн ухаан
- Дүгнэлт хийх ба шийдвэр гаргах чадвар
- Үйлчилгээг эрхэмлэх чадвар
- Хэлэлцээр хийх чадвар
- Оюун санааны уян хатан байдал зэрэг болно.

Дээрх 10 чадваруудын 7 нь хувь хүний өөрийгөө удирдах болон багаар ажиллах, бусдад нөлөөлөх чадварууд байгаа нь ирээдүйд зөвхөн эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн байгаад хангалттай биш өөрийгөө болон

бусдыг удирдаж чадах хүмүүс амжилттай байх нь судалгаагаар харагдаж байгаа юм.

Аливаа төрлийн өсөлт, хувь хүний хөгжил нь нэгэн чухал ур чадварыг шаарддаг нь “суралцах” юм. Суралцах нь бидний оюун ухааныг тэтгэж, сэтгэлийг тайвшруулах хэрэгсэл бөгөөд энэ бидний ямарваа нэг зүйлийг илүү сайн ойлгож, боловсруулах чадварыг бий болгодог тул хувийн болон мэргэжлийн хувьд хэрэгцээтэй юм. Та мэдлэг бол хүч гэсэн хуучны эшлэлийг сонсож байсан байх. Энэ нь таны бодож, төсөөлснөөс илүү үнэн үг юм. Боловсролтой хүн өөрийн ажил, мэргэжлийн явцад тулгарсан асуудлыг амархан зохицуулж чадна. Хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүссэн ээдрээтэй асуудлуудын (complex problems) шийдлийг олохын төлөө зүтгэж чадвал та чадварлаг прокурор байх болно.

Прокурорын ажлын зохион байгуулалт нь та өөрийн эзэмшсэн мэргэжлийнхээ туршид олж авсан мэдлэг болон бусад салбар эрх зүйн мэдлэг, ур чадвараас дутахааргүй үнэ цэнтэй юм.

Учир нь ажлын сайн зохион байгуулалт нь таны ажлын чанар, үр нөлөө, бүтээмжийг тодорхойлох үндсэн шалгуур болдог. Шинээр томилогдсон прокурорын хувьд ажлаа зөв, сайн төлөвлөх, зохион байгуулах арга барил, дадал, ур чадварыг эзэмшихийн тулд хийж байгаа прокурорын мэргэжлийн ажлын зарим онцлог, тодруулбал: прокурорын ажлын мөн чанар, хүлээх үүрэг, түүнд хүлээлгэх хариуцлага, ажил мэргэжлийн ерөнхий нөхцөлийг судалж, мэдэх шаардлагатай.

Прокурорын байгууллага нь хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Хяналт тус бүрээр прокурорын хяналтын ерөнхий нөхцөлүүдийг авч үзвэл:

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ерөнхий нөхцөл нь:

1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь Монгол Улсын Прокурорын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зарчмуудын үндсэн дээр хэрэгжих бөгөөд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас эхэлж хэргийг шалгаж шийдвэрлэх бүхий л явцад байнга, тасралтгүй байна.
2. Прокурор мөрдөн шалгах ажиллагааны хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдүүлэг авах өрөөний шаардлагыг бүрэн хангуулах арга хэмжээ авч, зөвшөөрөл олгоно.
3. Прокурорын хянан шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлсан “Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх журам”-ыг баримтална.
4. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналттай холбоотой дараах харилцааг Улсын ерөнхий прокурорын дангаар болон бусад байгууллагатай хамтран батлсан заавар, журмаар зохицуулна:

   4.1. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос гаргасан

гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авах, хянах, шийдвэрлэх;
4.2 эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хүлээн авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх;
4.3. барьцааны мөнгийг төрийн сангийн дансанд байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх;
4.4. шинжилгээний обьектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах,
4.5. мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах;
4.6. эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх.

Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналтын ерөнхий нөхцөл

1. Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналтыг Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлнэ.
2. Прокурор нь зөрчлийн хэрэг бүртгэлт хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянаж, өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар тогтоол гаргана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан прокурорын шийдвэрийг хууль бус, үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны прокурор өөрчлөх буюу хүчингүй болгоно.
4. Эрх бүхий байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр, үйл ажиллагаа прокурорын хяналтад хамаарахгүй.
5. Прокурор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон эрх бүхий албан тушаалтнаас гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагааг Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулна.
6. Прокурор эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхгүй.
7. Прокурор эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас зөрчил шалгах тодорхой ажиллагааг явуулахдаа тухайн /эрх хязгаарлах, албадан ирүүлэх, хохирол нөхөн төлбөр гаргуулах, албадлагын арга хэмжээ авах гэх мэт/ ажиллагааг зохицуулсан холбогдох журмыг хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина.
8. Зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирол, нөхөн төлбөр төлөгдөөгүй бол Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан зааварт заасны дагуу шүүхэд нэхэмжлэл бичүүлэхээр холбогдох материалыг шилжүүлнэ.

Шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан прокурорын хяналтын ерөнхий нөхцөл

1. Шүүхэд төрийг төлөөлөх ажлыг Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын баталсан заавар, журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.
2. Прокурор нь иргэн, захиргаа, зөрчил, эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохдоо хэрэгт

цугларсан нотлох баримтад тулгуурлан, хэргийн бодит байдал, үйл баримт, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэл бүхий хууль зүйн дүгнэлт хийж гомдол, санал, хүсэлт, нэхэмжлэл, дүгнэлт, эсэргүүцэл, тайлбар гаргана.

3. Прокурор үйл ажиллагаандаа Олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбар зэрэг баримт бичгийг судалж хэрэглэнэ.
4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан тусгай журмаар зохицуулна.

Ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ерөнхий нөхцөл

1. Ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтыг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенц, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлнэ.
2. Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд прокурорын хяналтыг хэрэгжүүлнэ
3. Прокурор нь ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, хуулиар тогтоосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргана.
4. Прокурорын шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан, хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.
5. Эрх бүхий байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дотоод асуудлаар гаргасан шийдвэр, үйл ажиллагаа прокурорын хяналтад хамаарахгүй.
6. Ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргасан оролцогчдын гомдол, хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагааг Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулна.
7. Прокурор нь ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой шүүх хуралдаанд оролцохдоо энэ заавар болон Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан зааврыг баримтална.
8. Прокурор шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож дүгнэлт гаргах зэрэг болно.

Цагаа зөв төлөвлөн өөрийн зорилгод хүрэх буюу үнэ цэнэ бүтээх нь ажлын байранд прокурорын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, өөрийн мэдлэг, ур чадвараа бүрэн зарцуулж, хувь хүний ур чадвараа сайжруулж, тасралтгүй мэдлэгээ нэмэх боломжийг нээх юм. Иймээс өөрийн ажил мэргэжил, хяналтын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, заавар, чиглэлийг судалдаг судлаач байх, хяналтын чиглэлд хамаарах бусад асуудлыг сонирхдог, суралцдаг суралцагч байх хэрэгтэй.

Таны ажлын зохион байгуулалтаас гарсан сайн үр дүн, үнэ цэнэ нь хэмжигдэхдээ хэчнээн хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан, түүнийг зөрчигдөхөөс сэргийлсэн, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авсан талаар, төр, нийтийн ашиг сонирхлыг

хамгаалсан, таны хувь хүний мэргэжлийн ур чадвар хэдий хэмжээгээр нэмэгдсэн эсэхээр хэмжигдэх эерэг талтай.

Ажлын зорилго тавихдаа би ямар чадамжаа сайжруулж, юу чаддаг болчихвол мэргэжил, мэргэшлийн ямар ур чадвар дээшлэх вэ, хэчнээн хүнд ямар тусыг хүргэж чадах вэ, би ойрын 5 жил, энэ жил, энэ сар юу юу шинээр сурах вэ, ямар сургалтад хамрагдах вэ, хяналтын ажлын бүртгэл хөтлөх, хэдэн хэрэг, материалтай танилцах, хянах вэ, хуулийн хэрэгжилтэд шалгалт, судалгаа хийх; эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явцад биечлэн оролцох гэж бодож төлөвлөвөл зөв эхлэл болно.

СЭДЭВ 2. ХУВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ ЗАМААР АЖЛЫГ БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурор мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хувийн төлөвлөлтийг зөв аргаар зохион байгуулж өөрийн ажлыг бүтээмжийн чанарыг сайжруулах зохимжит арга барилуудын талаар асуудлыг тодруулан авч үзнэ.

2.1 Төлөвлөлт

Төлөвлөлт нь цаг хугацаа, орон зайд тавьсан зорилтуудыг арга, бүтэцтэйгээр зохион байгуулах амьдралын талбарт тохиолддог үйл явц, ур нөлөө. Төлөвлөгөө гэдэг нь аливаа төрлийн төслийн ухамсартай, хариуцлагатай боловсруулалт бөгөөд ерөнхий зорилго, хуваарь, хүлээгдэж буй үр дүн, ерөнхий зорилгод хүрэх хүртэл төлөвлөсөн зүйлсийн хэрэгжилтийг тодорхойлох стратегийн хэрэгсэл юм. Нөгөө талаар тодорхой цаг хугацаанд ямар ахиц өөрчлөлтөд хүрч болох буюу ур дүнгийн хүрэх түвшинг тогтоох асуудал юм.

Хувь хүний хөгжлийн төлөвлөлт (мөн хувь хүний хөгжлийн төлөвлөгөө гэж нэрлэдэг) нь хувь хүмүүст өөрсдийн давуу тал, сул тал, сайжруулах талбаруудыг тодорхойлоход туслах гарын авлага бөгөөд хувийн болон мэргэжлийн зорилгодоо хүрэх замын зураглалыг бий болгодог. Энэ нь хувь хүн өөрийн хувийн өсөлт, хөгжлийг тодорхой хугацаанд төлөвлөх хэрэгсэл юм.

Хувийн хөгжлийн төлөвлөгөө нь өөрийн давуу тал, сул тал, сайжруулах талбараа эргэцүүлэн бодох замаар өөрийгөө болон боломжоо илүү сайн ойлгоход тусална. Тэндээс та зорилгодоо хүрэх тодорхой замын зураглалыг бий болгож, амьдралынхаа чанарыг сайжруулж, амжилтад хүрэх боломжийг олгодог.

Хувь хүний хөгжлийн үр дүнтэй төлөвлөгөө гаргахад тань туслах үүднээс прокурорын мэргэжил арга зүйн хөгжлийн төлөвлөгөөний хамгийн хялбар загварыг танилцуулъя.

Зорилго	Өнөөгийн нөхцөл байдал	Хүссэн үр дүн	Үйлдлийн үе шатууд	Хугацаа	Явцын шинэчлэл
Мэтгэлцэх чадварыг сайжруулах	Бүлгийн өмнө үг хэлэх үед сандардаг	Өөртөө итгэлтэй, уран илтгэгч	Илтгэх урлаг, мэтгэлцээний сургалтад хамрагдах, үг хэлэх дасгал хийх, ажлын хурал дээр сайн дурааараа үг хэлэх	.....-.....	Ажлын гурван уулзалтад сайн дурааараа илтгэл тавьсан, амжилттай шүүх хуралд оролцсон.

2.2 Цагийн менежментийн тухай

Практикт прокуроруудын илэрхийлж буйгаар прокурорын үйл ажиллагааг хариуцлагатайгаар хэрэгжүүлэхэд ажлын өдөрт ногдож байгаа цаг хугацаа хангалтгүй санагддаг. Үүнд ажиллах орчин, ажлын ачаалал, нэг хүнд ногдох хэрэг, материалын тоо их зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна. Мөн орчин үеийн хууль, эрх зүйн орчин нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа прокуроруудад ажил мэргэжлийн өвөрмөц шинэ сорилтуудыг бий болгож байна. Хүн бүрт 24 цаг, ажлын 8 цаг ижил өгөгдсөн байтал зарим ажилтнууд яаж бусдаас илүү их ажлыг илүү бага цаг хугацаанд амжуулдаг шалтгаан нь маш сайн төлөвлөгдсөн цагийн менежмент болж байна. Прокурор ажлын цагаа төлөвлөх нь практикт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд чухал ач холбогдолтой төдийгүй прокурорын ажлын хариуцлага, ёс зүй, хувийн зохион байгуулалттай нягт уялдаатай.

Сайн цагийн менежмент гэдэг бол ухаалгаар ажиллах чадварыг хэлэхээс өөрт шахалт дарамт үүсгэн ажиллахын нэр биш билээ. Цагийн менежментийн талаар судалж, суралцахдаа та урсгалаар биш амьдрал дээрээ ягштал хэрэгжүүлж чадвал үр дүн нь илүү бүтээмжтэй илүү үр дүнтэй ажиллана, таны ажлын нэр хүнд өснө, стресс багасна, зэрэг, дэв ахих түүнд хүрэх боломж нэмэгдэх эерэг үр дүнтэй.

Цагийн зохион байгуулалт муу бол ажлыг тогтоосон цаг хугацаанд чанар муутай тулгаж гүйцэтгэх, хяналтын үр дүнгүй ажиллах, чанарын муу үзүүлэлттэй ажиллах, ажлын байран дээрх таны нэр хүнд буурах, эрүүл мэндийн буруу хэвшил зэрэг сөрөг үр дагаврууд үүсдэг байна.

2.3 Цаг төлөвлөх зарчим ба зохимжит арга барил

Цагийн менежмент нь цаг төлөвлөлт, ашиглалт өөрийн эрхэлж буй ажил болоод өөрийн цаг хугацаандаа эзэн байх утгатай ба ажлаа хэдий хугацаанд хийж, хэрэгжүүлэхийг төлөвлөх зохион байгуулах үйл явц юм. Цаг ашиглалт нь үр дүнд тулгуурладаг ба завгүй байх нь үр дүнтэй байна гэсэн үг биш юм.

Америкийн сургалт, хөгжлийн нийгэмлэгээс тодорхойлсноор цаг төлөвлөх 25 зарчим байдаг гэж тодорхойлсон байдаг. Үүнээс Япон,Солонгос, зэрэг азийн ихэнх улс орнуудын прокурорын байгууллагаас прокурор, ажилтнууддаа зөвлөсөн цаг төлөвлөх үндсэн зарчмыг авч үзье. Хэдий улс орнуудын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны төлөв байдал өөр боловч хувь хүний хөгжлийн сайн туршлагыг судалж, өөрсдийн нийгмийн амьдралын хүрээнд хэрэгжүүлэх нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар тангараг өргөсөн прокуроруудын хувьд ээлтэй билээ.

Үүнд: төвлөрөх, төлөвлөх, эмхэлж, цэгцлэх, үйлдэл хийх, суралцах гэсэн 5 үе шат байна.

Дэлгэрүүлбэл:

Ажилдаа төвлөрөх	**Үйлдэл хийх**
• Хэргийн тухайд бичиж, тэмдэглэх • Алсын хараа бүтээх • Ажлаа төлөвлөх • Зорилгоо тодорхой болгох • Чухал ажлын дараалал гаргах • Ажлын орчноо эмхэлж цэгцлэх • Ширээний эмх цэгц	• Цаг барих • Хэт ачааллаас зайлсхийх • Бусдаас суралцах • Стратегитай байх • Суралцах • Эргэн харж, үнэлж цэгнэх • Санал зөвлөгөө авах • Стресс ба амралт

Монгол Улсын прокурорын байгууллагын ажлын ачаалал, зохион байгуулалтад нийцүүлэн үзвэл цаг төлөвлөх зохимжит арга барил нь цагийн төлөвлөгөөний матриц үүсгэх юм. Энэ нь яаралтай ажлыг эхэнд тавьж, яаралтай бус ажлуудын жагсаалт гаргаж ажиллах билээ.

А. Хамгийн чухал хугацаатай ажил буюу ажил үүргийн 15 хувийг эзлэх, эдгээрийн бодит үр ашиг нь 65 хувь. Энэ ажлыг төлөвлөхөд өдрийн 3 цагийг зарцуулахад тохируулах

Б. Харьцангуй чухал ажил нь нийт ажил үүргийн 20 хувь, үр ашгийн мөн 20 хувийг эзэлнэ, энэ ажлыг 1 цагт багтаан төлөвлөж болох

В. Байнгын хийж, гүйцэтгэх ажлууд нийт ажлын 65 хувийг эзэлнэ, ажлын үр ашгийн 15 хувь болдог. Энэ ажлыг 45, 45 минутаар хийхээр төлөвлөх нь зүйтэй.

2.4 Прокурор туслах ажилтантай харилцах асуудал

Прокурорын байгууллага нь сүүлийн жилүүдэд төрийн албаны ил тод, нээлттэй байдлыг хангах, прокурорт итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, прокурорын үйлчилгээг цахимжуулах чиглэлд онцгой анхаарал хандуулж ажиллаж байна. Цаашид эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, прокурорын байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах нь зүйтэй. Байгууллагын бүтцийн зохион байгуулалттай холбоотойгоор нэгж газраас хамааран 1 туслах ажилтан 2-5 прокурорт тусалж ажиллаж байна. Иймд прокурор ажлын төлөвлөлт, зохион байгуулалт хийхдээ энэ талыг харгалзан үзэж, мөн өөрийн ажлын зохион байгуулалтаа тохируулах шаардлагатай юм.

Прокурорын байгууллагын хэмжээнд 2023 оны хагас жилийн байдлаар 623 прокурор, 206 туслах ажилтан, 548 захиргаа, үйлчилгээний ажилтан буюу нийт 1377 хүн ажиллахаас 608 прокурор, 205 туслах ажилтан, 524 захиргаа, үйлчилгээний ажилтан, нийт 1337 хүн ажиллаж, хүүхэд асрах чөлөөтэй 66 прокурор, ажилтан байна. Прокурорын туслах ажилтны сонгон шалгаруулалт жил бүр хүний нөөцийн судалгаанд тулгуурлан зохион байгуулагдаж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар прокурорын байгууллагын хүний нөөцөд иргэнийг бүртгэж, туслах ажилтны сул орон тоонд томилж, нийтэд мэдээлдэг.

Прокурорын өндөр шаардлагатай, ачаалал ихтэй ажлын ард прокурорын туслах ажилтны хамтын хөдөлмөрийн үр шим байдаг билээ.

Прокурор нь туслах ажилтанд өгсөн үүрэг даалгавар, даалгасан ажлын биелэлт, үр дүнг заавал тооцож ажиллахын хажуугаар өөрийн хариуцсан хяналтын ажлын чиглэлээр гаргаж буй эрх зүйн хэлбэрүүд болон бусад бичиг баримтыг боловсруулах ажилд туслах ажилтныг сургаж дадлагажуулна. Ингэхдээ туслах ажилтны боловсруулсан эрх зүйн хэлбэр болон баримт бичгийн төсөлтэй заавал танилцаж, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан эсэх, үг үсэг, утга найруулгын хувьд алдаагүй, зөв бичигдсэн эсэх, нотлох баримтад тулгуурлан хууль зүйн үндэслэлтэй бичигдсэн эсэх зэргийг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх ба боловсруулалтын явцад гаргасан алдаа дутагдал, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар туслах ажилтанд тухай бүр нь заалт чиглэл, зөвлөгөө өгч ажилладаг. Прокурорт хуваарилагдсан процессын ажиллагааг зохион байгуулахад, хэргийн оролцогч нартай уулзах, харилцах хамгийн чухал үүргийг туслах ажилтан гүйцэтгэдэг. Туслах ажилтныхаа ямар ажил үүрэг гүйцэтгэж байгааг маш сайн мэдэж, нэг баг болон ажиллах хэрэгтэй.

Ажлын зохион байгуулалтаа хийхдээ ажлын арга барил, туршлага солилцох, ажлын ачааллыг бууруулах зорилгоор туслах ажилтны ажлыг давхар бодож

төлөвлөх нь зүйтэй.

Прокурорын зөв ажлын зохион байгуулалтын үр дүнд ажлын менежмент хийх, бусдад үлгэрлэх ур чадвар, ажилтнаа сонсох, ойлгох, мэдрэх, таних, түүний онцлогт тохирсон ажлыг хуваарилах чадвар, мэдээ мэдээллийг хурдан шуурхай дамжуулах чадвар, туслах ажилтнаа урамшуулах, сэдэлжүүлэх замаар хамт олны уур амьсгалыг сайжруулах, нэмэгдүүлэх нэг тал болдог.

2.5 Прокурор хууль сахиулах байгууллагын ажилтантай харилцах асуудал

Прокурор ажил үүргээ гүйцэтгэхдээ өдөрт 5-аас доошгүй хууль сахиулах байгууллагын ажилтантай цахимаар болон танхим хэлбэрээр уулзалт зохион байгуулдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй, хуульд заасан арга хэлбэрээр явуулахад хууль сахиулах байгууллагын эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын үйл ажиллагааны үр дүн чухал нөлөөтэй билээ. Үүний хүрээнд шуурхай, тасралтгүй байж, хуулиа дээдлэн, шударга ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ажил хэрэгч байгаа албан хаагчдыг хүндэлж, тэдний ажлыг үнэлж, зөв чиглүүлж, үүрэг даалгавар өгч байх ёстой юм.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өсөн нэмэгдэж зохион байгуулалттай улс гүрэн дамнасан хэлбэрт шилжин хар тамхи зөөвөрлөх, мөнгө угаах, хүн худалдаалах, өмчийн харилцааны зэргээр цөөнгүй тохиолдох гэмт үйлдлүүдийн тоо өсөж хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэг зөрчилтэй уламжлалт аргаар тэмцэх нь үр дүн багатай, чирэгдэл ихтэй байгаа нь олон хүчин зүйлс, дотоодын судалгааны үр дүнгээс харагдаж байна. Үүнд эрх зүйн зохицуулалт, байгууллагын уялдаа холбооны асуудал хөндөгддөг. Иймд та өөрийн хувийн ажлын төлөвлөгөө, зохион байгуулалт хийхдээ хууль сахиулах байгууллагын ажилтны ажил мэргэжил онцлогийг хүндэтгэн, анхаарал хандуулах нь зохистой.

Бид хаана ч очсон, суурьшсан тус орчиндоо өөрсдийн соёлыг бүрдүүлж, бий болгож байдаг. Үүний адил ажлын орчинд ч мөн өөрийн гэсэн соёл бүрэлдэж бий болон тогтдог. Байгууллагын соёл нь байгууллагын дотор амьдрах, бодох, ажиллах, гишүүн байх тодорхой орчин болж байдаг ба энэ нь та өөр байгууллагын ажилтантай харилцахдаа байгууллагаа төлөөлж буй хэлбэр билээ.

СЭДЭВ 3. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ХУВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурор мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн хувийн зохион байгуулалтыг хэрхэн зохион байгуулах болон мэргэжлийн хүрээнд анхаарах шаардлагатай зарим асуудлуудын талаар тодруулан авч үзнэ.

3.1 Хувийн зохион байгуулалтад зайлшгүй нөлөөлөх зарим асуудлууд

Өмнөх сэдвүүдээр хувийн зохион байгуулалт хийхдээ нийгмээс танд нөлөөлөх бусад хүчин зүйлсийг хамааруулах тухай дурдсан. Прокурор бусдын өмнө хүлээсэн итгэл, эрхэлсэн ажилдаа эзэн болохын тулд өдөр тутмын үйл ажиллагаа, ажлаа төлөвлөн зохицуулах шаардлагатай.

Мэргэжлийн болон ёс зүйн мэдлэг, боловсролын түвшинд мэдэх ёстой мэдлэг, ойлголт, шаардлагыг мэдэх, ажил, амьдралдаа хэрэгжүүлэх, хийх ёстой ажлаа мэргэжлийн өндөр ур чадвартайгаар, үр бүтээлтэй байхад таны ажилд нөлөөлөх чухал ач холбогдолтой зарим ажлуудыг хэрхэн үр бүтээмжтэй, үр нөлөөтэй зохион

байгуулах талаар ойлголтыг тодрууллаа.

3.1.1 Прокурор хавтаст хэрэг, материалтай танилцахад анхаарах зарим асуудлууд.

Хавтаст хэрэг, материалуудтай танилцах, судлах, хянан шийдвэрлэх, шийдвэр гаргахад хэргийг хэрхэн шийдвэрлэвэл зохистой талаар эхний байдлаар үнэлэх итгэл, үнэмшил прокурорт төрдөг.

Прокурор шийдвэр гаргахад хэрэг, материалд авагдсан нотлох баримтыг тодруулах, нягтлах, үнэлэхэд бүхэлдээ чиглэгддэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд эрүүгийн хэрэг, материалыг хүлээн авах, шилжүүлэх ажиллагааны явцад нууцлал алдагдах, хэрэг, материалаас хуудас алдагдах, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт баримт, мэдээлэл алга болох, үрэгдэх, устгагдах зэрэг ноцтой асуудал гарах эрсдэлээс сэргийлэхэд эрүүгийн хэрэг, материалыг хүлээн авах, шилжүүлэх журам зохицуулдаг бол энэхүү журмын хэрэгжилтэд прокурор хяналтаа чиглүүлж байх шаардлагатай. Мөрдөгч хавтаст хэргийг зориулалтын саванд хийж, лацдаж битүүмжлээгүй, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд хэргийг шилжүүлэхдээ анхаарах асуудлуудын талаар мөрдөгч, туслах ажилтнуудад зөвлөж, сануулж байх хэрэгтэй. Танд тусалж болон хамтран ажиллаж ажил гүйцэтгэж байгаа албан хаагчийн мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой эерэг зөвлөгөөг та цагийг тааруулан зохимжит байдлаар илэрхийлдэг байх ёстой билээ.

Прокурорын байгууллагын цахим системд хэргийн бүрдэл, хэрэг, материалд холбогдуулан гаргасан шийдвэрийг бүрэн, гүйцэт, үнэн, зөв бүртгүүлэх ёстой бөгөөд энэ нь хэргийн хугацаа алдах, хэргийн хянан шийдвэрлүүлэх гэж буй явц байдал зэргийг хянах, шалгалт, судалгаа хийх зэрэгт чухал ач холбогдолтой. Иймд хэргийг хянах явцдаа цахим системд хэргийн мэдээлэл бүрэн бүртгэгдсэн эсэх, хэрэгт нотлох баримтын бүрдүүлбэр бүрэн эсэхэд хяналт тавьдаг байх ёстой юм. Энэ талаар ажлаа төлөвлөхдөө цаг хуваарилж өгөх, тухай бүр хянах зэргээр зохицуулан, процессын ажиллагааг шуурхай, хүртээмжтэй хянаж, чиглүүлэх хэрэгтэй.

3.1.2 Сургалт, судалгааны ажилд оролцох асуудал

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн нь Прокурорын байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Улсын ерөнхий прокурорын албан даалгаврыг хэрэгжүүлэн прокуроруудад зориулан сургалтуудыг зохион байгуулах, хууль тогтоомжийн судалгаанууды үе шаттай хийж, үр дүнг танилцуулах зэрэг ажлуудыг хариуцан зохион байгуулдаг байна.

Прокурор та прокурорын байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудад цаг заваа зориулан сууж, суралцаж өөрийн мэдлэг, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлж, өөрийн суралцахыг хүссэн сургалтын сэдвийн талаар саналаа сургалт, судалгааны ажил хариуцсан прокуроруудад уламжилдаг байх хэрэгтэй.

Та сургалтад хамрагдаж цагаа зохицуулахдаа нэг удаагийн, уламжлалт арга барилаар зохион байгуулахаас татгалзаж, давтамжтай, үргэлжилсэн хэлбэрээр, тухайн сэдэвт хамаарах олон агуулга бүхий цогц мэдлэгийг олгох, мэргэшүүлэхэд чиглүүлэх шинэлэг, үр дүнтэй арга хэлбэрийг сонгоорой.

Улсын ерөнхий прокурорын газар нь Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургуулиудтай сургалт, судалгааны чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулсан нь прокурорыг чадавхжуулах, эрдэм шинжилгээний хурал, семинарыг хамтран зохион байгуулах, онол, арга зүйн сурах бичиг, ном, гарын авлага гаргах, оюутан дадлагажуулах зэргээр хамтран ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байна. Мөн та өөрийн прокурорын

байгууллагын удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй эрхээрээ “Сургалтын цахим систем”-д нэвтэрч зөвхөн ажлын байрнаасаа суралцах бус харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглан орон зай, цаг хугацаа харгалзахгүйгээр хүссэн цагтаа, хүссэн газраасаа суралцах нөхцөл боломжийг өөртөө олгох боломжтой юм.

Судалгааны ажлуудыг прокурорын байгууллагын үйл ажиллагаанд судалгааны талаас эх сурвалж, дэмжлэг болгоход анхаарч, эрдэм шинжилгээний хурал, семинарт илтгэл хэлэлцүүлэх, судалгааны үр дүнгээр гарын авлага гаргахад өөрийн сонирхсон сэдвийн хүрээнд хамтран оролцох зэргээр идэвхтэй байх хэрэгтэй.

3.1.3 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох асуудал

Прокурор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар зарим ажлуудыг зохион байгуулдаг. Гэвч прокурорууд энэ ажлыг заавал хийх шаардлагагүй ажил мэтээр хойшлуулах, журмаар зохицуулсан тул шаардлагаар 1-2 ажил хийж, бүтээх, байгууллагын тоон үзүүлэлтэд тааруулж ажиллах зэргээр хайнга хандах тохиолдол цөөнгүй байдаг. Та хэрэг, материал хянахдаа гэмт хэргийн талаарх шалтгаан, нөхцөлийг үүсгэсэн нөхцөл байдалтай танилцаж, хэргийн байдлаас шалтгаалан мэдэгдэл бичих, тодорхой нөхцөл илэрсэн тохиолдолд шалгалт, судалгаа явуулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхээр подкаст, шторк, контент, зурган постер бэлтгэх зэргээр бүтээлч хандах, судалгаа хийх, судалгааны ажлын үр дүнгийн талаарх мэдээллийг өдөр тутмын сонин, хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийтлүүлэх зэргээр идэвх гаргах нь зүйтэй.

3.1.4 Төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлийн ажилд оролцох асуудал

Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хуулиар хүлээсэн чиг үүргээ иргэд олон нийтэд сурталчлах, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, зөрчил, эрүүгийн хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг бүрэн төлүүлэх, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чиглэлээр мэргэших, идэвх санаачилгаа нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөрчил болон эрүүгийн хэргийн улмаас болон бусад иргэний хэрэгт төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг гаргуулах ажиллагаанд оролцож улсын төсөвт төвлөрүүлэхээр шүүхээр шийдвэрлүүлэх нь прокурорын мэргэжлийн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой үүрэг юм. Иймд ажлын төлөвлөгөөндөө төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлийн ажилд идэвхтэй оролцох талаар тусгах нь зүйтэй.

3.1.5 Бусад асуудлуудын талаар

Ажлын зохион байгуулалтыг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх зарим асуудлуудын талаар авч үзье. Тухайлбал: Байгууллагын соёлын талаар судлах, байгууллагын ажилтнуудтай уялдаа холбоогоо зөвөөр дэмжих, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон ажиллах чадвараа сайжруулах, хариуцлагын мэдрэмжийг сайжруулах, идэвх чармайлттай байх зэрэг юм.

3.2 Гадаад орнуудын сайн туршлага

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд Америкийн нэгдсэн улсын хуульч бэлтгэх, прокуророор ажиллахад тавигдах шалгуурын талаар илүүтэйгээр авч үзэх ба Герман улсын зарим сайн туршлагын талаар товч дурдана.

Америкийн нэгдсэн улс, Герман улсын прокурорыг бэлтгэх тогтолцоо, асуудал

нь шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд мэргэшсэн, ёс зүйтэй, хариуцлагатай прокурор бэлтгэх байдаг байна.

Америкийн нэгдсэн улсын хувьд.

Энэ хэсэгт Америкийн Нэгдсэн Улс (цаашид АНУ)-ын хуульч бэлтгэж буй тогтолцооноос хуульч прокурор өөрийн ажлын зохион байгуулалт, цаашдын төлөвлөгөөнд тань авч хэрэгжүүлж болох зарим сайн туршлагыг авч үзнэ.

АНУ-д хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага нь ирээдүйн хуульчдыг бэлтгэхэд өргөн хүрээтэй оролцдог, бодлогын шинжтэй шийдвэрүүдийг гаргадаг, хууль зүйн боловсролыг мэргэжлийн зэргийн түвшинд олгож хуульчаа бэлтгэдэг, сургалтын агуулга нь практикт түшиглэсэн байдаг зэрэг цөөнгүй онцлогийг дурдаж болох юм.

АНУ-ын хувьд муж бүр хуульчийн мэргэжлээр ажиллаж буй тусгай албан хаагчдыг бэлтгэх өөрийн уламжлал, онцлог бүхий эрх зүйн тогтолцоотой тул тэдгээр нь харилцан адилгүй байдаг.[8] Жишээ нь, боловсролын хувьд тавигдах шаардлагыг авч үзвэл ихэнх муж хууль зүйн мэргэжлийн зэрэг (Juris Doctor) эзэмшсэн байхыг шаарддаг бол зарим мужид үүнээс гадна гадаадын улс оронд хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн эсхүл практикийн хуульчийн удирдлага дор тодорхой хугацаанд дадлагажиж ажиллан, суралцсан хүнд хуульчийн шалгалт өгөх эрх нь нээгдэнэ. Мөн Барын холбоо (Bar Association)-ны эрх зүйн байдлын хувьд муж бүр харилцан адилгүй зохицуулалттай. Тухайлбал, Нью-Йоркийн, Аризонагийн, Арканзасын, Колорадогийн, Делаверын Барын холбоод, мөн Америкийн болон Виржиниагийн Барын холбоод зэрэг нь сайн дурын гишүүнчлэлтэй, хувийн эрх зүйн хуулийн этгээд байдаг. Эдгээр Барын холбоо гишүүдийнхээ нийгмийн асуудалд анхаарах, мэргэжлийн хөгжлийг нь дэмжих, тодорхой лобби үйл ажиллагаа явуулах зэрэг чиглэлээр ажилладаг. Харин Алабама, Аляаск, Жиоржиа муж болон Колумбиагийн дүүргийн Бар нь заавал гишүүнчлэлтэй, хуульчдад мэргэжлийн дүрэм, ёс зүйн хяналт тавьж хариуцлага тооцдог нийтийн эрх зүйн шинжтэй субъект байдаг.[9] Цаашилбал Техас мужийн Бар нь тус мужийн Дээд шүүхийн харьяанд ажилладаг. Сайн дурын гишүүнчлэлтэй Барын холбоо бүхий мужуудын хувьд мужийн Дээд шүүх нь холбогдох дүрэм, журмаа батлан гаргах, хэрэгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Жишээ нь, Нью-Йорк мужид Давж заалдах шүүхийн харьяа Нью-Йорк мужийн хуульчийн мэргэжлийн шалгалтын зөвлөл нь хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулдаг бол хуульчдын сахилга хариуцлагын асуудлыг нь тус шүүхийн харьяа хороод хариуцдаг ажээ.[10]

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болсон нь Холбооны шүүх (Federal Court)-д шууд төлөөлөх эрх үүсгэхгүй. Үүний зэрэгцээ тухайн мужид ажиллах эрхтэй хуульч өөр мужийн дүүргийн шүүхэд төлөөлж оролцох тохиолдолд зөвшөөрөгдсөн байх шаардлага тавигддаг. Зарим мужийн прокурорууд тусгайлсан сургалтад хамруулсны дараа уг зөвшөөрлийг олгодог.

Дээрх нөхцөл байдлаас хамааралтай хуульч прокуророор ажиллахыг зөвшөөрөх байдал нь харилцан адилгүй байна. Холбооны дүүргийн прокурорын 60 гаруй хувь буюу 56 нь тухайн прокурорын газар байрлаж буй мужид хуульчаар ажиллахад эрх авсан байхыг шаарддаг. Харин 40 гаруй хувь буюу 39 дүүргийн прокурор тодорхой нөхцөлтэйгөөр өөр мужид ажиллах зөвшөөрөл авсан хуульч шүүхийн

[8] Lawyer Legion, State Bar Associations https://www.lawyerlegion.com/associations/state-bar

[9] National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements https://reports.ncbex.org/comp-guide/charts/chart-1/#1610142352111-e56b1dc2-06b5

[10] Нью-Йорк мужийн давж заалдах шатны шүүхийн албан ёсны цахим хуудас http://ww2.nycourts.gov/attorneys

өмнө төлөөлөхийг зөвшөөрдөг. Үүнээс 13 дүүргийн прокурорын газар АНУ-ын аль нэг мужид зөвшөөрөлтэй хуульчийг хүлээн зөвшөөрдөг. Жишээ нь, Канзас мужийн дүүргийн прокурор зөвхөн тухайн мужид болон Миссури мужийн Баруун дүүргийн шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчийг зөвшөөрдөг. Колумби мужийн дүүргийн прокурор тухайн хуульчийн тогтвортой суурьшин ажиллах газрын байршлыг нь харгалзан үздэг бол Нью-Йоркийн хойд дүүрэг, Коннектикут, Винсконсин мужийн зүүн дүүрэгт харьцангуй уян хатан буюу аль нэг мужид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байхыг шаарддаг байна.[11]

Боловсролын хувьд дийлэнх муж хуульчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болох, прокуророор ажиллахыг хүсэж буй хуульч нарт хууль зүйн мэргэжлийн дээд боловсролын зэрэг (J.D.)-тэй байхыг шаарддаг бөгөөд уг зэргийг америкийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуульд суралцаж авсан байх ёстой. Түүнчлэн Нью-Йорк зэрэг зарим мужид гадаад улсад хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн хүнийг хуульчийн мэргэжлийн шалгалт өгөхийг зөвшөөрдөг, улмаар прокуророор ажиллах эрх авах шалгалт өгөхийг зөвшөөрдөг бөгөөд үүний тулд тухайн эзэмшсэн боловсрол нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад тавигддаг шаардлагыг хангаж байгаа эсэх, суралцсан хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн эсэх, хугацааны хувьд тус улсад тавигдаж буй шаардлагыг хангасан эсэх, агуулгын хувьд нийтлэг эрх зүйд суурилсан бөгөөд тус улсын хуулийн сургуулиудад үздэг хичээлтэй дүйцэхүйц эсэхэд тухайлан дүгнэлт гаргаж, шалгалтад оруулах эсэхийг шийддэг.

Зарим тохиолдолд тус улсын магадлан итгэмжлэгдсэн сургуульд хууль зүйн магистрын зэргийн сургалтад хамрагдсан байхыг шаарддаг байна. Калифорни, Виржиниа, Баруун Виржиниа зэрэг мужид гадаад улсад суралцсан хуульч эсхүл хууль зүйн мэргэжлийн зэргээр суралцаагүй боловч практикийн хуульчийн удирдлага дор ажиллан суралцсан болон тухайн мужийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн сургуульд дөрвөн жилийн хугацаанд суралцсан хуульч шалгалт өгөх боломжтой.[12][13]

Дээрх өндөр шалгуур, бүтэц зохион байгуулалтын шаардлагатай шалгалтуудад тэнцсэн мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй, хариуцлагатай, шударга прокуроруудыг мужуудад томилон ажиллуулах ба шинээр томилогдсон прокурорууд нь мэргэжлийн хариуцлагын хүрээнд ажлаа сараар төлөвлөн үр дүнг, дээд шатны прокуроруудын өмнө хариуцан ажилладаг байна. Мөн өөрсдийн хувийн хөгжил, сэтгэл зүйд хамааруулан ажлын зохион байгуулалт хийдэг ба мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн онцлогийг харгалзан байгууллагын хөгжих бодлогыг баримталж, хувийн хөгжлийн SWOT шинжилгээний аргыг түлхүү ашиглан ажлаа төлөвлөдөг байна.[14]

Герман улсын хувьд.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад (цаашид Герман) хуучны Пруссийн засгийн газраас авч хэрэгжүүлж байсан нэгдмэл сургалтын тогтолцоо нь 1877 оноос эхлэн шүүгч, өмгөөлөгч, прокурор болон бусад бүх л хуулийн мэргэшлийн үндэс суурь болсоор иржээ. Энэхүү тогтолцоо нь улсын шалгалтаар төгсдөг их сургуулийн дөрвөн жилийн сургалтыг хоёр жил болгон богиносгосон, хуульч бэлтгэх дадлагын практик сургалтаас бүрддэг.

[11] Нью-Йорк мужийн давж заалдах шатны шүүхийн албан ёсны цахим хуудас http://ww2.nycourts.gov/attorneys

[12] The State Bar of California, Admissions https://www.calbar.ca.gov/Admissions/Requirements/Education

[13] https://barexam.virginia.gov/

[14] Сэдэв 3-т дурдсан хэсгийг эргэн харах

Германд хуульч болохын тулд хоёр шатны шалгалт өгөх ёстой бөгөөд нэгдүгээр улсын шалгалтыг их сургууль төгсөхдөө өгнө. Нэгдүгээр улсын шалгалт нь заавал үзэх ёстой салбар гурван эрх зүй, их сургуульд сонгон суралцсан хичээл буюу гүнзгийрүүлэн судалсан салбар хичээлийн агуулгаас бүрдэнэ. 2002 онд хийсэн шинэтгэлийн хүрээнд сонгон суралцах хичээлээр авдаг байсан их сургуулийн шалгалтыг нэгдүгээр улсын шалгалтын нэг хэсэг болгож өөрчилсөн байна. Ийнхүү их сургууль төгсөж нэгдүгээр улсын шалгалтад тэнцэн, хуульч бэлтгэх дадлагад амжилттай хамрагдсан бол хоёрдугаар улсын шалгалт өгөх эрхтэй болох бөгөөд түүнд тэнцсэнээр мэргэшсэн хуульч болно. Энэхүү тогтолцооны гол давуу тал нь шинжлэх ухааны гүнзгий мэдлэг эрчимтэй олгож, эрх зүйн ээдрээтэй маргааныг шийдвэрлэхэд сургах ба хоёр шатны шалгалт нь суралцагчийн чадварыг үнэлэх оновчтой шалгуур хэмээн үздэг. Германы хуульч бэлтгэх тогтолцоо нь шүүгчийн ур чадварыг суралцагчдад эзэмшүүлсэн байх ёстой хэмээх үзэл баримтлалд суурилдаг. Өөрөөр хэлбэл, шүүгчээр ажиллах ур чадвар эзэмшсэн хуульч бусад бүх төрлийн хуульчийн ажлыг хангалттай гүйцэтгэх ур чадвартай гэж үздэгтэй холбоотой. Үүнийг Einheitsjurist буюу хуульч бэлтгэх нэгдмэл тогтолцоо гэж нэрлэдэг. Ийм үзэл баримтлалд суурилдаг тул Холбооны Шүүгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зохицуулалт нь хуульч бэлтгэх эрх зүйн үндэслэл болдог байна.

Герман Улсын 11 муж улсад прокуророор томилогдохын өмнөх шалгалтын тусдаа журам үйлчилдэг хэдий ч эдгээр журам, зохицуулалтын үндсэн агуулга адил, холбооны улс даяар нэгдмэл зарчим баримталдаг. Мөн прокуророор томилогдохын өмнө эссэ бичүүлдэг нь тухайн хүний аливаа асуудлыг таньж тогтоох, цэгцтэй, ухаалаг байдлаар дүн шинжилгээ хийх, хамгийн чухал нь бичгээр бусдыг үндэслэлтэйгээр ятган үнэмшүүлэх, үр дүнтэй харилцах чадварыг шалгадгаараа онцлог юм. Түүнчлэн гүйцэтгэлийн шалгалт хэмээх шалгалт нь манай улсын бодлогын шалгалттай агуулгын хувьд ойролцоо боловч бодит амьдралд тохиолдож болох нөхцөлд илүү ойртуулсан үйл баримтад холбогдох баримт материалтай танилцаж дүн шинжилгээ хийдэг. Түүнээс гарсан үр дүнд үндэслэн шинээр томилогдсон прокуроруудад зориулсан сургалтын хөтөлбөрийг баталж, ажилд нь мэргэшүүлэхэд нь анхаарч өгдөг. Мөн тодорхойгүй, зөрчилдөөнтэй эсхүл үйл баримт, мэдээлэл дутуу зэрэг бодит нөхцөлд тулгарч болох асуудалтай хэрхэн ажиллах талаар прокурорууд өөрсдөө суралцаж, өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлдэг байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

1. Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, Хоёрдугаар дэвтэр, УБ., 2008.
2. П.Нарантуяа, “Хууль зүйн боловсролын тогтолцоонд шинэ стандарт үйлчилнэ” (Ярилцлага), Монголын Хуульчдын холбоо, 20176.
3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
4. Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
5. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012.

Гадаад хэлээр

1. Adam S. Minsky, Court Cites Student Loans As Reason To Deny Bar Admission To New Lawyer, Forbes, Jan 23, 2020, https://www.forbes.com/ sites/adamminsky/2020/01/23/ court-denies-bar-admission-to-new-lawyerdue-to-student-loans/?sh=3fb76b09548f

2. American Bar Association, 1969 Standards of the American Bar Association for Legal Education.
3. American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools.
4. American Bar Association, Survey of Law School Curricula 2002-2010.
5. Charles R. McManis, The History of First Century American Legal Education: A Revisionist Perspective, 59 WASH. U. L. Q. 597 (1981), https://openscholarship.wustl.edu/law_lawreview/vol59/iss3/2
6. Christopher P. Banks, The American Legal Profession: The Myths and Realities of Practicing Law. Thousand Oaks: SAGE Publications, ISBN 9781506333137, 2017.
7. Daniel R. Hansen, Do We Need the Bar Examination–A Critical Evaluation of the Justifications for the Bar Examination and Proposed Alternatives?, 45 Case W. Rsrv. L. Rev. (1995), p. 1192, https://scholarlycommons.law.case. edu/caselrev/vol45/iss4/32; 53
8. Marion R. Kirkwood and Willam B. Owens, (n.d.). A Brief History of the Stanford Law School, 1893–1946 (PDF), S.U. School of Law (Report), p. 1, https://web.archive.org/web/20120407053200/http://www.law.stanford.edu/ school/history/historysls.pdf
9. James M. Concannon, The Other Law Schools of Early Day Kansas, J. KAN B.ASS'N, Nov. 1996.
10. Lawrence M. Friedman, A History of American Law (1973).
11. Moline, Brian J., Early American legal education, Washburn Law Journal Vol 42, p. 42, https://contentdm.washburnlaw.edu/digital/collection/wlj/ id/6369/
12. National Conference of Bar Examiners https://reports.ncbex.org/
13. Нью-Йорк мужийн давж заалдах шатны шүүхийн албан ёсны цахим хуудас, http://ww2.nycourts.gov/attorneys
14. The State Bar of California, https://www.calbar.ca.gov/
15. Survey of Admission Rules in Federal District Courts (PDF), U.S. District Court for the District of Maryland, 2015.
16. Rules of the Court of Appeals for the Admission of Attorneys and Counselors at Law 520.4 (a), https://www.nybarexam.org/Rules/Rules. htm#520.4
17. Supreme Court of Delaware, Rules of the Supreme Court of the State of Delaware, https://www.courts.delaware.gov/rules/pdf/SupremeCourtRules
18. А.Э.Жалинский. Профессиональная деятельность юриста. Введение в специальность. Изд-во «Бек М. 1997
19. Ronald D. Rotunda and Mighael I. Krauss. Legal Ethics in a Nutshell. 2003 Deboran L. Rhode and David Luban. Legal Ethics, 4th (University Casebook Series). 2004

БҮЛЭГ 17. ПРОКУРОРЫН НИЙГМИЙН МЭДРЭМЖ

СЭДЭВ 1: ПРОКУРОР НИЙГМИЙН ОРОЛЦОГЧ БОЛОХ НЬ

1.1 Прокурорын үйл ажиллагааны зарчим ба нийгмийн хандлага
1.2 Прокурорын хяналт ба хүний эрхийн мэдрэмж, жендерийн хэвшмэл үзэл

СЭДЭВ 2: НИЙГМИЙН ХОЛБОО ХАМААРАЛ, НӨЛӨӨЛӨЛ

1.1 Нийгмийн мэдрэмжийн зарим ур чадварыг удирдах арга замууд
1.2 Нийгмийн хүрээллийн нөхцөл байдлыг шинжлэн судлах нь
1.3 Прокурорын ур чадвар ба шалгуур

СЭДЭВ 3: НИЙГМИЙН ХАНДЛАГА, НӨЛӨӨЛЛИЙН ЗАРИМ ШИНЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

3.1 Гадаад орны сайн туршлага
3.2 Өсөлтийн сэтгэлгээ ба шинэ чиг хандлагад суурилан бусдад нөлөөлөх нь
3.3. Цахим сүлжээ дахь цаг үеийн үзэл бодол ба олны анхаарал татсан, дуулиант хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нийгмийн хандлага

СЭДЭВ 4: ПРОКУРОРЫН ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ОЛОН НИЙТИЙН ЦАХИМ СҮЛЖЭЭГ АШИГЛАХ ЗОХИСТ БАЙДАЛ

4.1 Прокурорын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
4.2 Прокурор олон нийтийн цахим сүлжээг зохистой ашиглах нь

СЭДЭВ 1. ПРОКУРОР НИЙГМИЙН ОРОЛЦОГЧ БОЛОХ НЬ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд “Прокурор” нь эзэмшсэн мэргэжил, хийж гүйцэтгэж буй ажил, албан тушаалын онцлогоос хамааран нийгмийн харилцаанд ямар хэм хэмжээг баримтлах, ийнхүү нийгмийн харилцаанд оролцохдоо үйл ажиллагаандаа хуульд заасан зарчмыг баримтлах, түүнийг үнэлэх нийгмийн өөр өөр хандлагуудын талаар болон прокурорын хяналтын ажлыг хэрэгжүүлэхдээ хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах асуудлуудыг тодруулан авч үзэх болно.

1.1 Прокурорын үйл ажиллагааны зарчим ба нийгмийн хандлага

Улс орнуудын хууль эрх зүйн тогтолцоо нь тухайн улсын түүхэн уламжлал, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан олон талаар ялгаатай байдаг. XX зуунд эрх зүйн тогтолцоог “нийтийн эрх зүйн” болон “эх газрын эрх зүйн” тогтолцоотой гэж ерөнхийд нь ангилдаг байсан бол өнөө үед дээрх хоёр эрх зүйн тогтолцооны хөгжлийн хандлага нь төстэй болж, холимог эрх зүйн тогтолцоотой улс орнууд нэмэгдэж байна. Ихэнх судлаачид прокурорын байгууллагын чиг үүргийн гол ялгааг нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд прокурор нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн, харин эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд прокурор нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн байдаг гэж үздэг.[1]

Манай улсын прокурорын байгууллага түүний холбогдох хуулийг түүхчлэн харвал

[1] Г.Гантүвшин “...Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын прокурорын байгууллагуудын чиг үүрэг нь өргөн цар хүрээг хамарсан байдаг”, (2022), https://www.arslan.mn/social/news/639862.shtml ярилцлагаас ишлэв.

1940 оны Үндсэн хуульд прокурорын байгууллагын үндсэн чиг үүргийг тодорхойлж, үндсэн хуулийн статустай байгууллага болж, 1976 онд Прокурорын хяналтын тухай хууль батлагдсан бөгөөд 1993 оныг хүртэл үйлчилсэн. 1992 онд үндсэн хууль шинэчлэгдэн батлагдахад түүнд нийцүүлэн 1993 онд Прокурорын байгууллагын тухай хууль болж шинэчлэгдсэн. Улмаар 2002 онд нэмэлт өөрчлөлт орсон бол 2017 онд зарчмын өөрчлөлт орж нэршлийн хувьд Прокурорын тухай хууль болон өөрчлөгдсөн.

Хуульд заасан албан үүргээ биелүүлэх буюу хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулах зэргээр нийгмийн бусад харилцаанд оролцох оролцоо идэвхэждэг байна.

Прокурорын албан тушаалын томоохон чиг үүрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хяналтын явцад дүгнэлт гаргах, шийдвэр гаргах юм. Төрийн албан хаагч бүр шийдвэр гаргахгүй бөгөөд төрийн алба хаагч зохих ажиллагааг, хийж танилцуулаад дээд шатны удирдлага дарга хянаж, шийдвэр гаргадаг бол прокурорын нэг онцлог нь прокурор бүр шийдвэр гаргадаг. Ийнхүү шийдвэр гаргах эрх нь шууд хамааралтайгаар прокурорт өндөр хариуцлага, үүрэг оногдуулж байна гэсэн үг.[2]

Дээрх хариуцлагатай чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарын зан байдал, хандлага, харилцаа нөлөөлөх асуудал тэргүүн эгнээний байр суурь эзэлдэг. Иймд прокурор нь шийдвэр гаргахдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын хувийн байр сууринд автах ёсгүй билээ. Иймд хуульд заасан дараах зарчмуудыг өөрийн ажил үүргийн хүрээнд бүрэн баримтлах нь зохистой.

Тухайлбал:

Доктор, профессор Г.Совд хэлэхдээ: “Эрх зүйн үйлчилгээний хүрээнд үндсэн зарчмыг эрх зүйн аль ч салбарт ялгалгүй түгээмэл үйлчилдэг нийтлэг үндсэн зарчим, зөвхөн аль нэг тодорхой салбар эрх зүйн үндсэн зарчим, салбар эрх зүйн доторх тодорхой хэсэгт үйлчилдэг институтийн үндсэн зарчим гэж ангилдаг”[3] гэсэн байдаг. Мөн Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа хэлэхдээ: Эрх зүйн хэм хэмжээ нь зан үйлийн хатуу загварыг тогтоодог бол зарчим нь тодорхой хэрэг хянан шийдвэрлэхэд биш харин ерөнхий чиг баримжаа, үнэлэмжийн үндсийг зааж өгнө гэж[4] тэмдэглэсэн байна. Тиймээс эрүүгийн процессын хүрээнд хуульчлагдсан зарим зарчмуудыг товчхон тодруулан авч үзье. Үүнд:[5]

- Хууль ёсны зарчим
- Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх
- Хэргийн бодит байдлыг тогтоох
- Гэм буруугүйд тооцох
- Шударга ёсны зарчим юм.

Дэлгэрүүлбэл:

Хууль ёсны зарчим: Энэхүү зарчим нь “Хууль дээдлэх”, “Хуулийг чандлан сахих” утга санааг өөртөө агуулж байдаг. Тиймээс ч энэхүү журмын онол, арга зүйн мөн чанарыг тухайлан харуулах шаардлага бий. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

[2] Г. Бадамханд: Прокурор бол алдах эрхгүй алба сэдэвт ярилцлагаас ишлэв.
[3] Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (УБ, 2022), 10.
[4] Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, суурь ойлголт тулгамдсан асуудал, (УБ, 2005), 89.
[5] Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын үндсэн асуудал, (УБ, 2018), 84-103.

ажиллагаанд хуулийн зүйл заалтыг чандлан баримтлах хатуу журам үйлчилнэ. Тухайлбал: Үзлэг, нэгжлэг хийх хуульчлагдсан журмыг зөрчсөн л бол олдсон, олдох байсан баримт, сэлт, мэдээлэл нотлох ач холбогдлоо алдана. Хуулийн зүйл заалтын утга агуулгын зөв танин хэрэглэх мэргэжлийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг өөртөө төлөвшүүлэх учиртай.[6]

Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх: Хууль ёсоор хүлээсэн хариуцлага, ял шийтгэл нь тухайн хүнд сэтгэлтийн шаналал, зовлонг учруулах боловч энэ нь эрүү шүүлтэд шаналган зовоох шинжтэй үйлдэл, үйл ажиллагааг хуулиар хориглодог мөн түүнчлэн үүнтэй холбоотойгоор 1984 онд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” батлагдсан бөгөөд манай улс 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нэгдсэн ба эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүн бүрд баталгаатай эдлүүлэх үүргийг хүлээсэн билээ.

Хэргийн бодит байдлыг тогтоох: Уг зарчмын гол утга учир нь аливаа эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж хянан шийдвэрлэхдээ яллах, цагаатгах, хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоохоор илэрхийлэгдэнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн өмнө яллах, өмгөөлөх тал эн чацуу эрх эдлэх бөгөөд тэрхүү боломж нөхцөлийг шүүх, тухайн шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч бүрэн бүрдүүлэх ёстой.

Гэм буруугүйд тооцох: Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан бөгөөд нэг талаас төр, түүний байгууллага, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төрийн нэрийн өмнөөс эрхлэн хэрэгжүүлэгч иргэн нөгөө талаас гэмт хэрэг өдүүлэн түүндээ яллагдаж буй этгээдийн хоорондох харилцааны агуулга мөн чанараар тодорхойлогдоно.

Шударга ёсны зарчим: Шударга ёс нийгмийн амьдралын хүрээнд тулгуур хэм хэмжээ болон үйлчилсэн цагт хэнд ч болов амьдралынхаа утга учрыг ухаарч зөвхөн чин ариун эрмэлзэл, шударга хөдөлмөрөөрөө өмч хөрөнгөтэй, хангалуун амьдралтай болж чадна, үнэн хэзээд ч, ямар ч тохиолдолд ялна, ухаалаг нийгэм, төр түүнд үйлчилнэ гэсэн өөдрөг үзэл бодол, итгэл үнэмшил бүрэлддэг бөгөөд ингэснээрээ бодгаль хүний авьяас билэг, хичээл зүтгэл, урам зориг нь улам идэвхжиж улс эх орны хөгжин дэвших үндэс суурь нь тавигдахад эергээр нөлөөлж ирээдүй нь өөдлөн тодордог жамтай.

Прокурорын бүхий л үйл ажиллагаа төрийн нэрийн өмнөөс явагддаг, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахад чиглэгддэг. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина. Шүүх хуралд төрийг төлөөлж оролцоно.

Гэмт хэрэг хийсэн, амь нас хохирсон гээд тухайн гэмт хэргийн бодит байдал зураг төрхийг өдөр бүр харж, уншиж, танилцана гэдэг нь тийм ч аятай таатай ажлын нөхцөл биш гэдэг нь үнэн. Уншиж байгаа материал болгон нь гомдол тээсэн үнэн зөвийг тогтоож өгөхийг хүссэн байдаг. Тиймээс ч онцгой нөхцөл гэж төрөөс зөв тогтоож өгсөн байдаг тул тэр хэмжээгээрээ хариуцлагатай байх бөгөөд үйл ажиллагаандаа тусгай зарчмуудыг баримтлах нь зүйтэй юм.

Нийгмийн тогтсон ба хувьсах хандлага

Прокурорын ажил, албан үүрэгтэй холбоотойгоор нийгмийн хүрээллээс цөөнгүй төрлийн хандлага үзүүлдэг. Нийгмийн тогтсон хандлага гэдэг нь олон нийтийн

[6] Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын үндсэн асуудал, (УБ, 2018), 85.

баримжаа хэрэгцээг ухамсарлах хэлбэр бөгөөд үнэлэлтийн хоёр дахь хэлбэр. Нийгмийн тогтсон хандлага төлөвших үндсэн зам нь бие хүний хувийн туршлага практик амьдралд шууд оролцож нөлөөлөх явдал болно. Үүнд : тогтсон хандлага нь тухайн зүйлд итгэл төгс байх, буруутгах эрмэлзэл, тэмүүлэл ба шүүмжлэлтэй байх зэрэг сэтгэлийн хөдлөлөөр илэрч, хэрэгждэг байна.[7]

Тогтсон хандлага нь ухамсартай буюу ухамсаргүй хэлбэрээр илэрдэг. Мөн зан төлөвийн үндсэн дээр бий болдог. Жишээлбэл: Тухайн ажил мэргэжлийн талаар дутуу ойлголттой хүмүүсийн хандлага цөөнгүй юм. Сэтгүүлч мэргэжлийг зөвхөн хүнээс ярилцлага авдаг төдийгөөр, эмчийг гоё сайхан инээмсэглэж, бусдыг эмчилдгээр, менежерийг дандаа завгүй, яаруу, сандруу хүнээр төсөөлдөг. Энэ нь хүмүүст суусан тогтсон хандлага юм. Түүнчлэн прокурорын мэргэжлийн талаар буруу ойлголттой хүмүүс прокурорын мэргэжлийг хүний эрхийг зөрчдөг, бусдыг загнаж, буруутгадаг, муу талын дүрээр дүрслэх нь түгээмэл хандлага болсон байна.

Прокурор албан үүргээ гүйцэтгэхдээ нийгмийн тогтсон хандлагад үл автаж, асуудлыг олон талаас нь ул суурьтай эргэцүүлэн бодож, өөр талаас нь хардаг байх шаардлагатай. Энэ нь тогтсон хандлагад тулгуурлан хэргийг шийдвэрлэхээс зайлсхийх нийгмийн мэдрэмжийн давуу тал юм.

1.2 Прокурорын хяналт ба хүний эрхийн мэдрэмж

Прокурорын шийдвэр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэх онцгой үр дагавартай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллахдаа хүний эрхийн нарийн мэдрэмжтэйгээр ажил үүргээ гүйцэтгэх нь зүй ёсны шаардлага билээ.

Хүний эрх гэдэг ойлголт нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлбэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг. Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм.

Хүний эрх нь ялгаварлалгүй, салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай, хүн бүрд түгээмэл байдаг. Хүний эрхийг хамгаалах, эдлүүлэх үүргийн прокурор хуулиар хүлээсэн. Иймд прокурорын шийдвэр нь суурь зарчмуудыг баримталсан байх нь зүйтэй. Гаргасан шийдвэрээ бусадтай харилцах явцад зөв ойлгуулж чадаагүй бол нөгөө хүн дутуу, зөрүүтэй, буруу ойлголттой үлдэх нөхцөл өөрөө бүрэлдэж байдаг. Учир нь тэрхүү шийдвэрийг хүлээж авч байгаа этгээд нэг талаараа өөрийнх нь эрх зөрчигдөж байгааг ойлгоогүй, нөгөө талаараа эрх зүйн мэдлэг дутмаг байдлууд нөлөөлдөг. Прокурор хүн дотоод итгэл үнэмшилдээ гагцхүү хуульд захирагдана, хуулиа дагах гэсэн хандлагаар хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нь хуульд үндэслэсэн итгэл үнэмшлийг бий болгож, нийгмийн хүрээллийн сөрөг дайралтаас өөрийгөө хамгаалах арга хэрэгсэл болдог.

Манай орны эрх зүйн тогтолцоо нь агуулга, хууль зүйн техник, эрх зүйн эх сурвалж, арга зүй талаасаа Ром-Германы эрх зүйн тогтолцоонд хамаарах ба энэ утгаараа нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулалтад оруулах шаардлага тавигдаж байдаг. Иймд зөв итгэл үнэмшилтэйгээр хуулийг хэрэглэх нь хүний эрхийн баталгааны онолын болон практикийн чухал ач холбогдолтой юм.[8]

Тухайлбал, хэргийг шалгах явцад тухайн хүнийг дарамталж байна уу, хуулийн дагуу хэргийг шалгаж байна уу, бага насны хүүхдэд холбогдох хэргийг хуульд заасан тусгай журмын дагуу шалгаж байна уу, хүнийг хуулийн дагуу баривчилж, цагдан

[7] Д.Нацагдорж Нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал УБ, 1996 он
[8] П.Баянбаатар, Хүний эрх, онол арга зүйн сэтгүүл, (2018/02), 80.

хорьж байна уу, хоригдож байхдаа эрх нь зөрчигдөж байна уу гээд маш олон зүйл дээр хүний эрх талаас нь хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, өөрчлөх арга хэмжээ авч, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр ажилладаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаж, шүүхээр шийдвэрлүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд прокурорын хяналтын үйл ажиллагаа хэрэгжсээр байдаг. Хэдийгээр тухайн хүн гэмт хэрэг хийсэн ч "хүн" гэдэг утгаараа хуульд заасан эрхээ бүрэн эдлэх ёстой. Нөгөө талаараа хохирогчийн ч эрхийг давхар хамгаалж байгаа билээ.

Прокурор өөрийн хяналтын чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх, хэргийн оролцогч, өмгөөлөгчтэй харилцахдаа ялгавартай байдал гаргахгүй хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга зөв шийдвэрлэж чадахуйц мэдлэг, харилцааны соёлтой байх, прокурорт хандаж гаргасан гомдол, хүсэлт мэдээлэлд анхааралтай хандаж шуурхай шийдвэрлэх, ойр дотно харилцаатай хүмүүс, өмнө нь ажиллаж байсан, эрх ашгийг нь ямар нэгэн хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэний хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй байх үүрэгтэй.

Дээрх үүргээ эс биелүүлж, хэргийн оролцогч, өмгөөлөгч, бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа аашилж зандрах, айлган сүрдүүлэх, догшин хэрцгий харилцах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргах, хувийн сонирхлын үүднээс харьяаллын бус, бусдын хяналтад байгаа хэрэг материалтай танилцах, зөвлөгөө өгөх, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавих, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож дарамт шахалт үзүүлэх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах, саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэрэг материалын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэх юм бол хариуцлага хүлээнэ.[9]

Хүний эрхийн тухай ойлголт.

Хүний эрхийн асуудлыг сонгодог хэлбэрээр нь гаргаж тавьсан дэлхийн анхны баримт бичиг бол Францын 1789 оны "Хүний болон иргэний эрхийн тунхаглал" билээ. Энэ тунхаглалд "Хүмүүс эрхийнхээ хувьд адилхан эрх чөлөөтэй төрж, тэр хэвээрээ үргэлжлэх ёстой. Төрийн аль ч холбоо хүний зайлшгүй, салшгүй эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Эрх чөлөө, өмч, аюулгүй байдал, дарлалыг эсэргүүцэхийн утга нь энэ мөн" [10] гэжээ. 1779 оны АНУ-ын Тусгаар тогтнолын тунхаглал, 1787 оны АНУ-ын Үндсэн хууль тус тус батлагдсан явдал юм.

Тунхаглалд "Бид дараах үнэнийг зайлшгүй гэж үзнэ. Үүнд: Бүх хүн тэгш эрхтэйгээр заяагдсан, тэд өөрийг нь бүтээсэн бурхнаас бэлэглэсэн амьдрал, эрх чөлөө, аз жаргалын төлөөх тэмүүлэл гэсэн хэд хэдэн салшгүй эрхтэй. Энэ эрхүүдийг хангахын тулд удирдуулж байгаа түмэн олны саналын үндсэн дээр байгуулагдсан, шударга засаг хүмүүсийн дотроос байгуулагдан ажиллах ёстой" гэсэн байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "...айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн" гэж тодорхойлсон нь хүний эрхийн гол үзэл санаа болсоор иржээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил,

[9] Хуульчийн ёс зүй гарын авлага (УБ, 2013), 20.

[10] Хүний эрх, онол арга зүйн сэтгүүл, 2017. 2 дахь хэвлэл, 6 дахь тал

албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж хуульчилсан байдаг. Тиймдээ ч Үндсэн хуулийнхаа дагуу бүх хүн ямар ч нөхцөл, байдалд хууль ёсны эрх тэгш хандлагыг мэдэрч байх эрхтэй тул сэжигтэн, шүүгдэгч, яллагдагч аль нь ч байсан хууль ёсны дагуу эдлэх ёстой эрх эдэлж, үүргээ биелүүлэх нь зүй ёсных юм.

Иймд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах эрх мэдэл бүхий чиг үүрэгтэй албан тушаалтнууд хүн бүрд хүний эрхийн мэдрэмжтэй хандах шаардлагатай юм.

Эрх, эрх чөлөөтэй холбоотой нэр томьёоны тухайд.

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэд орсон байдаг. Хүний эрх, иргэний эрх, үндсэн хуульд заасан эрх, хувь хүний эрх, үндсэн эрх, эрх гэх мэт. Ямар нэр томьёо сонгон хэрэглэхээс үл хамааран энэ нь ямагт төрийн тулгуур хуулиар хамгаалагдаж буй суурь эрхийн тухай асуудал байдаг.[11]

Философи ойлголтын хувьд хувь хүнийг хүндлэх зарчим нь хувь хүний хүсэл зориг, үнэт зүйлсийг чухалчилж, хувь хүний бие даасан байдлыг эрхэмлэх тухай индивидуализмын үзэл санаанаас эхтэй бөгөөд төр, аль нэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхол, үнэт зүйлийг чухалчлах тоталитаризм болон зөвхөн өөрийн ашиг сонирхол, дур зоргыг чухалчлах тухай эгойзмын ойлголтоос ялгаатай гэж үздэг байна.

Бие хүний эрхэмсэг оршихуй, орон байрны халдашгүй байдлыг хангах, иргэний хувийн болон захидал харилцааны нууцыг хамгаалах, холбогдох хуулийн заалтуудыг хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны үе шат бүрд чанд сахих нь ардчилсан нийгмийн мөн чанарыг тодорхойлох нэгэн чухал үзүүлэлт мөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдсэн бодитой алхам бүхэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах эрхийн баталгааны илэрхийлэл болон тооцогддог.[12]

Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа “Хүний эрх нь позитив буюу төрөөс тогтоосон шинж агуулдаггүй, хуулиас үүдэлтэй бус, харин хүний мөн чанартай холбоотой байдаг. Иймд хүний эрхийг төрөөс тогтоох буюу олгох мөн цаг хугацаа, орон зайгаар хязгаарлах боломж байхгүй. Дээрх эрхийг Үндсэн хуулиар тогтоодог бус, хүлээн зөвшөөрдөг. Үүгээрээ хүний эрх хууль зүйн дээд хүчин чадалтай болдог. Иймд нийт үндсэн эрх нь хүний эрхэд суурилдаг гэж үзэж болно[13] гэж тэмдэглэсэн байдаг.

Монголчууд бид өвөг дээдэс, хүнийг “Түмэн бодисын охь, мянган амьтны манлай” хэмээн үнэлж цэгнэсэн байдаг. Энэ үнэлэмжийн ёсоор хүнийг дээдэлж, түүний эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм.[14]

Хуулийг зөв тайлбарлан хэрэглэх, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ёс зүйн асуудал чухал байр суурийг эзлэх юм. Ёс зүй гэдэг нь бүхий л харилцаанд нөлөөлж байдаг хамгийн чухал зүйл бөгөөд өндөрт өргөгдөх зүйл юм. Хүний эрхийн мэдрэмжид ч ёс зүй өөрөө өргөн хүрээндээ нөлөөлж байдаг. Учир нь нийгмийн

[11] Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол, арга зүй, хэрэгжилт, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, (УБ 2017), 139.

[12] Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын үндсэн асуудал, (УБ, 2018), 83.

[13] Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол, арга зүй, хэрэгжилт, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, (УБ, 2017), 139.

[14] Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, II дахь хэвлэл, (УБ, 2017), 193.

харилцаа хэргийн оролцогчид тэр тусмаа тухайн хэргийн хохирогч, яллагдагч нартай харилцахдаа өөрийн шийдвэрийг зөв тайлбарлан, зөв ойлгуулах нь чухал ач холбогдолтой.

СЭДЭВ 2. НИЙГМИЙН ХОЛБОО ХАМААРАЛ, НӨЛӨӨЛӨЛ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурор өөртөө нийгмийн мэдрэмжийн талаарх ойлголтыг олж аван, тухайн ур чадваруудыг дээшлүүлэх, албан үүрэгтэйгээ яаж зөвөөр уялдуулан ажиллах зохист аргуудын талаар авч үзэх болно.

2.1. Нийгмийн мэдрэмжийн зарим ур чадварыг удирдах арга замууд

Нийгмийн мэдрэмж гэдэг нь зүгээр бусдын бий болгосон нэр төдийн хий зүйл биш юм. Нийгмийн мэдрэмж гэдэг бодит байдалтай шууд холбоо хамааралтай.[15]

Нийгмийн хандлага нөлөөлөлд чухал нөлөө үзүүлэх хүчин зүйлсийн нэг нь эзэмшсэн мэргэжилдээ ёс зүйтэй хандах хандлагын талаарх ойлголт билээ. Хувь хүний хандлага нийгмийн тодорхой нөхцөлүүдэд болсон үйл явдлуудад тулгуурлан байнгын шинжтэй хувьсаж, өөрчлөгдөж байдаг.

Өмнөх бүлгүүдэд дурдсаны дагуу нийгмийн мэдрэмж, нийгмийн хандлага нь прокурорын ажил үүргээ гүйцэтгэхэд ихээхэн ач холбогдолтой асуудал болдог талаар дурдсан билээ. Тэгвэл нийгмийн мэдрэмжтэй хүмүүс ямар шинж чанарыг агуулсан байдаг талаар болон тэрхүү мэдрэмжийг прокурор хүний хувьд ажил мэргэжилдээ яаж ашиглаж давуу байдлыг бий болгох хэрэгтэй талаар тодруулцгаая. Үүнд:

- Бусдын мэдрэмжийг ойлгодог.
- Бусдыг сайн сонсдог хүмүүс бөгөөд харилцаандаа анхааралтай ханддаг.
- Нийгмийн харилцааг сайн зохицуулж, нийгмийн нөхцөл байдалд сайн дасан зохицдог.
- Хүмүүсийг байгаагаар нь, ялгаатай байдлаар нь хүлээж авдаг.
- Нийгмийн дүрэм, хэм хэмжээний талаар өргөн мэдлэгтэй байдаг.
- Хүсэл тэмүүлэлтэй ажилладаг.
- Ухамсартай, энэрэнгүй хүмүүс байдаг.
- Зөн совинтой, няхуур, оюунлаг хүмүүс байдаг.
- Объектив бөгөөд бусдын харж байгаагаас цааш зүйлийг харж чаддаг.[16]

Нөгөөтээгүүр, ажлын бүлгүүдийн онцлог шинж чанар болох нийгмийн мэдрэмжтэй хүмүүс шинэ санаа оноог нээж, зөвөөр ойлгож, багийн гишүүдийн эрэлт хэрэгцээнд нийцэх хандлагатай болж, шинэ санаа гаргах, ажил асуух, үүрэг хариуцлагаа хуваалцах эерэг орчныг бүрдүүлдэг байна. Прокурор нь нийгмийн мэдрэмжийн ур чадварыг удирдан өөрт бий болгосноор дээрх шинжүүдийг өөрийн ажлын байран дээр бий болгох давуу байдлыг үүсгэх эерэг үр дагавартай юм.

Прокурор хүн бусдыг үл тоосон хандлагатай ажиллаж болох уу? Та өөрийн өгөх хариултыг тунгаан бодож үзнэ үү.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарт нийгмийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчиж буруу зүйл хийж энд ирсэн байна гэдгийг зөвөөр ойлгуулж тэднийг ойлгож мэдэрдэг байх нь хэргийн оролцогч нарт хүндэтгэлтэй хандах хандлагыг харуулна. Ял хүлээлгэх хүнд ялтан шиг л хатуу хандаж, нийгмийн сөрөг хандлага, буруутгалыг мэдрүүлж болохгүй.

---

[15] https://www.rbc.com/en/wp-content/uploads/sites/4/2022/07/july1955.pdf The royal bank of Canada monthly letter, Head office5 Montreal, July 1955

[16] Confocal-manawatu.pbworks.com

Мөн жендерийн мэдрэмжтэй хандах нь Эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хэрэгцээ шаардлага байдгийг хүлээн зөвшөөрч, мөн тэдэнд нийгмийн үйлчилгээг адил тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх эрмэлзэл сэдэл бүхий хандлага юм. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн сэтгэл зүйн онцлог, эрэлт хэрэгцээг ойлгож харилцах, төлөвлөх, боломж нөхцөлийг бий болгох хичээл зүтгэл юм. Хуульд заасны дагуу хийсэн хэрэгт тохирсон ялыг оногдуулах боловч хүнийх нь хувьд хүндэтгэлтэй хандаж, тухайн хүнийг ойлгож мэдэрч хандах нь чухал юм.

“Жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, нийгэм, соёл ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон, ялгаатай ойлголт, хандлагыг ойлгоно. */ЖЭТБХТ хуулийн 4 дүгээр зүйлийн §4.1.3/*

Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип) гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүний шинж төрх, байр суурь, эрх, үүргийн талаарх нийгэмд тогтсон, уламжлагдан ирсэн хатуу итгэл үнэмшил, хүлээлт юм.

Стереотип нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг.

Тиймээс бусдыг ойлгож мэдэрнэ гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хүн хүртэл “хүнийхээ хувьд хүндлэл хүлээж” байгаадаа танд талархах явдал байна гэдэг нийгмийн мэдрэмжүүдийг өөртөө бий болгож чадсан давуу байдал юм.

Гэхдээ нийгмийн мэдрэмжтэй байх нь бүх зүйлд хүлээцтэй ханд, бүх зүйлийг ойлгож, бүх зүйлд найр тавь гэсэн үг бол биш. Зөвд зөөлөн, бурууд хурц асуудалд тунг нь таруулсан прокурор байгаарай.

2.2 Нийгмийн хүрээллийн нөхцөл байдлыг шинжлэн судлах нь

Нийгмийн ойлголтыг тайлбарлах олон хандлагууд байдаг. Үүнд:

- Германы социологич М.Веберийн тодорхойлсноор «нийгэм гэдэг нь бусад хүмүүс болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл юм».
- Америкийн томоохон социологич Т.Парсонс нийгмийг тодорхойлохдоо «холбогч эхлэлийн цэг нь хэм хэмжээ ба үнэт зүйлс байдаг хүмүүсийн хоорондын харилцааны тогтолцоо» хэмээн үзжээ.
- К.Марксын тодорхойлолтоор бол «нийгэм гэдэг нь хамтын үйл ажиллагааны явцад бүрэлдсэн хүмүүсийн хоорондын харилцааны түүхэн ёсоор хөгжигч цогц» юм. Энэ тодорхойлолтуудад нийгмийг нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо гэж үзэх хандлага их бага хэмжээгээр давтагдаж байна. Ийм хандлагыг тогтолцоот хандлага гэж нэрлэдэг.

Нийгмийн тогтолцоот чанарын хандлагыг шалтгаант чанар ба үүргийн талаас хандах хандлагаар хүмүүс баяжуулж байдаг.

Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм гэдэг бол нийгэмд хүний эзлэх байр суурийг бүхнээс дээгүүр дээр тавих, эрх чөлөө, чөлөөт хөгжил сайн сайхан аж байдлыг эрхэмлэн дээдлэх, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд бүтээсэн үнэт зүйл бүрийг гагцхүү хүний төлөө зориулах нийгмийн байгуулал байх ёстой.[17]

Тэгвэл нийгмийн нөхцөл байдлыг хэрхэн шинжлэн судалж, хэрхэн зөв гаргалгааг бий болгох вэ? Нөхцөл байдалд үнэлгээ хийхийг хэрхэн ойлгох вэ?

Нөхцөл байдлын үнэлгээ хийнэ гэдэг нь тухайн нөхцөл байдлын талаар мэдээлэл

[17] Г.Совд, Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар УБ, (2000). 14.

цуглуулах, цуглуулсан мэдээллээ боловсруулах, үнэлэх явдал юм. Нийгмийн ажлын нөхцөл байдлын үнэлгээний үйл явц нь судлах, оношлох, үйлчилгээ хүргэх алхмуудыг хэлнэ.

Нийгмийн хандлагыг өөртөө төлөвшүүлэх аргууд:

1. Бодлоо хянаж, аливаа сайн зүйлийг болох, бүтэх талаас нь эргэцүүлж бодож сурах хэрэгтэй.
2. Өөрийн хандлагыг зөв зүйл рүү чиглүүлэх хандлага бол мэдлэг, чадвар хоёрыг амьдралд зөв хэрэглэхэд туслах тул аливаа юм болгон хүнд сайн сайхан, эерэг талаас нь хандах хандлагыг өөртөө төлөвшүүлэх.
3. Хүн өөртөө агуулж, өдөр тутамдаа харьцаж байдаг эд хөрөнгө, цаг хугацаа, нэр хүнд, эрүүл мэндийн ач холбогдол, агуулгыг ойлгож, зан үйл буюу бодол сэтгэлгээ өөрчлөх.
4. Мэдлэгээ хэрэглээ болгох чадвараа хөгжүүлэх.
5. Эцэст нь өөрийн ажиллаж, амьдарч буй нийгмийн хүрээнд бүрэлдэн тогтсон нийтлэг ёс зүйн сэтгэлгээ, тэрчлэн тухайн хувь хүний үнэт зүйлстэй салшгүй холбоотой нийгмийн зүгээс өөрт нь тавьж буй тусгай шаардлагыг дагаж мөрдөж хэвших хэрэгтэй.

Ажлын байран дээр гардаг нөхцөл байдлуудад хэрхэн үнэлэлт дүгнэлт хийж болох талаар тохиолдол дээр тулгуурлан дүн шинжилгээ хийе. Та бүхэн дараах нөхцөл байдлуудад өөрийн зүгээс үнэлэлт өгч, хэрхэн хүлээж авах байсан, хэрхэн шийдвэрлэх талаас нь бодож үзнэ үү.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч прокурор таны хянан шийдвэрлэж буй хэргийн үр дүнг ойлгож хүлээн авахгүй таныг буруутгах, таныг ажлаа зөв хийсэнгүй гэж шүүмжилбэл яах вэ?

Ихэнх тохиолдолд иргэд өөрсдийн хүссэн үр дүнг прокуророос шаардах тохиолдол байдаг. Уур уцаараа гаргах, тань руу хараал, ёс бус үг хэллэх хэлэх хүртэлх хэмжээнд. Хэдий тийм боловч энэ тохиолдолд прокурор хүн яг адилхан тэр хүн рүү уурлаж уцаарласан, дургүйцсэн хандлага үзүүлж болохгүй билээ. Нүдийг нүдээр, шүдийг шүдээр гэсэн хэллэг бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд зохисгүй хэллэг юм. Надад яаж хандана би тийм хандлагаар л харьцана гэсэн хандлага прокурор мэргэжилтэй хүнд байж болохгүй. Өөрийн мэргэжилдээ нэр төртэй хандаж, прокурорын ёс зүйг эрхэмлэх хэрэгтэй. Зөвхөн мундаг мэдлэг ур чадвартай нэгэн биш мэргэжлийн ур чадвартай байхаас гадна, өндөр ёс зүйтэй байх нь чухал.

- Олон нийтийн сүлжээгээр прокурорыг буруутгах, таны шийдвэрлэсэн хэргийг онцгойлон дурдаж буруутгах тохиолдолд та яах хэрэгтэй вэ?

Зарим хэрэгт олны дэмжлэгтэй иргэн эсвэл дуулиан шуугиан дагуулсан хэргүүдийн талаар цахим сүлжээгээр хэргийн мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн цахим хуудсаар өөрсдийн үзэл бодлын хүрээнд таны хянаж буй хэрэг, материалын явцыг буруугаар дүгнэх, таныг буруутгах хандлага гарч ирэх тохиолдол түгээмэл бус боловч цөөнгүй байдаг. Олон нийтээс хэт муйхарлан зүтгэх, зөв буруу эсэхийг хамаарахгүй өөрсдийн зөв гэсэн хариултаар дайрч давшлах хандлагатай байдаг. Ийм нөхцөл байдал болсон үед та өөрийн шийдвэрлэх хэргийг хууль ёсны дагуу, гадны нөлөөлөлд авталгүй шийдэхэд анхаарч, шударга байж үнэнч хандан, итгэл үнэмшилтэй байхад анхаарах нь зүйтэй.

- Хэрэгт холбогдсон яллагдагч өөрийгөө буруугүй гээд таны танилаар дамжуулан таны шийдвэр гаргах байдалд нөлөөлөхийг завдвал яах хэрэгтэй вэ?

Прокурор хуулийн хүрээнд тухайн асуудлыг хянах, шийдвэрлэх хэрэгтэй. Гэр бүлийн харилцааны хүмүүсийн ятгалаг, танилын үг, дээд албан тушаалтны хууль бус шаардлага зэрэгт захирагдах ёсгүй. Хариуцсан хэргийг хууль ёсны дагуу нотлох баримтын хүрээнд шийдвэрлэж дүгнэх ухамсрыг өөртөө төлөвшүүлэх нь зүйтэй. Тухайн хэрэгт оролцогчийн ар гэрийн, хүндэтгэн үзэх нөхцөл байдлыг ойлгож болохгүй гэсэн үг биш ч хуулийн дагуу хийсэн хэрэгт нь тохирсон ялыг оногдуулахын зэрэгцээ бусдыг хүндлэх, хүнлэг ёсоор хандах нь зүйтэй.

Дүгнээд үзвэл, нийгмээс тан руу чиглэн ирэх хандлага үргэлж эерэг эсвэл сөрөг байхгүй учраас аль алиныг нь хүлээн авах чадварыг л өөртөө бий болгох нь чухал гэсэн үг юм. Прокурор хүний хувьд ажлын ачаалал ихтэй, дээрээс нь нийгмийн хүрээнээс ирэх сөрөг хандлагуудыг хүртэл хүлээж авах шаардлага үргэлж тулгардаг. Тиймээс нийгмийн зохист тэр мэдрэмжүүдийг өөрт бий болгож нөхцөл байдалд тулгуурлан завшааныг ашиглаж чаддаг, хүний арга эвийг олох чадварыг өөртөө суулгах гэдэг л нийгмийн мэдрэмжтэй байхын давуу тал юм.

Прокурор ажил үүргээ гүйцэтгэж байхдаа дараах хандлагуудыг өөртөө суулгасан байх нь таныг ажил үүргээ гүйцэтгэхэд илүү амар, хялбар байлгахад нөлөөлдөг. Тухайлбал:

1. Бүх хүнтэй тааламжтай нийлэмжтэй байна гэдэг боломжгүй зүйл гэдгийг хүлээн зөвшөөрөх; Ингэснээр та бусдаас ирэх тааламжгүй байдал болгонд сэтгэлээр унах, сэтгэл санаагаар хямрах нөхцөл байдлыг хэт мэдрэг хүлээн авах биш уян хатан хандаж сурна.
2. Бусдын яриа бодлыг эгдүүцэж биш зөв зарчмын асуудал гэж хүлээн авч “авах гээхийн ухаан”-аар хандах; Иргэдийг өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэхдээ зөв, буруу хандлага алыг нь ч гаргаж болно тэр үед төвөгшөөж дургүйцэх биш хүлээцтэй хандах нь чухал.
3. Тухайн үеийн сэтгэл хөдлөлд бүү авт; Нийгмийн харилцаанд оролцож байгаа хүмүүс нөгөө хүний үйлдэл ямар хариу үзүүлэхээс их шалтгаалдаг. Тань руу уурлах үед зөрүүлж уурлах нь хэзээ ч тухайн нөхцөл байдлыг намжаах үйлдэл биш. Тиймээс ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ сэтгэл хөдлөлдөө автаж битгий ханд.
4. Өөртөө хэт ойрхон хүлээж авах хэрэггүй.

Гаднаас ирэх муу энерги, хүчин зүйлс болгоныг хүлээн авч хариу урвал үзүүлэх хэрэггүй. Хэрвээ энэ нөхцөл байдал танд нөлөөлөөд байвал ажилдаа хандах хандлагад танд хүртэл сөргөөр нөлөөлнө.

Ямар ч хүн, ямар ч бодгаль байсан бүгд нийгмийн харилцааны оролцогч гэдэг нь үнэн зүйл юм. Тиймдээ ч хууль журмыг баримтлахаас гадна хэргийн оролцогчийг нийгмийн нэг хэсэг гэдгээр нь хүлээн авч үзэх нь чухал. Жишээлбэл, хэрэгт холбогдогчийг ямар хэрэг үйлдсэн, тухайн хэргийг үйлдэх болсон шалтгаан, хэрэгт нь тохирсон ямар ялыг оноох гээд бүхий л нөхцөл байдлыг судлан дүгнэж нотлох баримтыг судалсны үндсэн дээр хэргийг шийдвэрлэдэг.

Тийм ч учраас нийгмийн харилцаанд оролцож байгаа тэдгээр хүмүүстэй хэрхэн харьцах талаар хүртэл нарийн ойлголт ухагдахуун өөртөө бий болгох нь зүйтэй юм.

2.3 Прокурорын ур чадвар ба шалгуур

Прокурорын түүхэн хөгжлөөс судалбал эхэн үедээ бичиг үсгийн боловсрол эзэмшсэн, шударга, ард түмэндээ зөвшөөрөгдсөн хүмүүсийг прокуророор томилдог байжээ. Цаашлаад хүний нөөцийг бүрдүүлэх ажиллагаа үе шаттайгаар сайжирч, прокуроруудыг мэргэшүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, ахмад

прокуроруудаас суралцуулах зэрэг арга замаар боловсон хүчнийг бэлтгэж ирсэн байна. Одоо прокуроруудын өөрсдийн ур чадвараа олон талаар хөгжүүлэхээс гадна сургалтад хамрагдах, судалгааны ажилд идэвхтэй байх зэрэг аргаар мэргэжлийн үйл ажиллагааны явцад хөгжиж байна.

Чадвар бол тухайн хүн тодорхой үйл ажиллагаа явуулах ёстой нөөц бололцоо юм. Чадвар нь Хабилис буюу идэвхжүүлдэг гэсэн латин хэлнээс гаралтай ба энэ үг чадварлаг чанарыг илтгэдэг байна. Орчин үед чадварыг зөвхөн авхаалж самбаа, авьяас чадвар, оюун ухаан зэргээр үнэлэхээ больсон ба нийгмийн мэдрэмжтэй, өндөр ёс суртахуунтай, нийгмийн оролцоонд мэдрэмжтэй байх шалгууруар үнэлэх болсон. Хэрвээ та үргэлж шинэ чадвар эзэмшиж, ямар нэгэн зүйлийн талаар илүү ихийг мэдэхийг хүсдэг бол заавал цаг гарган судалдаг байгаарай.

Хуульч мэргэжлийн хүрээнд дагаж мөрдөх ёс зүйн шаардлагаар шударга байх, хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэх, хараат бус байх, хэн нэгний нөлөөнд автахгүй, хувийн харилцаа тогтоохгүй байх, хэрэв хувийн харилцаатай, садан төрлийн холбоотой, хэргийг шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ төрвөл хуульд заасны дагуу татгалзах зэрэг шаардлагуудаар ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх арга механизмыг тодорхойлсон байдаг. Тиймдээ ч өөрийн зүгээс баримтлах ёстой зарчмаа дагалгүй, мэдсээр байж авах арга хэмжээг аваагүй хувийн хүсэл зоригоор хандаж хийх нь хуульч хүнийхээ хувьд ёс зүйн зөрчлийг бий болгож буй хэрэг юм.

Прокурорын тухай хуульд түүний хараат бус байдлын баталгааг хуульчлахдаа хууль зүйн, эдийн засгийн, нийгэм, улс төрийн болон иргэн хүний хувьд хязгаарлалт хийж болох хязгаарлалтыг нь хуульчилсан байдаг.

Прокурор яагаад хараат бус байх ёстой вэ? Хараат бус байдал нь иргэдийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, цаашлаад ажил үүргээ үнэнч шударгаар биелүүлэхэд чухал нөлөөтэй байдлыг бий болгодог тул түүний бүрэн эрхийг тусгайлан хуульд зааснаас өөр үндэслэл, журмаар хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох, шалтгаангүйгээр прокурорыг чөлөөлөх, халах, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд томилохыг хориглодог байна.

Хэрвээ прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаж байх үед бусад этгээд өөрт болон бусдад давуу байдал бий болгохоор үйл ажиллагаанд нь нөлөөлөхийг оролдвол ямар арга хэмжээ авах нь зүйтэй вэ?

Нийгэм бол бүлэг хүмүүсийн хоорондын харилцаанаас үүдэж байдгийн хувьд таны хяналт тавьж буй хэрэгт хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх бүрэн эрхтэй. Мөн түүнчлэн саад учруулсан, хараат бус байдалд нь халдсан аливаа дарамт, шахалт, нөлөөллийн талаар дээд шатны прокурорт мэдүүлэх үүрэг танд оноогдсон. Гадна дотно чиглэн ирсэн нөөлөлд авталгүй өөртөө болон ажил мэргэжилдээ шударга байдлыг тогтоох хэрэгтэй. “Шударга ёс” гэдэг бол нийгмийн хөгжил дэвшлийн шаардлага, ард олны ашиг сонирхол хүсэл эрмэлзэл, үнэнийг эрхэмлэх ёс, тэгш эрхийн зарчмыг тусгасан ухагдахуун бөгөөд “Шударга ёс” нь хүн нийгмийн харилцаанд бодитой, зохистой хандах зүй ёсны шаардлага. Өөрөөр хэлбэл, шударга ёс нь хүний хувийн ашиг, сонирхлыг бусдын, нийгмийн ашиг сонирхолтой уялдуулах, нийтлэг чиг шугамд үндэслэгдсэн эрх зүйн зарчим юм.[18]

Түүнчлэн өөртөө хариуцлагыг бий болгох нь хуульчийн хараат бус байдлын тулгийн чулуу бөгөөд хариуцлагаа ухамсарласан хуульч өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг тул хариуцлагын дархлааг өөртөө бий болгохын тулд хичээх ёстой. Хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах

[18] Хуульчийн ёс зүй гарын авлага, (УБ, 2013), 17.

ёстой ч бүрэн төгс боловсрогдон ёс зүйн дүрэм гэж үгүй тул дүрмийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байх нь зүйтэй.

СЭДЭВ 3. НИЙГМИЙН ХАНДЛАГА, НӨЛӨӨЛЛИЙН ЗАРИМ ШИНЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

Зорилго. Нийгмийн хандлага хэрхэн прокурорын ажил үүрэгт нөлөөлдөг талаар болон нийгмийн эерэг, сөрөг хандлагыг хэрхэн хүлээж авах түүнийгээ хэрхэн зохицуулах удирдан чиглүүлэх талаар тодруулан авч үзнэ.

3.1 Гадаад орны сайн туршлага

Нийгмийн мэдрэмж нь нэг талаас хувь хүний нийгмийн харилцааны дохио, нөхцөл байдлыг таних, ойлгох, чадвар юм. Энэ нь та бусдын мэдрэмж, бодлыг хэр сайн ойлгож, нийгмийн хэм хэмжээний ерөнхий мэдлэгтэй хүн бэ гэдгийг илэрхийлэх юм. Нийгмийн мэдрэмжийн тухай ойлголтыг хэрэгжүүлснээр хүмүүс нөгөөгийнхөө мэдрэмжийг мэдэж чаддаг болно. Учир нь нийгмийн мэдрэмжтэй хүн “зөвхөн би” гэсэн суртлаас ангид байж нийгмийн харилцаандаа орохдоо мэдрэмж дээрээ тулгуурлан бусдыг байлдан дагуулах, бусдыг хандлагыг зөв чиглэл рүү шилжүүлэх зэргээр шаардлагатай харилцах харилцааг төвөггүй давахад туслах ур чадвар юм.

Нийгмийн мэдрэмжийн үндсэн зарчим нь нийгмийн хэм хэмжээний талаарх өргөн мэдлэгт суурилдаг. Нийгмийн мэдрэмж нь нийгмийн оюун ухааны нэг хэсэг болсон бөгөөд тэд ижил төстэй шинж чанаруудыг хуваалцдаг. Энэ нь бүлгийн гүйцэтгэлд чухал үүрэг гүйцэтгэдэг тул үүнийг нийгмийн чухал ур чадвар гэж үздэг.

Бүлгийн нийгмийн мэдрэмж нь хамтын оюун ухааны түвшинтэй нягт уялдаатай байдаг бөгөөд энэ нь тухайн бүлгийн (бүлгийн нэг гишүүн биш) өргөн хүрээний даалгаврыг гүйцэтгэх ерөнхий чадвар гэж тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, хүмүүс нийгмийн мэдрэмж сайтай бол хамтдаа ажил дээрээ сайн гүйцэтгэл гаргадаг.

Хүний эрхэм чанарыг хүндлэх мэдрэмжгүй, өөрийн ажил үүргийг ялархаж хийдэг, бусдад ялгавартайгаар ханддаг, аливаад хар бараанаар хандаж, мэдэрдэг хүн хэчнээн эрдэм боловсрол, ур чадварыг эзэмшсэн байлаа ч ажлыг үр бүтээмж, нийгмийн эерэг хандлагыг бий болгож үл чадна. Ажилтнуудын нийгмийн мэдрэмжийг сайжруулахын тухайд гадаадын зарим орны хувьд нийгмийн үндсэн мэдрэмжид тулгуурлан хувь хүний мэдрэмжийг сайжруулахад илүүтэй анхаардаг байна. Тухайлбал:

Солонгос улсын тухайд.

Солонгос улсын ажилтнууддаа анхаарах хамгийн том шалтгаан нь ажлын гүйцэтгэл дээр тулгуурладаг байна. Ажилтнуудаа ямар шалтгаанаас болж гүйцэтгэл муутай ажилласан, тэднийг хэрхэн дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлэх талаар сар бүрийн эцэст судалгаа авч дүгнэдэг байна.

Урт хугацаанд үр ашигтай ажиллахад ажилтнуудын гүйцэтгэл, бүтээмж маш чухал нөлөөтэй гэж үздэг ба гүйцэтгэл муутай ажилтнууд байгууллагынхаа хувьд хэд хэдэн сөрөг нөлөөг үзүүлдэг байна. Үүнд:

- Бүтээмж буурах
- Ажлын чанар унах
- Ажилтан хоорондын харилцаа, хамтын ажиллагаа муудах зэрэг байсан аж.

Багийн гишүүний гүйцэтгэл муудаж, бүтээмж буурах олон шалтгаанууд нь:

- Тодорхой бус хүлээлт

- Ажилдаа сэтгэл ханамжгүй байх
- Байгууллагын соёлд нийцэж чадахгүй байх
- Стресстэй ажлын орчин
- Сургалтын хөгжлийн хангалтгүй боломжууд
- Хүний нөөцийн дутуу төлөвлөлт
- Хувийн шалтгаан зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна.

Гүйцэтгэл муутай байгаа ажилтнуудын судалгаанд үндэслэн ажилтнуудыг бүгдийг нь хамруулсан судалгааны үр дүнд үндэслэн:

1. Асуудлыг тодорхойлох
2. Уулзалт хийж, түүний гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар ярилцах
3. Ажилтны хүлээлтийг тодорхойлох
4. Хамтдаа ажил сайжруулах төлөвлөгөө гаргах
5. Тогтмол уулзаж, төлөвлөгөөний гүйцэтгэл дээрээ ярилцах
6. Ололт амжилтыг магтан сайшаах
7. Асуудал дээр нь дэмжлэг үзүүлэх
8. Хэрэв гүйцэтгэл сайжрахгүй бол шаардлагатай шийдвэрийг гаргах зэрэг ажиллагаануудыг авч хэрэгжүүлдэг байна.

Япон улсын тухайд.

Япон улсад ажилтнуудынхаа суурь эрхэд илүүтэй анхаарал хандуулдаг. Ажлын байранд бүтээмжтэй, сэтгэл ханамжтай байх чухал нөхцөл болох хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийн асуудлуудад анхаарч, ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байх, хөдөлмөрийн хүрээний олон янз байдлуудыг ажилтнууддаа ойлгуулахыг эрмэлзэж олон талт сургалт, судалгааны ажлуудыг өрнүүлдэг байна.

Шинэ Зеланд улсын тухайд.

Шинэ Зеланд улсад 1 прокурорт ногдох хэрэг, материалын тоо их байдгаас шалтгаалан ажлын ачаалал их байдаг байна. Зөвхөн прокурорын үйл ажиллагаа, хэргийн шийдвэрлэлтийн явц байдалтай холбоотой жилд 750,000 дуудлага хүлээн авч, мөрдөн байцаалтын 190,000-200,000 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг гэсэн судалгаа байдаг байна.[19] Ажлын ачааллын дээрх нөхцөл байдлаас үүдэн ажилтнуудынхаа ажиллах орчин, нөхцөл, тав тухад илүү анхаарч, хөдөлмөрийн харилцааг уян хатан явуулахад нөлөөлдөг аж.

<u>3.2 Өсөлтийн сэтгэлгээ ба шинэ чиг хандлагад суурилан бусдад нөлөөлөх нь</u>

Амьдралдаа заавал том амжилт гаргахгүй ч амжилтад хүрсэн хүмүүст нийтлэг шинжтэй байдаг сэтгэлзүйн шинж чанар байдаг. НАСА үүнийг боломжит системийн инженерүүдийг сонгох шалгуур болгон ашигладаг байна. Энэхүү ойлголтыг өсөлтийн сэтгэлгээ[20] гэж нэрлэдэг байна. Өсөлтийн сэтгэхүйтэй хүмүүс аливаа салбарт оюун ухаан, ур чадварыг өөрсдийн хүчин чармайлтаар хөгжүүлэх боломжтой гэж үздэг. Үндсэндээ хэн ч өөрийн чадварыг аливаа зүйлд хүргэж, хөгжүүлж чадна гэж итгэдэг.

[19] Espiner, Guyon (3 October 2021). "$40m of public money for private law firms". Radio NZ. Retrieved 3 October 2021. ^ "CLO - About Us - Crown Solicitor Network". Archived from the original on 2 June 2010. Retrieved 4 September 2010.

[20] Карол Двэк- Өсөтийн сэтгэхүй, орчуулагч. Ц.Жавхлан 162-164 тал

Өсөлтийн сэтгэлгээний урвуу тал бол тогтсон сэтгэлгээ юм.

Өсөлтийн сэтгэлгээ гэдэг нь аливаа салбарт хувь хүн өөрийн оюун ухаан болон ур чадварыг хөгжүүлэх боломжтой гэсэн итгэл үнэмшил юм. Бид бүгд өсөлтийн болон тогтсон сэтгэлгээний холимог билээ. Амьдралынхаа зарим салбарт бид өсөлтийн сэтгэлгээний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Бусдад нь бид тогтсон сэтгэлгээний дагуу ажилладаг. Өсөлтийн сэтгэлгээтэй хүмүүс илүү тэсвэр хатуужилтай байдаг нь хүнд хэцүү нөхцөл байдлыг даван туулах боломжийг олгодог. Учир нь тэд бүтэлгүйтлээс айдаггүй, айхын оронд өсөж, хөгжин суралцах үйл явцад анхаарлаа төвлөрүүлдэг байна. Иймд мэргэжилтнүүд өсөлтийн сэтгэлгээтэй байхыг ихэнх байгын ур чадвар шаарддаг ажлын байрнуудад санал болгодог байна.

Монгол Улсын прокурорын байгууллагад хийсэн соёлын судалгааны үр дүнгээс үзэхэд[21] 0-1 жил ажилласан ажилтнуудын хувьд идэвх чармайлт сайтай бөгөөд байгууллагадаа сэтгэл хангалуун байдаг байна. Харин 1-3 жил ажилласан ажилтнуудын нийт үзүүлэлтүүд нь дундаж байна. Харин ялгаварлан гадуурхалтын түвшин өндөр байна. 3-5 жил болон 5-с дээш жил ажиллаж буй ажилтнуудын хувьд ажлын гүйцэтгэл, манлайлал болон бусад үзүүлэлтүүдээр 0-3 жил ажилласан ажилтнуудаас бага байна. Ажилласан жилээр харьцуулсан харьцуулалтын дүнд хариуцлагын тогтолцоо болон мотиваци нь хамгийн өндөр үзүүлэлтүүд байгаа бол ажлын гүйцэтгэл болон манлайлал нь хамгийн бага үзүүлэлттэй байна. Доор хүснэгтээр харуулав.

Хандлагын тухайд.

Хандлага гэдэг нь объект, хүмүүс, тодорхой нөхцөл байдлын талаар тааламжтай, тааламжгүй аль нэгэн байдлаар үнэлэх үнэлэлт юм. Энэ нь хүн ямар нэгэн хэрхэн бодож байгаатай холбоотой юм. Би ажилдаа дуртай гэх нь уг хүний ажилдаа хандах хандлагыг илэрхийлдэг. Хандлагыг эерэг, сөрөг гэж хуваж болдог.22

Бидний хандлага нь амьдралын муу мөчүүдийг даван туулахад туслах боловч гарч буй бэрхшээлийг шийдвэрлэх цорын ганц шаардлага биш юм. Хэдий тийм боловч сөрөг сэтгэлгээнээс илүү эерэг сэтгэлгээтэй байх нь үргэлж дээр байдаг. Эерэг сэтгэлгээ нь асуудлыг шийдвэрлэх чадвар, бодит байдал, эр зоригтой хосолдог бол бидний сайн сайхан байдал түүнийг дагаад нэмэгддэг байна. Эерэг сэтгэлгээтэй хүмүүст байдаг шинж чанараас прокурорт байвал зохих хэдэн сэтгэлгээг авч тодруулъя.

- Өөрсдөдөө шударга ханддаг, өөрийгөө эргэцүүлэн бодох чадварыг ашигладаг;
- Өөрсдийгөө эергээр үнэлдэг.
- Унаж, бүтэлгүйтэж, түүнээсээ сурах боломжийг олж хардаг.
- Бэрхшээл, саадыг үл харгалзан өөрсдийгөө зоригжуулдаг.
- Өөрсдийн сэтгэл хөдлөлийг сайн мэддэг, удирддаг, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгодог.

Тэгвэл дээр дурдсан эерэг сэтгэлгээ прокурор хүнд байснаар ямар шаардлагатай вэ гэвэл та албан үүргээ биелүүлж байх үедээ гаднаас ирэх стресс сөрөг хандлагад эерэг сэтгэлгээгээр хандаж чадна.

Нэг алдлаа гээд үргэлж өөрийгөө буруутгаж ажил үүргээ гүйцэтгэх айдастай болж цаашлаад хийж байгаа зүйлээсээ халшрах, хийхийг хүсэхгүй байсан ч өөртөө шударга бус хандаж хийсээр байх сэтгэлгээ танд байж болохгүй.

Буруу бол буруугаа хүлээж байж алдаанаасаа суралцдаг эерэг хандлагатай

[21] Прокурорын байгууллагын соёлын судалгааны дэлгэрэнгүй тайлан 2023 он

[22] Д.Болормаа, Байгууллагын зохион байгуулалтын зан төлөв, 3 дахь хэвлэл, УБ, (2002), 98.

болно. Ажил дээр үүссэн асуудлыг шийдвэрлэх, зөв гаргалгааг бий болгох, бусдын сэтгэлгээг ойлгодог харилцан хүлээцтэй хандах эерэг байдлыг бий болгоно. Ер нь прокурортой уулзахаар ирж байгаа хүмүүс ихэнхдээ л уурлаж, бухимдсан байдаг. Тэгэхээр "гал шиг ороод ирсэн хүний өөдөөс хэзээ ч битгий гал шиг бай.[23]

3.3. Цахим сүлжээ дахь цаг үеийн үзэл бодол ба олны анхаарал татсан, дуулиант хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нийгмийн хандлага

Прокурорын байгууллагаас олон нийттэй харилцахад дараах нийтлэг зарчмуудыг баримталдаг. Үүнд:

- Хуулиар нууцлахаар тогтоосон, хориглосноос бусад тохиолдолд ил тод, нээлттэй байх;
- Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой байх;
- Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, төр байгууллага, хувь хүний нууц, оюуны өмчийн эрхэд халдахгүй байх;
- Үнэн зөв бодитой байх;
- Прокурорын байгууллагын нэр хүндэд харшлахгүй байх;
- Мэдээллээр хангах ажиллагаа шуурхай, хуулийн хүрээнд байх зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд цахим мэдээллийн хэрэгсэл, өргөн нэвтрүүлгийн мэдээ мэдээллийн сувгууд, олны дэмжлэгтэй иргэд цахим сүлжээгээр дамжуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх нь ихсэх болсон үед прокурорын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар хэвлэлийн эрх чөлөө нэр дор олон нийтэд ташаа мэдээлэл түгээх асуудал цөөнгүй үүсэх болсон. Нэн ялангуяа прокурорын хараат бус, бие даасан байдалд халдах замаар иргэдийн хуулийн байгууллагад итгэх итгэлд тулгуурлан сөрөг хандлагуудыг түгээж байна. Үүнээс үүдэн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүй, мэдээллийн эх сурвалж, үнэн бодит эсэхийг нягталдаггүй иргэдийг массыг үүсгэдэг.

Прокурорын байгууллагаас цахим орчинд прокурорын байгууллага болон прокурорын хараат бус байдалд халдсан, алдагдуулсан, худал ташаа мэдээ, мэдээлэл түгээсэн асуудалд тухай бүр залруулга, тодруулга өгч, прокурорын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажилладаг. 2023 онд Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, прокурор, ажилтныг ажил, албан үүрэгтэй нь холбогдуулан гүтгэлэг, доромжлол, заналхийлэлд өртөх аюул, эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголын Хуульчдын холбоотой хамтран иргэд, олон нийтэд хандаж "мэргэжлийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, ажил хэргийн нэр хүндэд халдахгүй байхыг уриалсан" мэдэгдлийг гаргасан. Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн анхан шатны 38 шүүх шүүн таслах ажиллагаа явуулж байгаагаас 19 нэгж прокурорын газар 17 шүүхийн байранд улсын яллагчийн өрөөг бий болгон үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд энэ онд 11 нэгж прокурорын газар харьяа нутаг дэвсгэрийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн байранд улсын яллагчийн өрөөтэй болж, прокурорын аюулгүй байдлыг ханган, шүүх хуралдаанд бэлтгэх боломжийг бүрдүүлсэн байна.

Таны хяналтад буй хэргийн талаар сэтгүүлч, иргэд мэдээлэл авахаар ирсэн тохиолдолд та цаг үеийн шаардлагатай зарим асуудлаар энгийн ойлгомжтой байдлаар тайван, сандрахгүйгээр олон нийттэй харилцахад баримтлах нийтлэг зарчмуудыг баримтлан мэдээлэл өгөхөд болох юм. Прокурорын байгууллагын олон нийттэй харилцах журмын зарим заалтуудаас:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх болон хуулиар хориглосноос бусад тохиолдолд дараах мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрсөн хэмжээнд олон нийт, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд өгч

[23] Д.Булганцэцэг: Прокурор хүн сэтгэлгүй байж болохгүй сэдэвт ярилцлагаас

болно.Үүнд:

- Олны анхаарал татсан, нийгмийн хор аюул ихтэй, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц байдал, шийдвэрлэлтийн талаар;
- Авлигын гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүрээлэн буй орчны эсрэг, мөнгө угаах зэрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явц байдал, шийдвэрлэлтийн талаар;
- Олны анхаарал татсан, улс төрд нөлөө бүхий этгээдийн үйлдсэн авлигын гэмт хэргийг шалгаж, гэм бурууг тогтоон, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураан авсан ажиллагааны үр дүнгийн талаар;
- Харьяа нутаг дэвсгэр дэх эрүүгийн болон зөрчлийн хэргийн гаралт, шийдвэрлэлт, нөхцөл байдлын талаар;
- Гэмт хэрэг, зөрчлийн статистик дүн, мэдээ;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл зэрэг болно.

Олон нийттэй харилцах ажлын хүрээнд олж мэдсэн мэдээ, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулсан, задруулсан, олон нийтэд хүргэсэн нь прокурорт сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болдог байна.

СЭДЭВ 4. ПРОКУРОРЫН ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ОЛОН НИЙТИЙН ЦАХИМ СҮЛЖЭЭГ АШИГЛАХ ЗОХИСТ БАЙДАЛ

Зорилго: Үзэл бодлоо илэрхийлэх эрх хийгээд хэрхэн хязгаартайгаар эдлэх, мөн зөв зохистой цахим сүлжээг ашиглах шаардлагатай эсэхийг тодруулан авч үзнэ.

4.1 Прокурорын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Өнөөдрийн байдлаар 3,96 тэрбум хүн цахим сүлжээг өдөр тутамдаа ашигладаг бөгөөд дэлхийн интернэт хэрэглэгчид дунджаар олон нийтийн мэдээллийн сайтуудад өдөр бүр 144 минутыг зарцуулдаг судалгаа байдаг байна. Энэ хугацааг жилийн 365 өдөрт үржүүлэн үзвэл интернэт хэрэглэгчид жилд ойролцоогоор 876 цагийг зөвхөн цахим сүлжээ ашиглаж, өнгөрөөдөг байна.[24]

Монгол Улсын Үндсэн хуулийн §16.16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх” эрх чөлөөтэй гэж заасан байдаг.

§16.17. “…мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.[25]

Италийн социологич Сципион Сигеле /Scipio Sighele/ 1891 онд бичсэн “Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг” гэсэн номын утга нь “...хүн гэдэг нь өөрийн дотор үнэмшил итгэлийг дарж амьдардаг бөгөөд тэрхүү буруу зүйлийг хийж болохгүй түгжээ зарим тохиолдолд цоожноос мултран гарах үе байдаг. Ялангуяа хэвийн тайван байдлаас илүүтэйгээр түүнийг цочроох, айдас бий болгох, түгшээх бухимдал үүсгэх үед илүүтэйгээр илрэн гардах байх...”юм. Нийгмийн харилцаанд оролцогч болох хүн нь зарим тохиолдолд нийгэмд тэр тусмаа олонхын дунд илрэн гарах үедээ өөртөө буруу

[24] Ц.Жавхлан Уншихуй, урагшлахуй УБ,2021 он, 13-14 тал
[25] Прокурорын тухай хууль, /шинэчилсэн найруулга/, (2017), 61.1.

гэх бодсон зүйлээ ч ил гаргахаас зайдасхийдэггүй гэсэн үг юм. Олонх бөөгнөрөл үүсгэх нь өөрөө нийгмийн эрүүл харилцааг бий болгох нийгмийн зөв хандлагыг бүтээхэд уг сууринаасаа хэцүү байдаг байна.

Ийм тохиолдол бий болсон ч өөрийн гэсэн үзэл бодолтой байх, цаг үеийн үзэл бодлыг дагахгүй байх нь прокурор хүнд байх чухал зан чанарын нэг юм.

4.2 Прокурор олон нийтийн цахим сүлжээг зохистой ашиглах нь

Монгол Улс олон улсын хэмжээнд кибер аюулгүй байдлын нөхцөл байдлаараа 2020 онд 194 орноос 120 дугаарт, цахим засаглалын кибер аюулгүй байдлын индексээр 160 орноос 123 дугаарт эрэмбэлэгдсэн. Ийнхүү цахим орчинд хүн бүхэн аливаа хязгаарлалтгүйгээр мэдээлэл түгээх болон олж авах нөхцөл боломж бүрдсэн орчин цаг үед прокурор нь өөрийн ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийн нууцлалыг чанд хадгалж хамгаалах, түүнчлэн дээр дурдсанчлан нийгмийн хандлага, прокурорын байгууллага болон прокурорт итгэх итгэлийг алдагдуулахгүйн тулд өөрийн үзэл бодол, илэрхийлэлдээ үргэлж хянамгай хандах нь нэн чухал юм.

Олон нийтийн сүлжээнд өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, хандлага, чадварыг бий болгож, оролцох шаардлагатай ба үүнээс үүдэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах, хохирох эрсдэлийг бууруулах, зохистой хэрэглээ төлөвших, олон нийтийн сүлжээний зохисгүй хэрэглээнээс үүсэх хор аюулаас сэргийлэх эерэг талтай.

Прокурорын ёс зүйн дүрэмд дараах зүйлсийг хориглосон байдаг. Үүнд:

- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр прокурорын байгууллагын нэр хүндэд харш сурталчилгаа хийхийг хориглоно.
- Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа прокурорын нэр хүндэд харшилсан, эсхүл прокурорын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулах, уг төрлийн мэдээллийг дэмжсэн хандлага илэрхийлэхийг хориглоно.
- Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно.
- Байгууллагын албан ёсны цахим сүлжээнээс бусад сүлжээнд шаардлагагүй тохиолдолд дүрэмт хувцастай зураг болон албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбоотой зураг, дүрс, бичлэг мэдээллийг цахим сүлжээнд байршуулахгүй байх зэргээр хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаандаа эдгээр ёс зүйн хэм хэмжээг баримтлах ёстой.[26]

Европын холбооноос гаргасан “Интернэт дэх аюултай контент” (European Commission, 2004) судалгааны тайланд төрийн зүгээс интернэтэд зохицуулалт хийх гол шалтгаануудыг тоймлон дурдсан байдаг.[27] Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлыг сахих. Галт зэвсгийн наймаа, хар тамхины сурталчилгаа, терроризмын суртал ухуулгыг интернэт ашиглан зохион байгуулах боломжтой тул сэрэмжлэх.
- Хүүхэд, цөөнхийн эрх ашгийг хамгаалах. Зүй зохисгүй зар сурталчилгаа, мэдээ мэдээлэл, хүчирхийлэл, бэлгийн зан үйлийг талаар мэдээ их тул хязгаарлах.
- Хүний ёсноос гажууд үйлдлээс сэргийлэх. Яс үндсээр ялгаварлан гадуурхах, үзэн ядах үзэл суртлыг дэмжих үзлийг сурталчлахыг зогсоох.
- Эдийн засгийн аюулгүй байдлыг дэмжих. Кредит картын хуурамч гүйлгээ,

[26] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар зарлигийн нэгдүгээр хавсралт, Прокурорын ёс зүйн дүрэм, 2.4.12, 2.4.13, 2.4.14.

[27] Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчны зохицуулалт зөвлөмж, (УБ, 2021), 2.

хакердах мөн санхүүгийн залилангийн үйлдлүүдээс сэргийлэх.
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах. Нууц мэдээлэл алдагдах, хуурамч мэдээлэл түгээх үйлдлээс сэргийлэх, таслан зогсоох.
- Иргэний аюулгүй байдлыг хангах. Хувь хүний мэдээлэлд халдах, хувь этгээдийг интернэт ашиглан дарамтлахаас урьдчилан сэргийлэх.
- Нэр хүндэд халдахаас хамгаалах. Гүтгэлгийн шинж чанартай, эсвэл бусадтай харьцуулсан сурталчилгаа хийхийг хориглох.
- Оюуны өмчийг хамгаалах. Оюуны өмчийн хууль, гэрээгээр хамгаалагдсан бүтээлийг хууль бусаар түгээхийг таслан зогсоох зэрэг болно.

Дээрх хүчин зүйлс цахим орчны зохицуулалтыг тогтооход хэр хэмжээний хөшүүрэг болдог ба хөгжингүй улс орнууд эдгээр хөшүүргүүдийг ашиглаж зохицуулалт хийдэг байна. Ингэхдээ аль нэг байгууллагад онлайн орчны контентын агуулгыг тодорхойлох эрх мэдлийг төвлөрүүлэхгүйгээр аль болох олон байгууллагад эрх мэдлийн хуваарилалтыг хийдэг байна. Энэ нь нэг талаас хүний үндсэн эрх болох үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалсан хэрэг юм. Иймд прокурор нь дээр дурдсан гол зохицуулалт бүхий интернэт орчин дахь анхаарах асуудлуудыг цаг ямагт анхаарч байвал зохистой билээ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Эрүүгийн хууль, /шинэчилсэн найруулга/, 2015.
3. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
4. Прокурорын тухай хууль, /шинэчилсэн найруулга/, 2017.

Монгол хэл дээрх ном, товхимол:

1. Г.Совд, Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар УБ, 2000.
2. Д.Болормаа, Байгууллагын зохион байгуулалтын зан төлөв, 3 дахь хэвлэл, УБ, 2002.
3. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын үндсэн асуудал, УБ, 2018.
4. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, суурь ойлголт тулгамдсан асуудал, УБ, 2005.
5. А.Сэргэлэнтуяа, АНУ-ын хуульч бэлтгэх тогтолцооны талаарх тойм судалгаа, УБ, 2022.
6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол, арга зүй, хэрэгжилт, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, УБ, 2017.
7. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, II дахь хэвлэл, УБ, 2017.
8. П.Баянбаатар, Хүний эрх, онол арга зүйн сэтгүүл, 2018/02.
9. Прокурорын ёс зүйн дүрэм, 2018.
10. Прокурорын мэргэжлийн дүрэм,
11. Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчны зохицуулалт зөвлөмж, УБ, 2021.
12. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол, арга зүй, хэрэгжилт, Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, УБ, 2017.
13. Г.Гантүвшин “Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын прокурорын

байгууллагуудын чиг үүрэг нь өргөн цар хүрээг хамарсан байдаг...” сэдэвт ярилцлага 2022.

Гадаад хэл дээрх ном, товхимол

1. 3.3 The Social Self: The Role of the Social Situation – Principles of Social Psychology – 1st International H5P Edition (opentextbc.ca)
2. https://www.rbc.com/en/wp-content/uploads/sites/4/2022/07/july1955.pdf The royal bank of Canada monthly letter, Head office5 Montreal, July 1955
3. www.confocal-manawatu.pbworks.com

БҮЛЭГ 18. СТРЕСС МЕНЕЖМЕНТ

СЭДЭВ 1. СТРЕСС, ТҮҮНИЙ ҮНДСЭН ХЭЛБЭР

1.1. Стрессийн тухай олон талт ойлголт
1.2. Стресс үүсгэгч хүчин зүйлс
1.3. Ажил мэргэжилтэй холбоотой стресс
1.4. Стрессийн улмаас хүний бие махбод, сэтгэлзүйд үзүүлдэг нөлөө

СЭДЭВ 2. СТРЕССИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗҮЙ

2.1. Стресс үүсгэгчийг таньж мэдэх, ухамсарлах, хүлээн зөвшөөрөх
2.2. Стресс тайлах энгийн аргуудыг хэрэгжүүлэх
2.3. Ажил эрхлэлтэй холбоотой стресст өртсөн үед хувь хүний түвшинд хэрэгжүүлэх алхам
2.4. Мэргэжлийн тусламжид хандах

СЭДЭВ 1. СТРЕСС, ТҮҮНИЙ ҮНДСЭН ХЭЛБЭР

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд прокурорын стрессийн тухай мэдлэгийг нэмэгдүүлж, өөрт тулгарсан сэтгэл зүйн болон биеийн стрессийг даван туулах өөрийн онцлогт тохирсон арга зүйг хэрэгжүүлэх талаар авч үзнэ.

1.1 Стрессийн тухай олон талт ойлголт

“Стресс” хэмээх үг англи хэлнээс гаралтай ба “хүчдэл, дарамт, хэт ачаалал” гэсэн утга санааг илэрхийлнэ. Биологийн шинжлэх ухаанд даарах, өлсөх, сэтгэлийн дарамтад өртөх, гэмтэл авах зэрэг янз бүрийн тааламжгүй нөлөөллийн улмаас хүнд үүсэж буй физиологийн хамгаалах хариу урвал болох “хүчдэлийн байдал”-ыг стресс гэдэг.[1]

Өөрөөр хэлбэл хүний амьдралд тохиолдож буй хэт их дарамт бүхий нөхцөл байдал, өөрчлөлтөд дасан зохицох үйл явцын үр дүнд хүний сэтгэц, бие махбод, оюун санааны сайн сайхан байдалд нөлөөлж буй заналхийлэл юм. Хувь хүн өөрийн чадавхынхаа хэмжээгээр стресст дасан зохицох ба хүн бүрд харилцан адилгүй хугацаагаар үргэлжилнэ. 1936 онд Г.Селье (Hans Selye) стресст өгөх хариу урвалыг дараах 3 үе шатыг дамжин илэрдэг хэмээн тодорхойлсон. Үүнд:

1-р шат буюу сэтгэл түгшилтийн үе: Хүн тааламжгүй нөхцөл байдалтай тулгарах үед түүний талаарх мэдээллийг мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар тархинд хүлээн авч, нөхцөл байдлыг аюултай эсвэл аюулгүй хэмээн дүгнэдэг. Хэрэв нөхцөл байдлыг аюулгүй хэмээн дүгнэвэл бие махбод ямар нэгэн хариу үйлдэл үзүүлдэггүй. Харин бодит аюул тулгарсан хэмээн үзвэл мэдрэл, дотоод шүүрэл, зүрх судас, уушги, булчин, арга ясны тогтолцооны үйл ажиллагаанууд болон бодисын солилцоо эрчимжин, сэтгэл түгшиж, нөхцөл байдлаас зугтах эсвэл нүүр тулахад бие махбод бэлтгэгддэг. Өөрөөр хэлбэл бие махбодод физиологийн тайван бус байдалд шилждэг.

2-р шат буюу эсэргүүцлийн үе: Энэ үед, үүссэн түгшүүрийг эсэргүүцэн бие махбод физиологийн тайван байдал руу шилжихийг оролддог. Гэвч аюул заналхийллийн талаарх ойлголт хэвээр байгаа үед бие махбод физиологийн тайван байдалд эргэн шилждэггүй. Улмаар стрессийг даван туулах буюу шийдвэрлэхийн тулд автоматаар

[1] С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. Улаанбаатар хот. 2013 он.

буюу өөрийн эрхгүй, санамсаргүйгээр сэтгэл түгшилтээс өөрийгөө хамгаалан хэн нэгэн хүнтэй өөрийгөө адилтгах, нөхцөл байдлыг үгүйсгэх, хүлээн зөвшөөрөхгүй байх гэх мэтээр сэтгэл зүйн хамгаалах механизмыг боловсруулдаг. Хамгаалах механизм нь үл ухамсарлагдсан, аюул заналыг эсэргүүцэж буй “Эго”-ийн идэвхтэй тэмцэл учир ухамсарлахуйгаас ямар нэг юм ухамсарлагдахгүйгээр устаж байдаг.

3-р шат буюу туйлдал ядаргааны үе: Нөхцөл байдалд дасан зохицох чадвар буурч, бие махбод стресст бууж өгөн туйлдаж ядарна. Дахин стресс бүхий нөхцөл байдал тулгарахад эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болно. Энэ үед хамгаалах чиг баримжаатай төрх үйл улам ихэснэ. Ямар нэгэн зорилго чиглэлгүй үйл ажиллагаа явуулна. Сэтгэл түгшилт нэмэгдэж, сэтгэл гутралд автан цөхөрнө. Улмаар стрессийг даван туулж чадалгүй, стрессийн шалтгаант биеийн болон сэтгэцийн эмгэгээр өвчлөх буюу амь насанд аюул учирна.[2]

1.2 Стресс үүсгэгч хүчин зүйл

Стресс үүсгэгч хүчин зүйлийг стрессор хэмээн нэрлэх ба аюул заналхийлэл гэж үздэг бодит эсвэл төсөөллийн ямар нэгэн өдөөгч бүхий нөхцөл байдал юм. Тухайлбал: ажилгүйдэл, ажлын хэт их ачаалал, санхүүгийн баталгаагүй байдал, хүний эрхийн зөрчил, хүмүүс хоорондын зөрчил будилаан, ойр дотнын хүн өвдөх болон нас барах, хүчирхийлэлд өртөх, гэр бүлийн дотоод зөрчил болон гэр бүл салалт, технологийн зарим дэвшил, замын түгжрэл, агаарын бохирдол гэх мэт. Түүнчлэн хувь хүний сэтгэхүйн үйл явцаар дамжуулан бий болдог ойлголт, бодол, төсөөлөл, мөн бие хүний дотоод будилаан зэрэг нь стресс үүсгэгч дотоод хүчин зүйлсэд хамаарах ба стресс үүсгэгчээс хамгийн их хувийг эзэлдэг. Учруулах хохирлыг нь харгалзан стрессоруудыг сул стрессор, дунд зэргийн стрессор, хүчтэй стрессор, сүйрүүлэх хүчтэй стрессор хэмээн ангилдаг. Стрессорын хүчнээс хамааран хөнгөн буюу хүнд стресс үүснэ. Хэдий чинээ хүчтэй стрессор нөлөөлнө, тэдий хэмжээний хүнд стресс үүсэж, стрессийн шалтгаант эмгэгт өртөж болзошгүй. Мөн түүнчлэн сул болон дунд зэргийн стрессорт удаа дараа давтан өртөх тохиолдолд ч стресс, гэмтлийн дараах стрессийн эмгэг үүсэх боломжтой юм.[3]

Стресст өртдөггүй хүн гэж үгүй бөгөөд хувь хүний сэтгэлзүйн хэв шинж, темперамент, зан чанар, итгэл үнэмшил, аливааг үзэх үзэл хандлага, туулж өнгөрүүлсэн амьдралын туршлага, сэтгэлийн тэнхээ, тухайн хүнд нөлөөлж буй стрессорын онцлог, хүч, үргэлжлэх хугацаа, давтамж зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хүн бүр стрессийг харилцан адилгүй мэдэрнэ. Ихэнх стресс нь өдөр тутмын амьдралын ердийн нэг хэсэг бөгөөд хувь хүн үүнийг зохих ёсоор даван туулж чаддаг. Удаан хугацаанд үргэлжилж буй эсвэл илүү ноцтой стрессийн үр дагаврын улмаас мэргэжлийн тусламжид ханддаг байна. Г.Селье нь стресс болгон хортой биш болохыг нотолж, стресс бол бидний амьдралын салшгүй хэсэг, зайлшгүй байх үзэгдэл гэж үзжээ. Стресс нь дараах хэлбэрүүдтэй. Үүнд:

Eustress буюу Эерэг стресс: Хувь хүнийг эрүүл байх, эрч хүч, итгэл найдвар, урам зоригийг мэдрэх, зорилгодоо хүрэх сэдэл тэмүүлэл авах зэргээр өдөөдөг аливаа стресс үүсгэгч хүчин зүйл юм. Жишээлбэл дурлах, хүндэлдэг хүнтэйгээ уулзах, албан тушаал дэвших, шагнуулах, зорьсон зорилгоо биелүүлэх гэх мэт амьдралд тохиолдож буй таатай үйл явдлын нөлөөнд хүн инээх, баярлах, догдлох, сэтгэл ханах, өөрөөрөө бахархах зэргээр эерэг сэтгэл хөдлөлийг мэдэрч амьдралд нь дэм болдог учир энэ нь ашиг тустай стресс юм. Гэвч ховор тохиолдолд эерэг стресс

[2] Brian Luke Seaward. Managing stress. Ninth edition. Paramount wellness institute. Boulder, Colorado, USA. 2018. Jones & Bartlett Learning, Burlington, MA.

[3] Shim Yoongi. Post-traumatic stress disorder and psychological treatment for firefighters, police officers, military personnel and general trauma victims. 2018.

таагүй үр дүнд хүргэх тохиолдлууд бий. Ялангуяа эрүүл мэндийн байдал сул эсвэл настай хүмүүст аль болох сэтгэлээ хүчтэй хөдөлгөхгүй байхыг зөвлөдөг. Учир нь сэтгэл догдлуулсан гэнэтийн сайхан мэдээ нь тухайн хүнийг сэтгэлийн хэт хөөрөлд хүргэж, даралт ихсэх зэргээр бие махбодод сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Neustress: - Авцалдаагүй эсвэл аар саар буюу чухал бус гэж мэдрэгдсэн аливаа төрлийн мэдээлэл, мэдрэхүйн өдөөгчийг хүлээн авахыг хэлнэ. Энэ төрлийн стресс нь үр дагаварт нөлөөлдөггүй, сайн ч биш, муу ч бич стресс юм.

Distress буюу Сөрөг стресс: Дистресс хэмээх үг нь сүйрэл, гай зовлон гэсэн үгнээс үүсэлтэй. Бодит эсвэл төсөөллийн тааламжгүй өдөөгчийн улмаас тухайлбал, ажлын нөхцөл байдалтай холбоотойгоор ажлын ачаалал хэт их байх, ажилтан хоорондын зөрчил будилаан, гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчил, хэрүүл маргаан, аливаа асуудлын талаар тодорхой мэдээлэлгүй боловч хэт сөргөөр ургуулан бодож төсөөлөх гэх мэт стрессоруудын нөлөөгөөр сөрөг сэтгэл хөдлөлүүдийг мэдэрдэг. Сэтгэлийн шаналал дарамтыг мэдэрч цаашлаад амьдрал илүү төвөгтэй болж буй мэт мэдрэх, түгшүүр ихтэй болж, сэтгэлээр унах, асуудлын гарц гаргалгааг олж чадахгүй болох, түүнчлэн стрессийг эерэг аргаар тухай бүрд даван туулж чадаагүйн улмаас сөрөг сэтгэл хөдлөлүүд хуримтлагдсаар байвал сэтгэцийн тулгамдсан асуудал үүсэх, цаашлаад сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгээр өвчлөх эрсдэлтэй.[4]

Цочмог стресс: Хүчтэй боловч богино хугацаанд үргэлжилдэг стресс юм. Стрессийн улмаас богино хугацаанд цусанд норадреналин, адреналины хэмжээ ихэссэнээр зүрх судас, амьсгалын эрхтэн тогтолцоо болон бодисын солилцооны үйл ажиллагаа ихэсдэг. Мөн сэтгэцийн хувьд сөрөг үр дагавар илэрч болно.

Архаг стресс: Хүчтэй биш боловч удаан хугацаагаар үргэлжилдэг стресс ба жишээлбэл санхүүгийн асуудал, үл ойлголцол гэх мэт. Архаг стрессийн үед кортизол даавар нь цусанд удаан хугацаанд тогтвортой хадгалагдсанаар маш олон сөрөг үр дагаврыг бий болгодог. Тэдгээрт дархлаа тогтолцоо буурах, эсийн гэмтэл, анхаарал төвлөрөх чадвар болон ой тогтоолт буурах, даралт ихсэх, өвдөлт мэдрэх чадвар буурах, аз жаргалын даавруудын (серотонин, окситоцин, дофамин)-ын түвшин буурах, аз жаргалыг мэдрэх сэтгэл хангалуун байдал буурах зэрэг үр дагаврууд орно. Улмаар сэтгэл гутрал, таргалалт, зүрх судас болон тархины үйл ажиллагаа алдагдах, хорт хавдар, сэтгэцийн эмгэгээр өвдөх эх үүсвэр болно.[5]

1.3 Ажил мэргэжилтэй холбогдох стресс

Гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбоотойгоор ажлын байранд тулгарч буй аливаа зөрчил, асуудлуудын улмаас цаашид оногдсон албыг гүйцэтгэхэд бэрхшээлтэй нөхцөл байдал үүсэж ажлын байрны стресс бий болдог. Оюуны болон сэтгэл зүйн ачаалал илүүтэй шаардсан ажил хөдөлмөрийн улмаас ажлын байрны стресст өртөх нь түгээмэл байдаг. Гэвч хувь хүний сэтгэлийн тэнхээ, асуудлыг даван туулах чадвар, зан төлөв, мэдлэг туршлага, дадал зуршил, хандлага, түүнчлэн хамт олон болон удирдлагын дэмжлэг, ажлын орчин нөхцөл, урамшуулал, удирдлагын менежмент гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч хүн бүр ажлын байрны стресст харилцан адилгүй өртөж болно. Ажлын байрны стрессийг зохих хэмжээнд даван туулж чадаагүй үед түүний архаг үр дагавар болох ажлаас халшрах хам шинж үүсэж даамжрах нь бий. Түүнчлэн ажлаас халшрах хам шинжийн үр дагавар нь хувь хүнд сэтгэл гутралаар даамжрах, ажлын бүтээмжгүй, ажилдаа дур сонирхолгүй болох цаашлаад ажлаа солих, өөр ажил хийх хүсэлтэй болох эсвэл ажлаас халагдах

[4] С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. Улаанбаатар хот. 2013 он.

[5] Brian Luke Seaward. Managing stress. Ninth edition. Paramount wellness institute. Boulder, Colorado, USA. 2018. Jones & Bartlett Learning, Burlington, MA.

зэргээр илэрдэг бол байгууллагын түвшинд хамт олны уур амьсгалд сөргөөр нөлөөлөх, хүний нөөцийн хомсдолд орох, эдийн засгийн хувьд зохих хэмжээний алдагдал үүсэх, ажилтнуудын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, байгууллагын ажлын гүйцэтгэл, чанар буурч нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.[6]

1.4 Стрессийн улмаас хүний бие махбод, сэтгэлзүйд үзүүлдэг нөлөө

Хүн стресст өртсөнөөр бие сэтгэцийн тэнцвэрт байдал алдагдан бие махбодын болон сэтгэцийн талаас 5 бүлэг шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

1. Физиологийн илрэл
2. Нийгмийн илрэл
3. Сэтгэл хөдлөлийн илрэл
4. Төрх үйлийн илрэл
5. Танин мэдэхүйн илрэл

Физиологийн илрэл: Стрессийн үед симпатик мэдрэлийн тохируулга парасимпатик мэдрэлийн тохируулга хоёрын хоорондын тэнцвэр алдагдаж, симпатик мэдрэлийн хүчдэл давамгайлна. Өөрөөр хэлбэл сэтгэл түгшилт нь мэдрэл-шингэний замаар симпатик мэдрэлийн тогтолцоонд, ялангуяа түүний бүрэлдэхүүн хэсэг болох амьсгал, хоол боловсруулах үйл ажиллагааг тохируулдаг автомат төвд хөөрлийн нөлөө үзүүлнэ. Үүнтэй холбоотой стрессийн үед физиологийн талаас симпатик мэдрэлийн хүчдэл давамгайлсан шинжүүд илэрнэ. Үүнд:

- Хүүхэн хараа хэвийн бус өргөсөх
- Амьсгалахад бэрхшээлтэй болох буюу амьсгаа бачуурах
- Цусны ба шээсний катехоламин ихсэх, мөн кортикостеройд ихсэх
- Цусны глюкоз ихсэх
- Хооллох дур буурах
- Цусны даралт ойролцоогоор 10 мм мөнгөн усны баганын даралтаар ихсэх
- Биеийн энд тэнд халуу эсвэл хүйт оргих гэх мэт тааламжгүй сэрэл үүсэх
- Булчин чангарч улмаар толгой өвдөх, хүзүү гилжийх, булчин нугарахгүй хөших, хэвлийн хана чангарах, гар хөлийн булчин шөрмөсний рефлекс ихсэх

Сэтгэл хөдлөлийн илрэл: Дараах сөрөг сэтгэл хөдлөлийн байдлууд илэрнэ. Үүнд:

- Сэтгэл тогтворгүй болох, сэтгэл зовних
- Сэтгэл түгших, гутрах, гуниглах
- Ганьхрах
- Уурлах, бухимдах
- Ичих, эмээх, гэмших
- Горьдлого тасрах, арга барагдан гаслах
- Өөртөө итгэлгүй болох, өөрийгөө дорд үзэх
- Ганцаардах
- Эргэлзэх, тээнэгэлзэх

Төрх үйлийн илрэл: Түрэмгийлэл бүхий шинжүүд, буруу зан үйлүүд давамгайлан илэрнэ. Үүнд:

- Архи тамхи болон бусад мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх
- Хооллох хэв маяг өөрчлөгдөх
- Хүчирхийлэл үйлдэх
- Зөрүүдлэх

[6] Э.Мөнх, Б.Солонго. Онцгой байдлын алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. Онцгой байдлын салбарын эмч сэтгэл зүйч, алба хаагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар хот. 2022 он.

- Албадмал хөдөлгөөн үйлдэх
- Өөрийн мэдэлгүй гэнэтийн үйлдэл хийх
- Осол сүйдэлд өртөх эрсдэлтэй болох
- Салгалан чичрэх

Танин мэдэхүйн илрэл: Ой тогтоолт, оюун ухааны хүрээг хамарсан өөрчлөлтүүд илэрнэ. Үүнд:

- Анхаарал сарних
- Анхаарал төвлөрүүлэх чадвар буурах
- Мартамхай болох
- Сэтгэн бодох чадвар буурах
- Шийдвэр гаргах чадвар буурах буюу асуудлыг зохистой шийдвэрлэхгүй орхих /зориггүй болох/
- Улигт бодолд автах
- Сэтгэцийн хориг саадтай болох

Нийгмийн илрэл: Хүн хоорондын харилцаа болон нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой тулгамдсан асуудлууд үүснэ. Үүнд:

- Ажил сургуулиасаа таашаал мэдрэхээ болих
- Ажил сургуулиасаа хоцрох, үл ялих шалтгаанаар ажил сургуулиа таслах буюу түүнийг орхих
- Ажлаа олон солих
- Хувийн зохион байгуулалтгүй болох
- Бусадтай харилцах харилцаа үр дүн муутай болох
- Бусадтай зай барьж харилцах буюу нийгмээс өөрийгөө тусгаарлах
- Бусдын хараат болох[7] [8]


СЭДЭВ 2. СТРЕССИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗҮЙ

Зорилго. Энэхүү дэд сэдвийн хүрээнд стресс бүхий нөхцөл байдлыг даван туулахын тулд тухай бүрд өөрт болон бусдад хор гэмгүй эерэг аргаар шийдвэрлэх нь хувь хүнийг сэтгэлийн шалтгаант өвчин эмгэгээр өвчлөхөөс сэргийлэх тухай болон стрессийг тайлах аргууд нь хүн бүрд харилцан адилгүй нөлөөллийг үзүүлдэг талаар дэлгэрүүлэн авч үзье.

Өөрт тохиолдсон сэтгэл зовоосон асуудлын талаар бусадтай ярилцахад зарим хүмүүс уйлж, сэтгэл тайвширч, тайван болдог бол заримд нь сэтгэлийн шаналал улам ихсэж, хямардаг. Иймд хүн бүрд тохирох стрессийг тайлах арга гэж байхгүй тул хувь хүнээс маш их хүчин чармайлт шаардагдана. Стресс нь өөрөө аяндаа арилахгүй, харин түүнд тохирсон хариу арга хэмжээг авснаар стрессээ удирдаж, даван туулах өөрт тохирсон үр дүнтэй аргыг давтамжтай хэрэгжүүлж үр дүнд хүрэх боломжтойг санаарай. Стрессийг даван туулахад дараах алхамуудыг хэрэгжүүлээрэй.

[7] С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. Улаанбаатар хот. 2013 он.

[8] Brian Luke Seaward. Managing stress. Ninth edition. Paramount wellness institute. Boulder, Colorado, USA. 2018. Jones & Bartlett Learning, Burlington, MA.



2.1 Стресс үүсгэгчийг таньж мэдэх, ухамсарлах, хүлээн зөвшөөрөх тухай

Асуудлаа ойлгож, ухамсарласнаар нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх алхам эхэлнэ. Бодит байдалтай нүүр тулах нь хэцүү, тааламжгүй мэдрэмжийг үүсгэх боловч, хэдий чинээ бодит байдлаас зугтаана тэр хэмжээгээр асуудал цааш даамжирсаар байх болно. Тиймээс асуудлыг ойлгож, асуудалтайгаа нүүр тулгарч, түүнээс үүсэж буй мэдрэмжийг үгүйсгэлгүйгээр байгаа хэлбэрээр нь хүлээн авч, хүлээн зөвшөөрөхийн тулд өөрт тулгарсан асуудалдаа цаг зарцуулж эргэцүүлэн тунгаан бодох хэрэгтэй. Үүний тулд:

- Өөрт үүсэж буй таагүй сэтгэл хөдлөл мэдрэмжүүд нь юутай холбоотойг ажиглаарай. Тухайлбал ажил эрхлэлт, гэр бүлийн асуудал, нийгмийн асуудал, өөрийн хүсэл тэмүүлэл зорилго гэх мэтийн алинтай нь хамааралтай байгааг таньж мэдэх нь өөрийгөө ойлгох эхний алхам болно.
- Стрессорт ямар хариу үйлдэл үзүүлж буйг ажигла. Тухайлбал харилцааны зөрчилд байн байн орох, нойр хямрах, амархан уурлаж бухимдах, ажлын бүтээмж буурах, хэтрүүлэн ажиллах зэрэг шинж тэмдгүүд илэрч буй эсэх, хэрэв илэрч байвал түүний урт хугацааны үр дагаврыг эргэцүүлэн тунгаан бодоорой. Үр дүнд нь та өөрт тулгарсан асуудал бэрхшээлийг даван туулах зорилго чиглэлтэй арга хэмжээ авч эхэлж чадна.
- Стресст өртөх үед стресс үүсгэгч хүчин зүйл дээр хэт их төвлөрч, улмаар хэцүү дарамттай мэдрэмжийг үүсгэн, стрессийг даван туулж чадахгүй мэт санагдах нь түгээмэл тохиолддог. Иймд таны амьдралд хэдий таагүй үйл явдал тохиолдож хэцүү байсан ч тухайн үйл явдлын улмаас таны болон ойр дотнын хүмүүст, мөн амьдрал болон ажил эрхлэлтэд ямар өөрчлөлт гарч байгааг анзаар. Магадгүй ямар нэгэн сайн үр дагавар бий болсон эсвэл сургамж авах боломж олдсон гэм мэтээр стресс бүхий нөхцөл байдал нь ашигтай ч байж мэдэх тул стресст хандах хандлага тань өөрчлөгдөнө.

Тохиолдол 1. *“Хууль шүүхийн байгууллагын төсвийн хуваарилалтыг харахад бодлогын гажиг байна. Үнэндээ эдгээр дотроо прокурор шүүх шинжилгээний байгууллагуудад шооврдор гэх үү төсөв хуваарилж байна. Жишээ нь прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэгт нааш цааш явах хэргийн газар, эсвэл шилжүүлж авч ирэхэд бензин шатахуунд 750 мянган төгрөг, цагдаад 3 сая төгрөг байх жишээтэй.” (Аймгийн прокурорын газрын ажилтан).*[9] Тус жишээнээс үзвэл үүсэж буй асуудлыг өөрийн хэмжээд шууд шийдвэрлэх боломжгүй тул танд стресс үүсгэж болзошгүй. Гэвч аливаа зүйлийг байгаагаар нь хүлээж авахаас өөр сонголтгүй байж

[9] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

болно. Стресс үүсгэгчийг хүлээн зөвшөөрч, дасан зохицож чадвал стресст үзүүлэх хариу үйлдэл тань өөрчлөгдөнө.

- Асуудал бэрхшээлийг шийдвэрлэхдээ дараах алхмыг хэрэгжүүлээрэй. Өөрт үүссэн асуудлыг шийдвэрлэхдээ тодорхой бөгөөд бодитой төлөвлөх нь асуудлыг шийдэхэд дөхөм болно. Үүний тулд дараах зарчмыг баримтлаарай:

- Өөрийнхөө ажил, амьдралд тулгарч буй асуудлыг тодорхойл
- Итгэлтэй хүнтэйгээ ярьж, тухайн асуудлыг хөндлөнгийн хүний нүдээр хар
- Тулгамдсан асуудлаа шийдвэрлэх сонголтууд гарга
- Сонголт бүрийн эерэг, сөрөг талыг үнэл
- Үр дагаврыг урьдчилан тооц
- Асуудлаа шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруул
- Асуудлаа шийдэх хугацааг товло
- Төлөвлөгөөний дагуу алхам алхмаар шийдвэрлэ

2.2 Стресс тайлах энгийн аргуудыг хэрэгжүүлэх

Нэг. Стресс үүсгэгчээс зайлсхийж эсвэл өөрчилснөөр нөхцөл байдал өөрчлөгдөнө. Зарим тохиолдолд зайлсхийх нь үр дүнтэй байдаг. Үүний тулд өөрт хамааралгүй зүйлсээс ангид байх, таныг стресстүүлдэг хүмүүсээс зайгаа барих, таныг үргэлж стресстүүлдэг хүнтэй харилцахдаа хязгаар тогтоож шаардлагатай тохиолдолд харилцах, өөрийн хянаж болох хүрээлэл болон орчны хүчин зүйлсийг хянах, зарим ажлыг бусдад даатгаж сурах, мөн зарим тохиолдолд “Үгүй” гэж хэлж чадсанаар өөрт болон бусдад аль алинд нь ашигтай байж болно.

Хоёр. Үүссэн тааламжгүй сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх шаардлагатай. Учир нь үүссэн тааламжгүй сэтгэл хөдлөл, мэдрэмж нь өөрөө аяндаа устаж үгүй болдоггүй хэмээн үздэг. Иймд хамгийн их итгэдэг, таны нууцыг хадгалж чадах дотнын хүн, эсвэл ярилцаж болох асуудлын хэмжээнд ижил төрлийн асуудалтай хүмүүстэй ярилцах хэрэгтэй. Үйл явдлын талаар бусадтай ярилцсанаар бусад хүмүүс таны мэдрэмжийг хуваалцаж, улмаар стрессийн түвшин багасах боломжтой юм. Өөрт үүссэн тааламжгүй мэдрэмжийн талаар бусадтай ярилцах боломжгүй үед тэмдэглэл хөтлөх аргыг хэрэглэх нь үр дүнтэй байж болно. Энэ зорилгоор “Атнасовын хорлогдсон үзэгний арга” хэрэглэж болно.

Атнасовын хорлогдсон үзэгний арга: хэн нэгэнтэй зөрчилдөж, муудалцсан, гомдсон, уурласан үед түүнд хандаж бухимдлаа тайлагдтал буюу сэтгэлээ онгойтол захидал бичнэ. Уг захидалд өөрийн санаанд орж ирсэн бүх бодол санааг, сэтгэл хөдлөл буюу мэдрэмжийг бүгдийг нь бичих хэрэгтэй ба үүний дараагаар бичсэн захидлаа хэд хэдэн удаа чангаар уншаарай. Харин тухайн бичсэн захидлыг урж хаях, шатаах гэх мэтээр өөрийн хүссэн үйлдлийг хийж болох ч зөрчилд орсон хүнд илгээж болохгүй.


Гурав. Өөрийгөө олж харах. Хүн стресст өртсөн үедээ өөрийн сайн сайхан шинж чанар, нөөц чадваруудыг төдийлөн анзаардаггүй. Хүн бүрд олон төрлийн харилцан адилгүй нөөц чадварууд байдаг учир, өөрийн бусдаас илүү давуу чадварыг санан, нөөц чадваруудыг ашиглах хэрэгтэй. Өөрийн эерэг нөөц чадваруудыг таньж, өөрөө өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь сэтгэл санааны байдалд эергээр нөлөөлнө.

Дөрөв. Амьсгалын болон булчин сулруулах, тайвшруулах дасгал хийх шаардлагатай. Жишээлбэл, стресс түргэн тайлах Эверлийн амьсгалын дасгал (Зураг 1) нь хэвлийн амьсгалын дасгалын нэг төрөл бөгөөд дасгалыг тогтмол хийснээр дараах үр дүнд хүрэх боломжтой.

- Хэвлийгээр амьсгалах үед уушгины дээд, дунд, доод бүх хэсэгт агаар жигд нэвтэрч агаарыг хамгийн их хэмжээгээр хүлээн авч улмаар цус хүчилтөрөгчөөр

илүү хангагдана.

- Өрц доошлох үед хэвлийн хөндийд даралт үзүүлнэ. Үүний үр дүнд хэвлийн эрхтнүүдийн гүрвэлзэх хөдөлгөөн, цусны эргэлт сайжирна.
- Мэдрэл тайвшруулна. Стресс тайлна, хүчдэлийг сулруулна.
- Стресст өртсөн ч түүнийг хөнгөнөөр даван туулах чадвартай болно.[10]



Зураг 1. Амьсгалын дасгал

Тав. Цагийн менежмент сайтай байх. Анхаарал төвлөрүүлэн ажил гүйцэтгэхэд саад болж зүйлсийг цэгцлэх, жишээлэл ажлын цагуудад шаардлагагүй гар утасны мэдэгдэл, дуудлагыг хүлээн авахыг хязгаарлан гар утасны мэдэгдлийн тохиргоог өөрчлөх зэрэг.

Зургаа. Өөртөө анхаарал тавих. Үүний тулд амьдралын буруу хэв маягийг зөв дадалд оруулах буюу зан үйлээ өөрчлөх шаардлагатай. Аливаа эерэг зан үйлийг дадуулахад удаан хугацааны туршид суралцдаг бөгөөд, үүнтэй адил эмгэг зан үйлийг аажмаар өөрөө ч мэдэлгүй суралцаж дадал болгосон байдаг хэмээн дасан сурахуйн онолоор тайлбарладаг. Иймд ашиггүй, буруу, сөрөг зан үйлээс ангижрахын тулд бас л сурах процесс явагдах учиртай. Тиймээс эдгээр алхмыг хэрэгжүүлэхэд маш их хүчин чармайлт, уйгагүй зүтгэл, зохион байгуулалт шаардагдана. Өөртөө анхаарал тавьж, хэрэгжүүлэх алхмууд:

[10] Э.Мөнх, Б.Солонго. Онцгой байдлын алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. Онцгой байдлын салбарын эмч сэтгэл зүйч, алба хаагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар хот. 2022 он.

2.3 Ажил эрхлэлтэй холбоотой стресст өртсөн үед хувь хүний түвшинд хэрэгжүүлэх алхам

- **Ажилдаа хандах хандлагаа өөрчлөх.** Ажилдаа хандах сөрөг хандлагаа өөрчилж тухайн ажил үүргийг гүйцэтгэснээр өөрт тань эергээр нөлөөлдөг өөрчлөлтүүд, үр дүнд анхаарал хандуулаарай. Түүнчлэн хүн ажил үүрэг гүйцэтгэх нь өөрийн амьдралыг залгуулах, ажил мэргэжлийн амжилтад хүрэх, нийгэм хамт олны дунд харилцаанд орох, өөрийгөө хөгжүүлэх, бусдад тусалснаар эерэг сэтгэл ханамж авах зэрэг хэрэгцээгээ хангаж буй үйл явц учир өөрийнхөө төлөө ажиллаж байгааг ухамсарлаж, ажилдаа чин сэтгэлээс дурлаж, сэтгэлээрээ хандаж, хандлагаа өөрчлөөрэй.
- **Ажлын орчинд хувийн зохион байгуулалтыг сайжруулах**
  - ✓ Ажил албаны хов ярианаас хол байхыг хичээх. Энэ нь хамт олонд сөрөг уур амьсгалыг бий болгож, эцэст нь танд сөргөөр нөлөөлнө.
  - ✓ Шударга шүүмжлэлд уурлаж бухимдалгүй хүлээн авч, зохистой дүгнэлт хийх
  - ✓ Ажлын орчныг эмх цэгцтэй байлгаж, ажилд саад болох зүйлсээс салах
  - ✓ Мэргэжлийн карьерын хувьд өөртөө хэрэгжиж болохуйц зорилт тавих
  - ✓ Ажлаа гүйцэтгэхдээ яаралтай, чухал ажлаасаа эхэлж эрэмбэлэн хийх зарчмаар ажлаа төлөвлөх
  - ✓ Өөрийн хүч бололцоогоо бодитой үнэлэх.
  - ✓ Хамтран ажиллагсдаа ойлгохыг хичээх, болж өнгөрсөн зүйлүүдээс сургамж авах
  - ✓ Хүмүүст тохиолдож болох бүх асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж чадахгүйдээ бухимдаж магадгүй. Гэхдээ энэ нь таны үүрэг биш гэдгийг санаарай. Хүмүүст туслахын тулд чадах бүхнээ хийсэн бол бага ч гэсэн тусалж чадсан зүйлээ хүлээн зөвшөөрч байх.
  - ✓ Ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх.
  - ✓ Хамтран ажиллагсад, хамт олонтой эерэг харилцаатай байх. Тэдэнтэй хүндэтгэлтэй, нээлттэй байдлаар харилцаж, ажлын талаар бүтээлч санал зөвлөмж өгөх, хүлээн авах чадварыг хөгжүүлэх.
  - ✓ Үзэл бодлын зөрүүтэй асуудалд хүндэтгэлтэй хандах. Бусдын үзэл бодлыг ойлгох, өөрийн үзэл бодлыг тайвнаар тайлбарлах, үүссэн үзэл бодлын зөрчилдөөнийг шууд бөгөөд нээлттэй байдлаар шийдвэрлэх.
- **Эерэг сэтгэлгээг хөгжүүлэх.** Аливааг асуудлыг эерэг талаас нь харах чадвартай, өөдрөг үзэлтэй хүмүүс зүрх судасны эрүүл мэндийн хувьд сайн байдаг төдийгүй, сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, таргалалт зэрэг өвчинд өртөх нь бага байдаг хэмээх судалгаа бий. Энэ төрлийн хүмүүс стресс, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд өртөх нь харьцангуй бага байдаг хэмээн ойлгож болно. Ажлын орчинд стресс бүхий нөхцөл байдалд өртсөн үед аливааг эерэг талаас нь сэтгэн бодох аргын талаар дор жишээ дурдав.

Эерэг сэтгэлгээний жишээ

- ✓ Хов зөөдөг ажилтан – Мэдээлэл түгээгч
- ✓ Ууртай ажилтан – Энэ хүн стрессээ гадагшлуулж байна даа
- ✓ Ажлаас үргэлж хоцордог ажилтан – Гэр бүлд нь ямар нэгэн асуудал тулгарсан байх
- ✓ Байнга ажил хянадаг дарга – Хариуцлагатай, ажилчдаа алдаа зөрчил гаргахаас сэргийлдэг
- ✓ Өдөр тутмын ажилд байнга оролцдог дарга – Ажилдаа сэтгэлтэй
- ✓ Бусдын амжилтад атаархагч – Атаархаж байгаа учир илүү сайн хичээх сэдэл авсан байх
- ✓ Алдааг сануулагч удирдлага – Бусад ажилчдыг алдаа гаргахаас сэргийлж байна.

➢ **Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх.**

Тохиолдол 2. *“Орон тоо гарахад туслах ажилтнууд шууд томилогддог. Тэдний мэргэжлийн ур чадвар шууд прокурорын ажлыг гүйцэтгээд явахад туйлын хангалтгүй учраас, дээд шатны прокурор, ер нь орлогч болон даргын ачаалал шууд нэмэгдэж байгаа юм. Ер нь шинэ ажилтнуудын ажлыг хэсэгтээ хийнэ гэсэн үг.” (Аймгийн прокурорын ажилтан).*[11]

Энэ тохиолдлоос үзвэл туршлагагүй, чадваргүй эсвэл ажлын гүйцэтгэл удаан, үр дүн муутай ажилладаг гэх мэт шалтгааны улмаас тухайн ажилтны ачааллыг хэн нэгэн өөр дээрээ авч ажиллах нь буруу юм. Учир нь тухайн ажилтан хялбар аргаар ажлаа бусдаар гүйцэтгүүлэх арга барилд суралцах, хамт ажиллагсдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх эрсдэл нь их учир зохих зөвлөмжийг өгч, өөрөөр нь гүйцэтгүүлэх хэрэгтэй. Нөгөө талаар өөр дээрээ ажлын ачааллыг авч буй хүмүүсийн хандлага буруу байх тохиолдол бий. Тухайлбал, ажилтныг өөртэйгөө ижил арга замаар ажиллуулах гэж зүтгэх, би л энэ ажлыг хийхгүй бол бусад нь дутуу хагас чанаргүй хийх байх зэргээр өөрийгөө хэт өндрөөр үнэлсэн хандлага, эсвэл хэтийдсэн хатуу шаардлага тавих хандлага гаргадаг учир анхааараарай.

➢ **Өөрийгөө хөгжүүлэх.**

Тохиолдол 3. *“Прокурорын залуучууд ажлын ачааллаа даахгүй явдал маш их гардаг. Тэдний ажлын туршлага хомс, мэдлэг ур чадвар бага байдал, дээрээс нь хувийн зохион байгуулалт тааруухан байгаа нь ажлын ачааллыг бий болгож байна. Залуу прокуроруудыг сургах, чиглүүлэх ажлыг сайн хийх хэрэгтэй.” (Дүүргийн прокурорын ажилтан).*

Тохиолдол 4. *“Шинээр прокурор болж буй хүмүүсийн мэргэжлийн ур чадвар туйлын хангалтгүй ба тэдгээрийг туслах ажилтнаас прокуророор томилон ажиллуулах хоорондмэргэшүүлэх шаардлага бодитой байна. Тэднийг мэргэшүүлдэг сургалтын тогтолцоо алга байна, тийм сайн хөтөлбөр байхгүй байна.” (Дүүргийн прокурорын газрын ажилтан).*[12]

Дээрх 2 тохиолдлоос үзвэл залуу мэргэжилтнүүдийн чадавх сул байгааг харуулж байна. Залуу болон шинээр ажилд орж буй хүмүүс тухайн ажлын орчин нөхцөл,

[11] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

[12] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

хамт олон дунд дасан зохицох хэрэгцээ шаардлага тулгарахаас гадна, ажил мэргэжлийн хувьд туршлагагүй байдал, өөрийгөө хамт олон болон удирдлагадаа таниулах хэрэгцээний улмаас хэт их хүчин чармайлт гаргах, түүнчлэн ажиллахын зэрэгцээ өөрийгөө хөгжүүлэн суралцах, гэр бүлийн амьдрал төлөвлөлт, шинээр гэр бүл зохиох зэрэг хэд хэдэн ачааллыг зэрэг авснаар ажлаас халшрах хамшинжид өртөх эрсдэл их байдаг. Гэвч мэргэжилтэн бүрийн хувийн хандлага, идэвх зүтгэл, ажил мэргэжлийн амжилтад хүрэх хүсэл тэмүүлэл, хувь хүний зохион байгуулалт, харилцааны болон асуудлыг шийдвэрлэх чадвар, ажил мэргэжилтэй холбоотой ур чадварууд зэрэг олон хүчин зүйлээс хамаарч залуус бүгдээрээ халшрах хамшинжид өртдөггүй. Иймд эзэмшсэн мэргэжил, компьютер техник хэрэгсэлтэй ажиллах, харилцааны гэх мэт ур чадвараа ахиулахын тулд хувийн зохион байгуулалт сайн хийж өөрийгөө хөгжүүлэн суралцаарай.[13]

Тохиолдол 5. *“Зөрчлийн прокурор цагдаагийн байгууллагын тоо бүртгэгч болох нь холгүй байна. Энэ гомдлыг ингэж шийдвэрлэнэ, хүний эрх зөрчигдөж байна, гомдлын шийдвэрлэх хугацаа дуусна, энийг ингэж бүртгэ гээд явдаг. Энэ цагдаагийн байгууллагын удирдлагын ажил баймаар. (Аймгийн прокурорын ажилтан).* Энэ тохиолдолд *ажил үүргийг ялгах, зохих шаардлагыг тавих, өөрийн эрх бүхий удирдлагад мэдээлэх, шаардлагатай бол өөрсдийн гүйцэтгэж буй ажлын чиг үүргийн хүрээнд ажил үүргийг гүйцэтгэх талаар албан ажил өрнүүлэх санал санаачилга гаргаж ажиллах.*

Тохиолдол 6. *“Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 30 хоногийн дотор хийгдсэн байх ёстой учраас хугацаандаа багтахын тулд олон шүүх хурлыг зэрэг товлодог. Гурван дүүрэг нэг шүүхтэй. Бүгд хойшилдог. Үүнийг яаралтай шийдэх хэрэгтэй. Хэрэв шүүх хуралдаан зарлагдсан бол яг тэр цагтаа л хийдэг байхыг хатуу заах хэрэгтэй (Дүүргийн прокурорын ажилтан).”*

Тохиолдол 7. “*2017 оноос хойш төрийн өндөр албан тушаалтантай холбоотой хэргүүдийг шалгаж эхэлсэн. Ийм байдлаас болж сошиал орчинд анхаарлын төвд ороод хуулийн дагуу шийдвэр гаргахад нөлөөлж байна (Дүүргийн прокурорын газрын ажилтан).”*

Тохиолдол 8. “*Хан-Уул дүүргийн хувьд эхний улирлын байдлаар 98 шүүх хуралдаан цагтаа эхлээгүй хойшилсон. Хурлын заал хүрэлцээгүй. Манай шүүх Сонгинохайрханд байдаг. Өглөө 08:30 цагт шүүх хуралтай гээд очдог. Өдөржин байлгаж байгаад 13 цаг болонгуут хойшиллоо гээд буцаадаг. Ирсээр байтал 15 цаг болдог. Энэ үйл явц бараг өдөр бүр тохиолдож байна.” (Дүүргийн прокурорын ажилтан).*[14] Дээрх тохиолдлуудад ажил үүрэг гүйцэтгэхэд бэрхшээлтэй байгаа асуудлын талаар хамт олноороо хэлэлцэн ярилцаарай. Ярилцлагын үр дүнд тухайн асуудал нь ажилтнуудын дийлэнхэд нь тохиолдож буй асуудал гэж дүгнэвэл тухайн асуудлыг шийдвэрлэж болохуйц арга замуудын талаар хамт олноороо нэгдэж санал санаачилга гарган, түүнийг удирдлагад мэдээлэх, саналаа илэрхийлж, ажил хэрэг болгоорой. Харин тухайн асуудал нь маш ховор тохиолддог асуудал хэмээн дүгнэвэл хувь хүн өөрөө хэт эмзэг хүлээн авч байх талтай учир тухайн асуудал нь ажил үүрэг гүйцэтгэхэд ямар хэмжээгээр нөлөөлж буйг тунгаан бодох, яльгүй зүйлд стресстэж бухимдаад байгаа нь өөртөө анхаарал хандуулах болсныг илтгэнэ.

Тохиолдол 9. *“2022 онд туслах ажилтнуудад зориулсан бүтэн өдрийн онлайн сургалтыг хийсэн, хэдэн хүн хамруулах талаар судалгаа гаргаж тоо өгсөн, тэгээд*

[13] Э.Мөнх, Б.Солонго. Онцгой байдлын алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. Онцгой байдлын салбарын эмч сэтгэл зүйч, алба хаагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар хот. 2022 он.

[14] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

байгууллагууд өөр өөрсдөө зохицуулалт хийгээд хамруулах хүнээ хамруулаад явсан. Үр дүнгийн хувьд бол яг үнэлгээ хийж, давуу сул талаа ярилцах хэрэгтэй санагддаг (Аймгийн прокурорын газрын ажилтан)."

Тохиолдол 10. "*Манай байгууллагын хэмжээнд сургалт хангалттай явуулдаг боловч үр дүн муутай явагддаг. Туршлагагүй хүмүүс сургалт хийх нь өгөөжгүй байдаг. Гадны орнуудтай том эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, гадны олон улсын газраас чанартай сургалт хиймээр байна." (Аймгийн прокурорын газрын ажилтан)*.[15]

Шаардлагагүй хурал цуглаан, өр өгөөжгүй буюу хэрэгцээгүй сургалт нь ажилтнуудын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, ажиллах дур сонирхлыг бууруулах хандлагатай байдаг тул удирдах түвшний ажилтнуудын зайлшгүй анхаарах зүйлийн нэг юм.4 Харин ажилтнууд өөрт хэрэгцээтэй байгаа сургалтын талаар нээлттэй санал санаачилга гаргаж, тухайн байгууллагаас сургалтын хэрэгцээг тодорхойлж буй санал асуулгад идэвхтэй оролцох хэрэгтэй.

2.4 Мэргэжлийн тусламжид хандах:

Бусдаас дэмжлэг хүсэх. Шаардлагатай тохиолдолд бусдаас дэмжлэг хүс. Бусдаас тусламж хүсэх нь ичгэвтэр, эсвэл тусламж хүсэх нь сул дорой байдлыг илтгэнэ хэмээн бодох нь буруу ойлголт юм. Тиймээс тусламж хэрэгтэй үед бусдаас тусламж хүсэж дэмжлэг авах нь бэрхшээлийг даван туулахад тус болно. Үүний тулд өөрийн байгууллагын сэтгэл зүйчид хандах, шаардлагатай гэж үзвэл харьяа дүүргийн эмнэлгийн сэтгэцийн эмч, сэтгэл зүйчид хандаж тусламж аваарай.

Тохиолдол 11. *"Прокурорын байгууллагад ажиллаж байгаа эмэгтэйчүүд ихэнх нь нэг бол гэр бүлгүй, эсвэл гэр бүлээ цуцалсан байдаг. Ажил гэр бүлийн тэнцвэрт харилцаа байх ямар ч боломжгүй. Жендерийн асуудлыг огт авч ярьдаггүй. Эмэгтэй ажилчдыг дэмжих бодлого гэж байдаггүй. Хүний нөөцийн бодлогод ч тусгадаггүй. Хувийн амьдрал шууд золиослогддог. Ер нь ар гэрээс асар их дарамттай ажилладаг." (Дүүргийн хяналтын прокурор).*

Тохиолдол 12. *"Ажлаас бол үнэхээр халширч байна. Манайд өглөө ажилдаа дуртай инээж ирдэг хүн бараг байхгүй шүү. Бүгд яана л гэж ирдэг. Ялангуяа эмэгтэйчүүд илүү их халширч байна. Ихэнх нь гэр бүлгүй, эсвэл гэр бүл нь салсан байдаг. Ер нь прокурорын байгууллагын ажлыг 40 гаран насны эмэгтэйчүүд их ачаа үүрч, нугалж байгаа шүү. Ар гэр, залуу насаа золиослоод зүтгэсэн. Эрчүүдээсээ ялгагдах юмгүй болж байна. Зан ааш нь ч хатуу болж байна. Энийг бас бодох ёстой л байх." (Дүүргийн хяналтын прокурор)*.[16]

Дээрх 2 тохиолдлыг авч үзвэл прокурорын байгууллагын ажлыг гүйцэтгэхэд хүйсийн онцлог хамааралтай мэт ажиглагдаж байгаа боловч хувь хүний сонголт, нийгэмд өөрийгөө үнэлж буй тухайн хүний үзэл санаа гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг байх талтай. Мөн ажил ажил үүргийн хүрээнд ажил мэргэжлийн амжилтад хүрэх хүсэл тэмүүлэл ихтэй байх хэрэгцээ шаардлагын улмаас гэр бүлийн хүрээнд хувь хүн, эх, эхнэр, гэрийн эзэгтэй байх үүрэг хариуцлагын тэнцвэр алдагдаж, улмаар ажил амьдралын тэнцвэрт байдалд нөлөөлж болно. Иймд ажил мэргэжлийн амжилтад хүрэх хүсэл тэмүүлэл хэрэгцээ ихтэй байсан ч хувь хүн, эх, эхнэр, гэрийн эзэгтэй байх нь ч хувь хүний чухал хэрэгцээ болохыг хүлээн зөвшөөрч ажил амьдралыг тэнцвэртэй авч явахад анхаарах шаардлагатай. Дээрх тохиолдлуудтай

[15] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

[16] МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

ижил төстэй асуудал тулгарч амьдралын хэмнэл өөрчлөгдөж, дасан зохицоход бэрхшээл тулгарч буй тохиолдолд мэргэжлийн хүнд хандаж тусламж авааарай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. Улаанбаатар хот. 2013 он.
2. Brian Luke Seaward. Managing stress. Ninth edition. Paramount wellness institute. Boulder, Colorado, USA. 2018. Jones & Bartlett Learning, Burlington, MA.
3. Shim Yoongi. Post-traumatic stress disorder and psychological treatment for firefighters, police officers, military personnel and general trauma victims. 2018.
4. Э.Мөнх, Б.Солонго. Онцгой байдлын алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. Онцгой байдлын салбарын эмч сэтгэл зүйч, алба хаагчдад зориулсан гарын авлага. Улаанбаатар хот. 2022 он.
5. American Psychiatric Assocation. Diagnostic and Statistical Manual of Mental Disorders (DSM-5).
6. UpToDate олон улсын цахим платформ.
7. МУИС, Нийгмийн судалгааны хүрээлэн. Монгол Улсын прокурорын байгууллагын системийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2022 он.

БҮЛЭГ 19. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛ

СЭДЭВ 1. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ


1.1 Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хяналтын ажлын модуль
1.2 Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын ажлын модуль
1.3 Шүүхэд төрийг төлөөлөх хяналтын ажлын модуль
1.4 Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хяналтын ажлын модуль

СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ (ERP)-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ

2.1 Үүрэг даалгавар, түүний биелэлт тооцох, ажлын төлөвлөгөө гаргах
2.2 Албан хэрэг хөтлөлт (Албан бичиг боловсруулалт, хүлээн авах, хариуг илгээх)
2.3 Цахим гарын үсэг ашиглах тухай ойлголт


СЭДЭВ 1. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

1.1 ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ



1. ЗӨРЧЛИЙН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1 Зөрчлийн гомдол, мэдээллийн ХАЙЛТ хийх цэс



Жишээ нь он дараалаар, хяналт тавьж буй прокурорын нэр, гомдлын төлөв, шийдвэрийн төрөл, гомдлын дугаараар гэх мэт.

Мөн хайлтын хэлбэрүүдийг давхар сонгож хайлт хийх боломжтой бөгөөд жишээ нь 2018 оны 1 дүгээр улиралд “Хялбаршуулсан” журмаар шалгаж шийдвэрлэсэн зөрчлийн гомдол, 2020 зөрчлийн гомдол мэдээллээс гэмт хэргийн шинжтэй үндэслэлээр “Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн” гомдол хайх гэх мэтээр ашиглах боломжтой.

Тайлбар: Системийн хайлтын хэсгүүдээс хэрэглэгч өөрт шаардлагатай нийт 24 үзүүлэлтээс сонгож хайлт хийх боломжтой.

1.2 Зөрчлийн гомдол мэдээллийг хяналтын прокурорт ЦОХОЛТ хийх цэс.



Тайлбар: Гомдол мэдээлэл цэсийн Цагдаагаас татагдсан гомдлууд цохолт хийх товчлуурыг идэвхтэй болгосноор цагдаа, прокурорын байгууллагын цахим системийн дундын санд байршсан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл жагсаалтаар харагдах бөгөөд гомдлын дугаараар хайлт хийж тухайн гомдлын өмнөх дөрвөлжин нүдийг идэвхжүүлэн цохолт хийх товчлуурыг дарж тухайн прокурорын нэрийг сонгож хадгална.

Ингэснээр тухайн чек хийсэн гомдлын тоогоор цохолт хийгдсэн прокурорын хяналтад буюу цахим бүртгэлээр тухайн прокурорт шилжинэ.

Цохолт хийх жагсаалтад дахь гомдол, мэдээлэл нь Цагдаагийн цахим санд бүртгэгдсэн даруйд автоматаар дундын санд шилждэг.

1.3 Зөрчлийн гомдол мэдээллийг шинээр БҮРТГЭХ цэс.




Гомдол мэдээлэл шинээр бүртгэх цэсний бүх талбарын өгөгдлүүдийг бүрэн бүртгэсний дараа хадгална.

Гомдол гаргагч, холбогдогч тодорхой эсэх товчлуурыг идэвхжүүлснээр Иргэний бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбогдох бөгөөд гомдол гаргагч, холбогдогчийн регистрийн дугаарыг ашиглан /хайлт хийж/ бүртгэлүүдийг зааврын дагуу бүртгэнэ.

Гомдол, мэдээллийг дундын сангаас цохолт хийх эсхүл шинээр бүртгэх талбарыг сонгож үндсэн 2 аргаар цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэх боломжтой.

Гомдол мэдээллийг бүрэн бүртгэсний дараа Зөрчил үйлдэгдсэн газар бүртгэх талбар гарч ирэх бөгөөд энэ талбарыг бүртгэснээр цахим системээс зөрчил үйлдэгдсэн газар, бүс нутгаар судалгааг гаргадаг тул бүрэн бүртгэх шаардлагатай.


1.4 Зөрчлийн гомдол, мэдээлэлд эрх бүхий албан тушаалтны ШИЙДВЭР бүртгэх цэс



1. Шийдвэрийн төрөл цэсэнд эрх бүхий албан тушаалтны шийдвэр төрлөөрөө задрах бөгөөд тухайн шийдвэрт тохирох сонголтыг сонгож бүртгэлийг хийнэ.
2. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн огноог сонгож өгнө.
3. Эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүртгэхийн өмнө холбогдогч заавал бүртгэсэн байх бөгөөд холбогдогч хэсэгт дархад урьдчилж бүртгэсэн холбогдогчын мэдээлэл автоматаар гарч ирнэ.


4. Холбоглох бүх мэдээллийг оруулж дуусад заавал нэмэх тэмдэглэлгээг дарсанаар хадгална.

1.5.1 Гомдол, мэдээллийг ЗШШ БАЙГУУЛЛАГА ХООРОНД ХАРЬЯАЛЛЫН дагуу шилжүүлэх цэс.



1. Гомдол, мэдээллийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага хооронд буюу прокурорын хяналт өөрчлөгдөхгүйгээр байгууллага хооронд шилжүүлэх бүртгэлийг бүртгэхдээ шилжүүлэх төрлийг эхэлж сонгоно.
2. Шилжүүлэх байгууллага сонгож /шилжин очиж байгаа байгууллага/ хадгалах үед цахим бүртгэлд эрх бүхий байгууллага солигдсон байдлаар харагдана.


1.5.2 Харьяаллаар шилжиж ирсэн гомдол, мэдээлэлд ШИЙДВЭР бүртгэх цэс.



1. Харьяаллын дагуу шилжиж ирсэн гомдол, мэдээлэл дээрх төлөвтэй харагдана.
2. Эрх бүхий албан тушаалтны санал, шийдвэр бүртгэхдээ шийдвэрлэлт бүртгэх цэсийг сонгож бүртгэлийг хийсний дараа прокурорын шийдвэрийг бүртгэнэ.
3. Нэг гомдол, мэдээлэлд 1 түүнээс дээш удаа эрх бүхий албан тушаалтны санал, шийдвэр


бүртгэх тохиолдол гарах бөгөөд жишээ нь /эрх бүхий албан тушаалтан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэлд прокурор нэмэлт ажиллагаа хийлгэхээр эсхүл гомдлоор дахин хянаад зөрчлийн хэрэг нээлгэхээр даалгасан тохиолдолд ЭБАТ дахин нээх саналтай оруулж ирж болно/ энэ тохиолдолд 2 дахь саналыг бүртгэхдээ эрх ЭБАТ хүлээн авсан огноог сүүлд хүлээж авсан огноогоор солино. Сольж бүртгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн мэдээний мөрөнд тоологдоно.

1.5.3 Зөрчлийн гомдол, мэдээллийг ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА ХООРОНД харьяаллын дагуу шилжүүлэх бүртгэл бүртгэх цэс




1. Эрх бүхий байгууллага, прокурорын хяналт зэрэг шилжиж өөр прокурорын газрын хяналтад шилжүүлэх бүртгэл бөгөөд шилжүүлэх төрөл цэсээс прокурорын байгууллага хооронд төрлийг сонгоно.
2. Шилжиж очих прокурорын газрыг сонгоно.
3. Шилжүүлэх байгууллага сонгож /шилжин очиж байгаа байгууллага/ хадгалах үед тухайн нэгжийн цахим бүртгэлээс хасагдаж шилжиж очсон прокурорын газрын нэр дээр харагдана. /бусад огноо, шийдвэрийн дугаар гэх мэт бүрэн бүртгэсний дараа хадгалах товч идэвхтэй болно.

1.5.4 Зөрчлийн гомдол, мэдээлэлд ХАРЬЯАЛАЛ ТОГТООЛГОХ эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүртгэх цэс




Улсын Ерөнхий Прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар нь дээд шатны прокурорын хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, эсхүл зөрчлийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын газрын саналыг үндэслэн, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах болон прокурорын хяналтын харьяаллыг тогтооно. Энэ тохиолдолд шилжүүлэх төрөл талбараас хяналт тогтоолгох төрлийг сонгож бүртгэлийг хийнэ.

1.5.5 Зөрчлийн гомдол, мэдээллийг ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүртгэх цэс.




1. Эрх бүхий албан тушаалтан хүлээн авсан огноо гомдол, мэдээлэл бүртгэгдсэн огноогоор автоматаар татагдах бөгөөд уг хугацаанаас хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэр гаргана.
2. Татгалзсан үндэслэлийг сонгож хадгална.

1.5.6 Зөрчийн гомдол, мэдээлэлд ХЯЛБАРШУУЛСАН журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн ЭБАТ-ын ШИЙДВЭР бүртгэх цэс




1. Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авсан бол дарж орсноор бусад цонх идэвхтэй болно.
2. Торгуулийн шийтгэлтэй хамт эрх хасах арга хэмжээ хэрэглэсэн бол хамт дарж мэргэжлийн үйл ажиллагаа, эрхийн нэр, эрх хассан хугацааг оруулж өгнө.
3. Торгуулийн хэлбэр төрлөөрөө задарна. /бэлэн, бэлэн бусаар/
4. Хуулийн хугацаагаар задарна.
5. Эрх бүхий албан тушаалтан торгуулийг хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол хугацааг бүртгэнэ.
6. Эрх хассан хугацаа жил, сараар
7. Торгууль ноогдуулсан хуулийн зүйл, заалт бүртгэх хэсэг.
8. Мэдээллийг бүрэн оруулж заавал нэмэх дарснаар хадгална.



1. Хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн материалыг цахим бүртгэлд бүртгэсний дараагаар “төлөлт, өршөөл” цэс идэвхтэй болно.
2. Өршөөлийн тухай хуульд заасан үндэслэлээр шийтгэлээс чөлөөлөх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дугаар байна.
3. ЭБАТ өршөөлд хамруулсан шийдвэрийн дугаар
4. Торгох шийтгэлийн биелэлт төрлөөр задарч харагдана. Биелэлтийг тухай бүр заавал бүртгэх шаардлагатай.


Төлөлт болон өршөөлд хамрагдаж шийтгэлээс чөлөөлөгдсөн 2 тусдаа ойлголт тул анхаарах шаардлагатай.

1.5.7 Зөрчийн гомдол, мэдээлэлд ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭХ ЭБАТ-ны шийдвэр бүртгэх цэс




1. Эрх бүхий албан тушаалтан шийтгэлээс чөлөөлж албадлагын арга хэмжээ авах тухай тогтоол үйлдсэн тохиолдолд тийм сонголтыг сонгож бүртгэнэ.
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг шалгахад тусгай журмаар шалгах бөгөөд хуульд заасан бусад тохиолдолд ердийн журмаар шалгаж шийдвэрлэнэ.

1.5.8 Зөрчлийн гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй үндэслэлээр харьяаллын дагуу шилжүүлэх ЭБАТ-ЫН ШИЙДВЭР бүртгэх цэс.




Эрх бүхий албан тушаалтан гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд даруй харьяаллын дагуу шилжүүлэх санал үйлдэж прокурорт ирүүлэх бөгөөд саналыг өгөгдлийн дагуу бүртгэнэ.

1.6 Прокурорын ШИЙДВЭР бүртгэх цэс.



Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг бүртгэж хадгалахад прокурорын шийдвэр цэс идэвхтэй болох бөгөөд шийдвэрийн төрөл цэсээс сонгож хадгална. Бүртгэл хийхдээ хуулийн хугацаанд прокурор хянасан эсэхийг нягталж цахим бүртгэлийг бүртгэнэ.

Шийдвэрийн төрлийг сонгож бүртгэл хийхдээ ЭБАТ шийдвэрийг хэвээр үлдээсэн, зөрчлийн хэрэг нээсэн төрлүүдээс бусад тохиолдолд прокуророос эрх зүйн хэлбэр үйлддэг тул тогтоолыг сайтар нягталж төрлийг зөв сонгож бүртгэлийг хийнэ.




1. Эрх бүхий албан тушаалтны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг прокурор дараах 3 үндэслэлээр хүлээн авч хянана. Бүртгэлд авч хянах тохиолдолд ажлын 5 хоног тоологдох бусад 2 тохиолдолд тухай бүрд нь прокурорын шийдвэрийг оруулах ба хяналтын хугацаа хэтрүүлсэн мэдээний мөрөнд буухгүй.
2. Эрх бүхий албан тушаалтны татгалзаж шийдвэрлэсэн материалыг прокурор хянаад дараах 5 шийдвэрийн аль нэгийг гаргана.

1.6.1 Зөрчлийн гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй үндэслэлээр харьяаллын дагуу шилжүүлэх тухай ЭБАТ-н шийдвэрт ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ТУЛ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА РУУ ШИЛЖҮҮЛСЭН прокурорын шийдвэр бүртгэх цэс

Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг бүртгэлээр авч гэмт хэргийн шинжтэй бол эрх бүхий байгууллагат шалгуулахаар шилжүүлэх үед энэ бүртгэлийг бүртгэнэ.


1.7 Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг оролцогчийн гомдлоор прокурор дахин хянах.



Шийдвэрлэсэн зөрчлийн материал, хэргийг оролцогчийн гомдлоор дахин хянаж прокурор шийдвэр гаргасан тохиолдолд ЭБАТ-ны санал дахин бүртгэхгүй бөгөөд өмнөх прокурорын шийдвэр дээр нэмж бүртгэн хянах үндэслэл хэсэгт “оролцогчийн гомдлоор” хэсгийг сонгож бүртгэлийг хийнэ. Хянах үндэслэлийг буруу сонговол хяналтын хугацаа хэтэрсэн мэдээний мөрөнд тоологдоно.

Хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн болон бусад шалгалтыг хийгээд прокурор шийдвэр гаргасан тохиолдолд уг үндэслэлийг сонгож шүүхэд бичсэн прокурорын дүгнэлт бусад эрх зүйн хэлбэрийг хугацаа алдахгүйгээр бүртгэлийг хийнэ.


1.8 Шалгасан нийт хоног, гомдол гаргагч, холбогдогч нэмж бүртгэх.



1. Уг товчлуурыг ашиглан гомдол гаргагч цэс рүү шилжихгүйгээр гомдол гаргагч нэмж бүртгэх боломжтой.

2. Уг товчлуурыг ашиглан холбогдогч цэс рүү шилжихгүйгээр холбогдогч нэмж бүртгэх боломжтой.
3. Гомдол, мэдээлэл хүлээн авсан өдрөөс ЭБАТ шалгаж шийдвэрлэсэн нийт хугацаа


1.8.1 Зөрчийн гомдол, мэдээлэлд Гомдол гаргагч, холбогдогч, гадаадын иргэн, хуулийн этгээд бүртгэх цэс



1. Дундын сангаас гомдол цохолт хийхэд гомдол гаргагч автоматаар татагдах бөгөөд шинээр бүртгэх тохиолдолд хүн, албан тушаалтан, хуулийн этгээд аль тохирохыг сонгож бүртгэнэ.
2. Гомдол гаргагч болон холбогдогчийн регистрийн дугаарыг оруулж хайх хэсгийг дарснаар Иргэний бүртгэл мэдээллийн сангаас нийт 7 төрлийн мэдээлэл татагдах бөгөөд татагдаагүй үлдсэн хэсгийг гараар заавал бүртгэж оруулна.
3. Гомдол гаргагчийн ажил эрхлэлт, үндсэн захиргааны хаягийн мэдээллийг бүрэн оруулж


хадгална.

1.9 Зөрчлийн гомдол мэдээлэлд ХОХИРОЛ бүртгэх цэс



1. Материал болон хэргээс хохирлыг зөв тодорхойлж хохирлын төрөл хэсгээс тохирохыг сонгож бүртгэх бөгөөд төрөл аль хэсгийг сонгосноос хамаарч дахин задарна мөн тохирохыг сонгоно.
2. Хохирогч тодорхойгүй хэрэг материалд уг хэсгийг чеклэнэ.
3. Энэ хэсэгт эд хөрөнгийн хохирлын хэмжээг зөвхөн төгрөгөөр оруулна.
4. Хохирол нөхөн төлөгдсөн тохиолдолд тухайн талбарын мэдээллийг бүрэн бүртгэж нэмэх товчийг дарсны дараагаар хадгална.

1.10 Зөрчлийн гомдол, мэдээлэлд авсан арга хэмжээ, шаардлага, даалгавар, албан бичиг, хариуцлага бүртгэх, илрүүлсэн зөрчил бүртгэх цэс




Тайлбар: Мэдэгдэл бүртгэх талбар бүх цэс өгөгдлийн дагуу бүртгэгдэнэ. Мэдэгдлийг тухайн нэгжийн дээд шатны прокурорын нэрээр бичнэ. Мэдэгдлийн хариу ирүүлэх хугацаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 2, Прокурорын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт зааснаар 1 сар байдаг тул хариу ирүүлэх огноо хэсэгт мэдэгдлийн огноо дугаараас хойш 1 сарын хугацаа тооцож хариу ирүүлэх огноог цахим бүртгэлд бүртгэнэ.

Шаардлага бүртгэхэд мэдэгдлийн нэгэн адил бөгөөд хариу ирүүлэх хугацааны хувьд шаардлагын он, сар, өдрөөс хойш 15 хоног байна. Хариу ирүүлэх огноог шаардлагын он сар өдрөөс 15 хоног тооцож хариу ирүүлэх огноог цахим бүртгэлд бүртгэнэ. Танилцсан огноо хэсэгт шаардлагын хариуг ирүүлж прокурорт танилцуулагдсан хугацаагаар бүртгэнэ.

Тухайн гомдол, мэдээлэлд прокурорын даалгавар бүртгэхдээ авсан арга хэмжээ цэсээс даалгаврын шат, төрлийг зөв сонгож бүртгэх чухал.

Ямар прокурор цэсэд хяналтын прокурор, дээд шатны прокурор аль нь болохыг сонгоно.


1.11 Зөрчлийн гомдол, мэдээлэлд “ЗӨВШӨӨРӨЛ” бүртгэх цэс



Тайлбар: Цахим бүртгэлд эрх бүхий албан тушаалтны саналыг тусад нь бүртгэхгүй ба зөвшөөрөл бүртгэхдээ хамт бүртгэнэ. Хойшлуулшгүйгээр прокурорын зөвшөөрөлгүй ажиллагаа явуулсан тохиолдолд /хүчинтэйд тооцуулах/ тийм, үгүй сонголтыг сонгож бүртгэх бөгөөд бусад сонголтыг зааврын дагуу бүртгэнэ.

Эрх бүхий албан тушаалтан прокурорын зөвшөөрөлтэй явуулах ажиллагааны тухай саналыг 24 цагийн өмнө прокурорт ирүүлнэ. Прокурор эрх бүхий албан тушаалтны санал болон хойшлуулшгүй тохиолдолд ажиллагаа явуулсан хэрэг, материал, тайлбарыг хүлээн авч 24 цагийн дотор шийдвэрлэнэ.


1.12 Зөрчлийн гомдол, мэдээлэлд ЭРХ ХЯЗГААРЛАХ арга хэмжээ бүртгэх цэс




Эрх хязгаарлах арга хэмжээг төрөл бүрээр нь бүртгэхдээ саатуулсан үндэслэл, шийдвэрлэлтийг зөв сонгож бүртгэх нь чухал.

Эрх хязгаарлах арга хэмжээг төрөл бүрээр нь бүртгэхдээ үндэслэл, шийдвэрлэлтийг зөв сонгож бүртгэх нь чухал. Прокурорын зөвшөөрлөөр явагдах ажиллагаа.

1.13 Зөрчлийн гомдол, мэдээлэлд ДШП шийдвэр бүртгэх цэс




1. Дээд шатны прокурор хянах болсон үндэслэл төрлөөрөө задарна.
2. Хяналт тавьж, дээд шатны прокурорт танилцуулсан прокурорын нэр сонгоно.
3. Аль нэгжийн дээд шатны прокурор төрлөөрөө задарна
4. Шийдвэр гаргасан дээд шатны прокурорын нэр сонгоно.
5. Дээд шатны прокурорын шийдвэр төрлөөрөө задарч харагдана.



1. Дээд шатны прокурорын хяналтыг бүртгэсний дараа 2, 3 дугаарыг сонголтоор зааврын дагуу бүртгэж хадгална.


1.14 Зөрчлийн гомдол, мэдээлэл ОРОЛЦОГЧИЙН ГОМДОЛ цэс



Оролцогчийн гомдол талбарт шинээр бүртгэх цэс байхгүй бөгөөд удирдлага зохион байгуулалт модульд бүртгэж материалтай нь холболт хийсэн гомдол уг хэсэгт харагдана.


ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ

1.15 Зөрчлийн хэрэг хайлтын талбар




Тайлбар: Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих модуль хэсгээс “зөрчлийн хэргийн” хайлт хийхдээ зурагт харагдаж буй нийт 27 талбараас дангаар нь болон хослуулж хайлтыг хийх боломжтой. Жишээ нь: 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар шийтгэл оногдуулсан хэргүүдийг хайх, зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл буюу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчилд нийт нээсэн хэрэг гэх мэт олон янзаар хайлт хийх боломжтой.

1.16 Зөрчлийн хэрэг нээх



1. Хэргийн дугаарыг автоматаар дараалын дагуу олгоно
2. Хэргийн дугаарыг гараар оруулах буюу шивж оруулах тохиргоо
3. Тухайн хэргийг нээсэн огноог зөв оруулна
4. Шалгасан байгууллага оруулна /цагдаагийн байгууллага, эрх бүхий байгууллага/
5. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж буй зүйл ангийг сонгож оруулна
6. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах хэлбэрээс буруу сонголтыг хийвэл хэргийн хугацаа сунгахад алдаа заахаар цахим бүртгэл тохируулагдсан. /ердийн , тусгай журам/ аль сонголт хийснээс хамааруулж зүйл анги №5 хэсэг ялгаатай харагдана. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан тусгай журмыг баримтална.
7. Холбогдогч цэс рүү шилжихгүйгээр холбогдогчийн мэдээллийг бүртгэх боломжтой товчлуур
8. Тухайн хэргийг нээсэн өдрөөс эрх бүхий албан тушаалтан, прокурор шийдвэр гаргаж хэрэг бүртгэлтийн ажиллагааг дуусгавар болгосон өдөр хүртэлх нийт хоногийг харуулна
9. Тухайн хэргийн хугацаа дуусах өдрийг харуулна.
10. Хэргийн товч утгыг оруулна
11. Хяналт тавих прокурорын нэрийг сонгож бүртгэнэ.

1.17 Зөрчлийн хэргийн хугацаа сунгах цэс.




Тайлбар: Зөрчлийн хэрэг бүртгэлтийн удирдах албан тушаалтан хэргийн хугацааг 14 хоногоор сунгасан даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх бөгөөд зөв тооцож сунгасан эсэхэд прокурор хяналт тавьж цахим бүртгэлд сунгахдаа хугацаа дууссан өдрөөс үргэлжлүүлэн зөв тооцож бүртгэнэ.

Хэрэг бүртгэлтийн хугацааг 30 хоногоор сунгахад зөрчлийн хэргийн хугацаа сунгах прокурорын тогтоол үйлдэх бөгөөд тогтоолд заасан хугацаагаар үргэлжлүүлэн сунгана. Эхлэх огноог тус хэргийн хугацаа дууссан өдрөөс үргэлжлүүлэн тоолж дуусах огноог сонгож, сунгах тогтоол үйлдсэн прокурорын нэрийг сонгож хадгална.

Хугацааг хэсэгчилж өгсөн бол эхлээд хэсэгчилснээр эхлэх, дуусах огноог сонгож бүртгэнэ, дараа нь үлдэгдлийг нь өгөхөд өмнөх хугацаа руу орж дуусах огноог засах эсвэл устгаад дахин оруулна.


Ердийн, тусгайгаа журам сольсон бол нэмж хугацаа ордоггүй бөгөөд өмнөх хугацаагаа устгаад дахин эхнээс нь оруулах хэрэгтэй.

1.18 Зөрчлийн хэргийн холбогдогч, хохирогч бүртгэх цэс гэж өөрчлөх




1. Холбогдогч бүртгэхэд хүн, албан тушаалтан, хуулийн этгээд төрлүүдээс тохирохыг сонгоно.
2. /регистрийн дугаараар/ хайлт хийхэд Иргэний бүртгэлийн нэгдсэн системээс мэдээлэл татагдах бөгөөд тухайн мэдээлэл хязгаарлагдмал хүрээнд татагддаг тул үлдсэн хэсгийг гараар бөглөж мэдээллийг бүрэн оруулна.

1.19 Зөрчлийн хэрэгт хохирол бүртгэх цэс



1. Материал болон хэргээс хохирлыг зөв тодорхойлж хохирлын төрөл хэсгээс тохирохыг сонгож бүртгэх бөгөөд төрөл аль хэсгийг сонгосноос хамаарч дахин задарна мөн тохирохыг сонгоно.
2. Хохирогч тодорхойгүй хэрэг материалд уг хэсгийг чеклэнэ.
3. Энэ хэсэгт эд хөрөнгийн хохирлын хэмжээг зөвхөн төгрөгөөр оруулна.
4. Хохирол нөхөн төлөлт бүртгэхдээ тухайн талбарын мэдээллийг бүрэн бүртгэж нэмэх товчийг дарсны дараагаар хадгална.


1.20 Зөрчлийн хэрэгт зөвшөөрөл бүртгэх.



Тайлбар: Цахим бүртгэлд эрх бүхий албан тушаалтны саналыг тусдаа бүртгэхгүй зөвшөөрөл бүртгэхдээ хамт бүртгэнэ. Хойшлуулшгүйгээр прокурорын зөвшөөрөлгүй явуулсан тохиолдолд /хүчинтэйд тооцуулах/ тийм, үгүй сонголтыг сонгож бүртгэх бөгөөд бусад сонголтыг зааврын дагуу бүртгэнэ.

Эрх бүхий албан тушаалтан прокурорын зөвшөөрөлтэй явуулах ажиллагааны тухай саналыг 24 цагийн өмнө прокурорт ирүүлнэ. Прокурор эрх бүхий албан тушаалтны санал болон хойшлуулшгүй тохиолдолд ажиллагаа явуулсан хэрэг, материал, тайлбарыг хүлээн авч 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

1.21 Зөрчлийн хэрэгт ЭРХ ХЯЗГААРЛАХ арга хэмжээ бүртгэх цэс




Тайлбар:


1. Эрх хязгаарлах арга хэмжээний төрлийг зөв сонгоно.
2. Эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай эрх бүхий албан тушаалтан, прокурорын тогтоолын огноо оруулна.
3. Прокурорын нэрийг сонгоно.

Эрх хязгаарлах арга хэмжээний төрлийг сонгож өгөгдлийг зааврын дагуу бүртгэнэ.

Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор , .гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол үндэслэлээр саатуулсан бол прокурорт даруй мэдэгдэнэ.



Эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө.




Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх эрх хязгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

1.22 Зөрчлийн хэргийн ШИЙДВЭРЛЭЛТ бүртгэх цэс.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаад болон ажиллагааны явцад шийтгэл оногдуулсан, хэрэгсэхгүй болгосон, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийн аль нэгийг гаргана эсхүл нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх саналуудын аль нэгийг гаргах бөгөөд хэргийн шийдвэрлэлт бүртгэхдээ эхлээд шийдвэрийн төрөл хэсэгт ЭБАТ шийдвэрийг өгөгдлийн дагуу бүртгэл хийж хадгалсны дараа прокурорын шийдвэр цэс идэвхтэй болох бөгөөд шийдвэр гарсны дараа бүртгэлийг хийнэ.

1.22.1 Зөрчлийн хэрэгт Эрх бүхий албан тушаалтны шийдвэрт прокурорын шийдвэр бүртгэх.




1. Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрлэлт бүртгэхдээ шийтгэлийн төрлийг сонгон холбогдох мэдээллийг бүрэн бүртгэнэ.
2. Бүртгэлийг бүрэн оруулсны дараа нэмэх товчлуур заавал дарж хадгална.

Хянах үндэслэл хэсэгт гомдлоор, шалгалтаар хэрэг, материалд хяналт тавьснаас бусад тохиолдолд “бүртгэлд авч хянасан” сонголтыг сонгож бүртгэнэ.


1. ЭБАТ албадлага авсан бол доор байх талбарыг заавал сонгож байж мэдээ тоолно

1.23 Зөрчлийн хэрэг ОРОЛЦОГЧИЙН ГОМДОЛ цэс




Энэ хэсэгт шинээр бүртгэх сонголт байхгүй бөгөөд удирдлага зохион байгуулалт модульд бүртгэсэн гомдол уг оролцогчийн гомдол цэсэд харагдана.


1.24 Зөрчлийн хэрэг ШҮҮХ цэс



1.2. ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ




2.1. Эрүүгийн хэргийн хайлт, жагсаалт




1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн дугаарыг хийж хайлт хийхэд шууд хайсан гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн үндсэн цэс гарч ирнэ.
2. Эрүүгийн хэргийг хайхдаа ерөнхий мэдээллээс сонгож хайлт хийж болно.
3. Эрүүгийн хуулийн зүйл, ангиар хайлт хийнэ.
4. Яллагдагчийн мэдээллийн бүртгэлээс хайлт хийнэ.
5. Хохирогчийн мэдээллийн бүртгэлээс хайлт хийнэ.
6. Хэргийн болон цагдан хорионы хугацаагаар хайлт хийнэ. Жишээ нь: Хугацаа сунгаагүй хэрэг бүртгэлтийн хэргийг харах бол “ХБ хугацаа хэдээс” гэсэн өгөгдөлд 0 гэж хайхад үндсэн хугацаандаа байгаа хэргүүдийн жагсаалт гарна. “Цагдан хорионы хугацаа хэдээс” гэсэн өгөгдөлд 2, “Цагдан хорионы хугацаа хэд хүртэл” гэсэн өгөгдөлд 4 гэсэн тоог тус тус хийж хайхад 2-4 дүгээр хугацаанд цагдан хориотой байгаа хэргүүдийн жагсаалт гарна.
7. Хэргийн бусад мэдээллээс цонхны өгөгдлийн дагуу сонгож хайлт хийнэ.

2.2. Шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээх болон эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах бүртгэлийн талаар



Шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тохиолдолд хэргийн хайлт, жагсаалт хэсэг дэх **ХЭРЭГ БҮРТГЭХ** товчийг дарснаар доорх цонх нээгдэнэ.



1. “Хэрэг бүртгэлт” товчийг идэвхжүүлнэ.
2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн огноо бичигдэнэ.
3. Хэргийн дугаарыг гараас болон автоматаар оруулна. Хэрэг бүртгэлтийн хэргийн дугаар 9 оронтой байна.
4. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн үндэслэлээс “Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн”, “Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн”, “Гэмт хэргийн шинжийг прокурор шууд илрүүлсэн”, “Гэмт хэргийн шинжийг мөрдөгч шууд илрүүлсэн” аль нь болохыг сонгоно.
5. Хэргийн утгыг дэлгэрэнгүй бичнэ.
6. Яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд тодорхой эсэхийг заавал сонгож бүртгэнэ.
7. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын төрлөөс Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Тагнуулын байгууллага, Хамтарсан ажлын хэсэг аль нь болохыг зөв сонгож бүртгэнэ.
8. Хуулийн он болон зүйл, заалтыг сонгоно.
9. Хэрэг хохиролгүй тохиолдолд “Хохиролгүй” товчийг дарж бүртгэл хийнэ.

Нэмэлт тайлбар: Дээрх цонхонд зөрчлөөс хэрэг бүртгэх болон хуучин цахимаас хэрэг сэргээх тохиолдолд “Хэрэг бүртгэх” товчийг дарж бүртгэл хийнэ. Хуучин цахимаас хэрэг бүртгэхдээ сүүлийн шийдвэрийг бүртгэсний дараа “хүчингүй болгох” товчийг дарж холбогдох бүртгэлийг хийнэ.

ЭХ ГХГМ дугаараар дээд талаас хайдаг хэсгийг тайлбарлах


Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн албан тушаалтан, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж буй албан тушаалтан, хяналт тавьж буй прокурорыг үнэн зөв бүртгэнэ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн огноо, гэмт хэрэг үйлдэгдсэн газар тодорхой эсэх, нууц эсэх талаарх сонголтуудыг заавал сонгож бүртгэнэ.

Мэдээ:

- Зөрчлөөс хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь ХБМБ-2 мэдээний 5 дугаар мөрөнд бууна.
- Яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд тодорхой эсэхийг бүртгэснээр ХБМБ-2 мэдээний үлдэгдэл хэргийн тухайд 16-18, хугацаа сунгасан хэргийн тухайд 22 дугаар мөрөнд бууна.

Шинээр эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тохиолдолд хэргийн хайлт, жагсаалт хэсэг дэх **ХЭРЭГ БҮРТГЭЛ** товчийг дарснаар доорх цонх нээгдэнэ.



1. “Мөрдөн байцаалт” товчийг идэвхжүүлнэ
2. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан огноо бичигдэнэ.
3. Хэргийн дугаарыг гараас болон автоматаар оруулна. Мөрдөн байцаалтын хэргийн дугаар 13 оронтой байна.
4. ЭХҮ-ж яллагдагчаар татсан үндэслэлээс “Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн”, “Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн”, “Гэмт хэргийн шинжийг прокурор шууд илрүүлсэн”, “Гэмт хэргийн шинжийг мөрдөгч шууд илрүүлсэн” аль нь болохыг сонгоно.
5. Хэргийн утгыг дэлгэрэнгүй бичнэ. Анх бүртгэгдсэн гомдол мэдээллийн утгыг сольж эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэргийн утгыг бичнэ.
6. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хуулийн он болон зүйл, заалтыг сонгоно.
7. Ердийн журмаар эсхүл хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэлбэрийг сонгож бүртгэнэ.
8. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын төрлөөс Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Тагнуулын байгууллага, Хамтарсан ажлын хэсэг аль нь болохыг зөв сонгож бүртгэнэ.
9. Хэрэг хохиролгүй тохиолдолд “Хохиролгүй” товчийг дарж бүртгэл хийнэ.
10. Хэргийн нэмэлт мэдээлэлд “Хэргийн үйлдэл”, “Хэрэг гарсан газар”, “Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан”, “Хулгайн төрөл”, “Гэмт хэрэгт ашигласан багаж зэвсэг, хэрэгсэл”, “Гэмт хэрэг хамтран үйлдэх”, “Гэм буруугийн хэлбэр”, “Гэмт хэрэг үйлдсэн арга, хэлбэр”, “Гэмт хэргийг олж тогтоосон арга” зэрэг өгөгдлийг бүрэн бүртгэнэ.

Нэмэлт тайлбар: ЭХҮ-ж яллагдагчаар татсан албан тушаалтан, ХБМБ явуулж буй албан тушаалтан, хяналт тавьж буй прокурорыг үнэн зөв бүртгэнэ.


Гэмт хэрэг үйлдэгдсэн огноо, гэмт хэрэг үйлдэгдсэн газар тодорхой эсэх, нууц эсэх талаарх сонголтуудыг заавал сонгож бүртгэнэ.

Мэдээ:

- Зөрчлөөс эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тохиолдолд ХБМБ-3 мэдээний 7 дугаар мөрөнд бууна.
- Зөрчлөөс эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг нь ХБМБ-3 мэдээний 10 дугаар мөрний “Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг”-ийн тоонд тоологдож шийдвэрлэлт нь мэдээний тус тусын үзүүлэлтэд задарч бууна.

2.3. Хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын хэргийн бүртгэл


2.3.1. Хэргийн ерөнхий мэдээлэл



Нэмэлт тайлбар: Хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын хэргийн ерөнхий мэдээллийг цонхны өгөгдлийн дагуу бүрэн бүртгэнэ. /Зураг 3, 4-т харуулав/


1. **“Давхар хяналтад авах”** бүртгэлийг хийхдээ “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдэж олны анхаарал татсан”, “Нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулсан байж болзошгүй”, “Дипломат дархан эрх ямба эдэлж байгаа хүн, шүүгч, прокурор болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтанд холбогдох”, “УЕП-н ХБМБАХТ ажил хариуцсан туслах прокуророор мөрдөн байцаалтын хугацаа сунгуулсан”, Улсын ерөнхий прокурорын газраас давхар хяналтад оруулахыг даалгасан”, “Нийслэлийн прокурорын газраас давхар хяналтад оруулахыг даалгасан” үндэслэлүүдийн аль нь болохыг сонгож бүртгэнэ.

2.3.2. Яллагдагчийн бүртгэл



1. Мөрдөн байцаалтын хэрэгт яллагдагч бүртгэх хэсэг
2. “Шинээр бүртгэх” товчийг дарахад яллагдагч бүртгэх цонх нээгдэнэ.
3. Бүртгэсэн яллагдагчийн мэдээлэл жагсаалтаар харагдана.

Нэмэлт тайлбар: Засварлах товч руу дарж орсноор яллагдагчийн дэлгэрэнгүй мэдээлэл харагдана. Яллагдагчийн хувийн байдлыг дутуу бүртгэсэн тохиолдолд **Хувийн байдлыг дутуу бүртгэсэн** гэж гарч ирнэ.



1. Яллагдагчийг бүртгэхдээ хүн, албан тушаалтан, хуулийн этгээдийн аль нь болохыг сонгоно.
2. Яллагдагчийн регистрийн дугаарыг оруулж хайлт хийхэд Улсын бүртгэлийн нэгдсэн цахим системээс тухайн хүний ерөнхий мэдээлэл татагдана. Цахим системээс мэдээлэл татагдаагүй тохиолдолд яллагдагчийн ерөнхий мэдээллийг өгөгдлийн дагуу бүрэн бүртгэнэ. Гадаадын иргэнийг яллагдагчаар татсан тохиолдолд “тийм, үгүй” товчийг идэвхжүүлж бүртгэлийг үргэлжлүүлнэ.
3. Яллагдагчийн “ажил мэргэжлийн мэдээлэл”-д эрхэлсэн ажилтай эсэхийг сонгож, төрийн алба, хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхэлдгийн аль нь болохыг сонгож бүртгэнэ.
4. “Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл”-д яллагдагчийн үндсэн захиргаа болон оршин суугаа хаягийн мэдээллийг бүрэн оруулна.
5. “Яллагдагчийн мэдээлэл”-д мэргэжил, ам бүл, насанд хүрсэн эсэх, ял шийтгэлтэй эсэх зэрэг холбогдох мэдээллийг бүрэн бүртгэнэ.
6. Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдолд тогтоолын огноо,


дугаар, үндэслэл, прокурорын нэрийг бүртгэнэ.

7. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолд өөрчлөлт орсон бол өмнөх тогтоол ыг .....товчоор хүчингүй болгосны дараа өөрчлөгдсөн зүйл ангийг дахин энэ цонхны “ЭХҮ-ж яллагдагчаар татах” хэсэгт бүртгэнэ. .....Өөрчлөх, хүчингүй болгох талаар дэлгэрэнгүй оруулах, тэр баганад огноотой бол цааш шүүх рүү шилждэггүй талаар
8. “Холбоотой хэргийн мэдээлэл”-д яллагдагчийн урьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэргүүд жагсаалтаар харагдана.

Мэдээ:

- Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан хүн, хуулийн этгээдийн тоо ХБМБ-3 мэдээний 24-26 дугаар мөрөнд задарч бууна.
- Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон тоо ХБМБ-3 мэдээний 61 дүгээр мөрөнд бууна.

Хуулийн этгээдийг яллагдагчаар татсан тохиолдолд “Яллагдагчийн бүртгэл” цонхноос “Хуулийн этгээд”-г сонгоно.




1. Яллагдагчаар татагдсан хуулийн этгээдийн мэдээлэл болон төлөөлөх хүний мэдээллийг бүрэн оруулна.
2. Хуулийн этгээдийн мэдээлэл хэсэгт хуулийн этгээдийн регистрийн дугаарыг оруулж хайлт хийхэд Улсын бүртгэлийн нэгдсэн цахим системээс тухайн байгууллагын ерөнхий


мэдээлэл татагдана. Цахим системээс мэдээлэл татагдаагүй тохиолдолд хуулийн этгээдийн ерөнхий мэдээллийг өгөгдлийн дагуу бүрэн бүртгэнэ.

Хуулийн этгээдийн төлөөлөх хүний мэдээлэл хэсэгт төлөөлөх хүний регистрийн дугаарыг оруулж хайлт хийхэд Улсын бүртгэлийн нэгдсэн цахим системээс ерөнхий мэдээлэл татагдана. Цахим системээс мэдээлэл татагдаагүй тохиолдолд тухайн хүний ерөнхий мэдээллийг өгөгдлийн дагуу бүрэн бүртгэнэ.

3. Төрийн байгууллагын хаягийн мэдээллийг бүрэн бүртгэнэ.
4. Яллагдагчийн мэдээллийг бүрэн оруулна.
5. Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдолд тогтоолын огноо, дугаар, үндэслэл, прокурорын нэрийг бүртгэнэ.
6. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолд өөрчлөлт орсон бол өмнөх тогтоолыг ӨӨРЧЛӨХ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ товчоор хүчингүй болгосны дараа өөрчлөгдсөн зүйл ангийг дахин энэ цонхны “ЭХҮ-ж яллагдагчаар татах” хэсэгт бүртгэнэ.
7. “Холбоотой хэргийн мэдээлэл”-д яллагдагчийн урьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэргүүд жагсаалтаар харагдана.

2.3.3. Хэргийн хугацаа





1. Хэрэг бүртгэлтийн хэргийн үндсэн хугацаа программаас тоологдоно.
2. Мөрдөн байцаалтын үндсэн хугацаа программаас тоологдоно.
3. Үндсэн хугацаа дуусахад шинээр бүртгэх товч дарж “Хугацааны хэлбэр” хэсгээс үргэлжилсэн хугацаа эсхүл ердийн журмаар хугацаа сунгах аль нь болохыг сонгож бүртгэнэ.
4. Хэд дэх хугацааны хэд дэх сар /1-3 хүртэлх сар/ болохыг зөв тооцож бүртгэнэ. Хэднээс хэдэн хүртэл хугацаа сунгах огноог оруулж, хугацаа сунгах эрх бүхий прокурорын нэрийг сонгож хадгалах товчийг дарна.
5. Үндсэн хугацаа дуусахад шинээр бүртгэх товч дарж “Хугацааны хэлбэр” хэсгээс ердийн журмаар хугацаа, үргэлжилсэн хугацаа эсхүл хялбаршуулсан журмаар хугацаа сунгах аль нь болохыг сонгож бүртгэнэ.
6. Хэд дэх хугацаа сунгаж байгааг тоогоор оруулж, хэднээс хэдэн хүртэл хугацаа сунгах огноо болон сунгах эрх бүхий прокурорын нэрийг сонгож хадгалах товчийг дарна.

Нэмэлт тайлбар:

Үндсэн хугацаа нь хэргийн ерөнхий мэдээллийг хадгалахад программаас автоматаар тоологдоно.


Мөрдөн байцаалтын хэргийн ангилал, зүйл ангиас хамааранд хэргийн хугацааг программаас 14, 30 хоногоор тоолно. Хэргийн зүйлчлэл өөрчлөгдөж хөнгөнөөс хүнд ангилал руу шилжсэн бол зүйл ангийг яллагдагч болон ерөнхий мэдээлэл дээр оруулснаар хэргийн хугацаа 30 хоног тоолно.


Хэргийг нэмэлтээр буцаасан тохиолдол болгонд “Хэргийн хугацаа” цэсэд өмнөх хугацаанаас үлдсэн бол үргэлжилсэн хугацааны бүртгэл хийх, шинээр хугацаа сунгасан бол ердийн журмаар хугацаа сунгасан бүртгэлийг хийнэ.

Мэдээ:

- Хэрэг бүртгэлтийн хэргийн үндсэн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн хэрэг ХБМБ-2 мэдээний 20 дугаар мөрөнд, хугацаа сунгасан хэрэг 21 дүгээр мөрөнд тус тус бууна.
- Мөрдөн байцаалтын хэргийн үндсэн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн хэрэг ХБМБ-3 мэдээний 29 дүгээр мөрөнд, хугацаа сунгасан хэрэг 30-34 дүгээр мөрөнд задарч бууна.

2.3.4. Ажиллагааны хяналт







1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад гаргасан мөрдөгчийн санал бүртгэгдэнэ. Санал гаргасан мөрдөгчийн нэрийг сонгож бүртгэлийг үргэлжлүүлнэ.
2. Саналын төрлийг зөв сонгоно.
3. Ямар санал хүссэн болохыг буюу “Зөвшөөрөл хүссэн санал”, “Хүчинтэйд тооцуулах санал”, “Зөвшөөрөл хүссэн мөрдөгчийн саналыг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрсөн санал”-ын аль нь болохыг сонгоно.
4. Санал, дэд саналыг зөв сонгож саналын утгыг бичиж оруулна. Цонхны өгөгдлийг бүрэн

бүртгэж хадгалах товчийг дарна.

5. Мөрдөгчийн саналыг шийдвэрлэсэн тохиолдолд “Прокурорын шийдвэр” товчийг дарж прокурорын шийдвэрийг татна. Мөрдөгчийн саналыг хүлээн авч шүүхэд санал гаргах тохиолдолд “Шүүхэд шилжүүлэх” товчийг дарна.



1. Прокуророос хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад шүүхэд гаргасан санал, хүсэлт, гомдлыг бүртгэнэ. Прокурорын нэрийг сонгож бүртгэлийг үргэлжлүүлнэ.
2. Саналын төрлийг зөв сонгоно.
3. Ямар санал хүссэн болохыг буюу “Зөвшөөрөл хүссэн санал”, “Хүчинтэйд тооцуулах санал”, “Зөвшөөрөл хүссэн мөрдөгчийн саналыг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрсөн санал”-ын аль нь болохыг сонгоно.
4. Санал, дэд саналыг зөв сонгож саналын утгыг бичиж оруулна. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.
5. Программаас шүүхийн нэрийг сонгож оруулна.
6. Саналын үндэслэлийг сонгож оруулан цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.



1. Мөрдөгчийн гаргасан саналыг сонгоно.
2. Мөрдөгчийн гаргасан саналын төрлийг сонгоно.
3. “Шийдвэрийн төрөл”-д зөвшөөрсөн, татгалзсан аль нь болохыг сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Нэмэлт тайлбар: Ажиллагааны хяналт цэсэд бүртгэсэн бүртгэл “Зөвшөөрөл” цэсэд бууна.


Мэдээ:

- Мөрдөн шалгах ажиллагааны явцад шүүхэд гаргасан прокурорын санал, хүсэлт, гомдол нь ХБМБ-4 мэдээний 44 дүгээр мөрөнд, прокурорын зөвшөөрлөөр хийгдсэн мөрдөн шалгах ажиллагаа нь ХБМБ-4 мэдээний 58 дугаар мөрөнд тус тус бууна.



Тайлбар: Шүүхээс прокурорын гаргасан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн тохиолдолд “Шүүхийн шийдвэр” мөрөнд татагдаж, жагсаалтаар харагдана.

2.3.5. ХБМБ дуусгах




1. Мөрдөгчөөс хэрэг бүртгэлтийг дуусгаж гаргасан саналыг “Хэрэг бүртгэлийн хэргийг хаах”, “Харьяаллын дагуу шилжүүлэх”, “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах” саналуудаас сонгож бүртгэнэ. Мөрдөгчөөс гаргасан санал жагсаалтаар харагдана. Прокуророос хэргийг ажиллагааны явцад татаж хянаад шийдвэр гаргах тохиолдолд “Саналгүй” өгөгдлийг сонгоно.
2. Мөрдөгчийн гаргасан саналыг шийдвэрлэхдээ “Прокурорын шийдвэр” товчийг дарж “Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах”, “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах”, “Нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг мөрдөгчид буцаах”, “Гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх”, “ХБХэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах”, “Нэгтгэх /ХБ/” гэсэн сонголтуудаас шийдвэрийг сонгож бүртгэнэ.
3. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах бүртгэл хийсэн тохиолдолд мөрдөн байцаалтын хэргийн хугацаа тоологдож эхэлнэ.
4. Мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж гаргасан мөрдөгчийн саналыг “Харьяаллын дагуу шилжүүлэх”, “Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх”, “Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох”, “Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх” саналуудаас сонгож бүртгэнэ. Мөрдөгчөөс гаргасан санал жагсаалтаар харагдана.
5. Мөрдөгчийн гаргасан саналыг шийдвэрлэхдээ “Прокурорын шийдвэр” товчийг дарж “Хэрэг бүртгэлийн хэргийг хаах”, “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах”, “Нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг мөрдөгчид буцаах”, “Гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх”, “ХБХэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах”, “Нэгтгэх /ХБ/” гэсэн сонголтуудаас шийдвэрийг сонгож бүртгэнэ.
6. Хэрэг бүртгэлтийн хэргийг прокурор хянах хугацааг программаас автоматаар тоолж “Прокурор хянах хоног” болон “Дуусах огноо” харагдана.
7. Мөрдөн байцаалтын хэргийг прокурор хянах хугацааг программаас автоматаар тоолж “Прокурор хянах хоног” болон “Дуусах огноо” харагдана.
8. Прокурор мөрдөн байцаалтын хэргийг хянах хугацааг сунгах тохиолдолд “Хяналтын хугацаа сунгах” товчийг дарж доорх цонхны дагуу бүртгэлийг хийнэ.

Нэмэлт тайлбар: ∅335744 хэтэрсэн хугацааг сэргээх буюу прокурорын хяналтын хугацааг хойшлуулах товч. Дээд шатны хяналт цэсэд прокурорын хяналтын хугацааг сэргээсэн талаар бүртгэл хийгдсэнээр прокурор хянаж дуусах хугацааг хойшлуулна.

ХБМБ дуусгах цэсэд мөрдөгчийн санал бүртгэгдсэн тохиолдолд хэргийг прокурорын хяналтад байгаа хэрэг гэж үзнэ.


Мөрдөгчийн саналыг илүү бүртгэсэн тохиолдолд заавал шийдвэр оруулж байж хяналтаас хасагдана. Мөрдөгчийн 1 саналд прокурорын 1 шийдвэр бүртгэгдэнэ.




1. Шинээр бүртгэх товч дарж хяналтын хугацаа сунгах бүртгэл хийнэ. Хугацаа сунгасан бүртгэл жагсаалтаар харагдана.
2. Хяналтын хугацаа сунгасан үндэслэлийг өгөгдлөөс сонгож бүртгэнэ. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товч дарна.

Мэдээ:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг дуусгаж гаргасан мөрдөгчийн санал, прокурорын шийдвэрүүд ХБМБ-2, ХБМБ-3 мэдээний холбогдох мөрөнд бууна.
- Хэрэг бүртгэлтийн хэргийг хянах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд ХБМБ-2 мэдээний 23 дугаар мөрөнд, мөрдөн байцаалтын хэргийг хянах хугацаа хэтрүүлсэн тохиолдолд ХБМБ-3 мэдээний 28 дугаар мөрөнд тус тус бууна.
- Мөрдөн байцаалтын хэргийг хянах хугацаа сунгасан тоо ХБМБ-3 мэдээний 27 дугаар мөрөнд бууна.




Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай ирүүлсэн хэрэгт прокурорын шийдвэр оруулахдаа “Прокурорын шийдвэр” товч дээр дарж гарч ирсэн цонхонд “шийдвэрийн төрөл” сонгож бүртгэл хийнэ.



1. Хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэх тохиолдолд “Шийдвэрийн төрөл”-өөс “Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах” төрлийг сонгоно.
2. Шийдвэрийн үндэслэл хэсгээс “Гэмт хэргийн шинжгүй”, “Тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа”, “Яллагдагч нас барсан”, “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан”, “Тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон” аль нь болохыг сонгоно.
3. Дэд цэсний бүртгэл бүрэн хийгдсэн эсэхийг шалгаж “тийм, үгүй” сонголтыг хийнэ. Дэд цэсний бүртгэл дутуу тохиолдолд уг цонхны бүртгэл хадгалагдахгүй. Бүх дэд цэсний бүртгэл хийгдсэний дараа хэргийн эцсийн шийдвэрийг оруулах шаардлагатайг анхаарах.
4. Зөрчил шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлсэн эсэхийг “тийм, үгүй” сонголтоор хийнэ. Цонхны мэдээллийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:

- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хэрэг нь ХБМБ-2 мэдээний 13 дугаар мөрөнд, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан үндэслэл нь 24-28 дугаар мөрөнд задарч бууна.




1. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай ирүүлсэн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тохиолдолд “Шийдвэрийн төрөл”-өөс “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах” төрлийг сонгоно.
2. “МША явуулах байгууллагад хүргүүлсэн огноо”-ноос мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолох тул “Мөрдөн байцаалтын хугацаа” цэсэнд хэргийн хугацаа / үргэлжилсэн хугацаа, ердийн журмаар хугацаа сунгах г.м/ бүртгэнэ.
3. “Дугаар олгох” хэсэгт хэргийн дугаарыг оруулж “яллагдагч нэмэх” товч дээр дарж гарч ирсэн цонхонд яллагдагчийн мэдээллийг бүртгэн хадгалах товчийг дарна. /Зураг №..../

   Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.
4. Энэ шийдвэрийн дараа заавал яллагдагчийн мэдээлэл хэсэг рүү орж хувийн байдлыг бүрэн бүртгэх шаардлагатай.

Мэдээ:


- Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тохиолдолд ХБМБ-3 мэдээний 5 дугаар мөрөнд бууна.




1. “Шийдвэрийн төрөл”-өөс “Нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг мөрдөгчид буцаах” төрлийг сонгоно.
2. “МША явуулах байгууллагад хүргүүлсэн огноо”-ноос мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолох тул “Мөрдөн байцаалтын хугацаа” цэсэнд хэргийн хугацаа / үргэлжилсэн хугацаа, ердийн журмаар хугацаа сунгах г.м/ бүртгэнэ. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:

- Нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр буцаасан хэрэг нь ХБМБ-2 мэдээний 20 дугаар мөрөнд бууна.




1. Хэргийг эцэслэн шийдэлгүй гадаад улсын эрх бүхий байгууллага руу хүргүүлэх тохиолдолд энэ сонголтыг хийнэ.



1. Хэрэг тусгаарлахдаа “шийдвэрийн төрөл”-өөс “ХБХэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах” төрлийг сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:


- Тусгаарласан хэрэг ХБМБ-2 мэдээний 6 дугаар мөрөнд бууна.




1. Хэрэг нэгтгэх тохиолдолд “Шийдвэрийн төрөл”-өөс “Нэгтгэх /ХБ/” төрлийг сонгоно. Хэргийг нэгтгэхдээ үндсэн хэрэг дээрээ “Нэгтгэх” шийдвэрийг бүртгэнэ.
2. “Шийдвэрийн үндэслэл”-ийг оруулна.
3. Нэгтгэх үндсэн хэргийн дугаарыг бичиж хайх товчийг дарснаар нэгтгэх үндсэн хэргийн мэдээлэл татагдана. Татагдсан хэргийн сонгох товчийг дарж идэвхжүүлсний дараа хадгалах товчийг дарж нэгтгэнэ. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:

- Нэгтгэсэн хэрэг ХБМБ-2 мэдээний 11 дүгээр мөрөнд бууна.



Тайлбар: Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай ирүүлсэн хэрэгт прокурорын шийдвэр оруулахдаа “Прокурорын шийдвэр” товч дээр дарж гарч ирсэн цонхонд “шийдвэрийн төрөл” сонгож бүртгэл хийнэ. Цонхны мэдээллийг бүрэн бүртгээд хадгалах товчийг дарна.




1. Мөрдөн байцаалтын хэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлахад шийдвэрийн үндэслэлийг тодорхой бичнэ.
2. Хэргийн төрлөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн аль нь болохыг сонгож бүртгэнэ.
3. Хэргийн ерөнхий мэдээллийг хуулах эсэхийг “тийм, үгүй” сонголтоор сонгож бүртгэнэ.
4. Хэргийн дугаарыг гараас болон автоматаар сонгож оруулж болно. Дугаарыг оруулж хадгалах товч дарснаар хэрэг тусгаарлагдана. Цонхны мэдээллийг бүрэн бүртгээд хадгалах товчийг дарна.

Нэмэлт тайлбар: Шүүх дээр хэргийг тусгаарласан тохиолдолд мөн энэ бүртгэлээр тусгаарлана. Бүртгэлийг хийхдээ “Саналгүй” гэсэн бүртгэл хийж шүүхэд шилжүүлсний өмнөх өдрөөр шинээр тусгаарлаж хэргээ үүсгээд, хэргийн ерөнхий мэдээлэл дээр огноо бусад мэдээллээ засварлаж оруулна.

/Зөвхөн энэ бүртгэлээр өөр хэргээс тусгаарлаж үүсгэхийг анхаарах шаардлагатай. ЭХ жагсаалтаас шинээр бүртгэх дарж МБ хэрэг шууд үүсгэх нь буруу/

Мэдээ:

✓ Тусгаарласан хэрэг нь ХБМБ-3 мэдээний 8, 9 дүгээр мөрөнд бууна.




Хэргийг эцэслэн шийдэлгүй гадаад улсын эрх бүхий байгууллага руу хүргүүлэх тохиолдолд энэ сонголтыг хийнэ.

Тайлбар: Хэргийг түдгэлзүүлсэн тохиолдолд “Шийдвэрийн үндэслэл”-ээс “Сэтгэцийн, эсхүл хүнд өвчнөөр өвчилсний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол”, “Яллагдагч оргон зайлсан бол”, “Яллагдагчийн гадаад улсын болон олон улсын байгууллагын дипломат дархан эрхийг хязгаарлаагүй, эсхүл яллагдагчийн хуульд заасан халдашгүй байдлыг түдгэлзүүлээгүй бол” гэсэн сонголтуудаас сонгож бүртгэнэ. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:

✓ Түдгэлзүүлсэн хэрэг нь ХБМБ-3 мэдээний 18, 44-47 дугаар мөрнүүдэд бууна.




Тайлбар: Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтанд буцаасан тохиолдолд цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

“МША явуулах байгууллагад хүргүүлсэн огноо”-ноос мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолох тул “Мөрдөн байцаалтын хугацаа” цэсэнд хэргийн хугацаа /үргэлжилсэн хугацаа, ердийн журмаар хугацаа сунгах г.м/ бүртгэнэ.

Мэдээ:

✓ Нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтад буцаасан хэрэг нь ХБМБ-3 мэдээний 35-39 дүгээр мөрөнд бууна.




Тайлбар: Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгож хэрэг бүртгэлтэнд буцаах тохиолдолд цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

“МША явуулах байгууллагад хүргүүлсэн огноо”-ноос хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолох тул “Хэрэг бүртгэлтийн хугацаа” цэсэнд хэргийн хугацаа /үргэлжилсэн хугацаа, ердийн журмаар хугацаа сунгах г.м/ бүртгэнэ.

Тайлбар: Хяналтын прокуророос Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд ХБМБ дуусгах цэсэд бүртгэл хийнэ. Дээд шатны прокуророос Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд “Прокурорын шийдвэр” цэсэд “Хүчингүй болгох” товч дээр дарж бүртгэл хийнэ.

Мэдээ: Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгосон нь ХБМБ-3 мэдээний 19, 60, 64-66 дүгээр мөрнүүдэд бууна.




Тайлбар: Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтанд буцаасан тохиолдолд цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

“МША явуулах байгууллагад хүргүүлсэн огноо”-ноос мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолох тул “Мөрдөн байцаалтын хугацаа” цэсэнд хэргийн хугацаа /үргэлжилсэн хугацаа, ердийн журмаар хугацаа сунгах г.м/ бүртгэнэ.

Нэгтгэх үндсэн хэргийн дугаарыг бичиж хайх товчийг дарснаар нэгтгэх үндсэн хэргийн мэдээлэл татагдана. Татагдсан хэргийн сонгох товчийг дарж идэвхжүүлсний дараа хадгалах товчийг дарж нэгтгэнэ.

Мэдээ:


✓ Нэгтгэсэн хэргийн тоо ХБМБ-3 мэдээний 14-15, 16-17 мөрнүүдэд бууна.


Прокурорын шийдвэр
МӨРДӨГЧИЙН САНАЛ: ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ
* Шийдвэрийн төрөл
Шүүхэд шилжүүлэх
* Шийдвэрийн огноо
Огноо оруулах
* Прокурорын нэр
Сонгоно уу
* Шийдвэрийн дугаар
Шийдвэрийн дугаар
Дэд цэсний бүртгэлүүд бүрэн хийгдсэн эсэх
Зөвшөөрөл олгосон эсэх
Сонгоно уу
Авсан арга хэмжээтэй эсэх
Сонгоно уу
Хариуцлага тооцуулсан, илрүүлсэн зөрчил байгаа эсэх
Сонгоно уу
Дуудан ирүүлсэн эсэх
Сонгоно уу
Хураан авсан, битүүмжилсэн эд зүйлтэй эсэх
Сонгоно уу
Баривчилсан эсэх
Сонгоно уу
ТСАХ авсан эсэх
Сонгоно уу
Хохиролтой эсэх
Сонгоно уу
Хохирогчтой эсэх
Сонгоно уу
Шүүхэд шилжүүлсэн хэлбэр
Сонгоно уу
Хавтасны тоо
Хавтасны тоо
Шүүхэд хэргийг хүлээж авсан огноо
Огноо оруулах
Хуудасны тоо
Хуудасны тоо
Хэргийн утгыг дэлгэрүүлж оруулах
Гар утсаа хулгайд алдсан гэх
Эд мөрийн баримттай эсэх
Сонгоно уу
Шүүхийн харъяалал тодорхой эсэх
Сонгоно уу
ШҮҮХИЙН ХАРЪЯАЛАЛ ТОГТООЛГОХ
Прокурорын саналын огноо
Огноо оруулах
УДШ-ийн шийдвэрийн огноо
Огноо оруулах
Саналын дугаар
Дугаар
УДШ-ийн шийдвэрийн дугаар
Дугаар
Хэрэг хянан шийдвэрлэх шүүх
Сонгоно уу
БОЛИХ
ХАДГАЛАХ
1
2
3
4
5
6
7
8

1. Прокурорын шийдвэр товчийг дарж “шүүхэд шилжүүлэх” төрлийг сонгоно.
2. Дэд цэсний бүртгэл бүрэн хийгдсэн эсэхийг шалгаж “тийм, үгүй” сонголтыг хийнэ. Дэд цэсний бүртгэл дутуу тохиолдолд уг цонхны бүртгэл хадгалагдахгүй.
3. Шүүхэд шилжүүлсэн хэлбэр буюу “ердийн журмаар”, “хялбаршуулсан журмаар” шийдвэрлэж байгаа аль нь болох сонголтыг зөв хийнэ.
4. Шүүхэд шилжүүлэх бүртгэл хийсэн хэргийг шүүх хүлээн авсан тохиолдолд “Шүүхэд хэргийг хүлээж авсан огноо” татагдаж харагдана.
5. Яллах дүгнэлт үйлдсэн хэргийн утгыг дэлгэрэнгүй оруулна.
6. Эд мөрийн баримттай эсэхийг “тийм, үгүй” сонголтыг хийнэ.
7. Шүүхийн харьяалал тодорхой эсэхийг “тийм, үгүй” сонголтыг хийнэ.
8. Шүүхийн харьяалал тогтоолгохоор хэргийг УДШ-д хүргүүлсэн тохиолдолд “Шүүхийн харьяалал тогтоолгох” цонхны мэдээллийг бүрэн оруулна.

Мэдээ:

- ✓ Шүүхэд шилжүүлсэн хэрэг ХБМБ-3 мэдээний 21 дүгээр мөрөнд бууна.
- ✓ Хялбаршуулсан журмаар болон ердийн журмаар шүүхэд шилжүүлсэн хэрэг ХБМБ-3 мэдээний 42, 43 дугаар мөрөнд задарч бууна.




1. Прокурорын шийдвэр товчийг дарж “Хэрэгсэхгүй болгох” төрлийг сонгоно.
2. “Шийдвэрийн үндэслэлээс “Гэмт хэргийн шинжгүй”, “Тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон”, “Өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүх, прокурорын шийдвэр хүчин төгөлдөр”, “Сэжигтэн, яллагдагч нас барсан”, “Хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан”, “Ял оногдуулах насанд хүрээгүй”, “Хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахааргүй”, “Өршөөл үзүүлэх тухай хуулиар”, “Бусад” үндэслэлүүдээс сонгож бүртгэнэ.
3. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авхуулахаар шүүхэд шилжүүлсэн эсэхийг “тийм, үгүй” сонголтоор хийнэ.
4. Дэд цэсний бүртгэл бүрэн хийгдсэн эсэхийг шалгаж “тийм, үгүй” сонголтыг хийнэ. Дэд цэсний бүртгэл дутуу тохиолдолд уг цонхны бүртгэл хадгалагдахгүй.
5. Зөрчил шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлсэн эсэхийг “тийм, үгүй” сонголтоор хийнэ.

Мэдээ:


✓ Хэрэгсэхгүй болгосон хэрэг ХБМБ-3 мэдээний 20 дүгээр мөрөнд бууна.

✓ Хэрэгсэхгүй болгосон үндэслэл нь ХБМБ-3 мэдээний 51-58 дугаар мөрөнд задарч бууна.

2.3.6. Прокурорын шийдвэр



1. Нийт прокурорын шийдвэрийн жагсаалт харагдана.
2. Прокурорын шийдвэрт өөрчлөлт оруулсан тохиолдолд “Өөрчлөх” товчийг дарахад дараах цонх нээгдэнэ.
3. Прокурорын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд “Хүчингүй болгох” товчийг дарахад дараах цонх нээгдэнэ.




1. Дээд шатны прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан шийдвэрт өөрчлөлт оруулсан тохиолдолд “Шийдвэрийн төрөл”-өөс өөрчлөлт оруулах шийдвэрийн төрлийг сонгоно.
2. Дээд шатны прокурорын нэрийг сонгохоос өмнө “ДШП хяналт” цэсэд бүртгэл хийсэн байх шаардлагатай.
3. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулахдаа “Дугаар олгох” хэсэгт хэргийн дугаарыг оруулна.
4. Яллагдагч нэмж байгаа тохиолдолд “Яллагдагч нэмэх” товчийг дарж гарч ирсэн цонхонд яллагдагчийг нэмж, хуулийн он, зүйл хэсгийг бүртгэнэ. /Зураг № ... /
5. Дээд шатны прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан шийдвэрийг


хүчингүй болгосон тохиолдолд “Шийдвэрийн төрөл”-өөс “МБХэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах”, “Гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх”, “Түдгэлзүүлэх”, “Нэмэлт ажиллагаа хийлгэхээр МБ-д буцаах”, “Шүүхэд шилжүүлэх”, “ЭХҮЯТТ-г хүчингүй болгож хэрэг бүртгэлтэд буцаах”, “Хэрэгсэхгүй болгох”, “Нэгтгэх /МБ/” шийдвэрийн аль нь болохыг сонгоно.

6. Дээд шатны прокурорын нэрийг сонгохоос өмнө “ДШП хяналт” цэсэд бүртгэл хийсэн байх шаардлагатай.

Мэдээ:

✓ Прокурорын шийдвэр цэсэнд жагсаалтаар буусан шийдвэр тус бүр ХБМБ-2, ХБМБ-3 мэдээний үзүүлэлтүүдэд бууна.






Тайлбар: Шүүх рүү хэрэг өгөхийн өмнө заавал “Шалгах” товчийг дарж хэрэг дундын санд татагдахад бэлэн болсон эсэхийг шалгах шаардлагатай.

2-с дээш удаа шүүх рүү шилжиж байгаа хэргийн “Шалгах” товчийг дарахад мэдээлэл шинэчлэгдээгүй анхаарах хэрэгтэй. /шүүхийн цахим манай цахим бүртгэлээс хэргээ шинэчилж татдаггүй. Энэ тохиолдолд шүүх бүртгэлээ шинэчилж хэргээ хүлээн авах ёстой/

Шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүх хүлээн аваагүй тохиолдолд “Шүүхэд хэргийг хүлээн аваагүй байгаа” төлөв харагдана.


Шүүх хэргийг хүлээж авсны дараа автоматаар шүүхэд шилжсэн төлөвт шилжинэ. /Шүүх хэргийг хүлээж аваагүй тохиолдолд “яллах дүгнэлт үйлдсэн” төлөв хэвээрээ байна/



1. Дээд шатны прокурорын тогтоолоор прокурорын шүүхэд шилжүүлэх шийдвэрийг өөрчилсөн тохиолдолд “Өөрчлөх” товчийг дарж нээгдсэн цонхонд “Шийдвэрийн төрөл”-өөс “Шүүхэд шилжүүлэх” төрлийг сонгож цонхны бусад өгөгдлийг бүрэн бүртгэнэ.
2. Дээд шатны прокурорын нэрийг сонгохоос өмнө “ДШП хяналт” цэсэнд бүртгэл хийсэн байх шаардлагатай.
3. Дээд шатны прокурорын тогтоолоор прокурорын шүүхэд шилжүүлэх шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд “Хүчингүй болгох” товчийг дарж нээгдсэн цонхонд “Шийдвэрийн төрөл”-өөс сонгож цонхны бусад өгөгдлийг бүрэн бүртгэнэ.
4. Дээд шатны прокурорын нэрийг сонгохоос өмнө “ДШП хяналт” цэсэнд бүртгэл хийсэн байх шаардлагатай.

5. Шүүхээс хэргийг прокурорт буцаасан тохиолдолд “Шүүхээс буцаасан” товчийг дарж гарч ирсэн цонх дахь “Шүүхээс хэргийг прокурорт буцаасан хэлбэр”-ээс үндэслэлийг сонгоно. “Шүүхээс хэргийг прокурорт буцаасан хэлбэр”-ээс хамаарч “Шийдвэрийн төрөл” өөрчлөлийг сонгож бүртгэнэ. Цонхны бусад өөрчлөлийг бүртгэн хадгалах товчийг дарна.

2.3.7. Шүүхийн шийдвэр




Тайлбар: “Шүүхийн шийдвэр” хэсэгт яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийн шийтгэх, цагаатгах тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, Улсын дээд шүүхийн тогтоол зэрэг шүүхийн шийдвэр татагдаж жагсаалтаар харагдана. /Энэ хэсэгт шинээр бүртгэл хийхгүй/

Мэдээ:

✓ Шүүхийн шийдвэр шүүхэд төрийг төлөөлөх ажлын мэдээнд бууна.


2.3.8. Нэгтгэх, тусгаарлах




Тайлбар: “Нэгтгэх/Тусгаарлах” хэсэгт нэгтгэгдсэн, тусгаарлагдсан хэргийн жагсаалт харагдана. Хэрэв хэрэг “Нэгтгэх” эсхүл “Шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах” бол “Прокурорын шийдвэр”-ээс нэгтгэж, тусгаарлах төрлийг сонгоно.

Хуучин дугаараар тусгаарлах бол хуучин дугаартай хэрэг рүү орж “Нэгтгэх” прокурорын шийдвэрийн “Тусгаарлах” товчоор бүртгэнэ.

2.3.9. Дээд шатны прокурорын хяналт



Тайлбар: ДШП-хяналт хэсэгт дээд шатны прокуророос хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг хянаж гаргасан шийдвэрийг “Шинээр бүртгэх” товчийг дарж бүртгэнэ.




1. “Дээд шатны хяналт” цонхонд “Дээд шатны прокурорын газраас” хянасан эсэх нь “Тийм, үгүй” төлөвтэйгөөр харагдана.
2. “Хянасан үндэслэл” хэсгээс үндэслэлийг сонгоно.
3. Дээд шатны прокуророос прокурорын шийдвэрийг хянаад гаргасан шийдвэрийн хэлбэрийг сонгоно.
4. Хянасан шийдвэрийн төрлийг сонгоно.

5. Шаардлагатай нэмэлт тайлбарыг бичиж, цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.


Мэдээ:

✓ Дээд шатны прокуророос хянасан хэрэг бүртгэлтийн хэрэг ХБМБ-2 мэдээний 32-34, шийдвэрлэлт нь 35-39 дугаар мөрөнд, мөрдөн байцаалтын хэрэг ХБМБ-3 мэдээний 65-66, 71-73 дугаар мөрөнд, шийдвэрлэлт нь 68-69, 74-75 дугаар мөрөнд тус тус задарч бууна.




1. Дээд шатны прокуророос прокурорын шийдвэрийг хүчингүй болгох бүртгэл хийсний дараа “Прокурорын шийдвэр” цэс рүү орж прокурорын шийдвэрийг “Хүчингүй болгох” товчийг дарна.
2. “Шийдвэрийн төрөл” өгөгдлөөс прокурорын шийдвэрийг хүчингүй болгоод “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах”, “Нэмэлт хэрэг бүртгэл явуулахаар хэргийг мөрдөгчид буцаах”, “Гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх”, “ХБХэргээс шинээр эрүүгийн хэрэг тусгаарлах”, “Нэгтгэх /ХБ/” аль нь болохыг сонгоно.
3. “Дээд шатны хяналт” цэсийн бүртгэлээс прокурорын шийдвэрийг хүчингүй болгосон дээд шатны прокурорын нэр татагдсан байна. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгээд хадгалах товчийг дарна.

2.3.10. Харьяалал




Тайлбар: Харьяалал цэсэд бүртгэл хийхдээ “Шинээр бүртгэх” товчийг дарж дараах цонхны дагуу холбогдох бүртгэлүүдийг хийнэ.



1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага хооронд харьяаллаар шилжүүлж байгаа тохиолдолд “Шилжүүлэх төрөл”-өөс “ХБМБ байгууллага хооронд” төрлийг сонгоно.
2. “ХБМБ байгууллага төрөл”-өөс “Цагдаагийн байгууллага”, “Авлигатай тэмцэх байгууллага”, “Тагнуулын байгууллага”-руу шилжүүлэх аль нь болохыг сонгоно.
3. Прокурорын байгууллага хооронд харьяаллаар шилжүүлэх тохиолдолд “Шилжүүлэх төрөл”-өөс “Прокурорын байгууллага хооронд” сонгоно.
4. Хэргийн харьяалал тогтоолгох тохиолдолд “Хяналт тогтоолгох” гэснийг сонгож хяналт тогтоолгохоор хүргүүлж байгаа албан бичгийн огноо болон УЕПГ, НПГ сонгож бүртгэнэ.


Мэдээ:

- ✓ Харьяаллаар шилжүүлсэн хэрэг бүртгэлтийн хэрэг ХБМБ-2 мэдээний 29, харьяаллаар шилжиж ирсэн хэрэг 30 дугаар мөрөнд тус тус бууна.
- ✓ Харьяаллаар шилжүүлсэн мөрдөн байцаалтын хэрэг ХБМБ-3 мэдээний 40, харьяаллаар шилжиж ирсэн хэрэг 41 дүгээр мөрөнд тус тус бууна.




Тайлбар: Харьяаллаар шилжүүлсэн хэргийг “Харьяаллын шийдвэрийг буцаах” товчийг дарж буцаах боломжтой.

2.3.11. Мөрдөн шалгах ажиллагаа



1. “МША” цэсэд “шинээр бүртгэх” товч дарж прокурор өөрийн биеэр оролцсон мөрдөн шалгах ажиллагааны оролцоог бүртгэнэ.
2. “Мөрдөн шалгах ажиллагааны оролцоо” цонхны өгөгдлөөс ажиллагаанд оролцсон үндэслэлийг сонгоно.
3. “Аль шатанд оролцсон” болохыг өгөгдлөөс сонгоно.
4. “Ажиллагааны төрөл”-ийг сонгож цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна. Бүртгэл тус бүр жагсаалтаар харагдана.

2.3.12. Зөвшөөрөл




Тайлбар: Зөвшөөрөл цэсэд “Ажиллагааны хяналт цэс”-нд бүртгэгдсэн мэдээлэл орж ирнэ. / Зураг №...../

Мэдээ:

✓ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олгосон прокурорын зөвшөөрөл ХБМБ-4 мэдээний 58 дугаар мөрөнд бууна.


2.3.13. Хохирогч / хуулийн этгээд



Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хохирогч бүртгэхдээ “Шинээр бүртгэх” товч дарна. Бүртгэсэн хохирогч тус бүр жагсаалтаар харагдана.


Мэдээ:

✓ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогчоор тогтоогдсон хүн, хуулийн этгээд ХБМБ-4 мэдээний 2-4 дүгээр мөрөнд бууна.


Хохирогч бүртгэл
Төрөл
Хүн
1
2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
3
Гадаадын иргэн test
Үгүй
Тийм
* Регистрийн дугаар
AA12345678
ХАЙХ
Ургийн овог
Ургийн овог
* Эцэг/эх/ нэр
Нэр
* Нэр
Нэр
Утас
Утас
* Нас
Нас
И-мэйл хаяг
И-мэйл хаяг
* Боловсрол
Сонгоно уу
* Хүйс
Сонгоно уу
4
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН МЭДЭЭЛЭЛ
Эрхэлсэн ажилтай эсэх
Сонгоно уу
5
ҮНДСЭН ЗАХИРГААНЫ ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ
* Аймаг, нийслэл
Сонгоно уу
Хороолол
Сонгоно уу
* Сум, дүүрэг
Сонгоно уу
Байр, гудамж
Сонгоно уу
* Баг, хороо
Сонгоно уу
Тоот
Тоот
Бусад (Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл)
6
* Төрөл:
Сонгоно уу
Хохирогчийн байдал :
Сонгоно уу
* Тогтоогдсон огноо
YYYY-MM-DD
* Гэр бүлийн хүчирхийлэлд автсан:
Сонгоно уу
* ЛГБТ эсэх:
Сонгоно уу
Хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийсэн эсэх:
Сонгоно уу
* Авсан арга хэмжээ:
Сонгоно уу
7
ХОХИРОГЧ, ЯЛЛАГДАГЧИЙН ХАМААРАЛ
Яллагдагч:
Сонгоно уу
Хэрхэн хамааралтай болох:
Сонгоно уу
НЭМЭХ
Яллагдагч
Хамаарал
Үйлдэл
БОЛИХ
ХАДГАЛАХ

1. Хохирогчийн мэдээллийг бүртгэхдээ эхлээд “Хүн”, “Албан тушаалтан”, “Хуулийн этгээд” аль нь болохыг сонгоно.
2. Хохирогчийн регистрийн дугаарыг оруулж хайлт хийхэд Улсын бүртгэлийн нэгдсэн цахим системээс тухайн хүний ерөнхий мэдээлэл татагдана. Цахим системээс мэдээлэл татагдаагүй тохиолдолд хохирогчийн ерөнхий мэдээллийг өгөгдлийн дагуу бүрэн бүртгэнэ.
3. Гадаадын иргэнийг хохирогчоор тогтоосон тохиолдолд “тийм, үгүй” товчийг идэвхжүүлж бүртгэлийг үргэлжлүүлнэ.
4. Хохирогчийн “ажил мэргэжлийн мэдээлэл”-д эрхэлсэн ажилтай эсэхийг сонгож, төрийн алба, хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхэлдгийн аль нь болохыг сонгож бүртгэнэ.
5. “Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл”-д хохирогчийн үндсэн захиргаа болон оршин суугаа хаягийн мэдээллийг бүрэн оруулна.
6. “Хохирсон этгээд”, “Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч”, “Иргэний нэхэмжлэгч”-ийн аль нь болохыг сонгож цонхны өгөгдлийн дагуу хохирогчийн байдал, хохирогчоор тогтоогдсон огноо, гэр бүлийн хүчирхийлэлд автсан эсэх, ЛГБТ эсэх, хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийсэн эсэх, авсан арга хэмжээ зэргийг нэг бүрчлэн сонгож бүртгэнэ.
7. “Хохирогч, яллагдагчийн хамаарал” өгөгдөлд яллагдагчийн нэрийг сонгож хохирогчтой ямар хамааралтай болохыг “Нэмэх” товчоор тус бүрт нь нэмж бүртгэнэ. /тухайн хамаарал бүртгэсэн хэсгийг хасах товчоор хасаж болно/


2.3.14. Хохирол



Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт “Хохирол” бүртгэхдээ “Шинээр бүртгэх” товч дарна. Бүртгэсэн хохирол тус бүр жагсаалтаар харагдана.

Мэдээ:

✓ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад бүртгэгдсэн хохирол ХБМБ-4 мэдээний 5-32 дугаар мөрөнд бууна.




1. “Хохирол тодорхойлсон огноо”-г хохирол тогтоосон шинжээчийн дүгнэлтийн огноо, хохирогч, иргэний нэхэмжлэгчийг тогтоож мэдүүлэг авсан огноо гэх мэтээр тодорхойлж бүртгэнэ.
2. “Хохирогчийн төрөл”-өөс хүн, төрийн байгууллага, хуулийн этгээдийн аль нь болохыг сонгож бүртгэнэ.
3. Хохирлын төрлийг өгөгдлөөс сонгоно. Тайлбар хэсэгт дэлгэрэнгүй тайлбар бичиж болно.
4. Энэ хэсэгт хохирогч /Хохирсон, нас барсан хүн/-ийг сонгож бүртгэнэ. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоосон тохиолдолд өгөгдлийн дагуу бүртгэл хийнэ.
5. Хохирогчгүй хэрэг болон хохирогч тогтоогдоогүй, тодорхойгүй хэргийн хувьд “Хохирогч тодорхойгүй” товчийг чагтална. Бусад тохиолдолд хохирогчийг заавал бүртгэнэ.
6. Шууд хохирлоос гадна хор уршиг учирсан эсэхийг сонгож, учирсан хор уршиг, хэмжээ,

ноцтой хохирол учирсан эсэх зэргийг заавал бүртгэнэ. /Хохирол, хор уршгийн дүн ялгаатай/


7. Хохирол төлөгдсөн байдал хэсэгт хохирол төлөгдсөн огноо, аль шатанд, хэчнээн төгрөгийн хохирол төлөгдсөн болох, хохирлын төлөлт, хор уршгийн төлөлт зэргээр бүрэн бүртгэнэ.

Тайлбар: “Хохирол төлөгдсөн байдал” хэсэгт хохирол төлсөн огноо, аль шатанд төлөгдсөн болох, нөхөн төлсөн хэмжээг бүртгэнэ. Хохирол төлөлт, хор уршгийн төлөлт аль нь болохыг зөв сонгож бүртгэн нэмэх товчийг дарна. Нөхөн төлөгдсөн хохирол, хор уршгийн хэмжээ жагсаалтаар харагдана.

2.3.15. Хянан шалгах ажиллагаа



Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын хянан шалгах ажиллагаа явуулсан тохиолдолд “Шинээр бүртгэх” товч дарна. Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.




1. Хянан шалгах ажиллагаа явуулсан үндэслэлийг сонгоно.
2. Хянан шалгах ажиллагаа явуулсан албан тушаалтныг бүртгэнэ.
3. Хянан шалгах ажиллагаа тогтоогдсон эсэхийг “тийм, үгүй” сонголтыг хийнэ.
4. Тогтоогдсон нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тайлбар бичиж болно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:


✓ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын хянан шалгах ажиллагаа явуулсан удаа ХБМБ-4 мэдээний 35-36 дугаар мөрөнд бууна.

2.3.16. Хураан авсан эд зүйл




Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хураан авсан эд хөрөнгийг “Шинээр бүртгэх” товч дарж бүртгэнэ. Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.

2.3.17. Битүүмжилсэн



Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад битүүмжилсэн эд зүйлийг “Шинээр бүртгэх” товч дарж бүртгэнэ. Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.


2.3.18. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан



Тайлбар: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан тохиолдолд “Шинээр бүртгэх” товч дарж бүртгэнэ.

Царцаасан хөрөнгийг энд бүртгэнэ.

Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.




1. Хязгаарласан эд хөрөнгийн төрлийг сонгоно.

2. “Шийдвэрлэлт” хэсэгт хязгаарласан эд хөрөнгийг хэрхэн шийдвэрлэснийг бүртгэнэ.
3. Хязгаарласан эд хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн шийдвэрийн утгыг зөв сонгож бүртгэнэ.
4. “Шийдвэрлэсэн хэлбэр” хэсэгт “тогтоолоор”, “дээд шатны прокурорын шийдвэрээр хүчингүй” болсон эсэхийг сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:

✓ Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа ХБМБ-4 мэдээний 34 дугаар мөрөнд бууна.

2.3.19. Гомдол, хүсэлт




Удирдлага зохион байгуулалт модульд бүртгэсэн гомдол, хүсэлт энэ хэсэгт жагсаалтаар харагдана. Гомдлоор шийдвэр хүчингүй болсон тохиолдолд ДШХяналт цэсэнд давхар бүртгэнэ.

Мэдээ:


✓ Гомдол, хүсэлт Удирдлага зохион байгуулалтын мэдээнд бууна.

2.3.20. Таслан сэргийлэх арга хэмжээ



Тайлбар: Таслан сэргийлэх арга хэмжээний бүртгэлийг “Шинээр бүртгэх” товчийг дарж бүртгэнэ.


Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.




Тайлбар: ТСАХ мэдээлэл хэсгээс яллагдагчийн нэрийг сонгож аль шатанд, ямар таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан болохыг сонгож огноо, таслан сэргийлэх арга хэмжээ авсан субьектийг сонгож бүртгэнэ. Хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг түдгэлзүүлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээний хувьд цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

Мэдээ:


✓ Таслан сэргийлэх арга хэмжээ авсан нийт яллагдагч ХБМБ-4 мэдээний 50 дугаар мөрөнд, төрөл болон хугацаагаар 51-57 дугаар мөрөнд задарч бууна.



1. Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг бүртгэхдээ яллагдагчийн нэрийг сонгоно.
2. Барьцаа гаргагч нь хэн болохыг сонгоно.
3. “Үе шат” хэсэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад эсхүл прокурорын хяналтын шатанд аль нь болохыг сонгоно.
4. Шийдвэрлэх субъектийг сонгоно. Барьцааны мөнгөн дүн, барьцааны мөнгө байршуулсан дансны дугаар, барьцаанаас татгалзсан эсэхийг бүртгэж хадгалах товчийг дарна.




1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг бүртгэхдээ яллагдагчийн нэрийг сонгоно.
2. Яллагдагчийг цагдан хорьсон огноог бүртгэж, цагдан хорих хугацааг сонгож оруулна.
3. “Үе шат” хэсэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад эсхүл прокурорын хяналтын шатанд аль нь болохыг сонгоно.
4. Яллагдагчийг цагдан хорьсон талаар мэдэгдсэн хэлбэр болон 2 цагийн дотор мэдэгдсэн эсэх, хугацаа хэтрүүлсэн эсэхийг сонгож оруулна.
5. Цагдан хорьсон үндэслэлийг сонгож оруулна.
6. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч эсэхийг “тийм”, “үгүй” сонголтыг хийнэ. Шийдвэрлэх субъектийг сонгоод хадгалах товчийг дарна.



1. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн нэрийг сонгоно.
2. Хязгаарлалт тогтоосон хэлбэрийг сонгож оруулна.
3. “Үе шат” хэсэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад эсхүл прокурорын хяналтын шатанд аль нь болохыг сонгоно.
4. Шийдвэрлэх субъектийг сонгоод хадгалах товчийг дарна.

Нэмэлт тайлбар: Таслан сэргийлэх арга хэмжээ бүртгэхийн өмнө заавал ажиллагааны хяналт цэсэд санал зөвшөөрөл бүртгэсний дараа ТСАХ цонхонд субъектээ зөв сонгож зөвшөөрсөн шийдвэрийг оруулж хадгална.

2.3.21. Сэжигтнийг баривчлах



Тайлбар: Сэжигтнийг баривчлах бүртгэлийг “Шинээр бүртгэх” товчийг дарж бүртгэнэ.

Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.


Мэдээ:

✓ Баривчилсан сэжигтэн ХБМБ-4 мэдээний 47-48 дугаар мөрөнд, баривчилсан сэжигтнийг үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдолд 49 дүгээр мөрөнд бууна.



1. Сэжигтнийг баривчлах бүртгэл хийхдээ “Сэжигтэн” + дарж сэжигтний мэдээллийг бүрэн оруулна.
2. Сэжигтнийг баривчилсан огноо, цаг, минут, баривчилсан хугацаа, зарцуулсан цаг, минутыг бүртгэнэ.
3. Баривчилсан хэлбэрийг сонгоно.
4. Баривчилсан үндэслэлийг сонгоно.
5. Баривчилсан сэжигтнийг суллах, үргэлжлүүлэн хорих эсэх шийдвэрийг бүртгэнэ.
6. “Үргэлжлүүлэн цагдан хорих эсэх”-ийг чагтална. Сулласан, үргэлжлүүлэн хорьсон албан тушаалтан, сулласан үндэслэл, сулласан, үргэлжлүүлэн хорьсон огноо, цаг, минут зэргийг бүртгэж хадгалах товчийг дарна.

2.3.22. Дуудан ирүүлэх




Тайлбар: Дуудан ирүүлэх цэсэд “Дуудан ирүүлэх”, “Албадан ирүүлэх”, “Эрэн сурвалжлах” ажиллагааг “шинээр бүртгэх” товчийг дарж бүртгэнэ.

Бүртгэсэн ажиллагаа тус бүр жагсаалтаар харагдана.


Мэдээ:

- ✓ Дуудан ирүүлэх тухай прокурорын мэдэгдэх хуудас ХБМБ-4 мэдээний 41-43 дугаар мөрөнд бууна.
- ✓ Эрэн сурвалжлах ажиллагааны даалгавар ХБМБ-4 мэдээний 37, 38-39 дугаар мөрөнд, эрэн сурвалжлах ажиллагаа явуулахаар бичсэн тогтоол ХБМБ-4 мэдээний 40 дүгээр мөрөнд тус тус бууна.




1. Дуудан ирүүлэх ажиллагааг бүртгэхдээ “Зорилго” хэсгээс ямар зорилгоор дуудан ирүүлэх шаардлагатай байгааг сонгоно.

2. Хэнийг дуудсан болохыг өгөгдлөөс сонгоно.
3. Дуудсан хэлбэрийг сонгож цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.




Тайлбар: “Шийдвэр” хэсэгт ажиллагааны хяналт цэсээс прокурорын зөвшөөрөл орж ирнэ. Яллагдагчийн нэрийг сонгож, огноог оруулж хадгалах товчийг дарна.




1. “Эрэн сурвалжлах” ажиллагаа явуулах хэлбэрийг сонгоно.
2. Эрэн сурвалжлах ажиллагааны зорилгыг сонгоно.
3. Эрэн сурвалжлагдсан этгээдийг өгөгдлөөс сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.

2.3.23. Авсан арга хэмжээ




Тайлбар: Мэдэгдэл, шаардлага, даалгавар, эрэн сурвалжлах тогтоол, албан тоот, хариуцлага, илрүүлсэн зөрчлийг “Авсан арга” хэмжээ цэсэд “шинээр бүртгэх” товчоор бүртгэнэ.


- ✓ Мэдэгдэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын мэдээнд, шаардлага Удирдлага зохион байгуулалтын мэдээнд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд болон нэмэлтээр буцаасан даалгавар, эрэн сурвалжлах ажиллагааны даалгавар ХБМБ-4 мэдээний 37, 38-39 дугаар мөрөнд, эрэн сурвалжлах ажиллагаа явуулахаар бичсэн тогтоол ХБМБ-4 мэдээний 40 дүгээр мөрөнд, хариуцлага, илрүүлсэн зөрчил Удирдлага зохион байгуулалтын мэдээнд тус тус бууна.



1. Аль шатанд даалгавар бичсэнийг өгөгдлөөс сонгоно.
2. Даалгаврын төрлийг сонгоно.
3. Даалгавар бичсэн прокурорыг сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.




1. Аль шатанд эрэн сурвалжлах тогтоол бичсэнийг өгөгдлөөс сонгоно.
2. Хэнд бичсэн болохыг тодорхой бичиж оруулна.
3. Эрэн сурвалжлах тогтоолын хариу ирүүлсэн эсэхийг сонгоно. Цонхны өгөгдлийг бүрэн бүртгэж хадгалах товчийг дарна.



1. Аль шатанд албан тоот бичсэнийг өгөгдлөөс сонгоно. Тайлбар хэсэгт дэлгэрэнгүй тайлбарыг бичиж оруулна.
2. Албан бичгийн хариу ирүүлсэн эсэхийг заавал бүртгэнэ.


1.3. ШҮҮХЭД ТӨРИЙГ ТӨЛӨӨЛӨХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ




ХАЙЛТЫН ТАЛБАР

Хайлтын талбар нь 5 хэсгээс бүрдэх ба аль ч шатны шүүхээс болон хэргийн мэдээллээс хайх боломжтой.


1. Тайлбар: Эрүүгийн хэргийн дугаар, ерөнхий мэдээллээр хайх ба аль ч шатны шүүхийн талбараас хайлт хийх боломжтой.



Хайлтын талбараас хайлт хийснээр хэргийн жагсаалт гарч ирнэ.




1. Харандааны зураг дээр дарснаар шүүхэд хэрэг хүлээж авсан жагсаалт гарч ирнэ.




1. Хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэний дараа уг талбарыг бүртгэнэ.
2. Шүүхийн шийдвэр дундын сангаас татагдахгүй тохиолдолд уг товчлуурын тусламжтайгаар гараар бүртгэнэ.
3. Шүүхийн шийдвэр нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, ЭХХШТХуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд бүртгэнэ.
4. Эрүүгийн хэргийг тухайн шүүх хүлээн авсан тохиолдолд “ХАРАХ” товчлуур гарч ирэх ба хэрэв шүүх хэргийг хүлээж аваагүй тохиолдолд уг товчлуур харагдахгүй.

Мэдээ: Энэ жагсаалт нь шүүх хүлээн авсан огноо татагдсан тохиолдолд ШТТ-1 мэдээний 1-ээс 3-р мөрөнд буух ба нийт хэргийн тоонд нэмэгдэнэ. ШТТ-1 мэдээний 2-р мөрөнд эцэслэн шийдвэрлэгдсэн огнооноос хамаарч бууна.




Уг талбараас шүүхэд шилжсэн хэргийн ерөнхий мэдээллийг харах боломжтой.


АНХАН ШАТ




1. “Анхан шат”-ны шүүхийн бүртгэлүүд рүү орно.
2. “ПРОКУРОР ОРОЛЦСОН БАЙДАЛ” цэсэд Улсын яллагчийн дүгнэлт бүртгэгдэнэ.




Дараах 3 төрлөөс аль тохирохыг сонгож бүртгэнэ.




1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт прокурор оролцсон байдлыг бүртгэнэ. ШТТ-1 мэдээний 20, 21-р мөрөнд бууна.
2. Буцаасан эсэх-ийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 12-р мөрөнд бууна.




1. Гэм буруугийн шүүх хуралдаанд прокурор оролцсон байдлыг бүртгэнэ. ШТТ-1 мэдээний 22, 23-р мөрөнд бууна.
2. Прокурор яллахаас татгалзсан эсэхийг “ТИЙМ” гэж сонгож бүртгэвэл үндэслэлээс хамаарч ШТТ-1 мэдээний 18, 19-р мөрөнд бууна.
3. Шүүх хуралдаанаас прокурорт буцсан эсэхийг “ТИЙМ” гэж сонгож бүртгэвэл ШТТ-1 мэдээний 13-р мөрөнд бууна.




1. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүх хуралдаанд прокурор оролцсон байдлыг бүртгэнэ. ШТТ-1 мэдээний 24, 25-р мөрөнд бууна.




1. “ШҮҮХИЙН ШИЙДВЭРТЭЙ ТАНИЛЦАХ” хэсэг рүү нэвтэрч, прокурор танилцсан эсэхийг бүртгэж оруулна.




1. Хялбаршуулсан журмаар гэж сонговол ШТТ-1 мэдээний 26-р мөрөнд бууна.
2. Шүүгдэгчийн зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон эсэхийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 32-р мөрөнд бууна.




1. “Эсэргүүцэл” Хэрэв прокурор эсэргүүцэл бичвэл тухайн талбарыг сонгож бүртгэнэ. Эсэргүүцлийг хэлэлцсэн тохиолдолд ШТТ-1 мэдээний 35-р мөрөнд бууна.




1. Шүүхийн шийдвэрээс хамаарч, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд дараах төрлүүдээс тохирохыг сонгож, бүртгэнэ. Төрөл цэсний сонголтоос хамаарч ШТТ-1 мэдээний 36-аас 46-р мөрөнд задарч бууна.



1. Шинээр илэрсэн нөхцөл байдлыг бүртгэнэ.




1. Шинээр илэрсэн нөхцөл байдал тогтоогдвол бүртгэнэ. Хэлэлцэгдсэн эсэхээс хамаарч ШТТ-1 мэдээний 47, 48-р мөрөнд бууна.



1. Шүүхийн шийдвэр татагдаагүй тохиолдолд уг товчлуур дээр дарж шийтгэх тогтоолыг бүртгэх боломжтой.

Мэдээ: ШТТ1- мэдээний 4, 5 мөрөнд буух ба 6-11 дүгээр мөрөнд задарч тоологдоно. Хэд хэдэн зүйл ангиар шийтгэхдээ 2002 болон 2015 оны хууль хэрэглэсэн бол 2015 оны хөнгөн, хүндийн аль нэгэн дээр тоологдоно.




1. Шийдвэрийн төрлөөс хамаарч ШТТ-1 мэдээний 26, 27-р мөрөнд бууна.
2. Үндсэн ялын шийдвэрийн төрлийг ял оногдуулах гэж сонговол үндсэн ялын төрлөөс хамаарч ШТТ-2 мэдээний 9-өөс 13-р мөрөнд задарч бууна.

   -Хорих ял оногдуулахгүй тэнсэх ШТТ-2 мэдээний 20


   -Ялаас чөлөөлөх ШТТ-2 мэдээний 21 (Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн бол ШТТ-2 мэдээний 4)

   -Хэрэгсэхгүй болгох үндэслэл нь ЭХХШТХ-ийн 34.19-1.1 бол ШТТ-1 мэдээний 29, 30, 31


   -Цагаатгах ШТТ-1 мэдээний 29, 30
3. Сонголтоос хамаарч ШТТ-2 мэдээний 20-оос 25-р мөрөнд задарч бууна. (Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн бол ШТТ-2 мэдээний 4-өөс 8)




1. Албадлагын арга хэмжээ. Төрлөөс хамаарч ШТТ-2 мэдээний 14-өөс 19-р мөрөнд задарч бууна.




1. Нэмэгдэл ял. Эрх хасах ял нь ШТТ-2 мэдээний 13-р мөрөнд бууна.



1. Цагдан хоригдсон хугацаа




1. Хэрэгт эд мөрийн баримт авагдсан тохиолдолд уг талбарт шийдвэрлэлтийн бүртгэлээс сонгон бүртгэнэ.




1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг энэ талбарт бүртгэхдээ:

   -Хохирлын 5 төрлийг аль тохирохыг чагталж, хэрхэн шийдвэрлэгдсэнийг сонгож бүртгэнэ.




1. Нэхэмжлэл. Хохирогчийн гаргасан нэхэмжлэлийг доорх шийдвэрлэлтээс сонгон бүртгэнэ.


ДАВЖ ЗААЛДАХ




1. Давж заалдах шатны бүртгэл




1. Хэлэлцэх үндэслэлийг бүртгэхдээ дээрх 3 үндэслэлээс тохирохыг сонгож бүртгэнэ.




Давж заалдах шатны шүүхэд гаргасан прокурорын дүгнэлтийг бүртгэх цэс




1. Дүгнэлтийг үндэслэлүүдээс аль тохирохыг сонгож бүртгэнэ.
2. Шүүх хуралдаанаас прокурорт буцсан эсэхийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 13-р мөрөнд бууна.




Магадлалтай танилцах талбар




1. Магадлалтай танилцах бүртгэлийн хэсгийг сонгож прокурор танилцсан талбарыг мэдээллийг энэ хэсэгт бүртгэнэ.
2. Шүүгдэгчийн зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон эсэхийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 32-р мөрөнд бууна.
3. “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 33, 34-р мөрөнд бууна.



1. Дээрх цонхоор нэвтэрч магадлалыг бүртгэнэ.



1. Магадлалын бүртгэхдээ шийдвэрийн төрлөөс аль тохирохыг сонгон авч бүртгэнэ.




Магадлалын бүртгэх цэсэнд:


ШТТ-1 мэдээний 4, 5 мөрөнд буух ба 6-11 дүгээр мөрөнд задарч тоологдоно.

Хэд хэдэн зүйл ангиар шийтгэхдээ 2002 болон 2015 оны хууль хэрэглэсэн бол 2015 оны хөнгөн, хүндийн аль нэгэн дээр тоологдоно.


Шийдвэрийн төрлөөс хамаарч **“Өөрчлөх”, “Заримыг хүчингүй болгох, өөрчлөх”** гэсэн сонголтоор бүртгэвэл эрүүгийн хариуцлагыг бүртгэнэ. **“Бүгдийг хүчингүй болгох”** гэж сонговол анхан шатны шийдвэр хүчингүй болж, шүүхийн шийдвэртэй холбоотой мэдээний мөрүүдээс хасагдана. Мөн буцаах төрлийг **“Анхан шатны шүүхэд”** гэж сонговол **ШТТ-1 мэдээний 15-р мөрөнд тоологдоно**. **“Цагаатгах”** болон **“Хэрэгсэхгүй болгох”** гэж сонговол **ШТТ-1 мэдээний 28-р мөрөнд бууна.**




1. Магадлалын албадлагын арга хэмжээний бүртгэл төрлөөс хамаарч ШТТ-2 мэдээний 14-өөс 19-р мөрөнд задарч бууна.




1. Нэмэгдэл ял. Эрх хасах ял нь ШТТ-2 мэдээний 13-р мөрөнд бууна.




1. Цагдан хоригдсон нийт хугацааг бүртгэнэ.




1. Магадлалд дурдагдсан эд мөрийн баримт байгаа бол уг цэсэд бүртгэлийг хийнэ.




1. Хохирол, хор уршиг учирсан тохиолдолд уг бүртгэлийг бүртгэх ба шийдвэрлэлтийн төрлөөс тохирох өгөгдлийг сонгоно.




1. Магадлалд нэхэмжлэл дурдагдсан тохиолдолд шийдвэрлэлт цэсээс сонголт хийн бүртгэнэ.




1. Шүүхийн шийдвэрээс хамаарч, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд дараах төрлүүдээс тохирохыг сонгож, бүртгэнэ.



1. Тухайн хэрэгт бичсэн эсэргүүцлийн төрөл болон үндэслэлээс аль тохирохыг сонгож, бүртгэнэ. Төрөл цэсийн сонголтоос хамаарч ШТТ-1 мэдээний 36-аас 46-р мөрөнд задарч бууна.
2. Эсэргүүцлийг хэлэлцсэн тохиолдолд ШТТ-1 мэдээний 35-р мөрөнд бууна.




1. ШИНБ-ын бүртгэл




1. Шинээр илэрсэн нөхцөл байдал тогтоогдвол бүртгэнэ. Биелсэн төрлөөс хамаарч ШТТ-1 мэдээний 47, 48-р мөрөнд бууна.


ХЯНАЛТЫН ШАТ




1. Хяналтын шат цэс рүү нэвтэрч, хэлэлцэх үндэслэлийг бүртгэнэ.




1. Хэргийн оролцогч болон үндэслэлээс тохирохыг нь сонгож бүртгэнэ.




1. Хяналтын шатны прокурорын дүгнэлт бүртгэх.




1. Дүгнэлтийг үндэслэлүүдээс аль тохирохыг сонгож бүртгэнэ. Шүүх хуралдаанаас прокурорт буцсан эсэхийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 13-р мөрөнд бууна.




1. Хяналтын шатны тогтоолтой танилцах талбарыг сонгож бүртгэх.




1. Магадлалтай танилцах бүртгэлийг хэсгийг сонгож прокурор танилцсан талбарыг мэдээллийг энэ хэсэгт бүртгэнэ.
2. Шүүгдэгчийн зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон эсэхийг “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 32-р мөрөнд бууна.
3. “ТИЙМ” гэж сонговол ШТТ-1 мэдээний 33, 34-р мөрөнд бууна.




1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын дүгнэлтийг энэ цэс рүү орж бүртгэнэ.



1. Шинээр илэрсэн нөхцөл байдал тогтоогдвол бүртгэнэ. Хэлэлцэгдсэн эсэхээс хамаарч ШТТ-1 мэдээний 47, 48-р мөрөнд бууна.




1. Доорх цэс рүү орж хяналтын тогтоолыг бүртгэнэ.



1. Хяналтын тогтоолыг бүртгэхдээ Эрүүгийн хариуцлага, эд мөрийн баримт, хохирол, нэхэмжлэл зэргийг тус бүрийн цэс рүү нэвтэрч бүртгэнэ.
2. Хяналтын тогтоолын үндсэн ял, албадлагын арга хэмжээ, нэмэгдэл ял, цагдан хоригдсон хугацааг тус бүрийн цэс рүү нэвтэрч бүртгэнэ.


ШТТ-1 мэдээний 4, 5 мөрөнд буух ба 6-11 дүгээр мөрөнд задарч тоологдоно. Хэд хэдэн зүйл ангиар шийтгэхдээ 2002 болон 2015 оны хууль хэрэглэсэн бол 2015 оны хөнгөн, хүндийн аль нэгэн дээр тоологдоно. Шийдвэрийн төрлөөс хамаарч тохирох сонголтыг хийж бүртгэнэ.

ЗӨРЧИЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА




1. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны модуль хайлтын 4 талбартай.
2. Шүүхийн сангаас татагдаагүй тохиолдолд шинээр бүртгэх товчлуураар бүртгэл хийнэ.
3. Шүүхийн сангаас татагдсан тохиолдолд “татах” цэсээр нэвтэрч бүртгэл хийнэ.

ЭРҮҮГИЙН ШҮҮХ




1. “Татах” товчлуураар нэвтэрснээр дэлгэрэнгүй мэдээлэл харагдана.


АНХАН ШАТ



1. Анхан шатны шүүхийн шийдвэр нь 4 талбараас бүрдэнэ.




1. Прокурорын тайлбар бүртгэл. ШТТ-4 мэдээний 1-р мөрөнд, төрлөөс хамаарч 2-оос 7-р мөрөнд задарч бууна.




1. Шүүхийн шийтгэвэр хэсгийг өгөгдөл тус бүрийг бүртгэж давхар холбогдогчийн шийтгэлийн хэсгийг бүртгэнэ.
2. “+” товчлуураар холбогдогч нэмж бүртгэх бол дарах бөгөөд ингэснээр зөрчлийн модулийн холбогдогч талбар руу шилжинэ.

   Шийдвэрлэсэн байдлаас хамаарч ШТТ-4 мэдээний 9-өөс 14-р мөрөнд задарч бууна.




1. Оролцогчийн гомдол хэсэгт доорх төрлөөс тохирох өгөгдлийг сонгон бүртгэнэ.




1. Эсэргүүцэл хэлэлцэгдсэн тохиолдолд бүртгэнэ. ШТТ-4 мэдээний 20-р мөрөнд бууна.


ДАВЖ ЗААЛДАХ ШАТ



1. Давж заалдах шатны талбарт прокурорын тайлбар, магадлал гэх 2 дэд цэсээр бүртгэнэ.




1. Прокурорын тайлбар хэсэгт доорх өгөгдлөөс аль тохирохыг чагтлан бүртгэнэ. ШТТ-4 мэдээний 1-р мөрөнд, төрлөөс хамаарч 2-оос 7-р мөрөнд задарч бууна.




1. Магадлалын шийдвэрлэсэн байдлаас тохирох өгөгдлийг сонгон бүртгэнэ. Шийдвэрлэсэн байдлаас хамаарч ШТТ-4 мэдээний 9-өөс 14-р мөрөнд задарч бууна.

ЗАХИРГААНЫ ШҮҮХ



1. Захиргааны шүүх хайлтын талбар ба ШИНЭЭР БҮРТГЭХ товчлуур дээр дарж гараар бүртгэлийг оруулна.
2. Бүртгэлийн жагсаалтаас хэргийг сонгож нүдний зурагтай товчлуур дээр дарж цааш бүртгэлийг үргэлжлүүлнэ.




1. Захиргааны шүүхийн дэлгэрэнгүй бүртгэл хэсэгт шүүхэд шилжүүлсэн хэлбэр холбогдогч, хохирол, хураан авсан бүртгэлүүд харагдана.


АНХАН ШАТ




1. Захиргааны шүүхийн анхан шат цэсэд прокурорын тайлбар, шүүхийн шийтгэвэр, оролцогчийн гомдол бүртгэлүүд харагдана.



1. Прокурорын тайлбар хэсэгт шүүхэд прокурорын оролцсон хэлбэрүүдээс тохирохыг сонгоно. ШТТ-3 мэдээний 1-р мөрөнд, төрлөөс хамаарч 2-оос 4-р мөрөнд задарч бууна.




1. Шүүхийн шийтгэврийг бүртгэхдээ шүүх хуралдаанд оролцох үндэслэлээс тохирох өгөгдлийг сонгож бүртгэнэ. Шийдвэрлэсэн байдлаас хамаарч ШТТ-3 мэдээний 6-аас 11-р мөрөнд задарч бууна.




1. Оролцогчийн гомдол талбарыг бүртгэхдээ төрийн байгууллагын хүсэлтээр бол “Төрийн байгууллага хүсэлт гаргасан эсэх”-ийг чагтална.


ДАВЖ ЗААЛДАХ ШАТ




1. Захиргааны шүүхийн давж заалдах шатны прокурорын тайлбарыг бүртгэх




1. Прокурорын тайлбарыг бүртгэхдээ прокурорын шүүхэд оролцсон байдлыг сонгож, агуулгыг гараар бичиж бүртгэнэ. ШТТ-3 мэдээний 1-р мөрөнд, төрлөөс хамаарч 2-оос 4-р мөрөнд задарч бууна.




1. Давж заалдах шатны шүүхийн магадлал бүртгэх




1. Магадлалыг бүртгэхдээ шүүх хуралдаанд оролцох үндэслэлээс сонгож бүртгэл хийнэ. Шийдвэрлэсэн байдлаас хамаарч ШТТ-3 мэдээний 6-аас 11-р мөрөнд задарч бууна.




1. Оролцогчийн гомдлыг бүртгэх хэсэг




1. Оролцогчийн гомдол гаргагчийн төрлөөс тохирох хэсгийг сонгож бүртгэх.




1. Прокурорын гомдол бүртгэх хэсэг




1. Прокурорын гомдол бүртгэхдээ доорх талбарыг бүрэн бөглөнө. Гомдлын биелсэн төрлөөс хамаарч ШТТ-3 мэдээний 12, 13 дугаар мөрөнд бууна.




1. Хяналтын шатны шүүхийн прокурорын тайлбар бүртгэх хэсэг



1. Прокурорын тайлбар бүртгэхдээ доорх 2 сонголтоос сонгож бүртгэлийг бүртгэнэ. ШТТ-3 мэдээний 1-р мөрөнд, төрлөөс хамаарч 2-оос 4-р мөрөнд задарч бууна.




1. Хяналтын шатны прокурорын гомдол бүртгэх цэс




1. Прокурорын гомдол бүртгэх хэсэг. Гомдлын биелсэн төрлөөс хамаарч ШТТ-3 мэдээний 12, 13-р мөрөнд бууна.


ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА




1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хайлтын талбар
2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинээр бүртгэнэ.




1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүртгэх хэсэг
- Оролцох үндэслэлээс хамаарч ШТТ-5 мэдээний 1-8 дугаар мөрөнд
- Ашиг сонирхол гэсэн сонголтоос хамаарч ШШТ-5 мэдээний 9-11 дүгээр мөрөнд
- Маргааны төрөл болон Маргааны дэд төрлөөс хамаарч ШШТ-5 мэдээний 30-39 дүгээр мөрөнд тус тус задарч бууна.




1. Бүртгэх хэсгийн бүртгэлийг бүртгэснээр доорх жагсаалт гарч ирэх ба нүдний зурагтай хэсэгт дарж цааш нь бүртгэлийг бүртгэнэ



1. Тухайн хүсэлтийг прокурор хэрхэн шийдвэрлэснийг бүртгэнэ.




1. Прокурорын шийдвэр бүртгэхэд “шийдвэр” хэсгээс сонголтууд гарч ирэх ба тохирох өгөгдлийг сонгон авч бүртгэх.




1. Прокурорын шийдвэрийг бүртгэхэд доорх жагсаалтад дээр нэмэгдэж бууна.


АНХАН ШАТ



1. Хуралдааны бэлтгэл цэсийг бүртгэхдээ доорх өгөгдлүүдээс тохирохыг чагталж хадгална. Хийж гүйцэтгэсэн ажиллагаанаас хамаарч ШТТ-5 мэдээний 12-18 дугаар мөрөнд задарч бууна.




2. Талууд эвлэрсэн цэсийн өгөгдөл тус бүрийг бүртгэж хадгална. ШТТ-5 мэдээний 21, 22 дугаар мөрөнд бууна.




1. Шүүхийн шийдвэр бүртгэх цэс. Прокурорын тайлбарыг хангасан эсэхээс хамаарч ШТТ-5 мэдээний 24-29 дүгээр мөрөнд задарч бууна.

   Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсан эсэхээс хамаарч ШТТ-5 мэдээний 19, 20, 23 дугаар мөрөнд бууна.




1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлт бүртгэх цэс. Биелэгдсэн эсэхээс хамаарч ШТТ-5 мэдээний 43, 44 дүгээр мөрөнд бууна.


ДАВЖ ЗААЛДАХ ШАТ



1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны давж заалдах шатны прокурорын гомдол, тайлбар бүртгэх цэс. Гомдол биелсэн эсэхээс хамаарч ШТТ-5 мэдээний 40- 42 дугаар мөрөнд задарч бууна.




1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлт бүртгэх цэс




1. Магадлал бүртгэнэ.


ХЯНАЛТЫН ШАТ



1. Хяналтын шатны шүүхийн прокурорын гомдол, тайлбар бүртгэнэ. ШТТ-5 мэдээний 40- 42 дугаар мөрөнд задарч бууна.




1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлт бүртгэх цэс




1. Хяналтын шатны шүүхийн тогтоол бүртгэнэ.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА




1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хайлтын талбарт шинээр бүртгэх цэс рүү орж бүртгэлийг бүртгэх




1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүртгэх хэсэг




1. Шинээр бүртгэх цэсийг бүртгэснээр жагсаалтын хэсэгт бууж ирэх ба засах болон харах товчлууруар орж харна.



1. Уг хэсэгт прокурорын шийдвэрлэлт бүртгэнэ.




1. Прокурорын шийдвэр бүртгэх хэсэг




1. Прокурорын шийдвэрлэлт бүртгэснээр жагсаалт хэсэгт бууж ирэх ба засах болон харах цэсээр нэвтэрч орно.

АНХАН ШАТ




1. Анхан шатны бүртгэлийн хэсэгт дараах талбарууд руу тус бүр нэвтэрч бүртгэлийг хийнэ.

ДАВЖ ЗААЛДАХ ШАТ




1. Давж заалдах шатны шүүхийн бүртгэх цэсэд доорх талбарууд байх ба нэвтэрч бүртгэл хийнэ.

ХЯНАЛТЫН ШАТ



1. Хяналтын шатны шүүхийн бүртгэлд доорх талбаруудаас сонгон бүртгэл хийнэ.

1.4 ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН МОДУЛЬ



Товч тайлбар:

Прокурорын байгууллагын “Цахим бүртгэлийн нэгдсэн систем”-ийн “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт”-ын модульд ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын ажлын чиглэлээр хийсэн шалгалт, судалгаа, танилцах ажиллагаа, тэдгээрийн мөрөөр авсан арга хэмжээ, илрүүлсэн зөрчил, хоригдол, ялтан болон албадлагын арга хэмжээ авагдсан, шийтгүүлсэн, баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн мэдээлэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, Хорих ангиас ирүүлсэн санал, прокурор, шүүхийн шийдвэрийг бүртгэж, хяналт тавина.

ЯЭАТХ-ийн модуль нь дараах хэсгээс бүрдэнэ.

- Шалгах танилцах
- ХЯЭА /Хорих ял эдлүүлэх ажиллагаа/
- ХӨТЯЭА /Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа/
- ТЭНСЭХ, ААХ, ХЯОШТБХОЙШЛУУЛАХ /Тэнсэх, Албадлагын арга хэмжээ авсан, Хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах/
- ЗШГ /Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа/
- Тушаал хянасан
- Өлсгөлөн /Өлсгөлөн зарласан хоригдогчийн бүртгэл/
- Зөрчил гаргасан
- Баривчлах, Цагдан хорих, Саатуулах
  - Захиргааны журмаар баривчлах байр
  - Саатуулах байр
  - Үндэслэлгүй хоригдсон этгээдийг сулласан
  - Цагдан хорих байр
  - ШШГБ /ШШГБ татагдах хэсэг/

Талбар бүр нь **“ХАЙЛТ”** болон **“ШИНЭЭР БҮРТГЭХ”** гэсэн хэсэгтэй.

Хайлт хэсгийн дурын талбарт өөрийн хайх зүйлийнхээ утгыг сонгож ХАЙЛТ товчыг дарснаар мэдээллээ хайна.

Дахин хайлт хийхэд өмнө нь оруулсан мэдээллүүдийг цэвэрлэж ЦЭВЭРЛЭХ товчийг дарна.


Талбар бүрийн ШИНЭЭР БҮРТГЭХ хэсэгт өгөгдлийн дагуу мэдээллээ үнэн зөв, бүрэн оруулж ХАДГАЛАХ товчийг дарснаар таны мэдээлэл бүртгэгдэнэ.

- Талбарын ≡ ЖАГСААЛТ -д байгаа бүртгэлийг өөрчлөх, засвар хийх тохиолдолд товчийг дарна.
- Талбарын жагсаалтад байгаа бүртгэлийн мэдээллийг харах бол товчийг дарна.
- Тухайн талбарын жагсаалтаас бүртгэлийг устгах болох товчийг дарна.
- Жагсаалтыг эксел файл руу хуулж хадгалах бол товчийг дарна.
- Шинээр бүртгэх үйлдлийг цуцлах бол БОЛИХ товчийг дарна.

НЭГ. ШАЛГАХ, ТАНИЛЦАХ АЖИЛЛАГАА /ШАЛГАХ ТАНИЛЦАХ/

1.1 Хайлт хэсэг

Шалгах танилцах ажиллагааны ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийхэд өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг цэвэрлэж ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.




1. Жагсаалтыг эксел файлруу хуулж хадгалах бол уг товчийг дарна.
2. “Шалгалтын нэр” талбарт тухайн шалгалт, судалгаа, танилцах ажлын нэрээс “Түлхүүр үг”-ээр хайлт хийх боломжтой.

1.2. Шинээр бүртгэх талбар


Тайлбар: Ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр хийсэн шалгалт, судалгаа болон танилцах ажиллагаа, түүний мөрөөр авсан арга хэмжээ, илэрсэн зөрчлийн талаар тухай бүр цахим бүртгэлд бүртгэнэ.

ЖАГСААЛТ хэсгийн ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарахад энэхүү талбар гарч ирэх ба өгөгдлийн дагуу мэдээллийг үнэн зөв бүртгэж, ХАДГАЛАХ товчийг дарна. Таны бүртгэсэн шалгалт, судалгаа, танилцах ажил талбарын ЖАГСААЛТ хэсэгт орно. Мэдээллийг бүртгэхийг цуцлах бол БУЦАХ товчийг дарж цуцална.



1. Шалгалт, судалгаа, танилцах ажлын утгыг удирдамжид заасан байдлаар дэлгэрэн оруулна.


1.3 Шалгалт, судалгаа, танилцах ажлын мөрөөр авсан арга хэмжээ, илрүүлсэн зөрчил, хариуцлага, эрх сэргээсэн талаарх бүртгэл.




1. Шалгалт, судалгаа, танилцах ажлын мөрөөр бичсэн мэдэгдлийг бүртгэнэ.




1. ЖАГСААЛТ хэсгээс тухайн бүртгэсэн шалгалт, судалгаа, танилцах ажлын бүртгэл рүү / ЗАСАХ/ товчийг дарж шалгалт, судалгаа, танилцах ажлын явцад авсан арга хэмжээг сонгож бүртгэнэ. Тухайлбал: Шалгалтын мөрөөр хэдэн зөрчил илэрсэн болох, илэрсэн зөрчлийг арилгуулахаар прокуророос шаардлага, албан бичиг, даалгавар бичсэн эсэх, шалгалтын явцад зөрчигдсөн эрхийг сэргээсэн эсэх зэрэг ямар арга хэмжээ авсан болохыг тус тусад нь хамаарах хэсэгт сонгож бүртгэнэ.






1. Шалгах, танилцах ажлын явцад үйлдэгдсэн даалгаврыг бүртгэнэ.



1. Шалгалт, судалгаа, танилцах ажлын мөрөөр хүргүүлсэн албан бичгийг бүртгэнэ.



1. Шалгах, танилцах ажлын мөрөөр хариуцлага тооцуулсан алба хаагчийн мэдээллийг бүртгэнэ.




1. Шалгалт, танилцах ажлын мөрөөр илэрсэн зөрчил, хэдэн хоригдол, ялтны эрхийг сэргээсэн, хэдэн хоригдлыг хорих ангид татан оруулах арга хэмжээ авагдсан зэрэг мэдээллийг бүртгэнэ.

ХОЁР. ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА /ХЯЭА/


2.1 Хайлт хэсэг.

ХЯЭА /Хорих ял эдлүүлэх ажиллагаа/-ны ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ.

Дахин хайлт хийхэд заавал ЦЭВЭРЛЭХ товч дарах буюу өмнө нь оруулсан мэдээллээ цэвэрлэсний дараа хайлтыг хийнэ.



1. Жагсаалтыг эксел файлруу хуулж хадгалах бол товчийг дарна.
2. Хоригдлын мэдээлэлийг шинээр бүртгэх




Хайлтын хэсэгт дэлгэрэнгүй хайх, ял биелэгдсэн байдлаар, санал, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хайх гэсэн илүү өргөн сонголттойгоор мэдээллээ хайж болно.

2.2. Шинээр бүртгэх талбар.

Тайлбар: Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан зааврын 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор нь хорих ангид шинээр ирсэн хоригдлын мэдээллийг тухай бүр авч цахим бүртгэлд даруй бүртгэнэ.” гэж зааны дагуу хорих ангид шинээр хуваарилагдаж ирсэн хоригдлын хувийн хэрэг, материалыг хүлээн авч бүртгэлийг хийнэ.


ХЯЭА цэсний жагсаалт хэсгийн ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар хоригдлын мэдээлэл бүргэх энэхүү талбар гарч ирнэ.

Хоригдлын регистрийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад хоригдлын мэдээлэл автоматаар гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.




1. Ялтан нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
2. Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл хэсэгт ялтны одоо оршин сууж байгаа хаягийг заавал оруулна.
3. Хоригдол /Ялтан/-ны ерөнхий мэдээллийг бүртгэж ХАДГАЛАХ товч дарснаар ШҮҮХИЙН ШИЙДВЭР ХАЙХ талбарт шилжинэ. Бүртгэлийг цуцлах бол БОЛИХ товчийг дарна.


Хоригдол /Ялтан/-ны ерөнхий мэдээллийг бүртгэж ХАДГАЛАХ товч дарснаар ШҮҮХИЙН ШИЙДВЭР ХАЙХ энэхүү талбарт шилжинэ.




Шүүхийн шийдвэрийн огноог оруулж ХАЙХ товч дарснаар дараах талбар гарч ирнэ.



1. Шүүхээс тухайн ялтанд хэд хэдэн төрлийн ял, ААХ оногдуулсан бол оногдуулсан ялын тоогоор “ХЯЭА”, “ХӨТЯл”, “ААХ”-ээр сонгоно.
2. Шүүхийн шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулж хадгалснаар ЯЛТАН, ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ бүртгэх гэсэн дараагийн талбарт шилжинэ.




1. ЯЛЫН МЭДЭЭЛЭЛ хэсгийн БҮРТГЭХ гэсэн улаан товчийг дарахад энэхүү талбар гарч ирнэ.




1. Уг талбарт шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ, шүүхээс тогтоосон хугацаа, шийдвэр хүчин төгөлдөр болсон огноо, ШШГ байгууллага, зэрэг өгөгдсөн мэдээллийг бүрэн оруулж ХАДГАЛАХ товч дарснаар ялтны үндсэн бүртгэл хийгдэж, ялтны мэдээлэл ЖАГСААЛТ хэсэгт нэмэгдэж орно.


Шийтгэх тогтоолд дурдагдсан гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлын хэмжээг бүртгэнэ.



Тайлбар: Хоригдол өөр хорих ангид шилжсэн тохиолдолд ЯЛТНЫ ШИЛЖИЛТ гэсэн талбарт тохирох өгөгдлийг бүртгэж хадгална.




Тайлбар: Хоригдлын ял эдлэх дэглэм өөрчлөгдөж хорих анги шилжүүлж байгаа тохиолдолд ДЭГЛЭМ ШИЛЖИЛТ гэсэн хэсгийг сонгож мэдээллийг бүртгэж хадгална.




Тайлбар: Хоригдлын ял эдэлсэн хугацааны тооцоог харах тохиолдолд ТООЦОО гэсэн сонголтыг дарж ороход дээрх байдлаар хоригдлын ялын тооцоог дэлгэрэнгүй харах боломжтой.


Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа, шагналын хоног, цагдан хоригдсон хугацаа, өршөөл, уучлал, хуулийн тэгшитгэлээр хасагдсан хугацааг тухай бүр үнэн зөв бүртгэснээр хоригдлын ял эдэлсэн хугацааг цахим бүртгэл автоматаар харуулна.




Ял эдэлсэн хугацаа, шагналын хоногийг тухай бүр зөвтгөж бүртгэснээр ялын тооцоо үнэн зөв уншигдна.




Хоригдлын ялын хугацаа дуусаж бүрэн биелсэн, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон, дахин гэмт хэрэг үйлдсэн, дэглэм бууруулсан, дэглэм чангаруулсан, ял өөрчлөгдсөн, шийтгэх тогтоол магадлал хүчингүй болсон, ХБ, МБ байгууллагад шилжүүлсэн гэх мэт хаагдсан үндэслэлийн аль тохирохыг сонгож хадгална.







Тайлбар: Хоригдлын ялын мэдээллээс “2-р хуудас”-руу дарж ороход “ПРОКУРОРЫН ТОГТООЛ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ” гэсэн талбарт шилжинэ. Уг талбарт хоригдлыг дэглэм, зэрэглэл өөрчлүүлэх, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолгох, өршөөл, уучлалд хамруулах, зөвшөөрөл авах гэх мэт Хорих анги, ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж бүртгэнэ.



Нэг хоригдолд олон санал, шийдвэр бүртгэгдсэн тохиолдолд Прокурорын шийдвэрийг бүртгэхэд хамаарах Хорих анги, ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, Шүүхийн шийдвэрийг бүртгэхэд хамаарах прокурорын шийдвэрийг тус тус зөв харгалзуулан сонгохыг анхаарах.







ГУРАВ. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА /ХӨТЯЭА/

3.1 Хайлт хэсэг

Хайлтын хэсэгт дэлгэрэнгүй хайх, ял биелэгдсэн байдлаар, санал, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хайх гэсэн илүү өргөн сонголттойгоор мэдээллээ хайж болно.




1. ХӨТЯЭА /Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа/-ны ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийхэд өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг цэвэрлэхдээ ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.
2. Жагсаалтыг эксел файл руу хуулж хадгалах бол товчийг дарна.




Хайлтын хэсэгт дэлгэрэнгүй хайх, ял биелэгдсэн байдлаар, санал, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хайх гэсэн илүү өргөн сонголттойгоор мэдээллээ хайж болно.

3.2 Шинээр бүртгэх талбар


Тайлбар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153 дугаар зүйлийн 153.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн тогтоолыг прокурорын хяналтад ирүүлсэн даруй прокурор хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны мэдээллийг тухай бүр цахим бүртгэлд даруй бүртгэнэ.




1. Ялтан нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
2. ХӨТЯА цэсний ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар ялтны мэдээлэл бүргэх энэхүү талбар гарч ирнэ. Ялтны регистрийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад ялтны мэдээлэл автоматаар гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.
3. Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл хэсэгт ялтны одоо оршин сууж байгаа хаягийг заавал оруулна.
4. Ялтны ерөнхий мэдээллийг бүртгэж ХАДГАЛАХ товч дарснаар ШҮҮХИЙН ШИЙДВЭР ХАЙХ талбарт шилжинэ. Бүртгэлийг цуцлах бол БОЛИХ товчийг дарна.




1. Шүүхийн шийдвэрийн огноог оруулж ХАЙХ товч дарснаар дараах талбар гарч ирнэ.




1. Шүүхээс тухайн ялтанд хэд хэдэн төрлийн ял, ААХ оногдуулсан бол оногдуулсан ялын тоогоор “ХӨТЯл”, “ААХ”-ээг сонгоно.
2. Шүүхийн шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулж хадгалснаар ЯЛТАН, ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ бүртгэх гэсэн дараагийн талбарт шилжинэ.




1. ЯЛЫН МЭДЭЭЛЭЛ хэсгийн БҮРТГЭХ гэсэн улаан товчийг дарахад дараах талбар гарч ирнэ.




1. Уг талбарт шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ, шүүхээс тогтоосон хугацаа, шийдвэр хүчин төгөлдөр болсон огноо, ШШГ байгууллага, зэрэг өгөгдсөн мэдээллийг бүрэн оруулж ХАДГАЛАХ товч дарснаар ялтны үндсэн бүртгэл хийгдэж, ялтны мэдээлэл ЖАГСААЛТ хэсэгт нэмэгдэж орно.




1. Ялтны байнга оршин суух хаяг нь өөрчлөгдөж, ялтныг тухайн орон нутгийн ШШГГазарт харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд ШИЛЖИЛТ гэсэн товч дарж зохих бүртгэлийг хийнэ.



1. Ялтны торгох ялын төлөлтийг тухай бүр ТӨЛӨЛТ товч дарж бүртгэнэ.




1. Ялтанд өмнө хилийн хориг тавигдсан хоригийг цуцалсан бол ХИЛИЙН ХОРИГ товч дарж цуцалсан огноог бүртгэнэ.




1. Ялтанд шүүхээс тогтоосон ялын хугацаа дуусаж бүрэн биелсэн, торгох ялыг тогтоосон хугацаанд бүрэн төлсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн, хорих ялаар сольсон, шийтгэх тогтоол магадлал хүчингүй болсон гэх мэт хаагдсан үндэслэлийн аль тохирохыг сонгож хадгална.


   Ял шийтгэлийн биелэлтийн талаарх бүртгэлд хаагдсан үндэслэлийг зөв сонгосон эсэхээс хамаарч ЯЭА-1 мэдээний 6-18, 25-34-р мөрний утга зөв, буруу гарахад нөлөөлнө.



1. Ялтны ялын мэдээллээс “2-р хуудас”-руу дарж ороход “ПРОКУРОРЫН ТОГТООЛ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ” гэсэн талбарт шилжнэ.




1. Нэг ялтанд олон санал, шийдвэр бүртгэгдсэн тохиолдолд Прокурорын шийдвэрийг бүртгэхэд хамаарах Хорих анги, ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, Шүүхийн шийдвэрийг бүртгэхэд хамаарах прокурорын шийдвэрийг тус тус зөв харгалзуулан сонгохыг анхаарах.



1. Уг талбарт ялтны ялыг хорих ялаар солих, өршөөл, уучлалд хамруулах, ялаас чөлөөлөх, зорчих бүсийг өөрчлөх гэх мэт ШШГГазар, хэлтсээс иргүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж бүртгэнэ.


ДӨРӨВ. ТЭНСЭХ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ, ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛАХ /ТЭНСЭХ, ААХ, ХЯОШШТБХОЙШЛУУЛАХ/

4.1 Хайлт хэсэг




1. ТЭНСЭХ,ААХ,ХЯОШШТБХОЙШЛУУЛАХ цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.
2. Жагсаалтыг эксел файлруу хуулж хадгалах бол товчийг дарна.

Хайлтын хэсэгт дэлгэрэнгүй хайх, ял биелэгдсэн байдлаар, санал, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хайх гэсэн илүү өргөн сонголттойгоор мэдээллээ хайж болно.




4.2 Шинээр бүртгэх талбар

Тайлбар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185 дугаар зүйлийн 185.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн тогтоолыг прокурорын хяналтад ирүүлсэн даруй прокурор албадлагын арга хэмжээ авагдсан болон тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн мэдээллийг тухай бүр цахим бүртгэлд даруй бүртгэнэ.




1. ААХ авагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
2. ТЭНСЭХ,ААХ,ХЯОШШТБХОЙШЛУУЛАХ цэсний ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар ялтны мэдээлэл бүртгэх энэхүү талбар гарч ирнэ.

   Тэнсэх, ААХ авагдсан этгээдийн Регистрийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад ялтны мэдээлэл автоматаар гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.
3. Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл хэсэгт ялтны одоо оршин сууж байгаа хаягийг заавал оруулна.
4. Ялтны ерөнхий мэдээллийг бүртгэж ХАДГАЛАХ товч дарснаар ШҮҮХИЙН ШИЙДВЭР ХАЙХ талбарт шилжинэ. Бүртгэлийг цуцлах бол БОЛИХ товчийг дарна.




1. Шүүхийн шийдвэрийн огноог оруулж ХАЙХ товч дарснаар дараах талбар гарч ирнэ.


/Нийт бүртгэсэн ялтны мэдээлэл ЯЭ-2 мэдээний 1-р мөрөнд бууна./




1. Шүүхээс тухайн ялтанд хэд хэдэн төрлийн ял, ААХ оногдуулсан бол оногдуулсан ялын тоогоор “ХӨТЯл”, “ТЭНСЭХ”, “ААХ”-ээг сонгоно.
2. Шүүхийн шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулж хадгалснаар ЯЛТАН, ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ бүртгэх гэсэн дараагийн талбарт шилжинэ. Цуцлах бол болих гэсэн товч дарна.




1. ЯЛЫН МЭДЭЭЛЭЛ хэсгийн БҮРТГЭХ гэсэн улаан товчийг дарахад дараах талбар гарч ирнэ.




1. Уг талбарт шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ, шүүхээс тогтоосон хугацаа, шийдвэр хүчин төгөлдөр болсон огноо, ШШГ байгууллага зэрэг өгөгдсөн мэдээллийг бүрэн оруулж ХАДГАЛАХ товч дарснаар ялтны үндсэн бүртгэл хийгдэж, ялтны мэдээлэл ЖАГСААЛТ хэсэгт нэмэгдэж орно.







1. Ялтны ялын мэдээллээс “2-р хуудас”-руу дарж ороход “ПРОКУРОРЫН ТОГТООЛ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ” гэсэн талбарт шилжинэ.




1. Уг талбарт ялтны ялыг хорих ялаар солих, өршөөл, уучлалд хамруулах, ялаас чөлөөлөх, зорчих бүсийг өөрчлөх гэх мэт ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж бүртгэнэ



1. Ялтны байнга оршин суух хаяг нь өөрчлөгдөж, ялтныг тухайн орон нутгийн ШШГГазарт харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд ШИЛЖИЛТ гэсэн товч дарж зохих бүртгэлийг хийнэ.




1. Ялтанд өмнө хилийн хориг тавигдсан хоригийг цуцалсан бол ХИЛИЙН ХОРИГ товч дарж цуцалсан огноог бүртгэнэ.




1. Шүүхээс тогтоосон хяналтын хугацаа дуусаж бүрэн биелсэн, дахин гэмт хэрэг үйлдсэн, хорих ялаар сольсон, шийтгэх тогтоол магадлал хүчингүй болсон гэх мэт хаагдсан үндэслэлийн аль тохирохыг сонгож хадгална.

   Хаагдсан үндэслэлийн сонголтоос хамаарч ЯЭА-2 мэдээний 2, 3-р мөрөнд бууна. Хаалт хийгдээгүй ажиллагаанд байгаа шийтгүүлсэн этгээдийн тоо 5-р мөрөнд бууна.




1. Нэг ялтанд олон санал, шийдвэр бүртгэгдсэн тохиолдолд Прокурорын шийдвэрийг бүртгэхэд хамаарах Хорих анги, ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, Шүүхийн шийдвэрийг бүртгэхэд хамаарах прокурорын шийдвэрийг тус тус зөв харгалзуулан сонгохыг анхаарах.




1. Уг талбарт ялтны ялыг хорих ялаар солих, өршөөл, уучлалд хамруулах, ялаас чөлөөлөх гэх мэт ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж мэдээллийг үнэн зөв бүртгэнэ.

ТАВ. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА /ЗШГА/

5.1 Хайлт хэсэг




1. ЗШГА цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.
2. Жагсаалтыг эксел файл руу хуулж хадгалах бол товчийг дарна.




Хайлтын хэсэгт дэлгэрэнгүй хайх, ял биелэгдсэн байдлаар, санал, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хайх гэсэн илүү өргөн сонголттойгоор мэдээллээ хайж болно.

6.2 Шинээр бүртгэх талбар

Тайлбар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 141 дүгээр зүйлд заасны дагуу зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолыг прокурорын хяналтад ирүүлсэн даруй прокурор шийтгүүлсэн этгээдийн мэдээллийг тухай бүр цахим бүртгэлд даруй бүртгэнэ.




1. Шийтгүүлсэн этгээд нь хүн, албан тушаалтан, хуулийн этгээд аль нь болохыг сонгоно.
2. Шийтгүүлсэн этгээд нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
3. ЗШГА цэсний ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар ялтны мэдээлэл бүртгэх энэхүү талбар гарч ирнэ. Шийтгүүлсэн хүн, хуулийн этгээдийн регистр болон бүртгэлийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад ялтны мэдээлэл автоматаар гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.
4. Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл хэсэгт ялтны одоо оршин сууж байгаа хаягийг заавал оруулна.
5. Шийтгүүлсэн этгээдийн ерөнхий мэдээллийг бүртгэж ХАДГАЛАХ товч дарснаар ШҮҮХИЙН ШИЙДВЭР ХАЙХ гэсэн дараагийн талбарт шилжинэ. Бүртгэлийг цуцлах бол БОЛИХ товчийг дарна.




1. Шүүхийн шийдвэрийн огноог оруулж ХАЙХ товч дарснаар дараагийн талбарт шилжинэ.

/Нийт бүртгэсэн этгээдийн мэдээлэл ЯЭ-3 мэдээний 1-4-р мөрөнд бууна./




1. Тухайн этгээд нь хэд хэдэн зөрчил үйлдсэн болон шүүхээс хэд хэдэн төрлийн шийтгэл оногдуулсан бол зөрчил үйлдсэн зүйл анги нэг бүрийг, мөн оногдуулсан шийтгэлийн тоогоор “ШИЙТГЭЛИЙН ТӨРӨЛ”-ийг тус тус сонгоно.

   Шүүхийн шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулж хадгалснаар ЯЛТАН, ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ бүртгэх гэсэн дараагийн талбарт шилжинэ. Цуцлах бол БУЦАХ гэсэн товч дарна.




1. ШИЙТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ хэсгийн БҮРТГЭХ гэсэн улаан товчийг дарахад дараах талбар гарч ирнэ.





1. Торгох шийтгэлийн төлөлтийг тухай бүр нь “Шийтгэлийн мэдээлэл” талбарт орж төлөлт хийсэн огноогоор бүртгэнэ.

   Уг талбарт шүүхээс оногдуулсан шийтгэлийн төрөл, хэмжээ, шүүхээс тогтоосон хугацаа, шийдвэр хүчин төгөлдөр болсон огноо, ШШГ байгуулага зэрэг өгөгдсөн мэдээллийг бүрэн оруулж ХАДГАЛАХ товч дарснаар ялтны үндсэн бүртгэл хийгдэж, ялтны мэдээлэл ЖАГСААЛТ хэсэгт нэмэгдэнэ.




Шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд нь хохирол төлбөртэй эсэхийг заавал бүртгэнэ.






1. Шийтгүүлсэн этгээдийн байнга оршин суух хаяг нь өөрчлөгдөж, тухайн орон нутгийн ШШГГазарт харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд ШИЛЖИЛТ гэсэн товч дарж зохих бүртгэлийг хийнэ.




1. Шийтгүүлсэн этгээдийн өмнө тавигдсан хилийн хоригийг цуцалсан бол ХИЛИЙН ХОРИГ товч дарж цуцалсан огноог бүртгэнэ.




1. Шийтгэл бүрэн биелсэн, шийтгэх тогтоол магадлал хүчингүй болсон, Зөрчлийн шийтгэлийг солиулсан, Хуулийн этгээдийг татан буулгасан гэх мэт хаагдсан үндэслэлийн аль тохирохыг сонгож хадгална.


   Хаагдсан үндэслэлийн сонголтоос хамаарч ЯЭА-3 мэдээний 5-12-р мөрөнд бууна. Хаалт хийгдээгүй ажиллагаанд байгаа шийтгүүлсэн этгээдийн тоо 21, 22-р мөрөнд бууна.




1. Ялтны ялын мэдээллээс “2-р хуудас”-руу дарж ороход “ПРОКУРОРЫН ТОГТООЛ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ” гэсэн талбарт шилжинэ.




1. Уг талбарт ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж бүртгэлийг хийнэ.
2. ШГА-аар түдгэлзүүлсэн, сэргээсэн огноогоор бүртгэлийг хийж ХАДГАЛАХ товч дарна.






1. Нэг этгээдэд олон санал, шийдвэр бүртгэгдсэн тохиолдолд Прокурорын шийдвэрийг бүртгэхэд хамаарах ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, Шүүхийн шийдвэрийг бүртгэхэд хамаарах прокурорын шийдвэрийг тус тус зөв харгалзуулан сонгохыг анхаарах.



1. Уг талбарт шийтгүүлсэн этгээдийг өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулах, баривчлах шийтгэлээр солих гэх мэт ШШГГазар, хэлтсээс ирүүлсэн санал, түүнийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийг ШИНЭЭР БҮРТГЭХ товч дарж мэдээллийг үнэн зөв бүртгэнэ.

ЗУРГАА. ТУШААЛ ХЯНАСАН


6.1 Хайлт хэсэг



6.2 Шинээр бүртгэх талбар

Тайлбар: Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан зааврын 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор нь ял эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг тухай бүр хянана.” гэж зааны дагуу ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой Хорих анги, цагдан хорих, баривчлах төв, байр, ШШГГазар, хэлтсийн даргын тушаал, шийдвэрийн үндэслэлийг тухай бүр хянаж, энэ талаарх бүртгэлийг цахим бүртгэлийн ТУШААЛ ХЯНАСАН цэсэнд бүртгэнэ.


Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хянасан тушаал нэг бүрийг цахим бүртгэлд бүртгэхдээ зураг үзүүлсний дагуу мэдээллийг үнэн зөв оруулж, “Тушаалын утга”, “Хууль тогтоомж зөрчсөн үндэслэл”, “Тогтоолын агуулга” хэсгийг товч, тодорхой бөглөж ХАДГАЛАХ товч дарснаар таны оруулсан мэдээлэл ЖАГСААЛТ хэсэгт бууна.



1. Тухайн тушаалыг хянаж хууль, тогтоомж зөрчсөн үндэслэлээр өөрчлөх болон хүчингүй болгож шийдвэрлэсэн бол “Хууль тогтоомж зөрчсөн эсэх”, “Прокурор тогтоол бичсэн эсэх” гэсэн хоёр сонголтыг чеклэснээр хамаарах сонголтууд гарч ирнэ.


ДОЛОО. ЗӨРЧИЛ ГАРГАСАН

7.1 Хайлт хэсэг




1. ЗӨРЧИЛ ГАРГАСАН цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.

7.2 Шинээр бүртгэх талбар




1. Зөрчил гаргасан хоригдол /ялтан/ хуулийн этгээд болон гадаадын иргэн бол “Тийм” гэсэн сонголтыг тус тус идэвхжүүлнэ.



1. Зөрчил гаргасан ялтныг бүртгэх талбарын мэдээллийг үнэн зөв бөглөж, ХАДГАЛАХ товч дарж хадгална. Бүртгэлийг цуцлах бол БУЦАХ товч дарна.

НАЙМ. ӨЛСГӨЛӨН


8.1. Хайлт хэсэг



1. ӨЛСГӨЛӨН цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.

8.2. Шинээр бүртгэх талбар

Тайлбар: Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан зааврын 11.4 дүгээр зүйлд заасны дагуу ШШГГазар, хэлтсийн харьяа Цагдан хорих төв, байранд хоригдсон этгээд өлсгөлөн зарласан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч байгаа эсэхийг танилцаж, шалган, өлсгөлөн зарласан этгээдийн мэдээллийг цахим бүртгэлийн ӨЛСГӨЛӨН цэсэд бүртгэж ХАДГАЛАХ товч дарна.




1. Өлсгөлөн зарласан хоригдогч нь гадаадын иргэн бол “Тийм” гэсэн сонголтыг идэвхжүүлнэ.
2. Өлсгөлөн зарласан этгээдийн эрүүл мэндийг сайжруулах албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд “Албадан эмчилгээнд оруулсан эсэх” сонголтыг тийм болгож, “ААХ талаар” талбарт холбогдох мэдээллийг товч, тодорхой бичнэ.

ЕС. БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ, САТУУЛАХ

9.1 Захиргааны журмаар баривчлах байр


9.1.1 Хайлт хэсэг



1. “ЗАХИРГААНЫ ЖУРМААР БАРИВЧЛАХ БАЙР” цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.

9.1.2 Шинээр бүртгэх талбар

Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан зааврын 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Прокурор нь баривчлах байранд шинээр хүлээн авсан этгээдийн мэдээллийг тухай бур авч цахим бүртгэлд бүртгэнэ.” гэж заасны дагуу хяналтын харьяа баривчлах төв, байранд шинээр хуваарилагдаж ирсэн этгээдийн мэдээллийг хүлээн авч цахим бүртгэлд бүртгэнэ.




1. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
2. “ЗАХИРГААНЫ ЖУРМААР БАРИВЧЛАХ БАЙР” цэсний жагсаалт хэсгийн ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар ялтны мэдээлэл бүргэх энэхүү талбар гарч ирнэ. Ялтны регистрийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад ялтны мэдээлэл автоматаар

гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.


9.2 Саатуулах байр

9.2.1 Хайлт




1. “Саатуулах байр” цэсэнд хайлт хийгдэхгүй. Хөгжүүлэлт хийгдэж байгаа болно.

9.2.2 Шинээр бүртгэх талбар




9.3 Үндэслэлгүй хоригдсон этгээдийг сулласан

9.3.1 Хайлт




1. “ҮНДЭСЛЭЛГҮЙ ХОРИГДСОН ЭТГЭЭДИЙГ СУЛЛАСАН” цэсний ХАЙЛТ талбараас өөрийн хайх зүйлийнхээ 1 буюу түүнээс дээш хэд хэдэн утгыг сонгож ХАЙХ товчийг дарснаар мэдээллээ хайна. Таны хайсан мэдээлэл талбарын ЖАГСААЛТ хэсэгт гарч ирнэ. Дахин хайлт хийх бол өмнөх талбаруудад оруулсан мэдээллүүдийг ЦЭВЭРЛЭХ товчийг дарж хайна.

9.3.2 Шинээр бүртгэх талбар




1. Үндэслэлгүй хоригдсон этгээд нь гадаад улсын иргэн бол ТИЙМ гэх сонголтыг идэвхжүүлнэ.
2. “ҮНДЭСЛЭЛГҮЙ ХОРИГДСОН ЭТГЭЭДИЙГ СУЛЛАСАН” цэсний ШИНЭЭР БҮРТГЭХ товчийг дарснаар хоригдсон этгээдийн мэдээлэл бүртгэх энэхүү талбар гарч ирнэ.

   Хоригдсон этгээдийн Регистрийн дугаарыг оруулаад ХАЙХ товч дарахад ялтны мэдээлэл автоматаар гарч ирнэ. Гарч ирэхгүй тохиолдолд мэдээллийг гараар оруулж хадгална.




3. Үндсэн захиргааны хаягийн мэдээлэл хэсэгт хоригдсон этгээдийн одоо оршин сууж байгаа хаягийг заавал оруулна.
4. Сулласан үндэслэлийг товч, тодорхой бичнэ.

9.4 Цагдан хорих байр



1. “Цагдан хорих байр” цэсэнд хайлт хийгдэхгүй.


9.4.1 Шинээр бүртгэх талбар



1. Цагдан хоригдсон этгээдийн хөдөлгөөний мэдээг харьяа ШШГГазар, хэлтсээс тухай бүр авч өгөгдлийн дагуу мэдээллийг үнэн зөв бүртгэнэ. ЯЭ-5 мэдээнд сүүлийн бүртгэлээр мэдээ гарна.


СЭДЭВ 2. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ (ERP)-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ

1. ХЯНАХ САМБАР




Хянах самбар модуль- Хүний нөөцийн удирдлага, Үүрэг даалгавар, Хурал, Ажлын хэсэг, Цаг бүртгэл, Мэдээлэл модулиудад бүртгэгдсэн дата өгөгдлүүдийг график, диаграммаар үзүүлэх мониторингийн хэсэг.

Өгөгдсөн эрхийн хүрээнд Системийн хэмжээнд, Байгууллага, Нэгж, Албан хаагч зэргээр ялгамжтай үзүүлнэ




2.1 ҮҮРЭГ ДААЛГАВАР, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ ТООЦОХ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ

Хянах самбар- Хэрэглэгчийн эрхээс хамаарч энэ цэсэд байгууллагын болон ажилтны хувьд бүртгэгдсэн үүрэг даалгаруудын хугацаа, төрөл зэргээр графикаар харуулна




Миний үүрэг даалгавар- Энэ цэсэнд хэрэглэгчийн өгсөн үүрэг даалгавар, Хяналт тавих, Хариуцан гүйцэтгэхээр бүртгэгдсэн үүрэг даалгаврын жагсаалтууд харагдана.




Үүрэг даалгавар хариуцан гүйцэтгэх хүнд доорх гүйцэтгэл оруулах товч дээр дарж үүрэг даалгаврын гүйцэтгэл оруулна.


Гүйцэтгэл оруулах




1. Гүйцэтгэл оруулах товч



1. Гүйцэтгэлийг хувиар нь тооцож оруулна.




1. Үүрэг даалгаврыг өгсөн буюу хяналт тавих ажилтан үүрэг даалгврыг хариуцан гүйцэтгэх ажилтан гүйцэтгэл оруулсныг хяналтын үнэлгээ өгч хянаж дуусгана



1. Үүрэг даалгаврын гүйцэтгэлтэй танилцан, хянаад тухайн үүрэг даалгаврыг дуусгах бол тийм гэж сонгоно. дуусгана
2. Үүрэг даалгаврын хяналтын үнэлгээг оруулна. Хяналтын үнэлгээ 60 болон түүнээс дээш хувьтайг биелэгдсэнд тооцно

Байгууллагын хяналт


Байгууллагын хэмжээнд бүргэгдсэн үүрэг даалгаврын жагсаалт харагдана.



1. Үүрэг даалгаврын Байгууллагын хяналт


2. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратеги төлөвлөгөө, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Гүйцэтгэлийн биелэлт дэд цэсүүдтэй




1. Улсын ерөнхий прокурорын баталсан Прокурорын байгууллагын Стратеги төлөвлөгөө
2. Байгууллагын төлөвлөгөө
3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө




Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт




1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүйг ‘Дэлгэрэнгүй’ товч дээр дарж харна

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дэлгэрэнгүй




2.2 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ (АЛБАН БИЧИГ БОЛОВСРУУЛАЛТ, ХҮЛЭЭН АВАХ, ХАРИУГ ИЛГЭЭХ)




1. АЛБАН БИЧИГ БОЛОВСРУУЛАЛТ хэсгийг сонгож, ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ / + / товч даран албан бичиг боловсруулж илгээх хэсэг гарч ирнэ.

Албан бичиг боловсруулах хэсэгт дараах сонголтыг хийж хадгалах товчийг дарна. Дараах зургийг хэсэг хэсгээр тайлбарлав.




1. Тухайн албан бичгийг боловруулж байгаа ажилтан
2. Албан бичгийн төрлийг сонгоно.
3. Албан бичгийн товч утга, /тэргүү бичих/
4. Албан бичгийн хавсралтыг файлыг оруулна.
5. Дээрх хэсэгт текстэн мэдээллээ бичих эсвэл WORD дээр бичсэн текстээ хуулж албан бичгийн талбар дээр буулгаж болно.
6. Албан бичгийн товч утгыг бичнэ.
7. Албан бичиг боловсруулж дууссан бол ХАДГАЛАХ ТОВЧ дарж хадгална.

Албан бичиг илгээхдээ дараах цонхонд албан тушаалтан нэмнэ.




1. Албан бичгийг боловсруулж байгаа албан тушаалтан байна. Энэ нь тухайн албан бичиг шинээр боловсруулахад автоматаар сонгогддог учир нэмэх шаардлагагүй.
2. Хянах хэсэгт тухайн албан бичгийг хянах албан тушаалтныг сонгоно.
3. Баталгаажуулах хэсэгт тухайн албан бичгийг баталгаажуулах, тоон гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан байна.




1. Боловсруулах, хянах, баталгаажуулах албан тушаалтан нь нэг хүн байвал дээрх товчийг дарснаар бүх сонголт автоматаар сонгогдоно.


Хүлээн авах байгууллага сонгоно.




Албан бичиг явуулах байгууллага сонгох хэсэг




1. Албан бичиг явуулах байгууллага сонгохдоо байгууллагын нэрний ард чагтлан сонгоно.
2. Тухайн байгууллагын хэнд хандаж албан бичиг боловсруулж байгаагаа бичнэ. Мөн өмнө нь тухайн газарт бичиг явуулж байсан бол сонголт санал болгоно.
3. Дээрх мэдээллүүдээ зөв бүртгэсэн эсэхийг шалган, СОНГОХ товчийг дарна. Мөн БУЦАХ дарж үйдлээ буцаах боломжтой.




1. Албан бичиг боловсруулж дууссан бол БОЛОВСРУУЛЖ ДУУСАХ ТОВЧ дарна. Үүний дараа ХЯНАХ албан тушаалтан руу шилжинэ.



1. Хянах албан тушаалтан руу шилжнэ.




1. Хянаж байгаа албан тушаалтан албан бичиг хариуцаж буй хүн буюу боловсруулсан албан тушаалтан руу бичгийг буцааж шилжүүлж болно.
2. Албан бичиг хянаж дууссан бол ХЯНАЖ ДУУСГАХ товч дарна.




1. Баталгаажуулах ажилтан руу шилжүүлнэ.

2.3 ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ АШИГЛАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ


Баталгаажуулж дуусгах, тоон гарын үсэг зурах




1. Албан бичиг БАТАЛГААЖУУЛЖ ДУУСАХ ТОВЧ дарж, тоон гарын үсэг зурснаар хүлээн авах байгууллага руу шууд илгээгднэ.




1. Тоон гарын үсгийн нууц үгийг оруулна.




1. Тоон гарын үсэг зурагдаж илгээсэн албан бичиг харагдана. Тухайн албан бичиг хугацаатай бол шийдвэрлэх огноо, хуудасны тоо оруулна.




1. Албан бичиг баталгаажуулах явцад албан бичгийн дугаар дарааллын дагуу автоматаар олгогдож илгээгдэнэ.



1. Ирсэн албан бичиг харах жагсаалтаас дэлгэрэнгүй дарж албан бичигтэй танилцана.




1. PDF хэлбэрээр харж болно.
2. Тухайн албан бичигтэй танилцах шаардлагатай албан тушаалтан нэмнэ.
3. Хариуцах албан тушаалтанд цохолт хийнэ.




1. Ирсэн албан бичгийн жагсаалт


Цохолтоор хүлээн авсан ажилтан ирсэн бичгийг хүлээж аваад, шийдвэрлэж хаах шаардлагатай.




1. Албан бичиг харах хэдэн ч албан тушаалтан нэмэж болно.
2. Ирсэн албан бичиг шийдвэрлэлтийн явц харагдана. Албан бичиг шийдвэрлэгдсэн бол хаах ёстой. Хаагаагүй тохиолдолд зөрчилд бүртгэгдэнэ.
3. Албан бичиг цохолт хийгдсэн байдал харагдана.




Ирсэн бичгийг ЦОХОЛТ хийж шилжүүлнэ.






1. Албан бичиг хүлээн аваад холбогдох эрх бүхий албан тушаалтан руу цохолт хийж шилжүүлнэ.


Албан бичиг хүлээн авсан албан тушаалтан шийдвэрлэж, хаах ёстой.




1. Албан бичиг шийдвэрлэх
2. Албан бичиг төлөв харагдана.




1. Албан бичиг шийдвэрлэсэн утга бичих




1. Албан бичиг шийдвэрлэгдсэн бол хаах.
2. Албан бичиг төлөв харагдана.



Албан бичиг бүрэн шийдвэрлэж, хаасан бол дараах төлөвтэй харагдана.




Ирсэн албан бичиг төлөв харагдана.




1. Албан бичиг хаагдсан төлөв харагдана.
2. Албан бичиг хугацаанд нь шийдвэрлэсэн төлөв харагдана.

Хугацаатай үүрэг даалгаврыг хариу бичиг цахимаар боловсруулж илгээх болон явсан бичиг бүртгэхдээ холбож шийдвэрлэнэ.

Цахимаар боловсруулж хариуг илгээх




1. Албан бичгийн хариу эсэх сонгоно
2. Бичгийн дугаар цонхны хайлтын товч дээр дарна.




1. Байгууллагад ирсэн бичгийн жагсаалт харагдана.

Явсан бичиг бүртгэж хариу бичиг явуулах




1. Явсан бичиг шинээр бүртгэх



1. Албан бичгийн хариу эсэх тийм сонгоно


5. ХҮНИЙ НӨӨЦ

Хүний нөөц модульд хэрэглэгч өөрийн төрийн албан хаагчийн анкет, мэдээлэл, томилолт, хамрагдсан сургалтын мэдээллүүд харагдана



1. Өөрийн бүртгэлийн урд байрлах checkbox сонгож өөрийн мэдээллийг дэлгэрэнгүй харна


Хамрагдсан сургалтын бүртгэлийн жагсаалт



1. Сонгосон сургалтыг дэлгэрэнгүй харна

7.АЖЛЫН ХЭСЭГ


Ажлын хэсгийн бүртгэл үүсгэж өдөр тутмын үйл ажиллагааг удирдана



1. Шинээр бүртгэх товч дарж шинээр ажлын хэсгийн бүртгэл үүсгэнэ.

8.ТАЙЛАН


Тайлан модульд ERP системийн зарим модулиудын бүртгэлийн тайланг загваруудаас сонгож харна




6.ХУРАЛ


Хурал, уулзалтын жагсаалтад бүртгэлтэй бүх хурал, уулзалтууд харагдана. / Хандах эрхийн түшингээс хамааран жагсаалтын утгууд ялгаатай харагдана гэдгийг анхаарна уу! /

Хуралд хавсаргасан бүх файлыг нэгдсэн байдлаар нэгтгэн хурлын файлын жагсаалтаас харна.




1. Хурал, уулзалтыг бүх албан хаагч нэмэх боломжтой. Бүртгэхдээ жагсаалтын зүүн дээд буланд байрлах нэмэх товчийг даран гарч ирэх цонхны мэдээллийг бүрэн бөглөж хадгална. Бүртгэгдсэн хурал, уулзалт төсөл байдалтай үүсгэгдэнэ. Тухайн хурлын мэдээллийг бүрэн бөглөж хуралд оролцогчдыг бүртгэж оруулсны дараа НИЙТЛЭХ товч дарснаар хурлын тов мэдэгдэл байдлаар оролцогчдод хүргэгдэнэ. Харин НИЙТЛЭХ товчийг дараагүй үед хурлын гишүүдэд харагдахгүй зөвхөн хурал үүсгэж байгаа ажилтанд харагдана.






1. Ангилалыг сонгоно.
2. Хурлын төрлийг сонгоно

Зөвлөлийн хурал



1. Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлыг бүртгэнэ
2. Зөвлөлийн хурлын хэлэлцсэн асуудлын шийдвэр (үүрэг даалгавар) тус тусад нь бүртгэнэ


Шуурхай зөвлөгөөн



1. Шуурхай зөвлөгөөн, Хурлаас үүрэг даалгавар үүсгэж болох ба үүрэг даалгавар оруулж өгөхдөө Үүрэг даалгавар товчийг даран гарч ирэх хэсэгт шинээр үүсгэх гэж байгаа үүрэг даалгаврынхаа нэрийг бичиж өгөн Enter товч дарна. Үүсгэсэн үүрэг даалгаврын ард байрлах Засварлах товчийг дарахад үүрэг даалгаврын дэлгэрэнгүй хэсэг рүү шилжиж бүртгэлийг бүрэн бөглөж нийтэлнэ.


9.САНАЛ АСУУЛГА

Судалгаа үүсгэх



1. Санал асуулга шинээр үүсгэх товч дарж, хамрах хүрээ санал асуулгын мэдээллийг бүртгэж нийтлэнэ

Судалгаа бөглөх



1. Судалгаа бөглөх товч дээр дарж судалгааг бөглөнө

10. ФАЙЛЫН САН


Үр дүнтэй хамтран ажиллах боломжийг олгоно. Та өөрийн компьютероос хүссэн файлаа хуулан байгууллагын албан хаагч нартай хуваалцах, тухайн файлыг өөрийн компьютерт хадгалж авах, боломжтой.




1. Байгууллагын файлууд-д байршуулсан файлууд тухайн байгууллагын бүх хэрэглэгчид харагдана
2. Хуваалцсан файл-д хэн нэгэн хэрэглэгч тантай хуваалцсан файлууд байршина.

Өөр хэрэглэгчтэй файл, хавтсыг хуваалцах боломжтой. Хуваалцсан файлууд энэхүү хавтсанд автоматаар хадгалагдана. Хуваалцахыг хүссэн файл, хавтас дээрээ Mouse 2-оо дарахад Хуваалцах/Холбоос/, Хуваалцах/Албан хаагч/ гэх 2 сонголт гарч ирэх ба үүнээс сонголтоо хийн хуваалцахад “Хуваалцсан файлууд” хавтсанд орно.






11.ЦАХИМ ШУУДАН




Шинээр мэйл бүргүүлэхдээ Бүртгүүлэх товчийг даран бүртгэлийн цонх нээгдэнэ. Цахим хаяг бүртгүүлэхдээ заавал бөглөх (“*” тэмдэглэгээтэй) талбарыг гүйцэт бөглөх шаардлагатай. Хэдэн ч Мэйл бүртгүүлэх боломжтой ба бүгд дэлгэцийн зүүн гар талд байрлах Sidebar-д байрлан харагдана.




Та Шуудан илгээх товч дээр даран мэйл илгээх цонхыг гаргаж ирнэ. Цахим шуудан илгээх үйлдлийг гүйцэтгэхдээ заавал бөглөх (“*” тэмдэглэгээтэй) талбарыг гүйцэт бөглөх шаардлагатай. Мэйл шинээр нэмэхэд жагсаалтад шууд нэмэгдэнэ.

12. МЭДЭЭЛЭЛ



Олон нийтийн арга хэмжээ нийтлэхдээ системийн нүүр хуудасны дээд хэсэгт байрлах Олон нийтийн арга хэмжээ бичих товчинд дарж шаардлагатай мэдээллийг бөглөн нийтэлнэ. Олон нийтийн арга хэмжээний хамрах хүрээ нь хэрэглэгчийн хандах эрхээс хамаарч нийтлэх хүрээ нь ялгаатай байна.

Хамрах хүрээний ард байрлах Нэмэх товчийг дарж арга хэмжээ нийтлэх хүрээгээ сонгож өгнө.



Системд бүртгэлтэй Төрийн байгууллагуудад хамааралтай эсвэл тухайн нэг байгууллага болон хэд хэдэн байгууллагууд, нэгж хэлтэс, албан хаагчдад зориулсан мэдээ мэдээлэл, санал асуулга гэдгээс хамаарч хамрах хүрээг сонгон мэдээ, мэдээлэл олон нийтийн арга хэмжээ, тушаал шийдвэр нийтлэх, санал асуулга явуулах боломжтой албан хаагч бүр нээлттэй харилцах талбар юм.

